

МОНГОЛ УЛС  
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ



# ХУУЛЬ САХИУЛАХУЙ

---

ОНОЛ, АРГА ЗҮЙН  
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2026  
№01 (45)

Улаанбаатар хот

UNIVERSITY OF INTERNAL AFFAIRS,  
MONGOLIA



# LAW ENFORCEMENT

---

THEORETICAL AND METHODOLOGICAL  
QUARTERLY JOURNAL

2026  
№01 (45)

Ulaanbaatar



**СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИН ЗӨВЛӨЛ**

**Сэтгүүлийн эрхлэгч:**

**С.Гантулга** Доктор, дэд профессор

**Ерөнхий редактор:**

**Л.Одхүү**

**Нарийн бичгийн дарга:**

**Ц.Чингүнжав**

**Гишүүд:**

**Ж.Амарсанаа** Академич

**О.Үржин** Шинжлэх ухааны доктор, профессор

**Б.Бат-Эрдэнэ** Доктор, профессор

**Д.Зүмбэрэллхам** Доктор, профессор

**И Габ Хван** Доктор, профессор

**Д.Эрдэнэбаатар** Доктор, профессор

**Хармаев Юрий Владимирович** Доктор, дэд профессор

**Б.Энхболд** Доктор, дэд профессор

**Б.Мөнхдорж** Доктор, дэд профессор

**Ц.Одбаяр** Доктор, дэд профессор

**Н.Угтахбаяр** Доктор, дэд профессор

**Г.Буянтогтох** Доктор, дэд профессор

**Ц.Очгэрэл** Доктор

**П.Чимэдцэрэн** Доктор

**JOURNAL EDITORIAL BOARD**

**Editor of the journal:**

**Gantulga S**, Ph.D., Associate professor

**First Secretary:**

**Odkhuu L**

**Secretary:**

**Chingunjav Ts**

**Members:**

**Amarsanaa J**, Academician

**Urjin O**, Sc.D., Professor

**Bat-Erdene B**, Ph.D., Professor

**Zumberellkham D**, Ph.D., Professor

**Eui Gab Hwang**, Ph.D., Professor

**Erdenebaatar D**, Ph.D., Professor

**Kharmaev Yuri Vladimirovich**, Ph.D, Associate professor

**Enkhbold B**, Ph.D., Associate professor

**Munkhdorj B**, Ph.D., Associate professor

**Odbayar Ts**, Ph.D., Associate professor

**Ugtakhbayar N**, Ph.D., Associate professor

**Buyantogtokh G**, Ph.D., Associate professor

**Ochgerel Ts**, Ph.D.

**Chimedtseren P**, Ph.D.

## ГАРЧИГ–TITLE

ХУУЛЬ САХИУЛАХЫН УДИРДЛАГА  
LAW ENFORCEMENT MANAGEMENTТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ БА ИННОВАЦ (ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН  
ЖИШЭЭН ДЭЭР)

DEVELOPMENT AND INNOVATION OF PUBLIC ORGANIZATIONS IN EXAMPLE OF THE POLICE

10

**Ц.Чингүнжав (МРА)**Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн докторант, цагдаагийн ахмад  
**Ts. Chingunjav (MPA)**, Police captain, Ph.D. student of the Executive Management Academy of the University of Internal AffairsГЭМТ ЯВДАЛ СУДЛАЛ  
CRIMINOLOGY

## ЗӨРЧЛИЙН МАТЕРИАЛЛАГ БА ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

A COMPARATIVE STUDY OF SUBSTANTIVE AND PROCEDURAL LEGAL FRAMEWORKS GOVERNING VIOLATIONS

19

**Д.Нямдорж**

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, докторант, цагдаагийн хошууч

**D. Nyamdorj**, Senior Researcher and Lecturer, Center for Crime, Police and Internal Troops Studies, Research Institute, Office of Research and Innovation, University of Internal Affairs of Mongolia; Doctoral Candidate; Police Major

## ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ХИЙМЭЛ ОЮУН АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

THE NECESSITY AND REQUIREMENTS FOR THE USE OF ARTIFICIAL INTELLIGENCE IN INVESTIGATIVE ACTIVITIES

28

**О.Баярсайхан**

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

**O. Bayarsaikhan**, Police captain, Lecturer at the Department of Criminal Investigation Methodology, Police School, University of Internal AffairsХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ХИЙМЭЛ ОЮУНД (AI)  
СУУРИЛСАН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ АШИГЛАХ НЬ

THE APPLICATION OF ARTIFICIAL INTELLIGENCE-BASED TECHNOLOGICAL SOLUTIONS IN COMBATING ILLEGAL LOGGING CRIMES

34

**Б.Энхцогт**

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

**B. Enkhtsogt**, Police Captain, Lecturer at the Department of Criminal Law and Criminology, Police School of University of Internal AffairsХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХЭД НЭЭЛТТЭЙ ЭХ СУРВАЛЖИЙН  
МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛЫН (OSINT) ОНЦЛОГ

METHODOLOGY RESEARCH TO ACCESS THE POTENTIAL AND MODALITIES OF APPLYING OPEN-SOURCE INTELLIGENCE (OSINT) ANALYZING AND COLLECTING IN DATA TO INVESTIGATE CRIME OF HUMAN TRAFFICKING

42

**Д.Мөрөн**

Хууль зүйн доктор, профессор, Монгол Улсын Гавьяат хуульч

**D. Muren**, Honored Lawyer of Mongolia, Doctor (Ph.D), Professor, Police colonel**Ч.Тулгацоодол**

Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналтын улсын байцаагч, Орхон их сургуулийн докторант

**Ch. Tulgatsoodol**, Inspector of Mongolia Immigration Agency, Doctoral of Orkhon University



## ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ БА МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

CERTAIN THEORETICAL ISSUES OF COVERT OPERATIONS IN EXECUTIVE ACTIVITIES AND CRIMINAL INVESTIGATION

52

### С.Буянжаргал

Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн хурандаа

**S. Buyanjargal**, Doctoral Candidate, University of Internal Affairs, Colonel of Police

## САНХҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ТУЛГАМДАЖ БҮЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ

CHALLENGES IN CONDUCTING FORENSIC ANALYSIS IN FINANCIAL CRIME INVESTIGATIONS AND POSSIBLE SOLUTIONS

61

### Э.Сэргэлэн

Дотоод хэргийн их сургуулийн докторант, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

**E. Sergelen**, Ph.D. student at the University of Internal Affairs, Head of the Investigation Division, Department for Combating Economic Crimes, Criminal Police Department, Police Lieutenant Colonel

## ХУУЛЬ БУСААР ЭМ ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОР УРШИГ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE CONSEQUENCES AND CURRENT STATE OF THE CRIME OF COUNTERFEIT DRUG DISTRIBUTION

70

### Р.Сундуйсүрэн

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

**R. Sunduisuren**, Master's student at the University of Internal Affairs

## ХИЛ СУДЛАЛ

LIMNOLOGY

## ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ОЮУН УХААНЫГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

RESEARCH RESULTS ON THE EMOTIONAL INTELLIGENCE OF BORDER GUARD OFFICERS

80

### Б.Нямжав

Доктор (Ph.D), хурандаа, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн эрхлэгч

**B. Nyamjav**, Ph.D. Colonel, Head of the Border Security Research Center, Research Institute

## МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР АЛТ НЭВТРҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

CURRENT SITUATION OF THE CRIME OF ILLEGAL GOLD TRANSPORTATION ACROSS THE BORDER OF MONGOLIA

93

### Д.Мягмарсүрэн

Дотоод хэргийн их сургуулийн докторант

**D. Myagmarsuren**, Doctoral student at the University of Internal Affairs


**ХИЛИЙН ЦЭРГИЙН ОПЕРАТИВ УРЛАГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ОНОЛЫН ҮНДЭС**

THE ORIGINS, DEVELOPMENT, AND THEORETICAL FOUNDATIONS OF BORDER GUARD OPERATIONAL ART

**А.Амгаланбаяр**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

99

**A. Amgalanbayar**, Associate Professor, Department of Border Service Management and Strategy, National Academy of Governance, Lieutenant Colonel

**Б.Баттүвшин**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны магистрант, дэд хурандаа

**B. Battuvshin**, Lieutenant Colonel, Master's student of Class 8022 at the Executive Management Academy, University of Internal Affairs

**ХИЛИЙН БҮСЭД ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ ҮҮССЭН ҮЕИЙН ХАРИЛЦАН АЖИЛЛАГАА**

INTERAGENCY COOPERATION IN BORDER AREAS DURING EMERGENCY SITUATIONS

**А.Амгаланбаяр**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

110

**A. Amgalanbayar**, Associate Professor, Department of Border Service Management and Strategy, National Academy of Governance, Lieutenant Colonel

**Ц.Тамжид**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны магистрант, хошууч

**Ts. Tamjid**, Major, Master's Student, Class No. 8022, Academy of Management, University of Internal Affairs

**УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ГАЗАР ОРНЫ ОНЦЛОГ, БАЙГАЛЬ, ЦАГ УУР НӨЛӨӨЛӨХ НЬ**

THE IMPACT OF GEOGRAPHICAL FEATURES AND CLIMATE ON STATE BORDER PROTECTION

**А.Энхзориг**

118

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, Хилийн цэргийн 0165 дугаар анги, Хилийн төлөөлөгч, зөрчил шалган шийдвэрлэх ахлах ажилтан, ахмад

**A. Enkhzorig**, Master's student of the University of Internal Affairs, Border Guard, Border Guard Unit 0165, Senior Officer for Conflict Resolution, Captain

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ**

COURT DECISION EXECUTION STUDIES

**ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГАА БА ТЕХНОЛОГИЙН УЯЛДАА ХОЛБОО, УЛАМЖЛАЛ**

ENSURING THE SECURITY OF DETENTION FACILITIES: OPERATIONAL AND TECHNOLOGICAL COORDINATION AND DEVELOPMENT

**А.Анхжаргал**

125

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 2024-7051 дүгээр дамжааны магистрант, ахмад

**A. Ankhjargal**, Captain, Master's student of Distance Program No. 2024-7051, Class 403 (Training and Research Division), School of Court Decision Enforcement, University of Internal Affairs

**ГАМШИГ СУДЛАЛ**

DISASTER STUDIES

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО, АНХААРАХ АСУУДАЛ**

DISASTER MANAGEMENT SYSTEM, STAKEHOLDER ROLES AND RESPONSIBILITIES, ISSUES TO BE CONSIDERED

134

**Г.Галбадрах**

Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын докторант

**G. Galbadrakh**, Doctoral student in Disaster Studies at the University of Internal Affairs



## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН РАДИО ХОЛБООНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

### Г.Хатантуул

Онцгой байдлын ерөнхий газрын Холбоо, мэдээллийн технологийн газрын Холбооны төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, докторант, хошууч

**G. Khatantuul**, Senior Specialist, Major, Ph.D Candidate, Federal Planning and Readiness, Comm & Information Technology Department of NEMA 142

### Ц.Ганчимэг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

**Ts. Ganchimeg**, Disaster Risk Management Advisor, World Bank Country Office in Mongolia, Doctor of Security Sciences

## ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖ

POSSIBILITY OF IDENTIFYING FIRE RISK

155

### Э.Батзаяа

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант

**E. Batzaya**, Master's student at the Management Academy, University of Internal Affairs

## ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 66 ДУГААР АНГИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ГАЛ СӨНӨӨГЧДИЙН УР ЧАДВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF THE READINESS AND FIREFIGHTER'S SKILL OF FIRE FIGHTING AND RESCUE UNIT #66

164

### Ц.Балжинням

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

**Ts. Baljinyam**, Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, Captain

## ШИНГЭРҮҮЛСЭН ХИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF LIQUEFIED GAS FIRE SAFETY AMONG EMERGENCY SERVICE PERSONNEL

179

### Б.Баасанхүү

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшиг судлалын магистрант, ахмад

**B. Baasankhuu**, Graduate student of Disaster Studies course No. 7062 of the University of Internal Affairs, Captain

## МОНГОЛ УЛСЫН ОЙ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF FIRE RISK IN FOREST AND LAND AREAS OF MONGOLIA

191

### Ж.Эрдэнэцогт

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

**J. Erdenetsogt**, Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, captain

## ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

LEGAL STATUS OF THE STATE DISASTER CONTROL INSPECTOR

206

### Д.Жамбалдорж

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

**D. Jambaldorj**, Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, captain



### ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН ТАРХСАН ҮЕИЙН АЛБАДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ

INTERAGENCY COORDINATION CHALLENGES IN RESPONSE TO ZONOTIC INFECTIOUS DISEASE OUTBREAKS

215

#### Д.Санжхүү

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

**D. Sanjkhuu**, Captain, Master's Student, School of Emergency Management, University of Internal Affairs

### ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН АХЛАГЧ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ХООРОНДЫН ИТГЭЛЦЛИЙН СУДАЛГААНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF A STUDY ON TRUST AMONG THE LEADERSHIP MEMBERS OF THE NATIONAL EMERGENCY MANAGEMENT AGENCY OF MONGOLIA

224

#### Б.Мөнхтуул

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахлах дэслэгч

**B. Munkhtuul**, Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, senior lieutenant

### ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН УР ЧАДВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS OF FIRE SAFETY STATE INSPECTORS' PROFESSIONAL SKILLS

232

#### Д.Тэгшбаяр

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахлах дэслэгч

**D. Tegshbayar**, Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, first lieutenant

### ЗҮҮН БҮСИЙН УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

AN ANALYSIS OF THE CURRENT STATUS OF STATE RESERVE DEVELOPMENT IN THE EASTERN REGIO

247

#### А.Даваасүрэн

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

**A. Davaasuren**, Lieutenant, Master's Student, School of Emergency Management, University of Internal Affairs

### ИРГЭДИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙН АСУУДАЛ

METHODOLOGICAL ISSUES ON DISASTER PROTECTION TRAINING FOR CITIZENS

#### О.Шинэтунгалаг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

**O. Shinetungalag**, Lieutenant, Master's student School of Emergency Management, University of Internal Affairs

257

#### Н.Отгонцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

**N. Otgontseteg**, Lieutenant, Master's student School of Emergency Management, University of Internal Affairs



## УЛСЫН НӨӨЦИЙН БАРАА ХАДГАЛАЛТЫН ЛОГИСТИКИЙН ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

DEVELOPMENTAL CONSTRAINTS AND KEY CHALLENGES IN THE LOGISTICS OF STATE RESERVE GOODS STORAGE

269

### Б.Бат-Эрдэнэ

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн гамшиг судлалын магистрант, дэслэгч

**B. Bat-Erdene**, Lieutenant; Master's Student in Disaster Studies, Emergency Management School, University of Internal Affairs, Mongolia

## ЭРХ ЗҮЙ СУДЛАЛ LEGAL STUDIES

### ВИРТУАЛ ХӨРӨНГӨ (КРИПТОВАЛЮТ)-ИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

LEGAL REGULATION OF VIRTUAL ASSETS (CRYPTOCURRENCY)

280

### Б.Лхагварагчаа

Дотоод хэргийн их сургуулийн Гадаад хэлний институтийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хошууч

**B. Lkhagvaragchaa**, University of Internal Affairs Director of the Institute of Foreign Languages, Doctor (Ph.D.), Associate Professor, Police Major

### БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН ОРОС ЗҮГИЙН ХАРУУЛЫН АЛБАНЫ ТУХАЙ

CONCERNING THE RUSSIAN GUARD SERVICE DURING THE PERIOD OF AUTONOMY

289

### Л.Одзаяа

Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийгмийн ухааны тэнхимийн ахлах багш, хошууч

**L. Odzaya**, Senior lecturer at the Department of Social Science, School of Law, UIA, major

### МОНГОЛ УЛС ДАХЬ СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

THE HISTORICAL TRADITION OF COMBATING CRIMES AGAINST CULTURAL HERITAGE IN MONGOLIA

298

### Ц.Түвшинжаргал

Дотоод хэргийн их сургуулийн докторант

**Ts. Tuvshinjargal**, Doctoral student of the University of Internal Affairs, Mongolia

## ХУУЛЬ САХИУЛАХУЙН БОЛОВСРОЛ СУДЛАЛ LAW ENFORCEMENT EDUCATION STUDIES

### БАГШ, АЛБАН ХААГЧДЫН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН ТҮВШИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

CURRENT LEVEL OF PHYSICAL FITNESS OF TEACHERS AND STAFF AND WAYS TO IMPROVE IT

307

### Д.Түмэнцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Биеийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, ахлах дэслэгч

**D. Tumentsetseg**, Senior Lieutenant, Lecturer, Institute of Physical Training and Professional Development, University of Internal Affairs

**"АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААН" СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ**

## ANALYSIS OF THE CONTENT OF THE "SAFE LIVING SKILLS" TRAINING PROGRAM

**Н.Отгонцэцэг**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

**N. Otgontsetseg**, Professor of the Disaster protection department of the Disaster emergency Master's student at the Emergency management school, University of Internal Affairs, Mongolia

312

**О.Шинэтунгалаг**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

**O. Shinetungalag**, Professor of the Disaster protection department of the Disaster emergency Master's student at the Emergency management school, University of Internal Affairs, Mongolia



АЮУЛГҮЙ АМЬДРАХ  
УХААН

## ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖИЛ БА ИННОВАЦ (ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЖИШЭЭН ДЭЭР)

### DEVELOPMENT AND INNOVATION OF PUBLIC ORGANIZATIONS IN EXAMPLE OF THE POLICE

#### Ц.Чингүнжав (МРА)

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн докторант, цагдаагийн ахмад

#### Ts. Chingunjav (MPA)

Police captain, Ph.D. student of the Executive Management Academy of the University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: chingunjav.ts@gmail.com

**Хураангуй:** Хөгжил нь хүн төрөлхтний мөнхийн сэдэв төдийгүй түүнийг тодорхойлох онол, хандлага, чиглэл нь тухайн нийгэм, цаг хугацааг даган өөрчлөгдсөөр ирсэн. Яг үүнийг “хөгжил” гэнэ хэмээх утга төгөлдөр тодорхойлолтыг эцэслээгүй ч өнөөдрийг хүртэл бид хөгжлийг тодорхойлох оролдлого хийсээр байна. Улс орны, байгууллагын, хувь хүний гэсэн ерөнхий 3 түвшинд хөгжлийг авч үзэж болох ба эцсийн дүндээ хүний хөгжлийг эн тэргүүнд авч үзсэн улс хөгждөг жамтайг олон жишээ харуулсан. Гэхдээ энэ удаагийн сэдвийн хүрээнд хүний хөгжлөөс илүүтэй байгууллагын хөгжил тэр дундаа төрийн байгууллагын хөгжлийг инновацтай хослуулан авч үзсэн ба цагдаагийн байгууллагын жишээн дээр уг асуудлыг судлан шинжилсэн болно.

**Abstract:** Development is not only an eternal theme of mankind, but the theory, attitude and direction of defining it have been changing according to society and time. Even today, we are still trying to define development, even though we have not finalized the definition of the perfect meaning of "development". Many examples have shown that development can be considered at 3 general levels: country, organization, and individual. However, within the framework of this topic, rather than human development, the development of the organization, including the development of the public organization combined with innovation, was considered, and the issue was analyzed on the example of the police.

**Түлхүүр үгс:** Байгууллагын хөгжил, инновац, менежмент, хөгжил, өөрчлөлт

**Keywords:** Organizational development, innovation, management, change

#### Нэг. Байгууллагын хөгжлийн асуудал

Дэлхийн нийтийн хөгжил түүхэн хугацаанд чанарын шинэ түвшинд гарч өөрийн эерэг нөлөөг үзүүлж байгаа ч нэлээдгүй тохиолдол бидний нийгэмд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, хүний амьдрах орчны бохирдол, хүмүүс хоорондын харилцаа явцуурах,

мэдрэл-сэтгэцийн ачаалал нэмэгдэн, байнга яарч сандарсан байдал “соёл иргэншлийн өвчин” үүсгэж байна. Энэ нь хүнийг танихдаа олон арга хэрэглэж, нэг арга, хандлагыг баримталж туйлшрахгүй байхыг нөхцөлдүүлж байна. (Ганбаатар, 2020, хууд. 12) Үүнийг даван туулж, хөгжлийн дараагийн шатанд гарахын тулд бид



хөгжлийн тухай илүү сайтар ойлгож, судлан хөгжилд нөлөөлөх хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох хэрэгцээ шаардлага үүссээр байна.

Хөгжлийн категорийг авч үзвэл:

• Хөгжил бол аливаа өөрчлөлтийн цогц;

• Бодит системийн бүтэц, элементийн бүрэлдэхүүний өөрчлөлт;

• Хөгжил бол чанарын өөрчлөлт;

• Хөгжил бол буцалтгүй шинжтэй.

Хөгжлийг улс орны, байгууллагын, хувь хүний гэсэн ерөнхий 3 түвшинд авч үзэж болох ба эцсийн дүндээ хүний хөгжлийг эн тэргүүнд авч үзсэн улс хөгждөг жамтайг олон жишээ харуулж ирсэн.

Хөгжил нь тогтвортой шинжээ хадгалахын тулд гадаад орчныхоо нөлөөнд үл автан, аль нэг тийшээ гажиж болох боловч түүнийг анхны төлөв байдлаа сэргээх чадвартай байх зарчмыг байгууллагын хөгжлийн удирдлагын гол зорилго хэмээн үзэж болно.

Доктор Д.Бямбасүрэнгийн дэвшүүлсэн “Хэрэглэгчээр нийлүүлэлтийг жолоодох зэх зээлийн зохицуулалт хөгжлийг төрүүлэх чадвар илүүтэй” (Бямбасүрэн, 1994) гэсэн дүгнэлт нь байгууллагын хөгжлийн удирдлагын үндсэн зарчмын агуулгыг гаргаж ирэхэд зохих хэмжээгээр тус дөхөм болсон.

Америкийн судлаач В.Г.Беннис “Байгууллагын хөгжил гэдэг нь технологи, зах зээл, нөхцөлд зохицон байгууллагын бүтэц, үнэт зүйл, хандлага, итгэл үнэмшлээ өөрчлөхөд чиглэсэн сурч, боловсрох стратеги.” (Bennis, 1989, p. 2) гэж дүгнэснийг статик байдлаа хадгалах үйл ажиллагааны стратеги гэдгээр ойлгож болох юм.

Харин Австралийн эрдэмтэн Дж.Хант байгууллагын хөгжлийг “сурч

боловсрох үйл явц” (Blake & Mouton, 1982) гэжээ. Тэрээр байгууллагын бүтэц, үнэлэмж, байр суурь, хүмүүс хоорондын харилцааг шинэчлэх боловсролын арга, ажиллагаа гэдгийг тэмдэглэсэн нь “хөгжил бол процесс” гэсэн агуулгатай юм. Мэдээж олонх төрийн, төрийн бус, ашгийн болон ашгийн бус зэрэг олон төрөл, хэлбэрийн байгууллагын хувьд гадаад орчин нь урьдчилж төсөөлөхийн аргагүйгээр хувьсан өөрчлөгдөж байдаг. Энэхүү өөрчлөлтөд дасан зохицохын тулд байгууллага шинэ сорилт, бүтцээ тодорхойлох шаардлага үүсдэг. Уг өөрчлөлтөд уян хатан хандлага, зохион байгуулалтын бүтэц, байгууллагын нээлттэй уур амьсгал, үнэт зүйл, хандлагын төвшин өндөр байх, удирдлагын арга барил зэргийг ойлгож болдог.

Байгууллагын хөгжлийн тухай судлаачдын өгсөн тодорхойлолтуудад ихэвчлэн орчны нөлөөлөл, өөрчлөлтийг харгалзан удирдлагаас байгууллага, хамт олноо хэрхэн удирдан жолоодох тухай өөр өөрийн үзэл баримтлал, саналыг дэвшүүлсэн нь тодорхой харагдаж байна. Байгууллагын хөгжлийг тодорхойлох олон янзын тодорхойлолт хандлага байгаа хэдий ч үндсэндээ байгууллагыг зорилтоо биелүүлж, зорилгодоо хүрэх, тасралтгүй үр дүнтэй ажиллахад бүхий л оновчтой онол, хандлага хэрэг болно хэмээн судлаач миний бие үзэж байна.

Байгууллагын хөгжлийг хангах зорилт, хэрэгжүүлэх арга замыг сонгох үйл явц нь үндсэн 3 үе шатаас тогтдог байна. Үүнд: 1) Байгууллагын үйл ажиллагаа, хандлага, зан байдлын талаар мэдээлэл цуглуулах, 2) Олж авсан мэдээллийг хэсэгчилсэн байдлаар ашиглах эргэх холбоог бий болгох, 3) Удирдлага шийдвэр гарган төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэх гэсэн гурван үе шат багтана. Тэгвэл төрийн





байгууллага уг үе шатын дагуу өөрийн хөгжлийг бий болгох, тасралтгүй суралцаж, эерэг өөрчлөлтөд дасан зохицож байх нь тухайн улсын хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм.

Байгууллагын хөгжлийн тухай бүхий л салбарт ярьж болох хэдий ч уг асуудал нь менежментийн шинжлэх ухааны чухал асуудал тул байгууллагын хөгжлийн тухай онолуудыг хөгжлийн тулгуур асуудалтай холбон хүнийг удирдлагын төвд тавьж, байгууллагыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжил, дэвшилтэй нийцүүлэн удирдах шаардлагатай. Тэр дундаа төрийн байгууллагын хөгжлийн асуудал нь тасралтгүй суралцах, хөгжих байгууллагын загварт байх нь илүү үр ашигтай юм.

Нөгөө талаас орчин цагийн буюу шинэ зууны байгууллагууд төр, төрийн бус, ашиг, ашгийн бус байхаас үл шалтгаалан ялгаагүйгээр нийтлэг нэг хөгжлийн үзэл баримтлал, удирдлагын хүлээн зөвшөөрөгдсөн зарчмыг авч хэрэгжүүлэхийн чухлыг судлаач, эрдэмтэд зарим талаар хүлээн зөвшөөрч байна. Үүнийг өндөр хөгжилтэй улс орнуудын аль ч байгууллагын ажлын туршлага, практик алхмууд тодорхой харуулж байна.<sup>1</sup>

Байгууллагын хөгжлийн тухай ярихад менежментийн асуудал хөндөгдөх ба менежментийн шинжлэх ухааны хөгжил нь байгууллагын хөгжлийг дараагийн шатанд гаргаж байна. Учир нь менежментийн

шинжлэх ухааны гол судлагдахуун, объект нь байгууллага, түүний хөгжил юм. Менежментийг Мери Паркер Фоллет<sup>2</sup> “*Менежмент бол хүмүүсээр ажил бүтээлгэх урлаг*” хэмээн тодорхойлсон бол XX зууны менежментийн эцэг гэгддэг Петр Дракер “*Менежерүүд байгууллагынхаа хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, зорилгодоо хүрэхийн тулд манлайлагчийн байр суурьтай байж, нөөцүүдийн ашиглалтын талаарх шийдвэр гаргадаг*” гэжээ. (Д. Ганбаатар, Я. Шуурав, Д. Сэржамц, 2019, хууд. 24) Уг хоёр тодорхойлолтоос харвал менежмент урлаг гэх ойлголтоос шинжлэх ухаан болж, сүүлийн 100 орчим жил хөгжихөд үүнийг даган байгууллагын хөгжлийн тухай ойлголт, хамрах хүрээ мөн өргөжсөн байна.

Түүнчлэн “менежмент гэдэг байгууллагын зорилт, түүнд хүрэх замыг нарийн төлөвлөж, нөөцүүдийн ашиглалтыг оновчтой зохион байгуулж, хүмүүсээ идэвхжүүлэн манлайлж, улмаар ажлын үр дүнг үнэлэн хяналт тавих үйл ажиллагаануудын нэгдэл юм.” хэмээх тодорхойлолтоос байгууллага нь бүхэл бүтэн систем ба түүнийг хөгжлийг ярих нь системтэйгээр уг асуудалд анхаарал хандуулах ёстой хэрэгцээ шаардлагыг илтгэж байна.

### Хоёр. Инновацын удирдлага

Шинийг сэтгэж олохыг бүтээлч сэтгэлгээтэй, шинийг санаачлагч гэдэг. Энэ бол өмнөхөөсөө тэс өөрөөр бодох, сэтгэх үйл ажиллагаагаа явуулах, хариу

<sup>1</sup> АНУ, Швед, Германы төрийн байгууллагын шинэчлэл, тэргүүлэх компаниудын удирдлагын зарчим үүний бодит жишээ болж байна. (Ганбаатар, 2020, хууд. 23)

<sup>2</sup> Мери Паркер Фоллет (1868-1933) нь АНУ-ын менежментийн зөвлөх,

нийгмийн зүтгэлтэн, философич, байгууллагын зан үйл судлалын анхдагч бөгөөд менежментийн шинжлэх ухааны “Хүмүүнлэгийн сургууль”-ийн анхны төлөөлөгч юм. (Wikipedia, 2023)

үйлдэл үзүүлэх, хийж бүтээх явдал юм. (Хэрлэн, 2019, хууд. 95) Тодруулбал, бүтээлч байдал гэж шинэ, хэрэг болох санаа гаргах аливаа үйлдлийг хэлдэг бол инновац гэж тэрхүү шинэ санааг ажил хэрэг болгон зохион байгуулахыг хэлдэг байна.

Үүгээр зогсохгүй инновацийн дэлгэрэнгүй тодорхойлолтыг авч үзвэл:

Инновац нь чухал зэрэг өөрчлөлтийг авчирдаг шинэ санаа, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл явцыг бий болгох, хөгжүүлэх, хэрэгжүүлэх үйл явц ба тулгамдаж буй асуудлуудад бүтээлч шийдлийг олох, хангагдаагүй хэрэгцээ, шийдвэрлэгдээгүй асуудлыг шинэ арга замаар шийдвэрлэх явдал юм. Инновац нь технологи, бизнес, шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн зэрэг олон салбарт яригдаж, хэрэгжиж байна.

Инновацийн тухай хуулиас харвал тус хуулийн “3.1.1. “инновац” гэж шинэ мэдлэгийг баялаг болгон хувиргах үйл ажиллагааны үр дүнд бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, маркетинг, зохион байгуулалтын арга, шийдлийг” хэлнэ гэжээ. (Инновацийн тухай хууль, 2012)

Түүнчлэн инновацийн төрөл, хэлбэрүүд байх ба инновац нь дараах төрөлтэй байна. Үүнд: 1) Product Innovation буюу Бүтээгдэхүүний инновац, 2) Process Innovation буюу Үйл явцын инновац, 3) Service Innovation буюу Үйлчилгээний инновац, 4) Business Model Innovation буюу Бизнес загварын инновац, 5) Social Innovation буюу Нийгмийн инновац, 6) Open Innovation буюу Олон талт оролцогчдын оролцоонд

тулгуурласан нээлттэй инновац зэрэг төрөлтэй байна.

Сингапурын Үндэсний их сургуулийн профессор Зегер ван дер Вал (Zeger van der Wal)<sup>3</sup> инновацийн тухай авч үзэхдээ төрийн байгууллагад үндсэндээ таван янзын инновац хийгддэг хэмээжээ. Тодруулбал:

- **Үйл явцын инновац** - техникийн шинэчлэл, боловсон хүчний сургалт, хууль дүрмийг цөөлөх, ажлын урсгалыг түргэсгэх, ажлын шинэ арга замыг нэвтрүүлэх гэх мэт байгууллагын дотоод, гадаад үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд захиргааны, удирдлагын, технологийн буюу ажлын процесст хэрэгжүүлэх шинэ санаа, санаачилга үүнд багтана.

- **Бүтээгдэхүүн ба үйлчилгээний инновац** - иргэдэд ая таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн эсвэл тухайн цаг үеийн нөхцөл байдлын хэрэгцээ шаардлагын улмаас бий болгож байгаа төрийн шинэ үйлчилгээ, бүтээгдэхүүн, цахим засаглалын шийдлүүд гэх мэт.

- **Засаглалын инновац** - гол төлөв олон салбарын оролцоотой шийдэгдэх нийгмийн тодорхой асуудлыг шийдвэрлэхийн тулд үйл ажиллагааны шинэ хэлбэр, бүтэц, зохион байгуулалт, зохицуулалт, үйл явцуудыг гаргаж ирэх гэх мэт.

- **Үзэл баримтлалын инновац** - асуудлыг тодорхойлох, түүний шийдлийг олох санаа, үзэл баримтлалын хүрээг өөрчлөх. Жишээлбэл, орчин үеийн хотжилтын олон асуудлыг өөрөөр харж шийдэх “ухаалаг хот” санаа гэх мэт.

- **“Аман дээрх” инновац** - бодит асуудлыг нуун дарагдуулах, халхавчлах зорилгоор арга хэмжээ авч

<sup>3</sup> Prof. dr. Zeger van der Wal is Professor by Special Appointment at the Faculty of Governance and Global Affairs, Leiden University, the Netherlands, and Senior

Fellow at the Lee Kuan Yew School of Public Policy of the National University of Singapore (NUS).





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠢᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ ᠤᠳᠢᠷᠳᠠᠯᠭ᠎ᠠ

байгаа, өөрчлөлт хийгдэж байгаа гэх мэтээр оролцогч талуудад хэлж амлах нь үүнд багтана. (Хэрлэн, 2019, хуудсд. 96-97)

### Гурав. Төрийн байгууллагын хөгжилд инновацын гүйцэтгэх үүрэг

Төрийн байгууллага, алба хаагчдын үйл ажиллагаа залгамж чанартай явагдах хэдий ч уг үйл ажиллагаа нь тасралтгүй шинэ мэдлэг, ухаанд суурилж, хөгжиж, бага багаар өөрчлөгдөж, өөрчилж, заримдаа төрийн бодлого шийдвэрийн дагуу суурь шинжтэй шинэчлэлийг хийсээр ирсэн. Дэлхийн нийтэд тэр дундаа барууны зарим улсууд 1990 оноос хойш улсын салбарын шинэ удирдлагын үзэл баримтлалд тулгуурласан төрийн байгууллагыг удирдах шинэ үзэл баримтлал, ажиллах арга барилыг нэвтрүүлж, радикал шинжтэй өөрчлөлтүүдийг хэрэгжүүлсэн. Тодруулбал, төрийн байгууллагын үйл ажиллагааг оновчтой болгохоос эхлээд илүү гүнзгий үзэл бодлыг хувьсган өөрчлөх радикал шинэчлэл хийгдэж байна.

Төрийн байгууллагын хөгжилд анхаарал хандуулж, инновац нэвтрүүлэх нь цоо шинэ зүйл биш бөгөөд гагцхүү уг нэр томъёоны хэрэглээ өдрөөс өдөрт өргөжиж, үүнийг дагасан эерэг өөрчлөлтүүд хийгдсээр байна. Тодруулбал, цаашид илүү мэргэжлийн түвшинд, төрийн байгууллагын үндсэн чиг үүргийг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэж, хөгжлийн түүчээ болсон загварт суурилсан менежментийг илүү оновчтой авч явах асуудал нь чухал байна.

Төрийн албаны тухай хуулийн 5.1-д “Төрийн албаны эрхэм зорилго нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэхэд оршино.” хэмээн заасан байдаг. (Төрийн албаны тухай хууль, 2019) Үүнээс төрийн байгууллагын хөгжил нь ард түмэнд үйлчлэхэд чиглэгдэж буй тул цаг үедээ нийцэн, зарим тохиолдолд түүчээ болж хөгжих, инновац нэвтрүүлэх хэрэгцээ байгааг сайтар ойлгох нь чухал юм.

Төрийн байгууллага гэх тодорхойлолтод багтах төрийн захиргааны, тусгай, үйлчилгээний<sup>4</sup> байгууллагууд өөр өөрийн гэсэн онцлог, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлогтой хэдий ч үндсэн утгаараа тасралтгүй инновац нэвтрүүлж байхад ач холбогдол өгөх хэрэгцээ шаардлага өдрөөс өдөрт бий болж байна.

Судлаач миний бие төрийн байгууллагуудаас цагдаагийн байгууллагыг сонгон авч инновац нэвтрүүлж буй талаар болон инновацыг тасралтгүй нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойллоо.

Цагдаагийн албаны тухай хуулийн 4.1-д “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн.” заасан байдаг. (Цагдаагийн албаны тухай хууль, 2017) Тэгэхээр цагдаагийн байгууллагын хөгжил гэдэг угтаа цагдаагийн албаны хөгжлийн тухай асуудал юм. Тус байгууллагын хөгжил,

<sup>4</sup> Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйл. Төрийн албаны ангилал 6.1. Төрийн албыг доор дурдсанаар ангилна:

6.1.1. төрийн улс төрийн алба;  
6.1.2. төрийн захиргааны алба;  
6.1.3. төрийн тусгай алба;  
6.1.4. төрийн үйлчилгээний алба.

үйл ажиллагаанд инновац нэвтрүүлэх нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэгт чиглэнэ.

Гэмт хэрэгтэй тэмцэх гэдэг нь *“гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, мөрдөн шалгах зорилгоор хуульд заасан ажиллагаа явуулахыг”* хэлнэ хэмээн Цагдаагийн албаны тухай хуульд заасан байдаг. Тэгэхээр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах үйл ажиллагаанд тасралтгүй инновац нэвтрүүлэх нь Монгол Улсын дотоод аюулгүй байдлыг хангах, ард иргэд амар тайван амьдрахад ихээхэн ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 4.2 дугаар зүйлийн 4.2.2-ын Тайлбар хэсэгт *“хууль сахиулагч гэж цагдаа, тагнуул, авлигатай тэмцэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно.”* (Эрүүгийн хууль, 2015) хэмээн заасан нь цагдаагийн байгууллага хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллага гэдэг тодорхойлолт үүнээс тодорхой харагдана.

Олон улсад хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагууд техник, технологийн дэвшил, компьютер, хиймэл оюун ухааны хөгжил зэрэгт суурилсан үйл ажиллагааны болон техникийн инновацыг тасралтгүй нэвтрүүлж байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэхэд ихээхэн ахиц гаргаж байгааг олон жишээ харуулдаг.

Энэ нь зөвхөн машин техник, камерын хяналт, мэдээллийн сангаар хязгаарлагдахгүй бөгөөд богино хугацаанд өндөр гүйцэтгэл гаргахад чиглэгдсэн бүхий л үйл ажиллагаа хамаарах юм.

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар цагдаагийн байгууллагууд гэмт хэрэгтэй тэмцэх хэд хэдэн үр дүнтэй аргуудыг ашиглаж байна. Эдгээрээс дурдвал:

1. *“CompStat буюу Компьютерын статистик”-ыг ашиглах:* Энэ нь гэмт хэргийн хэв маяг, чиг хандлагыг хянах, асуудлыг тодорхойлох, цагдаагийн стратегийн үр нөлөөг хэмжихэд өгөгдөл, аналитик ашигладаг удирдлагын хэрэгсэл юм. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын цагдаагийн байгууллага “Т-21” системийн динамик загварчлалын тусламжтайгаар 2040 он хүртэлх гэмт хэргийн гаралтыг таамаглаж чадаж байгаа ба үүнийг илүү боловсронгуй болгох, шаардлагатай санхүүгийн нөөцийг шийдвэрлэх нь нэн чухал байна.

2. *Орчны (хүрээлэн буй орчин) дизайнаар дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх:* Энэ нь гэмт хэрэг, зөрчлийг бууруулахын тулд нийтийн орон зайд физик, дизайн, менежментийг ашигладаг олон талт арга юм. Өөрөөр хэлбэл гэмт хэрэгтнүүдэд боломж олгохгүй, иргэдэд илүү сонирхолтой байхаар олон нийтийн орон зайг бий болгох буюу хот, тосгоныг төлөвлөх, удирдах явдал юм. Үүнд цагдаагийн байгууллага, бусад төрийн байгууллага, хувийн хэвшилтэй хамтарч ажиллах нэн шаардлагатай.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх газрын (UNODC) мэдээллээр Норвегт 2020 онд 100,000 оршин суугч тутамд 2900, Финлянд улсад 2019 онд 100,000 оршин суугч тутамд 3000 орчим гэмт хэрэг ногдож байна гэжээ. Харин Дэлхийн банкны мэдээгээр 2019 онд Монгол Улсын гэмт хэргийн түвшин дунд зэрэг буюу 100,000 хүнд 3400 орчим байгаа тухай дүн мэдээнээс үзвэл технологийн боломжуудыг ашиглахгүйгээр,





ᠬᠤᠠᠳᠠᠭᠠᠳᠠᠨ ᠣᠷᠴᠢᠨ

материаллаг нөөцөд хөрөнгө оруулалт зарцуулахгүйгээр гэмт хэргийг бууруулах боломжгүй нь тодорхой болж ирнэ.

Түүнчлэн түгээмэл хэрэглэгдэж буй хэд хэдэн технологи, программ хангамжуудыг судалж үзвэл: 1) Бүртгэлийн удирдлагын систем (RMS)-ийн хөгжүүлэлтийг тасралтгүй хийх, 2) Биедээ зүүдэг камерууд нь шүүхэд нотлох баримт бүрдүүлэх, албан тушаалтны зан үйлийг хянахад тустай тул үүний нөөцийг хангалттай хэмжээнд бүрдүүлэх, 3) Автомашин дугаар таних (LPR) системийг төвийн цэгүүдэд байршуулж, нэвтрүүлэх нь хулгайд алдсан тээврийн хэрэгслийг таних, эрэн сурвалжлагдаж буй сэжигтнийг илрүүлэх зэрэгт тустай тул эдгээр систем, технологийг цагдаагийн байгууллага нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн байгааг олон тооны судалгаа харуулж байна.

Тодруулбал, 2021 онд нийт 1,471 алба хаагчийг хамруулсан судалгааны “Шийдвэрлэх асуудалд санал өгсөн байдал”-ыг авч үзвэл судалгаанд оролцсон нийт алба хаагчдын 52.3 хувь

нь “Ажиллах орчны тоног, төхөөрөмжийг нэмэгдүүлэх, орчин нөхцөлийг сайжруулах”, 31.8 хувь нь “Ажлын ачааллыг тэнцвэржүүлэх” хэмээн хариулсан байна. Эндээс цагдаагийн байгууллага нь техник, технологийн болон үйл ажиллагааны инновацыг цагдаагийн байгууллагад нэвтрүүлэх хэрэгцээ байгааг тодорхой түвшинд харах боломжтой.

Менежментийн шинжлэх ухаанд байгууллагыг бүхэл бүтэн систем хэмээн үзэж, байгууллагын хөгжлийг бүтэн зурагласан онол бол Системийн онол юм. Энэ үүднээс авч үзвэл бид байгууллагын хөгжилд хөрөнгө оруулах, инновац нэвтрүүлэх үндсэн арга бол гарцад суурилсан, үр дүнд чиглэсэн нөөцийг бүрдүүлэх, түүнийг зөв хуваарилах тухай асуудал юм. Тодруулбал, төрийн байгууллагын хөгжилд инновац нэвтрүүлнэ гэдэг нэг талаар техник, технологийн нөөцийг хангалттай бүрдүүлэх, үйл ажиллагааны инновацыг нэвтрүүлэх замаар системийг илүү боловсронгуй болгох боломжтойг ойлгох хэрэгтэй.

## ГАДААД ОРЧИН



## ГАДААД ОРЧИН

Зураг 1. Байгууллагын нээлттэй систем  
Эх сурвалж: (Д. Ганбаатар, Я. Шуурав, Д. Сэржамц, 2019)

Байгууллага бол нарийн төвөгтэй, нээлттэй систем бөгөөд өөртөө харилцан уялдаа бүхий дэд системүүдийг багтаадаг ба үүнийг менежментийн түрүү үеийн сургуулиуд тухайлан ажиглаагүй, зөвхөн тус тусын боловсруулсан үзэл бодлын дагуух дэд системүүдэд анхаарлаа төвлөрүүлж ирснийг Системийн онол илүү тодорхой болгосонг анхаарч үзэж, төрийн байгууллагын хөгжлийг системтэйгээр зураглах хэрэгтэй.

### Дүгнэлт

Дэлхийн улс орнуудын хөгжил, нөхцөл байдал нэн ялгаатай байдгийг бид мэднэ. Нэг хэсэг улс орон өндөр хөгжилтэйд тооцогдож байхад зарим улс орон ядуу, буурай гэх ангилалд байна. Энэ нь тухайн улс орны улс төр, эдийн засаг, хүн ам зүй зэрэг олон хүчин зүйлтэй холбоотой ч өөрийн өвөрмөц түүх, соёл, үнэт зүйл, ёс уламжлалын дэвшилттэй бүхнийг шингээсэн менежментийн ухаан, арга барилын цогц нэгдэл болох менежментийн буюу байгууллагын өөрийн гэсэн хэв маяг (загвар) бүрэлдэн тогтож, төлөвшөөгүйтэй холбон тайлбарлах боломжтой. (Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав, Х. Пүрэвдагва, Ц. Цэцэгмаа, Н.О. Лизунов, Л. Цэрэнчимэд, Д. Оюунчимэг, 2013, хууд. 529)

Бид улс орныг, салбарыг, байгууллагыг, нэгжийг удирдахдаа дэд системүүдийг удирдаж буй мэт боловч тухайн нэгж, байгууллага, салбар, улс орныг нэг бүхэл том систем хэмээн зураглаж, асуудалд системийн онолын үүднээс хандаж, хамтдаа ажиллах зарчмыг баримтлах аваас бүтээмж дээшилж, гарц буюу үйл ажиллагааны үр дүн, үр ашиг, үр өгөөж нэмэгдэх бүрэн боломжтой.

Өөрөөр хэлбэл баг, бүлгийн үйл ажиллагаа нь дэд системийн үйл

ажиллагаа төдийгүй нөгөө талдаа бүхэл системийн эд эс, элемент учраас том системийг ажиллуулахад хүн бүрийн хүчин чармайлт, ажил үүргийн хуваарилалт, гүйцэтгэл, үр дүн чухал юм.

Төрийн байгууллагын хөгжил нь хувийн хэвшлийн байгууллагын хөгжилтэй уялдан цаг ямагт өөрчлөлт, шинэчлэлтэд тэмүүлж байх ёстой ба үүнд инновац ихээхэн чухал үүрэгтэй цаг үед бид амьдарч байна.

Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэх, хууль сахиулах байгууллага болох цагдаагийн байгууллага нь хүний нөөцийн хувьд, технологийн хувьд, бүтэц, зохион байгуулалтын хувьд илүү ахисан түвшинд байж гэмээн гэмт хэрэгтэй тэмцэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журам хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох нөхцөл бүрдэнэ. Энэ нь улс орны дотоод аюулгүй байдал, хүн ам, ард иргэдийн амар тайван амьдралд нэн чухал ач холбогдолтой юм.

Иймд бид төрийн байгууллагын хөгжил, тэр дундаа цагдаагийн байгууллагын хөгжилд онцгойлон ач холбогдол өгч, техникийн болон үйл ажиллагааны инновацыг тасралтгүй нэвтрүүлэх хэрэгцээ шаардлагыг цаг ямагт мэдэрч, менежментийн шинжлэх ухааны чиг баримжаатай хөгжих нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

### Санал

Төрийн байгууллага тэр дундаа цагдаагийн байгууллагын цаашдын хөгжлийг зураглахдаа хэлбэрийн төдий бус, шинжлэх ухаанчаар асуудалд бодитоор хандаж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ард иргэдийн амар тайван амьдралд бодитой хувь нэмэр оруулахуйц хөгжлийн зураглалтай





болж, үүндээ хүрэхийн тулд тасралтгүй техникийн болон үйл ажиллагааны инновацыг нэвтрүүлэх саналыг дэвшүүлж байна.

### Ашигласан материал

#### I. Ном, сурах бичиг

1. Bennis, W. G. (1989). *Organization development: Its Nature, Origins and Prospects*. The University of Michigan: Addison-Wesley Publishing Company.
2. Blake, R. R., & Mouton, J. S. (1982). *Building a Dynamic Corporation through Grid Organization Development*. Texas.
3. Бямбасүрэн, Д. (1994). *Орчлонгийн хүрд*. Улаанбаатар: -.
4. Ганбаатар, Д. (2020). *Байгууллагын хөгжил, өөрчлөлтийн удирдлага*. Улаанбаатар: Арилдал ХХК.
5. Д. Ганбаатар, Я. Шуурав, Д. Сэржамц. (2019). *Менежмент*. -Уб: Сэлэнгэпресс ХХК.
6. Н.Цэнд, Г.Батхүрэл, Я.Шуурав, Х. Пүрэвдагва, Ц. Цэцэгмаа, Н.О. Лизунов, Л. Цэрэнчимэд, Д. Оюунчимэг. (2013). *Менежмент*. -Уб: Голден Ай Принтинг ХХК.
7. Хэрлэн, Б. (2019). Төрийн байгууллагын инновац ба соёл.

*Удирдахуйн онол, практикийн асуудлууд*, 95.

#### II. Хууль, эрх зүйн баримт бичиг

8. Инновацын тухай хууль. (2012). Улаанбаатар.
9. Төрийн албаны тухай хууль. (2019). Улаанбаатар.
10. Цагдаагийн албаны тухай хууль. (2017). Улаанбаатар.
11. Эрүүгийн хууль. (2015). Улаанбаатар.

#### III. Интернэт эх сурвалж

12. Wikipedia. (2023 оны 2 27). *Wikipedia*. Wikipedia: [https://en.wikipedia.org/wiki/Mary\\_Parker\\_Follett-ээс\\_Гаргасан](https://en.wikipedia.org/wiki/Mary_Parker_Follett-ээс_Гаргасан)
13. Wikipedia. (2023 оны 2 7). *Wikipedia*. Wikipedia: [mn.wikipedia.org/wiki/менежмент-ээс\\_Гаргасан](https://mn.wikipedia.org/wiki/менежмент-ээс_Гаргасан)
14. Wikipedia. (2023 оны 2 7). *Wikipedia*. Wikipedia: [https://en.wikipedia.org/wiki/Frank\\_Bunker\\_Gilbreth-ээс\\_Гаргасан](https://en.wikipedia.org/wiki/Frank_Bunker_Gilbreth-ээс_Гаргасан)
15. Wikipedia. (2023 оны 3 31). *Wikipedia*. Wikipedia: [https://en.wikipedia.org/wiki/Lillian\\_Moller\\_Gilbreth-ээс\\_Гаргасан](https://en.wikipedia.org/wiki/Lillian_Moller_Gilbreth-ээс_Гаргасан)
16. Wikipedia. (2023 оны 3 10). *Wikipedia*. Wikipedia: [https://en.wikipedia.org/wiki/Entropy-ээс\\_Гаргасан](https://en.wikipedia.org/wiki/Entropy-ээс_Гаргасан)

## ЗӨРЧЛИЙН МАТЕРИАЛЛАГ БА ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

### A COMPARATIVE STUDY OF SUBSTANTIVE AND PROCEDURAL LEGAL FRAMEWORKS GOVERNING VIOLATIONS

**Д.Нямдорж**

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээ, инновацын газрын Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Гэмт явдал, цагдаа, дотоодын цэрэг судлалын төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, докторант, цагдаагийн хошууч

**D. Nyamdorj**

Senior Researcher and Lecturer, Center for Crime, Police and Internal Troops Studies, Research Institute, Office of Research and Innovation, University of Internal Affairs of Mongolia; Doctoral Candidate; Police Major

\*хариуцлагатай зохиогч: nyamdorj.osko@gmail.com

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд эрүүгийн хариуцлагын түвшинд хүрэхгүй, нийгмийн хор аюул багатай үйлдэл, эс үйлдэхүйд хариуцлага оногдуулахад хэрэглэгддэг Монгол Улсын зөрчлийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлдэг хоёр үндсэн түвшний зохицуулалтыг судлав. Материаллаг эрх зүй болох Зөрчлийн тухай хууль нь зөрчилд тооцох үйлдлийн бүрэлдэхүүн, ангилал, хариуцлагын төрөл, хэмжээг тогтоодог бол процессын эрх зүй болох Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь зөрчил илрүүлэх, шалгах, нотлох баримт бүрдүүлэх, шийдвэр гаргах болон давж заалдах ажиллагааны дарааллыг зохицуулдаг. Судалгааны арга зүйд норматив шинжилгээ болон харьцуулсан эрх зүйн аргыг ашиглаж, олон улсын түвшинд түгээмэл хэрэглэгддэг зөрчлийн эрх зүйн гурван төрлийн систем буюу нэгтгэсэн кодексийн систем, журмын давамгайл систем, хосолмол хоёр түвшний системийг Монголын тогтолцоотой харьцуулан үзэв. Судалгааны үр дүнд Монгол Улсын хоёр хуульг загвар нь онолын хувьд тодорхой бүтэцтэй боловч хэрэглээний түвшинд тайлбарын нэг мөр байдлыг хангах шаардлагатай болохыг тодорхойлов.

**Abstract:** This article examines the two-tier legal framework governing administrative offenses in Mongolia, which applies to acts and omissions that do not reach the threshold of criminal liability and pose a relatively low level of social harm. The study focuses on the interaction between substantive law and procedural law within the administrative offense system. The Law on Offenses, as the substantive component, defines the elements of offenses, their classification, and the types and extent of sanctions, while the Law on the Resolution of Offense Cases, as the procedural component, regulates the detection, investigation, evidence-gathering, adjudication, and appeal procedures. Using normative legal analysis and the comparative legal method, the study situates Mongolia's administrative offense framework within the context of three internationally recognized models: the unified codified system, the regulation-dominant system, and the dual-level hybrid system. The Mongolian model is compared with these systems in terms of structural logic, coherence, and practical implementation. The findings indicate that although Mongolia's two-law model is theoretically well-structured and logically differentiated, challenges remain at the level of practical application, particularly with respect to consistent legal interpretation and the coordination between substantive and procedural norms. The study concludes that



МОНГОЛЫН  
Дотоод Ажил  
Хариуцлагын  
Төвийн  
Эрдэм Шинжилгээний  
Хүрээлэн





strengthening interpretative uniformity and improving normative coherence are essential for enhancing the effectiveness of the administrative offense legal system.

**Түлхүүр үгс:** зөрчлийн эрх зүй, материаллаг эрх зүй, процессын эрх зүй, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, эрх зүйн зохицуулалтын загвар, харьцуулсан эрх зүй.

**Keywords:** administrative offense law, substantive law, procedural law, offense adjudication procedure, legal regulatory models, comparative law.

### Удиртгал

Эрүүгийн хариуцлагын түвшинд хүрэхгүй, нийгмийн хор аюул харьцангуй бага боловч тодорхой нийгмийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг үйлдэл, эс үйлдэхүйд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт нь орчин үеийн хууль зүйн шинжлэх ухаанд бие даасан судалгааны салбар болон хөгжиж байна. Ийм төрлийн зөрчил нь эрүүгийн эрх зүйн хариуцлагаас ялгаатайгаар хөнгөн шинжтэй, нийгмийн аюулгүй байдал, нийтийн дэг журам, эрх зүйн сахилга бат, иргэдийн эрх, үүргийн хэрэгжилттэй шууд холбоотой байдаг. Тиймээс зөрчлийн эрх зүйн суурь ойлголт, зохицуулалтын бүтэц, эрх зүйн механизмыг нарийвчлан судлах нь хууль хэрэглээний нэг мөр байдал, байгууллагын хүчин чадал, шүүхийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэх онол, практикийн ач холбогдолтой.

Монгол Улсад зөрчлийн эрх зүй нь хоёр түвшний зохицуулалтын тогтолцоонд түшиглэн хэрэгждэг. Материаллаг эрх зүй нь Зөрчлийн тухай хуульд тусгагдаж, зөрчилд тооцох үйлдлийн бүрэлдэхүүн, ангилал, хариуцлагын төрөл, хэмжээ, субъектын шинжийг тодорхойлох үүрэгтэй бол процессын эрх зүй нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд тусгагдаж, зөрчил илрүүлэх, шалгах, нотлох, шийдвэр гаргах болон давж заалдах ажиллагааны дарааллыг тогтоодог. Энэ бүхэн нь зөрчлийг эрүүгийн гэмт хэрэгтэй эрх зүйн агуулга, хариуцлагын

шинжээр нь ялган, хөнгөн зөрчилд онцгойлсон хууль ёсны зохицуулалт бүрдүүлж байгаа юм.

Гэвч хоёр түвшний хосолмол бүтэц нь онолын хувьд зохион байгуулалт сайтай боловч практик хэрэгжилтэд тодорхой хүндрэл, сорилтуудын эх үүсвэр болж байна. Тухайлбал, зөрчлийн бүрэлдэхүүний томъёолол, нотлох баримтын шалгуур, шалгах ажиллагааны уялдаа, байгууллагуудын ойлголтын нэгдмэл байдал зэрэг олон асуудал хууль хэрэглээний шатанд маргаан дагуулж байна. Хууль эрх зүйн тогтолцооны үр нөлөө нь зөвхөн зохицуулалтын агуулгаас бус хэрэгжилтийн механизмын нарийвчлал, албан хаагчдын мэргэшсэн байдал, хууль хэрэглээний арга зүйн үнэлэмжид тулгуурладаг тул эдгээр асуудлыг системтэй судлах шаардлагатай болжээ.

Олон улсын хэмжээнд зөрчлийн эрх зүйн зохицуулалт улс орнуудын эрх зүйн уламжлал, захиргааны байгуулалтын түвшин, нийгмийн бүтцээс шалтгаалан өөр өөр хэлбэрээр хөгжсөн. Судалгааны практикт зөрчлийн эрх зүйг нийтлэг гурван системд ангилдаг нь: (1) материаллаг болон процессын зохицуулалтыг нэг цогц хуульд нэгтгэсэн кодексийн систем, (2) материаллаг болон процессын зохицуулалт нь салбарын хуулиуд болон захиргааны журамд тархай байрласан журам давамгайл систем, (3) материаллаг ба процессын зохицуулалтыг хоёр тусдаа хуульд

тогтоосон хосолмол хоёр түвшний систем юм. Монгол Улсын тогтолцоо гурав дахь системд хамаарч, онцгойлсон бүтэцтэй хэдий ч олон улсын жишигтэй харьцуулахад хөгжлийн тодорхой зөрүү, давуу болон сул талууд илэрч байна.

Иймээс энэхүү өгүүллийн зорилго нь Монгол Улсын зөрчлийн эрх зүйн хоёр түвшний зохицуулалтын бүтэц, логик уялдааг онолын үүднээс шинжлэхийн зэрэгцээ олон улсын түгээмэл загваруудтай харьцуулан, тэдгээрийн онцлог, ялгаа, хэрэглээний түвшний зөрүүг тодорхойлох явдал юм. Энэ нь зөрчлийн эрх зүйн хуулийн хэрэглээний бодлогыг сайжруулах, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох онол-практикийн үндэслэл болж өгнө.

### **Зөрчлийн материаллаг эрх зүйн шинжилгээ**

Монгол Улсын зөрчлийн материаллаг эрх зүй нь Зөрчлийн тухай хуульд суурилдаг бөгөөд зөрчилд тооцох үйлдлийн бүрэлдэхүүн, субъект, буруутай хэлбэр, хариуцлагын төрөл, хэмжээ зэрэг суурь ойлголтыг тогтоож өгдөг. Зөрчлийн бүрэлдэхүүн нь (Л.Баг-Очир, 2024, хууд. 10) объект, объектив тал, субъект, субъектив тал гэсэн дөрвөн элементийн нийлбэр байдлаар хуульчилсан бөгөөд тухайн үйлдэл нь эдгээр нөхцөлийг хангаж байж зөрчилд тооцогдох боломжтой.

Судлаач П.Эрдэнэцогт (П.Эрдэнэцогт, 2023, хууд. 8) зөрчлийн эрх зүйг “Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, нийтийн болон хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхол, хохирлыг хуулийн хүрээнд хамгаалах, зөрчигдсэн эрхийг нь сэргээх, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог

бэхжүүлэхэд чиглэсэн нийгмийн харилцааг зохицуулж буй хэм хэмжээний тогтолцоог хэлнэ” хэмээн тодорхойлсон.

Зөрчлийн хууль нь зөвхөн нэгэн тусгай хууль байхаас цаашлан, эрх зүйн тогтолцоонд бие даасан зохицуулалтын салбар, өөрөөр хэлбэл “зөрчлийн эрх зүй” хэмээн тодорхойлогдох боломжтой болтол шинээр бие даан хөгжсөн. Энэ нь эрх зүйн нийт тогтолцоог илүү нарийн давхаргад хувааж, нийгмийн аюулын шинжээрээ ялгаатай үйлдлүүдэд тохирсон, оновчтой хариуцлагын бодлого хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байгаа явдал юм.

Энэхүү материаллаг зохицуулалтын хүрээнд зөрчлийг төрөлжүүлэн ангилсан нь эрх зүйн онолын хувьд тодорхой, эрүүгийн гэмт хэрэгтэй зааг ялгааг тодруулдаг. Тухайлбал, нийгмийн хор аюулын шинж, хохирлын хэмжээ, хууль бус үйлдлийн хэлбэр, зөрчлийн давтамж зэргийг харгалзан торгуулийн хэмжээ, эрх хязгаарлах зохицуулалтыг багтаасан. Энэ нь хөнгөн зөрчил, давтан зөрчил гэх мэт ангиллын ялгаа дээр тулгуурладаг (Д.Мөрөн, 2016, хууд. 25).

Онолын үүднээс авч үзвэл Монголын материаллаг эрх зүй нь зөрчлийн бүрэлдэхүүнийг тодорхойлогч үндсэн элементүүдийг харьцангуй шалгууртай тогтоосон, логик бүтэцтэй гэж дүгнэж болно. Эрх зүй, нийгэм, эдийн засгийн хувьд харьцангуй өндөр хөгжсөн Олон улсын жишигтэй харьцуулан авч үзэхэд нэгтгэсэн кодексийн системтэй орнуудад зөрчлийн бүрэлдэхүүнийг илүү нарийвчлан тогтоогддог бол журамд тулгуурласан системтэй улсад бүрэлдэхүүнийг салбарын хуулиудад тархсан байдалтай тогтоодог. Монголын Улсын загвар нь материаллаг зохицуулалтыг





төвлөрүүлэн 2017 оноос анх хэрэгжүүлсэн гэхээр харьцангуй залуу тогтолцоо гэж болох ба процессыг

тусад нь мөн нэг хуулиар салган зохицуулснаараа бүрэн өөр гэхээр онцлогтой юм.

Үзүүлэлт	Монгол Улс	Герман	АНУ
Бүрэлдэхүүний элемент	Объект, объектив тал, субъект, субъектив тал	Дэлгэрэнгүй томъёолол	Салбар бүр харилцан адилгүй
Зөрчлийн ангилал	Хөнгөн, давтан гэх мэт	Өргөн хүрээтэй	Агентлаг бүр өөр
Хариуцлагын төрөл	Торгууль, баривчлах, нэмэгдэл	Торгууль, эрх хасах	Торгууль, эрх хасах
Хор аюулын үнэлгээ	Дундаж тодорхойлсон	Нарийн шалгууртай	Агентлагаас хамаарна

#### Хүснэгт №1. Материаллаг эрх зүйн харьцуулалт

Дээрх хүснэгтээс Монгол Улсын Зөрчлийн материаллаг эрх зүй нь зөрчлийн бүрэлдэхүүний суурь элементүүд, ангилал, хариуцлагын төрлийг нэг хуульд төвлөрүүлэн тогтоосон кодификацийн шинжтэй боловч хор аюулын үнэлгээ, ангиллын нарийвчлалын хувьд бүрэн дэлгэрэнгүй түвшинд хүрээгүй, харьцангуй дунд зэргийн тодорхойлолттой загвар болох нь харагдаж байна. Харин Герман улс нь континенталь эрх зүйн уламжлалд суурилсан нэгтгэсэн кодексийн төлөөлөл болж, зөрчлийн бүрэлдэхүүн, хор аюулын шалгуур, хариуцлагын тогтолцоог нарийн, системтэй тогтоодог бол АНУ нь англо-саксоны эрх зүйн уламжлалтай, зөрчлийн материаллаг зохицуулалт нь салбар, агентлаг бүрээр ялгаатай журам давамгайл, уян хатан системийг илэрхийлж байна. Иймээс Герман, АНУ-ыг харьцуулалтын жишээ болгон сонгосон нь зөрчлийн эрх зүйн зохицуулалтын хоёр туйлын загварыг төлөөлүүлэн авч үзэх, тэдгээрийн дунд Монгол Улсын хоёр хуульг хосолмол загвар нь кодификац ба уян хатан байдлын хувьд ямар байр суурь эзэлж байгааг онолын түвшинд тодорхойлох боломжийг олгож байна. Энэ харьцуулалт нь Монголын материаллаг эрх зүйн давуу тал, мөн цаашид нарийвчлан сайжруулах шаардлагатай

чиглэлийг илрүүлэхэд чухал ач холбогдолтой.

Мөн олон улсын зөрчлийн эрх зүйн гурван систем нь зохицуулалтын төвлөрөл болон уян хатан байдлаараа ялгаатай бөгөөд Монголын хоёр хуульг хосолмол загвар нь кодификаци болон уян хатан байдлын түвшнээрээ эдгээр хоёр туйлын дунд байрлалд байна.

Монгол Улсын материаллаг эрх зүйд зөрчлийн бүрэлдэхүүнийг объект, объектив тал, субъект, субъектив талын бүрдлээр тогтоосон нь зөрчлийн эрх зүйг эрүүгийн эрх зүйгээс онолын хувьд тодорхой зааглах боломжийг бүрдүүлдэг. Гэхдээ бүрэлдэхүүн тогтоох шалгуур нь практик хэрэгжилтэд заримдаа маргаан дагуулдаг бөгөөд энэ нь үйлдлийн нийгмийн хор аюулын үнэлгээ, хохирлын хэмжээ, гэм бурууг тогтоох шалгуур зэрэг асуудал дээр тодорхой бус тайлбар үүсгэдэг учир нь хуулийг харвал эрүүгийн эрх шиг тодорхойлон тайлбарласан заалт байдаггүйтэй холбоотой. Үүнийг олон улсын нэгтгэсэн кодексийн системтэй харьцуулахад бүрэлдэхүүн илүү нарийвчлан тогтоогддог бол журамд тулгуурласан системтэй орнуудад бүрэлдэхүүн нь салбар бүрийн хуулиудад харилцан адилгүй байдлаар илэрдэг.

### Зөрчлийн процессын эрх зүйн шинжилгээ

“Зөрчлийн тухай хууль”-тай цуг батлагдан гарсан хууль бол “Зөрчил шалган шийдвэрлэх тухай” хууль юм. Тус хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь “зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ” (УИХ, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017) хэмээн тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, ЗШШТХ-д заасан ажиллагааг хангах зорилгоор явуулж буй хэрэг бүртгэлтийн ажиллагаа болон уг ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж буй эсэхэд тавих прокурорын хяналт, оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг шүүхээр хянан шийдвэрлэх цогц ажиллагааг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэж ойлгож болохоор байна. Энэхүү хууль нь Зөрчлийн тухай хуулиар заасан хэм хэмжээг хэрхэн шийдвэрлэх тухай зааж өгсөн байдгаараа процессын хууль юм (А.Хулан, 2026, хууд. 13).

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь зөрчил илрүүлэх, шалгах, нотлох баримт цуглуулах, шийдвэр гаргах, давж заалдах хүртэлх ажиллагааг үе шаттайгаар зохицуулдаг. Процессын зохицуулалт нь

илрүүлэлтийн эх үүсвэр, шалгах ажиллагааны эрх хэмжээ, нотолгооны стандарт, хугацааны зохицуулалт, оролцогчдын эрх, үүрэг, шийтгэлийн шинж чанар зэргийг тусгасан нарийн бүтэцтэй.

Хууль тогтоомжид нотолгооны эх үүсвэрийг тодорхой ангилж, нотолгооны үнэлгээний зарчим, дарааллыг тогтоосон нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өргөн утгаараа хүний эрхийн баталгааг бүх шатанд эрх бүхий албан тушаалтан, бусад оролцогчдын гэхгүй хангаж өгсөн ач холбогдолтой. Эрх бүхий албан тушаалтын шийдвэрт гомдол гаргах, давж заалдах ажиллагааны тогтолцоо нь шийдвэрийн хууль ёсны байдалд шүүхийн хяналт хэрэгжих нөхцөлийг бүрдүүлдэг байна.

Олон улсын жишгээс харахад (Hans-Heinrich Jescheck, 1996) журамд тулгуурласан тархай системтэй орнуудад шалгах ажиллагаа агентлаг бүрийн дүрэм, журамд тулгуурлан харилцан адилгүй хэлбэртэй байдаг бол нэгтгэсэн кодексийн системтэй улсад шалгах, нотлох, шийдвэрлэх ажиллагаа кодексийн дотор нарийвчлан нэгтгэгдсэн байдаг. Монголын процессын эрх зүй эдгээр хоёрын аль алинаас ялгаатай бөгөөд процессын бүх элементүүдийг нэг хуульд төвлөрүүлэн заасан бүтэцтэй.

Үе шат	Монгол	Герман	АНУ
Илрүүлэх	Байгууллага	Захиргааны алба	Агентлаг тус бүр
Шалгах	Нэг хуулиар	Кодексээр	Журмаар
Нотолгоо	Тодорхой ангилалтай	Стандарт өндөр	Агентлагаас хамаарна
Шийдвэр	ЭБАТ + шүүх	Захиргааны шүүх	Агентлаг
Давж заалдах	2 шат	Шүүхийн хяналт	Хязгаарлагдмал

#### Хүснэгт №2. Процессын үе шатны харьцуулалт

Монгол Улсын зөрчил шалган шийдвэрлэх процессын эрх зүй нь илрүүлэхээс эхлэн шалгах, нотлох, шийдвэр гаргах, давж заалдах хүртэлх

бүх үе шатыг нэг хуульд төвлөрүүлэн зохицуулсан тогтвортой, логик бүтэцтэй загвар болох нь харагдаж байна. Энэ нь процессын ажиллагаанд





Хууль сахиулахуй

оролцогч талуудын эрх, үүргийг нэг мөр ойлгох, хууль хэрэглээний суурь нэгдлийг хангах онолын давуу талыг бүрдүүлдэг.

Харьцуулбал, Герман улс нь (Justiz, 1968) процессын ажиллагааг нарийвчилсан кодексийн хүрээнд зохицуулж, нотолгооны стандарт болон шүүхийн хяналтыг өндөр түвшинд тогтоосон хатуу, системчилсэн загварыг төлөөлж байна. Харин АНУ-д (Justice) зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа агентлаг тус бүрийн журамд тулгуурладаг тул процессын уян хатан байдал өндөр боловч нотолгоо, давж заалдах боломжийн хувьд нэгдмэл бус, харилцан адилгүй шинж илэрдэг. Иймээс Монголын процессын эрх зүй нь Германы кодексийн нарийвчилсан стандарт болон АНУ-ын агентлагийн уян хатан зохицуулалтын хооронд дундын, тэнцвэржсэн байр суурь эзэлж байгаа бөгөөд цаашид нотолгооны стандартын нарийвчлал, шүүхийн хяналтын бодит үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр боловсронгуй болгох шаардлага байгааг уг хүснэгт харуулж байна.

**Олон улсын загваруудтай харьцуулалт:** Харьцуулалтын үр дүнгээс үзвэл зөрчлийн эрх зүйн зохицуулалт нь олон улсын хэмжээнд гурван үндсэн хэлбэрт ангилагддаг.

**Нэгдүгээрт,** нэгтгэсэн кодексийн систем нь материаллаг болон процессын эрх зүйг нэг цогц хуульд нэгтгэдэг. Энэ тогтолцоонд хууль хэрэглэгч нэг л эх сурвалжаас зөрчлийн бүрэлдэхүүн болон шалгах ажиллагааг харж болно.

**Хоёрдугаарт,** журамд тулгуурласан тархай системд зөрчлийн материаллаг ба процессын зохицуулалт салбар бүрийн хууль, журамд өөр өөрөөр тарсан байдалтай байдаг. Энэ нь уян хатан боловч нэгдсэн ойлголт бий болгоход бэрхшээлтэй.

**Гуравдугаарт,** хосолмол хоёр түвшний системд материаллаг ба процессын зохицуулалтыг хоёр тусдаа хуульд салгаж хуульчилдаг бөгөөд Монгол Улс энэ ангилалд хамаарна. Энэ систем онолын хувьд логик бүтэцтэй боловч хэрэгжилтийн шатанд тайлбарын нэг ойлголтын байдал шаардагдана.

Үзүүлэлт	Монгол	Нэгтгэсэн кодекс	Журмын давамгай систем
Хууль тогтоомж	2 хууль	1 цогц хууль	Салбарын хууль
Материаллаг зохицуулалт	Нэг хуульд	Кодекс	Салбар бүр
Процессын зохицуулалт	Тусдаа хууль	Кодекс	Агентлаг
Давуу тал	Логик	Нэг мөр	Уян хатан
Сул тал	Уялдаа шаарддаг	Шинэчлэх төвөгтэй	Тархай

**Хүснэгт №3. Олон улсын 3 системийн үндсэн шинжүүд**

Олон улсын зөрчлийн эрх зүйн зохицуулалт нь материаллаг болон процессын эрх зүйг хэрхэн нэгтгэж, эсхүл салгаж зохицуулж байгаагаас шалтгаалан гурван өөр институтийн логик бүхий системд хуваагдаж байгааг харуулж байна. Нэгтгэсэн кодексийн систем нь материаллаг ба процессын зохицуулалтыг нэг цогц хуульд

төвлөрүүлснээр хууль хэрэглээний нэг мөр байдал, тодорхой байдлыг хангадаг боловч шинэчлэл хийхэд хүндрэлтэй, уян хатан бус талтай. Харин журам давамгай систем нь салбар, агентлаг бүрийн онцлогт нийцсэн уян хатан зохицуулалтыг бий болгодог ч материаллаг болон процессын зохицуулалт тархай байрлалтайгаас

шалтгаалан нэгдсэн ойлголт, жигд стандарт тогтоох боломж хязгаарлагддаг.

Эдгээр хоёр хэрэглээний системийн дунд Монгол Улсын хоёр хуульт хосолмол загвар нь материаллаг зохицуулалтыг нэг хуульд төвлөрүүлж, процессын зохицуулалтыг тусдаа хуулиар нарийвчлан тогтоосон онолын хувьд логик бүтэцтэй систем болох нь харагдаж байна. Гэвч энэхүү загварын сул тал нь материаллаг ба процессын хуулиудын уялдаа, тайлбарын нэг мөр байдал практик хэрэгжилтийн шатанд байнга шаардагддаг явдал юм. Иймээс дээрх хүснэгт Монгол Улсын зөрчлийн эрх зүй нь кодификацийн тодорхой байдал болон журамд суурилсан уян хатан байдлын хооронд дундын, тэнцвэржүүлэх боломжтой байр суурь эзэлж байгааг харуулж, цаашдын эрх зүйн бодлого, шинэчлэлд чиг баримжаа өгөх онолын үндэс болж байна.

Процессын эрх зүйн хувьд Монголын тогтолцоо нэг хуулийн хүрээнд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны бүх үе шатыг багтаасан цогц зохицуулалттай байгаа нь онцлог юм. Энэ нь онолын хувьд төвлөрсөн, нэг мөр хэрэглээний үндэс болж болох боловч практик хэрэгжилтэд зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтны чадавх, нотолгооны стандартыг жигд хэрэгжүүлэх асуудал тулгардаг. Олон улсын жишгээс харвал журамд суурилсан загварт байгууллага бүр өөрийн дотоод журамд тулгуурлан шалгах ажиллагааг явуулдаг тул уян хатан сайн талтай боловч эрх зүйн баталгааны тогтолцоо сулрах эрсдэлтэй байдаг. Монголын систем харин эсрэгээр төвлөрсөн зохицуулалттай боловч хэрэгжилтийн түвшинд хэт ерөнхий заалттай хэсэг олонтой болох нь Хүний эрхийн байгууллага, Шүүх, Цагдаа, Прокурорын байгууллагын үйл

ажиллагааны жил бүрийн тайлан зэргээс тодорхой харагдаж байна.

Монгол Улсын хосолмол загварын нэг онцлог нь материаллаг ба процессын зохицуулалт тусдаа хуульд орсон явдал бөгөөд энэ нь онолын түвшинд тодорхой зааг, логик өгдөг ч практикт хоёр хуулийн уялдааг сайтар тайлбарлах, нэг мөр хэрэглээ тогтоох шаардлагыг бий болгодог. Энэ нь олон улсын хосолмол системийн улсуудтай (жишээ нь Чех, Словак) зарим талаар ижил боловч тухайн улсуудад материаллаг болон процессын хуулиуд тодорхой дагнасан хөгжлийн замтай байдаг.

Судалгааны үр дүнгээс харахад Монголын тогтолцоонд эрх зүйн логикийн илүү нарийвчлал, тодорхойлолтын нэгдсэн стандарт, нотолгооны шаардлагын нарийсгал, албан хаагчдын мэргэшлийн түвшинг сайжруулах зэрэг асуудал тулгамдаж байна. Эдгээр нь олон улсын жишээнээс суралцах боломжтой бөгөөд ялангуяа нэгтгэсэн кодексийн системийн тодорхой, нарийн шалгуур, журамд суурилсан системийн уян хатан байдлыг зохистой хослуулах боломжтой гэж үзэж болно.

Процессын эрх зүйд (Ц.Амарсайхан, Процессийн эрх зүй онол, туршлага, 2014, хууд. 24) “процессын эрх зүйн хэм хэмжээний мөн чанар нь материаллаг эрх зүйн хэм хэмжээг хэрэгжүүлэх журам, хэлбэр, аргыг бэхжүүлж журамлах байдлаар тодорхойлогдоно” хэмээн материаллаг болон процессын хэм хэмжээний хоорондын уялдаа холбоог томъёолсон. Энэ нь эдгээр хэм хэмжээ нь дангаар хэрэгжих боломжгүй бөгөөд аль алных нь тэнцвэрийг хадгалж байж хуулийн зорилго, зорилт болох хүний эрхийг ханган баталгаажуулах зарчмын хэрэгжилт бүрэн бодитой хангагдахыг илэрхийлж байна.





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ  
ᠵᠢᠨᠠᠨᠠᠭ ᠵᠢᠨᠠᠨᠠᠭ  
ᠵᠢᠨᠠᠨᠠᠭ ᠵᠢᠨᠠᠨᠠᠭ

Нөгөөтээгүүр материаллаг эрх зүйн салбар нь нийгмийн харилцаанд оролцож буй субъектуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлон зохицуулдаг бол процессын эрх зүйн салбарууд нь тухайн материаллаг харилцааг зохицуулж буй хуулиудыг шүүхийн байгууллагаас хэрэглэх тохиолдолд оролцогч бүх талууд ямар эрх үүрэгтэй болохыг заадаг (У.Сарантуяа, 2022) юм хэмээн тодорхойлсон нь зөрчлийн эрх зүй нь материаллаг эрх зүйн нэг хэлбэр бол зөрчлийн процесс нь процессын эрх зүйн салбар шинжлэх ухаан болохыг илтгэж байна.

Иймд Монгол Улсын зөрчлийн эрх зүйн тогтолцооны ирээдүйн хөгжилд материаллаг болон процессын зохицуулалтыг уялдуулах, хоёр түвшний хуулийн заалтыг нэг мөр хэрэглээтэй болгох, нотолгооны стандартчиллыг сайжруулах, практик хэрэглээнд чиглэсэн сургалт, арга зүйг боловсронгуй болгох шаардлага байна. Энэ нь зөрчлийн эрх зүйн тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх, хүний эрхийн баталгааг хангах, хууль хэрэглээний маргааныг бууруулахад чухал ач холбогдолтой.

Үзүүлэлт	Монголын үнэлгээ
Зохицуулалтын логик	Цэгцтэй
Төвлөрөл	Дундаж
Нэг мөр тайлбар	Дутмаг
Нотолгоо	Нарийвчлах шаардлагатай
Мэргэшил	Тухайн албан хаагчаас хамаарна
Нийцэл	Хосолмол системд тохиромжтой

#### Хүснэгт №4. Монголын системийн олон улсын дундах байрлал

Дээрх хүснэгтээс харахад Монгол Улсын зөрчлийн эрх зүйн тогтолцоо нь зохицуулалтын логикийн хувьд цэгцтэй, хосолмол системд нийцсэн бүтэцтэй боловч практик хэрэгжилтийн түвшинд төвлөрлийн дундаж байдал, тайлбарын нэг мөр бус байдал, нотолгооны стандартын нарийвчлал, мэргэшлийн тогтвортой бус байдал зэргээс шалтгаалан цаашид боловсронгуй болгох шаардлага байна.

#### Дүгнэлт

Энэхүү судалгаанд Монгол Улсын зөрчлийн эрх зүйн тогтолцоог бүрдүүлдэг материаллаг болон процессын хоёр түвшний зохицуулалтын бүтэц, агуулга, логик уялдааг шинжилж, олон улсын түгээмэл хэрэглэгддэг эрх зүйн гурван загвартай харьцуулан байршууллаа. Судалгааны үр дүнд зөрчлийн материаллаг эрх зүй нь зөрчилд тооцох

үйлдлийн бүрэлдэхүүн, хариуцлагын төрөл, хэмжээ зэргийг тодорхойлох онолын суурийг бүрдүүлж байгааг; процессын эрх зүй нь зөрчил илрүүлэх, шалгах, нотлох, шийдвэр гаргах болон давж заалдах ажиллагааны логик дарааллыг тогтоож, эрх зүйн баталгааг бүрдүүлдэг болох нь илэрхий болов.

Харьцуулсан шинжилгээний үр дүнгээс үзвэл Монгол Улсын тогтолцоо олон улсын хосолмол системд багтах бөгөөд материаллаг ба процессын зохицуулалтыг тусдаа хуульд төвлөрүүлсэн онцлогтой юм. Энэ нь онолын хувьд цэгцтэй бүтэцтэй боловч хэрэгжилтийн шатанд хоёр хуулийн уялдаа, нотолгооны стандартын жигд байдал, байгууллагын мэргэшсэн ажиллагааг хангах шаардлага үүсгэдэг. Нэгтгэсэн кодексийн системийн нарийвчилсан норматив бүтэц, журамд суурилсан системийн уян хатан

байдлыг харьцуулсан дүн нь Монголын тогтолцоонд тодорхой сайжруулалтын боломж байгааг харууллаа.

Нэгтгэн дүгнэвэл Монгол Улсын материаллаг–процессын хоёр түвшний загвар онолын хувьд зохистой харьцаатай ч практик хэрэгжилтийг дэмжих норматив уялдаа, нэг мөр хэрэгжүүлэх ойлголтын тайлбарын тогтолцоо, нотолгооны үйл ажиллагааны нарийвчлал, сургалт-мэргэшлийн бодлогыг бэхжүүлэх шаардлагатай байна. Иймд зөрчлийн эрх зүйн тогтолцоог хөгжүүлэх ирээдүйн бодлогод дээрх асуудлуудыг анхааран боловсронгуй болгох чиглэлээр судалгааны ажлыг системтэйгээр төлөвлөн хөгжүүлэх, үр дүнд суурилан хэрэглээг нэвтрүүлэх шаардлагатай байна.

#### Ашигласан материал

- Hans-Heinrich Jescheck, T. W. (1996). *Lehrbuch des Strafrechts: Allgemeiner Teil*. Germany: Duncker & Humblot, Berlin.
- Justice, U. D. (n.d.). *Administrative Enforcement and Civil Penalties*. Retrieved from <https://www.justice.gov/>
- Justiz, B. d. (1968). *Gesetz über Ordnungswidrigkeiten (OWiG)*. Germany.
- А.Хулан. (2026). *Зөрчил шалгах ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчлах шаардлага*. Улаанбаатар хот: ГУИС.
- Д.Мөрөн, Г. н. (2016). *Эрүүгийн эрх зүй*. Улаанбаатар хот: Сэлэнгэ пресс ХХК.
- Л.Бат-Очир, В. н. (2024). *Зөрчлийн эрх зүйн тусгай анги*. Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК.
- П.Эрдэнэцогт. (2023). *Зөрчлийн эрх зүй (ерөнхий анги) Зөрчил шалган шийдвэрлэх эрх зүй*. Уланбаатар: Мөнхийн үсэг.
- У.Сарантуяа. (2022). Үндсэн хуулийн процесс. *Эрдэм шинжилгээний өгүүлэл*, 10-14.
- УИХ. (2017). Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*, 24.
- УИХ. (2017). Зөрчлийн тухай хууль . *Төрийн мэдээлэл*, №24.
- Ц.Амарсайхан, Ж. н. (2014). *Процессийн эрх зүй онол, туршлага*. Улаанбаатар : Мэргэн Их Монгол.
- Ц.Амарсайхан, Ж. н. (2014). *Процессийн эрх зүй онол, туршлага*. Улаанбаатар: Мэргэн Их Монгол.



**ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ХИЙМЭЛ ОЮУН  
АШИГЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА****THE NECESSITY AND REQUIREMENTS FOR THE USE OF ARTIFICIAL  
INTELLIGENCE IN INVESTIGATIVE ACTIVITIES****О.Баярсайхан**

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Мөрдөх арга зүйн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

**O. Bayarsaikhan**

Police captain, Lecturer at the Department of Criminal Investigation Methodology, Police School, University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: o.bayarsaikhan.mba@gmail.com

**Хураангуй:** Төрийн үндсэн чиг үүргийн нэг нь гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогыг оновчтой боловсруулж, эрх зүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох замаар уялдуулах явдал юм. Гэмт хэрэгт тэмцэх чиг үүргийн хэрэгжилтийг хангахад Эрүүгийн процессын хууль чухал нөлөөлөл үзүүлнэ. Хэдийгээр гэмт хэрэгтэй тодорхой дүрмийн дагуу тэмцэж байгаа боловч гэмт этгээдүүд эрүүгийн процессоос ямагт зайлсхийх, оргон зайлах сонирхолтой байдаг. Энэхүү үзэгдэлд эрүүгийн процессын зүгээс эрэн сурвалжлах ажиллагаа явуулдаг ч маш их цаг хугацаа, хүч хэрэгсэл, эд хөрөнгө зарцуулж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад хүндрэлтэй нөхцөл байдал үүссээр байна гэж үзсэн. Энэхүү судалгаагаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд тулгамдаж буй асуудал, гэмт хэрэг илрүүлэх, шалгаж тогтоох, шуурхай байдлыг хангах, хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх үйл явдалд хиймэл оюун ашиглах хэрэгцээ, шаардлага, боломжийг судлахыг зорилоо.

**Abstract:** One of the main functions of the state is to rationally develop state policies to combat crime and coordinate them by further improving legal regulations. The Criminal Procedure Code will have an important impact on ensuring the implementation of the function of combating crime. Although crimes are fought according to certain rules, criminals are always interested in avoiding and fleeing from the criminal process. In this phenomenon, it is believed that although the criminal process conducts investigative operations, it consumes a lot of time, resources, and property, and it is difficult to achieve the goals of criminal proceedings. This study aims to examine the problems faced by case registration and investigation, the need, requirements, and opportunities for using artificial intelligence in detecting and investigating crimes, ensuring promptness, and restoring the rights of victims whose rights have been violated.

**Түлхүүр үгс:** Эрэн сурвалжлах ажиллагаа, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, хиймэл оюун, хэрэгцээ шаардлага.

**Keywords:** Investigation, coordination of government agencies, artificial intelligence, needs.

### Удиртгал

Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн **хүн, хуулийн этгээдийг олж тогтоон** шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино (УИХ, 2017) гэж хуульчилсан.

Хуулийн зорилтыг хангахад мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдлыг хангах нь хамгийн чухал. Гэвч практикт шалгагдаж байгаа хэргийн ажиллагаа ихтэй, ээдрээ төвөгтэй байдлаас үл шалтгаалж оролцогч нь хаана байгаа нь тодорхойгүй, харилцаа холбооны хэрэгсэл болон дуудан ирүүлэх хуудас гардуулж чадахгүй, гэмт хэргийн тоо өсөж нэг мөрдөгчид оногдох ачаалал ихтэй байдлаас шалтгаалан эрэн сурвалжлах ажиллагааг биечлэн хийж чадахгүй хэргийн шийдвэрлэлт удаашрах тохиолдол цөөнгүй байна.

### Үндсэн хэсэг

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу мөрдөгч дараах хүн, хуулийн этгээд, эд зүйл, хөрөнгийг олох зорилгоор эрэн сурвалжлах ажиллагааг өөрийн санаачилгаар, эсхүл шүүхийн шийдвэр, прокурорын даалгавраар явуулахаар заасан. Үүнд:

1. Байгаа газар нь мэдэгдэхгүй байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч, иргэний хариуцагч, гэрч;
2. Оргон зайлсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч;
3. Хулгайлагдсан, барьцаалагдсан хохирогч;
4. Хэн болох нь тодорхойгүй цогцсыг тогтоох;

5. Эмнэлгээс оргосон сэтгэцийн өвчтэй хүн;

6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий эд зүйл, мал, амьтан, баримт бичиг, тээврийн хэрэгсэл зэргийг олж тогтоохоор ажиллах үүрэгтэй.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хаана байгаа нь тодорхойгүй сэжигтэн, яллагдагчийг эрэн сурвалжлахдаа оршин суух бүртгэлтэй хаяг, төрөл садны хүмүүсийн хаяг, хань харилцаа, ажлын газар болон орогнож болох нийтийн байр, зочид буудал болон бусад газарт биечлэн очиж хайх, отолт хийх зэрэг ажиллагааг түгээмэл явуулдаг. Үүний зэрэгцээ үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, арилжааны банк, санхүүгийн байгууллагууд, үүрэн холбооны оператор кампаниуд, улсын хилээр гарсан эсэх болон бусад боломжтой лавлагааг авах байдлаар эрэн сурвалжлах ажиллагааг явуулах нь хугацаа алдах, хэрэг шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой нотлох баримт болохгүй материал бүрдүүлж байгаа нь зохиомол ачаалал бий болгосон үр дүн муутай байна.

Цагдаагийн байгууллага эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал амьтан, хэн болох нь тогтоогдоогүй цогцос, эд зүйл, тээврийн хэрэгслийг олж тогтоох зорилгоор 2010 оноос эхлэн дотоод сүлжээнд “ASAP” сан цэсийг бий болгож ашиглаж хэвшсэн.

Цагдаагийн байгууллагын эрэн сурвалжлах (ЦЕГ, 2026) “ASAP” санг ашиглаж эхэлсэн үеэс буюу 2010 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацааны ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд хүн, мал амьтан, эд зүйлийн талаарх **400,584** мэдээллийг бүртгэж, эрэн сурвалжлалт зарласнаас **374,737** хүн, мал амьтан, эд





МУХАММАД АХМЕТОВ  
 МУХАММАД АХМЕТОВ  
 МУХАММАД АХМЕТОВ

зүйлийн эрэн сурвалжлалтыг зогсон. Өөрөөр хэлбэл нийт эрэн сурвалжлалтын 93.5 хувийг олж тогтоосон байна.

Эрэн сурвалжлалт зарласан болон зогсоосон нөхцөл байдлыг төрлөөр нь ангилж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

д/д	Эрэн сурвалжлалтын чиглэл	Эрэн сурвалжлалт зарласан	Эрэн сурвалжлалт зогсоосон	Эрэн сурвалжлах ажиллагаанд байгаа	Гүйцэтгэлийн хувь
1	Сураггүй алга болсон хүн	52741	52265	476	99.1
2	Оргодол	14665	14044	621	95.7
3	Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд	61640	60210	1430	97.6
4	Цогцос	2215	1795	420	81
5	Галт зэвсэг, сум хэрэгсэл	1237	820	417	66.2
6	Түүх соёлын дурсгалт, үнэт зүйлс	263	248	15	94.3
7	Хулгайлагдсан тээврийн хэрэгсэл	8876	8408	468	94.7
8	Бодис	11	10	1	90.9
9	Мал, амьтан	10389	9954	435	95.8
10	Эд зүйлс	175237	159231	16006	90.8
11	Аман зураг	3263	2976	287	91.2
12	Шүүхээс даалгасан бусад хүн	60407	55920	4487	92.5
13	Зөрчил үйлдсэн этгээд	9640	8856	784	91.8
<b>Нийт</b>		<b>400,584</b>	<b>374,737</b>	<b>25,847</b>	<b>93.5</b>

**Хүснэгт 1. Эрэн сурвалжлалт зарласан болон зогсоосон нөхцөл байдлыг төрөл**

Цагдаагийн байгууллагын “ASAP” санд эрэн сурвалжлалт зарласан “Оргодол”, “Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд” зэргийг авч үзэхэд зарласан нийт оргодлын 95.7 хувь, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийн 97.6 хувийг олж тогтоож, эрэн сурвалжлах ажиллагааг зогсоосон үр дүн тогтоогдож байна. “ASAP” санд эрэн сурвалжлалт зарлагдсан этгээдийн тухайн мэдээллийг алба хаагчид дотоод сүлжээнд өөрийн нэвтрэх эрхээр хандаж танилцах, эргүүл, хяналт шалгалт явуулж байх үедээ илрүүлж эрэн сурвалжлалт зарласан албан тушаалтантай холбогдож зогсоож

шийдвэрлэдэг. Мөн эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлөөр олон нийтийн цахим платформ /Facebook/ ашиглаж эрэн сурвалжлалтын тухай мэдээллийг түгээж иргэдийн дэмжлэгийг авдаг, зарим тохиолдолд төлбөртэй мэдээлэл авч байгаа газар нь тогтоогдоогүй этгээдүүдийн байршлыг тогтоох зэрэг ажиллагаа явуулж байна.

Харин иргэдийн хувьд Цагдаагийн ерөнхий газрын “Police.gov.mn” сайтаас эрэн сурвалжлагдаж байгаа этгээдүүдийн талаарх мэдээлэлтэй танилцаж мэдээлэл өгөх байдлаар эрэн сурвалжлах ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг.


Эрэн сурвалжлалтын “ASAP” сангийн ашиглалтад дүн шинжилгээ хийхэд эрэн сурвалжлалт зарласан нийт мэдээллийн 93.5 хувийг олж тогтоосон нь ашиглалт сайн байна. Гэвч “ASAP” санд гэмт хэрэгт сэрдэгдсэн хаана байгаа нь тодорхойгүй этгээд бүрийн

мэдээллийг шивж оруулахгүй байгаа нь дутагдалтай тал гэж үзэж байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2020-2025 онд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн статистик (ЦЕГ, 2026) мэдээг судалж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдож байна.




МУИС-ийн Хуульчдын Хурал  
 МУИС-ийн Хуульчдын Хурал



Зураг 1. Сангийн ашиглалтын талаар

Гэмт хэргийн статистик мэдээг нийслэл, орон нутгаар нь ангилж судлахад дараах нөхцөл байдал тогтоогдож байна. Үүнд:

2020-2025 онд бүртгэгдсэн гэмт хэргийг нийслэл, орон нутгаар харуулав.




Зураг 2. Гэмт хэргийн бүртгэл

Дээрх мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд нийслэлд орон нутгаас нэг дахин их гэмт хэрэг бүртгэгдсэн байх бөгөөд мөрдөн шалгах албаны нэг мөрдөгчид ноогдох ачаалал дүүргийн газар нутгийн байршлаас шалтгаалж дунджаар 30-50 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.

жилүүдэд эрчимтэй өсөж байгаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэрэг байна.

Монгол Улсын Цагдаагийн байгууллагад 2020-2025 онд бүртгэгдсэн “Залилах” гэмт хэргийн статистик (ЦЕГ, 2026)

Монгол Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргээс сүүлийн



Зураг 3. Залилах гэмт хэргийн судалгаа

Монгол Улсын Цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах эрх бүхий мөрдөгч, эрүүгийн мөрдөгчийн батлагдсан орон тоонд нийт бүртгэгдсэн гэмт хэргийг хаваан тооцож үзэхэд ачаалал ихтэй гэсэн судалгааны үр дүн гарч байна.

Өмчлөх эрхийн эсрэг тэр дундаа залилах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүд ихэвчлэн бүртгэлтэй хаяг дээрээ амьдардаггүй, хаана байгаа нь тодорхойгүй, түрээсийн орон сууц, нийтийн байр, түрээсийн хашаа зэрэгт амьдрах, бусдын нэр дээр үл хөдлөх хөрөнгө худалдан авч амьдрах зэргээр мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийдэг.

Тухайн нөхцөл байдалд бид эрэн сурвалжлах ажиллагааг уламжлалт аргаар явуулах нь төдийлөн үр дүнд хүрэхгүй, мөрдөн шалгах ажиллагааны шуурхай байдлыг хангахгүй, хохирогчийн зөрчигдсэн эрхийг бүрэн хангаж чадахгүй. Өөрөөр хэлбэл эрэн сурвалжлах ажиллагаа уламжлалт аргаар явах нь хэргийн шийдвэрлэлтэд нөлөөлж байна.

Иймд нэгдүгээрт цагдаагийн байгууллагын “ASAP” сангийн ашиглалтыг сайжруулах. Тодруулбал гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийг “ASAP” санд нэг бүрчлэн мэдээллийг шуурхай оруулж байх.

Хоёрдугаарт эрэн сурвалжлах ажиллагаанд хиймэл оюуны дэмжлэг авах. Жишээлбэл эрэн сурвалжлалтын “ASAP” санд бүртгэгдсэн этгээдүүд төрийн захиргаа, үйлчилгээний аль ч шатны байгууллагаас үйлчилгээ авах үед өөрөө мэдээлэл өгөх боломжтой ухаалаг холболтыг хийж өгөх.

Цаашлаад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын олон хотод ашиглаж байгаа “Skynet” нэртэй нүүр царай таних хяналтын систем бий болгож “ASAP” санд зарлагдсан этгээдийн зурагтай харьцуулан хянаж байршлын талаарх мэдээлэл өгөх системийг хөгжүүлэх нь уламжлалт аргаар эрэн сурвалжлах ажиллагаа явуулснаас хэд дахин бага хүн хүч, цаг хугацаа зарцуулан ажиллах боломжтой.

### Дүгнэлт

Монгол Улсын хэмжээнд 2020-2025 онд бүртгэгдсэн гэмт хэргийн статистик мэдээгээр жил бүр гэмт хэргийн тоо өссөн, үүнээс өмнөх жилүүдэд ч буурсан тохиолдол байхгүй байгаа нь цаашид нэмэгдэнэ гэсэн чиг хандлагыг өгч байна. Үүнээс үзэхэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй мөрдөгчдийн ажлын ачаалал өшөө ч нэмэгдэнэ. Техник, технологийн хөгжлийг дагаж гэмт хэргийн нөхцөл байдал мөн өөрчлөгдөж байгаа өнөө үед бид эрэн сурвалжлах ажиллагааг

уламжлалт аргаар явуулах нь төдийлөн оновчгүй.

Эрэн сурвалжлах ажиллагаа нь төр иргэний зөрчигдсөн эрхийг сэргээх зорилгоор хийгдэж байгаа боловч эрэн сурвалжлагдаж байгаа этгээд төрийн захиргаа болон үйлчилгээний бус байгууллагуудаас өөрт шаардагдах үйлчилгээгээ авдаг. Өөрөөр хэлбэл төр татвар төлөгчдийн мөнгөөр гэмт хэргийн улмаас хохирсон иргэний зөрчигдсөн эрхийг сэргээхээр эрэн сурвалжлах ажиллагаанд тодорхой хүн хүч, хөрөнгө зарцуулж байгаа. Гэвч нөгөө талд төр үйлчилгээний байгууллагуудаар дамжуулж эрэн сурвалжлагдаж байгаа этгээдэд ямар нэгэн үйлчилгээг үзүүлсээр байдаг. Энэ үйл явдал нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байгааг илтгэж байна. Иймд эрэн сурвалжлах ажиллагааны чиглэлээр төрийн үйлчилгээ болон захиргааны байгууллагуудын бүртгэлийн системийг “ASAP” сангийн системтэй холбож хүний оролцоогүй хиймэл оюуны дүгнэлтээр цагдаагийн

байгууллагад мэдээлэл өгөх байдлаар шийдвэрлэх боломжтой.

### Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992.
2. Эрүүгийн хууль 2015.
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017.
4. Цагдаагийн албаны тухай хууль 2017.
5. Цагдаагийн байгууллагын гэмт хэргийн статистик мэдээлэл 2002-2025.
6. Б.Эрдэнэбат. Эрүүгийн процессын шуурхай байх зарчмын хэрэгжилт. Докторын зэрэг горилсон бүтээл.Уб., 2023.
7. П.Эрдэнэбаатар. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах арга зүй. Докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2024.
8. legalinfo.mn. Эрх зүйн нэгдсэн портал.
9. police.gov.mn. Цагдаагийн байгууллагын нэгдсэн мэдээллийн систем.





# ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХЭД ХИЙМЭЛ ОЮУНД (AI) СУУРИЛСАН ТЕХНОЛОГИЙН ШИЙДЛИЙГ АШИГЛАХ НЬ

## THE APPLICATION OF ARTIFICIAL INTELLIGENCE-BASED TECHNOLOGICAL SOLUTIONS IN COMBATING ILLEGAL LOGGING CRIMES

### Б.Энхцогт

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн, Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимийн багш, цагдаагийн ахмад

### B. Enkhtsogt

Police Captain, Lecturer at the Department of Criminal Law and Criminology, Police School of University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: enkhtsogt.police@gmail.com

**Хураангуй:** Энэхүү өгүүлэл нь хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн тулгамдсан асуудал болон түүнийг хиймэл оюунд суурилсан дэвшилтэт техник технологи ашиглан илрүүлэх, урьдчилан сэргийлэх системийн хэрэгцээ шаардлага, шийдлүүдийг судалж, монгол улсад ашиглах боломжтой технологийн дэвшлийг онцлон тухайн системийн загвар, үйл ажиллагааны механизмыг нарийвчлан харуулж дүгнэлт, саналыг дэвшүүлсэн болно.

**Abstract:** This study addresses the escalating problem of illegal logging crimes and examines the need for artificial intelligence-based technological systems for their detection and prevention. The research reviews advanced AI-driven approaches to monitoring and identifying illegal timber harvesting activities and evaluates their applicability within the Mongolian context. A conceptual model of an AI-enabled detection and prevention system is proposed, outlining its core functional mechanisms. The study concludes by presenting key findings and recommendations aimed at enhancing forest protection and strengthening institutional responses to illegal logging.

**Түлхүүр үгс:** Гэмт хэрэг, хууль бусаар мод бэлтгэх, хиймэл оюун, урьдчилан сэргийлэх, ойн сан, байгаль орчин.

**Keywords:** Crime, Illegal Logging, Artificial Intelligence (AI), Prevention, Forest Resources, Environmental Protection.

### Үндсэн хэсэг

Монгол улсад Ойн сан бүхий газар 14260.3 мянган га буюу нийт нутаг дэвсгэрийн 9.1 хувийг эзэлж байна. Монгол орны ой нь Сибирийн их тайга, Төв-Азийн хээр, цөлийн торгон заагт уур амьсгалын эрс тэс нөхцөлд тархан ургах тул байгалийн аясаар тэлэн ургах боломж нэн хязгаарлагдмал, ойн бүтээмж, өсөлтийн хувьд бага, ойн түймэр, хөнөөлт шавж, өвчин болон

хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд хялбархан өртөмтгий эмзэг экосистем юм.

Ойн сан бүхий газар нь гол, мөрний усны нөөцийг зохицуулах, хөрсийг элэгдэл, эвдрэлээс хамгаалах, уур амьсгалыг зөөлрүүлэх, хүлэмжийн хийг шингээх, амьтан, ургамал, бичил биетний амьдрах тааламжтай орчныг бүрдүүлэх, мөнх цэвдгийг тогтоон барих, цөлжилтийг сааруулах зэрэг

экологийн өндөр ач холбогдолтой (Монгол Орны Газарзүй-Геоэкологи Сэтгүүл - МОГГС, 2022).


Манай орны газар зүйн байршил, уур амьсгалын нөхцөл, гадаргын хэв шинжийн хувьд цөлжилтийн аюулд өртөх эмзэг, хуурай бүс нутагт хамаарах бөгөөд нутаг дэвсгэрийн ихэнх хувийг говь цөлийн бүс, цөлийн бор саарал элсэн хөрс зэрэг зонхилох экосистемийг бүрдүүлдэг билээ. Уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтаас улбаалан цөлжилт хүрээгээ тэлсээр нуур, ус ширгэх, бэлчээрийн ургамлын гарц эрс муудах, хөрс, ус давсжин, үржил шимээ алдах, элсний нүүлт хөдөлгөөн ихсэх болсон бөгөөд Монгол Улсад 2020 оны байдлаар цөлжилтөд өртсөн газар нутгийн хэмжээ 76.9 хувьтай байсан бол 2025 онд энэхүү үзүүлэлт 77.8 хувьд хүрч нэмэгдсэн байна.

Хууль бусаар мод бэлтгэх нь байгаль орчныг хамгаалахад ихээхэн аюул учруулж, ой модыг устгах, эко системийн тасалдал, эдийн засгийн алдагдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Энэхүү гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх нь зайлшгүй шаардлагатай ажил, арга хэмжээний нэг болоод байна.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь шууд санаатай, ашиг хонжоо олох гэсэн шунахайн сэдлээр үйлддэг, байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзмших, ашиглахтай холбоотой харилцаанд гэмт буруугийн санаатай хэлбэрээр халдсан Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм (Энхболд Б., Гантулга С., 2024).

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлд “Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан бол...” (Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015) гэмт хэрэг болохоор заасан байна.

Цагдаагийн байгууллагад сүүлийн 5 жилийн хугацаанд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нийт 1200 бүртгэгдсэн байна. Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт 2025 онд 457 бүртгэгдсэнээс “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэг 199 буюу 43.5 хувийг дангаар эзэлж байна (Гэмт хэргийн цагаан ном, 2021, 2022, 2023, 2024, 2025).



Зураг 1. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлт





Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь Монгол улсын хууль тогтоомжийг зөрчиж ойгоос мод, модон материалыг зөвшөөрөлгүй бэлтгэх, тээвэрлэх, худалдан авах, худалдах үйлдэл нь ойг устгах, биологийн олон янз байдлын алдагдал, Засгийн газрын орлогын томоохон алдагдал үүсгэх зэрэг байгаль орчин, нийгэм, эдийн засгийн ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй асуудал юм.

Олон улсын хэмжээнд Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь Бразил, Индонез, Бүгд Найрамдах Ардчилсан Конго зэрэг ойн асар их нөөцтэй орнууд болон Индонезийн Баруун Калимантан зэрэг бүс нутгуудад хамгийн өргөн тархсан байдаг байна.

#### **Хиймэл оюунд суурилсан технологийн шийдэл:**

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагааг илрүүлэх, урьдчилан сэргийлэхийн тулд орчин үеийн дэвшилтэд технологийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ашиглах нь зүйтэй юм. Үүнд:

Хиймэл оюун (AI), UAV-д суурилсан IoT нэгдсэн системийг хөгжүүлэх Монгол улсад нэвтрүүлэн ашиглах нь зүйтэй. Энэхүү систем нь хиймэл оюуны дэвшилтэт алгоритм, IoT технологи, UAV-ийн чадавхийг ашиглан ойг хамгаалах үр нөлөөг дээшлүүлэх, өргөтгөх боломжтой, бодит цагийн хяналтын шийдлийг бий болгодог байна.

Хиймэл оюуны (AI) технологи нь том хэмжээний мэдээллийн санг хурдан боловсруулж, дүн шинжилгээ хийх, хэв маягийг тодорхойлох, бодит цагийн ойлголтыг өгөх замаар хууль бус мод бэлтгэлийг шийдвэрлэх, улмаар


уламжлалт аргуудыг эрс сайжруулах боломжийг олгодог төдийгүй AI-ийг UAVs, IoT гэх мэт бусад технологитой нэгтгэх нь хяналтын цогц системийг бий болгож чадах юм.

IoT мэдрэгч, нисгэгчгүй агаарын тээврийн хэрэгсэл (UAVs), хиймэл оюун (AI) технологийг нэгтгэх замаар хууль бусаар мод бэлтгэх үйдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх шинэ шийдэл болно.

Тухайн системийн цөм нь акустик мэдрэгчээр тоноглогдсон IoT зангилаанаас бүрддэг бөгөөд энэ нь CNN загварыг ашиглан дууны дохиог илрүүлдэг. Ингэснээр Сэжигтэй дууг илрүүлэх үед IoT зангилаа нь LoRaWAN сүлжээгээр дамжуулан дохиог удирдлагын төв рүү илгээдэг. Дараа нь удирдлагын төв нь энэ дохиоллыг виртуалд суурилсан сервер рүү дамжуулдаг бөгөөд энэ нь өгөгдөл боловсруулах, тушаал, зааварчилгаа өгөх гол төв болдог юм.

Дохиоллыг хүлээн авсны дараа виртуал сервер нь автомат командыг газрын станц руу гаргаж, үйл ажиллагаа илэрсэн тодорхой байршилд дрон байрлуулах болно. Өндөр нарийвчлалтай камер, AI-ээр ажилладаг дүрс таних чадвараар тоноглогдсон дрон нь хууль бусаар мод бэлтгэж байгаа эсэхийг шалгахын тулд илрүүлэх газар руу бие даан нисдэг.

Хэрэв дроны AI камер нь хувь хүмүүс мод огтолож байгааг баталж байгаа бол энэ нь самбар дээрх дууны дохиоллын системийг идэвхжүүлж, зурагт үзүүлсэн шиг тухайн зөвшөөрөлгүй үйл ажиллагаа, гэмт хэргийг зогсоохыг анхааруулж, хүчээр идэвхжүүлдэг.



Зураг 2. Хууль бусаа мод бэлтгэлтийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх “UAV-IoT” системийн блок диаграм

Энэхүү олон давхаргат арга нь хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаанд хурдан бөгөөд үр дүнтэй хариу үйлдэл үзүүлэх боломжийг олгодог бөгөөд бодит цагийн акустик илрүүлэх IoT мэдрэгч, найдвартай дохио дамжуулах LoRaWAN сүлжээ, төвлөрсөн боловсруулалт хийх үүлэн сервер систем, газар дээр нь шалгах, хөндлөнгөөс оролцох UAV-ийг нэгтгэсэнээр энэхүү систем нь хяналт тавих, хууль сахиулах үйл ажиллагаа явуулах цогц шийдэл болдог.

Тус систем нь илрүүлэх нарийвчлал, хариу арга хэмжээ авах хугацааг сайжруулж, газрын өргөн хүрээнд эргүүл, хяналт шалгалт хийх хэрэгцээг багасгахын зэрэгцээ ойг хамгаалах ажлыг илүү өргөтгөх боломжтой, зардал багатай шийдэл болж өгдөг.

### IoT системийн дизайн ба ажиллагаа:

Энэхүү судалгаанд боловсруулсан олон давхаргат ухаалаг хяналтын систем нь хууль бус мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагаанд хурдан бөгөөд үр дүнтэй хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлдэг. Систем нь акустик илрүүлэлт бүхий IoT мэдрэгч,

найдвартай LoRaWAN сүлжээ, төвлөрсөн өгөгдлийн боловсруулалттай үүлэн сервер, болон газар дээрх хяналт шалгалт гүйцэтгэх UAV (дрон)-ийг нэгтгэсэн цогц бүтэцтэй (G.M.A.S. Wibawa & Muhibbin, 2023).

Энэхүү хосолмол архитектурын шийдэл нь хууль бус үйл ажиллагааг илрүүлэх нарийвчлал, мэдээлэл дамжуулах хурд, хариу арга хэмжээ авах хугацааг мэдэгдэхүйц сайжруулж, өргөн хүрээний биечилсэн эргүүл, хяналт шалгалт хийх хэрэгцээг багасгадаг. Үүний үр дүнд уг систем нь өргөтгөх боломж сайтай, зардал багатай, найдвартай ойн хамгаалалтын шийдэл болж өгдөг.

### IoT системийн бүтэц:

Системд ашиглагдаж буй IoT зангилаа нь ойн бүс нутагт хууль бус мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагааг үр ашигтай, урт хугацаанд хянах зориулалттайгаар бүтээгдсэн. Тус зангилаа нь ESP32 микроконтроллерийн самбар, дуу илрүүлэх өндөр мэдрэмжтэй микрофон, болон лити батерейгаас бүрдсэн эрчим хүчний систем бүхий бие даасан төхөөрөмж юм.





Энэхүү загвар нь баг бөх, найдвартай ажиллагаатай, засвар үйлчилгээ хийхэд хялбар, бие даасан эрчим хүчний эх үүсвэртэй гэсэн гол үзүүлэлтүүдийг хангаснаар алслагдсан болон хүндрэлтэй орчинд олон жилийн турш тасралтгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлдэг байна.

#### Ажиллагааны горимууд:

IoT зангилаа нь гүн унтах (deep sleep) ба ажиллах (active) гэсэн хоёр үндсэн горимд ажилладаг .

- Гүн унтах горимд, зангилаа бүхэлдээ эрчим хүчний хэрэглээг хамгийн бага түвшинд хүргэж, зөвхөн 5  $\mu$ A гүйдэл ашиглан энерги хадгалдаг. Энэ төлөв нь системийн ашиглалтын

хугацааг 10 хүртэл жилээр уртасгах боломжийг бий болгодог.

- Ажиллах горимд, зангилаа 10 минут тутам 10 секундын хугацаанд идэвхжиж, микрофоноо асаан 16 кГц-ийн дээж авах хурдаар орчны дуу авиаг бичиж авдаг.

Цуглуулсан дууны өгөгдлийг TinyML суурьтай CNN хиймэл оюуны загвар боловсруулж, гинж, хөрөө зэрэг хууль бус мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагаанд хамаарах дуу чимээ, дохионы онцлог акустик хэв шинжийг тодорхойлдог. Ингэснээр тус загвар нь хуурамч дуу чимээг ялгаж, шаардлагтай өгөгдлийг өндөр нарийвчлалтай илрүүлэх үр дүнтэй.



Зураг 3. IoT дуу илрүүлэх системийн үндсэн самбарын хяналт

#### Холболтын бүтэц ба өгөгдлийн дамжуулалт:

Сэжигтэй дууг илрүүлмэгц системийн зангилаа болох LoRaWAN гарц (RAK7244) руу дохиоллын мэдээлэл илгээдэг. Уг гарц нь Raspberry Pi 4 болон GPS модультай, олон сувгийн урт зайн холболтыг дэмждэг өндөр гүйцэтгэлтэй төхөөрөмж юм.

RAK7244 гарц нь илрүүлсэн дохиог үүлэн сервер рүү дамжуулж, цаашдын өгөгдлийн боловсруулалт, анализ болон хяналт тавьж буй байгууллагын хариу арга хэмжээг идэвхжүүлнэ. Энэхүү реал-тайм харилцаа холбооны бүтэц нь хууль бус мод бэлтгэлийг илрүүлэх,

мэдээлэлд тулгуурласан шуурхай шийдвэр гаргах үйл явцыг дэмждэг (Z. Hasan, 2023) байна.

#### Техникийн үзүүлэлт ба эрчим хүчний менежмент:

ESP32 микроконтроллер нь бага эрчим хүчний хэрэглээтэй, суурилуулсан Wi-Fi болон Bluetooth холболт хийх боломжтой тул IoT системд хамгийн тохиромжтой шийдэл юм. Мөн Knowles SPH8878LR5H-1 микрофон нь 67 дБ(A) SNR ба 134 дБ SPL AOP үзүүлэлттэй, дууг гажуудалгүйгээр илрүүлэх чадвартай өндөр гүйцэтгэлтэй мэдрэгч бөгөөд

гинж, хөрөөний дууг нарийн ялгах боломжийг олгодог.

Эрчим хүчний менежментийн систем нь 18Ah лити батерей болон идэвхтэй ба унтах горимуудын хооронд автоматаар шилждэг хяналтын хэлхээ бүхий оновчтой зохион байгуулалттай. Үүний үр дүнд зангилаа нь 8 жил ба түүнээс дээш хугацаанд тасралтгүй ажиллах боломжтой.

Энэхүү баг бөх, ухаалаг, эрчим хүчний хэмнэлттэй IoT зангилаа нь ойн нөөцийг хамгаалах, хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгааллын орчин үеийн технологийн шийдэл болгон ашиглахад бүрэн тохиромжтой юм.

### **Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах нисгэгчгүй дрон:**

Дрон нь 6S 16,000 mAh батерейгаар ажилладаг бөгөөд нэг цэнэглэлтээр 40 мин хүртэл нисэх боломжийг олгодог бөгөөд хамгийн ихдээ ойролцоогоор 26 км зайг хамардаг. Холболт нь 4G GSM модемоор, ялангуяа SIM COM A7670 G загвараар бүтээгдсэн бөгөөд энэ нь Дроныг үүлэн сервертэй бодит цаг хугацаанд шууд харилцах боломжийг олгодог. Интеграцийг Mission Planner програм хангамжийг ашиглан удирддаг тул дрон болон үүлэн серверийн хооронд тасралтгүй зохицуулалт хийх боломжтой.

IoT дуу илрүүлэх зангилаа систем нь дууг тодорхойлж, баталгаажуулах үед илэрсэн дууны GPS-ийн нарийн координат бүхий дохио, мэдээллийг үүлэн сервер рүү илгээдэг. Дараа нь үүлэн сервер энэ мэдээллийг боловсруулж, байршлын мэдээллийг GSM модемоор дамжуулан дрон руу илгээдэг. Координатыг хүлээн авсны дараа дрон бие даан хөөрч, заасан газар руу чиглэнэ. Мөн нислэгт давхар хяналт тавих нь дроны нислэг

тогтвортой, нарийвчлалтай байх боломжийг илүү бүрдүүлэх төдийгүй үр дүнтэй, агаарын тандалт хийх боломжтой байдаг.

Байршил дээр дрон нарийвчилсан судалгаа хийж, өндөр нарийвчлалтай зураг авах эсвэл шууд видео бичлэг цацаж, хууль бус мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагаа байгаа эсэхийг шалгана. Авсан видео бичлэгийг бодит цаг хугацаанд үүлэн сервер рүү буцааж дамжуулдаг бөгөөд үүнийг шууд дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргах зорилгоор боловсруулдаг.

Дээрх зорилгоор тус систем нь Amazon Web Services (AWS) серверийг ашигладаг бөгөөд илүү хүчирхэг, өргөтгөх боломжтой үүлэн тооцооллын өгөдлийг нөөцийг бий болгодог. Серверийн тал дээр AWS-ийн бэлэн AI хэрэгслүүд нь бичлэг дотор хүн эсвэл сэжигтэй үйл ажиллагаа байгаа эсэхийг илрүүлэхийн тулд ажилладаг ба бодит цагийн видеонд шинжилгээ хийх оновчтой, нарийвчлалтай болгосон сургалтын дэвшилтэт загваруудыг ашигладаг.

Хэрэв ямар нэгэн хууль бус үйл ажиллагаа илэрсэн тохиолдолд дрон нь гэмт хэрэгтнүүдэд анхааруулах, цаашид хууль бус үйлдлийг таслан зогсоох зэрэг идэвхтэй гэрэл, дууны дохиоллын системээр тоноглогдсон байна. Mission Planner программ хангамжийг ашиглаж дроны нислэгийн зам, түр зогсох цэг, тодорхой үйлдлүүдийг нарийн төлөвлөж, гүйцэтгэж, хяналтын ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлдэг.

AWS cloud үйлчилгээ, AI хэрэгсэл, Mission Planner програм хангамжийн энэхүү интеграци нь бодит цагийн хяналт, хөндлөнгийн оролцоо хийх чадвартай өндөр мэдрэмжтэй, автоматжуулсан системийг бий болгодог (Boateng, Agyeman, Inyong, & E.S.K. Agbadzah, 2023) юм.





## Байгаль орчинд оруулах хувь нэмэр, шинэлэг тал:

1. Технологийн шинэлэг интеграци: Энэхүү судалгаа нь IoT, UAVs, AI-ийг хослуулан иж бүрэн хяналтын системийг бий болгодог. Нисгэгчгүй камераар дамжуулан гинж, хөрөөний дуу авианы акустик илрүүлэлтийг биечилсэн хяналттай нэгтгэх нь хууль бус мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагааг тодорхойлох, таслан зогсоох найдвартай арга юм.

2. IoT системийн батерейны ашиглалтын хугацаа: IoT зангилаа нь эрчим хүч хэмнэх механизмаар бүтээгдсэн бөгөөд нэг батерей дээр дор хаяж 8 жил ажиллах боломжийг олгодог. Энэхүү шинэчлэл нь засвар үйлчилгээний зардлыг мэдэгдэхүйц бууруулж, алслагдсан ойн бүсэд урт хугацааны байршил, хяналтыг баталгаажуулдаг.

3. CNN-ийн тусламжтайгаар илрүүлэх Өндөр нарийвчлал: гинж, хөрөөний дуу чимээг илрүүлэх зориулалттай Convolutional Neural Network (CNN) загварыг ашиглах нь өндөр нарийвчлалд хүрч, үр дүн нь 99.37% нарийвчлалтай, 0.0185 бага алдагдалтай байдаг байна. Энэ нь CNN-ийн системийн үр нөлөө уламжлалт эргүүл, хяналт шалгалтын тогтолцооноос давсан үзүүлэлт гаргж байгааг харуулж байна.

4. Бодит цагийн хариу үйлдэл ба идэвхтэй оролцоо: системийн бодит цагийн хариу үйлдэл хийх чадвар нь дуу чимээ, гэрлийн дохиололоор тоноглогдсон Дроныг идэвхжүүлснээр шууд хөндлөнгөөс оролцох боломжийг олгодог. Энэхүү шинэ UAV-ийг идэвхтэй үйл ажиллагаанд ашиглах нь хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үйл ажиллагааг үр дүнтэй саармагжуулдаг.

5. Өргөтгөх чадвар, найдвартай харилцаа холбоо: систем нь өргөтгөх

боломжтой байхаар бүтээгдсэн тул өргөн ойн сан бүхий газар нутагт өргөн цар хүрээнд хяналт тавих боломжийг олгодог. LoRaWAN-ийг харилцаа холбоонд ашиглах нь хол зайд найдвартай өгөгдөл дамжуулах боломжийг олгодог төдийгүй хүрээлэн байгаа орчны хяналт шинжилгээний янз бүрийн хувилбарууд нь тус системийн хэрэглээг улам бүр сайжруулдаг.

## Дүгнэлт

Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, мөн 2 дахь хэсэгт “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн” хэмээн тус тус заасан байдаг.

Энэхүү өгүүллээр UAVs, IoT, AI технологийг нэгтгэх замаар хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн түгээмэл асуудлын цогц, шинэлэг шийдлийг гаргасан бөгөөд микрофон, микроконтроллероор тоноглогдсон хямд өртөгтэй IoT зангилааг багтаасан дэвшилтэт технологийг ашигласнаар энэхүү систем нь хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулаад зогсохгүй байгаль орчныг хамгаалах автоматжуулсан шийдлүүдийн шинэ стандартыг тогтооно.

Энэ төрлийн судалгааг цаашид хийх нь хиймэл оюуны алгоритм дахь сайжруулалтыг судлах, системийн програмуудыг хүрээлэн буй орчны хяналтын бусад цэгүүдэд өргөжүүлэх, илрүүлэх чадварын цар хүрээг өргөжүүлэхийн тулд нэмэлт мэдрэгчийг

нэгтгэх замаар энэ ажилд тулгуурлах боломжтой юм.

AI технологи, ялангуяа гүнзгийрүүлсэн сургалтын алгоритмууд нь хууль бус үйл ажиллагааг хурдан, шуурхай хугацаанд тогтоохын тулд томоохон мэдээллийн санг боловсруулах, дүн шинжилгээ хийхэд үр дүнтэй болох нь батлагдсан.

Хиймэл дагуулын зураглал, газрын эргүүл гэх мэт уламжлалт аргууд нь үнэ цэнэтэй өгөгдлийг өгдөг боловч тэдгээрийн хязгаарлалт нь олон тооны мэдээллийн эх үүсвэрийг хөшүүрэг болгодог шинэлэг шийдлүүдийн хэрэгцээг тодотгож өгдөг.

Хэдийгээр ахиц дэвшил гарсан ч өгөгдлийн чанар, тооцооллын чанар мөн хүрээлэн буй орчны хүчин зүйлүүд гэх мэт бэрхшээлүүд хэвээр байна. Харин энэ хохирлыг багасгахад дээрх системийг нэвтрүүлэх нь маш үр дүнтэй шийдэл болно.

### Санал

Хиймэл оюун (AI), UAVs, IoT зэрэг дэвшилтэт технологийг нэвтрүүлэх нь хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрс сайжруулаад зогсохгүй Хүрээлэн байгаа орчны эсрэг бусад гэмт хэргүүдэд ашиглахад үр дүнтэй.

Цаашдын судалгаа нь өгөгдлийг урьдчилан боловсруулах, илүү дэвшилтэд AI загварыг хөгжүүлэх, олон тооны мэдээллийн интеграцийг сайжруулах замаар эдгээр асуудлыг шийдвэрлэх ёстой. Үүнээс гадна хууль бус мод бэлтгэх гэмт хэрэгтэй тэмцэхэд засаглал, олон улс, төрийн болон төрийн бус байгууллага, нөхөрлөл, хоршоолол, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх нь чухал үүрэгтэй.

Эдгээр технологийн боломжийг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхийн тулд

байнгын судалгаа, боловсруулалт зайлшгүй шаардлагатай. Энэ чиглэлд AI алгоритмыг илүү нарийвчлалтай боловсронгуй болгох, зайнаас тандан судлах шинэ аргачлалыг боловсруулах, хяналтын нэгдсэн системийг бий болгох зэрэг орно.

Технологийн дэвшлийг үр дүнтэй засаглалтай хослуулснаар байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг эрс сайжруулж, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн байгаль орчин, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, ойн тогтвортой менежмент, хадгалалтыг дэмжих боломжтой.

### Ашигласан материал

1. Boateng, R., Agyeman, J., Inyong, S., & E.S.K. Agbadzah, H. (2023). Adjarko - Exploring species extraction volume and residues of illegal and conventional logging operations- Asian J. Environ. Ecol. pp. 59-68.

2. G.M.A.S. Wibawa, M., & Muhibbin, B. (2023). Parmono- Criminal actions of illegal logging in the perspective of forestry law- Int. J. Law, Environ. Natural Resour., 3 (1). pp. 84-95.

3. Z. Hasan, M. (2023). Astarida- Penegakan hukum lingkungan sebagai upaya pembangunan yang berkelanjutan- Jurnal Ilmiah Advokasi, 11 (1) . pp. 128-140.

4. Гэмт хэргийн цагаан ном. (2021, 2022, 2023, 2024, 2025).

5. Монгол Орны Газарзүй-Геоэкологи Сэтгүүл - МОГГС. (2022). *Монгол Орны Газарзүй-Геоэкологи Сэтгүүл - МОГГС*, 174.

6. Монгол Улсын Эрүүгийн хууль. (2015).

7. Энхболд Б., Гантулга С. (2024). *Эрүүгийн эрх зүй тусгай анги сурах бичиг*.





## ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ИЛРҮҮЛЭХЭД НЭЭЛТТЭЙ ЭХ СУРВАЛЖИЙН МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛЖ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛЫН (OSINT) ОНЦЛОГ

### METHODOLOGY RESEARCH TO ACCESS THE POTENTIAL AND MODALITIES OF APPLYING OPEN-SOURCE INTELLIGENCE (OSINT) ANALYZING AND COLLECTING IN DATA TO INVESTIGATE CRIME OF HUMAN TRAFFICKING

**Д.Мөрөн**

Хууль зүйн доктор, профессор, Монгол Улсын Гавьяат хуульч

**D. Muren**

Honored Lawyer of Mongolia, Doctor (Ph.D), Professor

**Ч.Тулгацоодол**

Гадаадын иргэн, харьяатын газрын Хяналтын улсын байцаагч, Орхон их сургуулийн докторант

**Ch. Tulgatsoodol**

Inspector of Mongolia Immigration Agency, Doctoral of Orkhon University

хариуцлагатай зохиогч: murun.d@gmail.com

**Хураангуй:** Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд интернэтийн хэрэглээ хөгжихийн хирээр, түүнийг буруугаар ашиглах болсон нь хүн худалдаалах гэмт хэрэг, тэр дундаа бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг цахим орчинд үйлдэгдэхэд ихээр нөлөөлж байгаа асуудлын талаар болон Олон улсын цагдаагийн байгууллага энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд ашиглаж байгаа Нээлттэй эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд дүн шинжилгээ хийх аргачлал (OSINT) түүний онцлогын талаар авч үзсэн болно.

Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлийн онцлог, хэрхэн олж тогтоон цуглуулах, дүн шинжилгээ хийх түүнийг нягтлах, нууцлалыг хадгалах, судалгааны ажил явуулах ач холбогдол, мөрдөгч нарыг мэргэшүүлсэн сургалтанд хамруулах, цахим нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд тооцох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагын талаар судалгааны ажлыг хийж хүн худалдаалах гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхэд анхаарах тодорхой санал дүгнэлтийг боловсрууллаа.

**Abstract:** This research article was conducted the introduction of the internet, and its misuse, had a significant effect on human trafficking, including on trafficking for sexual exploitation and methodology research to access the potential and modalities of applying open-source intelligence (OSINT) analyzing and collecting in data to investigate crime of human trafficking by International Police Authorities.

The conclusion of this research was to examine and analyze the existing legal landscape, regulations and policies in Mongolia pertaining to the acquisition and fortification of digital evidence in the context of identifying and combating human trafficking, and features of Open-source intelligence (OSINT), how to collect cases, analyzing for importance information, conducting comprehensive training programs for investigators

**Түлхүүр үгс:** Нээлттэй эх сурвалжийн мэдээлэл цуглуулах арга зүй

**Keywords:** Methodology for collecting data of open-source intelligence

## Удиртгал

Олон улсад цахим хэрэгсэл ашиглан гэмт хэрэг үйлдэх ялангуяа цахим орчинг ашиглан насанд хүрээгүй хүнийг худалдаалах гэмт хэрэг өссөөр байгаа ба Монгол Улсын хууль хяналтын байгууллага энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд бэлэн байх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Статистик мэдээллээс үзэхэд 2018 оноос хойш Монгол Улсын иргэд Камбож, Малайз, Мьянмар, Филиппин, Макао, ХонгКонг, Хятад, Япон, Бельги, Турк, Унгар, АНУ зэрэг дэлхийн 18 улсад бэлгийн мөлжлөгийн золиос болон хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон ба 70 гаруй хохирогчийг холбогдох байгууллагууд хамтран эх оронд нь авчиржээ. Цагдаагийн байгууллагын мэдээллээр 2023-2025 оны эхний 9 сарын байдлаар Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн судалгаагаар Эрүүгийн хуулийн 12.3, 12.6, 13.1, 16.8, 16.9 зүйлээр 176 эрүүгийн хэрэгт сэжигтнээр 52, хохирогчоор 141 хүн тогтоогдон шалгагдсан ба энэ төрлийн гэмт хэргийн гаралт өссөн үзүүлэлттэй байна. Ялангуяа цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж байгаа Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх ажиллагаанд Цагдаагийн байгууллагад бүтэц, зохион байгуулалтын шинэчлэл хийж техник технологийн орчин үеийн арга хэрэгслийг өргөнөөр ашиглах хэрэгцээ шаардлага гарсаар байна.

## Үндсэн хэсэг

Насанд хүрээгүй хүүхдийн бэлгийн мөлжлөгийг харуулсан бичлэгүүдийг анх 1990-ээд оноос цахим хуудсуудаар дамжуулж интернэтийн өргөн хүрээ болон нэрээ нууцлах давуу талыг ашиглаж түгээж эхэлсэн. Дараа нь цахим орчинд "бусад төрлийн бэлгийн үйлчилгээний зар сурталчилгаа" дэлгэрч эхэлсэн байдаг. Өнөөдөр олон

улсад бэлгийн үйлчилгээ худалдан авагчдыг элсүүлэх, сурталчлах, уруу татах үйл ажиллагааны дийлэнх нь интернэтээр дамжин цахим орчинд явагдаж байна. (United Nations, 2021)<sup>1</sup>

Шинэ техник технологийн хурдацтай хөгжил нь гэмт хэрэгтнүүдэд илүү зохион байгуулалттайгаар, газарзүйн өргөн хүрээг хамарч ашиг орлого олох боломжийг олгосоор байгаа ба гэмт этгээдүүд хохирогчийг элсүүлэх, хяналтдаа байлгах, бэлгийн мөлжлөгийн хохирогч болгох зэрэг хүн худалдаалах гэмт хэргийн бүхий л үе шатанд технологийг ашигладаг. Технологи нь хүн худалдаалах, тэр дундаа бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг үйлдэх томоохон хэрэгсэл болжээ.

Хүчирхийлэл, мөлжлөгийг цахимаар шууд дамжуулан харуулах боломжтой болсон нь тэдний үйлчлүүлэгчдийн хүрээг тэлж улмаар хууль бус ашиг орлогыг нэмэгдүүлэх боллоо. Хохирогчийн видео бичлэг, фотозураг нь олон веб хуудсуудад дахин дахин нийтлэгдсэнээр түүнийг үзэх үзэгчдийн тоо нэмэгдсээр байна. Мөн өсвөр насны хүүхдүүдэд зориулсан аппликейшнүүд нь танихгүй хүнтэй хяналтгүйгээр холбоо тогтоох, асар их хувийн мэдээлэлд нэвтрэх гүүр болдог болсон. Хохирогчийг тохиролцоо хийх замаар хувийн фотозураг, видео бичлэгээ илгээхийг ятгаж улмаар хяналтандаа оруулах, гэр бүлийнхэнд нь илгээнэ, үзүүлнэ хэмээн сүрдүүлдэг хэлбэрт шилжсэн байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг элсүүлэхэд тулгардаг байсан газарзүйн байршил, заавал биечлэн уулзах гэх мэт бэрхшээлүүд байхгүй болжээ. Интэрнэт нь гар утасны аппликейшн, мессеж, олон нийтийн цахим сүлжээг ашиглан хохирогчдын тоог өмнө байснаас ихээр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж





Хүний эрхийн хамгаалалт

байна. Мөн гэмт хэрэгтнүүд хохирогчийг элсүүлэх, хяналтандаа байлгахад ихээхэн нөлөө үзүүлэхүйц урьд өмнө байгаагүйгээр хүний хувийн мэдээлэлд нэвтрэх, олж авах, ашиглах боломжийг интернэт орчин олгож байгаа. Тэд боломжит хохирогчийн цахим олон нийтийн сүлжээг хянах замаар тэдний эмзэг байдлыг ашиглан гэмт хэргийн хохирогч болгох боломжтой болсон байна. Жишээ нь, хувь хүн санхүүгийн хүнд нөхцөл байдалд байгаа нь илт байвал гэмт хэрэгтнүүд хуурамч ажлын санал тавьж, амлалт өгөх замаар уруу татдаг.

Гэмт хэрэгтэнүүд шинэ технологид дасан зохицох өндөр чадвартай, хууль сахиулах байгууллагаас өөрсдийнх нь эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар хялбархан олж мэдэж, гэмт үйлдлээ нуун далдлахад чиглэсэн хууль эрх зүйн цоорхойг ашиглан мэдлэг ур чавдараа дээшлүүлсээр байна. Дэлхий даяар ашиглагдаж буй сүлжээний нэг хэсэг болох 'dark web' нь ердийн хайлтын системээр илрэх боломжгүй 'хууль бус хаалттай сүлжээ' юм. Хэрэглэгчдэд тухайн вэб хуудас руу болон тус хуудаст байгаа мэдээлэлд нэвтрэх тусгайлсан эрх бүхий зөвхөн шифрлэгдсэн тусгай холбоос хэрэгтэй тул мөрдөгчид энэ төрлийн гэмт хэргийн сонирхогч, хохирогч, үйлчлүүлэгч, хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдийг олж тогтооход хүндрэлтэй нөхцөл байдлыг үүсгэдэг.

Хууль сахиулагчид интэрнетэд суурилсан хүн худалдаалах гэмт хэрэг, мөлжлөгийг илрүүлэхтэй холбоотой бэрхшээлүүдтэй тулгарсаар байгаа хэдий ч нөгөөтэйгүүр тухайн гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэх, хохирогчийг олж тогтоох зэрэгт ашиглахад нэн шаардлагатай техник технологи, хэрэгслүүд шинээр бий болсоор байна.

2019 онд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хамтран ажилладаг технологийн компаниудын нэгдэл болох 'Tech Against Trafficking' (Хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг технологи) байгууллага нь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага (ИОМ) болон бусад олон улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглаж болох 260 гаруй технологийг тодорхойлжээ. Үүнд хувь хүний фотозураг танихаас эхлээд хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдээлэх, өгөгдлийн санг удирдах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, гүнзгийрүүлсэн сургалтуудад хамруулах болон хиймэл оюун ухаан ашиглах зэрэг хэрэгслүүд багтдаг.

Эдгээр хэрэгслийн ихэнх нь тухайлбал, хүний нүүр царай таних, гүнзгийрүүлсэн сургалтууд зэрэг нь хууль бус буюу далд сүлжээ (хаалттай сүлжээ)-нээс өгөгдөл цуглуулахад шаардлагатай нээлттэй эх сурвалжийн мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийх аргачлалыг (OSINT) ашиглахад хэрэглэгдэх боломжтой байна.

Олон орны Цагдаагийн байгууллага "OSINT" судалгаа хийх аргачлалыг хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг шалгах, хариу арга хэмжээ авах хэрэгсэл болгон ашиглах нь улам бүр нэмэгдэж байна. Тэд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгч гэмт этгээдүүд, хохирогчийг олж тогтоох, гэмт хэргийн уялдаа холбоог олох зорилгоор "OSINT" судалгаа хийх аргачлалыг ашигладаг. Мөн цахим ажлын зар сурталчилгаа нийтэлдэг вэб хуудсууд, тэдгээрийн хөтчийг судалж, бусад зар сурталчилгаа, эцэст нь хохирогч, гэмт этгээдийн хоорондын харилцаа, холбоог олж тогтоох зэрэгт идэвхтэй ашиглаж байна.

“OSINT” гэдэг нь мэдээллийн технологийг ашиглан үйлдэгдсэн гэмт хэргийг илрүүлэхэд шаардлагатай асуултад хариулт авах зорилгоор олон нийтэд нээлттэй мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

“Нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх” гэдэг нь тодорхой нэг асуултанд хариулахын тулд олон нийтэд нээлттэй мэдээллийн эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт гаргахыг хэлнэ.

Тухайлбал, вэб хуудсууд, хэлэлцүүлгийн өрөөн дэх харилцан яриа, олон нийтийн мэдээллийн сүлжээ, ажлын зар сурталчилгаа зохион байгуулж буй вэб хуудсуудын мэдээлэл, бусад бүхий л нээлттэй эх сурвалжуудын мэдээлэлд дүн шинжилгээ хийх зэрэг багтана.

Өнөөдөр нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд хийх дүн шинжилгээний аргачлалыг мэдээлэл шаардсан асуултад хариулт авах зорилгоор хувь хүн, хууль сахиулах байгууллага, маркетингийн компаниуд гэх мэт олон салбар, тоглогчид ашигладаг болсон.

### “OSINT” буюу нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд хийх дүн шинжилгээний аргачлал

Боловсруулалт хийж, дүн шинжилгээ хийгээгүй цуглуулсан мэдээлэл нь оновчтой баримт мэдээ болдоггүй онцлогтой тул зөвхөн дүн шинжилгээ хийгдсэн мэдээллийг шийдвэр гаргахад ашиглаж болох “баримт мэдээ” гэж үздэг.

Мэдээлэл боловсруулах 5 үе шат байдаг бөгөөд энэ нь “OSINT” судалгаанд хамааралтай.

**Бэлтгэл ажил.** Мөрдөгч хариулт авахыг хүссэн асуултыг тодорхойлж, тухайн мэдээллийг олоход хамгийн тохиромжтой эх сурвалжуудыг тодорхойлно;

**Мэдээлэл цуглуулах.** Байж болох боломжит мэдээллийн эх сурвалжуудаас мэдээлэл цуглуулах;

**Боловсруулах.** Мэдээллийг зохион байгуулалтад оруулж цэвэрлэх;

**Дүн шинжилгээ хийх.** Мөрдөгч мэдээллийг хөрвүүлж зохих тайланг боловсруулах;

**Тайлагнах.** Нэгтгэж, дүн шинжилгээ хийсэн мэдээллийг талуудад танилцуулах, тайлагнах;

Гэмт хэрэг мөрдөн шалгах үйл ажиллагаанд “OSINT”-ыг ашиглах хоёр зам байдаг.

Идэвхгүй байдлаар – Судлах зорилтот хүнтэй харилцахгүй.

Идэвхтэй байдлаар- Судлах зорилтот хүнтэй ямар нэгэн байдлаар харилцаа тогтооно. Жишээлбэл, судлах зорилтот хүнийг нийгмийн сүлжээнд "найз"-аар нэмэх, хэлэлцүүлгийн өрөөнд зорилтот хүнтэй харилцах гэх мэт.

Дээр дурьдсанчлан Тагнуул, Цагдаагийн байгууллага “OSINT”-ыг идэвхгүй байдлаар тогтмол ашигладаг бөгөөд нууц цахим сайтууд дээр тавигдсан зар сурталчилгаа нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдийн бэлгийн үйлчилгээг санал болгож байгаа эсэхэд хяналт тавихад ашигладаг. (Gill.R, 2023)

Мөрдөгчид бэлгийн үйлчилгээний зар сурталчилгаан дээрх утасны дугаар, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэл түгээж буй этгээдийн мэдээллийг харьцуулж, хүн худалдаалах гэмт хэргийн сэжиг, хам шинж байгаа эсэхийг тогтоохоор холбоос, дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулдаг. Тэд зар сурталчилгааны хэв маягийг ажиглан хэрэглэгдэж буй үг хэллэг, хохирогчдын өгсөн тодорхойлолт зэргийг ашиглан зар сурталчилгааны мэдээллийн өгөгдлийн цэгүүдийг холбох боломжтой мэдээллүүдийг судалдаг. Ингэснээр





мөрдөгчид “OSINT” судалгааны идэвхтэй хэв маягийг ашиглах боломжтой болох бөгөөд хүн худалдаалах гэмт хэргийн сэжигтэнтэй “үйлчлүүлэгч” мэтээр холбоо тогтоох оролдлогыг цахим сүлжээгээр хийж мэдээллийг улам бататгах боломжтой болно.

АНУ-ын Цагдаагийн байгууллага “Innocent Lives” сан (ILF) зэрэг ашгийн бус байгууллагад хандаж хүн худалдаалах гэмт хэрэгтнийг илрүүлэхэд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг хүсдэг байна.

Тус сан нь цахим сүлжээнд хүүхдийн бэлгийн хүчирхийлэгч гаж донтнуудыг нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх замаар хайн илрүүлдэг өндөр ур чадвартай мэргэжилтнүүдээс бүрдсэн ашгийн бус байгууллага ба интернетэд идэвхтэй хайлт хийж, хүүхдийн бэлгийн хүчирхийллийн хохирогчдын зургийг олж, дараа нь хууль сахиулагчидтай хамтран гэмт хэрэгтнүүдийг олж тогтоохоор ажилладаг.

Цагдаагийн ажилтнууд хохирогчдыг олж тогтоосон тохиолдолд мөн гэмт хэрэгтнийг илрүүлэхэд тусламж авах зорилгоор “Innocent Lives” сан (ILF)-д ханддаг бөгөөд энэ байгууллагын мэргэжилтнүүд хаалттай вэб буюу “dark web”-д хайлт хийж гэмт хэрэгтнүүдийг тогтооход туслалцаа үзүүлэн ажилладаг<sup>1</sup>. (ILF, 2023)

Цагдаагийн байгууллага интернетэд суурилсан “OSINT” судалгаа хийх аргачлалыг ашигласнаар ажлын үр дүн нэмэгдэх боломжтой ба “OSINT” нь "харьцангуй бага нөөцөөр ажиллах" нөхцлийг бүрдүүлдэг. Уг судалгааг хийх аргачлалыг ашигласан мөрдөн шалгах ажиллагаа нь хайлтын мэдээллийг алсын зайнаас найдвартай цуглуулдаг бөгөөд хэргийн газарт албан хаагч ажиллуулахаас хамаагүй

бага цаг хугацаа, зардал, хүн хүч шаарддаг. Түүнчлэн автоматжуулсан тоон мэдээлэл цуглуулах хэрэгслүүд буюу тусгай программ хангамж ашиглах нь их өгөгдлийг нэгтгэх ажлыг илүү үр дүнтэй, хурдан болгодог байна. Нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ, судалгаа хийх нь мөн харьцангуй бага эрсдэлтэй мөрдөн шалгах ажиллагаа бөгөөд эрсдэл нь ихэвчлэн мэдээлэл алдагдах тохиолдолд хувь хүний болон байгууллагын нэр хүндэд хохиролтой байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Монгол Улсад гэмт этгээдүүд эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгт дараах байдлаар элсүүлж байна.

Фейсбүүк, Инстаграм зэрэг олон нийтийн сүлжээнд хуурамч хаяг нээж охид, эмэгтэйчүүдтэй танилцах, дотно харилцаа үүсгэх замаар нүцгэн фото зураг, бичлэгийг нь хуурч мэхлэх замаар авч түүгээр нь сүрдүүлж бэлгийн харилцаанд орохыг шаарддаг.

Цахим орчинд “Гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучлана” гэсэн зарыг байршуулж зардлыг нь дааж итгэлийг нь олох замаар улсын хилээр гаргаж гадаад улсын гэмт бүлэглэлийн эрх мэдэлд шилжүүлдэг. Фейсбүүк, Инстаграм, үнэгүй зар болон бусад зарын сайтуудад “Массажист, бариа засалд сургаж ажилд авна. Сарын цалин 5-8 сая төгрөг” гэх зар байршуулж ажилд орохоор ирсэн охид, эмэгтэйчүүдийн эмзэг байдлыг нь далимдуулан элсүүлэх зэрэг арга замыг ашигладаг байна.

Фейсбүүкт “Санхүү авна, өгнө” гэсэн зар байршуулах. Ийм зар Монгол Улсад маш түгээмэл бөгөөд санхүүгийн хувьд хүнд байдалтай эмэгтэйчүүд, охидыг уруу татахад ашигладаг байна.

Цахим орчноос гадна, Монгол Улсад танилын хооронд ам дамжсан яриагаар хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг элсүүлэх арга одоо ч

хамгийн түгээмэл ашиглагдсан хэвээр байна. Хохирогчдыг ихэнхдээ "найзууд" нь элсүүлдэг байна. Эхлээд олон нийтийн сүлжээгээр элсүүлж, улмаар тэдгээр "элссэн хүмүүс" нь дараа дараагийн танил эмэгтэйчүүд, охидыг ам дамжуулан гэмт хэргийн хохирогч болгодог байх магадлалтай. Түүнчлэн бусад улс оронд ашиглагддаг хохирогчоо хянах аргуудыг мөн ашигладаг ба тэд ихэнх тохиолдолд хохирогчийн хувийн нууц фото зураг, бичлэгийг олон нийт болон эсвэл гэр бүл, найз нөхдөд нь үзүүлнэ, нийтлэнэ гэж заналхийлж сүрдүүлдэг байна. "OSINT" аргачлалыг гадаадын хууль сахиулах байгууллагууд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид аль зочид буудлуудыг ашиглаж байгааг шалгахад мөн ашигладаг. Жишээ нь, "TraffickCam" нэртэй программ нь ухаалаг утастай хэн бүхэнд зочид буудлын өрөөнүүдийн зургийг оруулах боломжийг олгодог. Ингэснээр хууль сахиулагчид хохирогч болох хүний үйлчилгээг хаана санал болгож байгааг олж тогтооход ашигладаг байна. Expedia зэрэг сайтуудын зургийг мэргэжлийн гэрэл зурагчид авдаг бол бэлгийн үйлчилгээний зар сурталчилгаанд тавигдсан зургийг хохирогчид өөрсдөө ухаалаг гар утсаар авсан байдаг тул мэргэжлийн зургийг засваргүй авсан зурагтай харьцуулахад хууль сахиулагчдад хүндрэл учирдаг байна. TraffickCam хэрэглэгчид дэлхийн 255,000 зочид буудлаас 3 сая орчим зураг оруулжээ.

Монгол Улсад арилжааны бэлгийн үйлчилгээ буюу биеэ үнэлэлт, бэлгийн мөлжлөг үйлдэгдэх магадлалтай газруудын (ялангуяа зочид буудал, баар, массажны газар, зочид буудал) байршлын талаар цагдаагийн байгууллага ерөнхийд нь мэддэг. Цагдаагийн байгууллага нь мэдэгдэж буй дээрх байгууллагуудад

тогтмол нэгжлэг хийдэг тул хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчид бэлгийн үйлчилгээ үзүүлдэг, бэлгийн мөлжлөг үйлддэг газрын байршлыг өөрчлөх боломжтой юм. Иймээс TraffickCam гэх мэт програмуудыг ирээдүйд хохирогч болон хохирогчдын бэлгийн мөлжлөгт өртөж байгаа газруудыг олж тогтооход ашиглаж болох юм.

Монгол Улсын хэмжээнд мэдээлэл технологийг ашиглан үйлдэгдэж буй хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдлын талаар илүү их судалгаа, шинжилгээг хийх шаардлагатай байгаа төдийгүй олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөнөөр ашиглаж охид эмэгтэйчүүдийг гэмт хэргийн хохирогч болгох аюул улам бүр нэмэгдсээр байна. Цагдаагийн байгууллага хохирогчдыг бэлгийн мөлжлөгт уруу татсан, хууран мэхэлсэн зар сурталчилгаануудыг цахим орчинг илрүүлсээр байна. Энэ нь мөрдөгчид "OSINT" аргачлалыг ашиглан хууль бус сүлжээ, түүнд оролцогчдыг олж тогтоохын тулд мэдээллийг хайх, эмхэтгэх ур чадварыг эзэмшсэн зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол Улсын хууль сахиулах байгууллага цахим орчинд үйлдэгдэж байгаа хүн худалдаалах гэмт хэргийг "OSINT" судалгаа хийх аргачлал ашиглан илрүүлэх, мөрдөн шалгах, улмаар цахим нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхэд Монгол Улсын эрх зүйн орчинг судлах, үнэлэх зайлшгүй шаардлагатай.

"OSINT" аргачлалыг тогтмол ашиглахад хууль сахиулах байгууллагуудад тулгардаг хамгийн том бэрхшээлийн нэг бол хүний нөөцийн хомсдол юм.

Мөрдөгч нар холбогдох судалгааг хийх боломжгүй үед "OSINT" судалгаа хийдэг орон тооны мэргэжлийн шинжээчтэй байх нь оновчтой юм.





Ингэснээр бусад мөрдөгчид “OSINT” судалгааны үр дүнд бий болсон мэдээллийг авах боломжтой болох бөгөөд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх бусад мөрдөн шалгах үйл ажиллагаагаа зохион байгуулахад хүндрэл учруулахгүй. Авсрала Улсад тухайлбал, “OSINT” судалгаа хийдэг тусгай нэгжийг цагдаагийн байгууллага нь байгуулсан ба тус нэгж нь зөвхөн нээлттэй мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг, мэргэжлийн мэдээллийн шинжээчид ажилладаг байна. Мөн Хойд Америкийн хууль сахиулах байгууллагын ажилтантай хийсэн ярилцлагаас үзэхэд утасны дугаар, цахим шуудангийн хаяг, олон нийтийн сүлжээ, IP хаягаар нь гэмт этгээдүүдийн арга барил, сүлжээг тодорхойлохоор үндсэн түвшинд өгөгдлийг гаргаж авч, дүн шинжилгээ хийдэг.

Хүн худалдаалагчид мэдлэг, ухамсарын түвшин, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй байдаг ч хохирогчдын үйлчилгээг ихэнхдээ цахимаар сурталчилдаг тул мэдээлэл цуглуулах,

дүн шинжилгээ хийх аргачлал, хэрэглүүрийг эзэмших нь хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгахад нэн чухал юм.

“OSINT” судлагааг “гоё багаж хэрэгсэл ашиглах шаардлагагүйгээр сайн хийж болно” гэдгийг мэргэжилтнүүд хүлээн зөвшөөрдөг. Мөрдөгчид гэмт хэрэгтний арга барил, аргачлалыг мэдэж авснаар “OSINT” судалгааг хийж эхлэх боломж бүрддэг.

Гэмт хэрэгтнүүд өөрсдийн хууль бус үйл ажиллагаагаа хэрхэн санхүүжүүлж байгаа, шилжүүлж байгаа болон эдгээр орлогоо хаана төвлөрүүлж байгааг “OSINT” дүн шинжилгээгээр илрүүлэх боломжтой байдаг. Жишээ нь, АНУ-ын цахим

орчинд бэлгийн үйлчилгээний сурталчилгаа явуулдаг 27 сувгийн 15 нь крипто-валютаар төлбөр хийхийг зөвшөөрдөг тухай мэдээлжээ. Маш олон крипто валютын төлбөр олон нийтийн блокчэйд хийгддэг тул АНУ-ын хууль сахиулах байгууллага блокчэйд дүн шинжилгээ хийх аргачлалыг хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд ашигладаг байна. Энэхүү блокчейн шинжилгээ хийх программ нь алгоритмыг автоматаар хянах аргыг ашиглан нийтийн блокчейн дансны систем дээр хийгдэж буй гүйлгээний шинж чанарт дүн шинжилгээ хийж виртуаль хэтэвчийн холбогдох гүйлгээний асар их мэдээллийн санд дүн шинжилгээ хийдэг. Сүүлийн үед хүн худалдаалах гэмт хэрэгтнүүд крипто-валютыг хэрэглэх нь улам бүр нэмэгдэж байгаа нь “OSINT” хийх аргачлалыг ашиглан “мөнгөний араас мөшгих” замаар гэмт хэрэгтнийг илрүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.

Хойд Америкт нэлээд олон хууль, хууль сахиулах байгууллагууд Spotlight, Traffic Jam зэрэг программ хангамжид суурилсан (Saas) хэрэгслийг ашиглан хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй зар сурталчилгааны хөтчийг илрүүлж, улмаар мэдээлэл, зураг, утасны дугаар, олон нийтийн сүлжээн дэх зохион байгуулагчийн цахим хаяг зэргийг “OSINT” ашиглан олж тогтоож эхлээд байгаа тухай мэдээлсэн байна.

Spotlight болон Traffic Jam нь эцсийн хэрэглэгчид хохирогчдыг илүү хурдан аврах, гэмт этгээдийг илрүүлэхийн тулд фотозураг, утасны дугаар, олон нийтийн сүлжээний хэрэглэгчийн нэр гэх мэтийг хайхаар интернетэд нэвтрэх боломжтой үүлэн технологид суурилсан программ хангамжийн хоёр жишээ юм. Зөвхөн Spotlight гэхэд л хүн худалдаалах гэмт

хэргийн хохирогч болсон 14,874 хүүхэд, 16,927 хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгчдийг илрүүлэхэд тусалжээ.

Хайлтын мэдээллийн чанарыг ойлгох нь “OSINT” судалгаа хийж сурахад хууль сахиулах байгууллагад нэн чухал ур чадварт тооцогддог. Жишээлбэл, цахим зураг, видео бичлэгийн жинхэнэ эсэхийг шалгах нь “OSINT” судалгаа хийх мөрдөгчдийн чухал ур чадвар гэж тодорхойлсон байдаг. Мөрдөгчдийн хайлтын мэдээллийн чанарыг шалгахын тулд сурч болох чухал ур чадварууд нь:

Эх сурвалжийн мэдээллийг хэрхэн судлах вэ? Жишээлбэл, анх оруулсан контентыг олон нийтийн сүлжээнд шалгаж, "эх сурвалжийн нэр хүнд, өрөөсгөл болон найдвартай байдлыг" үнэлэх.

Зураг, видеоны мета мэдээллийг цуглуулснаар тухайн контент хаана, хэзээ үүсгэгдсэн талаар мэдээлэл авах боломжтой. Жишээлбэл, EXIF-ийн өгөгдлийг шалгах, гэрэл зурагтай холбоотой мэдээлэл нь гэрэл зургийг хэзээ, ямар камераар, хаана авсан зэргийг илрүүлэх.

"Мэдээллийг бусад мэдэгдэж байгаа баталгаатай эх сурвалжаар олон талаас нь судлах" гэх мэт бусад эх сурвалжийг ашиглан баталгаажуулах.

Шүүх шинжилгээний хэрэгслийг ашиглан зураг, видеог өөрчилсөн эсэхийг мэдэх, жишээлбэл, хиймэл оюун ухаан ашиглан өөрчлөлт хийсэн контентийг хайж олдог сайтад зураг, видеог байршуулах гэх мэт.

Гол хүмүүсийг хэн болохыг нь баталгаажуулах, гарал үүсэл, үндсэн мэдээллийг нь олж шалгах, тэдэнд мэдээллийн хэрэгслийг өөрчлөх сэдэл, арга хэрэгсэл байгаа эсэхийг тодорхойлох

Мөрдөгчид “OSINT” хийх явцад өөрсдийгөө болон байгууллагаа

аюулгүй байлгах талаар анхаарч ажиллах нь чухал.

Цагдаагийн байгууллага хүн худалдаалах гэмт хэргийг мөрдөн шалгах хүрээнд “OSINT” судалгааг хийж эхлэхээс өмнө нээлттэй эх сурвалжийн мэдээллийг цуглуулах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах үйл ажиллагааг дотоодын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын стандартад нийцүүлж журам боловсруулах шаардлагатай.

Журамд: Хэргийг мөрдөн шалгах явцад нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах зорилгыг тодорхойлж, баримтжуулахыг шинжээчээс шаардах зэрэг “OSINT” судалгаа хийж эхлэхээс өмнө хийх шаардлагатай алхмуудыг тоймлон тусгасан байх, судалгаа хийх зайлшгүй шаардлага хэрэгцээг баталгаажуулахаар зөвшөөрлийн түвшинг тодорхойлж, хэн зөвшөөрөл өгөх ёстойг тогтоох, олж авсан мэдээллийг найдвартай, үнэн зөв эсэхийг тогтоохоор үнэлгээ хийх тухай тусгах, хүний эмзэг мэдээлэл цуглуулах бол Мэдээлэл Хамгааллын Нөлөөллийн Үнэлгээг хэзээ, хэрхэн хийх тухай тусгах, мэдээллийг хянаж, хадгалах, мэдээлэл үнэн зөв, хамааралтай эсэхийг баталгаажуулах, мэдээллийг найдвартай хадгалж, зөвхөн нэвтрэх эрхтэй хүмүүс л ашиглах асуудлыг баталгаажуулах, тусгай компьютерээс мэдээллийг хадгалах зориулалт бүхий төхөөрөмжид зөөвөрлөхдөө аюулгүй ажиллагааг хангах, мэдээлэлд хэн нэвтрэх боломжтойг тодорхойлох, албан хаагчид/шинжээчдэд хуурамч нэр, хаяг үүсгэх ажлыг хэн хариуцах, хувь хүний мэдээлэл алдагдсан тохиолдолд баримтлах журмыг тогтоох, дотоодын болон олон улсын хууль сахиулах байгууллагатай мэдээлэл солилцох, мэдээлэл дамжуулах тухай журам боловсруулах, журмыг зөрчсөн тохиолдолд авах арга



МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ  
МОНГОЛ УЛСЫН  
ХУУЛЬ



хэмжээг нариймчлан тусгах, бодлогод мониторинг хийх, хянах – журам нь үр ашигтай хэрэгжих, ач холбогдолтой байхад шаардагдах шинэчлэн сайжруулалт хийгдэж байгаа эсэхэд тогтмол мониторинг хийх, хянах талаар тусгана.

Цагдаагийн байгууллага мөрдөгч нарт зориулсан “OSINT”-ын сургалтанд нээлттэй эх сурвалжийн хайлтын шинжилгээний үндэс, суурь мэдлэгийг олгох, цахим орчинд нийтлэгдсэн мэдээллийг анх оруулсан олон нийтийн сүлжээн дэх хаягийг олж үнэлэх, мэдээллийн эх сурвалж нь хэр нэр хүндтэй, найдвартай эсэхийг судалж үнэлэх, мэдээллийг бусад баттай эх сурвалжтай харьцуулах замаар олон талаас нь судлах” гэх мэт бусад эх сурвалжийг ашиглан мэдээллийг баталгаажуулах, шүүх шинжилгээний хэрэгслийг ашиглан фотозураг, видеог өөрчилсөн эсэхийг мэдэх, жишээлбэл, хиймэл оюун ухаан ашиглан хийсэн өөрчлөлтийг тогтоодог сайтад зураг, видеог байршуулан шалгах, гол хүмүүсийг хэн болохыг нь олж илрүүлэх, баталгаажуулах, тэдний талаарх мэдээллийг цуглуулж, ашигладаг нэр, таних мэдээллийг олж тогтоох, нээлттэй эх сурвалжид дүн шинжилгээ хийдэг үнэгүй дүн шинжилгээний хэрэгслүүдийг олж мэдэх, хэрэглэх, ашиглах, цагдаагийн алба хаагчид ашиглах боломжтой хайлтыг илүү үр дүнтэй болгох, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийхэд нэг талыг барьсан хандлага байгаа эсэх, тэдгээр нь үр дүнд хэрхэн нөлөөлж болохыг мэддэг байх, удалгаанд зайлшгүй шаардлагатай болон шаардлагагүй мэдээллийг ангилж, хайлтыг хэрхэн хязгаарлах тухай мэдэж авах, хууль тогтоомж, дүрэм журам дахь хязгаарлалт, тавигдах шаардлагыг

хэрэгжүүлэх, мэдээлэл жинхэнэ болохыг баталгаажуулах, батлах, хамгаалах, хадгалах зэрэг чиглэлүүдийг анхаарах шаардлагатай.

### Дүгнэлт

Техник, технологи эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед цахим орчинд Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр Эрүүгийн цагдаагийн албанд Олон улсын цагдаагийн байгууллагын өргөнөөр хэрэгжүүлж байгаа туршлагыг хэрэгжүүлж байгаа туршлагаас мэдээлэл цуглуулах, бэхжүүлэх, дүн шинжилгээ хийх “OSINT” судалгааг хэрэгжүүлж ажиллах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

“OSINT” судалгааг нэвтрүүлж ажилласнаар цахим орчинд үйлдэгдэж байгаа хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх, дүн шинжилгээ хийх улмаар хүн хүч, цаг хугацаа хэмнэн ажиллах, хэргийн илрүүлэлтэд чухал ахиц нөлөө үзүүлэх юм.

Цахим орчинд шүүлт хийх программ хангамж (Мальтего гэх мэт) худалдан авах санхүүжилт дутагдалтай байгаа ба энэ төрлийн гэмт хэргийг технологийн сүүлийн үеийн шийдлийг ашиглахгүйгээр мөрдөгч нар ихэнхдээ зөвхөн уламжлалт аргаар л илрүүлж байгаа нь бодит үнэн гэдэг нь судалгааны дүнгээр батлагдаж байна.

### Санал

Дээрх дүгнэлт, судалгааны үр дүн, алба хаагчдын хүсэлтийг харгалзан дараах саналыг дэвшүүлж байна.

1. Цагдаагийн байгууллагын ЭЦА-нд бүтцийн өөрчлөлт хийж хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр дагнасан Нэгж байгуулж нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, бэхжүүлэх дүн шинжилгээ хийх “OSINT” судалгаа хариуцсан

мэргэшсэн шинжээч, мөрдөгч нараар бэхжүүлэх.

2. Цагдаагийн мөрдөгч, шүүгч, прокуроруудыг хамруулан нээлттэй эх сурвалжаас мэдээлэл цуглуулах, бэхжүүлэх, дүн шинжилгээ хийх ойлголт, чадвар эзэмшүүлэх мэргэшүүлэх сургалтыг байнга зохион байгуулж сургагч багш бэлтгэх

3. Шүүх шинжилгээний хүрээлэнд фотозураг болон видео бичлэгт шинжилгээ хийх төрөлжсөн лаборатори байгуулах.

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль тогтоомжид цахим болон бодит нотлох баримтын хооронд эрх зүйн ялгаа байхгүй байгаа нь “OSINT” судалгааны явцад цуглуулсан цахим нотлох баримтыг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэвтрүүлэхэд ноцтой саад учруулж болзошгүй тул цахим нотлох баримтыг нотлох баримтын хэмжээнд үнэлж хамааруулах талаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах.

5. Нээлттэй эх сурвалжийн мэдээллийг цуглуулах, бэхжүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах үйл ажиллагааг зохицуулах Журам-ыг дотоодын хууль тогтоомж, дүрэм болон олон улсын стандартад нийцүүлж боловсруулах.

6. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээлэлийг нэгтгэсэн Тагнуул, Цагдаа болон бусад байгууллагууд “Мэдээллийн нэгдсэн сан” байгуулж хамтын ажиллагааг нь сайжруулах зэрэг саналыг дэвшүүлж байна.

#### Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 2019 он

2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль 2012 он

3. Эрүүгийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2015 он

4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017 он

5. Зөрчлийн тухай хууль 2017 он

6. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль 2017 он

7. Гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр 2015 он

8. “Хүн худалдаалахтай тэмцэх нь” судалгааны тайлан ХЭҮК 2011 он

9. “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” Улаанбаатар хот 2023 он

12 “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх” судалгааны тайлан ОУШХБ 2017 он

14. “Цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох эрх зүйн зохицуулалт” судалгааны ажил ХЗҮХ 2018 он

15. UNODC Global Report on Trafficking in Persons 2009, 2022

16. Gill.R. (2023). *“What is the Open-Source Intelligence?”* [www.sans.org/blog/](http://www.sans.org/blog/). UK: SANS.

ILF, i. w. (2023, 09 18). Best practices for Authenticating Online content with OSINT. (I. team, Interviewer)

United Nations, (. (2021). *“Traffickers abusing online technology, UN crime prevention agency.* New-York, USA: UN news, Global Perspective Human Stories, <http://news.un.org/en/story/2021/10//1104392>.



## ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ БА МӨРДӨН ШАЛГАХ НУУЦ АЖИЛЛАГААНЫ ОНОЛЫН ЗАРИМ АСУУДАЛ

### CERTAIN THEORETICAL ISSUES OF COVERT OPERATIONS IN EXECUTIVE ACTIVITIES AND CRIMINAL INVESTIGATION

#### С.Буянжаргал

Дотоод хэргийн их сургуулийн докторант, цагдаагийн хурандаа

#### S. Buyanjargal

Doctoral Candidate, University of Internal Affairs, Colonel of Police

хариуцлагатай зохиогч: buyanjargals1960@gmail.com

**Хураангуй:** Энэхүү өгүүлэлд гүйцэтгэх ажил ба мөрдөн шалгах нууц ажиллагааны үүсэл хөгжил, онолын асуудал, ойлголт, онцлогийг хөндөн авч үзлээ.

**Abstract:** This article examines the origins and development of operational and investigative covert activities, as well as their theoretical issues, concepts, and distinguishing features.

Бид гүйцэтгэх ажил ба мөрдөн шалгах нууц ажиллагааны онолын асуудлыг судлан авч үзэхдээ юуны өмнө эдгээр үйл ажиллагаа манай улсад хэдий үеэс эхтэй болох, эрх зүйн үндэс нь юу байсан болох талаар товч авч үзлээ.

**Түлхүүр үгс:** Тагнуулын үйл ажиллагаа, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаа, цагдаа.

**Keywords:** confidentiality, investigation, punitive actions, criminal, operational-search activities, operational investigation, police.

#### Удиртгал

Профессор Д.Мягмарцэрэн (Д.Мягмарцэрэн, 2003): “1932 онд Дотоодыг хамгаалах газарт цагдаагийн байгууллагыг харьяалуулах болсон үеэс эхлэн гэмт хэрэгтэй тэмцэх ажилд гүйцэтгэх ажлыг ашиглах болсон түүхтэй байна” гэж тэмдэглэсэн.

1934 оны 02 сарын 02-ны өдөр Сайд нарын зөвлөлөөс баталсан “БНМАУ-ын Цагдан сэргийлэх тухай” дүрмийн дөрөвдүгээр бүлэг (Цагдан сэргийлэх газрын үүргийн тухай)-г цагдан сэргийлэхийн гүйцэтгэх ажлуудын жагсаалтад: “гэнэт алга болсон хүүхэд ба (хүмүүсийг) эрнэ (ЦЕГ, 2016)”, “эрүүгийн гэмт хэргүүдийг илрүүлэх, мөрдөн байцааж шүүхэд шилжүүлнэ” (ЦЕГ, 2016); Зургадугаар бүлэг (Цагдан сэргийлэхийн албан ажлын тухай)-ийн 17-д: “Манааны ба гүйцэтгэх ажлын

хийгээд улс төрийн ажилчид болбоос ...”; мөн 1936 оны 6 сарын 13-ны өдөр баталсан “Монгол Ард Улсын Дотоод явдал эрхлэх яам, түүний харьяа Улсын цагдан сэргийлэх газрын дүрэм”-д “Улсын цагдан сэргийлэх газар нь нийт 7 хэлтэстэй, тэдгээрийн нэг нь “Гүйцэтгэх хэлтэс” байна гэж заасан нь Монгол Улсын цагдаагийн байгууллагад гүйцэтгэх ажил эрхлэх болсон судлаачийн түүхэн цаг хугацаатай дүйж байна.

Энэ цаг үед Цагдан сэргийлэх байгууллагын гүйцэтгэх ажлын эрх зүйн үндэс нь Дотоод явдлын яамны сайдын тушаалаар баталсан Дотоодыг хамгаалах газрын заавар журам байв. Харин 1959 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Нийгмийг аюул учралаас хамгаалах яам түүний асуудлыг эрхлэх сайдын дугаар тушаалаар “Улсын

цагдан сэргийлэх байгууллагын Нууц тагнуулын ажлын тухай заавар” батлагдсанаар цагдаагийн байгууллага нь өөрийн бие даасан гүйцэтгэх ажлын заавартай болжээ. Ийнхүү цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажлын зааврыг 1992 он хүртэл НАХЯ-ны (хуучнаар) сайд, 1992 оноос Цагдаагийн төв байгууллагын дарга, 2003 оноос Цагдаагийн ерөнхий газрын дарга ба Тагнуулын ерөнхий газрын дарга нар хамтран, 2013 оноос мөн дээрх байгууллагын дарга нар хамтран баталж, Улсын ерөнхий прокурор зөвшөөрөл олгодог байсан. Харин 1999 оны 07 дугаар сарын 08-ны өдөр батлагдан өдгөө хүчин төгөлдөр хэрэгжиж буй Тагнуулын байгууллагын тухай хуулиар гүйцэтгэх ажилд дагаж мөрдөх журам, зааврыг батлах бүрэн эрхийг Тагнуулын байгууллага (ТЕГ-ын дарга)-д (УИХ, 1999) олгосон.

Монгол Улсын цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлын онолын үндэс нь хууль тогтоомжоос гадна эрдэмтэн судлаачдын ном бүтээлд тусгалаа олсон байдаг. Хошууч генерал А.Думбурай (А.Думбурай, 1998): “Шуурхай эрэн сурвалжлах арга хэмжээ гэдэг бол шуурхай эрэн сурвалжлах үйл ажиллагааны зорилтуудыг биелүүлэхэд чиглүүлж цагдан сэргийлэх байгууллагын нууц арга тактик, хүч хэрэгслийг илээр хэрэгжүүлэх арга, хэрэгслүүдтэй хоршин ашиглаж байгаа цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааг хэлдэг”. Ийнхүү тодорхойлсон нь тухайн үеийн ЗХУ-д “гүйцэтгэх ажил” гэдгийг “шуурхай эрэн сурвалжлах ажил” хэмээн авч үздэг жишгээр томъёолсон гэж хэлж болохоор юм.

Одоо ч мөн ОХУ-д цагдаагийн байгууллагаас явуулах “гүйцэтгэх ажил” гэдэг ойлголтыг “оперативно-розыскная деятельность” гэж

нэрийддэг, үүнийг манай улсад “шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа” (гүйцэтгэх ажил) гэж орчуулан хэрэглэдэг. Харин монголын цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлыг энэ үйл ажиллагаатай адилтган авч үзэх нь зөв эсэх асуудал маргаан дагуулдаг (ОХУ, 2011). ОХУ-д шуурхай эрэн сурвалжлах ажил, түүнтэй холбоотой эрх зүйн үндсэн харилцааг Холбооны улсын шуурхай эрэн сурвалжлах ажиллагааны тухай хууль (Закон об оперативно-розыскной деятельности)-иар зохицуулахаас гадна ОХУ-ын Үндсэн хууль; Эрүүгийн (Уголовный кодекс), Эрүүгийн байцаан шийтгэх (Уголовно-процессуальный кодекс), Төрийн нууцын тухай (Закон О государственной тайне), Прокурорын байгууллагын тухай (Закон О прокуратуре), Цагдаагийн албаны тухай (Закон О полиции), Холбооны аюулгүй байдлын албаны тухай (Закон О федеральной службе безопасности) хуулиудаар тус тус зохицуулж байна.

ОХУ-ын эрдэмтэн, судлаачдын дунд “оперативно-розыскная деятельность” буюу Монголоор шуурхай эрэн сурвалжлах ажиллагаа гэх нэр томъёо нь оновчтой бус, харин эрүүгийн гэмт хэрэг үйлддэг гэмт бүлэглэлтэй тэмцэх ажилд хамаарна” гэж үздэг нь цөөнгүй байна (В.Н.Ушаков, 2006).

Ж.Болдбаатар, Р.Баярмагнай нарын эрдэмтэн судлаач (Болдбаатар.Ж, Баярмагнай.Р, 2025): “Гүйцэтгэх тагнуулын ажил гэдэг нь гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилж сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагаас “Гүйцэтгэх ажлын тухай” хууль, түүнд нийцүүлж боловсруулсан бусад хэм хэмжээний хүрээнд ердийн болон нууц арга, хүч, хэрэгсэл ашиглах замаар хэрэгжүүлэх гүйцэтгэх тагнуулын ажлын арга хэмжээнүүдийн нийлбэр цогц юм” гэж цагдаагийн





байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлыг “гүйцэтгэх тагнуулын ажил” хэмээн томъёолж, тагнуулын байгууллагад илүүтэй хамаатуулсан. Энэхүү сурах бичигт цааш нь: “Цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажил гэдэг нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 11.2-д заасан үндэслэл, 12.1.3-аас 12.1.6-д заасан хүрээнд Эрүүгийн цагдаагийн алба, ажилтнаас гүйцэтгэх ажлын хүч, ердийн ба тусгай, нууц арга, хэрэгслийг ашиглан хуулиар харьяалуулсан хэрэг, үйлдсэн этгээдийг олж тогтоохоор мэдээлэл, баримт сэлт эрж олох, цуглуулах, шинжлэх, үнэлэх, шалгах, баримтжуулах ажиллагааг хэлнэ” гэж өргөн утгаар тодорхойлсон байна. Энэ нь одоо хэрэгжиж байгаа “Гүйцэтгэх ажлын тухай” хууль болон цагдаагийн байгууллагын эрүүгийн хэргийг шуурхай илрүүлэх, үнэн зөв, бодитой тотоох, шийдвэрлэх чиг үүрэгтэй илүү уялдуулсан тодорхойлолт гэж хэлж болохоор юм.

Монгол Улсын “Гүйцэтгэх ажлын тухай” 1998 оны хуульд (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997): “Үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглан явуулж байгаа мэдээ, мэдээлэл, баримт бичиг, нотолгоо эрж олох, цуглуулах, шалгах үйл ажиллагааг гүйцэтгэх ажил гэнэ” хэмээн гүйцэтгэх ажлыг төрийн тусгай албадаас явуулах онцгой үйл ажиллагаа болохыг хуульчлан тодорхойлсон.

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид зааснаар цагдаагийн байгууллага нь “эрэн сурвалжлах ажил эрхэлнэ”, “мөрдөн шалгах нууц ажиллагаа” явуулна.

Дээрх бүгдээс дүгнэвэл, манай улсын эрдэмтэн, судлаачид цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлыг “эрэн сурвалжлах”, “гүйцэтгэх ажил”,

“гүйцэтгэх тагнуул” гэх зэргээр өөр өөр нэршлээр нэрлэх, түүнчлэн “эрэн сурвалжлах нууц ажиллагаа” хэмээн нэрийдэж болно хэмээн үзэл санаа, байр сууриа илэрхийлсэн (Болдбаатар.Ж, Баярмагнай.Р, 2025) нь уг нэр томъёоны хувьд нэгдсэн үзэл баримтлал үгүй байгаа нь ажиглагдана. Цаашид гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааг гүйцэтгэх байгууллага (алба)-дын чиг үүрэг, зорилт, онцлогтой уялдуулан тусгайлан судлах, нэр томъёог тогтох шаардлага байна.

Дээрх ажиллагааны эрх зүйн орчинг дэлгэрүүлэн авч үзье. Монгол Улсын Үндсэн хуульд (УИХ, Монгол Улсын Үндсэн хууль, 1992) гүйцэтгэх ажил явуулахтай холбоотой үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг ханган хамгаалах (хязгаарлах) асуудлыг баталгаажуулж өгсөн. Тухайлбал, Монгол Улсын үндсэн хуулиар иргэн халдаггүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуулиас гадуур хэнийг ч дур мэдэж саатуулах, нэгжих, хорих, мөрдөн шалгах, эрх чөлөөнд нь халдах, хязгаарлыг хориглодог бөгөөд иргэн түүний хувийн болон гэр бүлийн захидал, харилцааны нууц, орон байрны халдашгүй байдал зэргийг хуульд зааснаар хамгаална. Иргэн эрх чөлөөгөө эдлэхдээ бусдын эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг гажуудуулж болохгүй. Эх орны тусгаар тогтнол, үндэстний аюулгүй байдал, нийгэм дэх дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн юм. Зөвхөн хуульд заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд зохих хязгаарлалтыг авч хэрэгжүүлнэ” гэсэн.

Гүйцэтгэх ажлын тухай хуулиар түүнийг эрхлэн явуулах нийтлэг үндэслэл, зарчим, арга, хэрэгсэл, нийтлэг журам зэргийг зохицуулна. Энэ хуульд батлагдсан цагаас нь хойш нийт

13 удаа (1999, 2001, 2002, 2006, 2013, 2015, 2016, 2017, 2020, 2021, 2022, 2023, 2024) нэмэлт өөрчлөлт оруулсан байх ба дийлэнх нь гүйцэтгэх ажил явуулах чиг үүрэг бүхий байгууллагын чиг үүрэг, бүтэцтэй чиглэгдсэн өөрчлөлтүүд (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997) байна. Тухайлбал, 2020 оны 05 сарын 14-ний өдрийн хуулиар гүйцэтгэх ажлыг тодорхойлсон 2 дугаар зүйлд нэмэлт оруулж, 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулжээ.

Дээрх хуулийн 9-р зүйлд гүйцэтгэх ажил явуулах “эрхийг”, 11-р зүйлд “үндэслэлийг”, харин 12 дугаар зүйлд “хүрээг” нийт 7 төрөл ангиллаар хязгаарласан. Үүнд: Гадаад, сөрөх, цэргийн тагнуулын үйл ажиллагаа, эрэн сурвалжлах ажил (УИХ, Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999), ... хүнийг эрэн сурвалжилж олох ажил (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997), ... эд хөрөнгийг эрж олох ажил (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997), мөн хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шүүх ажиллагаанд ач холбогдол бүхий нотлох баримт, түүний эх сурвалжийг олох ажил” байна. Эдгээрээс сүүлийн 4 төрлийн ажиллагааг цагдаагийн байгууллага хууль тогтоомжийн хүрээнд гүйцэтгэдэг.

Энэ хуульд зааснаар тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх (зөвхөн гүйцэтгэх алба), авлигатай тэмцэх, цэргийн тагнуулын байгууллага гүйцэтгэх ажил явуулах эрхтэй (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997) ба харьяалах чиг үүрэг түүнийг хэрэгжүүлэх ажил арга хэмжээ, гүйцэтгэх ажлын онцлог, хэрэг бүртгэлтийн хэргийг шалгах журмууд нь өөр, тус тусын онцлогтой байдаг.

Анх хууль батлагдахад цэргийн тагнуулын байгууллага, хилийн

тагнуулын, тахарын албад гүйцэтгэх ажил явуулах байгууллагын тоонд ордог байсныг 2015 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн ба 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар тус тус хассан.

Гүйцэтгэх байгууллага тус бүр үндсэн чиглэл, хэрэг бүртгэлтийн хэрэг шалгах, гүйцэтгэх ажил явуулах аргачлал зэргийг мөн салбар хуулиудаар нарийвчлан зохицуулдаг. Үүнд:

- Тагнуулын байгууллагын тухай (1999);
- Цагдаагийн албаны тухай (1999);
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай (2017);
- Авлигын эсрэг (2006) зэрэг хуулиуд болно.

Тагнуулын байгууллагын тухай хуульд зааснаар Тагнуулын байгууллага нь нийт 7 чиглэлээр (УИХ, Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999) гүйцэтгэх ажлын арга хэмжээ, арга хэрэгслийг ашиглан тагнуулын үйл ажиллагаа явуулна. Энэ хуулийн (УИХ, Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999) 3 дугаар зүйлд: Сөрөх тагнуулын үйл ажиллагааг Монгол Улсын эсрэг, гадаад улсын тусгай алба байгууллага, иргэдээс явуулж буй тагнах болон бусад үйл ажиллагаа, Тагнуулын ерөнхий газарт хуулиар харьяалуулсан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх ажиллагаа” гэж тодорхойлсон.

Цагдаагийн албаны тухай хуулийн 6.5-д: “Цагдаагийн байгууллага нь үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх төрөлжсөн болон үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр мөрдөх, гүйцэтгэх ажил явуулах албатай байна” гэж хуульчилсан. Мөн судлан буй ажиллагааг цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэгт хамааруулж:”хууль тогтоомжид заасан





үндэслэл, журмын дагуу гүйцэтгэх ажил явуулах”; “гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагатай хамтран ажиллах” гэж тус тус заасан (УИХ, Цагдаагийн албаны тухай хууль, 2017).

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь ГА-ын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хорих ангид ГА явуулна (УИХ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017)

Авлигатай тэмцэх газар нь олон нийтийг авлигаас ангид байлгах, түүнд өртөхөөс сэргийлэх, тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр ГА, хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаа явуулах, тодорхой төрлийн хуульд заасан субъектүүдийн хөрөнгө, орлогыг хянаж шалгах чиглэлтэй төрийн тусгай байгууллага ба авлигын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор ГА явуулах, бусад байгууллагуудтай хамтран ажиллах эрхтэй (УИХ, Авлигын эсрэг хууль, 2006).

2017 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д (УИХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017) мөрдөн шалгах нууц ажиллагаа буюу өмнө нь гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг байсан гүйцэтгэх ажиллагаа (гүйцэтгэх ажлын арга хэмжээ)-дыг эрүүгийн процесс ажиллагааны хүрээнд явуулахаар хуульчилсан. Энэ хууль батлагдан гарсантай холбогдуулан Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулаагүй.

Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын арга хэрэгслийг ашиглан дээрх гүйцэтгэх байгууллагуудаас явуулж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа болон цагдаагийн байгууллагаас явуулах мөрдөн шалгах нууц ажиллагаа хоёр ялгаатай юу,

ялгаатай бол чухам юугаараа ялгаатай вэ?

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хуульд "мөрдөн шалгах нууц ажиллагаа" гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг ойлгоно" гээд, уг нэр томъёог хуульчлан тодорхойлоогүй ба мөрдөн шалгах нууц ажиллагааг тус хууль болон түүнд нийцүүлэн баталсан журам, заавраар зохицуулах, тухайн ажиллагааны үр дүнг нотлох баримтад тооцохоор зохицуулалт оруулсан нь "мөрдөн шалгах нууц ажиллагаа"-ны Тагнуулын байгууллагын тухай хуульд заасан "гүйцэтгэх ажил"-аас ялгагдах онцлогийг илэрхийлж байна гэж үзэж байна.

Хууль тогтоомжид тусгагдсан "гүйцэтгэх ажил", "мөрдөн шалгах нууц ажиллагаа", "сөрөх тагнуулын үйл ажиллагаа", "эрэн сурвалжлах ажил" гэсэн ойлголтууд нь хоорондоо ялгаатай, бие даасан ойлголтууд болох талаар салбарын эрдэмтэн судлаач, практик ажилтнуудын дунд эргэлзээ төрүүлсэн үзэл санаанууд цухалздаг, нэгдсэн ойлголтод хүрээгүй байдал ажиглагдах нь зайлшгүй судлах асуудал мөн юм.

Тагнуулын байгууллагын тухай хуульд зааснаар тагнах ажиллагаа болон тухайн төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах хүрээнд (УИХ, Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999) хийгддэг ГА гэх нэр томъёо нь үндэсний аюулгүй байдал, иргэний амь нас, эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, эд хөрөнгийг гэмт үйлдлээс хамгаалах зорилгоор хуулийн дагуу харъяалуулсан төрийн байгууллагаас ердийн ба тусгай, нууц арга, хэрэгсэл ашиглах ажиллагааг илэрхийлдэг. Мөн хуулийн 11-р зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр Тагнуулын байгууллага нь

эрэн сурвалжлах чиглэлд ГА явуулах эрхтэй (УИХ, Тагнуулын байгууллагын тухай хууль, 1999).

Доктор Ж.Бямбаа: “Монгол Улсын Үндсэн хуульд заасан мөрдөх, мөшгөх гэх ойголт, мөрдөн байцаах, эрэн сурвалжлах ажлын нийлэмжийг агуулж байдаг ба зорилго нь хэргийг бүрэн дүүрэн илрүүлэх, сэжигтэй этгээдийн олж тогтоох, гэм бурууг шийдэх, улмаар бусад байгууллагаас хараат бус шударга, шүүхээр шийдвэрлүүлэхэд хүртэл ажиллагаанд чиглэгддэг. Тийм учраас мөрдөх, байцаах хэмээх уламжлалт хоёр ажиллагааг салган тусгаарлаж болдоггүй байсны нэгэн адил мөрдөн шалгах, эрүүгийн эрэн сурвалжлах ажлыг тусад нь авч үзэх боломжгүй” (Ж.Бямбаа, 2025) гэж тэмдэглэсэн.

*Эрэн сурвалжлах ажил* гэдэг нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсноор Тагнуул, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуулиар харьяалуулсан хэргүүдийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олох зорилгоор хэрэгжүүлэх нууц, далд ажиллагаа” юм. Өөрөөр хэлбэл дан ганц цагдаагийн байгууллага бус тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас зөвхөн гэмт хэрэг илрүүлэх, үйлдсэн этгээдийг олж тогтоох зорилгоор явагддаг нь гүйцэтгэх ажлаас ялгагдах талыг харуулж байна.

Гүйцэтгэх ажил, эрэн сурвалжлах, мөрдөн шалгах чиг үүргээр ил, нууц далд аргаар хэрэгжүүлдэг ажиллагаанууд нь прокурорын байгууллагын хяналт дор хэрэгждэг хэдий ч иргэний эрх, эрх чөлөөг үгүйсгэх эрсдэл бүхий, олон нийтийн зүгээс мөн чиглэлээрх эрүүгийн процесс ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих боломжгүй, өмгөөлөх чиг

үүргийг хэрэгжүүлэхэд хязгаарлагдмал нөхцөл байдлууд үүсдэг зэрэг асуудлууд тулгардаг, нөгөөтэйгүүр өөр өөрийн онцлог арга зүй, арга хэлбэрээр явагдах нарийн ажиллагаанууд билээ. Мөрдөгч нь яллах, цагаатгах баримтын аль алинд нь ач холбогдол өгч, гүйцэтгэх ажлын арга хэмжээг оновчтой сонгон хэрэглэж, субъектив хандлагаас ангид хэргийн бодит байдлыг үнэн зөв тогтоох үүрэгтэй. Ноцтой, ээдрээ түвэгтэй буюу зохион байгуулалттай гэмт бүлгийн үйлдсэн гэмт хэргүүдийг мөрдөн шалгахад эрүүгийн албаны нягт хамтын ажиллагаа тун чухал байр суурийг эзэлнэ. Гэтэл практикт мөрдөгч дангаар мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах нь эрсдэл бүхий, зарим ажиллагаа нь мэргэжлийн өндөр ур чадварыг шаардах, мөн мөрдөгч дангаар гүйцэтгэх, эсхүл багаар, туршлагатай алба хаагчтай хамтран явуулах хоёр мэдээж өөр өөр үр дүнг авчирна.

Мөрдөгч нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд тухайн гэмт хэргийг нотлох процесс ажиллагааг хангах зорилгоор шүүхийн өмнөх шатанд мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд гүйцэтгэх ажлын арга хэмжээг ашиглан шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулна, тэдгээрийг нотлох баримтаар үнэлэх, тооцох асуудал заавал журамлагдсан байх ёстой.

Нотлох баримт заавал нотлогдсон эх сурвалжтай байна, харин гүйцэтгэх ажлын эх сурвалжийг ил гаргах боломжгүй, зарим тохиолдолд тодорхой бус буюу баттай эх сурвалжгүй байдаг зэргээс нотлох баримтын хэмжээнд үнэлэн авч үздэггүй. Практикт хүний эрхийг зөрчсөн гэх зэргээр ач холбогдол өгдөггүй хэвшмэл ойлголт оршсоор байгаа нь уг онцгой ажиллагааны үнэ цэнийг бууруулах сөрөг талтай. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх





тухай хуулийн шинэчилсэн найруулгаар гүйцэтгэх ажлын бүх ажил, арга хэмжээнд хяналт тавих чиг үүргийг прокурорын байгууллагад өгсөн.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хэрэг бүртгэлтийг нээх, нээхээс татгалзах, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож хаах, түдгэлзүүлэх, эргэн сэргээх зэрэг 30 орчим ажиллагааг мөрдөгч зөвхөн прокурорын зөвшөөрлөөр явуулахаар болж “бие даах” хэлбэрүүд нилээд хумигдсан нь гүйцэтгэх ажилтан, эрдэмтэн судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг. Энэ талаар Ром-Германы нийтлэг жишгийн дагуу эрүүгийн мөрдөх, яллах чиг үүргийг прокурорын өдөр тутмын удирдлага дор хамтдаа хэрэгжүүлэх нь зүйн хэрэг боловч, нөгөөтэйгүүр шүүх эрх мэдэл гэх хэсэгт орсон прокурорын чиг үүрэг нь гүйцэтгэх эрх мэдэлтэй байнга нэгдэж нийлэх нь зөв гэхэд эргэлзээтэй. Гүйцэтгэх ажлын тодорхой аргуудыг прокурорын байгууллага хяналт тавих нэрээр мэдэх, нууцлал аюулгүй байдлыг задруулах эрсдэл үүсгэнэ гэж үзэж, шүүмжлэлтэй хандах явдал мэргэжлийн салбарынханд байна (Г.Нэргүй, 2016).

Монгол Улсад тагнах үйл ажиллагаа болон гэмт хэргээс урьдчилж сэргийлэх, гэмт хэргийг мөрдөн шалгах шатанд хийгдэх ГА-д тавих хяналтыг Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 5 дугаар бүлэгт хуульчлан зохицуулсан буюу Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд нар шат шатандаа хуульд заасан эрх хэмжээгээр, мөн Гүйцэтгэх байгууллагын дарга, Прокурор хяналт тавина. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын байгууллагын хяналтыг Ерөнхий прокурор, түүнээс тусгайлж эрх олгосон прокурор нууцаар сонсох, харах тусгай техник хэрэгсэл ашиглаж

хэрэгжүүлнэ (УИХ, Гүйцэтгэх ажлын тухай хууль, 1997). “Прокурорын тухай” хуульд ГА болон МШНА-нд тавих хяналтыг хэрэгжүүлэх чиглэлийн эрхүүдийг хуульчилсан (УИХ, Прокурорын тухай хууль, 2017).

Судлан буй ажиллагаануудыг өөр өөр чиг үүрэгтэй байгууллагууд бие даан хэрэгжүүлдэг, Эрүүгийн, Гүйцэтгэх ажлын, Прокурорын тухай хуулийн заалтууд нь эрүүгийн процессын хэм хэмжээтэй яв цав нийцэж байх нь хуулийн хийдэл, хууль зөрчигдөх явдлаас сэргийлнэ. Гүйцэтгэх байгууллагууд нь тэдгээр ажиллагааг явуулах зайлшгүй хэрэгцээ, хуулийн үндэслэл, даган гарах үр дагаврыг бодитоор тооцох, хамгийн богино цаг хугацаанд зайлшгүй шаардлага, хууль журмын хүрээнд хэрэгжүүлэхийг эрмэлзэх ёстой. Гэвч ГА зохион явуулах хүрээ, нөхцөл байдал, онцлог, ашиглагдаж буй техник хэрэгсэл, хүн хүчнээс шалтгаалан үргэлжлэх хугацааны хувьд харилцан адилгүй, ялангуяа тагнуулын байгууллагаас явуулах зарим ажиллагааг урт хугацаанд зохион байгуулах шаардлага үүсдэг. Энэхүү сүүлийн нөхцөл байдал шаардлага нь тагнуулын байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлын бусад гүйцэтгэх байгууллагуудаас явуулах гүйцэтгэх ажлаас ялгаатай болохыг харуулж байна.

### Дүгнэлт

1. Монгол Улсын орчин цагийн цагдаагийн байгууллагад гүйцэтгэх ажил эрхлэх болсон цаг үе нь Дотоодыг хамгаалах газарт цагдаагийн байгууллагыг харъяалуулсан 1932 оны үеэс эхлэлтэй байна.

2. Өнөөдөр Монгол Улсад ГА, МШНА явуулах гол хууль, эрх зүйн үндэс нь Монгол Улсын Үндсэн хууль, түүнийг дагаж гарсан Гүйцэтгэх ажлын

тухай, Тагнуулын байгууллагын тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай хуулиуд, тэдгээрийг дагаж гарсан хуульчилсан актууд болно.

3. “Гүйцэтгэх ажил”, “мөрдөн шалгах нууц ажиллагаа”, “сөрөх тагнуулын үйл ажиллагаа”, “эрэн сурвалжлах ажил” нь хоорондоо ялгаатай, бие даасан ойлголтууд юм.

“Гүйцэтгэх ажил”, “мөрдөн шалгах нууц ажиллагаа”, “эрэн сурвалжлах ажил”-ыг зөвхөн гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор ашигладаг бол “сөрөх тагнуулын үйл ажиллагаа” нь зөвхөн тагнуулын байгууллагын эрх хэмжээний хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоос гадна өөр бусад зорилгоор ашиглагддаг тагнах болон бусад онцгой ажиллагаа байна.

Цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажил нь харъяалалд шалгах гэмт хэргүүдийг бүрэн дүүрэн мухарлах, түүнээс урьдчилж сэргийлэх, тасалж зогсооход чиглэгддэг, тэдгээр гэмт хэргүүд нь нийгмийн бүхий л салбарыг хамарсан шинжтэй, мөн энэ ажилд тагнуулын байгууллагаас ашигладаг бүх төрлийн хүч, арга хэрэгслийг ашигладаггүй (тодорхой төрлийн) зэрэг байдал нь цагдаагийн байгууллагаас явуулах гүйцэтгэх ажлын онцлог ялгааг харуулж байна гэж хэлж болохоор юм.

### Ашигласан материал

#### Хууль тогтоомж

1. Авлигын эсрэг хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 2006. № 35.
2. Гүйцэтгэх ажлын тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 1998. № 3.
3. Монгол Улсын Үндсэн хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 1992. № 01.
4. Тагнуулын байгууллагын тухай хууль. //Төрийн мэдээлэл. УБ. 1999. № 35.

4. Гүйцэтгэх ажлын шугамаар олж авсан мэдээлэл, баримтууд нь хичнээн үнэ цэн, өндөр ач холбогдол бүхий байсан ч, нотлох баримтаар шууд үнэлэх боломж байхгүй хэвээр байгаа. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар нотлох баримт гэх ойлголтыг хуульчлан тодорхойлоогүй (Болдбаатар.Ж, Баярмагнай.Р, 2025), тухайн хэрэгт чухал ач холбогдол бүхий гэж процесс ажиллагаанд оролцогч бүрийн мэдэх баримт, мэдээлэл болгоныг хамаатуулан үзэх эсэх нь маргаантай хэвээр байна.

5. Дээрх ажиллагааны явцад түүнд оролцогчдын эрх, эрх чөлөөг хангах асуудал чухал ба энэ ойлголтод нэн тэргүүнд, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг гэмт халдлагөд өртөхөөс сэргийлэх, дараагийн дугаарт, хэргийн холбогдогчийн эрхийг хязгаарлах явцад үндсэн хуулиар олгогдсон эрхийг хангаж ажиллах асуудлууд хамаарч байна. Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах асуудлыг журмаар зохицуулж (УИХ, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017) байгаа нь иргэний үндсэн эрх чөлөөг хангах, хамгаалах, түүнд тавих хяналтыг сулруулах сөрөг ач холбогдолтой гэсэн шүүмжлэл дагуулдаг нь анхаарал татаж байна.

5. Цагдаагийн албаны тухай хууль (Шинэчилсэн найруулга). //Төрийн мэдээлэл. УБ. 2017. № 8.
6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (Шинэчилсэн найруулга). //Төрийн мэдээлэл. УБ. 2017. № 24.
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Шинэчилсэн найруулга). //Төрийн мэдээлэл. УБ. 2017. № 23.
8. БНМАУ-ын Цагдан сэргийлэхийн тухай дүрэм. //Монгол Улсын цагдаагийн байгууллагын үйл





ажиллагаанд холбогдох хууль, дүрмийн эмхэтгэл (ЦЕГ-ын Төв архив). УБ. 2016.

#### Ном бүтээл

9. Ж.Болдбаатар, Р.Баярмагнай нар. Монгол Улсын нийтийн эрх зүй. УБ. 2025.
10. А.Думбурай. БНМАУ-ын цагдаагийн байгууллагын шуурхай эрэн сурвалжлах ажлын үндэс (сурах бичиг). УБ. 1988.
11. Д.Мягмарцэрэн. Цагдаагийн байгууллагын гүйцэтгэх ажил, түүний эрх зүйн зохицуулалтыг судлах нь (Магистрын ажил). ХСИС. 2003.

12. Правовое регулирование деятельности ФСБ по обеспечению национальной безопасности РФ (Общ. ред. В.Н.Ушаков). ФСБ России. М., 2006.

13. Эрүүгийн тагнуулын ажил (сурах бичиг). УБ. 2010.

#### Интернэт эх сурвалж

14. <https://normativ.kontur.ru/document?moduleId=1&documentId=501354>
15. Гэмт хэргийн илрүүлэлтэд сөргөөр нөлөөлөх заалт байна. 2016.05.02. <https://news.mn/r/732766/>

# САНХҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙН МӨРДӨН ШАЛГАХ АЖИЛЛАГААНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ БОЛОМЖ

## CHALLENGES IN CONDUCTING FORENSIC ANALYSIS IN FINANCIAL CRIME INVESTIGATIONS AND POSSIBLE SOLUTIONS

### Э.Сэргэлэн

Дотоод хэргийн их сургуулийн докторант, Эрүүгийн цагдаагийн албаны Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа

### E. Sergelen

Ph.D. student at the University of Internal Affairs, Head of the Investigation Division, Department for Combating Economic Crimes, Criminal Police Department, Police Lieutenant Colonel

\*хариуцлагатай зохиогч: sergelen0608@yahoo.com

**Хураангуй:** Энэхүү судалгааны ажил нь татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт эдийн засгийн шинжилгээ хийх явцад тулгарч буй хүндрэлүүд болон тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замыг судлахад чиглэсэн болно. Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн гаралт, учруулах хохирлын хэмжээ нэмэгдэж байгаа нь эдийн засгийн шинжилгээ, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагааны ач холбогдлыг улам бүр нэмэгдүүлж байна. Судалгаанд эдийн засгийн шинжээч, санхүүгийн шинжээч-мөрдөгч нарын гаргадаг шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадалгаа нь эдийн засгийн холбогдолтой гэмт хэргийг нотлох баримтын чухал эх сурвалж болдгийг онцлон авч үзсэн. Гэвч практикт анхан шатны баримтыг хуурамчаар үйлдэх, дансны хуулгыг цаасан хэлбэрээр гаргаж өгөх, нээлттэй эх сурвалжийн мэдээлэлд тулгуурлан хийсэн эдийн засгийн дүн шинжилгээг нотлох баримтаар үнэлэх эрх зүйн зохицуулалт хангалтгүй зэрэг хүндрэлүүд тулгамдаж байгааг тодорхойлсон. Иймд эдийн засгийн гэмт хэргийн шинж чанарт нийцсэн дүн шинжилгээний арга зүйг боловсронгуй болгох, эдийн засгийн шинжилгээг зөвхөн хэрэгт авагдсан баримтаар хязгаарлахгүйгээр статистик, зах зээлийн мэдээлэлд тулгуурлан хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх, мөн мэргэжлийн ёс зүй, ур чадвар бүхий шинжээчдийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай гэж дүгнэв.

**Abstract:** This study examines the challenges encountered in conducting economic analysis in cases of tax evasion crimes and explores possible solutions to address these difficulties. In Mongolia, the increasing incidence of economic crimes—particularly tax evasion—and the growing scale of financial damage have highlighted the critical importance of economic analysis and financial investigation in criminal proceedings. The research emphasizes that expert opinions issued by economic experts and investigative assessments prepared by financial investigator-experts serve as key sources of evidence in resolving economically related criminal cases. However, in practice, several challenges persist, including the falsification of primary accounting documents, the provision of bank statements in paper form, and the lack of sufficient legal mechanisms to recognize economic analyses based on open-source, market, and statistical data as admissible evidence. The study concludes that it is necessary to develop analytical methodologies tailored to the specific characteristics of economic



Урьдчилсан судалгаа



crimes, to improve the legal framework allowing broader use of economic and market-based data in expert analysis, and to strengthen the professional competence and ethical standards of economic experts. Enhancing these aspects would contribute to more effective detection, investigation, and adjudication of tax evasion crimes.

**Түлхүүр үгс:** Эдийн засгийн гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, эдийн засгийн шинжилгээ, шүүх нягтлан бодох бүртгэл

**Keywords:** Economic crime; tax evasion; economic analysis; foren

### Удиртгал

Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 онд 17.5 хувиар өсөж, гадаад улсаас хийгдэх хөрөнгө оруулалт нэлээдгүй ихсэх хандлага бий болж түүнчлэн уул уурхайн салбарын экспортын хэмжээ нэмэгдсэнтэй холбоотойгоор татвар төлөхөөс зайлсхийх, мөнгө угаах гэмт хэргийн гаралт нэмэгдэж, хохирлын хэмжээ ихсэх болсон.

Эдийн засгийн гэмт хэргийг илрүүлж, эрүү, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар бодит шийдвэр гаргаж чадахгүй байгаагаас үүдэн гэмт этгээд гадаад улс руу оргон зайлах, ял завших, шүүхийн шатанд хэрэг удаашрах зэрэг үзэгдэл гарч, нийгэмд сөрөг хандлагыг бий болгож, олон нийтийг хууль сахиулах, шүүх байгууллагад итгэх итгэлийг бууруулж байна.

Эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх, нотлох ажиллагаа явуулахад эдийн засгийн шинжилгээ хийх, санхүүгийн шинжээч мөрдөгчийн санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах, хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулах зэрэг ажил нь тус төрлийн гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны чухал хэсэг бөгөөд онцлог мөн.

Эдийн засгийн гэмт хэрэг үйлдэх, түүнийгээ нуун далдлах, эх үүсвэрийг нь өөрчлөх, мөнгө угаах арга, хэрэгсэл өөрчлөгдөж байгаа хэдий ч гэмт хэрэг илрүүлэх, нотлох баримт бүрдүүлэх, санхүүгийн мөрдлөг явуулах, эдийн

засгийн шинжилгээ хийх арга тактик өөрчлөгдөхгүй байгаа нь дээр дурдсан асуудлуудын нэг шалтгаан байж болох юм.

Ийм учраас эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг түргэн шуурхай илрүүлэх, шүүхийн шатанд нотлох баримтаар үнэлэгдэх тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан эдийн засгийн шинжээч нарын шинжээчийн дүгнэлт, санхүүгийн шинжээч-мөрдөгч нарын мөрдөгчийн магадалгаа гаргахад тулгардаг асуудлууд, гэмт хэргийн шинж чанарт нийцүүлэн дүн шинжилгээ хийх арга аргачлалын загвар боловсруулах, зөвхөн нотлох баримтад үндэслэн шинжилгээ хийх нь зөв бодитой эсэхэд судалгаа хийх шаардлагатай гэж үзэн энэхүү судалгааны ажлыг хийсэн болно.

### Үндсэн хэсэг

Өнөө цагийн Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын эдийн засгийн шинжээчийн албан тушаал нь 1921 онд Монгол Улсын Сангийн хамаг хэргийг бүгд захиран шийтгэх яаманд хууль цаазын нягтлан бодогч гэсэн нэршилтэйгээр үүсэж, 1990 оноос Хууль зүйн яамны харьяа Шүүх нягтлан бодох бүртгэлийн магадлах товчоонд магадлагч нягтлан бодогч гэсэн нэршилтэй байсан байна.

Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын эдийн засгийн шинжээч нар нь тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд гаргасан эрх бүхий байгууллагын гаргасан акт, дүгнэлтээр тогтоосон

хохирол, дутагдал, зөрчлийн хэмжээ нь үнэн зөв, үндэслэлтэй эсэхэд нотлох баримтад тулгуурлан шинжилгээ хийж шинжээчийн дүгнэлт гаргаж байна. Уг шинжээчийн дүгнэлт нь эдийн засгийн холбогдолтой гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд нотлох баримтын гол эх сурвалж болох баримт юм.

Мөн Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (APG)-ийн шинжээчдийн багийн зөвлөмжөөр олон улсын жишигт нийцүүлэн Монгол улсын Хууль сахиулах байгууллагын харьяа нэгжүүд, мэдээлэх үүрэгтэй этгээдүүдэд эдийн засгийн тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн санхүүгийн шинжээчийг ажиллуулах зөвлөмжийн дагуу 2019 оноос хэрэгжүүлж ажилласан. Одоогоор Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, Монгол банкны Санхүү мэдээллийн алба, Санхүүгийн зохицуулах хороонд шинжээчид ажиллаж байна.

Харин хууль сахиулах байгууллагын санхүүгийн шинжээч нар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.11 дүгээр зүйл "...шинжилгээг шинжээч томилж хийлгэх шаардлагагүй, мөрдөн шалгах ажиллагаа явуулж тогтоох боломжтой, эсхүл өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгийн хүрээнд тогтоох боломжтой гэж үзвэл магадалгаа гаргаж болно.", 6.2 дугаар зүйлийн 5 дах хэсэгт "Тусгай мэдлэг эзэмшсэн мөрдөгч энэ хуульд заасан шинжээчийн эрхийг хэрэгжүүлж, магадалгаа гаргаж болно" гэсэн заалтыг удирдлага болгон мөрдөгчийн магадалгаа гаргаж гэмт хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг бүрдүүлж байна.

Энэхүү судалгааны ажлаар эдийн засгийн шинжээч, санхүүгийн

шинжээч нар нь хэрэгт авагдсан баримтад үндэслэн тусгай мэдлэгийн хүрээнд дүн шинжилгээ хийж татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримтаар үнэлэгдэхүйц шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадалгаа гаргахад тулгардаг асуудлууд, түүнийг шийдэх арга замыг хөндсөн болно.

### Хийгдсэн судалгааны ажлууд

Гадаад орны эрдэмтэн судлаачдын хувьд шүүх нягтлан бодох бүртгэлийн талаар тодорхой хэмжээний судалгаа шинжилгээ хийсэн байна. Тухайлбал Peterson (2020) Шүүх нягтлан бодох бүртгэлийн онол гэдэг нь ажиглагдаж байгаа шүүх нягтлан бодох бүртгэл болон практик ажлын тайлбар юм гэж томъёолсон. Мөн улс орны эдийн засагт үйлдэгдэж байгаа санхүүгийн залилан, эдийн засгийн гэмт хэргийг илрүүлэх, нотлоход шүүх нягтлан бодох бүртгэл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж байна. Санхүүгийн залилан хийх, эдийн засгийн гэмт хэрэг үйлдэх арга шинэчлэгдэж, илрүүлэхэд хүндрэлтэй болж байгаа учраас эдийн засгийн шинжээчийн чадвар, мэдлэг, хянамгай байдал нь тухайн төрлийн гэмт хэргийг илрүүлэх гол түлхүүр юм.

Шүүхийн шинжилгээний талаар хэд хэдэн тодорхойлолт эрдмийн ажлуудад тааралддаг. Тухайлбал шүүх нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн салбарын мэдлэг чадвар болон асуудлыг шийдвэрлэх судлаачийн сэтгэлгээг нотлох ажлын хүрээнд хэрэглэх гэж тодорхойлсон нь бий (Bolgna G. & Linquist R. (1995). Fraud auditing and forensic accounting New tools and technique (2ndBolgna). Шийдэгдээгүй асуудлыг нотлох ажлын хүрээнд нягтлан бодох бүртгэлийн, аудиторын, санхүүчийн болон мөрдөгчийн чадварыг хэрэглэхийг шүүх нягтлан бодох бүртгэл гэнэ.





(Arokiasamy L. & Cristal-Lee. S. (2009). Forensic accounting: Public acceptance towards occurrence of fraud detection. International Journal of Business and Management). Шүүх нягтлан бодох бүртгэл гэдэг нь аудит, эдийн засаг, санхүү, мэдээллийн систем, эрхзүйн салбаруудтай харилцдаг төвөгтэй эрдэм юм. (Crumbley D.L. (2009) “So what is forensic accounting”)

Зарим эрдэмтэд шүүх нягтлан бодох бүртгэлийн шинжилгээ залиланг илрүүлэхэд тусалдаг гэж баталдаг (Silverstone H. Sheetz M. Pedneault S. & Rudewicz F. (2004). Forensic accounting and fraud investigation for non-experts (Vol. 2). Hoboken NJ Wiley) бол хэсэг эрдэмтэд залилан үйлдэх сэдлийг тогтоодог гэсэн нь ч байдаг. (Razee 2005 Causes consequences and deterrence of financial statement fraud Critical Perspectives on Accounting)

Залиланг тухайн байгууллагын ажилтнууд, хуучин ажилтнууд, гуравдагч этгээдүүд үйлдэж болох (Crumbley D. Heitger L. & Smith G. (2003) Forensic and investigative accounting. Chicago IL: CCH Incorporated) бөгөөд хамгийн гол нь санхүүгийн тайлан, анхан шатны баримтыг өөрчлөх замаар залилан үйлдэгддэг. (Ozili (2015). Forensic Accounting and Fraud: A Review of Literature and Policy Implications International Journal of Accounting and Economics Studies)

Мөн санхүүгийн шинжээч мөрдөгч хүнд байх чадварын талаар эрдэм шинжилгээ ажлууд бичигдсэн байна. Жишээлбэл хүчтэй дүн шинжилгээ хийх чадвар, аман болон бичгээр харилцах чадвар, бүтээлч сэтгэлгээ, ажил хэрэгч байдал (Messmer, 2004), шүүмжлэлтэй сэтгэлгээ, стратегч сэтгэлгээ, аудит хийх чадвар, судалгаа хийх чадвар, гэмт хэрэгтэн шиг бодох чадвар, мөрдөгчийн дадал, аман болон

бичгийн харилцааны чадвар (Davis C. Farrell R. & Ogilby S. (2010). Characteristics and skills of the forensic accountant. White paper. American Institute of Certified Public Accountants), санхүүгийн тайлагналын ахисан түвшний мэдлэг, шинжилгээ хийх, залилангийн аргыг гүнзгий ойлгох (Ramaswamy V. (2005). Corporate governance and the forensic accountant. CPA Journal) чадварыг санхүүгийн шинжээч мөрдөгч эзэмшсэн байвал зохино гэжээ.

### **Татвар төлөхөөс зайслхийх гэмт хэргийн нөхцөл байдал, шинжилгээ хийхэд тулгамдаж байгаа асуудал**

Шүүхийн мэдээллийн цахим сангаас авсан мэдээллээр 2020 онд 1 хэрэг, 2021 онд 4 хэрэг, 2022 онд 25 хэрэг, 2023 онд 10 хэрэг, 2024 онд 13 хэргийг шүүхээр шийдвэрлэж татвар төлөхөөс зайлсхийх зүйл ангиар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн байна.

Тухайлбал Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 347 дугаартай шийтгэх тогтоолд дурдсанчлан “Нэр бүхий иргэн нь Хувь Хүний Орлогын Албан Татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т “хувиараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх, зуучлалын үйл ажиллагаа эрхэлж олсон орлого”-оос, улсын төсөвт холбогдох татвар ногдуулж төлөхөөр заасныг зөрчиж, 2018-2021 онуудад алтны орлого 3.884.309.288.5 төгрөг, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого 348.500.000 төгрөгийн орлогод хувь хүний орлогын албан татвар 498.405.79 төгрөгийг өөрөө тайлагнаж, 394.902.523.07 төгрөгийг төлөхөөс зайлсхийсэн” гэх хэргийг Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан

шатны шүүхээс эцэслэн шийдвэрлэсэн байдаг. Шүүхийн шийдвэрт 10 /арав/ сарын хугацаанд зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх, гэмт хэргийн хохирол, хор уршигт /394.902.523 /гурван зуун ерэн дөрвөн сая есөн зуун хоёр мянга таван зуун хорин гурав/ төгрөгийг Татварын ерөнхий газарт буюу улсын төсөвт нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн байдаг.

Мөн Эрүүгийн цагдаагийн албаны санхүүгийн шинжээч-мөрдөгчийн магадалгааг нотлох баримтаар үнэлэн Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 1328 дугаартай шийтгэх тогтоолд дурдсанчлан “Нэр бүхий иргэн нь Баянзүрх дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “...” ХХК-ийн менежерээр ажиллаж байсан гэх иргэн нь их хэмжээний татварын өрийг багасгах, татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор үйл ажиллагаа огт явуулдаггүй “...” ХХК-иас 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хооронд 41 ширхэг борлуулалтын төлбөрийн баримтаар 1,136,363,636.36 төгрөгийн үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээг худалдан авсан мэтээр, төлбөрийн баримтын хий бичилтийг бусдаар хийлгэн худалдан авалтын буцаалт хэсэгт тусгаж, төсөвт төлөх нэмэгдсэн өртгийн албан татварыг 113,636,363.64 төгрөгөөр бууруулан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэх хэргийг дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс эцэслэн шийдвэрлэн иргэнд 5,000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 5,000,000 төгрөгөөр торгох ял оногдуулсан. Энэ гэмт хэргийн улмаас улсын төсөвт 113,636,363.64 төгрөгийн хохирол учирсан бөгөөд шүүгдэгч нь татварын тайланг

залруулж, гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо төлсөн болохыг шийтгэх тогтоолд дурдсан байдаг. (Шүүхийн шийдвэрийн цахим сан, 2019)

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийг Мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг болох хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг, авлига албан тушаалын гэмт хэрэг, хүн худалдаалах гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэргүүдийн илрүүлэлт, шийдвэрлэлт нь өмчлөх эрхийн эсрэг жижиг хэргүүд буюу хулгайлах, дээрэмдэх, мал хулгайлах гэмт хэргээс бага байна.

Мөнгө угаах суурь гэмт хэрэгт холбогдуулан шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн хэргийн тоо бага, тус гэмт хэргийг дангаар нь буюу суурь гэмт хэргээс тусад нь шийдвэрлэх, мөн гэмт хэрэгт бага дүнтэй, хохирол багатай гэмт хэргийг хамруулж байгаа нь сайн хэдий ч хохирол ихтэй, олон нийтийн анхааралд өртсөн, зохион байгуулалттай гэмт хэргүүд шүүхээр шийдвэрлэгдэхгүй байгаа нь өнөөгийн хуулийн байгууллагын тулгамдсан асуудал болж байна. (Г.Гэрэлтуяа Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал)

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн тусгай мэдлэг, мэргэжил бүхий эдийн засгийн шинжээч нар шинжээчийн дүгнэлт, Санхүүгийн шинжээч-мөрдөгч нар мөрдөгчийн магадалгаа гаргаж, нотлох баримтын эх сурвалжийг бүрдүүлэх эрхзүйн орчин манай улсад үйлчилж байна. Эдийн засгийн холбогдолтой гэмт хэргийг илрүүлэх, хянан





Хууль сахиулах

шийдвэрлүүлэх чиглэлээр нотлох баримтад үндэслэн шинжилгээ хийхэд дараах хүндрэлүүд практик дээр үүсэж байна.

1. Татвар төлөхөөс зайслхийх гэмт хэргийг үйлдэхдээ анхан шатны баримтыг хуурамчаар эсвэл татвар, хууль хяналтын байгууллагад зориулж өөр хувилбараар үйлдэж, зарим тохиолдолд анхан шатны баримтыг хуурамч гэдгийг нотолж чадахгүй нөхцөл байдал үүсэх.

Жишээлбэл: Монгол Улсын уул уурхайн салбарын компани БНХАУ-ын компанид ашигт малтмалыг дэлхийн зах зээлийн үнээс 50 хувь бага үнээр худалдах гэрээг үндсэн гэрээнээс гадна давхар үйлдэж татварын байгууллагад борлуулалтын орлогоо багаар мэдүүлэх замаар аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас зайлсхийж байна гэж төсөөлье. Энэ тохиолдолд эдийн засгийн шинжээч үндсэн гэрээнээс гадуур үйлдсэн гэрээг анхан шатны баримтаар тооцож шинжилгээ хийхээс аргагүй байдалд хүрч гэмт хэрэг илрэхгүй байдалд орж байна. Шинжээч хэрэгт авагдсан нотлох баримтаас гадна нээлттэй эх сурвалжийн мэдээлэл, тухайн тохиолдолд ашигт малтмалын дэлхийн зах зээлийн үнийг ашиглан магадлах эсвэл статистик мэдээ мэдээлэлтэй харьцуулж магадлагч нягтлан бодох бүртгэлийн бус эдийн засгийн дүн шинжилгээ хийж тооцоолсон хохирлыг нотлох баримтаар үнэлдэг байх эрхзүйн орчин шаардлагатай байна.

2. Татвар төлөхөөс зайслхийх гэмт хэрэгт сэрдэгдсэн иргэн, аж ахуйн нэгжийн дансны хуулгыг арилжааны банк, банк бус санхүүгийн байгууллагууд хууль сахиулах байгууллагад цаасан хэлбэрээр гаргаж өгч байгаа нь дансны хуулганд шинжилгээ хийхэд нэлээдгүй цаг

хугацаа шаардсан ажлыг зохиомлоор бий болгодог. Мөн дансны хуулганы мэдээлэл нь дүн шинжилгээ хийхэд бүрэн хэмжээгээр шаардлага хангадаггүй, цаг хугацаа их шаарддаг, гарсан үр дүн хэрэг хянан шийдвэрлэхэд шууд үр дүнд хүрдэггүй дахин мэдээлэл авах шаардлага үүсэх зэрэг хүндрэлүүд тулгамдаж ирсэн. Энэхүү хүндрэлээс гарахын тулд Улсын ерөнхий прокурор, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 117/284 дугаар тушаалаар баталсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор банкнаас эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам”-ыг шинэчлэн боловсруулах, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны А-137 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг байгуулан ажиллаж, Монголбанкны Ерөнхийлөгч, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн А-185/А-176 дугаар хамтарсан тушаалаар “Мэдээлэх үүрэгтэй этгээдээс эрх бүхий хууль сахиулах болон терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам”, “Банкнаас дансны хуулга авах загвар” болон “Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс гүйлгээний тухай мэдээлэл авах загвар” тус тус батлагдсан.

Хууль сахиулах байгууллагын зүгээс Монголбанк, арилжааны банкнуудтай хамтран дансны хуулгыг банкнууд өөр өөрсдийн форматаар бус нэгдсэн нэг форматаар, файл хэлбэрээр, түргэн шуурхай гаргаж өгөх чиглэлд тодорхой ажлыг зохион байгуулж, эрхзүйн орчин бүрдүүлсэн хэдий ч арилжааны банкнууд өдийг хүртэл өөрсдийн системдээ өөрчлөлтийг хийхгүй байна.

## Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар өнөөгийн нийгэмд татвар төлөхөөс зайлсхийх, санхүүгийн залилан хийх, эдийн засгийн гэмт хэрэг үйлдэх арга шинэчлэгдэж илрүүлэхэд хүндрэлтэй болж байгаа учраас эдийн засгийн шинжээчийн чадвар, мэдлэг, хянамгай байдал нэн чухал. Түүнчлэн шүүмжлэлтэй сэтгэлгээ, дүн шинжилгээ хийх чадвар, судалгаа хийх чадвар, гэмт хэрэгтэн шиг бодох чадварыг “*шинжээч*” эзэмшсэн байвал зохино гэж дүгнэж байна. Иймд шинжээч нар гэмт хэргийн шинж чанарт үндэслэн дүн шинжилгээ хийх арга аргачлал шаардлагатай гэж дүгнэж байна.

Мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслэн дүн шинжилгээ хийж, нотлох баримтын эх сурвалжийг бүрдүүлэх эрхзүйн орчин манай улсад өнөөг хүртэл үйлчилж байгаа нь эдийн засгийн гэмт хэрэг үйлдэх арга шинэчлэгдэж, үндэстэн дамнасан гэмт хэрэг ихээр гарах болсонтой холбогдуулан, хэргийг илрүүлэхэд хүндрэлтэй болж байгаа учраас гэмт хэргийн шинж чанараас хамаарч магадлагч нягтлан бодох бүртгэлийн бус эдийн засгийн дүн шинжилгээ хийж тооцоолсон хохирлыг нотлох баримтаар үнэлдэг байх эрхзүйн орчин шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.3 дугаар зүйлд заасан “Татвар төлөхөөс зайлсхийх” гэмт хэргийг шалгаж шийдвэрлэхэд Татварын ерөнхий хуулийн 41 дүгээр зүйлийн 41.11. дэх хэсэгт “Татварын алба, татварын улсын байцаагч хяналт шалгалт хийхдээ дараах ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно:”, 41.11.2

дах хэсэгт “татварын улсын байцаагч татвартай холбогдсон эрүү, захиргааны хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр оролцох.” гэж заасан нь хуулийн хийдэл үүсгэж, төлөхөөс зайлсхийсэн татварын хэмжээг тогтооход хүндрэл учруулсаар ирлээ. Иймд Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хууль, Татварын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах замаар Татварын мэргэшсэн зөвлөх эдийн засгийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Тусгай мэдлэг мэргэжил эзэмшсэн “*шинжээч*” нар мэргэжлийн ур чадвар сайн эзэмшсэн байх, мэргэжлийн ёс зүйг чандлан сахих, дүн шинжилгээ хийх, судалгаа хийх чадварыг маш сайн эзэмшсэн чадварлаг боловсон хүчний нөөцөөр алба хаагчдыг бүрдүүлсэн байх нь хэргийг үнэн зөв, бодитой, түргэн шуурхай шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагаар шинжилгээ хийлгэж, эрх бүхий байгууллагын акт дүгнэлт гаргуулан хохирол, дутагдал, зөрчлийн хэмжээг тодорхойлох ажиллагаа нь нягтлан бодох бүртгэл хөтлөж, санхүүгийн тайлан гаргах, аудит хийх үйл ажиллагаанаас зорилго, зорилтын хувьд ялгаатай тул шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийх байгууллагын боловсон хүчнийг сурган дадлагажуулж, чадавхижуулах ажлыг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх шаардлагатай.

## Санал

Татварын гэмт хэрэг үйлдэх арга, хэлбэр улам нарийсч, далд болон олон





шатлалт бүтэцтэй болж буй өнөөгийн нөхцөлд татварын мэргэшсэн зөвлөх, мэргэжлийн нягтлан бодогч, санхүүгийн шинжээч зэрэг тусгай мэдлэг, ур чадвартай этгээдийг эдийн засгийн шинжээчээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт мэргэшсэн шинжээчийн институцийг салбарчилсан бүтэцтэйгээр хөгжүүлж, хүний нөөцийн орон тоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ тэдний мэргэжлийн ур чадвар, ёс зүй, дүн шинжилгээ хийх чадавхыг нэгдсэн стандарт, шаталсан шалгуур бүхий зохицуулалтаар хангах.

Шүүхийн шинжилгээг зөвхөн төрийн байгууллагаар гүйцэтгүүлэх хязгаарлагдмал тогтолцооноос татгалзан, тусгай зөвшөөрөлтэй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагаар шинжилгээ хийлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналт, үнэлгээ, чадавхжуулалтын тогтолцоог сайжруулах замаар шинжилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг нь татвар, санхүү зэрэг олон салбарыг хамарсан шинжтэй байдаг тул холбогдох төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах зорилгоор татвар, санхүүгийн зохицуулалтын байгууллага, мөрдөн шалгах байгууллага, прокурор болон шүүхийн шинжээчдээс бүрдсэн байнгын хамтарсан багийн тогтолцоог бүрдүүлэх, сургалт, мэдээлэл солилцоо, хамтын дүн шинжилгээг институцийн түвшинд зохион байгуулах.

### Ашигласан материал

- Arokiasamy L. & Cristal-Lee. S. (2009). Forensic accounting: Public acceptance towards occurrence of fraud detection. *International Journal of Business and Management*. (n.d.). Arokiasamy L. & Cristal-Lee. S. (2009). *Forensic accounting: Public acceptance towards occurrence of fraud detection. International Journal of Business and Management*.
- Bolgna G. & Linquist R. (1995). *Fraud auditing and forensic accounting New tools and technique* (2nd ed.). Bolgna, G. & Linquist, R. (1995). *Fraud auditing and forensic accounting: New tools and technique* (2nd ed.). New York, NY: John Wiley & Sons.
- Crumbley D. Heitger L. & Smith G. (2003) *Forensic and investigative accounting*. Chicago IL: CCH Incorporated. (n.d.). Crumbley, D. L., Heitger, L. E., & Smith, G. S. (2003) *Forensic and investigative accounting. Chicago, IL: CCH Incorporated*.
- Crumbley D.L. (2009) "So what is forensic accounting?". (n.d.). Crumbley, D.L. (2009), "So what is forensic accounting?", *The ABO Reporter*, available at: <http://aaahq.org/abo/reporter/fall09/abo08.htm>.
- Davis C. Farrell R. & Ogilby S. (2010). Characteristics and skills of the forensic accountant. White paper. American Institute of Certified Public Accountants. (n.d.). Davis, C., Farrell, R., & Ogilby, S. (2010). *Characteristics and skills of the forensic accountant. White paper. American Institute of Certified Public Accountants, pp. 11–26*.
- Ozili (2015). *Forensic Accounting and Fraud: A Review of Literature and Policy Implications International Journal of Accounting and Economics*

- Studies. (n.d.). Ozili, P. K. (2015). *Forensic Accounting and Fraud: A Review of Literature and Policy Implications. International Journal of Accounting and Economics Studies*, 3(1), 63–68.
- Ramaswamy V. (2005). Corporate governance and the forensic accountant. *CPA Journal*. (n.d.). Ramaswamy, V. (2005). *Corporate governance and the forensic accountant. CPA Journal*, 75, 68–70.
- Razee 2005 Causes consequences and deterrence of financial statement fraud Critical Perspectives on Accounting. (n.d.). Rezaee, Z. (2005). *Causes, consequences, and deterrence of financial statement fraud. Critical Perspectives on Accounting*, 16(3), 277–298.
- Silverstone H. Sheetz M. Pedneault S. & Rudewicz F. (2004). *Forensic accounting and fraud investigation for non-experts (Vol. 2)*. Hoboken NJ Wiley. (n.d.). Silverstone, H., Sheetz, M., Pedneault, S., & Rudewicz, F. (2004). *Forensic accounting and fraud investigation for non-experts (Vol. 2)*. Hoboken NJ Wiley. (n.d.).
- Г.Гэрэлтуяа Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал. (n.d.). Г.Гэрэлтуяа (2022). “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл “Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэлийн асуудал”. Мөнгө угаах гэмт хэргийн зүйлчлэл, тулгамдаж буй асуудал, цаашдын чиг хандлага сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 59-67 хуудас.
- Шүүхийн шийдвэрийн цахим сан. (2019). *Шүүхийн шийдвэрийн цахим сан*: [https://shuukh.mn/single\\_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court\\_cat=2&bb=1](https://shuukh.mn/single_case/39520?daterange=2019-01-01%20-%202019-12-12&id=1&court_cat=2&bb=1). UB.



## ХУУЛЬ БУСААР ЭМ ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОР УРШИГ, ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### THE CONSEQUENCES AND CURRENT STATE OF THE CRIME OF COUNTERFEIT DRUG DISTRIBUTION

**Р.Сундуйсүрэн**

Дотоод хэргийн их сургуулийн магистрант

**R. Sunduisuren**

Master's student at the University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: Sunduis109@gmail.com

**Хураангуй:** Стандартын бус хуурамч эмийн худалдаа нь дэлхий дахинд улс орнуудын хүн амын эрүүл мэнд, эдийн засгийн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл үзүүлж буй асуудлын нэг болоод байна. Эм, эмнэлгийн хэрэгслээс гадна биобэлдмэл үйлдвэрлэх, худалдах, түгээх, импортлох явдал нэмэгдэж, тусгай зөвшөөрөлгүй иргэн, хуулийн этгээд энэхүү үйл ажиллагааг ямар нэгэн зөвшөөрөлгүйгээр эрхэлж байгаагаас хүн амын эрүүл мэндэд аюул учруулах болсон бөгөөд малын эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанар, эрүүл ахуйн шаардлагын талаар ноцтой мэдээлэл нийгэмд түгээгдэх болсон.

Иргэдийн гарцаагүй байдал буюу хүнд өвчний өмнө хүчин мөхөсдсөн байдлыг далимдуулан малд хэрэглэгддэг эм, бэлдмэлийг хорт хавдар эдгээдэг, элдэв төрлийн ургамлыг ахуйн хүрээнд бэлдэж төрөл бүрийн өвчин анагаадаг гэж итгүүлэн нууцаар зарж борлуулсаар байгаа нь одоог ч хүртэл түгээмэл байна.

Монгол Улсад хуурамч эмийн эргэлт харьцангуй бага түвшинд илэрч байгаа хэдий ч эмийн импорт, хилийн хяналт шалгалт, онлайн худалдааны эрх зүйн зохицуулалт, шинжилгээний лабораторын тоног төхөөрөмжийн хүрэлцээ, мэргэшсэн боловсон хүчний дутагдал зэрэг хүчин зүйлээс шалтгаалан учирч болох эрсдэл өндөртэй байна.

**Abstract:** The sale of substandard and counterfeit medicines has become one of the major global threats to public health and economic security. In addition to medicines and medical devices, the production, sale, distribution, and importation of biological products have increased, with individuals and legal entities engaging in such activities without the required authorization. As a result, risks to public health have grown, and serious concerns regarding the quality and safety of veterinary drugs, biological products, and medical devices have been widely disseminated in society.

Exploiting people's vulnerability when facing severe illnesses, some individuals continue to secretly sell veterinary drugs and preparations by falsely claiming they can cure cancer, or promote the use of various homemade herbal mixtures as treatments for different diseases—practices that remain widespread even today.

Although the circulation of counterfeit medicines in Mongolia is relatively low, potential risks remain high due to factors such as pharmaceutical imports, border control and inspection challenges, inadequate legal regulation of online sales, limited laboratory testing equipment, and shortages of qualified professionals.

**Түлхүүр үгс:** Хуурамч эм, хууль бус худалдаа, тусгай зөвшөөрөл, гэмт хэрэг, эм

**Keywords:** Counterfeit drugs, illegal trade, special license, crime, drugs

## Удиртгал

Нийгмийн эрүүл мэндийн салбарын үндсэн үүргүүдийн нэг бол хүн амыг чанартай, аюулгүй, үр дүнтэй эмээр хангах асуудал байдаг. Гэвч хөгжил буурай улс орны хэдэн сая иргэд ядууралд нэрвэгдсэний улмаас эрүүл мэндийн үйлчилгээ авч, эмээр хангагдаж чадахгүйн улмаас амь насаа алдаж байна. Харамсалтай нь үүний эсрэг талд стандартын бус, хуурамч эмийн эргэлт, хэрэглээ нь үргэлж сүүдэр мэт оршин тогтноод зогсохгүй эмийн зах зээлийн хууль ёсны эргэлтэд орсоор байна.

Иргэдийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрх тэгш байдлыг хангах үүднээс энэхүү салбарт хийгдэх санхүүжилтийг үргэлж нэмэгдүүлсээр ирсэн ба хөгжиж буй бага орлоготой орнуудын хувьд сүүлийн 20 жилийн дотор 3 дахин нэмэгдсэн байна. Хөгжил буурай орнуудын тухайд энэ салбарт оруулж буй санхүүжилт нэмэгдсэн хэдий ч иргэдийн нуруун дээрх санхүүгийн ачаалал буурсангүй, тэд эрүүл мэндийн үйлчилгээний төлбөрийг өөрсдийн халааснаас гаргасан хэвээр л байна. Манай улсын тухайд Эрүүл мэндийн даатгалын сангын шимтгэлийн орлого 1995 онд 7.5 тэрбум байсан бол сүүлийн жилүүдэд 302.6 тэрбум төгрөгт хүрсэн нь тус сангийн орлого 40.4 дахин нэмэгдсээр байна (Н.Гантуяа, 2017).

Сүүлийн жилүүдэд эм, эмбиобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зах зээл төсөөлөхийн аргагүй байдлаар тэлсээр 15 жилийн өмнө дэлхийн эмийн зах зээл анх удаа 500 тэрбум долларт хүрч байсан бол тэр үетэй харьцуулахад 2 дахин өсөж 1.1 триллион долларт хүрээд байна (organization, 2021). Харамсалтай нь эмийн зах зээлийн энэхүү өсөлт, тэлэлт нь эм, эмбиобэлдмэл, эмнэлгийн

хэрэгслийн чанар, аюулгүй байдал, эмнэлгийн үйлчилгээний үр дүнд сөрөг нөхцөл бий болгож стандартын бус, хуурамч эм, вакцин, бусад бүтээгдэхүүнүүд эмийн зах зээлийн эргэлтэд орж эхэлсэн байна.

Албан ёсны бүртгэлтэй, тусгай зөвшөөрөл бүхий олон тооны эмнэлгийн үйлдвэрүүд стандартын бус эм, эмбиобэлдмэл, бусад тоног төхөөрөмжийг үйлдвэрлэсээр байгаа ба тэдгээр нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, улс орнуудын эрүүл мэндийн байгууллагаас гаргасан эмний чанар аюулгүй байдалд тавьж буй стандартын шаардлагыг хангадаггүй байна. Өөрөөр хэлбэл эрүүл ахуйн шаардлага хангаагүй бохир орчинд үйлдвэрлэсэн, эмний хайрцаг сав баглаа боодлын стандарт зөрчсөн, тухайн эмний найрлага, орц нь хувь хэмжээндээ хүрэхгүй байх эсхүл хэт их байх, бүтээгдэхүүний заавар, танилцуулга байхгүй, хадгалалт, хамгаалалт тээвэрлэлтийн стандарт зөрчсөн байх хэлбэрүүдийг агуулдаг байна.

Хуурамч эмийн эргэлт нь зөвхөн манай улсад биш дэлхийн олон улс гүрнүүдийн удирдлага төдийгүй эрүүл мэндийн байгууллага, эмч ажилтан, өвчтөн, эмчлүүлэгч бүрийн санаа бодлыг чилээсэн асуудал болсоор байна.

Стандартын бус, хуурамч эмийн хууль бус эргэлтээр ашиг олж санхүүжиж байгаа зохион байгуулалттай гэмт бүлэглэл нь ихэвчлэн 3-10 хүний бүрэлдэхүүнтэйгээр эмийн хууль бус бараа бүтээгдэхүүн, хуурамчаар дахин савлах, хаяг наалт хийж өөрийн сүлжээгээр дамжуулан гэмт хэргийн хар зах болон борлуулах, нийлүүлэх үүргийг тус тус гүйцэтгэдэг. Зарим нэг тусгай зориулалтын эм, биобэлдмэлүүдийг тусгайлан газруудад





нийлүүлдэг. Тухайлбал, допингын төрлийн эм, биобэлдмэлийг тусгай зориулалтын спорт клуб болон фитнес төвүүдээр борлуулдаг бол зарим гэмт бүлэглэл нь эмнэлэг, эмийн сан, эмийн тээвэрлэлт хариуцсан байгууллага, чиглэлд дээрмийн халдлага хийж, дээрэмдсэн эм, биобэлдмэл бодисыг эмийн борлуулалтын бөөний төв, гэрээт борлуулагч болон жижиглэнгийн эмийн санд борлуулж санхүүжилтээ босгодог.

Европын холбооны цагдаагийн албанаас гаргасан судалгаанаас харахад 180 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг 5000 гаруй үндэстэн дамнаж зохион байгуулалттай гэмт хэрэг үйлддэг бүлэглэлд хяналт тавьж ажиллаж байна (SOCTA, 2017). Эдгээр гэмт бүлэглэл нь дээд зэргийн уян хатан, ямар ч нөхцөлд дасан зохицох чадвар сайтай, олон төрлийн ур чадвартай мэдээлэл технологийн мэргэжилтэн, хурд авхаалж самбаа сайтай, олон талын мэдлэгтэй гишүүдээр хүрээлүүлсэн, үндсэн үйл ажиллагааг бизнесийн зарчмаар үйл ажиллагаа явуулдаг, халхавчийн олон төрлийн үйл ажиллагааны аж ахуйн нэгж эзэмшиж, тэдгээртэй маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийж үндэстэн дамнасан зохион байгуулалттай бүхий л төрлийн гэмт үйлдэлд оролцохоос гадна террорист бүлэглэлтэй хамтарч ажиллаж санхүүжүүлсээр байна.

Дээрх гэмт бүлэглэлийн 20 орчим хувь нь богино хугацаанд оршин тогтнож, зохион байгуулалттай гэмт хэргийн тодорхой нэг урсгал, чиглэл, сүлжээ, бүлэглэлийг дэмжиж ажилдаг. Гэмт хэргийн хар зах зээл дээр шинээр бүртгэгдэж, маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж, хүрээгээ эрчимтэй, хурдтайгаар тэлж байгаа салбар бол орчин цагийн гэмт хэргийн интерпрюнер гэгдэж буй Crime-as-a-

Service /CaaS/ болон Peer to Peer /P2P/ юм.

“P2P” болон “CaaS” нь цахим сүлжээн дэх бүхий л хууль бус бараа бүтээгдэхүүний хууль бус худалдаа төдийгүй хууль бус, гэмт хэргийн талаарх зөвлөгөө өгч, тодорхой төрлийн үйлчилгээ үзүүлдэг салбар юм. Гэмт этгээдийг цахим гэмт хэрэг үйлдэхэд шаардлагатай бүхий л мэдээлэл, техник хэрэгсэл, хакерын бүхий л төрлийн аппликайшныг зохион бүтээж худалдаанд гаргахын зэрэгцээ үйл ажиллагааг нь хариуцан ажилдаг байна. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн зах зээлийн үнэлгээ нь 2017 оны байдлаар 1.6-2.2 триллион ам долларт хүрсэн байна.

#### **Олон улс дахь хуурамч эм худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал**

1988 онд хуралдсан Дэлхийн эрүүл мэндийн ерөнхий чуулганаас баталсан WHA41.16 тогтоолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хуурамч нэр хаягтай, стандартын бус, хуурамч эмийн бэлдмэлийг экспортлох, хууль бусаар наймаалах явдлыг шалгаж таслан зогсоох тухай хөтөлбөрийг санаачлахыг зөвлөсөний дагуу олон улсын эмийн тухай гэрээний заалтуудыг зөрчигдсөн тохиолдолд Нэгдсэн үндэсний байгууллагын ерөнхий нарийн бичгийн даргатай хамтран шийдвэрлэж болно хэмээн заасан. Энэхүү тогтоолын дагуу 1992 оны 4 сарын 1-3-ны хооронд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын эм үйлдвэрлэгчдийн холбоотой хамтран Женев хотноо хуурамч эмийн тухай олон улсын анхны уулзалтыг зохион байгуулсан бөгөөд уг уулзалтанд оролцогчид “Хуурамч эм гэдэг нь үйлчлэгч бодис, үйлдвэрлэлийн нэрийг барьж тухайн

бүтээгдэхүүнийг санаатай болон луйврын зорилгоор хуурамч шошго хэрэглэн үйлдвэрлэсэн эмийг хэлнэ. Хураамчаар үйлдвэрлэх нь патентын болон ерөнхий нэршлийн эмэнд нэгэн адил хамаарах бөгөөд түүний найрлагад үйлчлэгч бодис огт байхгүй буюу бага хэмжээтэй байхыг хэлнэ” хэмээн тодорхойлсон.

Дээрх уулзалтаас гарсан зөвлөмжид эм үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгч бүх талууд хуурамч эмтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэхэд хамтран идэвхтэй оролцохыг уриалсан. Дэлхийн олон оронд хуурамч эм маш хурдацтайгаар тархаж буйтай холбогдуулан 1994 онд Дэлхийн эрүүл мэндийн чуулганаас гаргасан WНА47.13 тогтоолд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага хуурамч эмийн эсрэг тэмцэж, баталгаатай эмээр хангахад нь гишүүн улсууддаа дэмжлэг үзүүлэхийг зөвлөсөн. Хуурамч эмийг импортлох, хууль бусаар худалдаалах, сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэрт их хэмжээгээр үйлдвэрлэн худалдаалж байна

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан мэдэгдэлд “бага болон дунд орлоготой улс орнуудад хэрэглэж буй эмийн 10–30 хувь нь чанарын шаардлага хангаагүй, хуурамч бүтээгдэхүүн байдаг нь өвчтөнүүдийн эмчилгээний үр дүнд муугаар нөлөөлөх, эмэнд тэсвэртэй нянгийн тархалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна” (who.int, 2024.12.03).

Стандартын бус, хуурамч эмийн тархац дэлхий нийтийн тэр дундаа нийлүүлэлтийн гинжин хэлхээний хяналт багатай дунд болон бага орлоготой улс орнуудын хувьд томоохон асуудал болж байна. Өндөр орлоготой орнуудад нийтлэг гарч буй хуурамч, стандартын бус эмийн тохиолдлууд нь ихэвчлэн шинэ төрлийн даавар, стероид, нэмэлт

бүтээгдэхүүн байхад бага, дунд орлоготой улсуудад хумхаа, сүрьеэ, ХДХВ, ДОХ зэрэг хүний амь насанд аюул заналхийлсэн өвчнүүдийг эмчлэх нянгийн эсрэг үйлчилгээтэй эм бэлдмэлүүд нийтлэг бүртгэгдэж байна (ДЭМБ, 2024).

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага анх хуурамч эмийн тухай уулзалтыг 1992 оны 04 дүгээр сард зохион байгуулж, уулзалтад оролцсон төлөөлөгчид дараах тодорхойлолтуудыг хамтран гаргасан:

1. “Хуурамч эм” гэж хууль бусаар ашиг олох зорилгоор эм үйлдвэрлэгчийн нэрийг ашиглан хуурамч шошго хэрэглэж, дуурайлган үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хэлнэ.

2. “Стандартын бус эм” гэж Эмийн үндэсний зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн үйлдвэрлэгч үйлдвэрлэсэн жинхэнэ эм боловч чанарын стандарт эсвэл үзүүлэлт хангахгүй эмийг хэлнэ.

3. “Бүртгэлгүй эм” гэж үндэсний, бүс нутгийн хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд шалгагдаж, улсын бүртгэлд ороогүй эм, эмийн бүтээгдэхүүнийг хэлнэ.

Чанарын шаардлага хангахгүй эм, эмийн бүтээгдэхүүн, ялангуяа халдварт өвчинг эмчлэх нянгийн эсрэг үйлчилгээтэй эм хэрэглэх нь тухайн хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй байдаг. Хэдий хуурамч эм, иргэдийн нас баралт хооронд шууд хамаарал байгаа эсэхийг тодорхойлох хүндрэлтэй боловч Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаагаар Африкт жил бүр 169,000 хүүхэд уушгины үрэвсэл, 158,000 хүүхэд хумхаа өвчний эсрэг хуурамч эм хэрэглэснээс болж нас бардаг гэж тогтоогдсон (ДЭМБ, 2023).

Стандартын бус эм нь мөн үйлдвэрлэгчийн санаатай бус үйлдлээр илэрч болно. Эм, эмийн





бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах нь тухайн эмийн чанарт шууд сөрөг нөлөө үзүүлдэг. Тухайлбал антибиотик тетрациклинийг чийглэг уур амьсгалтай газар хадгалснаар химийн шинж чанар нь буурдаг байна (Келесидис Т, 2017).

Хуурамч нянгийн эсрэг эмийн бүтээгдэхүүнүүд нь ихэвчлэн хүний биед хортой бодис агуулдаг бөгөөд шохой, гурил, тальк зэрэг ямар ч эмчилгээний үр нөлөө үзүүлдэггүй бодис агуулдаг тохиолдлууд их гардаг. Гэвч зарим хуурамч эм халдварт өвчний клиник шинж тэмдгийг дарах үйлчилгээтэй бодис агуулдаг. Тухайлбал, хумхаа өвчний эсрэг хуурамч эм дотроо парацетамолын найрлагатай байсан тул өвчтөнүүдийн халуун буурч эхэлснээр тухайн эмийг сайн үйлчилгээтэй байна гэж үзэж байсан боловч энэ нь парацетамолоос болж халуун түр зуур буурах үзэгдэл байсан (Бассат Кю, 2022). Ингэж уг өвчний эмчилгээг удаашруулж, хойшлуулснаар өвчин хүндрэх, цаашлаад хүний амь нас эрсдэх аюул нүүрлэж болзошгүй. Мөн нэг төрлийн бодисыг зохих хэмжээнээс ихээр агуулснаар хүний амь нас эрсдэх, гаж нөлөө үзүүлэх, бактерийн антибиотик эсэргүүцэх чадварыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөө ихтэй. Эм үйлдэрлэгч байгууллага, компаний нэрийг ашиглаж, хуурамч, дуураймал эм үйлдвэрлэх нь оюуны өмчийн асуудлыг ч мөн хөндөж байгаа хэрэг юм.

Олон улсад гарч байсан хуурамч, стандартын бус эмийн тохиолдлуудаас 2017 онд ХБНГУ-ын Хойд Райн Вэстфэлиа хотын Боттроп тосгоны хорт хавдрын эсрэг эм үйлдвэрлэх эрх бүхий эм зүйч эр хавдрын эсрэг эмийн орц найрлагыг өөрчилж, 2005 оноос хойш эмнэлэг, эмийн сангуудад өөрийн эмийн сангаар дамжуулан нийлүүлж байсныг олж тогтоосон бөгөөд шүүхээс

түүний энэ үйлдлийн сүүлийн 5 жилийг л шүүн хэлэлцэхээр болж хохирогчийн тоог тогтооход нийт 3,700 гаруй өвчтөн тус эмийг хэрэглэж, 37 эмнэлгийн байгууллагуудад нийлүүлэлт хийгдсэн нь тогтоогдсон байна (Бертуг блог, 2023). Уг эмийг хэрэглэснээр өвчин эдгэхгүй, улам дордох тохиолдлууд ч гарч байсан. Энэ хэргийг илрүүлэхэд цагдаа, хууль хүчний байгууллага биш тухайн эмийн санд шинээр ажилд орсон зар сурталчилгаа хариуцсан дарга нь уг үйлдлийн талаар сэжиглэж зохих шатны байгууллагад мэдээлснээр уг үйлдэл олон нийтэд ил болсон. АНУ, Герман зэрэг улсуудад хэргийн талаар мэдээлэгч нь тухайн компаниас хурааж авсан хөрөнгийн 10-30 хүртэлх хувийг шагнал болгон авдаг практик байдаг.

Руанда улсын хувьд сүрьеэ болон хумхаа өвчний эсрэг эмүүдийг хувийн хэвшил зарж борлуулахыг төрөөс хориглож, төрийн санхүүжилттэй эрүүл мэндийн системд шилжсэнээр хуурамч эмийн нийлүүлэлтийн гинжин хэлхээг амжилттай бууруулсан туршлагатай. Гэсэн хэдий ч, энэ санаачлагыг амжилттай үргэлжлүүлэхийн тулд бүс нутгийн хамтын ажиллагаа шаардлагатай байсан боловч хөрш орнуудын хамтын ажиллагааны дутмаг байдлаас тус бодлогын үр дүн төлөвлөсөн хэмжээнд хүрч чадаагүй байна.

Олон улсын түвшинд энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас анх 2006 онд “Хуурамч эмчилгээний бүтээгдэхүүнтэй тэмцэх олон улсын хүчин”-ийг олон улсын түвшинд хуурамч эмтэй тэмцэх, үндэсний хэмжээнд хууль тогтоомж гаргахад дэмжлэг үзүүлэх зорилготойгоор байгуулж байсан түүхтэй. Гол үйл ажиллагаа нь хууль тогтоомж боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, хуурамч эмийг илрүүлэх,

урьдчилан сэргийлэх, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн.

Европын зөвлөлөөс Эмчилгээний эсрэг гэмт хэргийн конвенц буюу “Medicrime convention”-г боловсруулж, гишүүн улс орнууд 2011 оны 10 дугаар сарын 28-ны өдөр ОХУ-ын Москва хотноо гарын үсэг зурсан. Европын холбооны болон холбооны бус нийт 16 улс нэгдэн орсон, дэлхийн бүхий л улс орнууд нэгдэн орох боломжтой тус конвенц нь тодорхой төрлийн үйл ажиллагаануудыг гэмт хэрэг гэж үзэж, энэхүү конвенцод заасан гэмт үйлдлээс болж хохирсон хохирогчдын эрхийг хамгаалах, байгууллагад хариуцлага хүлээлгэх, үндэсний болон олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх, өвчтөний эрүүл мэндийг сахин хамгаалах үндсэн зорилготой.

Оюуны өмчийн эрхийн хувьд ихэнх тохиолдолд үндэсний хэмжээнд зохицуулдаг хэдий ч олон улсын түвшинд Худалдаатай хамаарах оюуны өмчийн эрхийн тухай хэлэлцээр (TRIPS)-ээр зохицуулагдаж байна. Олон улсын худалдаан дахь гажуудал, саадыг багасгах болон оюуны өмчийн эрхийг үр дүнтэй, зохистойгоор хамгаалахад дэмжлэг үзүүлэх хэрэгцээг харгалзан оюуны өмчийн эрхийг хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагаа нь өөрөө хууль ёсны худалдаанд саад болохгүй байх явдлыг хангах зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагаас санаачилсан.

Хуурамч, стандартын бус эм нь тухайн төрлийн өвчнийг анагаах үндсэн үүргээ гүйцэтгэхгүйгээс гадна олон нийтийн эм, эрүүл мэндийн байгууллага, системд итгэх итгэлийг үгүй хийх аюултай. Дэлхийн өнцөг булан бүрт, хууль бус гудамжны худалдаачид, вэбсайт, эмийн сан, эмнэлэг гээд хаана ч, хавдрын эсрэг

хамгийн үнэтэйгээс өвчин намдаах хамгийн хямд эмийг ч хуурамчаар чанар, ариун цэврийн шаардлага хангахгүй орчинд орц, найрлагыг өөрчлөн үйлдвэрлэж, хэрэглэгчдийн гарт хүргэж буй этгээдүүд хувь хүн болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн хэлбэрээр бусдын оюуны өмчийн эрхэнд халдаж, үйл ажиллагаагаа явуулсаар байна. Гэвч эдгээр эмийг илрүүлэх нөөц бололцоо, ур чадвар, байгууллага, улс орнуудын хамтын ажиллагаа дутмаг эмийн хууль тогтоомж сул байдал зэргээс шалтгаалж дэлхий нийт энэ гэмт хэрэгтэй дорвитой тэмцэж чадахгүй байна.

### **Монгол улсын хилээр эм, эмийн бэлдмэл хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал**

Цагдаагийн байгууллага, Хил хамгаалах байгууллагын хамтын хяналт шалгалтаар Монгол Улсын хилийн боомтоор 2019-2024 он хүртэл хугцаанд хууль бусаар эд зүйл нэвтрүүлэхийг завдсан 278 зөрчлийг илрүүлснээс 26 гэмт хэрэг, зөрчил буюу 9.3 хувь 700 сая төгрөгний үнэ бүхий эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар улсын хил нэвтрүүлэхийг завдсан зөрчил байна.

Хилийн боомтоор эмийг хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан гэмт хэрэг, зөрчлийг үйлдэж буй үйлдлийн аргаар нь авч үзвэл:

-Тээврийн хэрэгслийн эд ангид нуусан – 8;

-Эмийн жагсаалтад ороогүй эмийг биедээ авч явсан – 2;

-Хяналт шалгалтаас зайлсхийж нэвтрүүлэхийг завдсан – 3;


-Гар тээшэндээ нуусан – 5;

-Биедээ нуусан – 8 удаагийн үйлдэл тус тус гарсан байна.





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠬᠡᠮᠡᠳᠡ ᠶ᠋ᠢᠳᠠᠯ ᠰᠤᠳᠤᠯᠠᠭ



	2019	2020	2021	2022	2023	2024
■ Хууль бусаар эм нэвтрүүлэхийг завдсан	7	6	3	2	3	5
■ Бусад	67	62	10	53	45	15
■ Нийт	74	68	13	55	48	20

Хүснэгт №1:

Манай улсын иргэд 2019, 2020 онуудад Монголд үйлдвэрлэдэг “Тарваган шийр” эмийг ОХУ руу Эрэнцав боомтоор 5 удаагийн үйлдлээр 9100 ширхэгийг биедээ нууж хууль бусаар улсын хил нэвтрүүлэхийг завдсан зөрчил гаргаж байсан байна.

Илэрсэн зөрчлийг хилийн боомтоор нь авч үзвэл Алтанбулаг, Буянт-Ухаа, Замын-Үүд гэсэн Монгол Улсын

томоохон 3 боомтоор эмийг хууль бусаар нэвтрүүлэхийг завдаж байгаа бөгөөд зөрчлийн 71 хувь нь Монгол, Оросын хилийн боомтуудаар гарч байгаа нь хууль бусаар улсын хилээр эм оруулж ирэх зөрчлийн хяналт шалгалтыг хойд хилийн боомтууд руу чиглүүлэх нь зүйтэй болох нь харагдаж байна.



Мөн тээврийн хэрэгслийн эд ангийг зориудаар өөрчлөн нуувч болгон ашиглаж улсын хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэхэд ашиглаж байгаа нь

зөрчлийг илрүүлэхэд хүндрэлтэй болгож байна.

Монгол Улсын хилээр хууль бусаар эмийг нэвтрүүлэхийг завдсан зөрчил нь эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйл

“Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх” гэмт хэрэг тооцогдох бөгөөд дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ гэж хуульчилсан байна.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм зүйн сургуулийн эрдэмтэн багш, судлаачид хамтран 2021-2022 оны хугацаанд Монгол Улсын эмийн зах зээл дэх стандартын бус, хуурамч, бүртгэлгүй эмийн тархалтыг тогтоох зорилгоор 118 газрыг хамруулсан судалгааг явуулж 15 нэр төрлийн эмийн 1770 дээжийг түүвэрлэн авч МХЕГ-ын болон АШУҮИС-ийн лабораторийн шинжилгээнд хамруулахад хуурамч, дуураймал эм илэрчээ. Тодруулбал, Монгол улсын эмийн бүртгэлд бүртгэгдсэн Франц улсын PfizerPGM үйлдвэрийн Виагра 100мг эмийг дуурайлган хийсэн Силденафил цитрат 100 мг /хайрцаг дээрээ Виагра Pfizer гэсэн бичээстэй/ нэртэй хуурамч эм илэрсэн байна (home.inspection.gov.mn, 2022).

Дорноговь аймгийн Замын-Үүд боомтоор 2023 оны 06 дугаар сарын 18-ны өдөр нэр бүхий иргэн импортын лицензгүй, Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, хадгалалт тээвэрлэлтийн горим зөрчигдсөн 16 нэр төрлийн тариа 5175 ампул, 2 нэр төрлийн тарилгын шингэн 37 литр, 1 төрлийн тосон түрхлэг 1кг, 3 төрлийн эм 1000 таблетка, 2 төрлийн шингэн эм 7 литр, тарианы пенициллин 50 фалконыг хууль бусаар хил нэвтрүүлэхээр завдсаныг Замын-Үүд

боомтын Хилийн Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагчид илрүүлэн хурааж, хуулийн дагуу шийдвэрлэсэн бол хаяг шошгын зөрчилтэй нийт 11000 ширхэг нэг удаагийн тариур, дуслын системийг нэр бүхий иргэн зорчигч тээвэрлэх суудлын автомашинд нууж хууль бусаар улсын хилээр нэвтрүүлэхийг завдсан үйлдлийг Замын-Үүд боомт дахь Хилийн мэргэжлийн хяналтын албанаас илрүүлэн таслан зогсоож, прокурорт шилжүүлсэн шийдвэрлэсэн байна.

УБТЗ-ын хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Нэгдсэн эмнэлгийн байранд Монгол Улсад эмчлэх эрхийн зөвшөөрөлгүйгээр БНСУ-ын 8 эмч, 60 туслан ажилтан үзлэг, оношилгоо, эмчилгээ хийж байсныг МХЕГ-аас шалгаж Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй, зөвшөөрөлгүй эм, эмнэлгийн хэрэгслийг битүүмжлэн, зөрчлийн хэрэг үүсгэн шалгаж байна (home.inspection.gov.mn, 2022).

Цагдаа, гааль, хилийн байгууллагуудын хамтын хяналт шалгалтыг сайжруулахаас гадна дотоодын хяналт шалгалтыг нэмэгдүүлснээр энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломжтой байна.

### Дүгнэлт

Улсын хэмжээнд орон нутаг, үндэсний, олон улсын эрүүл мэндийн байгууллага, эмнэлэг, гааль, цагдаа, хууль сахиулах байгууллагууд, эм үйлдвэрлэгчид, иргэд хамтын ажиллагаа, уялдаа холбоог нэмэгдүүлж тэмцэж байж үр дүнд хүрнэ (Зөвлөл, 2023). Мөн иргэд өөрсдийн хэрэглэж буй эм, эмийн бүтээгдэхүүнд хяналт тавьж, сав баглаа боодол, үйлдвэрлэсэн, хүчинтэй хугацаа, хадгалах горим, үг үсгийн алдааг нягтлах, гудамж, зах, цахим вэб сайтууд, хувь хүний гар





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠶ᠋ᠢᠨ ᠭᠡᠮᠡᠳᠡᠯ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

дээрээс гарал үүсэл нь тодорхойгүй эм, эмийн бүтээгдэхүүн худалдан авахгүй байх, тухайн эмийн үнэ зах зээлийн ханшаас хэтэрхий үнэтэй эсвэл хямд эсэхийг харгалзан үзэх шаардлагатай.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон улс орнуудын хамтын ажиллагааг сайжруулж, хууль бус эмийн эргэлтэд тавих хяналтыг эрчимжүүлэх, Монгол Улсын хувьд эмийн стандартыг шинэчлэн тогтоох, зөрчлийн болон эрүүгийн хуульд стандартын бус хууль эмийн тодорхойлолтын нарийвчлан тодорхойлох, эм эмнэлгийн хэрэгсэл худалдан борлуулах, түгээх үйл ажиллагаанд гааль, эрүүл мэнд, хууль хяналтын байгууллагуудын хамтын хяналтын үйл ажиллагааг тогтмолжуулах нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд ахиж гарна.

Гаалийн байгууллага болон төрийн бусад байгууллага хоорондын хамтын ажиллагааг анхаарч төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан урьдчилсан сэргийлэх чиглэлийн сургалтыг тогтмол явуулж хэвших, цахим мэдээлэл солицоход цахим гарын үсэг, үл давтагдах дугаар ашиглах явцыг түргэтгэх, эрх бүхий тодорхой нэр заасан албан тушаалтанд нууцын зэрэглэлтэй мэдээ, мэдээлэлд холбогдох эрхийг нь нээж өгөх эрх зүйн орчинг бий болгох, “Хур” системд нэгдэх тусдаа мэдээллийн портал бий болгох асуудлыг судлах хэрэгцээ, шаардлага бий болж байна.

### Санал

Монгол Улсад хуурамч эмийн эргэлтийг бууруулахын тулд эмийн хяналтын цахим систем нэвтрүүлэх, импортын үеийн лабораторийн шинжилгээг чангатгах, онлайн худалдаанд тодорхой зохицуулалт тогтоох, иргэд болон эмч,

фармацевтуудын мэдлэгийг нэмэгдүүлэх, бүс нутгийн түвшний хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Манай улсын хувьд хуурамч, стандартын бус, бүртгэлгүй эмийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлж судлах, олон улсын байгууллагууд, дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас жил бүр гаргадаг тархалтын статистикт тайлан мэдээ гаргаж өгөх, бусад улс оронтой энэ чиглэлээр хамтран ажиллаж, туршлага судлах шаардлагатай.

Хилийн боомтуудад орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгслийг албанд нэвтрүүлж, тээврийн хэрэгслийг шалгах рентген тоног төхөөрөмжийг суурилуулж, албанд ашиглах.

Эм, эмийн хяналт зохицуулалтын газар, Цагдаагийн байгууллага хамтран улирал, жил тутамд Монгол Улсын хэмжээнд эм худалдаалж байгаа газруудаас түүврээр эм худалдан эмийн стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд тогтмол хяналт шалгалтыг хийх зэрэг саналтай байна.

### Ашигласан материал

1. Ньютон болон Тиммэрман 2016 он
2. WHO Global Surveillance and Monitoring system for substandard and Falsified Medical Products, 2017
3. ДЭМБ, Стандартын бус болон хуурамч эмийн тайлан. 2024 он
4. ДЭМБ, Нийгмийн эрүүл мэнд, нийгэм эдийн засагт хуурамч эмийн үзүүлж буй үр нөлөөний талаарх судалгаа 2023 он
5. Келесидис Т, Рафайлидис ПАЙ болон Фалагас МЕ, Хуурамч, стандартын бус нянгийн эсрэг эм бэлдмэл: шинжлэх ухааны нотлох баримт 2017 он

6. Бассат Кю, таннер М, Гуэрин ПЖ, Хумхаа өвчний эсрэг чанаргүй эмийн эсрэг тэмцэх нь 2022 он
7. Бертуг блог, Маркус Полманий нийтлэл 2023 он
8. Европын Зөвлөл, Эмийн чанарын удирдлагын газар 2023 он
9. <https://www.europol.europa.eu/socta/2017/>
10. <https://news.un.org/en/story/2015/07/505352-un-projects-world-population-reach-85-billion-2030-driven-growth-developing>
11. <https://www.montsame.mn/mn/read/75855>
12. <https://www.who.int/news-room/factsheets/detail/substandard-and-falsified-medical-products>



# ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫН СЭТГЭЛИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ОЮУН УХААНЫГ СУДАЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

## RESEARCH RESULTS ON THE EMOTIONAL INTELLIGENCE OF BORDER GUARD OFFICERS



Хилийн Цэргийн Алба Хаагчдын Сэтгэлийн Хөдөлгөөний Оюун Ухааныг Судалсан Судалгааны Үр Дүн

### Б.Нямжав

Доктор (Ph.D), хурандаа, Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын төвийн эрхлэгч

### B. Nyamjav

Ph.D. Colonel, Head of the Border Security Research Center, Research Institute

хариуцлагатай зохиогч: nyamjav0819@gmail.com

**Хураангуй:** Цэргийн алба нь хувь хүнээс бие, сэтгэлийн чадавх шаарддаг, амь нас, эрүүл мэндэд өндөр эрсдэлтэй, хатуу чанд дэглэм, журам, сахилга хариуцлагын тогтолцоонд ажилладаг, хувь хүний эрхийг цэргийн дүрмийн хүрээнд тодорхой хэмжээгээр хязгаарладаг онцлогоороо бусад мэргэжлээс ялгаатай байдаг нь хувь хүнд сэтгэл зүйн хувьд олон янзын өөрчлөлтийг үүсгэдэг. Зарим цэргийн алба хаагчид сэтгэлийн хөдөлгөөнөө удирдаж чадахгүй байдлаасаа болоод албанаас халшрах, зэвсэг галт хэрэгслийг зүй бусаар ашиглах, өөрийн болон бусдын амийг егүүтгэх, өргөсөн тангаргаасаа няцах гэх мэт гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд буурахгүй байна. Цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан түүний бүрэлдэхүүн хэсгийг судалснаар сэтгэл зүйн эдгээр хүчин зүйлс цэргийн алба хаагчдын үүрэг гүйцэтгэх ажиллагаа, сэтгэл зүйн эрүүл мэнд, багаар ажиллах чадвар, удирдан зохион байгуулах, манлайлах чадварт эерэг нөлөөтэй төдийгүй цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдалд анхаарч дэмжлэг үзүүлэх, стрессийн зохицуулалтыг хангах, алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийн асуудлыг сайжруулахад хөрш зэргэлдээх болон гадны бусад орнуудын энэ чиглэлийн судалгаануудын ололттой тал, хөгжлийн чиг хандлага, туршлагыг харгалзан үзэж салбарын бодлого, удирдлагын түвшинд анхаарч ажиллах асуудалд ач холбогдолтой юм.

**Abstract:** Military service is distinguished from other professions by its demand for high physical and psychological resilience, inherent risks to life and health, and adherence to rigorous regimes, procedures, and disciplinary systems. Furthermore, the necessity of operating within military regulations involves certain limitations on individual rights, which can induce a wide range of psychological shifts in personnel. Due to an inability to effectively manage emotions, some service members continue to exhibit problematic behaviors and criminal tendencies. These include occupational burnout, the misuse of firearms and ammunition, self-harm or homicide, and the violation of their military oath. Exploring the components of emotional intelligence (EI) among military personnel reveals that these psychological factors significantly enhance operational performance, mental health, teamwork, organizational management, and leadership capabilities. Furthermore, prioritizing the psychological stability of service members and ensuring effective stress management is essential. By integrating the findings, developmental trends, and best practices from international research—particularly from neighboring and other foreign nations—it becomes possible to provide more robust psychological support. Consequently, incorporating these insights into

sectoral policy and leadership strategies is of paramount importance for improving the overall psychological readiness and resilience of the armed forces.

**Түлхүүр үгс:** Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, цэргийн алба хаагчид.

**Keywords:** Emotional intelligence, military personnel.

### Удиртгал

Цэргийн сэтгэл зүйн шинжлэх ухаан үүссэн цагаасаа эхлэн цэргийн алба хаагчийн, цэргийн хамт олны сэтгэл зүйг судалж, цэрэг бие хүний сэтгэл зүйд цэргийн алба, түүний өвөрмөц нөхцөл хэрхэн нөлөөлдөг болохыг цэргийн алба, үүрэг, ахуйтай нь уялдуулан судалж ирсэн байдаг.

Цэргийн сэтгэл зүйн шинжлэх ухааны судалгааны анхаарал татсан асуудлын тоонд цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөн, зан төлөв, сэтгэл зүйн хямрал, түүний үүсэх шалтгаан, сэтгэл зүйн хямралаас урьдчилан сэргийлэх арга замыг оновчтой, зөв тодорхойлох явдал зүй ёсоор багтдаг бөгөөд бие бүрэлдэхүүний сэтгэлийн хөдөлгөөнийг мэдрэх, зөв удирдах асуудал нь сэтгэл зүйн бэлтгэлийн үндсэн зорилт юм.

Зарим цэргийн алба хаагчид сэтгэлийн хөдөлгөөнөө удирдаж чадахгүй байдлаасаа болоод албанаас халшрах, зэвсэг галт хэрэгслийг зүй бусаар ашиглах, өөрийн болон бусдын амийг егүүтгэх, өргөсөн тангаргаасаа няцах гэх мэт гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд буурахгүй байна. 2010-2020 онд хил хамгаалах байгууллагад үйлдэгдсэн онц ноцтой гэмт хэргийн талаар Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хил хамгаалах ерөнхий газар хамтарч шалтгаан нөхцөлийг нь тогтоохоор судалгаа хийсэн.

Дээрхи судалгааны үр дүнд хилийн цэргийн анги, салбарт нийт бүртгэгдсэн хэргийн 129 буюу 54.4 хувь нь хөнгөн, 21 буюу 8.9 хувь нь хүнд, 80 буюу 33.8 хувь нь хүндэвтэр,

7 буюу 2.9 хувь нь онц хүнд гэмт хэргүүд тус тус байна (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2020).

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хийгдсэн тус судалгаанаас үзвэл гэмт хэрэгт холбогдсон субъектыг авч үзвэл нийт бүрэлдэхүүний 85 нь ахлагч, 82 нь хугацаат цэргийн алба хаагч (цаашид ХЦАХ гэнэ), 63 нь дунд офицер, 14 нь гэрээт цэргийн алба хаагч (цаашид ГЦАХ гэнэ), 12 нь ахлах офицер эзэлж байна (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2020).

Зэвсэг, галт хэрэгсэлтэй холбоотой гэмт хэрэг үйлдэгсдийн 66.7 хувь нь санаатайгаар, 33.3 хувь нь санамсаргүйгээр үйлдэгдсэн бол санаатайгаар үйлдэгдсэн гэмт хэргийн ихэнх хувийг ХЦАХ, ахлагч нар эзэлж байна.

Хил хамгаалах ерөнхий газар, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн тус судалгааны дүгнэлтэд үйлдэгдсэн гэмт хэргүүдийн 49 хувь нь цэргийн алба хаагчдын сэтгэл хөдлөл болон зан төлөвөөс холбоотой үйлдэгдсэн хэмээн үзсэн тул хил хамгаалах албаны онцлог хилчдийн сэтгэл зүйд үзүүлэх нөлөөллийг судлах, хилчдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг тал бүрээс нь судлан оношлох судалгааны аргуудыг албанд нэвтрүүлэх, алба хаагчдын гэмт хэрэг үйлдэхэд сэтгэл зүйн хүчин зүйлүүд ямар нөлөө үзүүлдэг талаар нарийвчлан судалгаа хийх зайлшгүй хэрэгцээ цэргийн сэтгэл зүйчдийн өмнө тулгарч байгааг тодхон харж болох юм (Хууль зүйн үндэсний хүрээлэн, 2020).

Иймд цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг





ᠬᠤᠮᠤᠯᠠᠭᠠᠨᠢ ᠰᠤᠳᠠᠯᠠᠭᠠᠨᠢ

хүн ам зүйн хүчин зүйлстэй харьцуулан судалж, улмаар тэдний өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах төдийгүй бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, сэтгэл санааг анхаарах, сэтгэлийн хөдөлгөөнийхөө тусламжтайгаар бусдыг удирдах чадварын талаар зөвлөмж боловсруулж, албанд хэрэглэх хэрэгцээ, шаардлага байна хэмээн үзэж байна.

**Судалгааны түүвэр:** Судалгаанд нийт Хилийн цэргийн 19 анги, тусгай салбарын 2490 алба хаагчийг хамруулж, түүвэрлэлтийн найдвартай байдлыг хангах үүднээс 5 бүсийн байнгын бүрэлдэхүүн болох офицер, ахлагчаас гадна гэрээт цэргийн алба хаагч, хугацаат цэргийн алба хаагчдаас түүврийн хувилбарыг сонгож авсан.

**Судалгааны товч үр дүн:** Бидний хийсэн судалгаагаар цэргийн алба хаагчдын 0.4% нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан (цаашид СХОУ гэнэ)-ы сул түвшинд, 71.6% нь дунд зэрэг, 28% нь сайн түвшинд байна. СХОУ-ны 3 түвшинд алба хаагчдын эзлэх хувийн илэрсэн байдлыг тодруулан авч үзэхэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны сайн түвшинд ГЦАХ-чид, дунд зэрэг түвшинд ахлагчийн бүрэлдэхүүн, сул түвшинд ХЦАХ-чид тус тус эзэлсэн байна. Дискриптив статистик шинжилгээгээр СХОУ-ны өөрийгөө мэдрэх үзүүлэлтийн дундаж утга хамгийн их буюу 36,43 түүний дараагаар өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх, нийгмийн ур чадвар, бусдыг ойлгох үзүүлэлтүүд эрэмбэлэгдсэн байна. Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлтийн онооны дундаж утга хамгийн бага буюу 33.76 байгаа нь цэргийн алба хаагчдын сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт дунд зэрэг байгааг илтгэж байгаа тул алба хаагчдад тухайн

чадварыг сэтгэл зүйн бэлтгэлээр дамжуулан олгох.

### Үндсэн хэсэг

Орчин цагт амьдарч буй бие хүнд хамгийн чухлаар тавигдаж буй шаардлага бол бие хүний өөрийн сэтгэл хөдлөлөө хянан зохицуулах, удирдах, хандлагаа хөгжүүлэх асуудал юм. Хүнд аливаа нэгэн зүйлийг сонгох, шийдвэр гэрэгх, өөрийгөө дайчлах, бусадтай харилцах, ойлголцох, бусдад нөлөөлөх гээд амьдралын бүхий л үйл ажиллагаанд сэтгэлийн хөдөлгөөн чухал үүрэгтэй. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан сэдэв нь 1990 оноос хойш эрчимтэй судлагдаж, олны анхаарлыг ихээр татаж, өнөөдрийг хүртэл эрчимтэй судлагдаж байна. Сэтгэлийн хөдөлгөөний ангиллын талаарх асуудал бүрэн шийдэгдээгүй бөгөөд шинжлэх ухааны маргааныг дагуулсаар байна. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзэл баримтлал, тодорхойлолтууд цэгцрээгүй байгаа боловч өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгож, таньж мэдэх, удирдан зохицуулах зэрэг нь өндөр үр дүнтэй гэдэгтэй эрдэмтэд санал нэгтэй байдаг.

Гол төлөөлөгч болох Даниел Гольман 1995 онд “Сэтгэл хөдлөлийн чадамж” гэх бүтээлээ гаргасан ба сэтгэл хөдлөлийн оюун ухааны загварыг боловсруулснаар өнөөгийн сэтгэл хөдлөлийн оюун ухаан, хүний зан үйл, зохион байгуулах чадвар, хандлага, хувь хүний зан чанарууд оюуны ухааны чадавх зэргийг тодорхойлох, илрүүлэх аргын үндэс болсон. Тэрээр сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан гэдэг нь сэтгэл хөдлөлийг мэдэрч ойлгон хувь хүний бүтээмж, чадавхийг хөгжүүлэхэд ашиглах явдлыг хэлнэ. Хувь хүний амьдралд амжилт гаргах эсэх нь оюуны чадвар буюу IQ-гээс илүүтэйгээр сэтгэлийн хөдөлгөөний

оюун ухаан буюу EQ хамгийн их нөлөөлдөг гэж үзсэн. (Гоулман, Д., 1995)

Д.Майер, П.Салови нарын “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны чадвар”-ын онолоор өөрийнхөө болон бусад хүмүүсийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг хянах, бусдын дунд өөрийн бодол, үйл хөдлөлийг удирдан чиглүүлэх чадвар хэмээн тэд тайлбарладаг. (Mayer JD, 2010)

Эрдэмтэн Андреев, В.А. “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь дан ганц гадаад ертөнцийн мөн чанар, зүй тогтлыг оновчтой тусгах гэхээс илүү хувь хүний дотоод ертөнц, хувийн онцлог, зан үйл, бодит байдлыг мэдрэн тусгах чадварыг илэрхийлж байдгаараа оюун ухааны чадвараас ялгаатай юм. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны чадвар өндөртэй хүн сэтгэлийн хөдөлгөөнийг сайтар зохицуулах, дасан зохицох, үр дүнтэй харилцах чадвартай байдаг хэмээн үзсэн. (Андреева, 2004)

Мөн эрдэмтэн Гоулз Крисс сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан гэдэг нь сэтгэлийн хөдөлгөөнөө ухаалгаар удирдаж өөрийгөө болон нийгмийн амжилтыг бий болгоно хэмээн тодорхойлсон бол (Chriss, 2011) судлаач Стив Хэйн “Урт хугацааны явцад хүний эрүүл мэнд, аз жаргалтай байдал, эсэн мэнд амьдрах чадварыг дээшлүүлэхэд мэдрэмж, сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар нь гол нөлөө үзүүлдэг. Энэ нь хэвийн бус мэдрэмжүүдээс ангид байх, сөрөг мэдрэмжүүдийг хэрхэн эерэг мэдрэмж болгон хувиргахыг мэддэг байх чадвар юм” гэж үзсэн. (Hein, 2005)

Хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаар дээрх эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн санаа, нээлт, бүтээлүүд дээр нэмж Д.В.Люсин хувь хүний өөрийгөө болон бусдын сэтгэлийн хөдөлгөөн мэдрэмжийг ойлгох болон хянах чадвар нь хувь

хүний зан үйлийн ерөнхий чиг хандлагатай нягт уялдаатай байдгийг анхааруулсан нь бий. (Люсинь, 2000)

Эрдэмтэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны талаар шинэ онол, хандлагуудыг гаргасаар байгаа бөгөөд энэ нь багагүй маргааныг ч дагуулсаар байна. Өөрөөр хэлбэл, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан, оюун ухаан гэсэн ойлголт, үзүүлэлтийг нарийвчлан тодорхойлж, тэрхүү үйл явцад анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг онцолж, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь сэтгэл хөдлөлийг зохицуулах, стрессийг бууруулах, зан төлөвийг өөрчлөхөд хэрэглэгддэг бөгөөд энэ чиглэлд олон шинэчлэлүүдийг хийж, сэтгэцийн эрүүл мэндийг сайжруулахад үр дүнтэй байгааг чухалчилж байна. Мөн эдгээр шинэ онолууд нь урьд өмнөх онолуудтай харьцуулахад илүү нарийвчилсан нейробиологийн түвшинд судалгаа хийх чиг хандлагатай байна.

Тухайлбал, судлаач Лиза Барретт “Сэтгэл хөдлөлийн нийцтэй байдал ба нейробиологийн хамаарлын онол”-доо сэтгэл хөдлөл нь тархинд биологийн хэлбэрээр үүсдэг гэж үздэг бөгөөд сэтгэлийн хөдөлгөөн нь зөвхөн хариу үйлдлүүдээс бүрдэх биш, харин тархины урьдчилан таамаглах үйл явцын үр дүн хэмээн тайлбарласан байна. (Lisa Feldman Barrett, 2017) Мөн эрдэмтэн, судлаач Р.Давидсон “Сэтгэлийн хөдөлгөөний динамик загварын онол”-д сэтгэлийн хөдөлгөөн нь тархины үйл ажиллагааны динамик үйл явцын үр дүн гэж үзсэн байна. Тэрээр сэтгэлийн хөдөлгөөн нь хувь хүн бүрийн тархины танин мэдэхүйн, биологийн процессуудын хариу урвалыг илэрхийлдэг ба сэтгэл хөдлөлийг тархины тодорхой хэсэгт хамааралтай ч, бодит орчинд динамик байдлаар өөрчлөгддөг болохыг





ХУУЛЬ САХИУЛАХУЙ  
 ХИЛ СУДЛАЛ

тайлбарласан байна. (Davidson, 2012) Жеймс Гросс нь сэтгэлийн хөдөлгөөнийг зан үйлийн түвшинд хэрхэн зохицуулах талаархи судалгааг хийсэн. Түүний "Сэтгэлийн хөдөлгөөний зохицуулалт" (Emotion Regulation) хэмээх онолд сэтгэлийн хөдөлгөөнийг үүсгэх, зохицуулах болон тэдгээрийг илрүүлэх үйл явцыг тодорхойлдог ба сэтгэлийн хөдөлгөөнийг зөв зохицуулах нь хүний сайн сайхан байдлыг сайжруулдаг хэмээн үзжээ (Gross, 2015)

Энэ бүгдээс дүгнэхэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь хүний танин мэдэхүй, оюун ухаантай тодорхой үйл ажиллагаануудтай хамт илрэх боломжтой талаас нь тайлбарлаж, сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг түүний үзүүлэлтүүдтэй хамтад нь авч үзэж тайлбарласан болох нь харагдаж байна. Ийнхүү сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нь бие даасан сэтгэл зүйн томоохон бүрэлдэхүүн хэсэг болохоос гадна хүний амьдралдаа гаргах амжилт, аливаа асуудал, бэрхшээлийг даван туулах чадвар, амжилттай, аз жаргалтай амьдрах зэрэг хүний олон чухал чадваруудыг өөртөө багтааж байна.

Энэ удаад хилийн цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун

ухааныг судалсан. Цэргийн алба хаагчдын хувьд албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор хүлээж байгаагүй гэнэтийн хүндрэл, саад бэрхшээл, үүсч байгаа асуудлыг шийдвэрлэх, нөхцөл байдалтайгаа дасан зохицож, даван туулах хатуужлыг албаны хувьд шаарддаг.

Тиймээс цэргийн алба хаагчид өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө хянаж, анхаарлаа төвлөрүүлэхээс гадна нөхцөл байдлыг бодитоор мэдрэх, үнэлэх, өөрийгөө чиглүүлэх, санаачилгыг гартаа авч, саад бэрхшээлийг даван туулахаас гадна бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг мэдрэх, ойлгох, хуваалцах, хариу үйлдэл үзүүлэх, бусдын сэтгэл хөдлөлийг удирдах, нөлөөлөх нь албаны хувьд нэн чухал юм.

Хилийн цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлах зорилгоор Даниел Гольманы (ECI) "Emotional Competence Inventory" сорилоор сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг тодорхойлох 5 хэмжүүртэй, 50 асуулгатай тестээр судалгаа авсан.

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан	Кронба альфа	Асуултын дугаар
	0.934	50

Хүснэгт 1. СХОУ-ны судалгааны найдвартай байдлын шинжилгээ

Судалгааны үр дүнг байдлыг шинжилж үзэхэд кронбах боловсруулахаас өмнө судалгааны альфа коэффициент 0.934 буюу өгөгдлийн хүчин төгөлдөр, найдвартай хангалттай найдвартай байна.


Хувьсагч	Давтамж	Хувь
Нас	18-25	61.0
	26-35	22.7
	36-45	15.2
	46-с дээш	1.1
Хүйс	Эрэгтэй	84.4
	Эмэгтэй	15.6
Боловсрол	Дээд	27.9

	Тусгай дунд	664	26.8
	<b>Бүрэн дунд</b>	<b>1080</b>	<b>43.6</b>
Бүрэлдэхүүн	Офицер	486	19.6
	Ахлагч	607	24.5
	Гэрээт	240	9.7
	<b>ХЦАХ</b>	<b>1145</b>	<b>46.2</b>
Албан тушаал	Удирдах	206	8.3
	<b>Гүйцэтгэх</b>	<b>2272</b>	<b>91.7</b>
Ажилласан жил	<b>1-10</b>	<b>1588</b>	<b>64.1</b>
	11-20	786	31.7
	21-с дээш	55	2.2
Бүс	Төв	331	13.4
	<b>Уул</b>	<b>663</b>	<b>26.8</b>
	Ой тайга	390	15.7
	Тал хээр	462	18.6
	Говь цөл	632	25.5
	Total	2478	100.0

Хүснэгт 2. Судалгаанд оролцсон алба хаагчдын хүн ам зүйн мэдээлэл

Судалгаанд оролцсон алба хаагчдын хүн ам зүйн мэдээллийг давтамжийн шинжилгээнээс тодруулахад: 18-25 насны алба хаагчид нийт бүрэлдэхүүний 61%-ийг, эрэгтэй алба хаагчид бүрэлдэхүүний 84.4%-ийг, бүрэн дунд боловсролтой алба хаагчид нийт бүрэлдэхүүний 43.6%-

ийг, ХЦАХ нийт бүрэлдэхүүний 46.2%-ийг, гүйцэтгэх албан тушаалтнууд 91.7%-ийг, 1-10 жил ажилласан алба хаагчид 64.1%-ийг, уулын бүсэд ажилладаг алба хаагчид нийт бүрэлдэхүүний 26.8%-ийг тус тус эзэлж байна.



Зураг 1. Судалгаанд оролцсон алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны түвшин

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны гурван түвшингийн үзүүлэлт хэрхэн илэрч буйг харахад цэргийн алба хаагчдын 0.4% нь сул түвшинд, 71.6% нь дунд зэрэг түвшинд, 28% нь сайн түвшинд байгааг илтгэж байна. Энэ нь судалгаанд оролцсон цэргийн


алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан дунд зэрэг түвшинд байгааг графикаас харж болно. Харин сул болон сайн түвшинд судалгаанд оролцогчдын 0.4-28% эзэлж байгаа үзүүлэлттэй байна.





ᠬᠤᠠᠭᠠᠳᠤᠨ ᠰᠢᠴᠢᠨ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны түвшинд ЦАХ-ын эзлэх



Зураг 2. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны түвшинд алба хаагчдын эзлэх хувь

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны гурван түвшинд байгаа алба хаагчдыг тодруулан авч үзэхэд СХОУ-ны сайн түвшинд нийт бүрэлдэхүүний 75.8% буюу ГЦАХ-чид, дунд түвшинд нийт бүрэлдэхүүний 30.3% буюу ХЦАХ-чид, сул түвшинд нийт бүрэлдэхүүний 0.6% буюу ХЦАХ-чид тус тус эзэлж байна.

		Сул	Дунд	Сайн
Өөрийгөө мэдрэх үзүүлэлт	Давтамж	17	849	1612
	Хувь	0.7%	34.3%	65.1%
Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт	Давтамж	22	1350	1106
	Хувь	0.9%	54.5%	44.6%
Өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлт	Давтамж	18	908	1552
	Хувь	0.7%	36.6%	62.6%
Бусдыг ойлгох байдал	Давтамж	22	1125	1330
	Хувь	0.9%	45.4%	53.7%
Нийгмийн ур чадвар	Давтамж	18	962	1497
	Хувь	0.7%	38.8%	60.4%

Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны давтамжийн шинжилгээ

Давтамжийн шинжилгээнээс дүгнэхэд:

- Судалгаанд хамрагдсан нийт бие бүрэлдэхүүний 65.1% нь өөрийгөө мэдрэх үзүүлэлт сайн түвшинд байгаа нь цэргийн алба хаагчдын хувьд албаны үйл ажиллагаанд өөрийнхөө чадвар, нөөц бололцоог бүрэн дайчилж, үүрэг гүйцэтгэлтэд сэтгэлийн хөдөлгөөн нь хэрхэн нөлөөлөх талаар ойлгож, сэтгэлийн хөдөлгөөний хариу үйлдлээ таних чадвар сайн байгааг харуулж байна.

- Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлтийн хувьд нийт бие бүрэлдэхүүний 54.5% нь дунд зэрэг түвшинд, 0,9% нь сул түвшинд байгаа

нь цэргийн албаны өвөрмөц нөхцөлүүдтэй холбоотойгоор алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөн хүчтэй илэрсэнээс өөрийгөө хянаж, анхаарлаа төвлөрүүлж, бодитоор бодох чадвар дунд зэрэг түвшинд байгаа бөгөөд тухайн бүлгийн хүрээнд алба хаагчдын өөрийгөө эзэмдэх чадвар болон сахилга батыг бэхжүүлэх талын сэтгэл зүйн ажлыг түлхүү явуулах шаардлагатай хэмээн үзэж байна.

- Өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлтийн хувьд нийт бие бүрэлдэхүүний 62.6% нь сайн түвшинд, 36.6% нь дунд зэрэг түвшинд байна. Энэхүү үзүүлэлт дунд зэрэг байгаа алба хаагчдад аливаа саад

бэрхшээлийг даван туулах чадвар олгох, өөрийгөө бодитоор мэдрэх, үнэлэх, өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхижүүлэх зэрэг сэтгэл зүйн бэлтгэл олгох ажлыг зохион байгуулах хэрэгцээ шаардлага их байна гэж үзсэн.

• Бусдыг ойлгох байдлын хувьд нийт бие бүрэлдэхүүний 53.7% нь сайн түвшинд, 45.4% нь дунд зэрэг, 0.9% нь сул түвшинд байна. Тус чадвар алба хаагчдын хувьд маш чухал чадварын нэг бөгөөд удаан хугацаанд нийгмийн харилцаанаас тусгаарлагдсан орчинд буюу хилийн харуул, манаанд үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор томилогдон ажиллаж байгаа бүрэлдэхүүний хувьд энэ талын чадварыг сургалт, соён гэгээрүүлэх

ажлаар дамжуулан сайжруулах боломжтой юм.

• Нийгмийн ур чадварын хүрээнд нийт бие бүрэлдэхүүний 60.4% нь сайн түвшинд, 38.8% нь дунд зэрэг түвшинд гарсан байна. Алба хаагчдын дунд бусдад эергээр нөлөөлөх, багаар үүрэг гүйцэтгэх үед бусдыг удирдан чиглүүлэх, манлайлах ур чадварыг албаны хувьд харгалзан үзэж илүүтэй хөгжүүлэх талаар цэргийн сэтгэл зүйчид анхаарч ажиллах нь зүйтэй.

Судалгаанд оролцсон алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны үзүүлэлт бүрийг хүн ам зүйн хүчин зүйлс болох нас, хүйс, боловсрол, ажилласан жил, албан тушаал, бүс нутагтай харьцуулан судалж, дүгнэлт гаргахыг зорилоо.

Корреляци шинжилгээ						
	Нас	Боловсрол	Бүрэлдэхүүн	Албан тушаал	Ажилласан жил	Бүс
Өөрийгөө мэдрэх үзүүлэлт	.064**	.075**	-.048*	-.010	.013	-.027
	.002	.000	.017	.615	.518	.182
Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт	.003	-.023	.003	-.014	.022	-.024
	.864	.245	.901	.489	.276	.228
Өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлт	.109**	-.097**	-.098**	-.045*	.089**	-.049*
	.000	.000	.000	.024	.000	.015
Бусдыг ойлгох байдал	.033	-.032	-.017	-.007	.024	.005
	.098	.114	.404	.732	.236	.802
Нийгмийн ур чадвар	.584	-.007	-.036	-.014	.050*	-.038
	.640	.742	.075	.477	.012	.061
**. Correlation is significant at the 0.01 level (2-tailed).						
*. Correlation is significant at the 0.05 level (2-tailed).						

Хүснэгт 4. Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон хүн ам зүйн хүчин зүйлийн хамаарлын шинжилгээ

Корреляци шинжилгээнээс үзэхэд:

1. Өөрийгөө мэдрэх үзүүлэлтийн хувьд:

• Насны бүтэцтэй ( $R=0.064^{**}$  буюу  $R$  утга нь 0.002) эерэг сул хамааралтай байна. Энэ нь нас ахих тусам өөрийгөө мэдрэх үзүүлэлт өсөх хандлагатай ч, автоматаар дагаж хөгждөггүй, харин өөрийн сэтгэл хөдлөлийн сул болон давуу талаа ойлгож суралцах, хөгжих

хандлагаас хамаарч сайжирдаг болохыг харуулж байна.

• Боловсролтой ( $R=0.075^{**}$  буюу  $R$  утга нь 0.000) эерэг сул хамааралтай байна. Боловсролын түвшин өндөр байх нь өөрийгөө мэдрэх чадварт эерэг нөлөөтэй хэдий ч өөрийгөө мэдрэх үзүүлэлт боловсролоос үл хамааран сэтгэл хөдлөлөө ойлгох чадвар сул хөгжсөн байх боломжтой. Хамаарал





сул гарсан нь зөвхөн нас, боловсролоос шууд хамааралтай гэж үзэх нь учир дутагдалтай.

2. Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлтийн хувьд хүн ам зүйн хүчин зүйлүүдтэй харьцуулахад хамааралгүй байгаа бөгөөд алба хаагчдын хувьд сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт нь харилцан адилгүй байна гэсэн үг.

3. Өөрийгөө идэвхжүүлэх, сэдэлжүүлэх үзүүлэлтийн хувьд:

- Насны бүтэцтэй харьцуулахад ( $R=0.109^{**}$  буюу  $P$  утга нь 0.000) эерэг сул хамааралтай байна. Энэ нь нас ахих тусам алба хаагчдын өөрийгөө идэвхжүүлэх сэдэлжүүлэх үзүүлэлт нэмэгдэх хандлагатай боловч хамаарал төдийлөн хүчтэй биш байна.

- Боловсролтой ( $R=-0.097^{**}$  буюу  $P$  утга нь 0.000) сөрөг сул хамааралтай байгаа нь боловсролын түвшин өндөр байх хэдий ч удирдах албан тушаалтнуудын хувьд ажил, карьерын байдал өөрчлөгдөх үед өөрийгөө идэвхжүүлэх, сэдэлжүүлэх чадвар буурах хандлагатай байх магадлалтай юм.

- Бүрэлдэхүүнтэй ( $R=-0.098^{**}$  буюу  $P$  утга нь 0.000) сөрөг сул хамааралтай байгаа нь офицер, ахлагч, гэрээт болон хугацаат цэргийн алба

хаагч байхаас үл хамааран өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхижүүлэх үзүүлэлт харилцан адилгүй байна.

- Ажилласан жилтэй ( $R=0.089^{**}$  буюу  $P$  утга нь 0.000) эерэг сул хамааралтай байгаа нь ажилласан жил нэмэгдэх тусам өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх чадвар бага зэрэг өсөх хандлагатай боловч ажилласан жилээс гадна олон хүчин зүйл нөлөөлдөг байх боломжтой.

4. Бусдыг ойлгох байдлын хувьд хүн ам зүйн хүчин зүйлтэй хамааралтай хувьсагч байхгүй байна.

5. Нийгмийн ур чадварын хувьд: нас, ажилласан жилтэй ( $R=0.050^{*}$   $P$  утга нь 0.012) эерэг сул хамааралтай байгаа нь алба хаагчдын нас болон ажилласан жил нэмэгдэх тусам нийгмийн ур чадвар дагаж сайжрах хандлагатай байгаа нь ажлын орчин нөхцөл, хамт олны уур амьсгал, хувь хүний харилцаа зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байж болно.

Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан болон хүн ам зүйн хүчин зүйлсийн харьцуулсан корреляцийн шинжилгээгээр хамааралтай гарсан 2 үзүүлэлтийг /ӨМҮ, ӨСИҮ/ олон хүчин зүйлийн Анова шинжилгээ хийж үзлээ.

Анова шинжилгээ					
	Sum of Squares	df	Mean Square	F утга	P утга
Нас	7.366	2	3.683	5.989	0.003
	1521.932	2475	0.615		
Хүйс	2.022	2	1.011	7.712	0.000
	324.538	2475	0.131		
Боловсрол	9.684	2	4.842	6.97	0.001
	1725.070	2475	0.697		
Албан тушаал	0.055	2	0.027	0.359	0.698
	188.820	2475	0.076		
Ажилласан жил	0.139	2	0.070	0.225	0.798
	765.349	2475	0.309		
Бүрэлдэхүүн	8.626	2	4.313	2.956	0.052
	3611.363	2475	1.459		

Хүснэгт 5. Өөрийгөө мэдрэх үзүүлэлт болон хүн ам зүйн харьцуулсан Анова шинжилгээ

Өөрийгөө мэдрэх үзүүлэлт болон хүн ам зүйн үзүүлэлтийг Анова шинжилгээгээр үзэхэд Р утга 0.05-аас бага байгаа учраас нас, хүйс, боловсрол, бүрэлдэхүүн сатистикийн

хувьд хамаарал бүхий ялгаатай байна. Энэ нь өөрийгөө мэдрэх чадварт хүн ам зүйн дээрх хувьсагчууд нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна.

	Sum of Squares	df	Mean Square	F	Sig.
Нас	19.734	2	9.867	16.177	0.000
	1509.564	2475	0.610		
Хүйс	1.316	2	0.658	5.009	0.007
	325.244	2475	0.131		
Боловсрол	16.478	2	8.239	11.867	0.000
	1718.276	2475	0.694		
Албан тушаал	0.478	2	0.239	3.139	0.044
	188.397	2475	0.076		
Ажилласан жил	6.314	2	3.157	10.292	0.000
	759.175	2475	0.307		
Бүрэлдэхүүн	34.966	2	17.483	12.070	0.000
	3585.023	2475	1.448		

Хүснэгт 6. Өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлт болон хүн ам зүйн харьцуулсан Анова шинжилгээ

Өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлт болон хүн ам зүйн үзүүлэлтийг Анова шинжилгээ хийж үзэхэд Р утга 0.05-с бага байгаа учраас нас, хүйс, боловсрол, бүрэлдэхүүн, албан тушаал, ажилласан жил сатистикийн хувьд хамаарал бүхий ялгаатай байна. Судалгааны үр дүнгээс харахад өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхижүүлэх үзүүлэлт нас, хүйс, боловсролын түвшин, ажил, амьдралын туршлага зэргээс хамааран сайжирдаг хэмээн дүгнэж байна.

### Дүгнэлт

Цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг Даниел Гоулманы (ECI) “Emotional Competence Inventory” сорилоор судалж үзэхэд цэргийн алба хаагчдын 0.4% нь сул түвшинд, 71.6% нь дунд зэрэг, 28% нь сайн түвшинд байна. Бидний судалгааны түүврийн хувьд СХОУ-ны 3 түвшинд алба хаагчдын эзлэх хувийн илэрсэн байдлыг тодруулан авч үзэхэд сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны сайн түвшинд гэрээт цэргийн алба

хаагчид, дунд зэрэг түвшинд ахлагчийн бүрэлдэхүүн, сул түвшинд хугацаат цэргийн алба хаагчид тус тус эзэлж байна.

- Дискриптив статистик шинжилгээгээр: СХОУ-ны өөрийгөө мэдрэх үзүүлэлтийн дундаж утга хамгийн их буюу 36,43, Сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлтийн онооны дундаж утга хамгийн бага буюу 33.76 байгаа нь цэргийн алба хаагчдын сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт дунд зэрэг байгааг илтгэж байна.

- Давтамжийн шинжилгээгээр: Судалгаанд оролцогчдын 65,1% нь өөрийгөө мэдрэх үзүүлэлт сайн, 54.5% нь сэтгэл хөдлөлөө удирдах үзүүлэлт дунд зэрэг түвшинд, 45.4% нь бусдыг ойлгох үзүүлэлт дунд зэрэг, 0.9% нь нийгмийн ур чадвар сул түвшинд илэрсэн.

- Корреляцийн шинжилгээгээр: Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны таван үзүүлэлтийг хүн ам зүйн хүчин зүйлтэй харьцуулж үзэхэд өөрийгөө мэдрэх үзүүлэлт насны бүтэцтэй  $R=0.064^{**}$  буюу Р утга нь 0.002 эерэг





сул, боловсролтой  $R=0.075^{**}$  буюу  $P$  утга нь 0.000 эерэг сул хамааралтай байна.

- Анова шинжилгээгээр: Өөрийгөө мэдрэх, өөрийгөө сэдэлжүүлэх, идэвхжүүлэх үзүүлэлтүүд болон хүн ам зүйн үзүүлэлт  $P$  утга 0.05-аас бага байгаа учраас нас, хүйс, боловсрол, бүрэлдэхүүн, албан тушаал, ажилласан жилтэй статистикийн хувьд хамаарал бүхий ялгаатай байгаа нь сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан нас, хүйс, боловсролын түвшин зэргээс хамаарч харилцан адилгүй байдаг байна.

### Санал

Хилийн цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судалсан судалгааны үр дүнд тулгуурлан цэргийн алба хаагчидтай ажилладаг удирдах албан тушаалтнууд болон цэргийн сэтгэл зүйчдэд зориулан дараах санал, зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

#### 1. Цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хөгжүүлэх сургалтын чиглэлээр:

- Цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн өөрийн сэтгэл хөдлөлөө хянах, бусдын сэтгэл хөдлөлийг ойлгох, албаны стрессийг даван туулах, бусадтай харилцах чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулж, сургалт зохион байгуулах;
- Цэргийн албанд шинээр татагдан ирсэн хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчдад “Албанд дадлагажуулах сургалт”-ын хөтөлбөрт дээрх судалгааны үр дүнгээр тодорхойлогдсон сэтгэлийн хөдөлгөөний чадваруудыг хөгжүүлэх, зан төлөвийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн бүлгийн сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл

зүйн трейнинг, оролцоонд суурилсан сургалт явуулах;

- Цаашид цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны түвшинг сайжруулах сургалтуудыг батлагдсан хөтөлбөрийн дагуу хилийн отряд, заставт танхимын болон онлайн хэлбэрээр үе шаттай зохион байгуулж, сургалтын үр дүнг тооцох;
  - Сургалтын хөтөлбөрт алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг хөгжүүлэхэд чиглэсэн интерактив дасгал, техникүүдийг оруулж, оролцогч цэргийн алба хаагчдад өөрийн сэтгэл хөдлөлийг ойлгох, өөрийгөө идэвхжүүлэх, сэдэлжүүлэх аргуудыг түлхүү оруулж, энэ чиглэлийн чадваруудыг эзэмшүүлэх;
  - Цэргийн алба хаагчдын эерэг сэтгэл хөдлөлийг нэмэгдүүлэх, стресс менежментийг сайжруулах, алба хаагчдад өөрсдийгөө хөгжүүлэх боломжийг олгох үүднээс сургалтын платформууд, ном, гарын авлага зэрэг нэмэлт хувилбаруудыг санал болгон улмаар албанд ашиглах.
- #### 2. Сэтгэл зүйн үнэлгээ, хяналтын тогтолцоог сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн арга хэмжээний хүрээнд сэтгэл хөдлөлийн удирдлагын хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын ажиллагаатай мэргэжлийн их дээд сургуулиуд, олон улсын байгууллагуудтай хамтран салбарын хэмжээнд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - Сэтгэл зүйн үнэлгээ, хяналтын тогтолцоог сайжруулах зорилгоор цэргийн албанд шинээр татагдан ирсэн ХЦАХ болон ГЦАХ-аас сургалтын төвийн эхэнд сэтгэлийн

хөдөлгөөний оюун ухааны түвшинг үнэлэх сорил авч, тухайн алба хаагчийн СХОУ-ны түвшинг дээшлүүлэх чиглэлээр алба хаах хугацаанд нь хамруулж, үе шаттай үнэлгээ хийх;

- Гэмт хэргийн сэдэл, үйлдэл гарахад алба хаагчдын сэтгэл хөдлөл болон зан төлөвийн онцлог шинжийн талаас нөлөөлж болохуйц бусад шаардлагатай судалгаануудыг авч, үр дүнг нарийвчлан боловсруулж, сахилгын зөрчил, гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг бууруулахад нөлөөлөх бусад арга хэмжээг авч ажиллах;

### 3. Сэтгэл зүйн үйлчилгээний тогтолцоог сайжруулах чиглэлээр:

- Сэтгэл зүйн зөвлөгөөг алба хаагчдад илүү хүртээмжтэй байх боломжийг сайжруулж, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх нөхцөл боломжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж хилийн застав, харуулд зайнаас онлайн болон цахим зөвлөгөө, бүлгийн зөвлөгөөг өргөнөөр ашиглах;
- Сэтгэл зүйн зөвлөгөөнд алба хаагчдыг удирдлагын шийдвэр, саналаар хамруулахаас илүүтэйгээр сэтгэл зүйн судалгааны үр дүнд суурилж оролцуулах. Удирдлагын зүгээс алба хаагчдыг сэтгэл зүйн зөвлөгөө, засалд хамруулах явцад сэтгэл зүйн хамгааалалтын механизм ажиллах, сэтгэл зүйчид итгэхгүй байх, хувийн эмзэг мэдээлэл задрахаас айх зэрэг шалтгаанаар үр дүнд сөргөөр нөлөөлөх магадлалтайг анхаарч, энэ чиглэлийн нөхцөлийг бүрдүүлж ажиллах;

### 4. Судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр:

- Цэргийн сэтгэл зүйчид тус судалгаанд хэрэглэсэн сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг судлах

судалгааны аргачлал, математик, статистик боловсруулалтыг ЦАХ-дын сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх, сэтгэл зүйн асуудлуудыг судлах олон талт судалгааны хүрээнд ашиглах;

- Цэргийн алба хаагчдын сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааныг тодорхойлох олон улсад түгээмэл хэрэглэгддэг хил хамгаалах байгууллагын алба хаагчдын мэргэжлийн онцлогт тохирсон, баталгаат болон тохироц чанарын шаардлага хангасан тус арга, аргачлалуудаар түүврийн цар хүрээг нэмэгдүүлэн судлах зэрэг зөвлөмжүүдийг санал болгож байна.

### Ашигласан материал

#### Монгол хэл дээр:

Батсайхан, Б., & Дэлгэржав, М. (2013). Ерөнхий сэтгэл судлал. Улаанбаатар хот: Соёмбо принтинг ХХК.

Батсайхан, Б., Дэлгэржав, М. (2013). Сэтгэл судлалын бага тайлбар толь. Улаанбаатар хот: Соёмбо принтинг. Баярмаа, В. (2019). Өсвөр насныхны сэтгэл хөдлөл, зан үйлийн судалгаа. Сэтгэл судлалын докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар хот.

Мягмар, О. (2001), (2002). Сэтгэл судлал. Улаанбаатар хот.

Мягмар, О. (2012). Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд. Улаанбаатар хот: Соёмбо принтинг.

Мягмаржав, Г. (2023). Цэргийн сэтгэл зүй, ёс суртахууны хангалт. БХИС-ийн хэвлэлийн үйлдвэр. Улаанбаатар хот.

Цэрэндондов, П. (2013). Сэтгэл судлалын судалгааны арга зүй. Улаанбаатар хот.

Энхбаяр, Б. (2019). Оюутан бие хүний сэтгэлийн хөдөлгөөний оюун ухааны судалгаа. Сэтгэл судлалын





докторын зэрэг горилсон нэг сэдэв бүтээл. Улаанбаатар хот.

#### Орос хэл дээр:

Андреев, В.А. (1998). Социальная нейropsихология. Москва: Издательство Академия.

Изард, К. (2000). Психология эмоций. Санкт петербург: Питер.

Леонтов, А.Н., . (2003). Современная психология.

Люсинь, Д. (2004). Современные представления об эмоциональном интеллекте. Социальный интеллект: Теория, измерение, исследования Институт психологий.

Англи хэл дээр:

Aguilar, S. &. (2019). A review of the linkages between emotional intelligence and leadership in the military forces, pp. Business Ethics and Leadership, 3(2), 29–38.

Allport, G. W. (1960). Personality: A psychological interpretation. New York: H.Holt and. Company.

Bar-On, R. (2006). The Bar-On model of emotional-social intelligence.

Carrie H, Kennedy. (2009). Military Psychology: Clinical and Operational Applications.

Daniel, G. (1995). Emotional intelligence. New York: Bantan.

Davidson, R. (2012). The Emotional Life of Your Brain .

Garcia Zea, D. S. (2020). The impact of emotional intelligence in the military workplace.

Military Leaders in Their Decision-Making Process (Doctoral dissertation, Northcentral University).

Goleman, Daniel. (1995). Emotional Intelligence: Why It Can Matter More than IQ. New York: Bantam Books.

Gross, J. (2015). Emotion Regulation: Affective, Cognitive, and Social Consequences .

Lisa Feldman Barrett. (2017). How Emotions Are Made: The Secret Life of the Brain .

Mayer, J. D. (2008). Emotional intelligence.

Nelson D.B., L. G. (2000). Emotional intelligence: the role of transformative learning in academic excellence. Texas: Texas study of Secondary education.

Purre, M., & Oja, L. (2018). Mental health in the military context: Emotional states and help-seeking behaviours during conscription. Am. Psychol, 6, 196-222.

Salovey, P., & Mayer, J. D. (1990). Emotional intelligence. Imagination, Cognition and Personality.

Schaefer, H., Cotting, D., Proctor, E., Ryan, D., & Lerner, R. (2021). АНУ-ын Цэргийн Академийн сонсогчдын хүйс, байр суурь, сэтгэл хөдлөлийг хянах чадвар.

Waxler, M. (2020). Emotional intelligence and the modern military advisor. NCO Journal.

# МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ХУУЛЬ БУСААР АЛТ НЭВТРҮҮЛЭХ ГЭМТ ХЭРГИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

## CURRENT SITUATION OF THE CRIME OF ILLEGAL GOLD TRANSPORTATION ACROSS THE BORDER OF MONGOLIA

**Д.Мягмарсүрэн**

Дотоод хэргийн их сургуулийн докторант

**D. Myagmarsuren**

Doctoral student at the University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: gongorgongor24@gmail.com

**Хураангуй:** Монгол Улс болон олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон, хязгаарлалт тогтоосон алтыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэг нь зохион байгуулалттай гэмт хэргийн шинжтэй байдаг бөгөөд нийгмийн хор аюул ихтэй гэмт хэрэгт тооцогддог. Монгол Улсын хилээр алтыг гадгаш гаргах, гадаад улс орноос оруулахад хяналт тавьж татвар оногдуулах нь нэг талаасаа улсын төсөв, орлогыг бүрдүүлхээс гадна, үндэсний аюулгүй байдал, тус тусмаа эдийн засгийн аюулгүй байдалтай нягт холбоотой юм. Хууль бус алтын эргэлтэд хяналт тавьж, илрүүлэх, гэмт үйлдийг таслан зогсоох нь хууль сахиулах байгууллагын үндсэн чиг үүрэг юм. Улсын хилээр алт хэвтрүүлэхэд Монгол Улс олон улсын гэрээ, конвенцоор хүлээн үүргээ биелүүлэх, Цагдаагийн байгууллага, Гааль, Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй, саад бэрхшээл байсаар байна. Иймд хууль, хяналтын байгууллагаас улсын хилээр хууль бусаар алт гаргахтай холбоотой энэ төрлийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, цаашид мөрдөн шалгах ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлагатай байна.

**Abstract:** The crime of illegally importing goods (gold) prohibited or restricted in accordance with Mongolian and international agreements is an organized crime and is considered a crime of great social danger. Controlling the export of gold from Mongolia and the import of gold from foreign countries from the Mongolian border is closely related to the state budget and revenue, as well as national security and economic security. Controlling and detecting illegal gold circulation and stopping crimes are the main functions of law enforcement agencies. There are still difficulties and obstacles for Mongolia to fulfill its obligations under international treaties and conventions in exporting and importing gold across the state border, and for the Police, Customs, and Border Guard to fulfill their obligations under the law. Therefore, there is a need for law enforcement agencies to determine the current situation of this type of crime related to the export of gold across the state border, the issues facing future investigations, and to improve the legal and regulatory environment.

**Түлхүүр үгс:** Алт, хууль бус, хууль, улсын хил, ашигт малтмал.

**Keywords:** Gold, illegal, law, state border, minerals.



МОНГОЛ УЛСЫН  
ДОТООД ХЭРГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН  
УНИВЕРСИТЕТ





## Удиртгал

Хүн төрөлхтний хувьд чулуу нь зэр зэвсэг, ахуйн хэрэглээний эдлэл болохоос эхлээд сэтгэл санаагаа илэрхийлэх, түүх намтраа мөнхлөх, гоёл чимэглэл, зан үйл, шүтлэг бишрэл, эм тан, тоглоом наадгайн салшгүй хэрэглэгдэхүүн байсаар ирсэн билээ. Монгол орны хувьд газрын хэвлий болон гадаргад эрдсийн ангилалд байдаг гол төрөл эрдсүүд бараг бүгд илэрдэг төдийгүй зарим нь дангаараа, зарим нь хам гарлаар хуримтлал үүсгэн металл ашигт малтмал, металл бус ашигт малтмал, өнгөт эрдэнийн чулуу, урлаг чимэглэлийн чулуу, тунамал ба хувирмал чулуулаг болон оршдог.

Эдгээр чулуулгуудыг хэрэглээ талаас авч үзэхэд тухайлбал, үнэт эрдэнийн буюу зэвэрдэггүй төмөрлөгт алт, мөнгө, цагаан алт багтдаг байхад уг төмөрлөгт нь доогуур чанарын гол төлөв зэс, цагаан тугалга, никель, хар тугалга болон цайр ордог (яам, 2021). Алт нь дуунаас хурдан онгоц, цахилгаан дижитал техник хэрэгсэл, хими, эмнэлэг, гэрэл зургийн аппаратын үйлдвэр, гоёл чимэглэлд хэрэглэхээс гадна валютын метал болдог бол тальк буюу ард түмний нэршиж хэвшсэнээр өөхөн чулуу хэмээх /цагаан, цайвар ногоон буюу ягаан өнгөтэй/ чулуу нь эмнэлэг, гоо сайхны бүтээгдэхүүн, цаас, будаг, шаазан ваар, шил сав, барилгын материалд ашигладаг байна. Харин байгаль экологийн талаас нь авч үзвэл чулуулаг багасахад ус татарч, цөлжилт үүсэх аюул нүүрлэх билээ. Тиймээс л Монгол улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд: “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” хэмээн тунхагласан байдаг ба эдгээр

байгалийн баялагт “чулуу” зүй ёсоор орно.

Чулууг дотор нь эрдэнийн, урлаг чимэглэлийн чулуу, эрдэс, уулын болон усны чулуу гэх мэтчилэн янз бүрээр нэрлэдэг. Эдгээр чулуу нь хими, физикийн бүтэц, байгалийн тогтцоосоо болон янз бүрээр нэрлэгддэг ч эцсийн бүлэгт нэг л нэр буюу ерөнхий нэр болох “чулуу” гэсэн нэрдээ захирагддаг. Бидний хувьд ямар ч төрлийн чулуу байсан түүний үнэ цэнэ нь чулууны бүтцээс бус “эх орны минь чулуу” гэдэг утгаараа алт, эрдэнэс хэмээх чулуулгаас ч илүү үнэлэгдэнэ. Байгаль орчин гэдэгт хүний амьдрал, үйл ажиллагаанд шууд болон шууд бусаар нөлөөлдөг Монгол Улсын нутаг дэвсгэрийн чулуун мандал, усан мандал, шим мандал, агаар мандлын харилцан шүтэлцээг хүрээлэл хамаарна (хууль Б. о., 1995).

Сүүлийн 2 жилийн байдлаар манай улс эд зүйл хууль бусаар улсын хилээр оруулах болон гаргах 302 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 2024 онд 140 гэмт хэрэг, 2025 онд 162 гэмт хэрэг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нь өмнөх оныхоос 22 хэрэг өссөн үзүүлэлттэй байна. Эдгээр хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн болон нэвтрүүлэхээр завдсан эд зүйлсийн дотор манай эрдэнэсийн чулуунаас гадна байгалийн чулуу ихээхэн зөөвөрлөгдөх болжээ. Тухайлбал, Монгол Улсын иргэн Б нар нь чингэлэгт давхар хана хийж 24.5 тн байгалийн чулуу хууль бусаар хил нэвтрүүлэхийг завдсан ба хохирлын хэмжээ 145.557.236 төгрөг. Зөвхөн хохирлын хэмжээ тогтоосон тооноос харахад л манай улсад ямар хэмжээний хохирол учирч байгаа нь харагдах төдийгүй дээрх чулуу бүтээгдэхүүн болон буцаад хил даваад ирэхээрээ илүү их ашиг орлого олох нь ойлгомжтой юм..

Хууль, хяналтын байгууллагын ажилтнууд эрдэнэсийн чулуу л биш бол бусад чулуунд онцын ач холбогдол өгдөггүй захиргааны арга хэмжээ авах төдийгөөр үйл ажиллагаагаа хязгаарлаж байгаа нь учруулж байгаа хор уршигтай харьцуулахад нийгэмд учруулж байгаа хор уршиг нь өндөр юм.

### Улсын хилээр хууль бусаар алт нэвтрүүлэх гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал

Газрын баялаг ихтэй, түүгээрээ улсынхаа жилийн төсвөө баталдаг манай улсын хувьд эдийн засгийн бие даасан байдал, тусгаар тогтнол болоод Үндэсний аюулгүй байдалд ашигт малтмал, тэр тусмаа алт ихээхэн ач холбогдолтой юм.

Улсын их хурлаас улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох барааны нэр төрлийг, Засгийн газраас үнийн тарифын бус хязгаартай нэвтрүүлэх барааны жагсаалтыг баталдаг.

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, бэхжүүлэх чиглэлээр Хил хамгаалах байгууллага, олон улсын худалдаа, импорт, экспортын бараа материал, эд зүйлд

хяналт тавьж гаалийн татвар, хураамжийг хууль тогтоомжийн дагуу улсын төсөвт бүрдүүлэх чиглэлээр Гаалийн байгууллага, улсын хилээр хууль бусаар бараа хэвтрүүлэх гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, шалгах асуудлыг Цагдаагийн байгууллага хариуцан ажилладаг. Монгол Улсын хилийн нийт урт 8,252,658 километр бөгөөд үүнээс Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 4,709,685 километр, Оросын Холбооны Улстай 3543 километрээр хиллэдэг байна.

Хил гаалийн боомтын асуудлаар байгуулсан хэлэлцээрийн дагуу авто болон төмөр замаар Монгол-Оросын хилд 11, Монгол-Хятадын хилд 13, агаарын замын 4, бүгд 28 боомт байнгын болон түр хугацаагаар үйл ажиллагаа явуулдаг. Хил, гаалийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг нь орчин үеийн техник технологийг /дрон/, ялангуяа бүх төрлийн тээврийн хэрэгслүүдийг хууль бусаар эд зүйлс зөөвөрлөхөд ашиглаж байна. Компьютер, холбоо, хэвлэлийн технологийг хил нэвтрэх, эсвэл гаалийн бичиг баримтыг хуурамчаар үйлдэхэд ашиглах, урьдчилан төлөвлөж, зохион байгуулалттайгаар үйлдэж байна.

#### Алт болон бусад эд зүйлийн чиглэл

Сүхбаатар, Дорноговь, Өмнөговь аймгуудын боомтуудаас БНХАУ-ын чиглэлд	• Байгалийн баялаг /алт, байгалийн төрхөц бүхий чулуу/, эрдэс, агнахыг хориглосон ховор, нэн ховор ангийн эд эрхтэн
Завхан, Хөвсгөл аймгийн боомтуудаас ОХУ-ын чиглэлд:	• Хурдан удмын сонгомол үүлдрийн адуу
Сэлэнгэ аймгийн боомтуудаас ОХУ-ын Буриад улсын Улаан-Үүдийн чиглэлд	• Монгол Улсын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн, мансууруулах, сэтгэцэт нөлөөлөх бодис, сум, галт зэвсэг,
Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгийн хилийн боомтуудаас БНХАУ-ын Эрзэн, Мандал, ОХУ-ын Чита мужийн чиглэлд	• Мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, байгалийн баялаг /алт гэх мэт/, түүх соёлын дурсгалт зүйлс,
Ховд аймгийн Булган, Байтаг боомтоос БНХАУ-ын Шинжаан мужийн чиглэлд:	• Байгалийн баялаг /ашигт малтмал/, түүх соёлын дурсгалт зүйлс, мал ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэх
Баян-Өлгий, Увс аймгийн боомтуудаас ОХУ-ын Тува улс, Горный Алтайн чиглэлд	• Хил дамнансан малын хулгай, мал, малын махыг их хэмжээгээр хууль бусаар хил давуулах, хууль бусаар хил нэвтрэх,

Зураг 1. Алт болон бусад эд зүйлийн чиглэл





Улсын хилээр хууль бусаар эд зүйл болон алт нэвтрүүлэх гэмт хэргүүд дараах аргуудаар үйлдэгдэж байна. Үүнд:

- Ховор, нэн ховор ан амьтны эд эрхтэн, үнэт чулуу, алт, байгалийн төрхөц бүхий чулуу, зэс, хөнгөн цагаан зэрэг эд зүйлийг хууль бусаар хилээр нэвтрүүлэхдээ автомашиныг нуувч болгон ашигладаг. Тухайлбал, суудлын автомашинд давхар хана, хаалга гаргах, суудлын зөөлөвчинд нуух, бензиний банк, запас дугуй, моторын хажуу талын зай завсар зэргийг ашиглахаас гадна нэмэлт тоноглол хийх байдлаар эд зүйлийг хийх нуувчийг зориудаар бэлтгэх, ачааны болон том оврын автомашины ачаан дунд нуух, запас дугуйнд нуух, багажийн хайрцагт нуух зэргээр эд зүйлийг хийх боломжтой зайг ашиглах аргуудаар үйлдэгдэж байна;

- Гааль, Хилийн мэргэжлийн хяналтын байцаагч нартай үгсэн тохирох, хяналт шалгалтаар орохгүй байх;

- Автомашин, галт тэрэгний аль нэг хэсэгт бэхэлж хил нэвтрүүлэх (энэ тохиолдолд ихэвчлэн алтыг хууль бусаар гаргахад ашигладаг бөгөөд жишээ нь галт тэрэгний дугуйн орчим байрлах хөндлөн төмөр, бусад зүйлд нууцаар алтаа бэхлэх бөгөөд галт тэрэг хилээр гарсны дараа уг зүйлээ нууцаар авдаг);

- Техник технологийн дэвшлийг ашиглах. (дропоор эд зүйл тээвэрлэж хилийн боомтын бус газраар хууль бусаар нэвтрүүлэх. Энэ тохиолдолд хилийн наана цаана байгаа этгээдүүд урьдчилан газраа тохирох, байнгын харилцаатай байдаг);

- Бараа материалын үнэ, тоо хэмжээг бууруулах, гаальд мэдүүлэхгүй байх (энэ тохиолдол нь ихэвчлэн гаалийн байцаагчийн хяналт шалгалттай холбоотой байдаг);

- Бараа материалын үнэ, нэр, тоо хэмжээг зориудаар өөрчлөх буюу бууруулж гаальд мэдүүлэх (энэ нь гаалийн татвараас зайлсхийсэн тохиолдолд гардаг);

- Олон төрлийн бараан дунд хязгаарласан буюу хориглосон барааг хийж хилээр нэвтрүүлэх;

- Алт, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хувь хүн биедээ нуун далдлах буюу хувцас, эрхтэндээ хийж хилээр нэвтрэх зэргээр олон төрлийн аргыг хэрэглэж байна (Б.Лхагварачаа, 2024).

Монгол Улсаас БНХАУ-руу алт, байгалийн болон ангийн гаралтай эд зүйл, ховор ургамал, түүх соёлын дурсгалт зүйл, буу зэргийг хууль бусаар нэвтрүүлж байгаа бол БНХАУ-аас Монгол Улс руу химийн бодис, эм, эмнэлгийн хэрэгсэл, хуурамч онцгой албан татварын тэмдэгт, хар тамхи зэргийг хууль бусаар нэвтрүүлж байна. Харин Монгол Улсаас ОХУ-руу амьд адуу, мал зэргийг хилээр хууль бусаар нэвтрүүлж байгаа бол ОХУ-аас Монгол Улс руу эм, эмнэлгийн хэрэгсэл, сум, байгалийн чулуу, хүнсний бүтээгдэхүүн зэргийг хилээр хууль бусаар нэвтрүүлж байна. БНХАУ, ОХУ-аас бусад улс орон руу алт, эртний үнэт олдвор, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлсийг хууль бусаар гаргах гэмт хэргүүд бүртгэгдэж байна.



Зураг 2. Одоо ажиллаж байгаа хилийн боомтууд

Алт, зэс, гууль, хөнгөн цагаан, хуш модны самар болон ан амьтны гаралтай түүхий эд болох бугын чивсүүл, хүдрийн заар, доньд, бөхөнгийн эвэр, баавгайн сарвуу, ирвэс, шилүүс, тарвага, үнэг, чоно, хэрмийн арьс зэрэг ангийн гаралтай түүхий эд зүйлс БНХАУ-д эрэлт хэрэгцээ ихтэй, өндөр үнээр зарагддаг нь эд зүйлсийг хууль бусаар хил нэвтрүүлэх гэмт хэргийн шалтгаан болж байна.

### Дүгнэлт

Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон буюу хязгаарласан эд зүйлс болон алтыг Монгол Улсад бэлтгэн нийлүүлдэг, зуучилдаг, улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж зардаг, зохион байгуулдаг, хилийн чандад эдгээрийг захиалдаг, худалдан авдаг сүлжээ, бүлэглэл бий болж зохион байгуулалтад орсон бөгөөд улсын эдийн засгийн аюулгүй байдлыг алдагдуулж байгаа нь үндэсний аюулгүй байдалд заналхийлж байна гэж үзэж байна.

Иймд энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд төв, орон нутгийн цагдаагийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэн, хөрш зэргэлдээ улсын цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааг улам арган хүрээнд харилцан энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх зайлшгүй шаардлага тулгарч байгааг харуулж байна. Мөн энэ төрлийн гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа цагдаагийн албан хаагч, хилийн хяналт шалгалт хийж байгаа гаалийн ажилтан, хил хамгаалах албаны албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах хэрэгцээ, шаардлагатай байна.

### Санал

Монгол Улсын хилээр алтыг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэрэгтэй тэмцэхэд хууль, эрх зүйн орчныг болгох талаар дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Үнэт металл, байгалийн үнэт чулууг хууль бусаар борлуулах. Үнэт



МОНГОЛЫН ИРГЭД  
ТӨР  
ХАМГААЛАХ  
ЯМ



металл, байгалийн үнэт чулууг хууль бусаар эргэлтэд оруулсан, хадгалсан, тээвэрлэсэн, илгээсэн бол... гэж.

2. Монгол улсын Засгийн газар “Үнэт металлыг эргэлтэд оруулах” журам баталж алтны худалдах, худалдан авах, цэвэршүүлэх харилцааг яаралтай нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

3. Үнэт металлыг эргэлтэд оруулах журмыг зөрчих. Үнэт металлыг эргэлтэд оруулах журмыг зөрчсөн бол ... зэрэг зүйл, заалтуудыг шинээр нэмэлтээр оруулах.

4. Алт худалдан авч борлуулдаг иргэд буюу ченжүүдэд худалдан авч байгаа алтны гарал үүсэл, хэмжээ, худалдан борлуулсан иргэний мэдээлэл зэргийг бүртгэлжүүлэх, хяналт тавих тухай хуультай болох зэрэг саналтай байна.

### Ашигласан материал

1. Статистик мэдээ <https://police.gov.mn>
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. Монгол Улсын Их хурлын тогтоол. 2010. 48 дугаар тогтоол.
3. Монгол Улсын Эрүүгийн хууль Төрийн мэдээлэл эмхтгэл. УБ., 2015.
4. С.Гантулга, Б.Энхболд. Эрүүгийн эрх зүй тусгай анги. УБ., 2018. 220 дахь тал.
5. Б.Лхагварагчаа нар. Гэмт хэрэг мөрдөн шалгах арга зүй. УБ. 2024. 221 дахь тал.
6. Гаалийн тухай хууль. Төрийн мэдээллийн эмхэтгэл №23. УБ., 2008.

## ХИЛИЙН ЦЭРГИЙН ОПЕРАТИВ УРЛАГИЙН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ОНОЛЫН ҮНДЭС

### THE ORIGINS, DEVELOPMENT, AND THEORETICAL FOUNDATIONS OF BORDER GUARD OPERATIONAL ART

#### **А.Амгаланбаяр**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн Хилийн албаны удирдлага, стратегийн тэнхим, дэд профессор, дэд хурандаа

#### **A. Amgalanbayar**

Associate Professor, Department of Border Service Management and Strategy, National Academy of Governance, Lieutenant Colonel

#### **Б.Баттүвшин**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны магистрант, дэд хурандаа

#### **B. Battuvshin**

Lieutenant Colonel, Master's student of Class 8022 at the Executive Management Academy, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: btuvshin005@gmail.com

**Хураангуй:** Энэхүү өгүүлэл нь хилийн цэргийн оператив урлагийн үүсэл, хөгжил болон онолын үндсийг судалсан болно. Судалгааны хүрээнд хилийн цэргийн оператив урлагийн түүхэн хөгжлийн үе шатууд, түүний үндсэн онолууд, орчин үеийн хил хамгаалалтын үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө болон практик хэрэглээний чиг хандлагуудыг нарийвчлан авч үзсэн. Оператив урлаг нь стратеги, тактикийн хоорондох холболтыг бий болгох шинжлэх ухаан бөгөөд энэ нь тактикийн үүднээс удирдлагын орон зайг тодорхойлж, стратегийн түвшний зорилго, чиглэлийг шийдэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Өгүүлэлд хилийн цэргийн оператив урлагийн түүхийн хөгжлийн үе шатууд, онолын үндсийг болон үүний практик хэрэглээг тодорхойлсон. Мөн орчин үеийн хил хамгааллын байгууллагуудын туршлага, онолын шинэчлэл болон практик хэрэгжилтэд үзүүлэх ач холбогдлыг судалж, уг урлагийг хөгжүүлэх гол асуудал, боломжуудыг шинжилсэн. Дүгнэлт болон санал хэсэгт судалгааны үр дүнгээс үндэслэн хилийн цэргийн оператив урлагийг онол, практикийн холболтоор үр ашигтай хөгжүүлэх арга замуудыг тодорхойлсон. Энэхүү өгүүлэл нь судлаачид, хил хамгаалах байгууллага болон удирдлагын алба хаагчдад шинжлэх ухааны үндэслэлтэй шийдвэр гаргахад чиг баримжаа өгөх зорилготой.

**Abstract:** This article thoroughly examines the origins, development, and theoretical foundations of border guard operational art. The research explores the historical development stages of border guard operational art, its foundational theories, its impact on modern border protection activities, and trends in practical applications. Operational art serves as a science that bridges strategy and tactics, playing a crucial role in determining tactical leadership and shaping strategic goals and directions. The article details the historical development stages of border guard operational art, its theoretical underpinnings, and practical applications. It also explores the experiences of modern border protection organizations, the theoretical innovations, and the significance of practical implementation, identifying key issues and opportunities for the advancement



Урьдчилсан  
Хилийн Цэргийн  
Оператив Урлагийн  
Үндэслэл





of this art. In the conclusion and recommendations section, based on the research findings, strategic approaches and methods for effectively advancing border guard operational art through the integration of theory and practice are proposed. This article aims to provide guidance to researchers, border protection organizations, and leadership officers to make scientifically grounded decisions.

**Түлхүүр үгс:** Хилийн цэрэг, оператив урлаг, үүсэл хөгжил, онол

**Keywords:** Border Guard, Operational Art, Origin and Development, Theory

### Удиртгал

XXI зууны олон улсын харилцааны орчинд бүс нутгийн аюулгүй байдал олон талын сорилт, эрсдэлээр тодорхойлогдож байна. Хил дамнасан гэмт хэрэг, хууль бус үйл ажиллагаа, терроризм, бүс нутгийн мөргөлдөөн зэрэг хүчин зүйлс нь улс орнуудын хил хамгаалалтын онол, арга зүйн хөгжилд шинэ шаардлага тавьж байна. Монгол Улсын хувьд өргөн уудам газар нутаг, урт хилтэй бөгөөд хүн ам цөөн, олон улсын болон бүс нутгийн харилцааны төвд оршдог онцлог нь хил хамгаалалтыг стратегийн чухал асуудал болгож байна.

Хил хамгаалалтын урлагийн систем дотор оперативын урлаг нь голлох байр суурь эзэлж, салшгүй нэгэн хэсгийг бүрдүүлдэг. Хилийн цэргийн оперативын урлаг нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг улсын хил болон хилийн орон зайд хамгаалахад чиглэсэн, хилийн цэргийн оперативын бүлэг буюу бүсийн удирдлагын нэгжүүдийн ажиллагааг бэлтгэж, явуулах онол-практикийн асуудал юм. Улсын хилийн найдвартай байдлыг хангахын тулд хамгаалалтыг шинжлэх ухааны онолын суурьд тулгуурласан загварт шилжүүлж, хилийн цэргийн байгуулалт, удирдлагын үйл ажиллагааг илүү боловсронгуй, оператив урлагийн онолын үндэстэйгээр хөгжүүлэх нь тулгамдсан асуудлын нэг болжээ.

Цэргийн онолын ухаанд оператив урлагийг стратеги болон тактикийн түвшний уялдаа холбоог хангах чухал гүүр хэмээн үзэж, ХХ зуунаас эхлэн өргөн хүрээнд судалсан байдаг. Оросын цэргийн онолын сургуульд оператив урлаг онолын хувьд гүнзгийрэн хөгжиж, практикт үр дүнтэй хэрэгжсэн бол Израиль, АНУ зэрэг улс өөрийн орны нөхцөлд нийцүүлэн хил хамгаалалтын стратеги, тактикийн онолыг боловсруулсан байна.

Монгол Улсад хилийн цэргийн оперативын урлагийн асуудлаар Н.Наранжамц "Хилийн операци", "Бүс нутаг-хил хамгаалалтын үзэл баримтлал", Ш.Арвай "Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог", П.Даш "Хил хамгаалалтын онол", "Хил судлал-онол практикийн зарим асуудал" зэрэг ном болон бусад доктор, магистрын зэрэг горилсон судалгааны ажлуудад судлагдсан байна.

Энэхүү өгүүллийн зорилго нь хилийн цэргийн оператив урлагийн үүсэл, хөгжлийг түүхэн болон олон улсын туршлагын үүднээс авч үзэх, онолын үндсийг тодорхойлох, улмаар Монгол Улсын хил хамгаалалтын онцлогт нийцүүлэх боломжийг шинжлэхэд оршино.

Судалгааны ажилд түүврийн арга, харьцуулсан (хил хамгаалах байгууллага болон бусад орны туршлагатай) судалгааны арга, баримт

бичгийн шинжилгээний арга зэргийг хослуулан ашиглав.

- Эх сурвалжийн шинжилгээ (хууль эрх зүйн баримт бичиг, цэргийн болон хил хамгаалалтын онолын бүтээлүүд, гадаад улсын туршлагын материал)

- Харьцуулсан судалгаа, дүн шинжилгээ хийх арга

- Онолын нэгтгэл, дүгнэлт гаргах арга

Хэрэв хилийн цэргийн оператив урлагийг онолын түвшинд судлан хөгжүүлбэл хил хамгаалалтын удирдлагын үр нөлөө дээшилж, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын чадавх дээшилж, бүс нутаг, хилийн аюулгүй байдал хангагдах боломжтой.

Судалгааны үр дүнд:

- Хилийн цэргийн оператив урлагийн үүсэл, хөгжлийн үе шат тодорхой болно.

- Олон улсын туршлагад тулгуурласан харьцуулсан дүгнэлт гарна.

- Хил хамгаалалтын оператив урлагийн онолын үндэс Монгол Улсын нөхцөлд тодорхойлогдоно.

- Цаашид боловсронгуй болгох чиглэл, санал дэвшүүлнэ.

## **1. ХИЛИЙН ЦЭРГИЙН ОПЕРАТИВ УРЛАГИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ**

### **1.1. Оператив урлагийн цэргийн онол дахь үүсэл**

Орчин үеийн зэвсэглэлээр хангагдсан олон хүнтэй армитай, үйлдвэрлэл хөгжсөн нэлээд орнуудад XIX зууны эхэн үеэс XX зуунд оперативын урлаг үүсэх бодит нөхцөл бүрдсэн байна.

1. Дайны ажиллагаа томоохон орон зайд хэд хэдэн дэс дараалсан хэлбэрээр хоорондоо холбоо бүхий тулалдаануудаар үргэлжилсэн хугацаанд хүч задлан явагдах болсон;

2. Орос-Японы дайны дараа Оросын цэргийн онолчид анх удаа өөрийн хэмжээгээр тактикийн хүрээнээс халин гарсан байлдааны ажиллагааг тусгайд нь авч үзэх санал гаргажээ. Цэргийн урлагийн бие даасан бүрэлдэхүүн хэсэг болсон стратегид ордоггүй.

3. Дэлхийн 1-р дайны явцад дайны ажиллагааны шинэ хэлбэр болох Нэгдсэн бодлого төлөвлөгөөгөөр, нэгдсэн удирдлагаар явагдах тулалдаан болон байлдаануудын цогц болсон.

4. Цэргийн урлагийн хүрээнд дайны ажиллагааг явуулах практикт илэрхий буй болсон шинэ онолыг боловсруулах зайлшгүй шаардлага үүссэн.

Дараагийн жилүүдэд оперативын урлагийн онолын үндсийг цаашид боловсруулж, 1924 оноос АТУА-ийн цэргийн академийн сургалтын явцад биеэ даасан хичээл болж нэвтэрсэн.

Ийм байдлаар Оросод 1924 оноос цэргийн урлагийг стратеги, оператив, тактик гэж албан ёсоор хувааж үздэг болжээ.

Оперативын урлагийн хөгжсөн үе шат

I үе шат: XIX зууны эх-Хээрийн армиуд, оперативын нэгдэл бий болсон. (1812 онд Оросд, 1883 онд Францад, 1866 онд Пруссд, 1904 онд Японд;

II үе шат: 1904-1924 он. Оперативын урлагын онол буй болж, туршлага нэгтгэгдсэн;

-Орос-Японы дайн-  
Оперативын урлагийн категори болох армийн операци үүссэн.  
-Дэлхийн нэгдүгээр дайн-  
Фронтын операци үүссэн.

III үе шат: 1924-1953 он. Оперативын урлагийн онол ба практикийн хөгжил (Дэлхийн II дайны туршлага);

IV үе шат: 1947-1985 он. Оперативын урлагийн цаашдын хөгжил (цөмийн зэвсэг);





V үе шат: 1985-2010 он.

Оперативын урлаг хориглолтын чиглэлтэй цэргийн номлолын нөлөөн дор хөгжсөн.

Орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөн үүссэн. Алсын тусгалтай ӨЦЗ, физикийн шинэ зарчимд үндэслэгдсэн зэвсэг буй болж, операцийг явуулах арга ба оперативын шинэ үзэл баримтлал-мэдээллийн тэмцэл, удирдлагын тогтолцоог өөрчлөх шинэ үзэл баримтлал буй болсон. (Түмэн. Б, Наран-Очир. Б, Онцгойбаяр. Л, Ганзориг. Г, 2021, хууд. 23)

Оператив урлаг нь XIX зууны эхэн үеэс цэргийн шинжлэх ухаанд бие даасан ойлголт болон төлөвшсөн бөгөөд стратеги, тактикийн хоорондын гүүр хэмээн тодорхойлогддог. Стратеги нь улс орон, эвслийн түвшинд дайн, зэвсэгт мөргөлдөөний зорилгыг тодорхойлж, тактик нь түүний хэрэгжилтийг шууд тулалдааны түвшинд хэрэгжүүлдэг бол оператив урлаг нь тодорхой театрын түвшинд томоохон хүч, хэрэгслийг удирдан зохион байгуулах онол, урлаг юм.

Оросын цэргийн онолд М.Н.Тухачевский, А.А.Свёчин зэрэг нэрт онолчид оператив урлагийн үндсийг боловсруулж, стратегийн болон тактикийн зохицлын гол зарчмуудыг тодорхойлсон байдаг. Тухайлбал, оператив урлаг нь “тулааныг ялалтад хүргэхийн тулд цэргийн хүчийг тодорхой орон зай, хугацаанд төвлөрүүлэн ашиглах урлаг” гэж үзэж байв. (Тухачевский, 1922), (Свечин, 1927)

Дараа нь ЗХУ-ын цэргийн онолын сургуульд энэ ойлголтыг системтэй хөгжүүлж, дэлхийн хоёрдугаар дайнд практикт амжилттай хэрэгжүүлсэн нь цэргийн шинжлэх ухаанд шинэ хандлага авчирсан.

Энэхүү ойлголт нь зөвхөн томоохон дайны театрт бус, тухайн улсын хил хамгаалалт, бүсийн аюулгүй байдлын удирдлагад ч хэрэгжих боломжтой гэдэг нь цаг хугацааны явцад тодорхой болсон юм. Хил хамгаалалтын үйл ажиллагаа стратегийн зорилго, үндэсний аюулгүй байдлын бодлоготой шууд уялддаг учир оператив урлагийн зарчмуудыг нутагшуулах зайлшгүй шаардлага бий болсон.

## 1.2. Хил хамгаалалтын удирдлагад оператив урлагийг нутагшуулах үзэл санаа

Хил хамгаалалтын өдөр тутмын үйл ажиллагаа нь тактикийн түвшинд явагддаг бол хил орчмын ноцтой нөхцөл, мөргөлдөөний үед стратегийн чиглэлд уялдсан оператив удирдлага шаардагддаг. Иймээс хил хамгаалалтын удирдлагыг зөвхөн тактикийн арга хэрэгслээр биш, харин оператив урлагийн түвшинд төлөвлөн хэрэгжүүлэх шаардлага бий.

Зарим улс оронд хил хамгаалалтын үйл ажиллагааг цэргийн оператив урлагийн зарчимтай уялдуулан хөгжүүлсэн байдаг. Тухайлбал, ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны харьяа Хилийн алба нь цэргийн нэгжийн зохион байгуулалттай ижил бүтэц, удирдлагын түвшинтэйгээр ажиллаж, хилийн бүсэд оператив төлөвлөлт хэрэгжүүлдэг. Израиль улсын хувьд хил хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын бодлогын цөм хэсэгт байршуулж, өндөр технологид тулгуурласан мэдээлэл, тагнуул, хяналтын системийг оператив удирдлагатай уялдуулан хөгжүүлсэн. АНУ болон Европын зарим улс хил хамгаалалтад үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдлын концепцтой нийцүүлсэн “joint operation” буюу хамтарсан ажиллагааны үзэл санааг

нэвтрүүлж байна. Эдгээр туршлага нь хил хамгаалалтыг зөвхөн хууль сахиулах, хяналт шалгалтын түвшинд бус, харин цэргийн удирдлагын системтэй, олон шатлалтай, оператив зарчимд тулгуурласан цогц ойлголт болохыг харуулдаг.

### 1.3. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн хөгжилтэй уялдуулан тайлбарлах нь

Хил хамгаалалтын түүхэн хөгжлийг судлахдаа Хүннү улсын үеэс буюу манай эриний өмнөх анхны төрт улсын үеэс эхлэн авч үзэх нь онолын хувьд үндэслэлтэй гэж үздэг.

Монгол цэргийн урлаг дараах үе шатуудад хуваагдаж байна. Үүнд:

а. Монголын түрүү феодалын улсуудын цэргийн урлаг

б. Их Монгол улсын цэргийн урлаг XI-XII зуун

в. Монголын Юан гүрний цэргийн урлаг 1260-1368 он

г. Феодалын бутралын үеийн цэргийн урлаг XIII зууны сүүл XX зууны эх

д. Шинэ Монгол улсын цэргийн урлаг /1921-1990 он/

е. Орчин үеийн Монгол Улсын цэргийн урлаг 1990 оноос хойш

Аливаа улс гүрэн оршин тогтнож байна гэдэг нь улсын хилтэй байна гэсэн үг.

Улсын хил оршин байгаа нөхцөлд хил хамгаалах алба зайлшгүй хэрэгтэй институт болж, үйл ажиллагаа нь улс төр, цэргийн хөгжлийн түвшинтэй уялдан өрнөж иржээ. Тиймээс Монголын цэргийн урлагийн хөгжлийн хамтаар хил хамгаалах урлаг ч мөн үе шаттайгаар төлөвшин хөгжсөн гэж үзэх үндэслэлтэй.

Хан Улсын хааны зарлигаар МЭӨ 177 онд "Урт хот (их цагаан хэрэм)- оос хойших нум сум агсагчид нь Шаньюйгийнх, Урт хотоос дотогш

түшмэдийн хувцас өмсөгч нь миний биед захирагдана" гэж Хан улсын түүхэн эх сурвалж болох "Судар"-ын 94 дүгээр дэвтэр (дээд хэсэг)-т уг үйл явдлыг тэмдэглэн үлдээжээ.

Энэ баримтаас харахад улсын тусгаар тогтнол нь нутаг дэвсгэрийн эзэмшил, бүрэн бүтэн байдлаас хамааран тодорхойлогдох зүй тогтолтой байна. Хөрш хоёр улсын эрх мэдэл нь хилээр зааглагдан тогтдог нь төрийн бүрэн эрхт байдлын бодит илрэл юм. Ийм учраас энэ үзэгдэл нь түүхэн болон онолын хувьд онцгой үнэ цэн, ач холбогдол бүхий, цаг хугацаанд үл хувирах сургаал гэж үзэж болно.

Хоёр улсын нутаг дэвсгэрийн зааг хязгаарыг эрх зүйн болон бодит үндэслэлд тулгуурлан тогтоож, хилийн шугам, тэмдэг, хамгаалалтын арга хэрэгслийг иж бүрнээр бий болгосон нь хүн төрөлхтний түүхэнд урьд өмнө байгаагүй цогц байгуулалт болсон юм.

Их Монгол Улсын нутаг дэвсгэрийг тодорхойлохдоо Чингис хаан эртний хил хязгаарын уламжлалыг залгамжилж, хилийн баталгаажилт ба хамгаалалтыг төрийн тэргүүний хариуцлагын дээд илэрхийлэл гэж үзсэн нь түүхэн онцгой үзэл санаа байв.

Их Монгол Улсын үеэд аюулын чиглэл бүрт тохирсон аравт, зуут, мянгат, түмтийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хил манах, хязгаар нутгийг хамгаалахтай зэрэгцэн тухайн бүс нутгийг цэргийн ажиллагаанд бэлтгэн зохион байгуулах, урьдчилан хүн хүч, зэвсэг, техникийн бэлэн байдлыг хангуулах шаардлага тулгарч байв.

Аюул тохиолдох үед зөвхөн тухайн чиглэлийн түмт бус, бусад гурван чиглэлийн түмтийн хүчийг нэгтгэн маневрлан төвлөрүүлж, дайралт болсон хэсэгт шилжүүлэн ашигладаг байсан. Ийм зохион байгуулалт нь өнөөгийн ойлголтоор бол оператив-тактикийн





арга ажиллагаа, хил судлалын шинжлэх ухааны үндэс, улмаар төрийн хилийн бодлого, стратегийн түвшний хил хамгаалалтын урлагийн хөгжлийн эх суурь болсон гэж үзэж болно.

1911 онд тусгаар тогтнолоо сэргээснээс хойш хил хамгаалалтын асуудал үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудал байсаар ирсэн. 1921 оны Ардын хувьсгалын дараагаар хил хамгаалалтыг Зөвлөлтийн цэргийн байгуулалтын загварт тулгуурлан эхний удаа системтэй байгуулж, 1930-аад оноос хил хамгаалах байгууллагыг мэргэжлийн түвшинд хөгжүүлжээ.

Дайны өмнөх болон Дэлхийн хоёрдугаар дайны үеийн туршлагаар Монголын хилчид зөвхөн тактикийн ажиллагаа бус, тодорхой хэмжээнд оператив удирдлагын зарчимд нийцсэн зохион байгуулалттай үйл ажиллагаа явуулж байсан баримт бий. 1945 оны Чөлөөлөх дайнд хилийн цэргийн хүчийг фронтын түвшинд дайчлан ашигласан нь хил хамгаалалтын оператив удирдлагын анхны бодит жишээ болж үлдсэн.

Хүйтэн дайны жилүүдэд олон улсад хил хамгаалалт нь стратегийн тэнцвэрийн нэг хэсэг болж, цэргийн онолын түвшинд гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр хөгжсөн. Ардчиллын шилжилтийн дараахан хил хамгаалах байгууллагын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж, хууль эрх зүйн үндэс нь улам боловсронгуй болжээ. Энэ үеэс “Хил судлал” хэмээх шинжлэх ухааны салбар бие даан хөгжиж, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдөж эхэлсэн бөгөөд 1995 оны 12 дугаар сарын 6-нд Оюуны бүтээлийн олон улсын бүртгэл /International Chamber of Intellectual Innovation/-д EIW-0001175 дугаартайгаар албан ёсны бүртгэлд орсон билээ.

#### 1.4. Олон улсын туршлагатай харьцуулсан дүгнэлт

Дээрхээс харахад дэлхийн улс орнууд хил хамгаалалтыг стратегийн болон тактикийн хосолсон арга замаар хэрэгжүүлдэг бөгөөд түүний гол тулгуур нь оператив удирдлага юм. Орос, Израиль, АНУ зэрэг орны туршлагаас үзэхэд:

- Хил хамгаалалтыг үндэсний аюулгүй байдлын бодлоготой уялдуулдаг;
- Оператив түвшний төлөвлөлтийг цэргийн нэгжийн зарчимд нийцүүлэн хэрэгжүүлдэг;
- Тагнуул, мэдээлэл, технологийг оператив удирдлагын салшгүй хэсэг болгон ашигладаг;
- Бүс нутгийн болон олон улсын аюулгүй байдлын хамтын ажиллагаанд тулгуурладаг.

Монгол Улсад эдгээр туршлагаас судалж нутагшуулах олон боломж бий. Тухайлбал, хил хамгаалалтын удирдлагыг оператив урлагийн түвшинд хөгжүүлэх замаар зөвхөн тактикийн хүрээнд хязгаарлагдахгүй, стратегийн зорилгод нийцсэн оновчтой зохион байгуулалтыг бий болгох шаардлага тулгараад байна.

## 2. ХИЛИЙН ЦЭРГИЙН ОПЕРАТИВ УРЛАГИЙН ОНОЛЫН ҮНДЭС

### 2.1. “Оператив урлаг”-ийн онолын үндэс

Хил хамгаалах оперативын урлагийг судлахаас өмнө урлаг гэж юу болох, оперативын урлаг нь хаанаас эхтэйг тогтоох нь зүйтэй хэмээн үзэж байна.

Хил хамгаалах оперативын урлагийн мөн чанарыг гүнзгий судлахын тулд юуны өмнө “урлаг” гэсэн нэр томъёоны утга, мөн “оперативын урлаг”-ийн гарал үүсэл, хөгжлийн эхлэлийг тогтоох шаардлагатай гэж үзэж байна.

Хүн төрөлхтний түүхэн хөгжлийн явцад “урлаг” гэх ойлголт үүсэж, улмаар шинжлэх ухааны судалгааны бие даасан салбар болон хөгжжээ. Энэ ойлголт нь соёл, утга зохиол, уран сайхны бүтээл зэрэг нийгмийн олон талт илэрхийллийг багтаасан өргөн хүрээтэй юм. Уг ойлголтыг илүү тодорхой болгохын тулд толь бичигт өгсөн тодорхойлолтыг авч үзье.

“Монгол хэлний тайлбар толь”-д (Я.Цэвэл) дурдсанаар, “урлаг” нь үнэн байдлыг уран сайхны аргаар дүрслэх бүтээл бөгөөд түүнтэй холбогдон “урлаг судлал”, “урлагийн түүх”, “уран барилгын урлаг”, “ардын урлаг”, “эртний урлаг” зэрэг олон талт ойлголтуудыг хамардаг гэжээ. (Цэвэл, 1966, 431 дэх тал)

Урлаг гэдэг нь хүн төрөлхтний үйл ажиллагаанд илэрдэг дээд түвшний ур чадвар гэж үздэг.

Хил хамгаалалтын урлаг нь цэргийн урлагийн нэг хэсэг бус, харин өөрийн шинжлэх ухааны суурь, онол, арга зүйд тулгуурласан бие даасан судлагдахуун юм.

Цэргийн шинжлэх ухаанд дараах бүтэц, бүрэлдэхүүнээр тайлбарладаг.

Үүнд цэргийн урлаг, дайны түүх, зэвсэгт хүчний байгуулалтын үндэс, цэргийн сургалт болон хүмүүжлийн онол зэрэг нь гол чиглэлүүдийг бүрдүүлдэг.

Эдгээрээс цэргийн урлаг нь хамгийн чухал салбарын нэг бөгөөд дайн үүсэхтэй зэрэгцэн бий болж, үйлдвэрлэлийн хөгжил, нийгмийн хэрэгцээнээс хамааран хувьсан хөгжиж иржээ. Цэргийн урлаг нь дайныг (стратегийн) болон цэргийн ажиллагааг (оператив ба тактик) хэрэгжүүлэх арга хэлбэрийг судалдаг онол, практикийн ухаан юм.

Өөрөөр хэлбэл, цэргийн урлаг нь дайныг бүхэлд нь удирдан явуулах, хүч хэрэгслийг оновчтой ашиглах, ялалтад

хүрэх арга барилыг судалдаг бөгөөд стратеги, оператив урлаг, тактикийн уялдаа холбоонд тулгуурладаг иж бүрэн систем юм.

Стратеги нь цэргийн урлагийн хамгийн дээд салбарын хувьд зэвсэгт хүчний бүх төрлийн нэгдлүүдийн бэлэн байдлыг хангах, тэдгээрийн бүтэц-зохион байгуулалтыг төгөлдөржүүлэх, байлдааны тохиромжтой бүрэлдэхүүнийг тодорхойлох, түүнчлэн тэдгээрээр дайны ажиллагааг янз бүрийн хэлбэрээр (операц, тулалдаан, цохилт болон байлдааны ажиллагаа) бэлтгэх ба явуулах асуудлаар оперативын урлагийн онол болон практикийн үүрэг, шаардлагыг тодорхойлно.

Оперативын урлаг- цэргийн урлагийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд дайны ажиллагааг тодорхой хэлбэрээр зэвсэгт хүчний нэгдлүүд болон төрөл хоорондын бүлэглэлүүдээр бэлтгэн явуулах онол ба практикийг хамаарна.

Оперативын урлагийг мөн бусад эх сурвалжид дараах байдлаар томъёолсон. Үүнд:

- Энэ бол *операцын тухай сургаал* (Г.С.Иссерсон «Оперативын урлагийн хувьсал». -М., Воениздат, 1937. –х-17)

- Энэ бол *зэвсэгт хүчний янз бүрийн ай төрлийн нэгдлүүдээр ерөнхий цэргийн (ерөнхий флотын) хамтарсан болон биеэ даасан операц (байлдааны ажиллагаа) бэлтгэн явуулах онол ба практик юм.* Цэргийн нэвтэрхий толь (ВЭС. -М., Воениздат, 1983. –х-513)

-Энэ бол *оператив-стратегийн, оперативын болон оператив-тактикийн хэмжээний дайны ажиллагааны янз бүрийн хэлбэрийг бэлтгэн явуулах талаарх онолын мэдлэг ба практик зөвлөмжийн тогтолцоо юм.* (Нэр томъёоны тайлбар толь – М., ВАГШ, 2011.)

Оперативын урлагийг ирээдүйд “Энэ бол дайны ажиллагааны театр





дээр цэрэг (хүч)-ийн бүлэглэлийн явуулж байгаа янз бүрийн хэмжээний операцыг бэлтгэн явуулах талаарх онолын мэдлэг ба практик зөвлөмжийн тогтолцоо юм” гэж тодорхойлсон.

Тактик нь - нэгтгэл, анги, салбарууд байлдаан бэлтгэж, явуулах асуудлыг судлан, ЗХ-ний төрөл, мэргэжлийн цэргийг агаар болон тэнгис, хуурай газарт ашиглах арга хэлбэрүүдийг боловсруулдаг цэргийн урлагийн онол, практикийн асуудлыг хэлнэ. (Түмэн, 2005, 15 дахь тал)


Оператив урлаг нь цэргийн онолд стратеги, тактикийн хоорондох гүүрийн үүрэг гүйцэтгэдэг бөгөөд цэргийн хүчний зохион байгуулалт, удирдлагын системийг оновчтой ашиглах боломжийг олгодог (Тухачевский, 1922; Свечин, 1927). Энэ нь зөвхөн дайны театрын түвшинд бус, хил хамгаалалтын үйл ажиллагаанд ч шууд хэрэглэгдэх боломжтой.

Оператив урлагийн онолын үндсэн зарчим нь: Зорилго чиглэлд нийцсэн хүчний төвлөрөл – тодорхой газар нутаг, цаг хугацаанд хүч хэрэгсэл

зохион байгуулалттайгаар ашиглагдах. Уялдаа холбоо ба зохицуулалт – стратеги, тактикийн зорилгыг нэгтгэн хэрэгжүүлэх. Санал бодлын уян хатан байдал – нөхцөл байдлын өөрчлөлтөд хурдан хариу өгөх боломж. Эдгээр зарчмууд нь хил хамгаалалтын удирдлагын онолд онцгой ач холбогдолтой. Хил хамгаалалтын ажиллагаа нь тухайн улсын стратегийн аюулгүй байдлын бодлоготой нягт уялдсан байх шаардлагатай бөгөөд энэ нь оператив урлагийн онолын суурь зарчмуудаар баталгааждаг.

Харин улсын хил судлалын шинжлэх ухаанд хил хамгаалах урлаг болон оперативын урлагийн агуулгыг дараах байдлаар тодорхойлон авч үздэг.

Хил судлалын шинжлэх ухаан нь өөрийн гэсэн бүтэц, зарчим, хууль, зүй тогтол, объект, судлагдахуун онолуудтай билээ. Үүнээс хилийн хилийн цэргийн оператив урлагийн онол нь хил хамгаалалтын онол, тэр дундаа хил хамгаалах урлагийн бүрэлдэхүүн онолын нэг юм.



**Зураг 1. Хил хамгаалах урлагийн онолын салбарууд**

(Эх сурвалж: Ш.Арвай нар, “Улсын хил судлал – онол, практикийн зарим асуудал”, 2016, х.79).

Иймээс улсын хил хамгаалалтын зорилгоор хуурай газар, нуур, гол мөрөн болон хилийн боомт, гарц зэрэгт хил хамгаалах, алба-байлдааны ажиллагааг урьдчилан бэлтгэж, явуулах ажиллагааг улсын хил

хамгаалах урлаг хэмээн тодорхойлно. Энэхүү урлагийн онол, арга зүйн үндсийг хил хамгаалах урлагийн онол судлах ёстой. Тэдгээрийг нэгтгэн үзвэл дараах байдлаар илэрхийлж болно:

Улсын хил хамгаалах урлаг гэж газар орон дээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах бэлтгэлийг хангах, түүнийг явуулах онол, практикийн нэгдэл буюу өөрөөр хэлбэл, хилийн орон зайд төр, нийгэм, иргэдийн ашиг сонирхлыг хамгаалах, хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг бэлтгэх, зохион байгуулж явуулахтай холбогдсон үйл ажиллагааны онол, практикийн цогц ойлголт мөн. (Арвай. Ш, Муратхан. А, Нямдорж. Д, Наранжамц. Н, 2016, 79 дэх тал)

Улсын хил хамгаалах урлагийн онол нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах сонирхлын үүднээс, хил хамгаалалтын олон төрлийн орчны нөхцөлд хэрэгжих үйл ажиллагааны зүй тогтол, зарчим, төрөл хэлбэр болон цэргийн болон бусад байгууллагын хүч, хэрэгслийг ашиглах арга зүйг судалдаг шинжлэх ухааны салбарын үндсэн бүтэц гэж үзэж болно.

Дээрх тодорхойлолтыг үндэслэн үзвэл, хил хамгаалах урлагийн онолын судалгааны объект нь төр, засаг захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, нутаг дэвсгэрийн нэгжүүд, хилийн болон ерөнхий зориулалтын цэрэг, мөн цэрэгжүүлсэн болон хил хамгаалалтад туслах үүрэгтэй бусад байгууллагууд, тэдгээрийн хүч, хэрэгсэл юм. Харин судлах зүйл нь эдгээр субъектүүдийн хүчин чадал, нөөцийг ашиглан улсын хил хамгаалалтад тавигдсан зорилтыг хэрэгжүүлэх, үүний тулд ямар арга, төрөл, хэлбэр, замыг хэрэглэх боломжтойг судлахад оршино.

Хил хамгаалалтын урлагийн бүтэц дотор хил хамгаалах оперативын урлаг нь голлох байр суурь эзэлдэг, мөн түүний салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм.

Хил цэргийн оператив урлаг гэдэг нь улсын хил, хилийн орон зайд төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг

хамгаалахад чиглэгдсэн ХЦ-ийн оператив бүлэглэлүүдийн /бүс нутгийн удирдах газар/ ажиллагааг бэлтгэж, явуулах онол, практикийн нэгдэл юм.

Хил хамгаалах оператив урлаг нь улсын хил хамгаалалтын урлагийн салшгүй, чухал хэсэг болохын хувьд тэрээр хилийн стратеги, хилийн цэргийн тактикийн завсарт холбогч үүрэг хүлээж стратегийн зорилтыг хэрэгжүүлэх, тактикийг төгөлдөржүүлэх, хил хамгаалалтын урлагийн онол, практикийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хил хамгаалах оперативын урлаг нь онол ба практикийн хоёр талт шинж чанартай үйл ажиллагаа юм. Онолын хүрээнд хилийн цэргийн оперативын бүлгүүдийн хэрэгжүүлэх хил хамгаалалтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулах, үр дүнг нь дээшлүүлэх чиглэлээр судалгаа, төлөвлөлт хийгддэг. Харин практик тал нь хилийн цэргийн бодит ажиллагаа, түүний удирдлага, зохион байгуулалт, цэргийн хангалт, дэмжлэг зэрэг асуудлыг хамардаг.

Хил хамгаалах урлагийн онол ба практикийн хүрээнд бүс нутгийн хүчний байгууллагуудын хүч хэрэгслийг уялдуулан ажиллуулах, улсын хилийг хамгаалж буй хилийн оператив-тактикийн нэгтгэл, ангиудын үйл ажиллагаа болон тэдгээрийн хүч хэрэгслийг удирдах, зохион байгуулах асуудал хамаардаг.

## 2.2. Хил хамгаалалтын оператив удирдлагын онцлог

Хил хамгаалалтын оператив удирдлага нь дараах шинж чанартай:

- Стратегийн зорилттой уялдсан – хил хамгаалалтын үйл ажиллагаа улс орны аюулгүй байдлын бодлого, батлан хамгаалах стратегитай шууд холбогдоно.





- Тактикийн хэрэгжилтэд нийцсэн – өдөр тутмын хяналт, шалгалт, цэрэг, тусгай хэрэгсэл ашиглах ажиллагаанд шууд нөлөөлнө.

- Технологи, мэдээлэлд тулгуурласан – тагнуул, хяналтын систем, мэдээллийн технологийг оператив төлөвлөлтөд ашиглана. ((IDF), 2020)

- Бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаатай нийцсэн – хил дамнасан гэмт хэрэг, аюулгүй байдлын сорилтод хамтарсан арга хэмжээ авах боломжтой.

Эдгээр онцлог нь Монгол Улсын хил хамгаалалтын нөхцөлд өргөн хэрэглэх боломжтой бөгөөд цаашид оператив урлагийн онолыг нутагшуулснаар хил хамгаалалтын үйл ажиллагааг оновчтой удирдах боломж бүрдэнэ.

### 2.3. Монгол Улсын хил хамгаалалтын онолын практик холболт

Монгол Улсын хил хамгаалалтын түүх, хилийн цэргийн үйл ажиллагааны жишээг авч үзвэл, оператив удирдлагын зарчим үе үе хэрэглэгдэж байсныг харж болно. 1945 оны Чөлөөлөх дайны үеэр хил хамгаалах хүчийг фронтын түвшинд дайчлан ашигласан нь оператив удирдлагын практик жишээ болж байсан.

Манай улсад хил хамгаалалтын бүтцийг авч үзвэл, стратегийн түвшинд Хил хамгаалах ерөнхий газар, тактикийн түвшинд хилийн отряд, застав, харуул, манаа зэрэг нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Харин оперативын түвшинд бие даасан бүтэц, байгууллага одоогоор үгүйлэгдэж байгаа нь анзаарагддаг.

1999–2003 оны хооронд хилийн цэргийн командлал болон холбогдох албан тушаалтнууд улсын хилийг нэг хэв загвараар, нийтлэг зарчим,

шаардлагад тулгуурлан зохион байгуулах нь тохиромжгүй гэж үзэн, хилийн цагийн байдал болон хил орчмын нутаг дэвсгэрийн онцлогт нийцсэн уян хатан бүтэц хэрэгтэй гэж дүгнэсэн. Үүний үр дүнд “Хилийн төлөөлөгчийн удирдах газар” байгуулагдаж, тодорхой хугацаанд үйл ажиллагаа явуулсан боловч, байгууллагын чиг үүргийн давхцал болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан үйл ажиллагаагаа зогсоожээ.

Одоогийн нөхцөлд хил хамгаалалтын ажиллагаа зөвхөн газар нутгийг хамгаалахаас гадна олон улсын аюулгүй байдал, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд өргөн хүрээтэй болж, оператив удирдлагын онол практикт зайлшгүй шаардагдаж байна.

### 2.4. Хилийн цэргийн оперативын урлагийг хөгжүүлэх асуудлууд, чиг хандлага нь:

- Оперативын урлагийн онолын үндсэн асуудлууд

- Улсын хил хамгаалалтыг оперативын түвшинд зохион байгуулах онол-практикийн асуудлууд

- хилийн болон тусгай операцийг бэлтгэн явуулах;

- оперативын хангалтын онол практикийн асуудал;

- цэргийг алс зайд шилжүүлэн бүлэглэх ажиллагааг бэлтгэн явуулах;

- Зэвсэгт хүчний хил халхлалтын нэгтгэл, анги, салбаруудтай харилцан ажиллагааны асуудал.

- Бүс нутгийн хамтын ажиллагаа – хил дамнасан гэмт хэрэг, терроризмтэй тэмцэх олон улсын хамтын ажиллагаа өргөжүүлэх;

- Дижиталжуулалт – ухаалаг технологи, хиймэл оюунд тулгуурласан мониторинг, хяналтын систем хөгжүүлэх;

Эдгээр чиг хандлага нь хил хамгаалах байгууллагад хилийн цэргийн оператив урлагийг хөгжүүлэх онолын үндэсийг бататгах, практик хэрэгжилтийг сайжруулах боломжийг олгоно.

### Дүгнэлт

Монгол Улсын газар зүйн онцлог, хүн амын бүтэц, байгууллагын зохион байгуулалт нь оператив үзэл баримтлал, төлөвлөлтийг оновчтой болгож хэрэглэх шаардлагатайг харуулж байгаа бөгөөд өнөөгийн бүтэц, үүрэг гүйцэтгэл зарим тохиолдолд шаардлагад нийцдэггүй.

Олон улсын туршлагаас харвал оператив түвшний төлөвлөлт, тагнуул-мэдээлэл, техник технологийн интеграци, олон талт хамтын ажиллагаа нь үр дүнтэй практик арга хэлбэр болж байна. Ийм арга олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдалд нийцүүлэн ашиглагдана гэж үзэж байна.

Манай улсын хил хамгаалалт нь түүхийнхээ явцад олон эрсдэл, сорилттой тулгарч байсан бөгөөд орчин үеийн хил хамгаалалтыг хөгжүүлэх шаардлага нэмэгдэж байна. Хилийн цэргийн оператив урлагийн судалгаа нь хил хамгаалалтын үйл ажиллагааг онол, практик дээр боловсронгуй болгох гарц, арга замыг олж харуулах боломжийг олгож байна гэж дүгнэж байна.

### Санал

1. Хилийн цэргийн оператив урлагийн хөгжлийг шинэ эрсдэл, сорилтуудтай уялдуулан гүнзгийрүүлэн судлах. *(Өнөөдөр хил дамнасан гэмт хэрэг, терроризм зэрэг аюулууд нь хил хамгаалалтын арга хэмжээг шинэ түвшинд шилжүүлэхийг шаарддаг)*

2. Монгол Улсын хил хамгаалалт нь онолын шинэчлэлтэй холбоотой бөгөөд үүнийг хөгжүүлэхийн тулд хил хамгаалалтад суурилсан удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох. *(Оператив урлагийг хил хамгаалалтын удирдлагад илүү нэвтрүүлэх нь стратегийн түвшинд оновчтой шийдвэрүүдийг гаргахад чухал үүрэг гүйцэтгэнэ)*

3. Хил хамгаалалт болон аюулгүй байдлыг хангах зөвлөмжүүдийг боловсруулж, үүний тулд бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг илүү сайн хөгжүүлэх. *(Бүс нутгийн хамтын ажиллагаанд тулгуурлан хил хамгаалалтын сайн туршилагуудыг нэвтрүүлэх, тусгайлан шинэ технологийг ашиглах нь чухал юм)*

4. Дижитал технологи, хиймэл оюун зэрэг орчин үеийн шийдлүүдийг хил хамгаалалтад нэвтрүүлж, мэдээллийн аюулгүй байдал, хяналтын тогтолцоог боловсронгуй болгох.

### Ашигласан материал

- (IDF), И. б. (2020). *Хил хамгаалалтын үзэл санаа*. Тель-Авив. [https://doi.org/IDF\\_publications](https://doi.org/IDF_publications)
- Арвай, Ш, Муратхан, А, Нямдорж, Д, Наранжамц, Н. (2016). *Улсын хил судлал, онол практикийн зарим асуудал*. Улаанбаатар.
- Свечин, А. (1927). *Стратеги*. Москва. <https://doi.org/Воениздат>
- Тухачевский, М. (1922). *Улсын цэргийн байгуулалт*. Москва. <https://doi.org/Воениздат>
- Түмэн, Б. (2005). *Ерөнхий цэргийн тактик, түүний хөгжил*. Улаанбаатар.
- Түмэн, Б, Наран-Очир, Б, Онцгойбаяр, Л, Ганзориг, Г. (2021). *Оперативын урлаг*. Улаанбаатар.
- Цэвэл, Я. (1966). *Монгол хэлний тайлбар толь*. Улаанбаатар.





current legal framework, and to propose further policy-based solutions and practical measures for improvement.

**Түлхүүр үгс:** Хилийн бүс, онцгой нөхцөл байдал, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, харилцан ажиллагаа.

**Keywords:** Border zone, state of emergency, state military organization, law enforcement agency, cooperation.

### Удиртгал

Олон улсын хэмжээнд цэрэг зэвсгийн болон эдийн засгийн томоохон өрсөлдөөн бий болж, газар нутгаа тэлэх, хөгжил буурай улс орнуудыг колончлох сонирхол давамгайлж буй өнөө цаг үед дэлхийн улс орнууд хилийн аюулгүй байдлыг хангах талаар өөр өөрийн гэсэн өвөрмөц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараа буюу 2002 онд АНУ-д Эх нутгийн аюулгүй байдлын департамент-Department of homeland security /DHS/ байгуулагдсан ба энэ департаментыг урьд нь тус тусдаа үйл ажиллагаа явуулдаг, тусдаа бүтэц удирдлагатай байсан 20 агентлагыг нийлүүлэн байгуулжээ. Үүнд Эргийн хамгаалалт, Цагаачлал иргэншлийн алба, Гааль, Нууц алба, Хилийн харуул, Холбооны гамшгийн менежментийн агентлаг зэрэг ордог бөгөөд АНУ-ын гурав дахь том департамент болоод байна.

Түүний хүчин чармайлтаар Border Searches, Effectiveness of Border Security, Border games, Border Management гэх мэт хилийн аюулгүй байдлын асуудлыг хөндсөн судалгаанууд хийгдэж эхэлсэн байна. АНУ-д аюул заналын түвшингээс хамаараад хилийн аюулгүй байдлыг хангах дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Үүнд:

-Хилийн менежмент (Border Management) Хилийн менежмент гэдэг нь хилийн болон хил орчмын

дэглэм сахиулах талаар авч хэрэгжүүлж байгаа хилийн салбар, хилийн манаануудын үйл ажиллагаа.

-Хил хамгаалах (Border safety) Хил хамгаалах гэдэг нь засгийн газраас зохион байгуулах хилийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагын үйл ажиллагаа.

-Хил манах (Border Control) Хил манах гэдэг нь хилийн анги, салбаруудын үйл ажиллагаа.

-Хилийн аюулгүй байдал (Border Security) Хилийн аюулгүй байдал гэдэг нь хилийн орон зайд гарсан хил дамнасан гэмт явдлаас урьдчилан сэргийлэх таслан зогсоох үйл ажиллагаа юм.

Дээрх тайлбаруудаас үзвэл хил хамгаалахыг ажил үүргийн хувьд улсын хил хамгаалалтад оролцуулахаар хуулиар үүрэг хүлээлгэсэн субъектүүдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, төрийн бодлогоор хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм.

Харин манай улсын хувьд төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагууд нь улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах үндсэн чиг үүрэгтэй байгууллагууд юм. Хилийн бүсэд байгалийн аюулт үзэгдэл тохиолдох, хүн мал, амьтан, ургамлын гаралтай халдварт өвчин тархах, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх, зэвсэггүй бөөн иргэн улсын хил зөрчсөн, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг илэрсэн үед үйл





ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх чухал хүчин зүйл болдог.

Цэргийн байгууллага нь улсын батлан хамгаалалтыг хангах бол хууль сахиулах байгууллага нь дотоодын аюулгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй бөгөөд тэдний уялдаа холбоо нь улс орны тогтвортой байдлыг хадгалах стратегийн ач холбогдолтой юм.

Тиймээс Улсын хилийн бүсэд онцгой нөхцөл байдал бий болсон үед дээрх байгууллагууд үр дүнтэй, хурдан шуурхай харилцан ажиллаж, тулгарсан нөхцөлийн хор хөнөөлийг бууруулахад чилгэсэн хамтын үйл ажиллагаа явуулах нь нэн чухал юм.

#### Үндсэн хэсэг

**Онцгой нөхцөл байдал түүний тухай ойлголт, хилийн бүс түүнд үүсэж болзошгүй аюул:**

Онцгой нөхцөл байдал нь хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, байгаль орчинд ноцтой хохирол учруулахуйц гэнэтийн болон аюулт үзэгдэл, осол, гамшиг, халдварт өвчин зэрэг нөхцөл үүсэхийг хэлнэ. Иймд төрийн болон орон нутгийн байгууллагууд шуурхай арга хэмжээ авч, нөхцөл байдлыг хэвийн болгох үүрэгтэй байдаг.

Төрийн тэргийн бодон хууль сахиулах байгууллагууд "Онцгой нөхцөл байдал" гэсэн ойлголтыг өөрсдийн хууль тогтоомжийн хүрээд өөр өөрийн ойлголтоор хэрлэж байна. Тухайлбал Хил хамгаалах, Цагдаагийн болон Зэвсэгт хүчний хэмжээнд "онцгой нөхцөл байдал" гэсэн нэр томъёог хэрэглэдэг бол. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага "хямралт байдал". Онцгой байдлын байгууллага "гамшиг" гэсэн нэр томъёог тус тус хэрэглэн хууль, эрх зүйн зохицуулалтад тусгасан байдаг.

"Онцгой байдал" гэдэг нь гамшгаас урьдчилан сэргийлэх болон түүнийг арилгах, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад төрийн төв байгууллага, холбогдох агентлаг, аж ахуйн нэгж, албан тушаалтнуудын хамтын ажиллагааг уялдуулж зохицуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг тусгай ажиллагаа явагдаж буй нөхцөл байдлыг илэрхийлдэг. (В. Жавхланцогт, Ж. Өвгөнбүргэд, 2017)

Харин "онцгой нөхцөл байдал" гэдэг нь тодорхой газар нутагт осол, байгалийн аюулт үзэгдэл, бусад гамшгийн улмаас хүний амь нас хохирох, эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзэх, эдийн засагт их хэмжээний хохирол учрах, хүн амын хэвийн амьдралын нөхцөл алдагдах зэрэг нөхцөл үүссэн байдлыг хэлдэг гэж тодорхойлсон байдаг. (Ганболд, 2010)

Онцгой нөхцөл байдал гэдэг нь улсын хэмжээнд буюу тодорхой нутаг дэвсгэрт хүний амь нас, эрүүл мэнд, нийгмийн хэв журам, эдийн засгийн аюулгүй байдал, байгаль орчинд заналхийлж болзошгүй эсвэл аль хэдийн гарсан томоохон аюул, гамшиг, үймээн, зөрчил, дайны байдал зэрэгт зориулан төрөөс тусгай дэглэм тогтоохыг хэлнэ.

Онцгой нөхцөл байдлын талаар доорх хуулиуд болон баримт бичгүүдэд дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно. Үүнд:

-Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул

учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

-Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.

-Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно гэж тусгасан байна. (Монгол Улсын Үндсэн хууль, 1992)


2.Онц байдал зарлах тухай хуульд Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг

хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ гэж тусгасан байна. (Онц байдлын тухай хууль, 1995)

3.Гамшгаас хамгаалах тухай хуульд Энэ хууль нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд онцгой байдлын байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах зөвлөл, онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэний оролцоог уялдуулан зохицуулах, зохион байгуулах, гамшгаас хамгаалах улсын хяналтыг хэрэгжүүлэх харилцаанд үйлчилнэ. (Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017)


4.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд /Монгол Улсын УИХ-ын 2010 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор батлагдсан/-ын “Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга, зам” гуравдугаар бүлэгт “Оршин тогтнохуйн аюулгүй байдал”-ыг “Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал, Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, Соёл иргэншлийн аюулгүй байдал”-аас бүрдэхээр заажээ.

А) ОХУ-ын Хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар улсын хилийг “манах”, “хамгаалах” ойлголтуудыг харьцуулбал:





Б) Их, багын харьцаанд оршигч, эзлэхүүнээр илэрхийлэгдэх ойлголтуудын хоорондын харьцааны логик ёсоор, улсын хилийг “манах”, “хамгаалах” ойлголтуудыг харьцуулбал:



**ХИЛИЙН ОРОН ЗАЙ:** Хилийн шугамын дагуу орших хилийн асуудалтай холбоо бүхий үзэгдэл, үйл явц, улс орны дотоодод хилийн хяналт хэрэгждэг тодорхой зааг, зурвас бүхий нийгэм-газар зүйн бүс. Түүнд хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэр, хилийн ус, агаар мандал болон агаарын зайн хонгил багтана.

Зураг 1. Улсын хилийг манах, хамгаалах ойлголтуудыг харьцуулсан бүдүүвч

Монгол Улсын хилийн тухай хуулинд хил орчмын нутаг дэвсгэр" гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг хэлнэ хэмээн тодорхойлсон байдаг. (Монгол Улсын хилийн тухай хууль, 2016)

Энэхүү хилийн бүсэд үүсэж болзошгүй аюулт үзэгдлүүдийг дараах төрлөөр ангилж болох юм. Үүнд:

1. Байгалийн аюулт үзэгдлүүд:

- Газар хөдлөлт – хилийн анги, салбар, харуулын барилга, инженерийн байгууламж, дэд бүтцэд хохирол учруулах;
- Үер, усны аюул – хил орчмын гол, нуур үерлэх, зам, байгууламжийг сүйтгэх;
- Гал түймэр гарах – хилийн анги, салбар, харуулын барилга, инженерийн байгууламж, дэд бүтэц, хил орчмын иргэдийн амь нас, эд хөрөнгөд хохирол учруулах, байгаль экологийн тэнцвэрт байдал алдагдах, хил дамнан тархах;
- Цасан болон шороон шуурга – зам хаагдах, хил орчмын ард иргэдийн

эрүүл мэнд амь нас эрсдэх, мал, эд хөрөнгөд хохирол учруулах;

- Хүн, малын гоц халдварт өвчин тархах – хилийн боомтоор зорчиж буй иргэд халдвар тээн хил нэвтэрч, халдварыг тархаах, малын зүй бус хорогдол үүсэж, малчдын амжиргаа буурах, хилийн боомтоор нэвтрэх бараа бүтээгдэхүүний экспорт, импорт буурах.

2. Нийгэм, улс төрийн шинжтэй онцгой нөхцөл байдал

- Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүсэх – хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эсэргүүцэх, улс төрөөс гаргасан шийдвэртэй үл нийцэх, эсвэл улс төрийн зорилгоор үүссэн.

- Хууль бус хил нэвтрэх оролдлого – зэвсэггүй бөөн иргэд улсын хил зөрчих, хууль бус наймаа;


3. Аюулгүй байдлын болон хууль сахиулах шинжтэй нөхцөлүүд

- Хууль бус зэвсэг, мансууруулах бодис, валют нэвтрүүлэх оролдлого;

- Тагнуул, диверсийн үйл ажиллагаа зэрэг нь хилийн бүс түүнд мөрдөх журмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулдаг;
  - Зохион байгуулалттай бүлэг этгээдүүд улсын хил зөрчих, зөрчихөөр оролдлого яюуулах, зорчигч, тээврийн хэрэгсэл барьцаалах зэрэг юм.
- Тиймээс Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон Оршин тогтнохуйн аюулгүй байдлын баталгаа “Хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдал”-ыг хангахын тулд, Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд /БХЯ, ГХЯ,

ХХЕГ, ЦЕГ, ОБЕГ, ТЕГ, ГЕГ/-тай нягт хамтын ажиллагаатайгаар, улс орныхоо хил хязгаарыг манаж, хамгаалах үндсэн үүрэгтэй Хил хамгаалах байгууллага хилийн цагийн байдлын өрнөлтийн ямарч нөхцөлд үүрэг гүйцэтгэх мэдлэг, дадлага, чадвартай, “хил хамгаалахад хэрэгтэй бүхэнд сургагдаж бэлтгэгдсэн” байх ёстой байна.

Тиймээс энэ аюулгүй байдлыг хил орчмын нутаг дэвсгэрт хангах асуудал дан ганц Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа биш бөгөөд төрийн цэргийн болон хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын үүрэг мөн юм.



**Зураг 2. Хилийн дэд бүтцийн бүрдлийг харуулсан бүдүүвч**

Дээрхээс үзэхэд хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй, бүрэн бүтэн байдлыг хангах /Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагууд/ улсын хилийг хамгаалахад цагийн байдлын өрнөлтийн үед улсын хил дээр үүсэх

дараах үүргүүдийг биелүүлэхээр харилцан туслалцаж, хамтран ажиллах оролцох эрх зүйн орчин бүрдсэн байна гэж үзэж болохоор байна.

Энэхүү эрх зүйн орчныг бид албыг урагшлуулах, ажлыг сайжруулах хөшүүрэг болгон ашиглаж чадвал





хилийг хамгаалах хүч нөөц, том боломж байгаа нь харагдаж байна. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийг хамгаалах асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрэн дүүрэн бүрдүүлэхийн зэрэгцээ одоо хэрэгжиж байгаа дээрх хуулийн заалтуудыг хэрэгжүүлээд эхэлбэл энэ асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдсэн байна гэж үзэх бүрэн үндэстэй юм.

### Дүгнэлт

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салашгүй хэсэг бол хилийн аюулгүй байдал билээ. Тиймээс улсын хилийг хамгаалах нь Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллага /Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль зааснаар: Байгаль орчныг хамгаалах алба, Гаалийн алба, Дипломат алба, Гамшгаас хамгаалах алба, Мэргэжлийн хяналтын алба, Зэвсэгт хүчин, бусад цэрэг, Татварын алба, Гаалийн алба, Тусгай алба, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн албан ёсны сайтад байрлуулснаар Батлан хамгаалах яам, Гадаад хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар/-уудын хүчээр хэрэгжүүлэгддэг үйл ажиллагаа болохоор тэдгээр байгууллагуудын үүргийг тодорхойлж эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудал нэн чухал юм.

Тухайлбал, ОХУ улсын хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг гүйцэтгэж хилийн хамгаалалтад оролцдог байгууллага 18 байгаа юм. Үүнд: Холбооны хилийн алба, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Дотоод хэргийн яам, Гадаадтай эдийн

засгийн талаар харилцах яам, Хамтын ажиллагааны яам, Үндэстнүүдийн асуудал хариуцсан яам, Тээврийн яам, Эрүүлийг хамгаалах яам, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний яам, Онцгой байдлын яам, Байгаль орчны улсын хороо, Улсын гаалийн хороо, Холбооны цагаачлалын алба, Холбооны аюулаас хамгаалах алба, Гадаад тагнуулын алба, Гадаад эдийн засгийн хороо энд орж байна.

Манай Улсын хувьд дээрх байгууллагуудад үндэсний аюулгүй байдлыг хангах нэгэн нийтлэг эрх ашиг, нэн хариуцлагатай үүргийг Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаар ноогдуулж байгаа болохоор нэгэн цэг дээр үйл ажиллагааг нь төвлөрүүлэх, нягт харилцан уялдаатай ажиллах эрх зүйн орчин байна гэж үзэх бүрэн үндэстэй юм. Тиймээс эдгээр хуулийг бүрэн хэрэгжүүлж, байгууллагуудын харилцан ажиллагааг илүү тодорхой болгох шаардлагатай гэж дүгнэлээ.

### Санал

1. Мэдээлэл солилцооны нэгдсэн систем бий болгох.

Хилийн бүсэд онцгой нөхцөл байдал үүсэхэд төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээ авах шуурхай байдлыг хангах зорилгоор дижитал командын нэгдсэн удирдлагын системийг нэвтрүүлэх.

2. Хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах.

Байгууллагуудын уялдаа холбоог сайжруулахын тулд жил бүр хилийн орчимд хамтарсан сургалт, дадлага, команд-штабын сургуулалтыг тогтмол явуулах.

3. Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

Хил орчмын сум, багийн иргэдийг мэдээлэл дамжуулах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд

оролцуулах, тэдний мэдлэг, хандлагыг дээшлүүлэх зорилгоор нийгмийн сургалт, ухуулга зохион байгуулах.

4. Судалгаа, эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх.

Хилийн бүсэд гарч болзошгүй аюул, гамшгийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлж, бодлого, төлөвлөлтөд ашиглах “эрсдэлийн газрын зураг” боловсруулан хэрэгжүүлэх зүйтэй гэсэн саналыг тус бүр дэвшүүлж байна.

#### Ашигласан материал

В. Жавхланцогт, Ж. Өвгөнбүргэд .

(2017). *Хилийн албанд ашиглагдах зарим нэр томъёоны тайлбар толь.*

Гамшгаас хамгаалах тухай хууль.

(2017). *Эрх зүйн мэдээллийн*

*нэгдсэн систем.*

<https://legalinfo.mn/mn/detail/12458>

Ганболд, Ц. (2010). *Хилийн нэр томъёоны тайлбар толь.*

(2010). *Монгол Улсын УИХ-ын 48 дугаар тогтоол.* Уб.

Монгол Улсын Үндсэн хууль. (1992).

*Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.*

<https://legalinfo.mn/mn/detail/367>

(1992). *Монгол Улсын Үндсэн хууль.* Уб.

Монгол Улсын хилийн тухай хууль.

(2016). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.*

<https://legalinfo.mn/mn/detail/12418>

Онц байдлын тухай хууль. (1995). *Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.*

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=433>





## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ГАЗАР ОРНЫ ОНЦЛОГ, БАЙГАЛЬ, ЦАГ УУР НӨЛӨӨЛӨХ НЬ

### THE IMPACT OF GEOGRAPHICAL FEATURES AND CLIMATE ON STATE BORDER PROTECTION

#### А.Энхзориг

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, Хилийн цэргийн 0165 дугаар анги, Хилийн төлөөлөгч, зөрчил шалган шийдвэрлэх ахлах ажилтан, ахмад

#### A. Enkhzorig

Master's student of the University of Internal Affairs, Border Guard, Border Guard Unit 0165, Senior Officer for Conflict Resolution, Captain

хариуцлагатай зохиогч: a.zorigoo0216@gmail.com

**Хураангуй:** Бүс нутгийн биологийн төрөл зүйл, байгаль орчныг хамгаалах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах чиглэлээр томоохон төслүүдийг Дэлхийн байгаль хамгаалах сангаас хэрэгжүүлж байна. Алтай-Соёны их уулсын Алтайн нурууны өмнөд төгсгөл нь манай улсын нутагт байрлах Монгол Алтайн нуруу болно. Алтай-Соёны уулын бүсэд хамрах хэсэг нь эрс тэс уур амьсгалтай, гол, горхиудын сүлжээ харьцангуй сайн, олон жилийн цэвдэг чулуулаг, уур амьсгалын үргэлжлэл бөгөөд бусад уул нуруудыг бодвол нийтдээ өндөр өргөгдсөн байдгаараа онцлогтой. (сан, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар 2025)

Энэ судалгаа нь уулархаг, хүйтэн бүс нутгийн газарзүйн онцлог, цаг уурын нөхцөлийн онцлог тэдгээр нь хил хамгаалалтад хэрхэн нөлөөлөхийг авч үзэж, хилчдийн дээрх нөхцөлд үүрэг гүйцэтгэх чадвар бэлтгэлжилтийг нэмэгдүүлэх боломжийг судлах зорилготой. Түүхэн уламжлалаас үзэхэд, уулын бүсэд хил хамгаалалтыг зохион байгуулахад хамгийн хүндрэлтэй байдаг нь сүүлийн 20 жилийн хилийн зөрчлийн судалгаанаас харагдаж байна. Хил хамгаалалт зохион байгуулахад газар орны нөхцөлд дасан зохицсон сургалт, тусгай хэрэгсэл, техник, технологийн шинэчлэлт зайлшгүй шаардлагатай байдаг. Дэлхийн газар нутгийн маргаантай буюу тогтворгүй 20 улсын 16 улс нь 2438 метрээс дээш өндөрт байрладаг бөгөөд эдгээр бүс нутагт улс хоорондын мөргөлдөөн, терроризм, зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг томоохон аюул давамгайлж, эсрэг талууд газар нутгийн давуу талыг ашиглан орчин үеийн технологийг хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг бууруулах боломжтойг олон орны туршлага харуулдаг. Иймд хил хамгаалах байгууллагын уулын бүсэд тохирсон сургалт, техник, технологийн хангамжийг бодит нөхцөлд суурилсан байдлаар боловсруулах шаардлагатай гэж үзэж байна.

**Abstract:** The Altai-Sayan mountainous region, recognized by the World Wide Fund for Nature (WWF) as one of the world's 200 critical ecoregions, is a focal point for significant conservation initiatives. The WWF spearheads projects aimed at preserving biodiversity, safeguarding the natural environment, and fostering socio-economic progress in this region. The southern terminus of the Altai Range within the Altai-Sayan system lies in Mongolia, referred to as the Mongolian Altai Range. This area is distinguished by its extreme continental climate, a well-developed hydrological

network of rivers and streams, extensive permafrost, and a continuous climatic gradient. Notably, it stands out for its considerable elevation relative to other mountain ranges.

This study investigates the geographical and climatic peculiarities of this cold, mountainous region and their implications for border security operations. It seeks to identify strategies to enhance the readiness and operational efficacy of border guards in these demanding conditions. Historical evidence, supported by border violation data from the past two decades, underscores the inherent challenges of maintaining border security in mountainous terrain. Effective border protection necessitates specialized training tailored to the local environment, alongside the integration of advanced equipment, tools, and cutting-edge technology. Among the 20 countries globally with contested or unstable territories, 16 are situated at elevations exceeding 2,438 meters. These high-altitude regions are prone to significant risks, including interstate conflicts, terrorism, and organized crime, where adversaries often exploit topographical advantages. International best practices demonstrate that modern technology can significantly mitigate violations of border and frontier regimes. Consequently, there is a pressing need to develop training programs, equipment, and technological infrastructure for border protection agencies, meticulously designed to align with the unique demands of mountainous environments and grounded in real-world operational contexts.

**Түлхүүр үгс:** хил хамгаалалт, уулархаг бүс, байгаль цаг уур, сургалт

**Keywords:** border protection, mountainous areas, nature and climate, training

### Удиртгал

Монгол Улсын 8252.6 км газар нутгийн нэгээхэн хэсэгт хамрагдах уулархаг бүсэд Баян-Өлгий, Увс, Ховд аймгийн нутагт байрлах хилийн отрядын хүч хэрэгслээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулж байна. Эдгээр хилийн отрядууд нь Монгол Улсын нийт хилийн хэсгийн 20,6 хувийг эзлэх боловч хилийн цагийн байдлын өрнөлт, хамгаалж буй хэсгийн физик газар зүйн онцлогоос шалтгаалж Хил хамгаалалтын нягтрал, онцлог, хүч хэрэгсэл, тэдгээрийн боломж уур амьсгалаас харилцан адилгүй байна. (Ж.Өвгөнбүргэд 2012)

Монгол Улсын Үндсэн хуулийн “Төр нь үндэсний аюулгүй байдал, аж ахуйн хэвшил, хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн заалтыг үндэслэл болгон боловсруулсан “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх арга

замыг боловсруулж, бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай Бүсчилсэн юм. орчныг бүрдүүлэх үндсийг тодорхойлсон хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах үндсэн арга зам нь Монгол Улсад эдийн засгийн бүсчлэл тогтоож, түүгээр бүс нутаг, хот, хөгжлийн хөдөөгийн дамжуулан харьцангуй бие цогцолборуудыг бүрдүүлэх явдал мөн. тогтолцоонд даасан суурилсан нэгдмэл, бүс нутгийн Уулархаг бүсийн улсын хилийн шугамын явалт нь ихэнх буюу усны хагалбараар хэсгүүдэд уул нурууны оройгоор тогтоогдсон тул хилийн шугам, багана тэмдгийг шалгахад ихээхэн хүндрэлийг үзүүлнэ. Хил хамгаалалтад тээврийн болон илрүүлэлтийн техник хэрэгсэл ашиглах, хяналт зохиох, Хилийн эрэл явуулах, хүч хэрэгслийг шилжүүлэн





байрлуулах, орон нутгийн байгууллагуудтай холбоо барих, харилцан мэдээлэл солилцох боломж ихэнх хэсгүүдэд хязгаарлагдмал. Өвлийн улиралд цасан шуурга олон жилийн дунджаар 6-7 удаа тохиолдох бөгөөд.

үүний дотор:

11-15 м/с хүчтэй шуурга 10 хувь;

6-10 м/с 20 хувь;

2-5 м/с 70 хувийн магадлалтай байдаг.

Цасан бүрхүүл нь өвлийн улиралд цас унасны улмаас тогтсон цас, мөсөн давхарга юм. Цасан өвлийн газрын гадарга дээр бүрхүүлийн нягт өвөл бага, хавар их байдаг. Учир нь цагт цасан бүрхүүл дээрх агаар хүчтэй хөрдөг бол хавар агаарын ихэнх дулаан цасан бүрхүүл хайлахад зарцуулагдана. Уулархаг бүсэд өвлийн улиралд цаг агаарын эсрэг циклоны нөхцөл ноёлох учраас жилийн хүйтэн улиралд хур тунадас бага /10-15 хувь/ унадаг зүй хадгалагдан тогтолтой. Харин тогтож цасан газрын цас орсон гол үүсэх бүрхүүл гадаргын цацрагийн баланс сөрөг байх гадаргад нөхцөл нь уг Ийм учраас явдал юм. уулархаг бүс нутагт 6,8 дугаар сард ч цас орох тохиолдол элбэг байна. Тус бүс нутагт тогтвортой цасан бүрхүүл 10 дугаар сарын дунд үеэс тогтож 4 дүгээр сарын эцсээр ханзардаг. Иймд тогтвортой цасан бүрхүүл 196 хоног түүнээс удаан хугацаагаар байх боломжтой нь судалгаанаас харагдаж байна.

### **Улсын хил хамгаалалтад газар орны онцлог, байгаль, цаг уур нөлөөлөх нь**

Евро-Азийн эх газрыг дамнан орших нурууд нь маннай оронд Увс, Говь-Алтай аймгийн баруун хэсгийг Ховд аймгийн ихэнх, тус тус хамарна. Баян-Өлгий аймгийн нутгийг бүхлээр нь, Монгол Алтайн нуруу далайн

төвшнээс дээш дунджаар 2300 метрт өргөгдөж улсын хилийн дагуу оршино. Үүнээс Монгол Алтайн нурууны хамгийн өндөр оргил болох Хүйтэн уул /4374м/, Цаст уул /4193 м/, Таванбогд /4082м/, Мөнххайрхан /4204 м/ зэрэг 4000- аас дээш өргөгдсөн өндөр уулс юм. Эдгээр өндөр уулс, нутаг дэвсгэрийн хойноосоо урагшаа 1200 км үргэлжлэх байгалийн цогцолбор газрын шинж төрх нь он удаан жилийн турш хувьсан өөрчлөгдөж буйтай холбоотой өргөрөгийн хэд хэдэн бүс орших боломжтой. Байгалийн бүс нь гадаргын бүслүүрийн хүрээнд буюу хуурай газрын байгалийн цогцолбор газар гэж ялган авч үзэж буй физик газар зүйн ангилалын дээд нэгж, бүслүүр нь өндөр ууланд үүсдэг уулын бэлээс орой хүртэл байгалийн нөхцөл, төрх байдал солигдох зүй тогтолыг тус тус хэлнэ Монгол орон өргөн уудам нутагтай, уул нуруу, хотгор гүдгэр гадаргатай, эх газрын эрс тэс уур амьсгалтай учраас байгалийн 2 бүслүүр, 4 бүсэд оршдог.

Монгол орны нутгийн дийлэнх хэсгээр ялзмаг хөрстэй, уулын хэсэгтээ цэвдэгтэй, говийн их хэсгийн хөрсний хувьд нь 50 хувь нь говийн бор хөрстэй. Үүнийгээ дагаад ургамалын хувьд цөлөрхөг хээрийн, цөлийн гэсэн хуваагддаг. Уулын хэсгээрээ өвөлдөө - 40 хэм хүртэл хүйтэрч, зундаа 40 хэм хүртэл хоёр бүсэд халдаг. Хур тунадас жилдээ 250-350 мм орчим унадаг. (Ж.Өвгөнбүргэд 2012)

Дээрх онцлогуудаас хамаарч байгалийн бартаа, саад нь хилийн хэсгүүдэд харилцан адилгүйгээр оршиж, хил хамгаалах үйл ажиллагаанд чухал нөлөөллүүдийг үзүүлж байдаг. Тактик шинжээр нь байгалийн бартаа, саадыг үзүүлж буй нөлөөллөөр нь их бартаатай, дунд зэргийн бартаатай, сулавтар буюу бага бартаатай гэж гурав

ангилж авч үздэг бөгөөд өөр өөрийн онцлогуудтай байдаг.

Цаг агаарын эрс тэс өөрчлөлт газар орны бартаа, саад нь хилийн манаанд дараах нөлөөллийг үзүүлнэ. Хилийн манаа уул хадан дунд хөдөлгөөн үйлдэхэд 10°-ын өнцөг бүхий налуууд 2-3 км/цаг, 20° хүртэл бол 1-1,5 км/цаг, түүнээс дээш налуу бүхий уулын ар, энгэрт 1 км/цаг хурдтай явах нөхцөл үүснэ. Газар орныг баримжаалах зай бодит байдлаас 1,5-2 дахин буурна;

Эгц хадан хясаа, хавцал, гүнзгий жалга, өндөр оргил бүхий уул нуруу, хөтөл даваатай хэсэгт цэргийн хяналт тогтмол явуулах боломж эрс багасна; Дулааны улиралд уулын цас мөс хайлж, бороо их орсноос халтиргаа нуранги үүсэх, голын урсгал ширүүсэж, гатлахад хүндрэлтэй болж, газрын хөрсийг эвдэж, үерлэх, аянга буух, манан татсанаас хилийн манааны үүрэг гүйцэтгэлд хүндрэл учруулна; Хүйтний улиралд цас ихээр унах, байнга шуурснаас гуу жалга цасаар дүүрэх, хад асга, эрэг дээр цас тогсоноос нуралт болж халтиргаа гулгаа үүснэ. Холын зайд ажиглалт хийх, хил зөрчигчийг мөрдөх, байршлыг тогтоох боломж хязгаарлагдмал ба гэмт этгээдүүдийн зүгээс хилийн манааг отолт хийх, зэвсэгт эсэргүүцэлд өртөх магадлал өндөр;

Эрэл зохион байгуулах, газар оронд үзлэг шалгалт хийхэд тухайн орон нутгийн ард иргэдийг газарчнаар оролцуулах, үүний зэрэгцээ уул хаданд явж сурсан агт уналга, бусад зүтгэх хүч, тусгай зориулалтын хэрэгслүүд шаардлагатай болно. Уулархаг бүсийн хилийн отрядын хяналтын нэгдсэн төлөвлөгөөнөөс үзэхэд хилийн отрядын хариуцсан хэсгийн дөнгөж 43,2-58,9 хувь нь хяналтад хамрагдах боломжтой бөгөөд улирал, цаг агаарын байдлыг сайтар судалж үүрэг гүйцэтгэх. Жишээлбэл: Говь цөлийн

болон уулархаг бүсийн цаг Уур харьцуулсан дараах судалгаанаас дүгнэлт хийж Хил хамгаалах албанд хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй.

Цаг агаарын эрс тэс өөрчлөлт нь хилийн манаанд дараах нөлөөллийг үзүүлнэ. Үүнд: Хилийн манаа уул хадан дунд өгсөж уруудахад 10°-ын өнцөг бүхий налуууд 2-3 км/цаг, 20° хүртэл бол 1-1,5 км/цаг, түүнээс дээш налуу бүхий уулын ар, энгэрт 1 км/цаг хурдтай явах нөхцөл үүснэ. Газар орныг баримжаалах зай бодит байдлаас 1,5-2 дахин буурна; **(Б.Мөнгөнбагана 2025)**

Эгц хадан хясаа, хавцал, гүнзгий жалга, өндөр оргил бүхий уул нуруу, хөтөл даваатай хэсэгт цэргийн хяналт тогтмол явуулах боломж эрс багасна.

Дулааны улиралд уулын цас мөс хайлж, бороо их орсноос голын урсгал ширүүсэж, гатлахад хүндрэлтэй болж, газрын хөрсийг эвдэж, халтиргаа нуранги үүсэх, үерлэх, аянга буух, манан татсанаас хилийн манааны үүрэг гүйцэтгэлд хүндрэл учруулна;

Хүйтний улиралд цас ихээр унах, байнга шуурснаас гуу жалга цасаар дүүрэх, хад асга, эрэг дээр цас өнгийн тогтсоноос нуралт болж халтиргаа гулгаа үүснэ;

Холын зайд ажиглалт хийх, Хил зөрчигчийг мөрдөх, байршлыг тогтоох боломж хязгаарлагдмал ба гэмт этгээдүүдийн зүгээс отолт хийх, зэвсэгт эсэргүүцэлд өртөх магадлал өндөр;

Эрэл хайгуул явуулах, газар оронд үзлэг шалгалт хийхэд тухайн орон нутгийн иргэдийг газарчнаар оролцуулах, үүний зэрэгцээ уул хаданд явж сурсан агт уналга, бусад зүтгэх хүч, тусгай зориулалтын хэрэгслүүд шаардлагатай болно. Уулархаг бүсийн хилийн отрядын хяналтын нэгдсэн төлөвлөгөөнөөс үзэхэд хилийн отрядын хариуцсан хэсгийн дөнгөж 43,2-58,9 хувь нь хяналтад хамрагдах





ᠬᠢᠯᠢ ᠰᠤᠳᠯᠠᠯ

боломжтой бөгөөд өвлийн улиралд 2-3 дахин буурах төлөвтэй.

Хүйтэн сэрүүний улирал нь хил хамгаалалтад үзүүлэх эерэг нөлөөлөл:

Хил зөрчигчид нь уулын ам, хөндий, давааг ашигладаг тул хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлийг тогтооход дөхөмтэй бөгөөд тухайн хэсэгт цасан зурвас тогтсоноос ул мөрийг хянах боломжтой;

Цас их унаж, уулын даваа, гүвээ, зам харгуй хаагдаж, хоёр талаас хөдөлгөөн ажиллагаа үйлдэх боломжгүй болсноор цагийн байдлын өрнөлт багасаж, хил хамгаалалтыг заставууд цөөн тооны хүчээр зохион байгуулах нөхцөл бүрддэг;

Газар оронд үзлэг шалгалт хийх боломж хомс боловч хүн, мал, амьтны хөдөлгөөнийг илрүүлэх зорилгоор уулын ам, даваа гүвээ, хавцлыг хяналтад авах, ашигтай байрлал эзэлж отох, бүслэн хаах, төрөл бүрийн саад хаалтыг байгуулах боломжтой;

Хилчдийн хилд үүрэг гүйцэтгэх ачаалал хөнгөрч, бүх шатны хичээл сургууль, дадлага нормативыг нэгдсэн журмаар Зохион байгуулах боломж бүрдэнэ;

Хянах манааны өндөрлөгүүдээс гэгээтэй цагт хяналт зохион байгуулж, үйлдэл хөдөлгөөнийг илрүүлэх, шийдвэрлэхэд таатай нөлөө үзүүлнэ.

Уулархаг бүсэд хамрагддаг хилийн заставууд улсын хилийн дагуу үүрэг гүйцэтгэхэд автомашин, техник хэрэгсэл ашиглах боломжгүй.

Уулархаг бүсэд цаг агаар огцом, тогтворгүй шинжтэй бөгөөд энэ нь хангалт зохион байгуулах, хөдөлгөөн үйлдэх, орчны аюулгүй байдалд ноцтой саад болдог. Жишээлбэл:

Цасан шуурга, үер, шавар, нуранги зэрэг нь газар орны нөхцөлд хүнд нөлөө үзүүлдэг.

Зарим бүсэд нэгэн зэрэг хэд хэдэн төрлийн уур амьсгал, экосистем

оршдог нь тактикийн хувьд хүндрэл үүсгэнэ.

Тэгш бус гадаргуу, эгц налуу, хадан цохио, гүн хавцал нь явган болон механикжсан нэгжүүдийн маневрт нөлөөлдөг.

### Уулын бүсийн ангилал

Хөндий, голын сав газар, холбооны шугамын дагуу орших энэхүү бүс нь хуягт болон явган ангийн хамтарсан ажиллагаа явуулах боломжтой боловч маневрын талбай хязгаарлагдмал. Амин чухал ТТГ (тактикийн түвшний газрын) ихэнх нь зам, жим, хурдны шугам дагуу оршдог.

Уулын оргил хэсэг, ноёрхол бүхий өндөрлөгт байрлах бөгөөд хамгийн төвөгтэй маневрын орчин юм. Гэсэн хэдий ч ахисан түвшний уулын бэлтгэлтэй нэгжүүд энэ бүсэд байрлаж, дайсны ар тал, жигүүрт нэвтрэх, командлалын цэгүүд, логистикийн байгууламжуудыг устгах зэрэг өндөр үр ашиг бүхий ажиллагаа гүйцэтгэж чадна.

Хүйтэн бүс нутаг нь жилийн турш хасах температур давамгайлж, цас ихээр унадаг, мөсөн бүрхүүл тогтдог, хатуу нөхцөл бүхий орчин бөгөөд дэлхийн хуурай газрын дөрөвний нэгийг хамардаг.

Нойтон хүйтэн (Цельсийн +4 – -7°C)

Хуурай хүйтэн (-7 – -20°C)

Хүчтэй хүйтэн (-20 – -32°C)

Хэт хүйтэн (-32 – -40°C)

(Б.Мөнгөнбагана 2025)

Аюултай хүйтэн (-40°C ба түүнээс доош) Нойтон хүйтэн нөхцөл нь амьдрах, үйл ажиллагаа явуулахад хамгийн хүнд бөгөөд хувцас, техник хэрэгсэл тасралтгүй чийгт автдаг. Ус нь дулааныг агаараас 25 дахин хурдан дамжуулдаг тул хүний биеийн үндсэн температур хэтэрхий хурдан буурч, даарч осгох, хөлдөх, тоног төхөөрөмжийн эвдрэл зэрэг ноцтой

эрсдэл үүсдэг. Харин хуурай хүйтэн нь чийг бага, гадаргуу тогтвортой байдгаараа харьцангуй амьдрах орчинд хөнгөнд тооцогддог.

### Дүгнэлт

Хил хамгаалалтад уналга, тээврийн хэрэгсэл ашиглах боломж хязгаарлагдмал, цаг агаарын огцом өөрчлөлттэй үед төөрөх, осгох, цасны нурангид өртөх аюултай;

Орон нутагт байрлах харилцан ажиллагаатай байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай үед тэдний хүч хэрэгслийг татан авах боломж хязгаарлагдмал;

Хүч хэрэгслийг шилжүүлэн байрлуулах, бүлэглэх, маневр үйлдэхэд төвөгтэй бөгөөд цагийн байдал хурцадсан үед эрэл зохион байгуулахад хүндрэлтэй;

Цасан шуурганы нөлөөгөөр зам хаагдаж халтиргаа гулгаа үүссэнээс өөрчлөгдөнө; манааны Хилийн үүрэг гүйцэтгэх хугацаа, замнал.

Хилийн эмнэлгийн хүндрэлтэй; бүх төрлийн хүрэх хэмжээ арга харуулд застав, бусад яаралтай тусламж хангалт, авахад хүндрэлтэй.

Нэг цэгээс хяналтад хамрагдах хэсэг багасна;

Өндөр уул нь 25 хэмээс эгц уулын хажуу, нуруу, хяруудаас бүрдсэн байх бөгөөд 2500-3000 метрээс дээш мөнх цас, мөсөөр хучмал байхаас гадна уулын хавцлууд цасаар дүүрч, цасны зузаан нь метр тохиолдол хүрэх гарна. Дээрх шалтгаан хилийн багана, тэмдгүүдийн ихэнхийг шалгах 4-10 нөхцөлүүдээс боломжгүй болдог; (Б.Мөнгөнбагана 2025)

Хилд үүрэг гүйцэтгэх автотехник тал хээрийн бүсээс даац 20-25 хувь, хурд хоёр дахин багасаж, шатахуун зарцуулалт 75- хувиар ихсэж, агаарын даралт 1.2 хувиар сийрэгжин механик эвдрэл ихэсдэг.

Агаарын урсгал огцом өөрчлөгдөх, хүчтэй салхи ихтэй учир нисэгчгүй нисэх хэрэгслээр үзлэг хийхэд эрсдэлтэй.

Хил зөрчигчийг мөрдөн хөөх эрлийн бүлгийн өгсөж уруудах хурд 10°-ын өнцөгтэй уулын налуу газарт 4-5км, 20° хүртэл бол 2-3км, 30° бол 1,5-2км цагийн хурдтай байна. Харин автомашины хурд 10-15° бүхий налуутай газар оронд 8-12км/ц, 15-20° налууд 5-8км/ц хурдтай явах бөгөөд замын нугачаа, халтиргаа зэрэг нь хурд буурахад ихээхэн нөлөөлнө.

### Санал

Өвлийн улирал буюу 10 дугаар сараас хавар 3-4 дугаар сар хүртэл байгалиараа хамгаалагддаг цас ихтэй хүрэхэд хүндрэлтэй, эрсдэлтэй зарим хилийн заставуудыг түр хугацаагаар буулгах, хилийн цагийн байдлын өрнөлттэй, зөрчил ихтэй хэсэгт бүлэглэн шилжүүлж үүрэг гүйцэтгүүлэх, сургалт, бэлтгэлд хамруулах, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд хамруулах гэх мэт. Эсхүл хилийн салбарын тодорхой бүрэлдэхүүнийг буюу удирдлагын бүрэлдэхүүнээс бусад бүрэлдэхүүнийг ээлжийн журмаар үүрэг гүйцэтгүүлэх. Орон нутгийн ард иргэд, Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг хил хамгаалалтад идэвхтэй оролцуулах. Оролцуулахдаа өрх, хот айлаар нь хэсэг болгон хил хамгаалалтад оролцох график гарган оролцуулах.

Хил хамгаалалтад тогтмол идэвхтэй оролцож буй орон нутгийн ард иргэд, хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг урамшуулах, цалинжуулах.

Орон нутгийн уугуул иргэдийг улсын хилийн хэсэгт тогтмол суурьших боломжоор хангаж хил хамгаалалтад





оролцуулан, цалин урамшуулал олгож идэвхжүүлэх.

Алслагдсан хүрэхэд хүндрэлтэй хэсгүүдэд теле хяналтын камер суурилуулах.

Инженерийн байгууламжийг нэмэгдүүлэх, өвлийн улиралд тодорхой хэсгүүдэд цасан зурвас байгуулж хил хамгаалалтад үр дүнтэй ашиглах.

Хилийн салбаруудад орчин үеийн техник технологийн ололтыг нэвтрүүлэх нь зүйтэй юм. Үүнд туулах чадвар сайтай цасны мотоцикл, газар уснаа явагчаар хангах, хүчин хол зайд нислэг үйлдэх чадвартай нисэгчгүй нисэх хэрэгслээр хангаж сургалтад хамруулж чадварлаг эзэмшүүлэх саналыг дэвшүүлж байна.

### Ашигласан материал

1. Б.Мөнгөнбагана. 2025. “Алслагдсан хэсгийн хилийн заставын хил хамгаалалт. 2017.” 15.
2. Ж.Өвгөнбүргэд. 2012. Уулархаг бүсийн хил хамгаалалт.
3. Н.Ганбаатар. 2025. bpo.gov.mn. 10 10. <https://www.gov.mn/mn/organization/bpo>.сан, Дэлхийн байгаль хамгаалах. 2025. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар. 10 10. <https://mongolia.panda.org/>.-2025.Дэлхийн байгаль хамгаалах сан. 03 20.

# ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АЖИЛЛАГАА БА ТЕХНОЛОГИЙН УЯЛДАА ХОЛБОО, УЛАМЖЛАЛ

## ENSURING THE SECURITY OF DETENTION FACILITIES: OPERATIONAL AND TECHNOLOGICAL COORDINATION AND DEVELOPMENT



Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологийн уялдаа холбоо, уламжлал

### А.Анхжаргал

Сургалт, судалгааны 403 дугаар анги-Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 2024-7051 дүгээр дамжааны магистрант, ахмад

### А. Ankhjargal

Captain, Master's student of Distance Program No. 2024–7051, Class 403 (Training and Research Division), School of Court Decision Enforcement, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: aanxjargal@gmail.com

**Хураангуй:** Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологийн уялдаа холбоо, уламжлал сэдэвт өгүүллийн хүрээнд хэд хэдэн үндсэн асуудлыг хөндөхийг зорьсон. Эхний дугаарт хорих байгууллагын аюулгүй байдал хэмээх ойлголтыг тодруулах, аюулгүй байдлыг хангах ажиллагааны мөн чанар, хүрээг судласан. Дараагийн дугаарт технологи хэмээх ойлголтын агуулга, мөн чанарыг тодруулахыг зорьсон ба ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал технологи хоёр хэрхэн уялдаг талаар ерөнхий ойлголтыг уншигчдад хүргэх болно. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн хэрэглээний асуудлыг оновчтой, эргэлзээгүйгээр таниулах, судлах боломж бүрдэх юм.

**Abstract:** The article titled “The Relationship Between Prison Security Operations and Technology, and Their Traditions” aims to address several key issues. In the first part, it seeks to define the concept of prison security and to study the nature and scope of security operations. In the following section, it focuses on clarifying the concept and essence of technology, thereby providing readers with a general understanding of how prison security and technology are interrelated. Through this approach, the article intends to present and examine the application of technology in ensuring prison security in an objective and unambiguous manner.

**Түлхүүр үгс:** Аюулгүй байдал, хүний эрх, хэрэгцээ, ажиллагаа, арга зүй, хэвийн үйл ажиллагаа, хөгжил.

**Keywords:** Security, human rights, needs, operation, methodology, normal operation, development.

### Удиртгал

Манай улс нь төрт ёсны түүхийн арвин уламжлалтай бөгөөд төрийн чиг үүргийг хэрэгжүүлж арга зүй, эртнээс бие даан явуулж ирсэн соёлтой. Үүний нэг томоохон хэсэг нь хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж

ирсэн явдал юм. Тэгвэл энэхүү өгүүлээр хорих ял эдлүүлэх ажиллагааны аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба технологи хоёрын харилцах хамаарал, уялдаа холбоог судлах болно.

Хорих байгууллагын үйл ажиллагааг тогтвортой, хэвийн



явуулахад тус байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ихээхэн чухал бөгөөд шинжлэх ухааны мэдлэг, технологийн шийдлийг уялдуулах асуудал хорих байгууллагын хөгжлийн бүхий цаг үед хамтран хөгжиж ирсэн.

Гэсэн хэдий ч хорих байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах ажиллагаа хийгээд технологийн ойлголт агуулыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүй болоод аюулгүй байдал судлал, технологийн салбарын судлаач, шинжээчид нарийвчлан авч үзээгүй бөгөөд ерөнхий ойлголтод тулгуурлан хэрэглэж, хуульчилж, практик эргэлтэд оруулж ирсэн.

Иймд хорих байгууллагын аюулгүй байдлын ойлголт, хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааны хандлага чиглэлийг тодорхойлох, цаашлаад байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн ойлголтыг судлан, таньж мэдэх, хийдэл бүхий ойлголтуудыг нэгтгэх шаардлагатай.

Өгүүллийн хүрээнд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа ба хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологи гэсэн үндсэн хоёр агуулгын хүрээнд судласан. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал ба технологийн ойлголтыг зөв хэрэглэх, практик үйл ажиллагаанд оновчтой ашиглах боломж бүрдэнэ.

### **I. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь үндэсний аюулгүй байдал хийгээд, дотоод аюулгүй байдлыг хангах салбарт онцгой байр суурь бүхий төрийн байгууллага билээ. Иймд уг байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсгүүдтэй уялдах гарцаагүй.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хүний эрх, эрх чөлөөг хангаж, үндсэн хуульт байгууллыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрийн удирдлагыг бэхжүүлж, улс төрийн нам, иргэний нийгмийн байгууллага, чөлөөт хэвлэл мэдээллийн төлөвшлийг дэмжиж, нийгмийн дэг журам, тогтвортой байдлыг хангах нь дотоод аюулгүй байдлын үндэс мөн.” хэмээн тусгасан (УИХ-ын Тамгын газар, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай, 2010). Энд заасан хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журмыг хангах асуудал хорих байгууллагын үндсэн чиг үүрэг болох бөгөөд үүнд технологийн шийдлийг хэрхэн ашиглаж байгаад дүн шинжилгээ хийнэ. Учир нь өнөөдөр бидний хандлага, сэтгэхүйд тогтсон үзлээр бол аюулгүй байдал бол гэмт хэрэг, зөрчлөөс хамгаалагдах асуудал болоод байгаа бөгөөд өгүүллийн гол санаа нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах буюу хорих байгууллага дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан ажиллагаанд технологи ашиглах бус хорих байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулахад ашиглаж ирсэн технологийн шийдлийн талаар өгүүлэх болно.

Иймд өгүүллийн хүрээнд аюулгүй байдал хэмээх ойлголтын үндсэн утга, мөн чанарыг таньж мэдэхээс эхлэх нь зүйтэй.

Аюулгүй байдал судлалын асуудал нь дан ганц гэмт хэрэг, зөрчил, халдлагад хамаарахгүй бөгөөд тухайн хамгаалагдаж байгаа зүйлийн ашиг сонирхол, үндсэн хэрэгцээнд суурилж байдаг өвөрмөц онцлогтой. Нэг үгээр аюулгүй байдал хэмээх ойлголт нь судлагдаж байгаа объектынхоо хэрэгцээ хангагдах, хэвийн үйл





судалгааны агуулгаас товчлон хүргэе. Тухайлбал хорих байгууллагын аюулгүй байдал гэж хорих байгууллагын гадаад, дотоод сөрөг нөлөөллөөс хамгаалагдах хэрэгцээ хангагдаж, аюул, занал, эрсдэлт нөхцөл байдлыг урьдчилан судлах, үнэлэх, хор аюулыг бууруулах, таслан зогсоох, арилгах, урьдчилан сэргийлэх зорилт бүхий цогц арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж, үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хөгжих нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ” гэжээ (Ц.Очгэрэл, 2017). Уг тодорхойлолтоос үзвэл дээр дурдсанчлан хорих байгууллагын аюулгүй байдал бол ерөнхий агуулгаараа төлөв байдал болох нь харагдаж байгаа бөгөөд тэрхүү төлөв байдал нь тодорхой шинжүүдийг агуулсанаар хорих байгууллагын аюулгүй байдал гэх ойлголт нь бүрэн хэлбэржиж байна.

Үүнд “хэрэгцээ хангагдсан байх”, “аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэгдсэн байх”, “таслан зогсоох, арилгах арга хэмжээ авагдсан байх” гэсэн шинжүүдийг заажээ. Эдгээр шинжүүд нь өгүүллийн эхний хэсэгт дурдсан обьектив болон субъектив агуулгыг аль алиныг агуулсан байна. Ингэснээр хорих байгууллагын аюулгүй байдал нь хорих байгууллагын зорилго, чиг үүрэг хэрэгжихэд шаардлагатай бүхий хэрэгцээ болоод тэрхүү хэрэгцээг хамгаалах цогц арга хэмжээ авагдсанаар хэмжигдэж байна. Гэсэн хэдий ч аюулгүй байдал нь аюулгүй байх хийсвэр ойлголтыг тодорхойлсон бөгөөд тэрхүү хийсвэр ойлголтыг бодит болгоход чиглэсэн арга хэмжээ авагдсан байх төлөв юм. Харин байдал нь тэрхүү хийсвэр ойлголтод хэрхэн ойртож хэрэгжсэнээр хэмжигдэх зүй тогтолтой юм.

Дээрх агуулгыг дурдсаны шалтгаан нь бидний дундах аюулгүй байдлын хэвшмэл хандлага буюу аюулгүй

байдал хэмээх үгийн нийтлэг хэрэглээтэй холбоотойгоор зөвхөн хорих байгууллагын харуул хамгаалалтад уг сэдвийг чиглүүлдэгтэй холбоотой. Иймд энэхүү хэвшмэл хандлагыг оновчлох үүднээс дурдсан болохыг анхаарах хэрэгтэй.

Аюулгүй байдал хэмээх ойлголтын үг зүйн хөгжил болоод эрдэмтдийн аюулгүй байдал хэмээх ухагдахуунд суурилан авч үзвэл “хорих байгууллагын аюулгүй байдал бол хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааны төлөв бөгөөд ингэхдээ хорих байгууллагын хэрэгцээ хангагдсан, тэрхүү хэрэгцээнд нөлөөлж болох аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалагдсан байх явдал” болж байна.

Өгүүллийн хүрээнд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагааг тодорхойлох асуудал тулгарч байгаа бөгөөд аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь түүнийг хангахад чиглэсэн цогц арга хэмжээ болох нь харагдаж байна. Учир нь ажиллагаа гэдэг үгийг зохион байгуулалттай хийж гүйцэтгэх ажил гэж үзсэн (www.Menksoft.com, 2016). Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тус байгууллагын хэрэгцээ хангах, урьдчилан сэргийлэх, хамгаалахад чиглэсэн ажиллагааг гүйцэтгэхэд чиглэсэн зохион байгуулалттай ажил юм. Уг агуулгыг сөрөг нөлөөлөл бүхий хүчин зүйл, аюул заналаас үүдэлтэй үйл явцыг судлан тогтоох, хор уршгийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх цогц ажиллагаа болохыг доктор Ц.Очгэрэл тодорхойлсон (Ц.Очгэрэл, 2017). Энэхүү үзэл санаатай судлаачийн хувьд санал нэг байгаа бөгөөд хорих байгууллагын хэрэгцээг хангахын тулд хорих байгууллагын хэрэгцээг судлах, түүнд сөргөөр нөлөөлөх аюул, заналыг судлах, үр дагаварыг бууруулах,

тэмцэхэд чиглэсэн арга хэмжээнүүд болох нь харагдаж байна.

Ийнхүү хорих байгууллагын аюулгүй байдал болон аюулгүй байдлыг хангах ажиллагааг судлан шинжилснээр тухайн ажиллагаанд шаардлагатай техник, технологийн шийдлийг тодорхойлох боломж бүрдэнэ. Харин ингэж ойлголтыг бүрэн тодорхойлохгүйгээр аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хамаарах технологийн шийдлийг өрөөсгөл түвшинд авч үзэх эрсдэл тулгарах юм. Яг энэхүү агуулгыг хуульд тусгахдаа дараах ажиллагаанаас бүрдэнэ хэмээн үзжээ. Үүнд:

1. Аюулгүй байдлын удирдлага, зохион байгуулалт
2. Техникийн хяналт, хамгаалалт
3. Биечилсэн хяналт, хамгаалалт
4. Аюулгүй байдлын түвшин, эрсдэлийг үнэлэх
5. Гүйцэтгэх ажил зэргийг заасан (УИХ-ын Тамгын газар, 2017) ба эдгээр дээр хоригдолд үзүүлэх нөлөөллийн арга хэмжээг хамааруулж болохоор тусгасан.

Эдгээр нь арга хэмжээ нь хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, хорих байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээнүүд байгаа бөгөөд миний өгүүллийн хүрээнд дэвшүүлж үзэл санаатай тохирч байгаа юм.

Иймд эдгээр арга хэмжээнд орчин цагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага технологийн шийдлийг хэрхэн ашиглаж ирснийг судлая.

## **II. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа технологийн ойлголт**

Энэхүү өгүүллээр аюулгүй байдал, технологийн ойлголтыг нарийвчлан авч үзэхийн зэрэгцээ орчин үеийн технологийн ангилалд тулгуурлан

хорих байгууллагын аюулгүй байдал, технологийн хэрэглээг түүхэн баримтын хүрээнд тайлбарласнаараа онцлог юм.

Манай улсын орчин цагийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа буюу хорих ял эдлүүлэх ажиллагаа, хорих байгууллагын түүхэн хөгжлийг 1921 он буюу ардын хувьсгалтай нас чацуу гэж үздэг. Иймд 1921 оноос хойшхи түүхийн баримтуудад хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд технологийн шийдлийг хэрхэн ашиглаж байсныг тодорхойлоё.

Үүний тулд юуны түрүүнд технологи хэмээх ойлголтыг нэг мөр авч үзэх хэрэгтэй. Технологи хэмээх ойлголт нь дан ганц инженерчлэлийн шийдэл биш юм. Технологи нь зөвхөн машин техник бус, харин шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглэхэд шаардагдах мэдлэг, зохион байгуулалт, ур чадварын цогц юм ((UIS), 2017). Үүнээс үзвэл технологи нь шинжлэх ухааны мэдлэгийг практикт хэрэглэх үйл явц болох харагдаж байна.

Бусад эх сурвалжид технологи гэдэг үг нь байгал, нийгмийн орчныг өөрийн хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөхийн тулд шинжлэх ухааны мэдлэгийг практикт ашиглах үйл ажиллагаа гэж үзсэн байна (Oxford University Press, 2023). Шинжлэх ухааны нээлтүүдийг практик, үйлдвэрлэлд хэрэглэх арга гэж үзсэн (Cambridge University Press & Assessment, 2025). Харин монгол эх сурвалжид дараах байдлаар тусгасан буюу Оюуны бүтээлийг хэрэглээний бүтээгдэхүүн болгон хувиргахад чиглэгдсэн хүн, техник, мэдээлэл, зохион байгуулалтын харилцан уялдаат үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргын цогц гэж тодорхойлжээ (Монгол хэлний их тайлбар толь, 2016). Эдгээрээс үзвэл технологи хэмээх





ойлголт нь шинжлэх ухааны мэдлэгийг үйл ажиллагаанд хэрэглэх үйл явц болох харагдаж байна. Иймд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах буюу хэрэгцээ хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шинжлэх ухааны мэдлэгийн шийдлийг ашиглах ерөнхий агуулгыг тодорхойлж болно.

Харин технологийн салбар нь тэрхүү шинжлэх ухааны мэдлэгийг хэрэглээний чиглэлээр тодорхойлсон ойлголт бөгөөд шинжлэх ухаан “юу” болохыг зааж тодорхойлсон бол технологи нь түүнийг “хэрхэн” хэрэгжүүлэхэд чиглэсэн салбар гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл шинжлэх ухааныг хэрэглээнд нэврүүлэх арга зүйг технологи хэмээн үзэж болно. Гэхдээ технологи нь нэг шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоонд бус олон шинжлэх ухааны мэдлэгийн уулзварт бий болдог ойлголт юм. Үүнээс авч үзвэл бидний амьдрал бүхэлдээ технологиор хүрээлэгдэн оршиж байдаг болохыг санах хэрэгтэй.

Жишээлбэл хүн төрлөхтний түүхэнд “анжис” бол хөдөө аж ахуйн хувьсгалын үед бий болсон технологийн шийдэл байлаа. Хүн төрөлхтөн биологи, физикийн шинжлэх ухаан мэдлэгт тулгуурлан анжисийг бүтээсэн билээ. Мөн хорих байгууллагын удирдлага шийдвэр гаргах ажиллагаандаа SWOT шинжилгээ хийдэг гэж үзье. Энэ бол менежментийн шинжлэх ухааны судлагдахуун болох удирдлагын үйл ажиллагааны асуудал бөгөөд түүнийг практик хэрэглэх аргачлалыг боловсруулсан нь менежментийн технологи болох юм. Үүнээс үзвэл хорих байгууллагын ашиг сонирхлыг хангах, хэрэгцээг хангах, хэрэгцээг хамгаалах тогтолцоонд маш олон шинжлэх ухааны мэдлэг хийгээд тэдгээрийг мэдлэгт суурилсан олон

тооны технологийн шийдлийг ашиглаж ирснийг анхаарах хэрэгтэй.

Орчин үед энэхүү технологийн салбарыг олон төрлөөр авч үзэх болоод байна. 2008 оноос эхлэн дэлхийн оюуны өмчийн байгааллагаас технологийн салбарын ангиллыг шинээр тогтоосон. Энэ үеээс мэдээллийн технологийн салбар илүү хурдацтай хөгжиж ирсэнтэй холбоотойгоор мэдээллийн технологийн салбарыг илүү олон чиглэлд хуваан үзэх болсон. Нийт 5 бүлгийн 35 төрлийн технологийн ангиллыг тогтоосон байна (Ulrich Schmoch, 2008).

Дээрх хоёр агуулгаас авч үзвэл хорих байгууллагын аюулгүй байдал бол хорих байгууллагын үйл ажиллагаа хэвийн явагдахад шаардлагатай хэрэгцээ, хамгаалагсан, урьдчилан сэргийлэгдсэн байдал бөгөөд энэхүү хэрэгцээг хангах, хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахад шинжлэх ухааны олон талт мэдлэгийг авч хэрэгжүүлсэн байдал хэмээх агуулгаар ойлгох оновчтой гэж үзэж байна. Тухайлбал эдгээр нь хорих байгууллагын удирдлагын үйл ажиллагаа, хоригдлын аюулгүй байдлыг хангах буюу хоригдол бие хүний хэрэгцээг хангах, хамгаалахад чиглэсэн арга хэмжээ дэх технологийн шийдэл гэх мэт тусгайлан судлагдах өргөн боломжтой юм.

### **III. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологийн шийдлийг ашиглаж ирсэн байдал**

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангахад технологийн шийдлийг ашиглаж ирсэн байдал өргөн хүрээтэй ойлголт хэдий ч судлаачийн хувьд хорих байгууллагын үйл ажиллагаа нь хуулиар хүлээсэн зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхийн





баримтууд мөн билээ (Б.Галбадрах, Э.Өнөболд, 2021).

Эдгээр баримтуудаас үзвэл технологийн шийдэл, шинжлэх ухааны мэдлэгийн ололт, амжилтууд нь хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд өргөн хэрэглэгдэж ирсэн болохыг авч үзэх боломжтой байна.

Нэг үгээр хэлбэл технологийн шийдлийг хорих байгууллагын аюулгүй байдлын салбараас салган авч үзэх судлах, дүгнэх боломжгүй юм. Хүн буй цагт, төр ба түүний чиг үүрэг байгаа л бол, шинжлэх ухааны мэдлэг болон түүний технологид суурилсан олон төрлийн арга зүй, шийдлүүд ямагт бидний амьдралд-нийгмийн харилцааны салбар хүрээг үл харгалзан нөлөөлсөөр, өөрийн үүргийг гүйцэтгэсээр ирсэн ба цаашид ч өөрийн мөрөө үлдээх нь дамжиггүй.

### Дүгнэлт

1. Аюулгүй байдал хэмээх ойлголт нь хүн, нийгэм, байгал гээд бүхий салбарын асуудлыг холбосон өргөн хүрээтэй ойлголт бөгөөд аливаа юмс, үзэгдэл үйл явцын хэвийн өрнөл, хөдөлгөөнийг амжилттай хэрэгжүүлэхэд хамааралтай болох нь харагдаж байна. Иймд хорих байгууллагын аюулгүй байдал нь хорих байгууллагын бүхий үйл ажиллагаа, цаашлаад тус байгууллагын хуулиар хүлээсэн үүрэг, зорилтыг бүрэн илэрхийлсэн өргөн хүрээтэй ойлголт юм. Тэгэхээр хорих байгууллагын аюулгүй байдал бол байгууллагын үйл ажиллагаа, зорилго, чиг үүрэг зэргийг хэрэгжүүлэх боломжийг агуулж байна.

Тэгэхээр байгууллагын хэвийн үйл ажиллагаанд хамаарах бүхий л хүчин зүйлс, нөхцөл байдал, үйл явдлыг аюулгүй байдлын хэмжээнд авч үзэх, судлах нь хорих байгууллагын аюулгүй байдал судлалын салбарын үндсэн асуудал гэж үзэж байна.

2. Хүн төрлөхтний түүх бол дан ганц хүний хөгжил, хүмүүсийн хоорондын харилцааны түүх бус нөгөөтэйгүүр шинжлэх ухааны мэдлэг ба түүний технологийн хөгжил, хувьсал өөрчлөлтийн түүх байдаг. Энэ нь хүн оршин байгаа газраас технологи хэмээх ойлголтыг тусгаарлан авч үзэж боломжгүй болохыг сануулж байна. Технологийн шийдэл нь бидний амьдралын турш бидэнд олон боломж, давуу тал, хялбар шийдлийг санал болгож ирсэн үйл явж, үе шат, арга хэрэгсэл юм. Харин хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологи ашиглах явдал технологийн дэвшилд бус хорих байгууллагын үйл ажиллагаа, хуулиар хүлээсэн зорилго, зорилт хэрхэн хэрэгжсэн байдлаар үнэлэгддэг байна.

3. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаанд технологийн шийдэл тухайн цаг хугацаа, нийгмийн хөгжлийн байдлаасаа харилцан адилгүй байдлаар ашиглагдаж ирсэн байна. Технологийн хөгжлөөс хорих байгууллагын үйл ажиллагаа ангид орших боломжгүй бөгөөд гагцхүү шинэлэг арга зүйг хэрхэн нэврүүлж, хэрхэн туршиж ирсэн байдлаар аюулгүй байдлыг хангах ажиллагаа дахь технологийн хэрэглээг тодорхойлж ирсэн нь аюулгүй байдал ба технологи хэмээх ойлголтын хэрэглээ, практик үйл ажиллагааны гажуудал гэж дүгнэж байна.

Иймд хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь технологиос ангид тусдаа орших боломжгүй ба цаашид технологийн шинэ шийдэл, арга зүйг идэвхтэй нэвтрүүлэх асуудал бидний тулгамдсан асуудал юм. Харин технологийн шийдлийн хэрэглээ, түүний уламжлалын хувьд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэнд олон

ололт, амжилтууд байгааг онцолж байна.

### Ашигласан материал

(UIS), U. I. (2017). *Measuring Scientific and Technological Services (STS): Draft Paper for Consultation*. Montreal : UNESCO Institute for Statistics (UIS).

Cambridge University Press & Assessment. (2025). *technology*. Retrieved from Cambridge: <https://dictionary.cambridge.org/>

Douglas Harpers. (2023, 10). *etymonline*. Retrieved from Online Etymology Dictionary.: <https://www.etymonline.com/word/security>

Oxford University Press. (2023). *Technology*. Retrieved from Oxford English Dictionary: <https://www.oxfordlearnersdictionaries.com/>

Ulrich Schmoch. (2008). *Concept of a Technology Classification for Country Comparisons*. Germany: World Intellectual Property Organisation (WIPO).

www.Menksoft.com. (2016). *Mongoltoli*. Retrieved from Монгол хэлний их тайлбар толь:

<https://mongoltoli.mn/dictionary/detail/2487>

Б.Галбадрах, Э.Өнөболд . (2021). *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үүсэл хөгжлийн түүхэн товчоон*. Улаанбаатар : Адмон принт .

Монгол хэлний их тайлбар толь. (2016). *Технологи*. Retrieved from Монгол хэлний их тайлбар толь : <https://mongoltoli.mn/dictionary/>

УИХ-ын Тамгын газар . (2010). Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*.

УИХ-ын Тамгын газар. (2017). Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. *Төрийн мэдээлэл эмхэтгэл*.

Ц.Очгэрэл. (2017). *Хорих байгууллагын аюулгүй байдал*. Улаанбаатар: Соёмбо принтинг .

Ч.Улаанхүү. (2016). *Аюулгүй байдлын үндэс*. Улаанбаатар : Шидэт өнгө .

Я.Цэвэл. (2025). *Query.mn*. Retrieved from Toli.query.mn: <https://toli.query.mn/search?q=%D0%B0%D1%8E%D1%83%D0%BB>



## ГАМШГААС ХАМГААЛАХ ТОГТОЛЦОО, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ҮҮРЭГ ОРОЛЦОО, АНХААРАХ АСУУДАЛ

### DISASTER MANAGEMENT SYSTEM, STAKEHOLDER ROLES AND RESPONSIBILITIES, ISSUES TO BE CONSIDERED

**Г.Галбадрах**

Дотоод хэргийн их сургуулийн Гамшиг судлалын докторант

**G. Galbadrakh**

Doctoral student in Disaster Studies at the University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: g.galbadrakh101@gmail.com

**Хураангуй:** Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гамшгийн эрсдэлийн засаглалыг бэхжүүлэх нь нэн тэргүүний зорилтуудын нэг болж туссан байдаг. Иймд энэхүү судалгаагаар гамшгаас хамгаалах тогтолцоо ямар түвшинд байгааг тодорхойлж, газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үеийн салбаруудын харилцан хамаарал, нөлөөллийг тодорхойлж, цаашид анхаарах асуудлын саналыг дэвшүүллээ. Судалгааны үр дүнгээс гарсан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд талуудын үүрэг оролцоог нэмэгдүүлэхэд оруулах санал нь улс орны дотоод аюулгүй байдалд нөлөөлөгч гол хүчин зүйлүүдийн нэг гамшгийн эрсдэл бодитой буурахад ач холбогдолтой.

**Abstract:** Strengthening disaster risk governance has been identified as one of the top priorities in implementing the Sendai Framework for Disaster Risk Reduction. Therefore, this study aims to identify the current state of disaster risk management, identify the interdependencies and impacts of various sectors during earthquakes, and propose future recommendations. The study's findings suggest that stakeholders should be more actively involved in disaster risk management, which is a key factor affecting national security. This study is important for effectively reducing disaster risk, which is one of the key factors affecting national security.

**Түлхүүр үгс:** гамшгаас хамгаалах тогтолцоо, гамшгийн эрсдэл, талуудын үүрэг, оролцоо, гамшгаас хамгаалах үйл ажиллагаа

**Keywords:** disaster management system, disaster risk, stakeholder roles and responsibilities, disaster protection activity.

#### Удиртгал

Өнөөгийн даяаршин буй дэлхийд улс орнууд бие биеэсээ ихээхэн хамааралтай болохын зэрэгцээ, дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн аюул, эрсдэлийн цар хүрээ, хор уршиг нь том, жижиг, хөгжлийн түвшнээс үл хамааран сөрөг нөлөө үзүүлсээр байна.

Манай улс гамшгаас хамгаалах менежментийн тогтолцоог бий болгож, гамшгаас хамгаалах үндэсний

чадавхыг бэхжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого (2011-2020)”-ыг хэрэгжүүлж дууссан ба энэ бодлогын баримт бичгийг удирдлага болгон гамшгаас хамгаалах эрх зүйн орчин, тогтолцоо, чадавхаа үе шаттайгаар хэрэгжүүлж, бэхжүүлсээр ирсэн. Одоогоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, “Гамшгийн эрсдэлийг




олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)”, “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030)” зэрэг бодлогын баримт бичгийг батлан хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд манай улсад үндэсний болон орон нутгийн гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах менежментийн тогтолцоо бүрдэж, төрийн байгууллага, хувийн хэвшил, иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголт, оролцоо нэмэгдэж, мэргэжлийн байгууллагын чадавх дээшилж байна.

Энэ нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны удирдлагыг оновчтой явуулах, төрөөс баримтлах бодлогыг зөв тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулах үйл явцыг харилцан уялдаатай байхаар төлөвлөх,

хэрэгжүүлэх шаардлагыг бий болгож байна.

Монгол Улсад гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилго бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд оновчтой тогтолцоо, зохион байгуулалтын хэрэгцээ, шаардлага байгааг үндэслэн Улсын Их Хурлаас Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж шинэчлэн найруулсан нь “Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нутаг дэвсгэр, үйлдвэрлэлийн зарчмаар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд өмчийн хэлбэр үл харгалзан зохион байгуулна (Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017)” хэмээн орууж гамшгаас хамгаалах удирдлагын тогтолцооны схемийг дараах (Г.Ариунбуян, 2024) байдлаар тодорхойлсон.



Зураг №1. Гамшгаас хамгаалах тогтолцооны шинэчлэл



Үндэсний төрийн захиргаа  
 Үндэсний төрийн захиргаа



ᠬᠤᠮᠤᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

Гамшгаас хамгаалах талаар эрх зүйн орчны шинэчлэл эрчимтэй явагдаж, энэ шинэчлэлийн хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч талууд, тэдгээрийн эрх үүргийн хүрээ нэмэгдсэн байна.

Оролцогч талуудын эдлэх эрх, хүлээх үүргийн талаарх эрх зүйн зохицуулалтыг гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд найман зүйл 81 заалтаас 17 зүйлийн 171 заалт болж 52.6 хувиар нэмэгдсэн. Нэмэлт өөрчлөлтөөр Гамшгаас хамгаалах тухай хуульд өмнөхөөс илүү ихээр туссаны нэг илрэл нь оролцогч найман талаас хуулийн шинэчлэлээр 17 оролцогч тал болж нэмэгдсэн байна. Мөн нэмэлт өөрчлөлтөөр Аж ахуй нэгж, байгууллага, иргэдийн зөвхөн хүлээх үүргийг тусгасан байсан бол эдлэх эрхийг мөн тусгаж өгсөн. Түүнчлэн төрийн бус байгууллага, сайн дурынхны оролцоог тодорхой болгож өгснөөрөө гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орлцох, гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглалыг бүрдүүлээд байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчлэлтэй уялдаж шинээр болон шинэчлэгдэж батлагдсан нийт эрх зүйн

баримт бичигт гамшгийн эрсдэл, гамшгийн эрсдэлийн засаглалтай холбоотой нь Засгийн газрын тогтоолоор батлагдсан баримт бичгийн 67, Шадар сайдын тушаалаар баталсан баримт бичгийн 50, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсаны 57 хувийг тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, эдгээр эрхзүйн баримт бичгийн ойролцоогоор 60 хувь нь гамшгийн эрсдэлийн удирдлагыг төрийн болон нутгийн захиргааны бүхий л шатанд нэвтрүүлэх, эрсдэлийн засаглалыг бэхжүүлэх эрхзүйн орчныг бүрдүүлж өгсөн. Энд бодит жишээ болгож талуудын оролцоо ямар хамаарал, нөлөөлөлтэй болохыг авч үзэв.

“Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож онц байдал тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа” сэдвээр хийгдсэн стратегийн команд штабын сургуулилтад 64 байгууллага оролцсон байна. Эдгээр оролцогч талын хамаарал, нөлөөллийн түвшинг тодорхойлохдоо “Долоон түвшний оноогоор үнэлэх систем”-ийг ашигласан (Ж.Григгс, 2017).

Оноо		Тайлбар
+3	Шууд холбоотой	Харьцуулж буй зорилтын хэрэгжилтэд шууд хүчтэй нөлөөтэй, шууд хүчтэй уялдаатай
+2	Дэмжлэг болно	Харьцуулж буй үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тус болно
+1	Түлхэц үзүүлнэ	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх нөхцөлийг яваандаа бүрдүүлэх
0	Нөлөөгүй	Эерэг болон сөрөг ямар нэг нөлөө үзүүлэхгүй
-1	Зарим эсрэг нөлөө	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх сонголтуудыг хязгаарлах
-2	Эсрэг нөлөөлөл үзүүлэх	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх
-3	Саад учруулах	Харьцуулж буй зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй болгоно, хүчтэй эсрэг нөлөөтэй (Ж.Григгс, 2017)

**Хүснэгт №1. Харилцан хамаарал, нөлөөллийн үнэлгээ: Долоон түвшний оноо**

Сургуулилтад оролцсон 64 байгууллагыг харьяалах яам, агентлагаар багцлан 27 байгууллага болгон газар хөдлөлтийн гамшгийн үед

голлох нөлөө үзүүлэх 10 байгууллага, газар хөдлөлтийн гамшгийн үед бусдаас хамаарах 10 байгууллагыг эрэмбэлэн гаргав.

### **Гамшгийн менежментийг шинэчлэхэд төр-хувийн хэвшлийн хамтран ажиллах үйл ажиллагааны нөлөө**

Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь энгийн, гамшгийн бус цаг үед гамшгийн удирдлагын газрууд үйл ажиллагааг жигд гүйцэтгэх боломжийг бүрдүүлдэг. Засгийн газрын агентлаг өөрийн нөөц, чадамжаар бие даан үүрэг гүйцэтэхийн оронд, төр-хувийн хэвшлийн оролцоотойгоор зорилгодоо илүү үр дүнтэй хүрч чадах боломжтой. Энэ нь гамшгийн менежментийн үйл ажиллагаанд эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд агентлаг нь нийтийн хэрэгцээг даруй шийдэх, хариу арга хэмжээ авах чадвартай болдог.

Төр-хувийн хэвшлийн түншлэлүүд нь гамшгийн менежментийн үйл ажиллагааг илүү уян хатан болгох боломжтой. Хувийн хэвшлийн зөвлөхүүдийг тодорхой төсөлд зориулан түр хугацаагаар ажиллуулаад төсөл дууссаны дараа чөлөөлөх эсвэл бусад төсөлд зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд оролцуулж болно. Ингэснээр хувийн хэвшлийн зөвлөхүүд нь тодорхой гамшгийн удирдлагын төсөлд анхаарал шаардлагатай үед төрийн ажилчдыг дэмжих нэмэлт нөөц болж өгдөг.

Энэхүү байгууллагын уян хатан байдлын шалтгаан нь хувийн хэвшил нь төрийн байгууллагууд шиг захиргааны дотоод хяналт, бичиг баримт шаарддаггүй юм. Хэрэв олон салбартай томоохон гамшгийн удирдлагын газарт нэг салбараас нөгөө салбар руу шилжих хувийн хэвшлийн зөвлөхүүдийн баг шаардлагатай бол, хувийн зөвлөхүүд нь төрийн байгууллагын ажилтнуудаас илүү хурдан, үр дүнтэй шилжих боломжтой. Учир нь тэдгээрт байгууллагын дотор шилжин ажиллахад шаардагдах бичиг баримт бага байдаг. Ингэж хувийн

хэвшлийн зөвлөхүүдийг салбар хооронд шилжүүлэх хурд нь эцсийн дүндээ гамшгийн удирдлагын газарт ашигтай нөлөө үзүүлдэг.

### **Гамшгийн удирдлагыг шинэчлэхэд төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тактикийн нөлөө**

Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь онцгой байдлын үед тактикийн хариу үйлдэл үзүүлэх үе шатанд чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ингэснээр нийгмийн тэсвэрлэх чадварыг бэхжүүлэхэд хүчтэй хувь нэмэр оруулдаг. Жишээлбэл, 2005 онд Эрэг дагуух бүсэд хүчтэй Katrina хар салхи болоход Wal-Mart компани хэрэгцээт бараа хүргэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. 2010 онд Deepwater Horizon газрын тос асгарах үед тос задруулагчийг үйлдвэрлэдэг Nalco зэрэг компаниуд засгийн газартай нягт хамтран цэвэрлэгээний ажилд оролцож байв. Мөн энэхүү өгүүллийн эхэнд дурдсанчлан, Жоплин, Миссури мужид хүчтэй хар салхи болсоны дараа бизнесийн байгууллагууд сэргээн босгох хөрөнгө оруулалтыг эргэлдүүлэх үйл ажиллагаанд оролцож байсан.

2012 оны сүүлээр Sandy Хар салхи Нью Жерси эргийн зарим хэсэг болон Нью-Йорк хотын газар нутгийг сүйтгэсэнээс хойш, төр-хувийн хэвшлийн байгууллагууд хамтарсан оролцоогоор хохирсон нийгмийг яаралтай сэргээх боломж хэрхэн бүрдүүлж болох тал дээр эрчимтэй анхаарал хандуулсан.<sup>30</sup> Энэ нь гамшгийн үеэр болон дараа нь бизнесийн болон төрийн байгууллага хоёул тактикийн шийдвэр гаргалтад оролцох шаардлагатай болох нь тодорхой юм. Төрийн болон хувийн хэвшлийн хувь нэмрийг сайтар уялдуулснаар нийгмийн тэсвэртэй байдлыг бий болгоно.





ᠮᠤᠩᠰᠢᠭ ᠰᠤᠳᠯᠠᠯ

Аж ахуйн нэгжүүд ба төрийн байгууллагуудын хоорондын түншлэл нь гамшгийн менежментийн стратеги, үйл ажиллагаа, тактикийн чиг хандлагад шинэчлэл авчирч байна. Энэ нөлөөлөл нь нийгмийн гамшгийн өмнөх болон дараах тэсвэрлэлт, сэргээн босох чадамжийг олон талаараа бэхжүүлж өгдөг.

Стратегийн түвшинд, төр ба хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь гамшгийн менежментэд оролцдог төрийн байгууллагуудын анхаарал хандуулах чиглэлийг шинэчлэн тодорхойлох боломжийг олгодог. Төр-хувийн хэвшлийн түншлэл нь төрийн байгууллагуудын тодорхой бараа, үйлчилгээгээр хангах үүргийг багасгаж, төрийн салбарт стратегийн бусад чухал чиглэлүүдэд төвлөрөх боломжийг олгодог. Үйл ажиллагааны түвшинд, салбар хоорондын хамтын ажиллагаа нь төрийн байгууллагуудад дотоод нөөцөө илүү хурдан шилжүүлэх бололцоог бүрдүүлж, системийг өөрчлөгдөж буй нийгмийн хэрэгцээнд илүү хурдан

хариу арга хэмжээ авах чадвартай болгодог.

Тактикийн түвшинд, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа нь гамшгийн үед хариу арга хэмжээ авах болон сэргээн босгох үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэдний хамтын ажиллагаа нь гамшигт өртсөн бүс нутгуудад шаардлагатай бараа, үйлчилгээнийг илүү үр дүнтэй хүргэхэд тусалдаг.

Эдгээр стратеги, үйл ажиллагааны болон тактикийн үе шатаар нийгмийг гамшгийн дараа илүү хурдан сэргээн босоход дэмжлэг үзүүлдэг байна. Хэвтээ мөр болон босоо багана тус бүрд хамгийн өндөр оноо авсан байгууллагууд нь хоорондоо их хамааралтай болохыг харуулж байна. Хэвтээ чиглэлийн оноо нь газар хөдлөлтийн гамшгийн үед тухайн салбарын “Бусад салбар”-д нөлөөлөх нөлөөллийг үзүүлсэн бол босоо чиглэлийн оноо тухайн салбар бусад салбараас хэрхэн хамаарч байгааг үзүүлээ.

Тухайн салбар бусад салбарт хамгийн их нөлөө үзүүлэх 10 салбар (26-57 оноо):

- Онцгой байдлын ерөнхий газар
- Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөл
- Сангийн яам
- Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил харилцаа холбооны яам
- Гадаад харилцааны яам
- Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам
- Гаалийн ерөнхий газар
- Улсын бүртгэлийн ерөнхий газар
- Цагдаагийн ерөнхий газар

Тухайн салбар бусад салбараас хамгийн их хамаарах арван салбар (28-49 оноо):

- Онцгой байдлын ерөнхий газар
- Эрүүл мэндийн яам
- Барилга хот байгуулалтын яам
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
- Зам тээврийн яам
- Боловсрол, шинжлэх ухааны яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб
- Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар
- Цахим хөгжил, харилцаа холбооны газар, Цагдаагийн ерөнхий газар
- Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам
- Тагнуулын ерөнхий газар

Зураг №2. Газар хөдлөлтийн гамшгийн үед салбар дундын харилцан ажиллагаа /хамаарал, нөлөөллийн аргаар харьцуулсан шинжилгээ/ (П.Чимэдцэрэн, 2023)

Дээрх шинжилгээнээс харахад нэгдүгээрт гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь дан ганц Онцгой байдлын байгууллагын асуудал биш, бүхий л талыг хамарсан асуудал болох нь харагдаж байна. Хоёрдугаарт газар хөдлөлтийн гамшигтай тэмцэхэд хамгийн их нөлөө үзүүлэгч байгууллагууд нь Онцгой байдлын ерөнхий газар, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай дэд зөвлөл, Сангийн яам, Эрүүл мэндийн яам, Цахим хөгжил харилцаа холбооны яам, Гадаад харилцааны яам, Барилга хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Гаалийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар тус тус байна. Тиймээс эдгээр байгууллагын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах нэгдсэн төлөвлөгөөтэй байлгах, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр байнга сургаж, дадлагажуулах шаардлагатай. Харин газар хөдлөлтийн гамшгаас хамгийн их хамаарах байгууллагууд нь Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Барилга хот байгуулалтын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зам тээврийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Иргэний нисэхийн ерөнхий газар, Зэвсэгт хүчний жанжин штаб, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газар, Цахим хөгжил, харилцаа холбооны газар, Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Тагнуулын ерөнхий газар тус тус байна. Эдгээр байгууллагуудын харилцан ажиллагааг Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоол “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-аар зохицуулж байна.

Дээрх талуудаас гадна олон нийт, ард иргэдийн санал, хүч нөөц бололцоонд тулгуурлан гамшгийн

эрсдэлийг бууруулах нэгдсэн бодлого нэн чухал юм. Энэ бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн захиргааны байгууллагаас иргэдийн гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд голлон анхаарч ажиллах шаардлагатай хэдий ч гамшгаас хамгаалах улсын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагад бичигдээгүй (Б.Ууганбаяр, 2023) байгаа нь гамшгаас хамгаалах улсын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх, талуудын оролцоог нэмэгдүүлэхэд боловсролын салбарын эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байгааг харуулж байна. Иймд “Гамшгаас хамгаалах улсын алба болон Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага байна.

### Дүгнэлт

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд талуудын оролцоо хангагдаж, үндэсний түвшин, аймаг нийслэлийн түвшин, сум дүүргийн түвшин, баг хорооны түвшин, аж ахуйн нэгж иргэний түвшнийг хамарсан үндэсний гамшгаас хамгаалах цогц тогтолцоо бүрдэж, гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглал бэхэжсэн байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах субъектийн эрх, зохион байгуулах арга хэмжээ, оролцогчдын үйл ажиллагааг холбон зохицуулах, Төрийн болон төрийн бус байгууллага, гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл, орон нутгийн зөвлөл, улсын онцгой комисс, нутгийн нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, иргэний эрх, үүргийг Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлтээр тусгаснаар гамшгаас хамгаалах улсын албад, талуудын





оролцооны эрх зүйн үндэс бүрдсэн байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь дан ганц Онцгой байдлын байгууллагын асуудал биш, бүхий л талыг хамарсан асуудал юм. Иймээс төрийн байгууллага болон хувийн хэвшлийн байгууллагууд хамтран гамшгаас хамгаалах нэгдсэн төлөвлөгөөг баталж, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр байнгын сургалт, нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж албан хаагчдыг дадлагажуулах шаардлагатай байна.

### Санал

Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид хуулийн хэрэгжилтэд дараах зүйлийг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

Байгалийн уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай хууль бус үйл ажиллагааны улмаас бий болсон аюултай ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах;

Эдийн засаг, нийгмийн бусад салбарын олон талт харилцаанд тулгуурлан гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бодитой зарцуулах;

Шинжлэх ухаанд суурилсан гамшгаас хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, дэвшилтэт техник, технологи, инновацыг нэвтрүүлэх;

Үндэсний болон орон нутгийн гамшгийн эрсдэлийг удирдах засаглалыг бэхжүүлэх;

Гамшгийн эрсдэлээс хамгаалах чадавх, бэлэн байдлыг дээшлүүлэхэд талуудын гүйцэтгэл, хяналтын механизмыг нэмэгдүүлэх;

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагыг гамшгаас хамгаалах улсын албанд

оруулж, холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах;

Засаг захиргааны анхан шатны нэгж, хороо, баг, сууц өмчлөгчдийн холбоо, иргэний түвшинд гамшгийн эрсдэлийг ойлгох, хуульд заасан үүрэг, хариуцлагаа хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх гэх мэт.

### Ашигласан материал

1. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010
2. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”
3. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр (2015-2025)
4. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030).
5. Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
6. Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний Монгол Улсын төлөвлөгөө, Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоол
7. Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам, Засгийн газрын 2018 оны 347 дугаар тогтоол
8. Ж.Григгс, М.Нилсонс, А.Стивэнс, Хамаарал нөлөөллийг долоон түвшний оноогоор үнэлэх систем, 2017
9. Даш.П., Сэржмядаг.Д., Чимэдцэрэн.П., Гамшгаас хамгаалах бодлого, стратеги, 2021
10. Г.Ариунбуян, П.Чимэдцэрэн, “Гамшгаас хамгаалах тогтолцооны шинэчлэл”, Аюулгүй байдал, стратеги тойм, дугаар № 27, 2024/05, Уб., 2024, т.6.
11. Б.Ууганбаяр, П.Чимэдцэрэн, Газар хөдлөлтийн гамшгийн үеийн

удирдлага, зохицуулалтын өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ, Гамшиг судлал, инновац сэтгүүл, ISSN2790-1181, 2023 №(2)

12. П.Даш, Гамшиг судлалын шинжлэх ухаан, 2025

13. Zairol A. Auzzira\*, Richard P. Haighb, Dilanthi Amaratungab. Public-private partnerships (PPP) in disaster

management in developing countries: a conceptual framework, *Procedia Economics and Finance* 18 ( 2014 ) 807 – 814

14. Nathan E. Busch and Austen D. Givens,. Achieving Resilience in Disaster Management: The Role of Public-Private Partnerships, *Journal of Strategic Security* , Vol. 6, No. 2 (Summer 2013), pp. 1-19



## ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН РАДИО ХОЛБООНЫ ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ



ᠮᠠᠨᠤᠯᠤᠯᠤᠰᠤ ᠨᠠᠭᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠮᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ  
ᠨᠠᠮᠤᠮᠤᠯᠠᠭᠤᠨ

### Г.Хатантуул

Онцгой байдлын ерөнхий газрын Холбоо, мэдээллийн технологийн газрын Холбооны төлөвлөлт, бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн хошууч, докторант

### G. Khatantuul

Senior Specialist Major, Ph.D Candidate, Federal Planning and Readiness, Comm & Information Technology Department of NEMA

### Ц.Ганчимэг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах албаны тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

### Ts. Ganchimeg

Disaster Risk Management Advisor, World Bank Country Office in Mongolia, Doctor of Security Sciences

\*хариуцлагатай зохиогч: hatanaa86@gmail.com

**Хураангуй:** Гамшиг, ослын үед удирдлагын холбооны найдвартай ажиллагааг хангах нь эрэн хайх, аврах ажиллагааны үр дүнтэй шууд уялдана. Энэхүү судалгааны ажлын хүрээнд Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах онол арга зүйг судалж, төлөвлөлтийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох арга замыг тодорхойлсон болно. Судалгаагаар гамшгийн үеийн холбоо зохион байгуулалтын үр дүн хангалтгүй байгаа нь холбоо зохион байгуулалтын төлөвлөлт хангалтгүй байгаатай холбоотой гэх үндэслэлтэй байна. Иймд радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийг нарийвчлан судалж, нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тодорхойлох шаардлагатай гэж үзлээ. Иймээс радио холбооны техник хэрэгслийн нөхөн хангалтыг нэмэгдүүлэх, дижитал системийг үе шаттайгаар нэвтрүүлж аналог системтэй уялдуулах, нөөцийн зохион байгуулалтыг бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг тасралтгүй дээшлүүлэх, засвар үйлчилгээний хүртээмжийг сайжруулах зэрэг цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай байгааг тодорхойлсон. Энэхүү судалгаа нь дээрх асуудлыг бодлогын түвшинд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр авч үзэж, холбооны тогтвортой ажиллагааг хангах шийдлийг тодорхойлох ач холбогдолтой юм.

**Abstract:** Reliable command communications are vital to the effectiveness of search and rescue operations during disasters and emergencies. This study examines the theoretical and methodological foundations of radio communication planning within the National Emergency Management Agency, analyzes its current state, and proposes strategies for improvement. The findings indicate that inadequate effectiveness of field communication during disaster response is closely linked to deficiencies in planning. To address this challenge, the study highlights the need for an integrated approach that encompasses enhanced replenishment of communication equipment, the phased introduction of digital systems in coordination with analog networks, the establishment of reserve organizational structures, continuous capacity building of human resources, and improved accessibility of maintenance services. By providing scientifically

grounded insights at the policy level, the research contributes to strengthening the resilience, stability, and sustainability of communication systems, thereby ensuring more effective coordination and decision-making in emergency response operations.

**Түлхүүр үгс:** Онцгой байдал, гамшиг, радио холбоо, төлөвлөлт, зохион байгуулалт

**Keywords:** Emergency, disaster, radio communication, planning, organization

### Удиртгал

Гамшгийн хамгаалах үйл ажиллагаанд удирдлагын найдвартай, тасралтгүй холбоо зохион байгуулалт нь хамгийн чухал байр суурь эзэлдэг. Онцгой байдлын байгууллагад одоогоор радио холбооны аналог систем зонхилон ашиглагдаж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн хангалт 2025 онд ердөө 35 хувьтай байгаа нь холбооны бэлэн байдал хангалтгүй байгааг илтгэнэ. Үүнээс улбаалан гамшиг, ослын үед холбоо тасалдах, улмаар удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэхэд хүндрэл учрах эрсдэл өндөр хэвээр байна. Ялангуяа 2025 онд гарсан ой, хээрийн түймрийг унтраах ажиллагааны явцад холбооны найдвартай ажиллагааны сул тал тодорхой ажиглагдсан нь энэхүү асуудлын бодит байдлыг нотолж байна. Эдгээрийг шийдвэрлэхийн тулд дараах чиглэлээр цогц арга хэмжээ шаардлагатай. Үүнд:

➤ Холбооны хөрөнгө оруулалтыг улсын төсөв болон олон улсын төсөл, хөтөлбөртэй уялдуулах;

➤ Шинэ үеийн дижитал системийг нэвтрүүлж, аналог системтэй зэрэгцүүлэн ашиглах;

➤ Нөөцийн зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх, засвар үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

Эдгээр арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх нь удирдлагын холбооны найдвартай ажиллагааг баталгаажуулж, гамшгийн үед шуурхай удирдлага,

зохион байгуулалтыг сайжруулах стратегийн ач холбогдолтой юм.

### 1. Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийн онол, арга зүй

Ном, судалгааны эх сурвалжуудад төлөвлөлтийн тухай ойлголт, онол, арга зүйн талаар дурдсан байдаг. 1930-аад онд Женерал Моторс компанийн захирал, менежментийн захиргааны сонгодог онолыг үндэслэгч Альфред Слоун төлөвлөлтийн үйл явцыг албан ёсоор томъёолж, ашиглаж эхэлснээс хойш судлаачид төлөвлөлтийн талаар судалгаа хийх болсон байна. Тэд “Төлөвлөлт бол асуудлыг тунгаан бодож, түүнийг шийдвэрлэх, бэрхшээлийг даван туулах боломж, хувилбаруудыг боловсруулахад удирдагч, захирагч даргад туслах ухаан юм” гэж үздэг[1].

Төлөвлөлт бол аливаа байгууллага өмнөө тавьсан зорилгодоо хамгийн хэмнэлттэй ямар арга замаар хүрэх вэ? гэдгийг шийдвэрлэх үйл явц юм. Харин төлөвлөгөө нь тэрхүү үйл явцыг удирдан зохион байгуулж буй субъектийн гаргасан шийдвэрүүдийг тусгасан албан ёсны баримт бичиг. Төлөвлөлт гэдэг бол ажлыг зохион байгуулалттай болгох, үр дүн ихтэй, эрсдэлгүй байлгах аргыг олж тодорхойлох явдал мөн. Төлөвлөлт бол тодорхой зорилтыг гүйцэтгэх үйл явцын урьдчилсан дараалал юм. Төлөвлөлт гэдэг нь хувь хүн, байгууллагын өмнө тавигдсан зорилгыг хамгийн оновчтой арга замаар хангах






үйл явц юм гэж тодорхойлсон байдаг[2].

Харин төлөвлөлтийн арга зүй гэдэг нь зорилго тавих, тэдгээр зорилгод хүрэх арга хэмжээг тодорхойлох, нөөцийг хуваарилахад ашигладаг бүтэцлэгдсэн үйл явцыг хэлнэ. Энэ нь шийдвэр гаргахад чиглүүлж, үр дүнтэй хэрэгжилтийг баталгаажуулах замын зураглалыг бүрдүүлдэг. Төлөвлөлтийн

ерөнхий аргачлал хувьд нөхцөл байдлын шинжилгээ, зорилгоо тодорхойлох, нөөц ба хязгаарлалтыг тодорхойлох, зорилгод хүрэх хувилбаруудыг боловсруулах, хамгийн сайн хувилбарыг үнэлж сонгох, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилт, хяналт шинжилгээ үнэлгээ хийх гэсэн үе шатуудтай байна[3].



Зураг 1. Төлөвлөлтийн арга зүй

Холбооны системийг төлөвлөх гэдэг нь бэлтгэх ажиллагаатай нягт уялдаатай үйл ажиллагаа бөгөөд техник хэрэгслийг хэрхэн бэлтгэх, ашиглах, төрийн болон хувийн хэвшлийн тэрчлэн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын техник хэрэгсэлтэй хэрхэн зохицож ажиллах талаар эрх зүйн хувьд зохицуулах үйл ажиллагаа юм[4].

Онцгой байдлын ерөнхий газрын хувьд гамшгаас хамгаалах радио холбооны системийг төлөвлөх нь нийтийн хэрэглээний систем (үүрэн/интернет) доголдож болзошгүй нөхцөлд тасралтгүй ажиллах, уян хатан, нөөцтэй, найдвартай дэд бүтцийг бүрдүүлэх явдал юм. Олон улсын судлаачдын үзэж байгаагаар,

**гамшгийн үед радио холбооны систем нь мэдээлэл дамжуулах, зохицуулалт хийх, аврах ажиллагааг удирдах үндсэн хэрэгсэл болдог** (ITU-R, 2023; Wang, 2023; Abdolazadeh, 2023; Jiang, 2025) гэжээ.

Тиймээс Онцгой байдлын ерөнхий газраас радио холбооны системийг оновчтой төлөвлөсөн эрхзүйн баримт бичигтэй болох нь зүйтэй. Гадаадын туршлагаас үзэхэд, уг төлөвлөгөө нь гамшгийн үед холбоо зохион байгуулалтын тасралтгүй байдлыг хангах, Онцгой байдлын болон бусад хариу арга хэмжээний байгууллагуудын уялдаа холбоог бэхжүүлэх, нийтийн дэд бүтцээс хамааралгүй нөөц систем бий болгох, алслагдсан болон гамшгийн эрсдэлтэй бүс нутгийг хамруулах, улсын

хэмжээнд сүлжээний хүртээмж, хамрах хүрээг идэвхжүүлэх зорилттой боловсруулагддаг байна.

## 2. Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийн өнөөгийн байдал шинжилгээ

Онцгой байдлын байгууллагын холбоо зохион байгуулах төлөвлөлт нь 2020 оны А/232 дугаар тушаалаар батлагдсан “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам”-д үндэслэн хэрэгжиж байна. Уг журам нь олон улсын харилцаа холбооны байгууллагуудын (ITU-R) зөвлөмж, стандартуудтай нийцсэн бөгөөд үндэсний аюулгүй байдал, систем хоорондын уялдаа, нийцлийг хангах, холбооны дэд бүтцийг бий болгож өргөтгөх, сайжруулахад чиглэсэн онол, арга зүйн баримт бичиг юм.

Холбооны системийн төлөвлөлт нь байгууллагын үйл ажиллагааны шаардлага, эрсдэл, технологийн болон санхүүгийн нөөцөд тулгуурлж найдвартай, тасралтгүй, уян хатан харилцаа холбоог хангах зорилготой иж бүрэн үйл явц бөгөөд нөөц, нөхөн хангалт, засвар үйлчилгээ, сэргээн босголт, эрсдэлээс хамгаалах зэрэг дэд арга хэмжээнүүдийг багтаадаг (ITU-R, 2023; Г.Хатантуул, 2025).

Онцгой байдлын ерөнхий газрын **Холбоо, мэдээллийн технологийн газар (ХМТГ)** нь холбоо, зарлан мэдээлэл, мэдээллийн технологийн бодлого, стратегийг хэрэгжүүлэх үндсэн үүрэгтэй бөгөөд харин **Холбоо зохион байгуулалтын хэлтэс** нь холбоог зохион байгуулах төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хянах, хариуцах чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Одоогийн байдлаар VHF аналог радио холбооны системийг голлон ашиглаж байгаа бөгөөд зарим салбарт тоон радио холбооны төхөөрөмж нэвтрүүлсэн байна. Гэсэн хэдий ч дэвшилтэт технологийн хяналт, удирдлагын иж бүрэн систем дутмаг, сүлжээний хамрах хүрээ хязгаарлагдмал, ярианы ачаалал их зэрэг хүндрэл байсаар байна. Түүнчлэн техник хэрэгслийн 70 орчим хувь нь ашиглалтын хугацаа дууссан, нөхөн хангалт 35 хувьтай байгаа нь холбооны бэлэн байдал хангалтгүйг илтгэнэ.

Хүний нөөцийн хувьд, 2025 оны байдлаар 81 хувийн хангалттай боловч орон нутгийн нэгжүүдэд мэргэжлийн мэргэшсэн холбоочин хомс, мэдээллийн технологийн чиглэлийн мэргэжилтэн давамгайлж байгаа нь холбоо зохион байгуулах чадавхыг сулруулж байна. Засвар үйлчилгээний график төлөвлөгөөг жил бүр батлуулж хэрэгжилтийг хангадаг хэдий ч гамшгийн голомтод техникийн бэлэн байдлыг шуурхай хангах тусгай засвар, дэмжлэгийн бүтэц, бүлэг одоогоор байхгүй байна.

### 2.1. Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийн баримт бичгүүдэд хийсэн шинжилгээ

Холбоо зохион байгуулах төлөвлөлтийн баримт бичгийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын стратеги төлөвлөгөөнүүдэд холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр тодорхой зорилтууд тусгагдсан байдаг. Тухайлбал, 2021–2024 онд хэрэгжүүлсэн стратегийн төлөвлөгөөний 5 дугаар зорилтод “Гамшгийн мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохицуулалтыг сайруулах, холбоо, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах” гэж заасан бол, 2025–2028 оны стратегийн төлөвлөгөөнд





“Гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээллийн тогтолцоонд дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлж, шинэ шатанд гаргах” зорилт туссан байна[7].

Төрөөс гамшгаас хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд дараах баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Үүнд:

- 2020 оны А/232 тушаал – “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам”;

- 2024 оны А/429 тушаал – “Холбооны техник хэрэгсэлд тавигдах ерөнхий шаардлага”;

- 2024 оны А/430 тушаал – “Гамшгийн голомтод радио холбоо зохион байгуулах заавар”;

Төлөвлөлтийн үр өгөөжийг матрицын аргыг ашиглаж, 10 үзүүлэлтээр үнэлэхэд нийт 50 оноо байхаас 25 онооны үнэлгээтэй буюу дунд түвшинтэй бол системийн үр ашиг 63.8 хувьтай гарсан нь нөөц, хангалт, засвар үйлчилгээний үзүүлэлтүүд хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь радио холбооны үр ашиг, найдвартай байдал нь төлөвлөлтийн чанар, хэрэгжилтийн түвшнээс шууд хамааралтай болохыг нотолж байна.

Харин Онцгой байдлын ерөнхий газрын радио холбооны системийн үр ашигтай байдлыг матрицын аргаар үнэлэхэд нийт 63.8 хувьтай буюу дунд түвшинд байна. Энэ нь төлөвлөлтийн чанар байдлаас радио холбооны үр ашиг шууд хамааралтай байдаг нь нотлогдож байна.

### **2.1.2 Онцгой байдлын байгууллагын радио холбооны төлөвлөлтийн СВОТ шинжилгээ**

Онцгой байдлын байгууллагын радио холбооны төлөвлөлтөд СВОТ шинжилгээ хийхэд байгууллагын харилцаа холбооны системийн талаар удирдлагын баримт бичгүүдэд тусгаж,

техник хэрэгслийг төсөл хөтөлбөр, зээл тусламжаар худалдан авах, холбооны системд орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх чиглэлээр төлөвлөдөг зэрэг давуу талууд байна.

Түүнчлэн гамшгаас хамгаалах төрийн бодлого, баримт бичгүүдэд холбооны системийг сайжруулах талаар тусгагдаж, Гамшгаас хамгаалах тухай хуульд төрийн захиргааны байгууллага нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тухайн жилийн төсвийн 1 хувийг зарцуулахаар заасан[8], холбооны техник хэрэгслийг төсөл хөтөлбөр, зээл тусламжаар худалдан авах зэрэг боломжууд байна. Гэсэн хэдий ч холбоо, зарлан мэдээллийн бүтэц, орон тоо төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй, радио холбооны аналог систем нь аврах ажиллагааны хувцас, техник хэрэгсэлтэй уялдан ашиглах боломжгүй, хэрэгцээ хангалтын тооцох арга аргачлалыг хэрэгжүүлдэггүй, холбоо зохион байгуулалтын хэрэгцээ шаардлага бүрэн хангагдаагүй зэрэг сул талууд оршиж байна.

Нөгөөтээгүүр холбооны системийг бэхжүүлэх төсөв хөрөнгө, төлөвлөлт хангалтгүйгээс техник хэрэгслийн нийлүүлэлтийн эмх замбараагүй байдал үүсэх, байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологийн харилцан уялдаа алдагдах, үр ашиггүй систем, техникийн тоо олшрох хандлага аюул эрсдэл үүсэх магадлалтай байна. (Хүснэг 3-ийг үзнэ үү)

Эдгээр сул талууд, аюул эрсдэлийг бууруулахын тулд радио холбооны төлөвлөлтөд Онцгой байдлын байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны системд бүхэлд нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, холбооны системийн бүтцийг зураглах, суурь сүлжээг байгуулах, орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэх,

холбогдох зохицуулалтын баримт бичгийг шинэчлэн нэмэгдүүлэх, алба хаагчдыг сургах, чадавхжуулах, нөхөн хангалтыг хийх, засвар үйлчилгээний

зардлыг жил бүрийн төсөвт нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг тусгаж бодитойгоор хэрэгжүүлэх шаардлагатай.

<p><u>Давуу тал</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Онцгой байдлын байгууллагын холбоо системийн талаар удирдлагын баримт бичгүүдэд тусгагдсан.</li> <li>• Холбооны техник хэрэгслийг төсөл хөтөлбөр, зээл тусламжаар худалдан авалт хийдэг.</li> <li>• Холбооны систем орчин үеийн дэвшилтэд технологи нэвтэрч байгаа.</li> </ul>	<p><u>Сул тал</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Холбоо, зарлан мэдээллийн бүтэц, орон тоо хангалтгүй</li> <li>• Радио холбооны аналог систем нь аврах ажиллагааны хувцас, техник хэрэгсэлтэй уялдан ашиглах боломжгүй.</li> <li>• Хэрэгцээ хангалтын тооцох арга аргачлал байхгүй.</li> <li>• Холбоо зохион байгуулалтын хэрэгцээ шаардлагыг бүрэн хангагдаагүй</li> </ul>
<p><u>Боломж</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Холбооны системийг сайжруулах талаар гамшгаас хамгаалах төрийн бодлого, баримт бичгүүдэд тусгагдсан.</li> <li>• Гамшгаас хамгаалах тухай хуульд төрийн захиргааны байгууллага нь гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд тухайн жилийн төсвийн 1 хувийг зарцуулахаар заасан.</li> <li>• Холбооны техник хэрэгслийг төсөл хөтөлбөр, зээл тусламжаар худалдан авах боломжтой.</li> </ul>	<p><u>Аюул</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Холбооны системийн төсөв хөрөнгө хангалтгүй. Техник хэрэгслийн нийлүүлэлтийн эмх замбараагүй байдал үүсэх,</li> <li>• Байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологийн харилцан уялдаа алдагдах,</li> <li>• Үр ашиггүй систем, техникийн тоо ширхэг олшрох</li> </ul>
<p><u>Шийдэл: Аюул, эмзэг, сул талыг бууруулахын тулд доорх арга хэмжээнүүдийг төлөвлөлтөд тусгаж хэрэгжүүлэх. Үүнд:</u></p> <ul style="list-style-type: none"> <li>• Онцгой байдлын байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны системд бүхэлд нь хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;</li> <li>• Холбооны системийн бүтцийг зураглах, суурь сүлжээг байгуулах;</li> <li>• Орчин үеийн дэвшилтэд технологийг үйл ажиллагааны онцлогт нийцүүлж нэвтрүүлэх;</li> <li>• Холбогдох дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулж гаргах;</li> <li>• Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн алба хаагчдыг сургах, чадавхжуулах;</li> <li>• Холбогдох стандартын дагуу холбооны системд тавигдах шаардлагын дагуу нөхөн хангалтыг хийх;</li> <li>• Засвар үйлчилгээний зардлыг жил бүрийн төсөвт нэмэгдүүлэх;</li> </ul>	

**Хүснэгт 1. Онцгой байдлын байгууллагын радио холбооны төлөвлөлтийн СВОТ шинжилгээ**

### 2.1.3. Ой, хээрийн түймрийн үеийн холбоо зохион байгуулалт, тулгамдсан асуудал

Ой, хээрийн түймрийн тоо, давтамж нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагууд удирдлагын холбоог “Starlink” хиймэл дагуулын интернэт болон сансрын холбооны утсаар, бүлгийн холбоог хэт богино долгионы радио станцаар ханган ажиллаж байсан байна. Гэсэн хэдий ч ой, хээрийн түймрийн үеийн газар орон дээрх

холбоо зохион байгуулалтын үр дүн хангалтгүй байгаа нь радио холбооны төлөвлөлт, дэд бүтцийн зохион байгуулалт сул байгаатай холбоотой байна.

Сэлэнгэ аймагт гарсан ой, хээрийн түймрийн үеийн хээрийн судалгаагаар гамшгийн голомтод холбоо зохион байгуулах томилгоожсон бүтэц, сүлжээний хүртээмж, хамрах хүрээ, тоног төхөөрөмжийн хангалт дутмаг, холбоочдын мэргэжлийн чадвар, бэлтгэл сул, эрчим хүчний хангалт





хүрэлцээгүй зэрэг нийтлэг дутагдлууд илэрсэн байна. Мөн стандартын шаардлага хангаагүй холбооны техник хэрэгсэл нийлүүлэх, сэлбэг хэрэгслийн хомсдол, сансрын холбооны төхөөрөмжийн хүрэлцээ муу, газар орны уулархаг, бартаатай нөхцөлөөс шалтгаалан радио долгион бүрэн хүрэхгүй байх зэрэг нь бодит ажиллагаанд холбоо зохион байгуулах үр нөлөөг бууруулсан байна. Мөн түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж буй бүлгүүд холбоочингүй гарснаар холбооны горим алдагдаж, удирдлага зохицуулалт хүндрэл үүсдэг асуудлууд илэрч байв.

Иймд гамшгийн үед радио холбоог зохион байгуулах төлөвлөлтөд холбооны техник хэрэгсэл, тэжээл үүсгүүрийг стандартын дагуу бүрдүүлэх, судалгаанд үндэслэсэн хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгах, холбоо зохион байгуулалтын чиглэлийн орон тоог төрөлжүүлэх, сургалт, дадлагыг тогтмолжуулах шаардлагатай байгаа ажиглагдаж байна [12].

### **3. Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийг боловсронгуй болгох арга зам**

#### **3.1. Онцгой байдлын байгууллагын радио холбоог зохион байгуулах төлөвлөлтийн арга хэмжээний тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлсэн байдал**

Онцгой байдлын байгууллагын шуурхай ажиллагааны радио холбооны төлөвлөлтийг боловсронгуй болгох нь гамшгийн үед цаг алдалгүй, найдвартай, уялдаа холбоотой хариу арга хэмжээ авах үндсэн нөхцөл юм. Онцгой байдлын байгууллагын радио холбооны системд хийсэн СВОН шинжилгээгээр аюул, эмзэг, сул талыг бууруулахын тулд доорх арга

хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Системийн үнэлгээ, зураглал (Онцгой байдлын байгууллагын мэдээлэл, харилцаа холбооны системд иж бүрэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбооны системийн бүтцийг зураглах, хөгжүүлэх);

2. Суурь дэд бүтэц байгуулах (Нэгдсэн суурь сүлжээ байгуулах, холбооны системийг орчин үеийн ухаалаг технологиор шинэчлэх);

3. Бодлого, зохицуулалт (Холбооны үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам, заавар, стандартыг боловсруулах, хэрэгжилтийг хангах);

4. Хүний нөөц, чадавх (Алба хаагчдыг сургах, чадавхжуулах, радио холбооны чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэх);

5. Нөхөн хангалт, засвар үйлчилгээ (Системд тавигдах шаардлагын дагуу нөхөн хангалтыг тогтмол хийх, засвар үйлчилгээний зардлыг жилийн төсөвт тогтвортой тусгах).

Эдгээр шалгуурт нэн хэрэгцээтэй байдал буюу тулгамдсан асуудлыг хэр хурдан шийдвэрлэх шаардлагатай эсэх (жишээ нь: гамшгийн үеийн радио холбооны системийн доголдол), радио холбооны ашиглалтын найдвартай байдлын хангах шаардлага, гамшгийн үед үзүүлэх нөлөөлөл, үнэ өртөг, санхүү, нөөцийн хүртээмж зэрэг техник эдийн засгийн үндэслэл, насжилт, засвар үйлчилгээний хэрэгцээ зэрэг тогтвортой байдал, орон нутгийн, бүс нутгийн болон үндэсний системтэй харилцан ажиллах чадвар зэрэг зүйлүүд орно.

Онцгой байдлын байгууллагын радио холбооны системийг боловсронгуй болгох арга хэмжээг эрэмбэлэх нь шуурхай байдал, нөлөөлөл, техник эдийн засгийн үндэслэлийг тэнцвэржүүлсэн байвал



**Хүснэгт 2. Онцгой байдлын байгууллагын радио холбооны системийн төлөвлөлтийг сайжруулах тэргүүлэх арга хэмжээ**



ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤ ᠶ᠋ᠢᠨ ᠪᠠᠶᠢᠭᠤᠯᠤᠭ

Сайжруулах арга хэмжээ	Нэн яаралтай байдал (1-5)	Үр нөлөөлөл ((1-5)	Боломжит үндэслэл (1-5)	Харилцан ажиллах чадвар (1-5)	Жинлэсэн оноо (/100)	Эрэмблэл
	25%	30%	25%	20%		
Дижитал радио руу шинэчлэх (DMR/TETRA)	5	5	3	5	88	I
Нөөц систем (хиймэл дагуул, нарны) бий болгох	5	4	4	4	84	II
Хамтын ажиллагааны үнэлгээ + бусад агентлагуудтай нэгтгэх	4	5	3	5	82	III
Радио станцын нэвтрүүлгийн аудитыг тогтмол хийх	4	4	4	3	76	V
Харилцаа холбооны болон гамшгийн үеийн радио холбооны протоколуудыг боловсруулах	3	4	5	4	74	VI
Дуудлага хүлээн авагчийн сургалтын хөтөлбөр	4	4	5	3	78	VI
Дахин дамжуулалтын цамхаг, дэд бүтцийг шинэчлэх	4	5	2	3	70	X
Хөдөлгөөнт холбооны зангилгаануудын хүчин чадлыг нэмэгдүүлэх	3	4	3	4	68	VIII
Тогтмол загварчлал, дасгал сургуулилт хийх	4	3	5	3	72	IX

**Хүснэгт 3. Онцгой байдлын байгууллагын радио холбооны төлөвлөлтийн арга хэмжээний ач холбогдлын эрэмблэл**

**3.2 Онцгой байдлын шаттай хөгжүүлэх төлөвлөгөөний байгууллагын радио холбоог үе төсөл**





ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

Радио холбооны системд техникийн үзлэг шалгалт хийх	Холбоо зохион байгуулах хэлтэс	Хагас жилд	Техникийн баг, зөвлөх инженерүүд	Одоогийн нөхцөл байдлыг тогтоож цаашид авах арга хэмжээг тодорхойлох
Радио холбооны стандарт үйл ажиллагааны журам (SOP) боловсруулж, гамшигийн үед мөрдөж ажиллах журмыг тодорхой болгох	Холбоо зохион байгуулах хэлтэс, Шуурхай удирдлагын төв,	Хагас жилд	Ажиллагааны газрын бие бүрэлдэхүүн, мэргэжилтнүүд	Эрэн хайх аврах ажиллагааны үед радио холбоог зохион байгуулах журмын төслийг боловсруулах холбогдох нэгжүүдээс санал авах
Холбоочид болон дуудлага хүлээн авагч нарын сургалт	Сургалтын хэлтэс, Холбоо зохион байгуулах хэлтэс	Хагас жилд	Холбооны мэргэжилтнүүд, сургагч багш нар	7 бүсийн 100 холбоочид, дуудлага хүлээн авагчдыг оролцуулна
Нөөц төхөөрөмж худалдан авах	Санхүү, ар талын газар	Хагас жилдээ	Улсын төсөв,	5 бүсийн шуурхай удирдлагын төвүүд нөөц радио станцтай болно.
Хоёрдугаар үе шат: Дунд шатны зорилт, 2-4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ				
Одоо байгаа аналог радиог дижитал технологид шинэчлэх	Санхүү, ар талын газар	12-36 сар	Санхүүжилт, тоног төхөөрөмж	Дижитал радио суурилуулсан
Дахин дамжуулах станцуудын тархалтыг сайжруулах	Инженерчлэл	9-15 сар	Улсын төсөв, Дахин дамжуулах станцуудыг өргөтгөх багийн бие бүрэлдэхүүн	Хамрах хүрээг өргөтгөн
Бүс нутгийн хөдөлгөөнт радио холбооны хүчин чадлыг нэмэгдүүлэх	Холбоо зохион байгуулах хэлтэс	12-18 сар	Улсын төсөв, хөдөлгөөнт холбооны зориулалт бүхий техник хэрэгсэл, автомашин	Хөдөлгөөнт холбооны нэгж 6- 8 зангилаа байгуулсан байна.
Төрийн цэргийн байгууллагуудын агентлагуудтай харилцан ажиллах чадварыг нэгтгэж эхлэх	ҮАБЗ, ОБЕГ	15-18 сарын	Хэлэлцээр, технологийн интеграцлал	Агентлагуудтай хамтарсан харилцаа холбооны протоколууд
Гуравдугаар үе шат: Урт хугацааны зорилт: 5-8 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ				
Радиод зориулсан GPS-тэй хяналт тавих	Холбоо зохион байгуулах хэлтэс	5-6 жилд	Худалдан авалт, хувийн хэвшлийн түншүүд	Хариулагчийн аюулгүй байдал, хяналтыг сайжруулах.

Төвлөрсөн холбооны хяналтын төвийг байгуулах	ЦХИХХЯ, ОБЕГ	5-8 жилд	Дэд бүтэц, программ хангамж	Улсын хэмжээнд хяналт, диспетчерийн төв
Тасралтгүй туршилт, загварчлал	Холбоо зохион байгуулах хэлтэс	Жил бүр	Радио холбооны журам, харилцан зохицуулалт	Жил бүрийн онцгой байдлын байгууллагын радио холбооны дадлага сургуулилт
Тогтвортой байдал, засвар үйлчилгээний төлөвлөгөөг гаргах	Бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Холбоо зохион байгуулах хэлтэс	5-6 жилд	Улсын төсөв, стратеги бодлого	Радио холбоог хөгжүүлэх замын зураглалтай болно.

**Хүснэгт 4. Онцгой байдлын байгууллагын радио холбоог үе шаттай хөгжүүлэх төлөвлөгөөний төсөл**

### Дүгнэлт

Холбооны системийг төлөвлөх үйл ажиллагаа нь гамшгийн үед мэдээлэл, удирдлагын найдвартай байдлыг хангах үндсэн нөхцөл бөгөөд энэ нь бэлтгэл хангах ажиллагаатай нягт уялдсан стратегийн ач холбогдол бүхий цогц үйл явц юм. Энэхүү төлөвлөлт нь техник хэрэгслийг бүрэн бэлэн байлгах, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын нөөцийг уялдуулан ашиглах, үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэдэг.

Онцгой байдлын байгууллагын радио холбоог төлөвлөх баримт бичгүүдэд хийгдсэн шинжилгээгээр стратегийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө, бэлэн байдлын төлөвлөгөө, холбогдох стандарт, дүрэм, журам, технологийн шинэчлэлтийн замын зураг, олон улсын харилцаа холбооны протоколуудыг хэрэгжүүлэх зэрэг чиглэлүүдийг тусган хэрэгжүүлж буй нь тодорхой боловч радио холбооны дэд бүтцийн эрсдэл, эмзэг байдлыг үнэлэх, түүнийг бууруулах арга хэмжээг төлөвлөлтөд системтэй

тусгаагүй нь илэрч байна. Энэ нь ой, хээрийн түймрийн үед газар дээрх холбоо зохион байгуулалтын үр дүнд сөргөөр нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна. Иймээс радио холбооны төлөвлөлтийн чанарыг сайжруулах, эрсдэлийн үнэлгээ болон хяналт-шинжилгээний тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна. СВОН шинжилгээний дүнд илэрсэн сул талууд болон аюул, эрсдэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- ✓ Холбооны системийн бүтцийг зураглан тодорхойлох,
- ✓ Суурь сүлжээг үе шаттайгаар байгуулах,
- ✓ Орчин үеийн ухаалаг технологийг нэвтрүүлэх,
- ✓ Холбогдох дүрэм, журам, стандарт, зааврыг шинэчлэн боловсруулах,
- ✓ Радио холбооны сүлжээний нөөцлөлтийн (redundancy) бодлогыг боловсруулж, үндсэн болон нөөц зангилааг тодорхой болгох.
- ✓ Холбоо, зарлан мэдээллийн чиглэлийн мэргэжилтнүүдийг тогтмол сургах, чадавхжуулах,





- ✓ Эрчим хүчний нөөц (генератор, нарны эх үүсвэр, зөөврийн батерей)-ийн найдвартай байдлыг хангах тусгай төлөвлөгөө боловсруулах,
- ✓ Кибер аюулгүй байдлын хамгаалалтыг радио холбооны системийн төлөвлөлтөд тусгах,
- ✓ Системийн нөхөн хангалт, засвар үйлчилгээний төсвийг жил бүр нэмэгдүүлэх,
- ✓ Холбооны системийн гүйцэтгэлийг үнэлэх хяналтын механизмыг бүрдүүлэх.

Эдгээр арга хэмжээ нь Онцгой байдлын байгууллагын радио холбооны системийн найдвартай ажиллагаа, бэлэн байдлыг дээшлүүлж, гамшгийн үед удирдлага, мэдээлэл дамжуулалтыг тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

#### Ашигласан материал

1. П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, УБ хот, 2018 он, х-13.
2. П.Цэдэв, Гамшгаас хамгаалах төлөвлөлт, УБ хот, 2018 он, х-12.
3. [https://www.researchgate.net/publication/280897254\\_a\\_new\\_methodology\\_on\\_strategic\\_planning](https://www.researchgate.net/publication/280897254_a_new_methodology_on_strategic_planning).
4. Ч.Лхамжав, Холбоо зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт. УБ хот, 2018 он, х-2.
5. ОБЕГ-ын танилцуулга, 2025 он. <https://nema.gov.mn/>
6. ОБЕГ -ын Онцгой байдлын ерөнхий газрын 2021-2024 онуудад хэрэгжих стратеги төлөвлөгөө, 2021 он.
7. Онцгой байдлын ерөнхий газрын 2025-2028 онуудад хэрэгжих стратеги төлөвлөгөө, 2025 он.
8. Гамшгаас хамгаалах тухай хууль
9. Гамшгийн үеийн холбоо зохион байгуулах бэлэн байдлын төлөвлөгөөний төсөл, 2025 он.
10. ОБЕГ-ын хууль эрх зүйн баримт бичгүүд <https://nema.gov.mn/>
11. Гамшгаас хамгаалах цагаан ном, УБ хот, 2024 он.
12. “Ой, хээрийн түймрийн үед холбоо зохион байгуулалтад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын тухай” Илтгэх хуудас, 2025 он.
13. Олон улсын цахилгаан холбооны холбооны (ITU) Конвенц <https://www.itu.int/en/ITU-R/Pages/default.aspx>
14. Boldbaatar Sh (Ph.D) Climate Resilience Expert, Consultant, WBG, Report on Mainstreaming climate resilience into capital investment planning in Ulaanbaatar city, Climate resilience criterion/criteria for climate-smart municipal CIP methodolog, UB city, 2017.

## ГАЛ ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖ

### POSSIBILITY OF IDENTIFYING FIRE RISK

**Э.Батзаяа**

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн магистрант

**E. Batzaya**

Master's student at the Management Academy, University of Internal Affairs

хариуцлагатай зохиогч: erdenebatbatzaya83@gmail.com

**Хураангуй:** Сүүлийн жилүүдэд техник технологийн дэвшил, хотжилт, хүн амын төвлөрлийн улмаас гал түймрийн тоо хэмжээ нийслэл хотод жилээс жилд өсөн нэмэгдэж гал түймрийн улмаас үүдсэн хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн хохирол өсөн нэмэгдсээр байна. Ирээдүйд учирч болзошгүй гал түймрийн аюул, эмзэг байдлыг урьдчилан үнэлсний үндсэн дээр гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, гал түймрийн эрсдэлийг үнэлэхэд энэхүү өгүүллийн ач холбогдолыг хандууллаа.

**Abstract.** In recent years, due to technological advances, urbanization, and population concentration, the number of fires in the capital city has been increasing year by year, and the loss of human life, health, and property caused by fires has continued to increase. This article focuses on the importance of planning fire prevention activities and assessing fire risk based on a preliminary assessment of potential future fire hazards and vulnerabilities.

**Түлхүүр үг:** Гал түймэр, гал түймрийн аюул, гал түймрийн эрсдэл, гал түймрийн шалтгаан.

**Keywords:** Fire, fire hazard, fire risk, causes of fire.

#### Удиртгал

Манай оронд тохиолддог гамшгийн төрлүүдээс хамгийн түгээмэл нь объектын гал түймэр болон ой, хээрийн түймэр зонхилон тохиолдож байна. Олон жилийн дунджаас харвал гал түймэр нь нийт гамшгийн 90 гаруй хувь, гамшгийн хохирлын талаас илүү хувийг дангаар бүрдүүлж байна. Дэлхийн хэмжээнд жилд дунджаар 7 сая, хоногт 19178, цагт 799, минутад 13 тооны том жижиг гал түймэр гарч жил бүр 70000 гаруй хүн амь насаа алддаг статистик мэдээлэл байна. Монгол улсын хэмжээнд жилд дунджаар 3400 орчим тооны гал түймэр бүртгэгдэж, дунджаар 50-70 орчим хүн амь насаа алдаж, 30 орчим хүн түлэгдэж бэртэж гэмтдэг ба эдийн засагт дунджаар 4

орчим тэрбум төгрөгийн хохирол учруулж байна.

Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хуульд “гал түймэр” гэж гал хараа хяналтаас гарч, хүний амь нас, эрүүл мэнд, хувь хүн, хуулийн этгээдийн эд хөрөнгө, байгаль орчин, нийгэмд хохирол учруулах шатлагийн процесс юм. Өөрөөр хэлбэл иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэг дор үлэмж хохирлыг үүсгэдэг хор хөнөөл ихтэй гамшиг ослын хэлбэр бөгөөд нийгмийн шинжтэй үзэгдэл юм.

Гал түймрийн аюул - Хүний амь нас, эрүүл мэнд, байгалийн баялаг, эд хөрөнгөд үзүүлэх гал түймрийн хүчин зүйлийн нөлөөллийн шууд ба шууд бус заналхийлэл.

Гал түймрийн эмзэг байдал - Гал



УДИРДАГА  
УДИРДАГА  
УДИРДАГА





түймрийн хүчин зүйлийн нөлөөлөлд хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгалийн баялаг өртөх нөхцөл байдал.

Гал түймэртэй тэмцэх чадавх - Хүний амь нас, хүрээлэн буй орчин, эд материалд нөлөөлөх гал түймрийн хүчин зүйлийн нөлөөлөл болон гал түймрийн үүсэлт тархалтыг хязгаарлах хийц бүтээц, гал түймэртэй тэмцэх техник тоног төхөөрөмж, инженерийн байгууламж, холбоо, мэдээлэл, хүч хэрэгсэл түүний хүчин чадал, мэдлэг зэрэг үйл ажиллагаанд шаардлагатай зохицуулалтын арга хэмжээг хэрэгжүүлсэн байдал.

Гал түймрийн эрсдэл – Гал түймрийн улмаас хүний амь нас, мал амьтан, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хор уршгийн магадлал юм.

“Эрсдэл” хэмээх ойлголтын үүсэл, онолын асуудлыг судлаачид өргөн хүрээнд судалсан боловч тодорхой нэг шидэлд хүрээгүй өдийг хүрсэн байна. “Эрсдэл” гэдэг үг нь эртний Италийн “risicare” гэсэн үгнээс гаралтай бөгөөд энэ үг нь “зүрхлэх, (хувь заяа)” гэсэн утгатай юм байна.

Монгол Улсын стандарт Эрсдэлийн менежмент MNS ISO 31000-2020 нэр томьёоны тодорхойлолтод Эрсдэл гэдгийг тодорхой бус болгож байгаа үр нөлөө. “1-р тайлбар: Хүлээгдэж буй үр дүнгээс хазайх нөхцөлийг үр нөлөө гэх ба энэ нь эерэг, сөрөг эсхүл аль аль нь байж болох бөгөөд боломж эсхүл аюул заналыг бий болгож, түүнд хүргэж болно. 2-р тайлбар: Зорилт нь өөр өөр чиглэл, ангилалтай байж болох бөгөөд өөр өөр түвшинд ашиглаж болно. 3-р тайлбар: Эрсдэлийг ихэвчлэн эрсдэлийн эх үүсвэр, болзошгүй үйл явдлууд, тэдгээрийн үр дагавар, магадлал зэргээр илэрхийлнэ.” гэж

тодорхойлсон байна.

Эрсдэл гэдэг нэр томьёо нь тухайн аюулаас эрсдэлтэй байгаа тухайн объектод ирээдүйд тодорхой хугацааны завсарт хүлээгдэж байгаа хохирлыг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл эрсдэл нь тодорхой бус нөлөөлөл, үр нөлөө ба сөрөг үр дагавартай холбоотой ойлголт бөгөөд санамсаргүй үзэгдэл, хэмжигдэхүүн учир тоон үзүүлэлт талаасаа магадлалын онолтой холбож ойлгох нь зүйтэй<sup>1</sup>.

XX зууны хоёрдугаар хагас хүртэл эрсдэлийг зөвхөн эдийн засгийн (даатгалын асуудал, хөрөнгийн хөрөнгө оруулалт, валютын гүйлгээний дүн шинжилгээ, бизнесийн хөгжлийн стратеги гэх мэт) онолын чиглэлээр авч үздэг байсан. Харин гал түймрийн эрсдэлийн талаарх онолын ойлголтыг Чернобылийн атомын цахилгаан станцын ослын дараа (1986 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр) Оросын Холбооны Улс болон бусад улс оронд энэ чиглэлээр эрдэмтэн, судлаачид эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимтэй хөгжүүлж ирсэн<sup>2</sup>. Английн судлаач Ион Дэвис “Эрсдэлийг үнэлэхгүйгээр төлөвлөгөө боловсруулах нь та эхнэр, хүүхдээ ямар ч оношгүйгээр мээ заслын хагалгаанд оруулахтай агаар нэгэн” гэж зүйрлэсэн байдаг.

Иймээс гал түймрийн аюулын нөлөөлөх хүчин зүйлийг судлах, галын аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, түүнийг бууруулах арга хэмжээг боловсронгуй болгох талаар хэрэгцээ, шаардлага урган гарсаар байна (Ууганбаяр Э., 2025).

### Үндсэн хэсэг

Улаанбаатар хот нь Монгол Улсын нийслэл юм. Нийслэл хот 2025 оны

байдлаар нийт 1,768,151 хүн амтай<sup>3</sup>. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 1км<sup>2</sup> нутаг дэвсгэрт Баянгол дүүрэгт 9688, Чингэлтэй дүүрэг 1642, Сүхбаатар дүүрэгт 686, Хан –Уул дүүрэгт 417, Баянзүрх дүүрэгт 311 оршин сууж байна. Хамгийн бага нягтралтай дүүрэгт Багануур 47, Багахангай дүүрэг 29 харьяалагдаж байна.

Тухайн нутаг дэвсгэрт хүн амын нягтрал хэдий чинээ их байна, энэ нь олон төрлийн гамшгийн аюулд өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг тул хүн амын нягтшил, хөгжлийн бодлого, төлөвлөлтийг оновчтой уялдуулах нь гал түймрийн эрсдэлийг бууруулахад чухал үр дүнтэй байдаг.

Улаанбаатар хот Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 50 орчим хувийг дангаараа бүрдүүлдэг бөгөөд үүнийг салбараар авч үзвэл 70 гаруй хувийг үйлчилгээний, 30 хувийг үйлдвэр болон барилгын салбар эзэлж байна.

Хүн амын төвлөрөл нийслэл хотод ихсэж, нөгөө талаас чанарын шаардлага хангахгүй барилга, байгууламж олноор

баригдаж байгаа нь гал түймрийн эрсдэлийг улам нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсээр байна. Улаанбаатар хотын экосистемийн бүс дэх хүн амын эрчимтэй өсөлт, хэт төвлөрлийн улмаас нийслэл хотод тохиолдох аюулт үзэгдэл, ослын тохиолдох давтамж өсч, учруулах хор хохирол түүний аливаа гамшигт өртөх эмзэг байдал улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Тохиолдож буй аюулт үзэгдэл, ослын төлөв байдал, хүн амд учрах эрсдэлийг үнэлэх улмаар сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох нь нийслэлийн хүн ам, эд хөрөнгийг болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой (<https://www.1212.mn>, огноо байхгүй).

Нийслэл хотод тохиолдож буй аюулт үзэгдэл ослын тоо жилээс жилд өсөн нэмэгдэх хандлагатай байгаа нь доорх статистик үзүүлэлтээс харж болно. Улаанбаатар хотод тохиолдсон аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын тохиолдол зургийг 1 дүгээр зурагт харууллаа.



1 дүгээр зураг. Улаанбаатар хотод тохиолдсон аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын тохиолдол

Дээрх зургаас харахад Улаанбаатар хотод тохиолдсон аюулт үзэгдэл,





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰᠠᠳ ᠲᠣᠭᠣᠨ ᠲᠣᠭᠣᠨ ᠲᠣᠭᠣᠨ

техникийн холбогдолтой ослын 90 гаруй хувийг объектын гал түймэр эзэлсэн байна.


Монгол Улсад 2020-2024 онд бүртгэгдсэн гал түймрийн статистик мэдээлэлээс түүвэрлэн сүүлийн 5

жилийн хүн амын тоо, статистик мэдээлэлд бүртгэгдсэн гал түймрийн тоо, гал түймрийн улмаас нас баралт болон материалын хохирлын тооцооллыг хүснэгт 1-т үзүүлээ.

Он	Хүн ам, сая.хүн			Гал түймэр			Нас баралт			Материалын хохирол, тэрбум		
	Улаанбаатар хог	Аймаг, орон нутаг	Нийт	Улаанбаатар хог	Аймаг, орон нутаг	Нийт	Улаанбаатар хог	Аймаг, орон нутаг	Нийт	Улаанбаатар хог	Аймаг, орон нутаг	Нийт
2020	1597.2	1778.3	3375.5	1772	1264	3036	39	36	75	39.9	88.6	128.5
2021	1639.1	1770.8	3409.9	1509	1162	2671	31	30	61	31.5	100.7	132.2
2022	1691.7	1766.2	3457.9	1682	1398	3075	17	23	40	73.9	663.4	737.3
2023	1734.8	1769.9	3504.7	1563	1491	3054	19	51	70	49.3	170.1	219.4
2024	1768.1	1776.7	3544.8	1895	1704	3599	32	30	62	11.3	240.8	252.1
Жилийн дундаж үзүүлэлт			3458.5	1684.2	1402.8	3087.7	27.6	34.6	61.6	41.1	252.8	293.9

Хүснэгт 1. Монгол Улсын хэмжээнд 2020-2024 онд тохиолдсон гал түймрийн статистик  
Эх сурвалж: (гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2025)


Дээрх хүснэгтээс харахад жилд дунджаар 3087 гал түймэр бүртгэгдэж, гал түймрийн улмаас 61.6 хүн нас барсан байна. Дээрх хүснэгтэн тоон мэдээллээс түүвэрлэн 5 жилийн динамикийг зураг 2-т харууллаа.



Зураг 2. 2020-2024 онд онд улсын хэмжээнд бүртгэгдсэн гал түймэр

Гал түймрийн сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийн динамикаас харахад нийт гал түймрийн 51.9 хувь нь Улаанбаатар хотод, 43.2 хувь нь аймаг орон нутагт бүртгэгдсэн байна.

Гал түймрийн улмаас нас баралтыг Улаанбаатар хот болон аймаг, орон нутгаар ангилсан динамикийг зураг 3-т харууллаа.



Зураг 3. Гал түймрийн улмаас нас баралтын динамик

Гал түймрийн улмаас нас баралтын сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийн динамикаас харахад 44.9 хувь Улаанбаатар хотод, 55.1 хувь нь аймаг орон нутагт бүртгэгдсэн байна.

Манай улсын эдийн засгийн өсөлт, дэд бүтцийг дагаж бизнес эрхлэгчид Улаанбаатар хотод төрөл бүрийн зориулалттай барилга барих сонирхол эрс нэмэгдэж байгаа нь нөхцөл шаардлага хангаагүй зай талбайд хот төлөвлөлтийн болон /Галын аюулгүйн норм стандарт, дүрмийн/ техникийн шаардлага хангахгүй барих нь цөөнгүй байна.

Мөн хүн амын төвлөрөл, хотжилт, гал гэсвэршилтийн зэрэглэл багатай гэр орон сууц, стандартын шаардлага хангаагүй, галын аюулгүй зай хэмжээ зөрчсөн гал түймрийн онц аюултай объектууд нэмэгдэж байгаа зэрэг нь нийслэлийн гал түймрийн эрсдэлийг улам бүр нэмэгдүүлж байна.

Энэхүү тооцоот үзүүлэлт объектын галын аюул бий болох болон тэдгээр нь хүмүүст үзүүлэх хор уршгийн боломжит тоо хэмжээ юм. Гал түймрийн эрсдэлийг дараах нөхцөлд

гал түймрийн аюулгүй байдал хангагдсан гэж үзнэ.

$$R_3 \leq R_3^H$$

$R_3$  – аргачлалын дагуу тооцож гаргасан болзошгүй хувийн гал түймэрт өртөж болзошгүй эрсдэл.

$R_3^H$  –  $10^{-6}$  энэ нь Олон улсын жишигт 1 сая хүн амд 1 хүн гал түймэрт өртөх магадлалыг хэвийн норматит түвшинд байна гэж үздэг.

Улаанбаатар хотын хэмжээнд гарсан гал түймрийг статистик тоон мэдээлэлд тулгуурлан гал түймрийн эрсдэлийг тодорхойлох олон улсын түвшинд хэрэглэгддэг дараах томъёоллоор тодорхойлж үзлээ. Үүнд:

Жилд 1000 хүн амд учирч болзошгүй гал түйрийн эрсдэлийг 100 гал түймрийн улмаас нас барах тоог, 100000 хүн амд харьцуулан илэрхийлж нэг хүнд ноогдох гал түймрийн эрсдэлийг тодорхойлохын тулд дараах томъёоллоор олж болно. Үүнд:

$R_1$  – нэг жилд мянган хүнд ноогдох гал түймрийн эрсдэл  $\left[ \frac{\text{гал түймэр}}{10^{-3} \text{хүн-жил}} \right]$ ;





МУНГАЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ  
 МУНГАЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

$R_2$  – нэг жилд 100 гал түймэрт өртөж нас барах эрсдэл  $\left[ \frac{\text{нас баралт}}{10^{-2} \text{гал түймэр}} \right]$ ;

$R_3$  – нэг жилд 100000 хүн амын гал түймрийн улмаас нас барах эрсдэл  $\left[ \frac{\text{нас баралт}}{10^{-5} \text{хүн-жил}} \right]$ ;

$R_4$  – гал түймрийн улмаас барилга байгууламж эвдрэх эрсдэл,  $\left[ \frac{\text{барилга, байгууламж}}{\text{гал түймэр}} \right]$ ;

$R_5$  – гал түймрийн материаллаг шууд хохирлын эрсдэл,  $\left[ \frac{\text{төгрөг}}{\text{гал түймэр}} \right]$ ;

Гал түймрийн эрсдэлийн  $R_1, R_2, R_3$  хоорондоо харилцан хамааралтай.

Гал түймрийн шууд эрсдэлийг тодорхойлохдоо  $R_1, R_2, R_3$  харилцан холбоогоор тодорхойлж болно (Ууганбаяр Э., 2025).

$$R_3 = R_1 \cdot R_2$$

Улсын хэмжээнд гарсан гал түймрийн эрсдэлийг тодорхойлохын тулд 2020-2024 онд гарсан статистик тоо баримтыг үндэслэн гал түймрийн нөхцөл байдалд дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ, үзүүлэлтүүдийг тодорхойлон 2 дугаар хүснэгтэд харууллаа.

Үзүүлэлт		Он					Жилийн дундаж үзүүлэлт
		2020	2021	2022	2023	2024	
$R_1 (10^{-3})$	Улаанбаатар хот	1.10	0.92	0.99	0.90	1.07	0.99
	Аймаг, орон нутаг	0.71	0.65	0.79	0.84	0.95	0.78
	Нийт	0.89	0.78	0.88	0.87	1.01	0.88
$R_2 (10^{-2})$	Улаанбаатар хот	0.022	0.020	0.010	0.012	0.016	0.016
	Аймаг, орон нутаг	0.028	0.025	0.016	0.034	0.017	0.024
	Нийт	0.024	0.022	0.013	0.022	0.017	0.020
$R_3 (10^{-5})$	Улаанбаатар хот	0.024	0.018	0.009	0.010	0.017	0.016
	Аймаг, орон нутаг	0.020	0.016	0.013	0.029	0.016	0.018
	Нийт	0.021	0.017	0.011	0.019	0.017	0.017

Хүснэгт 2. 2020-2024 онд бүртгэгдсэн гал түймрийн эрсдэлийн түвшингийн аналалын динамик


Дээрх хүснэгтэд улсын хэмжээнд 2020-2024 онд бүртгэгдсэн гал түймрийн эрсдэлийн  $R_1, R_2, R_3$  түвшинг Улаанбаатар хот, аймаг орон нутаг, нийт дүнгээр харьцуулан судаллаа. Нийт бүртгэгдсэн гал түймрийн тоог хүн амын тоотой харьцуулсан үзүүлэлтээр тооцоход, гал түймрийн улмаас нас барах магадлал харьцангуй өндөр байна.

Гал түймрийн давтамж нь тухайн орон нутгийн нэг жилийн хугацаанд

гарах гал түймрийн давтамжаар тодорхойлогдоно. Мөн түүнчлэн гал түймрийн давтамж нь объектын барилга, байгууламж болон тухай нутаг дэвсгэрийн хэмжээнд нэг жилийн хугацаанд гарах объектын болон ой хээрийн гал түймрийн давтамжаар тодорхойлно (Ууганбаяр Э., 2025).


Гал түймрийн шалтгаан нөхцөлийн ангиллын статистик мэдээллийг 3 дугаар зурагт үзүүллээ.

## Гал түймрийн шалтгаан



	галтай санамсар болгоомжгүй харьцсан	цахилгаан тоног, төхөөрөмжийн ашиглалтын дүрэм зөрчсөн	пийшин зуухны буруу ашиглалт	ил гал болон бусад	шалтгаан тогтоогдоогүй
■ Sales	39	28	19	8	6

## Гал түймрийн шалтгааны улмаас нас баралт



	галтай санамсар болгоомжгүй харьцсан	цахилгаан тоног, төхөөрөмжийн ашиглалтын дүрэм зөрчсөн	пийшин зуухны буруу ашиглалт	ил гал болон бусад	шалтгаан тогтоогдоогүй
■ Sales	47.7	17.8	28.7	0.77	5.03

Зураг 4. Улсын хэмжээнд гарсан гал түймрийн тархалт: а) гал түймрийн шалтгаан; б) гал түймрийн шалтгааны улмаас нас баралт

Дээрх зургаас харахад гал тогтооход нийт гал гарсан шалтгааны түймрийн шалтгаан нөхцөлийг 39 хувь нь галтай санамсар





болгоомжгүй харьцсанаас үүссэн бөгөөд гал түймрийн улмаас нас баралтын 47.7 хувь нь галтай санамсар болгоомжгүй харьцсанаас амь насаа алдсан байна.

Статистик тоон мэдээллээс үзэхэд, гал түймрийн нийт тохиолдлын 19 хувь нь пийшин, зуухыг буруу ашигласнаас үүдэлтэй, Энэхүү шалтгааны улмаас гарсан гал түймрийн 28.7 хувьд хүмүүс амь насаа алдсан байна. Мөн цахилгаан тоног төхөөрөмжийн буруу хэрэглээ болон цахилгаан ашиглалтын дүрэм зөрчсөнөөс үүдэлтэй гал түймэр 28 хувийг эзэлсэн бөгөөд тухайн шалтгаанаас 17.8 хувьд амь насаа алдсан тохиолдол бүртгэгдсэн байгаа нь 80-90 хувь нь хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй байна.

Нийслэлд тохиолдож буй эдгээр аюулт үзэгдэл, осол нь хүн амын амьжиргааг төдийгүй, улс орны эдийн засагт доройтуулах ноцтой үр дагаврыг бий болгох магадлалтай.

Тогтвортой хөгжлийг хангаж, нийслэл хотын хүн ам, эд хөрөнгө, байгаль орчныг гамшгийн аюулаас сэргийлэх, хамгаалах тогтолцоог бэхжүүлэхийн тулд эрсдэлийг тооцох зайлшгүй шаардлага урган гарсаар байна (Ууганбаяр Э., 2025).

### Дүгнэлт

Монгол улсын хэмжээнд гарч буй гал түймрийн сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийн динамикаас харахад нийт гал түймрийн 51.9 хувь нь Улаанбаатар хотод, 43.2 хувь нь аймаг орон нутагт бүртгэгдсэн байна.

Гал түймрийн улмаас нас баралтын сүүлийн 5 жилийн дундаж үзүүлэлтийн динамикаас харахад 44.9 хувь Улаанбаатар хотод, 55.1 хувь нь аймаг орон нутагт бүртгэгдсэн байна.

Гал түймрийг статистик тоон мэдээлэлд үндэслэн гал түймрийн

эрсдэлийг дараах томъёоллоор тодорхойлж үзсэн байдаг байна. Энэхүү томъёоллоор жилд 1000 хүн амд учирч болзошгүй гал түйрийн эрсдэлийг 100 гал түймрийн улмаас нас барах тоог, 100000 хүн амд харьцуулан илэрхийлж нэг хүнд ноогдох гал түймрийн эрсдэлийг тодорхойлж үзлээ.

Улсын хэмжээнд 2020-2024 онд бүртгэгдсэн гал түймрийн эрсдэлийн  $R_1, R_2, R_3$  түвшинг Улаанбаатар хот, аймаг орон нутаг, нийт дүнгээр харьцуулан судаллаа. Нийт бүртгэгдсэн гал түймрийн тоог хүн амын тоотой харьцуулсан үзүүлэлтээр тооцоход, гал түймрийн улмаас нас барах магадлал харьцангуй өндөр байна.

Гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтооход нийт гал гарсан шалтгааны 39 хувь нь галтай санамсар болгоомжгүй харьцсанаас үүссэн бөгөөд гал түймрийн улмаас нас баралтын 47.7 хувь нь галтай санамсар болгоомжгүй харьцсанаас амь насаа алдсан байна.

### Эх сурвалжийн жагсаалт

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ 2017
2. Галын аюулгүй байдлын тухай хууль, УБ 2015
3. Ш.Паламдорж Батлан хамгаалах стратеги, УБ 2017
4. Монгол Улсын стандарт “Эрсдэлийн менежмент” MNS ISO31000:2020
5. Э.Ууганбаяр Галын аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага, түүнийг боловсронгуй болгох арга зам. Аюулгүй байдлын ухааны докторын зэрэг горилсон диссертац. УБ.,2025
6. Монгол Улсын стандарт MNS 4284:2006 “Галын ангилал”
7. Үндэсний статистикийн хороо. Хүн амын судалгаа <https://www.1212.mn>

8. Н.Н. Брушлинский, Основы теории пожарных рисков и ее приложения [Текст]: монография / Н.Н. Брушлинский, С.В. Соколов, Е.А. Клепко, В.А. Белов, О.В. Иванова, С.Ю. Попков. – М.: Академия ГПС МЧС России, 2012
9. Н.Л. Присяжнюк, Т.Н.Соловьева Категория «чрезвычайная ситуация» и ее связь с пожаром // Материалы тринадцатой научно-технической конференции «Системы безопасности» - СБ-2004. М.: Академия ГПС МЧС России, 2004.
10. Присяжнюк Н.Л., Соловьева Т.Н. Некоторые аспекты анализа и управления пожарным риском // Вестник Академии ГПС МЧС России. – М.: Академия ГПС МЧС России, 2005



## ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ, АВРАХ 66 ДУГААР АНГИЙН БЭЛЭН БАЙДАЛ, ГАЛ СӨНӨӨГЧДИЙН УР ЧАДВАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### ANALYSIS OF THE READINESS AND FIREFIGHTER'S SKILL OF FIRE FIGHTING AND RESCUE UNIT #66

#### Ц.Балжинням

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

#### Ts. Baljinnuam

Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, Captain

\*хариуцлагатай зохиогч: ts.baljka2020@gmail.com

**Хураангуй:** Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 2200 объектын гал түймрийн дуудлага мэдээлэл бүртгэгдэж байна, үүний улмаас 55 хүн амь нас эрсдэж, 380 гаруй толгой мал хорогдож, 30 орчим тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч байна. Монгол орон өргөн уудам нутаг дэвсгэртэй, алслагдмал сум, суурин газарт хүч очиж боломж хязгаарлагдмал тул зарим аймгуудын алсдагдмал сумдад гал түймэр III,IV зэргийн ангиудыг байгуулан ажиллуулж байна. Гал түймрийн үеийн хариу арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд гал сөнөөгчдөөс мэргэжлийн өндөр ур чадвар, арга тактикийн нарийн бэлтгэл шаардагддаг. Гал түймэр унтраах анги, бүлгүүд нь цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд ил задгай орчинд гарсан гал түймэр, тээврийн хэрэгсэл, олон нийтийн болон олон зориулалттай барилга байгууламж, шингэрүүлсэн шатдаг хий бүхий объект, мөн цацраг болон химийн аюултай орчинд гарсан гал түймрийг унтраах ажиллагаанд оролцдог. Эдгээр ажиллагааг ихэвчлэн агааргүй орчин, давчуу орон зай, хорт бодис хий ялгарах, галын тархалт нэмэгдэх, бүтцийн тогтворгүй байдал үүсэх зэрэг өндөр эрсдэл бүхий нөхцөлд гүйцэтгэдэг.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Онцгой байдлыг ерөнхий газрын харьяа, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гал түймэр 66 дугаар ангийн бэлэн байдлын шинжилгээ хийж үзлээ. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг үнэлэхэд ерөнхий чадавхын үнэлгээнд АНУ-ын ABS зөвлөх компанийн боловсруулсан “Эрсдэл ба бэлэн байдлын үнэлгээний загвар” болон Р. Оюун, Ш. Болдбаатар нарын боловсруулсан “Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгийн менежментийн чадавхыг үнэлэх арга зүйн заавар”-ыг ашигласан. Үнэлгээний үр дүнд тус гал түймэр, аврах ангийн бэлэн байдал 3.2 гэж дүгнэгдсэн бөгөөд энэ нь “Гал түймэр, аврах ангийн бие бүрэлдэхүүн удаан хугацаагаар гал түймэр, ослын үеийн хариу арга хэмжээ авахад бэлэн байх магадлал бага” дүгнэгдсэн байна. Гал түймэр, аврах анги бие бүрэлдэхүүний хувьд нийт 12 гал сөнөөгч нараас гал сөнөөгч мэргэжилтэй 1 хүн, 10 дээш жилийн ажлын туршлагатай 2 хүн, 10 хүртэлх жилийн ажлын туршлагатай 10 хүн бөгөөд 100 дээш гал түймэр унтраах ажиллагаанд оролцон 2 хүн, 20-40 удаагийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцон 7 хүн, 10 доош гал түймэр унтраах ажиллагаанд оролцсон 3 хүн байгаа нь мэргэжлийн гал сөнөөгч цөөхөн, гал сөнөөгч нарын ихэнх нь гал түймэр аврах ажиллагаанд оролцсон туршлага бага байгаа нь судалгааны үр дүнд нөлөөлөх үндэс болж байна.

**Abstract:** On average, approximately 2,200 fire incidents are reported annually across Mongolia, resulting in 55 human fatalities, the loss of over 380 livestock, and

property damage estimated at around 30 billion MNT. Due to Mongolia's vast territory and the remoteness of many sums and settlements, access and response capabilities are limited. Consequently, some remote sums in certain provinces operate fire units classified as Level III or IV. Effective response during fire incidents requires firefighters to possess advanced professional skills and precise tactical preparation. Firefighting units and teams participate in extinguishing fires that occur under challenging conditions, including open areas affected by severe weather, vehicles, public and multipurpose buildings, facilities containing liquefied combustible gases, as well as radiological and chemical hazard environments. These operations are typically conducted under high-risk conditions such as poor ventilation, confined spaces, toxic gas exposure, rapid fire spread, and structural instability.

Within the scope of this study, a readiness assessment was conducted for Fire Unit No. 66 in Khanbogd sum, Ömnögovi Province, which operates under the General Authority for Emergency Management. To evaluate the readiness of this firefighting and rescue unit, the overall capability assessment utilized the "Risk and Readiness Assessment Model" developed by the U.S.-based ABS Consulting firm, along with the "Methodological Guidelines for Evaluating Disaster Management Capacity of Enterprises and Organizations" by R. Oyoon and Sh. Boldbaatar. The evaluation results rated the unit's readiness at 3.2, indicating that "the firefighting and rescue personnel have a low probability of being fully prepared for prolonged response operations during fires or accidents." Among the 12 personnel, only one is professionally trained as a firefighter, two have more than ten years of work experience, and ten have up to ten years of experience. In terms of operational exposure, two personnel have participated in over 100 fire suppression operations, seven have participated in 20–40 operations, and three have participated in fewer than ten operations. This indicates a limited number of professional firefighters, and most personnel have little practical experience in fire suppression and rescue operations, which constitutes a key factor affecting the results of this study.

**Түлхүүр үгс:** Гал түймэр, аврах, бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварын шинжилгээ

**Keywords:** Fire, rescue, extinguishing, preparedness, analysis.

### Удиртгал

Монгол Улсын хэмжээнд жилд дунджаар 2200 объектын гал түймрийн дуудлага мэдээлэл бүртгэгдэж байна, үүний улмаас 55 хүн амь нас эрсдэж, 380 гаруй толгой мал хорогдож, 30 орчим тэрбум төгрөгийн эд хөрөнгийн хохирол учирч байна. Гал түймэрт нас барсан хүмүүсийн 60-70 орчим хувь нь бага насны хүүхдүүд байдаг (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Онцгой байдлын ерөнхий газар, 2008). 2023 оны 11 дүгээр сарын байдлаар Улсын хэмжээнд объектын гал түймрийн 2748

дуудлага мэдээлэл бүртгэгдэж объектын гал түймэрт 53 иргэн өртөж нас барж, 32 иргэн түлэгдсэн байна (Н.Отгонбаатар, 2023). Улсын хэмжээнд 2024 онд объектын гал түймрийн 3479 тохиолдол бүртгэгдэж /гал түймэр дээр ажилласан 2684, зөрчил 533, мэдээлэл 262/, 23 иргэний /том хүн 7, хүүхэд 16/ амь насыг аварч, утаажилтын бүсээс 3373 иргэнийг гаргасан. Гал түймэрт 60 иргэн /том хүн 43, хүүхэд 17/ өртөж нас барж, 52 иргэн /том хүн 44, хүүхэд 8/ түлэгдэж, 6 иргэн /том хүн 6/ бэртэж, 16 иргэн /13





том хүн, 3 хүүхэд/ угаартсанаас 2 иргэн /том хүн 2, хүүхэд 0/ угаартаж нас барсан байна. 2024 онд объектын гал түймрийн дуудлага, мэдээллийг 2023 онтой харьцуулахад гал түймрийн тоо 13,9 хувиар, гал түймэрт өртөж нас барсан иргэний тоо 6,3 хувиар тус тус өссөн (гамшиг судлалын үндэсний хүрээлэн, 2024). Галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээллийг иргэдэд түгээх ажил харьцангуй хязгаарлагдмал, тухайн нөхцөл байдад бүрт тохирсон арга хэмжээг хэрхэн авах талаар нарийвчилсан мэдээллийг иргэдэд хүргэж чадахгүй байгаагаас гал түймрийн ялангуяа объектын гал түймрийн тохиолдол буурахгүй байна. Олон улсын хэмжээнд жилд нийт 8 сая гаруй гал бүртгэгддэг ба Европын улс, АНУ, БНХАУ, ОХУ -уудад нийтдээ 30000 хүний аминд хүрч дэлхий даяар 800000 хүн гал түймэрт хохирдог байна. Гал түймэр нь гэр орон байшин сууцыг сүйтгэн устгаж олон гэр бүлийг үгүйрэл, хоосролд хүргэхээс гадна олон байшин, оффис, түймэрт өртсөнөөх бизнес үйлчилгээний салбарт асар их хохирол учруулж олон зуун компанийг дампуурахад хүргэдэг байна. Дэлхий аюулгүйн консул, гал түймэр нь өдөр хөгжилтэй орнуудын хувьд ДНБ -ний 1 хувьтэй тэнцэх хэмжээний хохирол учруулдагийг олон улсын байгууллагууд тайлагнасан байна.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааг мэргэжлийн нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, гал түймэр унтраах албаны бэлтгэл, бэлэн байдалд үнэлгээ дүгнэлт өгч ажиллаж байна. Монгол Улсын Шадар сайдын 2025 он 93 дугаар тушаалаар батлагдсан Онцгой байдлын байгууллагын бүсийн

ажиллах журмаар гамшиг, томоохон аюулт үзэгдэлтэй тэмцэх, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж бүсийн онцгой байдлын байгууллагуудын төлөвлөлт, бэлэн байдал, харилцан ажиллагааг хангах, бүсийн төв, түүний харьяа байгууллагуудын удирдлага, эрх, үүргийг тодорхойлон ажиллаж байгаа билээ. Гэсэн хэдий ч Монгол орон өргөн уудам нутаг дэвсгэртэй, алслагдмал сум, суурин газарт хүч очиж боломж хязгаарлагдмал тул зарим аймгуудын алсдагдмал сумдад гал түймэр III, IV зэргийн ангиудыг байгуулан ажиллуулж байна. Шинээр байгуулагдсан эдгээр ангиудын объектод гарсан гал түймэр аврах ажиллагааг зохион байгуулах үеийн гал сөнөөгч нарын үүрэг гүйцэтгэх чадавхыг сайжруулах, ялангуяа гал түймэр ангиудын бэлэн байдал болон гал сөнөөгчдийн ур чадварт шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээг зөвлөмж боловсруулах зорилгоор судлаж сэдвийг сонгосон болно.

**Судлагдсан байдал:** Гал түймэр унтраах ангийн бэлтгэл бэлэн байдлыг сайжруулах, аврагч гал сөнөөгч, нарын сургалт дадлага сургалтыг сайжруулах талаар судалгааны ажил хийгдэж байна. Үүнд:

Тухайлбал: К. Султанинкарим (2001), “Гал сөнөөгчдийн хөдөлмөрийн нөхцөлийг тогтоох асуудал”, М. Г. Шувалов (2009), “Основы пожарного дела”, В. М. Величко (2012), “Подготовка пожарных в прикладном спорте”, З.Билгүүн, “Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам” (2016), Отгонсүрэн “ Гал түймэр салааны үүрэг гүйцэтгэх чадавхын түвшнийг

үнэлэх онол, практик” (2014), Д.Ганболд “Гал түймэр багаж зэвсэглэмж” (2010 он), Т.Лхамжав ““Гал түймэр арга зүй”, (2002 он), О.Ганхуяг “Гал түймэр мэргэжлийн сургалтын сурах бичиг”, (2015) зэрэг ном бүтээл нийтлүүлсэн байна.

**Судалгааны ажлын зорилго:** Гал түймэр, аврах ангийн бэлэн байдлын талаарх ойлголт, мөн чанарыг судалж, ОБЕГ-ын харьяа гал түймэр анги салбарын бэлэн байдалд дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулахад тодорхойлоход оршино.

Тус зорилгын дагуу дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

1. Бэлэн байдлын тухай ойлголт, мөн чанарыг судлах.

2. Говийн бүсийн төв-Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 66 дугаар ангийн бэлэн байдал болон гал сөнөөгчдийн ур чадварт дүн шинжилгээ хийх.

3. Гал түймэр ангийн бэлэн байдал болон гал сөнөөгчдын ур чадварыг дээшлүүлэх талаар зөвлөмж боловсруулахад оршино.

Гал түймэр ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварыг судлахын тулд Гал түймэр 66 дугаар ангийг судалгааны ажлын объект болгон сонгож авсан. Тус судалгааны ажлыг хийхдээ дараах судалгааны арга зүйг ашиглаж байна. Судалгаанд харьцуулах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг үндсэн арга болон судалгааны ажлын тоон болон чанарын түгээмэл, арга зүй, аргачлалыг ашиглах.

### Судалгааны үр дүн:

#### 1. Бэлтгэл бэлэн байдлын тухай ойлголт ба үндсэн зарчим

Гал түймэр унтраах аврах ажиллагаа нь объектод гарсан гал түймэр, барилгын хана, дээвэр нурах,

дэлбэрэлт зэрэг аюулт нөхцөлд боогдсон, бэртэж гэмтсэн иргэдийг аврах тусгай ажиллагаа юм. Гал сөнөөгчид нь гал түймрийн орчинд ажиллахад бэлтгэгдсэн тусгай баг бөгөөд гал түймрийн үеийн хариу арга хэмжээ авах өндөр арга, багаж зэвсэглэмжийн ур чадварыг шаарддаг. Гал түймэр анги, бүлгүүд нь цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд ил задгай орчинд гарсан гал түймэр, тээврийн хэрэгсэл, олон нийтийн болон олон зориулалттай барилга, байгууламж, шингэрүүлсэн шатдаг хий бүхий объект, цацраг болон химийн аюул бүхий объектод гарсан гал түймэр унтраах ажиллагаанд оролцдог бөгөөд ихэвчлэн агааржуулалтгүй орчин, хязгаарлагдмал орон зай, хорт утаа, объектийн өөрчлөлт зэрэг эрсдэлтэй нөхцөлд үүрэг гүйцэтгэж байна. Гал түймэр гарах үед гал түймэр, аврах ажиллагаа явуулахад мэдээл мэдээлэл дамжуулалт, цагын тооцоолол, цагын байдлын нарийн төвөгтэй байдал гэсэн гурван гол хүчин зүйл байдаг. Иймээс гал түймэр унтраах, аврах тасгуудын үйл ажиллагаанд бэлтгэл, бэлэн байдлыг тогтмол хангах нь чухал ач холбогдолтой. Үүнд алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, бие бялдар болон сэтгэл зүйн бэлтгэл, онолын мэдлэг, техникийн мэдлэг, практик дадлага, туршлагыг тасралтгүй хөгжүүлэх шаардлага тавигддаг. Гал түймэр болон аврах ажиллагааг гүйцэтгэх явцад тухайн үеийн нөхцөл байдлыг бодитой үнэлж, оновчтой шийдвэр гаргах чадвар нь алба хаагч өөрийн болон бусдын аюулгүй байдлыг ханган үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэх үндсэн нөхцөл болдог.

Шинжлэх ухааны ном зохиол, мөн цэргийн болон гамшгаас хамгаалах салбарын нэр томъёоны тайлбар толь бичгүүдэд “бэлэн байдал” гэсэн ойлголтыг тухайн үйл ажиллагааны





онцлог, зорилготой уялдуулан өөр өөр байдлаар тодорхойлж тайлбарласан байдаг. Тухайлбал, цэргийн нэр томъёоны тайлбар тольд “байлдааны бэлэн байдал” гэдгийг тухайн нэгж, анги нь цагийн ямар ч нөхцөлд тогтоосон хугацаанд байлдааны ажиллагаанд шилжин орж, дээд командлалаас өгсөн үүргийг бүрэн хэрэгжүүлэх бодит чадварын түвшин гэж үздэг (Ш.Паламдорж, Цэргийн нэр томъёоны тайлбар толь, 2014). Мөн гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд “бэлэн байдал” гэдэг нь эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээнд тулгуурлан гамшиг тохиолдохоос өмнө авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд бий болсон бэлтгэл, чадавхыг илэрхийлдэг ойлголт юм (Ш.Паламдорж, цэргийн нэр томъёоны тайлбар толь, 2014). Судлаач Nick Carter бэлэн байдлыг гамшгийн менежментийн хүрээнд тайлбарлахдаа гамшиг тохиолдсон үед төрийн байгууллага, орон нутгийн захиргаа, байгууллага, иргэдийн зүгээс учирч болзошгүй хор уршгийг бууруулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулахад чиглэсэн урьдчилсан бэлтгэлийг хэлнэ гэж үзсэн байна. Үүнд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, шаардлагатай хүн хүч хэрэгсэл болон бараа материалын, багаж зэвсэглэмжийн нөөцийг бүрдүүлэх, бүрэлдэхүүний сургалт, дадлагыг зохион байгуулах зэрэг арга хэмжээнүүд багтдаг (Ш.Бодбаатар, 2005). Түүнчлэн уг судлаач гамшгийн менежментийн агуулгыг тодорхойлохдоо бэлэн байдлыг гол хүчин зүйл гэж үзсэн бөгөөд гамшгийн менежменттэй холбоотой ихэнх асуудал нь бэлэн байдлын түвшинтэй шууд хамааралтай болохыг онцолсон байдаг. Түүний үзэж байгаагаар урьдчилан сэргийлэх болон хохирлыг бууруулах арга хэмжээнүүд нь

ихэвчлэн төрийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд дээд түвшинд хэрэгждэг бол бэлэн байдлыг хангах арга хэмжээнүүд нь байгууллага бүрийн түвшинд хэрэгжих онцлогтой байдаг. Иймээс бэлэн байдлыг хангах үйл ажиллагаанд олон байгууллага хамрагддаг тул тэдгээрийн үйл ажиллагааг харилцан уялдуулах, зохицуулах асуудал тодорхой хүндрэл дагуулдаг гэж үзсэн байна (Ш.Бодлбаатар, 2005). Гамшгаас хамгаалах тухай хуулийн “Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах” гэсэн 10.1-д “өдөр тутмын бэлэн байдал”, “өндөржүүлсэн бэлэн байдал”, “бүх нийтийн бэлэн байдал” гэсэн зэрэгтэй байна гээд 10.3.3-д “гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн бэлэн байдлыг хангах” гэж заасан байдаг (гамшгаас хамгаалах тухай хууль, 2017). Онцгой байдлын ерөнхий газарын дэргэдэх Гамшиг судлалын хүрээлэн-гээс хэвлүүлсэн “Гамшгийн нэр томъёоны тайлбар толь”-д бэлэн байдлыг гамшгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх урьдчилсан бэлтгэлийн үйл ажиллагаа гэж тайлбарласан байдаг. Энэ нь эрсдэлийн үнэлгээ, дүн шинжилгээнд тулгуурлан гамшиг тохиолдохоос өмнө хэрэгжүүлэх бодлого, стратеги, зохион байгуулалтын арга хэмжээг хамарна. Үүнд байгууллагын бүтэц, удирдлагын зохион байгуулалт, зарлан мэдээллийн тогтолцоо, урьдчилан сэрэмжлүүлэх боломж, чадавхыг бүрдүүлэх, мөн болзошгүй аюул заналхийлэл болон бодит гамшгийн үед хүн амыг сэрэмжлүүлэх, хамгаалах арга хэмжээг төлөвлөх, түүнийг тасралтгүй сайжруулах үйл ажиллагаа багтдаг гэж үзсэн байна. (гамшиг судлалын хүрээлэн, 2012) Судлаач З.Билгүүн гал түймэр унтраах, аврах ангийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдал нь тухайн ангийн бие бүрэлдэхүүний хангалт, мөн ашиглагдаж буй техник, тоног

төхөөрөмжийн бэлэн байдлаас ихээхэн хамааралтай болохыг онцолсон байдаг. Тэрээр гал түймэр унтраах, аврах ангийн хүчин чадал болон байлдааны бэлэн байдлын түвшинг үнэлэхдээ хүний нөөцийн хангалт, техник хэрэгслийн ашиглалтын боломж, бэлтгэлжилтийн түвшинг харгалзан үзэх шаардлагатай гэж үзжээ. Мөн судалгааны үр дүнд II, III, IV зэрэглэлийн гал түймэр унтраах, аврах ангиудын орон тоо бүрэн хангагдаагүй байгаа нь ангийн бэлэн байдлын түвшин буурахад нөлөөлж буй гол хүчин зүйлсийн нэг гэж дүгнэсэн байна (З.Билгүүн, 2016)

Орчин үеийн байгууллагууд өрсөлдөх чадвар, уян хатан байдлаа хадгалах үүднээс уламжлалт тогтсон ажлын байрны бүтцээс илүүтэй ажилтнуудын ур чадварт суурилсан зохион байгуулалтын хэлбэрт шилжих хандлага нэмэгдэж байна. Ийм хандлагыг ур чадварт суурилсан байгууллага болон багийн загвараар тайлбарладаг бөгөөд энэ нь ажилтнуудын мэдлэг, чадварыг гол хүчин зүйл болгон ашиглаж, хүний нөөцийн боломжийг илүү үр ашигтай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлдэг. Удирдлагын түвшинд нөөцийн хуваарилалт, бүтээгдэхүүн болон үйлчилгээний гүйцэтгэлийг оновчтой төлөвлөхөд ажилтнуудын ур чадварын талаарх мэдээлэл чухал ач холбогдолтой. Ялангуяа байгууллагын бүтэц өргөжихийн хэрээр ур чадварын мэдээллийн санг бүрдүүлэх, түүнд тулгуурлан шийдвэр гаргах нь менежментийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлдэг. Иймээс ур чадварт суурилсан байгууллагын тогтолцоог бүрдүүлэхийн тулд ажиллах хүчний мэдлэг, ур чадварын талаарх үнэн зөв, чанартай мэдээллийн нэгдсэн санг бий болгох шаардлагатай гэж үздэг. Энэхүү үзэл баримтлалын хүрээнд далд

уурхайн аврагчийн үүрэг гүйцэтгэх ур чадварыг байгууллагын болон багийн үйл ажиллагаанд суурилсан хоёр түвшинд авч үзэх боломжтой. Гэвч аврах ажиллагааны онцлог, хамтын ажиллагаанд тулгуурласан гүйцэтгэлийг харгалзан үзвэл тухайн үүргийг гүйцэтгэх ур чадварыг багийн ур чадварт суурилсан байдлаар тодорхойлох нь илүү оновчтой гэж үздэг (Б.Алтангэрэл, 2025)

**2. Говийн бүсийн төв-Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын Ханбогд сум дахь гал түймэр унтраах, аврах 66 дугаар ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварт хийсэн дүн шинжилгээ**

“Аврагч” гэж аврах ажиллагааны арга технологийг эзэмшиж, мэргэжлийнхээ дагуу Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, аврах болон мэргэжлийн ангид ажиллаж байгаа мэргэшсэн албан хаагчийг хэлнэ гэсэн байна (онцгой байдлын ерөнхий газар, 2015). Дээрх тодорхойлолтод үндэслэн үзвэл “аврагч” гэсэн ойлголт нь Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагын харьяанд ажиллаж буй, түүнчлэн аврах болон мэргэжлийн ангид үүрэг гүйцэтгэж байгаа мэргэшсэн офицер, ахлагч нарыг хамруулсан өргөн хүрээтэй ойлголт юм.

Галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 11.1-д зааснаар, гал түймэр унтраах аврах анги нь улсын хэмжээнд өмчийн хэлбэрээс үл хамааран иргэн, аж ахуй нэгж, байгууллагын өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас хамгаалах, гал унтраах үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Онцгой байдлын байгууллагын үндсэн нэгж юм. 11.2-д дурдсанаар, тус анги нь гал унтраах болон ослоос аврах зориулалтын техник, тоног төхөөрөмж,





мөн анхны тусламж, аврах чиг үүрэгтэй томилгоот бүрэлдэхүүнтэй байх шаардлагатай. (онцгой байдлын ерөнхий газар, 2015). Гал түймэр унтраах дүрмийн Гал түймэр бэлэн байдал гэсэн хоёрдугаар бүлгийн 6-д “Гал түймэр унтраах ажиллагааны бэлэн байдлыг хангах үндэс нь томилгоот ээлжийн бүрэлдэхүүний дадлага, сургалтын төлөвлөлт, зохион байгуулалтын арга хэмжээ болно”, 7-д “ дадлага сургалт нь хувь хүний хөгжил, хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, автомашин техник, багаж, хэрэгслийн ашиглалт, бэлэн байдлыг хангахад чиглэнэ”, Шинэчилсэн найруулгын 8.4-д зааснаар, гал түймэр унтраах аврах анги нь үйл ажиллагаа явуулах зориулалтын байр, албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах боломж бүхий байгууламж, мөн бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, бие бялдарын гэсвэр хатуужлыг хөгжүүлэх, гал түймрийн дасгал сургуулилт явуулах зориулалттай тусгай газар эзэмшдэг байх шаардлагатай гэж заасан (Монгол улсын шадар сайдын тушаал 24 дүгээр тушаалын хавсралт, 2024).

Энэ бүгдээс үзэхэд гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг гал түймэр унтраах ажиллагаа, анхны тусламж үзүүлэх болон мэдлэг ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, авто машин, тусгай техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглах, сургалт бэлтгэл гэсэн үзүүлэлтээр үнэлж болох байна. Гал түймэр унтраах, аврах ажиллагааг нь өндөр эрсдэлтэй орчинд үүрэг гүйцэтгэдэг тул бие бүрэлдэхүүний бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор сургалт, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Тухайлбал, цаг агаарын хүндрэлтэй, ил задгай орчинд гарсан гал түймэр, тээврийн хэрэгсэл, олон нийтийн

болон олон зориулалттай барилга, байгууламж, шингэрүүлсэн шатдаг хий бүхий объект, цацраг болон химийн аюултай объектод гарсан гал түймэр унтраах ажиллагаанд оролцдог. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлтгэл бэлэн байдал нь өдөрт тутмын сургуулилт, багаж зэвсэглэмж, холбоо зохион байгуулалт, бие бялдар, Хөдөлмөрийн аюулгүй байдлын дүрэм, журамаар зохицуулна .

Гал түймэр унтраах, аврах ажиллагааны үр дүн, гал сөнөөгчдийн аюулгүй байдал нь бэлэн байдлын түвшнээс ихээхэн хамаардаг. Иймээс бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, сургалт бэлтгэлийн байдлыг тогтмол хянах, сайжруулах нь гал сөнөөгчдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, мөн аврах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад чухал ач холбогдолтой. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг хангах нь ихэвчлэн ур чадварын хөгжүүлэлт, багаж зэвсэглэмжийн бэлтгэл бэлэн байдал, холбоо зохион байгуулалт болон үйл ажиллагааны уялдаа холбоо, бие бялдар ба эрүүл мэндийн бэлтгэл, аюулгүй ажиллагааны журам, логистик болон дэмжлэгийн систем, түүнчлэн ослын дараах дүн шинжилгээ, сургамжийг тусгах боловсролын арга хэмжээнүүдийг хамардаг (IG), ametica). Бэлэн байдлын түвшинг тогтмол шаардлагад нийцүүлэн хадгалах нь байгууллагын удирдлагын хувьд нэлээд төвөгтэй асуудлын нэг юм. Хэрэв энэ чиглэлээр системтэй арга хэмжээ авахгүй бол бэлэн байдлын түвшин богино хугацаанд буурах эрсдэлтэй байдаг. Иймээс бэлэн байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөлт нь бодит нөхцөлд нийцсэн байх шаардлагатай бөгөөд сургалт, дадлага, үзлэг шалгалт, төлөвлөгөөний тодотгол, үүрэг гүйцэтгэх чадварын үнэлгээ, мөн гал түймрийн дараах дүн

шинжилгээ хийх зэрэг арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх нь чухал ач холбогдолтой (ОБЕГ даргын 2022 он А/82 дугаар тушаал, 2022). Энэхүү судалгаанд бэлэн байдлын ерөнхий үнэлгээг хийхдээ олон улсын болон дотоодын арга зүйн баримт бичгийг ашигласан. Тухайлбал, эрсдэл болон бэлэн байдлын үнэлгээний чиглэлээр боловсруулсан ABS Consulting компанийн загвар, мөн Р. Оюун, Ш. Болдбаатар нарын боловсруулсан “Аж ахуйн нэгж, байгууллагын гамшгийн менежментийн чадавхыг үнэлэх арга зүйн заавар”-ыг судалгаанд ашигласан болно. (ОБЕГ даргын А/82 дугаар тушаал, 2022)

Бэлэн байдлыг үнэлэхдээ аврах бүлгийн үйл ажиллагааг олон талаас нь авч үзсэн. Үүнд бие бүрэлдэхүүний ур чадвар, сургалт, манлайлал, зохион байгуулалтын үр ашиг, хэрэгцээт багаж хэрэгслийн нөөц, мөн аврах ажиллагааны журам, зааврыг хэрхэн мөрддөг зэргийг багтааж үнэлэлт хийдэг. Үнэлгээнд Гал түймэр унтраах аврах 66 дугаар ангийн бие бүрэлдэхүүнийг хамруулав. Тус анги нь Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 183 дугаар тогтоолоор Ханбогд суманд 4 дүгээр зэрэглэлийн анги байгуулагдсан. Ханбонд сум нь Монгол улсын Өмнөговь аймгийн зүүн урд зүгт байрлах сум. Сумын төвөөс баруун тийш 40км зайд, Гавилууд багийн нутаг дэвсгэрт Оюутолгойн зэсийн орд байдаг. Улаанбаатар хотоос 650 км, Өмнөговь аймгийн төвөөс 250 км зайтай. Ханбогд сум нь Гавилууд, Хайрхан, Жавхлант, Баян, Номгон гэсэн засаг захиргааны нэгж бүхий 5 багтай, 15151 км 2 газар нутагтай, 10000 гаруй хүн амтай сум юм. Гал түймэр унтраах, аврах 66 дугаар анги нь ангийн захирагч, гал түймрийн улсын хяналтын байцаагч, салааны захирагч, механик жолооч, нярав

амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин, шуурхай удирдлагын оператор, гал түймэр автомашины жолооч, аврагч гал сөнөөгч нар жижүүрлэн Ханбогд сумын иргэдийг гал түймэр, гамшиг, ослын аюулаас авран хамгаалах үүрэг гүйцэтгэж байна. 2018 оноос 2025 оны байдлаар хүртэл гал түймэр унтраах, аврах 66 дугаар ангид нийт 136 удаагийн гамшиг осол, аюулт үзэгдлийн дуудлага бүртгэгдсэн байна. Нийт 9.867.313.700 төгрөгний хохирол учирч, 13.423.210.100 төгрөгний эд хөрөнгө аварна хамгаалж, 66 иргэнийг аврах ажиллагаагаар аварна ажилласан байна. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр арга хэмжээг сар бүр зохион байгуулж ажиллаж байна. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын чиглэлээр алба хаагчид сумын хэмжээнд давтагдсан тоогоор 5059 айл өрхүүдээр явж галын аюулгүй байдал, стандарт норм дүрмүүдийг хангасан эсэхийг шалгаж хойшлуулушгүй 4529 зөрчлийг газар дээр нь арилгуулж 530 зөрчлийг хугацаатай үүрэг өгч тэмдэглэл хөтлөдөг (Балжинням, 2025 он).

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 он А/82 дугаар тушаалаар батлагдсан “Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар”-ыг алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх болон гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнг тооцох зорилгоор мөрдөж ажиллаж байна. Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажлыг ангийн болон салааны захирагч нар дүгнэдэг байна.

Үнэлгээнд 1. томилгоот ээлжинд үүрэг гүйцэтгэсэн онооны дундаж, 2. тухайн сард төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, шинээр санаачлан хийсэн





ᠬᠤᠮᠤᠰᠢᠭᠢᠨᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

бүтээлч ажил, 3. холбогдох дүрмүүдээр (ГТУД, ХАБЭАД, АБДТАҮДМД, Замын хөдөлгөөний) өгсөн шүүлгийн үнэлгээ, 4. гал түймэр унтраах, дасгал сургуулалтын норматив, бие бялдарын бэлтгэлжилтийн норматив өгсөн шүүлгийн үнэлгээ, 5. гал түймэр унтраах автомашины тусгай тоноглол, тоног төхөөрмж, багаж хэрэгслийг туршин шалгаж, техникийн үйлчилгээ, засвар хийсэн байдал, 5. нэгдсэн удирдамжит арга хэмжээ, дадлага, сургуулалт, олон нийтийг хамарсан

арга хэмжээнд оролцсон байдал, 6. үйлчлэх хүрээний зам гарц, усан хангамж, объект (онц чухал, галын аюултай гэх мэт)-ын судалгаа, тодотгол, 7. сургалт бэлтгэлийн хөтөлбөр, цаг сэдвийн төлөвлөгөөний дагуу сургалтад хамрагдсан байдал, 8. захирагч даргын үүрэг даалгаврын хэрэгжилт, 9. жагсаалын үзлэгт хамрагдсан байдал (хувцас, аяны үүргэвчийн үзлэг, цэргийн дүрмийн мэдлэг) зэрэг 9 шалгуур үзүүлэлтийг ашигласан байна.

№	Ажлын гүйцэтгэл	Өгөх оноо		
		5	10	15
Авбал зохих оноо		5	10	15
1	Алба хаагч тухайн ажлыг бүрэн гүйцэтгэж, үр дүнтэй зохион байгуулсан	4-5	7-10	11-15
2	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг бүрэн гүйцэтгэсэн боловч, үр дүн хангалттай түвшинд хүрээгүй	2-3	4-6	6-10
3	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг дутуу гүйцэтгэсэн боловч, тодорхой хэмжээний үр дүн гарсан	1	1-3	1-5
4	Алба хаагч тухайн гүйцэтгэх ажлыг гүйцэтгээгүй, эсвэл тодорхой үр дүн гараагүй	0	0	0

#### Хүснэгт №1. Гал түймэр унтраах, аврах ангийн ажлын гүйцэтгэлийг үнэлгээ

Мэргэжлийн онолын сургалт бүрийн дараа тухайн сэдвийн хүрээнд 10-аас доошгүй асуулттай мэдлэг бататгах шалгалт авч, уг шалгалтын дүнгээр онолын сургалтын үнэлгээг тооцдог байна. Түүнчлэн мэргэжлийн дадлага сургалтын оноог цагийн хуваарийн дагуу өдөр тутмын дадлага сургалтад оролцож авсан үнэлгээгээр тооцдог байна.

Алба хаагчийн сарын ажлын гүйцэтгэлийг дараах байдлаар дүгнэдэг байна. Үүнд:

90-100 оноо - “А” буюу “Маш сайн”

80-89 оноо - “В” буюу “Сайн”

70-79 оноо - “С” буюу “Хангалттай”

0.59 оноо - “0” буюу “Дутагдалтай”

0-59 оноо - “Е” буюу “Хангалтгүй”

Ажлын гүйцэтгэл, үр дүнгээрээ хамт олноо тэргүүлэн, “Маш сайн” дүгнүүлсэн нь алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу сайшаал хүртээх, шагнах үндэслэл

болно, “Хангалтгүй” дүгнүүлсэн нь алба хаагчид холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ноогдуулах үндэслэл болно гэжээ. Энэхүү албан хаагчдын ажил дүгнэх заавар нь манлайлал, идэвх санаачлага, шагнал шийтгэлд суурилсан үнэлгээ бөгөөд гал түймэр ангийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд шууд нөлөө, үр дүн багатай байна гэсэн дүгнэлт хийх үндэслэлтэй байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Говийн бүсийн төв-Өмнөговь аймгийн онцгой байдлын газрын Ханбогд сум дахь гал түймэр унтраах 66 дугаар ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварын шинжилгээг хийхдээ АНУ-ын ABS зөвлөх компанийн боловсруулсан “Эрсдэл болон бэлэн байдлын үнэлгээний загвар”-ыг болон Р.Оюун, Ш.Болдбаатар нарын боловсруулсан “Аж ахуйн нэгж байгууллагын гамшигын

менежментийн чадавхыг үнэлэх арга зүйн заавар”-ыг ашиглав. Үнэлгээнд Бие бүрэлдэхүүн гэсэн хэсэгт А.1 Бие бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх ур чадвар, А.2 Сургалт, А.3 Манлайлал, А.4 Зохион байгуулалт; Багаж хэрэгслийн нөөц гэсэн хэсэг В -д В.1 Гал түймэр аврах ажиллагааны нөөц боломж; Гал түймэр ажиллагаа гэсэн хэсэг С – д С.1 Дүрэм журмын хэрэгжилт гэсэн шалгуурыг сонгосон болно.

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын үнэлгээг салбарын

захирагч, удирдах албан тушаалтнуудтай харилцан ярилцах аргаар гүйцэтгэсэн. Үнэлгээ хийхдээ судалгаанд ашигласан хүснэгтэд тусгагдсан асуултуудын дагуу тухайн үзүүлэлт бүрийг 1–5 хүртэлх онооны шатлалаар үнэлсэн. Үүнд 5 оноо нь тухайн үзүүлэлт бүрэн хангагдсан буюу дүүрэн түвшнийг, 4 оноо нь хангалттай түвшнийг, 3 оноо нь дунд зэргийн хангалтыг, 2 оноо нь хангалтгүй байдлыг, харин 1 оноо нь тухайн чиглэлд чадамж маш сул буюу бараг байхгүйг илэрхийлнэ.

1	2	3	4	5
А.2.3. Багаж хэрэгсэл (хийн хамгаалалт)	А.2.2. Холбоо харилцаа	А.1.3. Бие бялдрын чадамж	А.1.1 Аврах, гал түймэр унтраах ангийн бие бүрэлдэхүүний чадамж	А.1.13. Бүтээгдэхүүний технологи (үйлчилгээний мэдлэг)
	А.2.9. Амьд гарах арга ухааны сургалт	А.1.6. Бие бүрэлдэхүүний тэнцвэртэй байдал (мэргэшсэн байдал)	А.1.2. Гамшгийн онцгой байдлын үеийн туршлага	А.4.1. Гамшгийн хариу арга хэмжээ
	А.2.10. Хөрвөх буюу орлон гүйцэтгэх чадварын сургалт	А.1.7. Удирдах чадвар	А.1.4. Стресстэй нөхцөл байдалд тайван байх чадвар	
	А.4.3. Хангалт ба багаж хэрэгсэл	А.1.9. Тоног төхөөрөмжид итгэх итгэл	А.1.5. Багаар хамтран ажиллах чадвар	
	С.1.5. Гамшгийн газрын зурагтай танилцах	А.1.12. Аврах, гал түймэр унтраах бүлгийн ур чадварын дадлага	А.1.8. Оюуны чадамж, эр зориг, dojty эрх бүхий аврах, гал түймэр бүлгийн ахлагч	
	С.1.7. Багаж хэрэгслийн үзлэг	А.2.4. Хийн төрөл ба тэдгээрийн хязгаарлалт	А.1.10 Аврах, гал түймэр унтраах ангийн бие бүрэлдэхүүндээ итгэх итгэл	
		А.2.5. Гал түймэр унтраах ажиллагаа- хөөс, ус, гал сөнөөгч, галын тархалт	А.1.11. Олон талт чиг үүрэг	
		А.2.6. Утаанд ажиллах	А.2.1. Төхөөрөмж	
		А.2.7. Анхны тусламж	А.4.2. Хэн юу хариуцах вэ	





ᠮᠤᠩᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

		А.2.8 Байр зүйн газрын зураг унших	В.1.2. Тоног төхөөрөмжийн хүртээмж	
		А.3.1 Зохион байгуулалт	В.1.5. Гамшигийн үеийн тээвэрлэлт	
		А.3.2. Бие бүрэлдэхүүн хоорондын харилцаа	В.1.8. Туршигдсан багаж хэрэгсэл	
		А.3.3. Дайчилгаа	С.1.1. Аврах, гал түймэр ажиллагаа	
		В.1.1. Радио холбоо	С.1.2. Аврах, гал түймэр ажиллагаа явуулахаас өмнө мэдээлэл солилцох	
		В.1.3. Тоног төхөөрөмжийн бат бөх, найдвартай байдал	С.1.3. Дуудлага хийх журам/мэдэгдлийн журам	
		В.1.4. Анхны тусламжийн хэрэгсэл		
		В.1.6. Логистикийн үйлчилгээ ба дэмжлэгийн тогтолцоо		
		В.1.7. Аврах ажиллагааны олс, шугам болон торон систем		
		С.1.4. Үйл ажиллагааны төлөвлөгөөний талаархи ойлголт		
		С.1.6. Томилгоот ээлжийн хуваарь		
1 буюу 2.2	6 буюу 13.6	20 буюу 45.5	15 буюу 34.0	2 буюу 4.5

**Хүснэгт №2. Гал түймэр унтраах аврах ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварын үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд**

Гал түймэр унтраах, аврах 66 дугаар ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварыг нийт 44 үзүүлэлтээр үнэлж үзэхэд маш хангалтгүй -1 үзүүлэлт буюу 2.2 хувь нь, хангалтгүй үзүүлэлт -6 буюу 13.6 хувь нь, дунд зэрэг үзүүлэлт - 20 буюу 45.5 хувь нь, хангалттай үзүүлэлт – 15 буюу 34.0 хувь нь, дүүрэн хангалттай үзүүлэлт 2 буюу 4.5 хувьтэй байна. Үнэлгээний үзүүлэлтүүдийн 100 гэж

үзэхэд дунд буюу дундаас доош үзүүлэлтүүд нь 61.3 хувийг эзэлж байна.

Үнэлгээний үр дүнд тус гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдал, гал сөнөөгч нарын ур чадвар **3.2** гэсэн үнэлгээтэй байсан бөгөөд энэ нь **“Гал түймэр унтраах, аврах ангийн бие бүрэлдэхүүн томоохон гал түймэр, ослын үеийн хариу арга хэмжээнд бэлэн байх магадлал бага”** түвшинд байна. Гал түймэр унтраах, аврах анги бие бүрэлдэхүүний хувьд нийт 12 гал

сөнөөгч нараас гал сөнөөгч мэргэжилтэй 1 хүн, 10 дээш жилийн ажлын туршлагатай 2 хүн, 10 хүртэлх жилийн ажлын туршлагатай 10 хүн бөгөөд 100 дээш гал түймэр унтраах ажиллагаанд оролцсон 2 хүн, 20-40 удаагийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцсон 7 хүн, 10 доош гал түймэр унтраах ажиллагаанд

оролцсон 3 хүн байгаа нь мэргэжлийн гал сөнөөгч цөөхөн, Судалгааны явцад гал сөнөөгчдийн ихэнх нь гал түймэр унтраах болон аврах ажиллагаанд оролцсон практик туршлага хязгаарлагдмал байгааг тогтоосон бөгөөд энэ нь судалгааны үр дүнд нөлөөлөх боломжтой хүчин зүйлсийн нэг гэж үзэж байна.



Дэвсгэж буй Урьдчилсан Судалгаа

Гал түймэр унтраах аврах ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн үр чадварын үнэлгээний үр дүн	
5	Үнэлгээний үр дүнгээс харахад гал түймэр унтраах, аврах анги, салбарууд нь томоохон хэмжээний гамшиг, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломж маш өндөр түвшинд байна.
4	Үнэлгээний үр дүнгээс харахад гал түймэр унтраах, аврах анги, салбарууд нь томоохон хэмжээний гамшиг, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломж өндөр түвшинд байна.
3	Үнэлгээний үр дүнгээс харахад гал түймэр унтраах, аврах анги, салбарууд нь томоохон хэмжээний гамшиг, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломж дунд түвшинд байна.
2	Үнэлгээний үр дүнгээс харахад гал түймэр унтраах, аврах анги, салбарууд нь томоохон хэмжээний гамшиг, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломж бага түвшинд байна.
1	Үнэлгээний үр дүнгээс харахад гал түймэр унтраах, аврах анги, салбарууд нь томоохон хэмжээний гамшиг, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломжгүй түвшинд байна.
Үнэлгээний огноо :	
2025. 10.13	
Хэсэг А - Бие бүрэлдэхүүн	
	3,3
A.1 Ур чадвар	3,7
A.2 Сургалт	2,4
A.3 Манлайлал	3
A.4 Зохион байгуулалт	4
Хэсэг В - Багаж зэвсэглэмжийн нөөц	
3,4	
В.1 Гал түймэр аврах ажиллагааны нөөц боломж	
3,4	
Хэсэг С - Гал түймэр ажиллагаа	
3	
C.1 Журам дүрэм	3
<b>Нийт оноо</b>	
3,2	
Энэхүү аргачлал нь бүх тохиолдлыг бүрэн тооцох зорилготой биш бөгөөд хэрэглэгч, салаа, тасаг, эсвэл гал түймэр унтраах, аврах ангийн бие бүрэлдэхүүн нь бүх нөхцөл, эсвэл тодорхой осол, хэрэг явдалд бэлэн байхыг баталгаажуулахгүй. Тодорхой бус байдал нь зөвхөн тооцоолох боломжтой шинжилгээний үндсэн параметруудад хязгаарлагддаг. Шинжилгээ нь хэрэглэгчийн өгсөн оролтын өгөгдлийн чанараас хамааран нэмэлт хязгаарлалттай байдаг. Хэрэв оролтын өгөгдөл үнэн зөв бус эсвэл бүрэн бус байвал энэ нь хэрэглэгчийн заасан сайжруулах үйл ажиллагааны үр ашиг болон/эсвэл үнэн зөв байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.	

**Хүснэгт №3. Гал түймэр унтраах аврах 66 дугаар ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн үр чадварын үнэлгээний үр дүн**



## Санал

Судалгааны ажлын үр дүнд үндэслэн доорх санал зөвлөмжийг боловсруулав.

1. Үнэлгээний үр дүнд тус гал түймэр, аврах ангийн бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадвар нь 3.2 гэсэн үнэлгээтэй байсан бөгөөд энэ нь “ Гал түймэр, аврах ангийн бие бүрэлдэхүүн томоохон гал түймэр, ослын үед шаардлагатай хариу арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл, бэлэн байдлын боломж бага ” үнэлэгдсэн тул тус ангийн бэлэн байдал, ур чадварыг дээшлүүлэх талаар үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах.

2. Үнэлгээний үзүүлэлтүүдийн 100 гэж үзэхэд дунд буюу дундаас доош үзүүлэлтүүд нь 61.3 хувийг эзэлж байгааг анхаарч “дундаас доош” үзүүлэлт болох гал сөнөөгч, аврагч нарын хортой хий илрүүлэх багаж хэрэгсэл (хийн хамгаалалт)ашиглах чадварыг дээшлүүлэх, холбоо харилцаа тогтоох, амьд гарах арга ухааны сургалт, бие бүрэлдэхүүний бие биенээ орлох ажил үүрэг гүйцэтгэх чадвар, багаж хэрэгслийн хангалт ба багаж хэрэгслийн талаар мэдлэгийг сайжруулах, байр зүйн газрын зураг унших чадварыг дээшлүүлэх, багаж хэрэгслийн үзлэгийг тогтмолжуулах.

3. “Дунд” гэсэн 20 үзүүлэлтүүдийг өдөр тутмын үйл ажиллагааны явцад болон тухайн жилийн сургалт, дадлагын үед болон бодит ажиллагааны дараа үед сургамж дүгнэлт хийж дээшлүүлэх арга хэмжээ авах.

4. “Хангалттай” болон “дүүрэн хангалттай” гэсэн үзүүлэлтүүдийг ангийн өдөр тутмын үйл ажиллагааны үед болон гал түймэр ажиллагааны сургамжид тулгуурлан бататган сайжруулах.

## Дүгнэлт

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 он А/82 дугаар тушаалаар батлагдсан “Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар”-ыг алба хаагчдын бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх болон гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааны гүйцэтгэлийг дүгнэж, үр дүнг тооцох зорилгоор мөрдөж ажиллаж байна. Энэхүү албан хаагчдын ажил дүгнэх заавар нь манлайлал, сахилга хариуцлага, идэвх санаачлага, шагнал шийтгэлд суурилсан үнэлгээ бөгөөд гал түймэр ангийн бэлэн байдлыг дээшлүүлэхэд шууд нөлөө, үр дүн багатай байна гэсэн дүгнэлт хийх үндэслэлтэй байна.

Иймд гал түймэр, аврах ангийн бэлэн байдлын үнэлгээг ажил мэргэжлийн ур чадвар, багаж хэрэгслийн нөөц боломж, гал түймэр унтраах ажиллагааны дүрэм журмын хэрэгжилт гэсэн илүү нарийн шалгуур үзүүлэлтүүдээр хийх нь бэлэн байдал, гал сөнөөгчдийн ур чадварыг дээшлүүлэхэд илүү үр дүнтэй хэмээн дүгнэж байна.

## Ашигласан материал

1. IG), M. -M.-M. (america). *MSHA - Mine Rescue Instruction Guide (IG) Series - MSHA 3027 (Formerly IG)*. 2008.
2. Preece, G., & Ellis, P. (1981). *Coalmining, a handbook to the History of Coalmining Gallery, Salford Museum of Mining, City of Salford Cultural Services*.
3. Б.Алтангэрэл. (2025). *Уул уурхайн аврагчдын үүрэг гүйцэтгэх чадварыг үнэлэх арга зүй*. улаанбаатар хот.
4. Б.Баттогтох. (2024). *Уурхайчин аврагчийн дурсамж, тэмдэглэл*. Улаанбаатар.

5. Баттогтох, Б. (2024). *Уурхайчин аврагчийн дурсамж, тэмдэглэл.*

6. *гамшигаас хамгаалах тухай хууль.* (20017). улаанбаатар.

7. *гамшигаас хамгаалах тухай хууль.* (2017). улаанбаатар хот.

8. гамшиг судлалын үндэсний хүрээлэн. (2024). *гамшигаас хамгаалах цагаан ном.* улаанбаатар хот: 109.

9. гамшиг судлалын хүрээлэн. (2012). *гамшигийн нэр томъёоны тайлбар толь.* улаанбаатар хот.

10. Д.Баяржаргал. (2022). Далд уурхайн аврах ажиллагааны онцлог, түүнд хийсэн шинжилгээ.

11. З.Билгүүн. (2016). *гал түймэр унтраах, аврах аврах ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам.* улаанбаатар хот.

12. Монгол улсын шадар сайдын тушаал 24 дүгээр тушаалын хавсралт. (2024). *гал түймэр унтраах дүрэм.* улаанбаатар хот.

13. Н.Отгонбаатар. (2023). гал түймэр унтраах үйл ажиллагааны шуурхай зохион байгуулалт, туршлага, сургамж, судалгааны эмхэтгэл. *гамшиг судлалын хүрээлэн.*

14. ном, Г. х. (2024). *гамшигаас хамгаалх цагаан ном.* улаанбаатар хот : 109.

15. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), О. б. (2008). Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага.

16. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Онцгой байдлын ерөнхий газар. (2008). “Монгол улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага”,.

17. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Онцгой байдлын ерөнхий газар. (2008). “Монгол улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн

тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага”, УБ хот, 2008 он.

18. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (UNDP), Онцгой байдлын ерөнхий газар. (2008). “Монгол улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага”, УБ хот, 2008 он. “Монгол улсад гамшигийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх гарын авлага”, УБ хот, 2008 он.

19. О.Оюунбилэг ь, 2. о. (2018). аврагч-гал сөнөөгчийн сэтгэл зүй, сэргээн заслын тусламж үйлчилгээг сайжруулах нь.

20. ОБЕГ даргын 2022 он А/82 дугаар тушаал . (2022). *гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын ажил дүгнэх заавар.* улаанбаатар хот.

21. ОБЕГ даргын А/82 дугаар тушаал. (2022). *Аж ахуй нэгж байгууллагын гамшигийн менежментийн чадавхыг үнэлэх арга зүйн.* улаанбаатар.

22. онцгой байдлын ерөнхий газар. (2015). *галын аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга.* улаанбаатар хот.

23. онцгой байдлын ерөнхий газар. (2015). *гамшигаас хамгаалах тухай хууль.* улаанбаатар хот.

24. Ш.Бодбаатар. (2005). *Гамшигийн менежмент гарын авлага.* Улаанбаатар хот: 213.

25. Ш.Бодлбаатар. (2005). *Гамшигийн менежмент гарын авлага.* улаанбаатар.

26. Ш.Бодлбаатар, Р. (2018). *аж ахуй нэгж байгууллагын гамшигийн*





*менежментийн чадавхыг үнэлэх арга зүйн заавар. Улаанбаатар хот.*

27. Ш.Паламдорж. (2014). *цэргийн нэр томъёоны тайлбар толь.* улаанбаатар хот: 102 дахь тал.

28. Ш.Паламдорж. (2014). *Цэргийн нэр томъёоны тайлбар толь.* улаанбаатар хот: 68 лах.

Э.Энхбат. (2017 он). Аврагч-гал сөнөөгчийн ур чадвар дээр суурилсан сургалтыг сайжруулах нь.

## ШИНГЭРҮҮЛСЭН ХИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### ANALYSIS OF LIQUEFIED GAS FIRE SAFETY AMONG EMERGENCY SERVICE PERSONNEL

#### Б.Баасанхүү

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн Гамшиг судлалын магистрант, ахмад

#### В. Baasankhuu

Graduate student of Disaster Studies course No. 7062 of the University of Internal Affairs, Captain

\*хариуцлагатай зохиогч: bbaasankhuu8@gmail.com

**Хураангуй:** Шингэрүүлсэн хийн галын аюулгүй байдалд хийсэн асуулгын шинжилгээг Онцгой байдлын байгууллагын гал түймэртэй тэмцэх чиглэлийн Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн зохицуулагч, гал түймэр унтраах, аврах ангийн захирагч, салааны захирагч зэрэг нийт 160 гаруй алба хаагчийг хамруулсан. Энэхүү судалгаагаар шингэрүүлсэн шатдаг хийн болзошгүй гал түймрийн үед ажиллах алба хаагчдын мэдлэг, ур чадвар, мөн гал түймэр унтраах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтад нөлөөлөх хүчин зүйлсийг Smart PLS 4.0 программаар тодорхойлсон.

Судалгааны үр дүнгээс харахад алба хаагчдын мэдлэг, ур чадвар нь гал түймэр унтраах ажиллагааны үр дүнтэй шууд хамааралтай болох нь тогтоогдсон. Түүнчлэн гал түймэр унтраах, аврах ангийн удирдах бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадварын нөлөөллийн хамаарал 0.490 буюу сул түвшинд илэрсэн ба алба хаагчдын шингэрүүлсэн хийн мэдлэгийн хүчин зүйлсийн хамаарал нь 0.322 буюу сул хамаарлыг тус тус үзүүлсэн байгаа нь энэ чиглэлд алба хаагчдыг яаралтай бэлтгэх шаардлагатай харуулж байна.

Судалгааны загварын тайлбарлах чадвар  $R^2 = 0.550$  гарсан нь гал түймэр унтраах ажиллагааны зохион байгуулалт нь гал унтраах үйл ажиллагааны үр дүнтэй дунд түвшний хамааралтай байгааг илтгэж байна. Иймд гал түймэр унтраах, үр нөлөөг нэмэгдүүлэхийн тулд алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах, ялангуяа шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн онцлогийн мэдлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

**Abstract:** The survey on liquefied gas fire safety included more than 160 officers from the Emergency Management Agency, including firefighting officers, dispatch center coordinators, firefighting and rescue unit commanders, and branch commanders. This study identified the knowledge and skills of officers working in the event of a liquefied gas fire, as well as factors affecting the management and organization of firefighting operations using the Smart PLS 4.0 program.

The results of the study showed that the knowledge and skills of officers are directly related to the effectiveness of firefighting operations. In addition, the correlation between the professional skills of the firefighting and rescue team management team was found to be 0.490, or weak, and the correlation between the factors of officers' knowledge of liquefied gas was 0.322, or weak, indicating the urgent need to train officers in this area.





The explanatory power of the research model was  $R^2 = 0.550$ , indicating that the organization of firefighting operations has a medium-level correlation with the effectiveness of firefighting operations. Therefore, in order to increase the effectiveness of firefighting, it is necessary to improve the professional knowledge and skills of officers, especially the knowledge of the characteristics of liquefied flammable gas fires.

**Түлхүүр үг:** Шингэрүүлсэн шатдаг хий, гал түймэр, шинжилгээ, ур чадвар, SmartPLS

**Key words:** Liquefied flammable gases, fire, analysis, skills, SmartPLS

### Удиртгал

Шингэрүүлсэн шатдаг хийтэй холбоотой гал түймэр нь энгийн шаталтын процессоос ялгаатай, өндөр эрсдэлтэй онцлогтой байдаг. Ялангуяа хий алдагдах, савны дотоод даралт нэмэгдэх, гаднын дулааны нөлөөлөлд өртөх зэрэг нөхцөлд сав, баллон хэт халж, улмаар дэлбэрэх аюул үүсдэг. Энэ төрлийн осол нь богино хугацаанд асар их, дулаан ялгарах, галын тархалт өндөртөй, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учруулах зэрэг аюултай үр дагаварт хүргэдэг.

Сүүлийн жилүүдэд ахуйн хэрэглээ, аж ахуйн нэгж, үйлдвэрлэлийн байгууллагуудад шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ нэмэгдэж байгаа нь энэ төрлийн гал түймрийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Ийм нөхцөлд гал түймэр унтраах, аврах ажиллагаанд оролцож буй алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, тактикийн бэлтгэл, удирдлага зохион байгуулалтын түвшин нь гал түймрийн хор уршгийг бууруулахад чухал нөлөөтэй хүчин зүйл болдог.

Гал түймэр унтраах ажиллагааны үр дүн нь зөвхөн техник, тоног төхөөрөмжөөс хамаарахгүй бөгөөд алба хаагчдын мэргэжлийн бэлтгэл, туршлага, ур чадвар, мөн гал түймрийн үед удирдлага зохион байгуулалтыг хэрхэн оновчтой хэрэгжүүлж байгаагаас ихээхэн шалтгаалдаг. Ялангуяа шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн голомтод ажиллах үед

аюулын бүсийг зөв тодорхойлох, галын тархалтыг хязгаарлах, сав баллоныг хөргөх, дэлбэрэлтийн эрсдэлийг бууруулах зэрэг тактикийн арга хэмжээг шуурхай, зөв хэрэгжүүлэх шаардлага тулгардаг.

Иймд шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлсийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлах, алба хаагчдын мэдлэг, ур чадвар болон гал түймэр унтраах ажиллагааны удирдлага зохион байгуулалтын хоорондын хамаарлыг тодорхойлох нь практик ач холбогдолтой асуудал юм.

Энэхүү судалгааны зорилго нь шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаанд гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын мэдлэг, ур чадвар хэрхэн нөлөөлж байгааг судалж, унтраах ажиллагааны удирдлага зохион байгуулалттай харьцуулах замаар тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхойлоход оршино.

### Үндсэн хэсэг

Судалгаанд Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах, аврах ангийн нийт 160 алба хаагч оролцсон бөгөөд үүнд шуурхай удирдлагын зохицуулагч, ангийн захирагч, салааны захирагч зэрэг албан тушаалтай алба хаагчид багтсан. Оролцогчдын ажлын туршлагын хувьд 1–3 жил ажилласан алба хаагчид 52.4%,

3–5 жил 23.8%, 5–10 жил 9.5%, 10–15 жил 14.3% хувийг эзэлж байна.

Судалгаанд оролцогчдын мэдлэг, ур чадвар нь шингэрүүлсэн шатдаг хийн галын онцлог, тархалт, дэлбэрэлтийн эрсдэл, тээвэрлэлтийн үед гал түймэр унтраах ажиллагааны зохион байгуулалттай шууд холбоотой бөгөөд ихэнх алба хаагчдын мэдлэгийг дунд түвшинд эзэмшсэн байгааг харуулж байна. Иймээс гал түймэр унтраах, ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг системтэйгээр нэмэгдүүлэх, сургалт, дадлагаар шингэрүүлсэн шатдаг хийн галын аюулгүй байдал, онцлог, эрсдэлийг үнэлэх чадварыг дээшлүүлэх шаардлагатай байгаа тул асуулгын судалгааг нарийвчилан авч үзнэ.

#### **Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл**

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдын боловсролын хувьд Магистр 10.2%, Бакалавр 87.3%, Дипломын дээд 2,5%-тай судалгаанд хамрагдсан алба хаагчдын боловсролын түвшин өндөр байна.

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдын төгссөн сургуулийн хувьд Дотоод хэргийн их сургууль 84.1%, Цагдаагийн академи 3.8%, ОХУ гал эсэргүүцэх, иргэний хамгаалалтын академи 3,8%, Улсын их дээд сургууль 3.8%, Хувийн их дээд сургууль 3.2%, Бусад сургууль 1,3%-тай судалгаанд

хамрагдсан. Нийт оролцогчдын 8.3% нь мэргэжлийн бус хүмүүс байна. Өөрөөр хэлбэл энэ чиглэл нь дэлхийн хамгийн өндөр эрсдэлтэй мэргэжлийн 3-т нь ордог. ОХУ буюу Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийг төгссөн тусгай мэдлэг эзэмшсэн байх ёстой. Иймд мэргэжлийн алдаа дутагдал гаргах магадлалыг нэмэгдүүлнэ.


Судалгаанд оролцож байгаа алба хаагчдын эзэмшсэн мэргэжлийн хувьд Онцгой байдал-Гамшгаас хамгаалах алба 68.2%, Онцгой байдал-Гамшиг судлал 7.6%, Галын техникч 0,6%, Гал түймэртэй тэмцэх байгууллагын ажил мэргэжил 1.3%, Онцгой байдлын ажил эрх зүй 8.9%, Галын аюулгүй байдлын мэргэжилтэн инженер 1,9%, Бусад гадаадын их сургуульд онцгой байдлын чиглэлээр төгссөн 1,3%-тай судалгаанд хамрагдсан. Бусад дээд сургууль төгссөн алба хаагчдыг анхаарах хэрэгтэй байна.

Шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн унтраах ажиллагаанд оролцсон эсэхийг үнэлж үзэхэд 1-5 нь 42,6%, 6-10 нь 2,6%, 10-15 нь 0.6%, 15-аас дээш нь 1.9%, харин нийт оролцогчдын 52.3% огт оролцож байгаагүй хэмээн дүгнэгдсэн. Иймд цаашид Бүсийн төвүүдэд олон улсын сургалтын түвшинд нийцсэн сургалтын баазтай болгох нь цаашид сургалтын үйл ажиллагаанд онол, практик сургалтыг нэвтрүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Зураг 1-т үзүүлэв.





ᠮᠤᠩᠭᠡᠷᠦᠭᠦᠯᠦᠰᠦᠨ ᠰᠢᠲᠳᠠᠭ ᠬᠢᠶᠢᠨ ᠭᠠᠯ ᠲᠦᠶᠢᠮᠦᠷᠢᠨ



Зураг 1. Шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн унтраах ажиллагаанд хэдэн удаа оролцож байсанг дүгнэсэн байдал


Шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн чиглэлээр тусгайлсан сургалтанд хамрагдсан эсэхийг үнэлж үзэхэд 3.9% маш сайн, 18.7% сайн, 53.5% дунд, 19.4% муу, 4.5% маш муу гэж дүгнэсэн байгаа нь цаашид алба хаагчдын ангилалын сургалтын үйл ажиллагаанд шингэрүүлсэн шатдаг хийн чиглэлээр онол, практикийн сургалтыг илүү нэвтрүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Зураг 9-т үзүүлэв.

**Шингэрүүлсэн шатдаг хийн суурь мэдлэг**

Судалгаанд оролцогчдын тэсрэлтийн үед үүсэх шатамхай хийн дээд болон доод тэсрэх хязгаарын талаарх мэдлэгийн түвшинг үнэлж үзэхэд 0.6 хувь нь маш сайн, 22.6 хувь нь сайн, 63.5 хувь нь дунд, 12.6 хувь нь

муу, 0.6 хувь нь маш муу түвшинд үнэлэгдсэн байна. Эдгээр үзүүлэлтээс харахад судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 63.5 хувь нь тухайн ойлголтын талаар дунд түвшний мэдлэгтэй байгаа нь ажиглагдаж байна.

Тэсрэлтийн дээд болон доод хязгаарын талаарх ойлголт нь шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр, ослын үед эрсдэлийг зөв үнэлэх, гал түймэр унтраах тактикийн шийдвэрийг оновчтой гаргахад чухал ач холбогдолтой байдаг. Иймд судалгааны үр дүнгээс харахад алба хаагчдын энэ чиглэлийн онолын мэдлэгийг нэмэгдүүлэх, шингэрүүлсэн шатдаг хийн галын аюулгүй байдалтай холбоотой сургалт, дадлагын хөтөлбөрийг цаашид системтэйгээр зохион байгуулах шаардлагатай гэж дүгнэж байна. Зураг 2-т үзүүлэв.




Зураг 2. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын тэсрэлтийн үед үүсэх дээд болон доод хязгаарын талаарх мэдлэгтэй эсэхийг дүгнэсэн байдал

Судалгаанд оролцогчдоос түймрийн тархалт болон дэлбэрэлтийн шингэрүүлсэн шатдаг хийн гал аюулын онцлогийн талаарх мэдлэгийн

түвшинг үнэлэхэд 0.6 хувь нь маш сайн, 34.2 хувь нь сайн, 51.9 хувь нь дунд, 11.4 хувь нь муу, 1.9 хувь нь маш муу гэж тус тус үнэлэгдсэн байна. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 51.9 хувь нь тухайн чиглэлийн мэдлэгийг дунд түвшинд эзэмшсэн байгаа нь ажиглагдаж байна.

Шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн тархалт болон дэлбэрэлтийн аюулын онцлогийг зөв ойлгох нь гал түймэр унтраах, ажиллагааны үед

эрсдэлийг зөв үнэлэх, тактикийн шийдвэрийг оновчтой гаргах, алба хаагчдын аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Иймд судалгааны үр дүнгээс үзэхэд алба хаагчдын мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн тархалт, дэлбэрэлтийн аюулын онцлогийн талаарх сургалт, дадлагын үйл ажиллагааг цаашид илүү системтэйгээр зохион байгуулах шаардлагатай байна. Зураг 3-т үзүүлэв.



Зураг 3. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын та шингэрүүлсэн шатах хийн гал түймрийн тархалт, дэлбэрэлтийн аюулын онцлогийг хир зэрэг мэдлэгтэй эсэхийг дүгнэсэн байдал

Судалгаанд оролцогчдын нефть болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын үеийн аюулгүй байдлын шаардлагын талаарх мэдлэгийн түвшинг үнэлж үзэхэд 1.9 хувь нь маш сайн, 41.1 хувь нь сайн, 51.9 хувь нь дунд, 5.1 хувь нь муу гэж тус тус үнэлэгдсэн байна. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 51.9 хувь нь тухайн чиглэлийн мэдлэгийг дунд түвшинд эзэмшсэн байгаа нь ажиглагдаж байна.


Нефть болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт,

ашиглалтын үеийн аюулгүй байдлын шаардлагыг мэдэх нь гал түймэр, ослын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зөв хэрэгжүүлэх, мөн гал түймэр унтраах, аврах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад чухал ач холбогдолтой юм. Иймээс судалгааны үр дүнгээс үзэхэд алба хаагчдын энэхүү чиглэлийн мэдлэгийг илүү сайжруулах, холбогдох стандарт, аюулгүй ажиллагааны шаардлагын талаарх сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна. Зураг 4-т үзүүлэв.






ᠬᠤᠠᠭᠠᠳᠤᠰᠤ ᠠᠯᠢᠪᠠ ᠬᠠᠭᠠᠳᠤᠰᠤ ᠠᠯᠢᠪᠠ



**Зураг 4. Судалгаанд хамрагдсан алба хаагчдын нефть болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын үеийн аюулгүй байдлын шаардлагыг мэддэг эсэхийг дүгнэсэн байдал**

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас та шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн үед аюулгүй ажиллагааны заавар, стандартыг бүрэн мөрдөж чаддаг эсэхийг үнэлж үзэхэд 3.2% маш сайн, 35.7% сайн, 53.5%

дунд, 7.6% муу дүнтэй судалгаанд хамрагдсан. Иймд гал түймэр унтраах дүрэм дээр шингэрүүлсэн шатах хийн талаар тактикийн мэдлэг олгох ур чадварын заалтыг оруулж өгөх шаардлагатай байна. Зураг 5-г үзүүлэв.




**Зураг 5. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас та шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн үед аюулгүй ажиллагааны заавар, стандартыг бүрэн мөрдөж чаддаг эсэхийг дүгнэсэн байдал**

**Ур чадвар**

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн унтраах дадлага хангалттай түвшинд явагддаг эсэхийг үнэлж үзэхэд 10.7% сайн, 52.8% дунд, 34% муу дүнтэй судалгаанд хамрагдсан. Тус шингэрүүлсэн шатдаг хийн унтраах дадлага, сургуулилт хангалттай


түвшинд явагдаж байгаа эсэхийг тодруулахад нийт оролцогсдын 86.8% нь энэ төрлийн дадлага, сургуулилт шаардлагатай байгааг харж болно. Иймд шингэрүүлсэн шатдаг хийн унтраах дадлага сургуулийг тогтмол нэвтрүүлэх шаардлагатай байна. Зураг 6-г үзүүлэв.



**Зураг 6. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн унтраах дадлага хангалттай түвшинд явагддаг эсэхийг дүгнэсэн байдал**

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн үед аюулгүй бүс тогтоох чадвартай эсэхийг үнэлж үзэхэд 3.2% маш сайн, 29.7% сайн, 58.2% дунд, 8.9% муу дүнтэй судалгаанд хамрагдсан. Нийт оролцогчдын 67.1%


нь болзошгүй аюулд бэлтгэлгүй байна. Иймд шингэрүүлсэн шатдаг хийн аюулгүй бүс тогтоох тактикийн тооцоог удирдах бүрэлдэхүүнд заавал орох шаардлагатай байна. Зураг 7-т үзүүлэв.



Зураг 7. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймрийн үед аюулгүй бүс тогтоох чадвартай эсэхийг дүгнэсэн байдал

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр дээр ажиллах үеийн сургалт, тоног төхөөрөмж хүрэлцээтэй эсэхийг үнэлж үзэхэд 1.3% маш их, 6.3% их, 50.9% дунд, 30.2% бага, 11.3% маш бага гэсэн дүнтэй судалгаанд хариулсан байна. Энэхүү судалгааны

асуулгын үр дүнгээс харахад энэ төрлийн томоохон хэмжээний гал түймрийн үед шаардлагатай өндөр өсөлтийн хөөс болон шаардлагатай тоног төхөөрөмж зайлшгүй шаардлагатай байгааг судалгаанд оролцогсад онцолж байна. Зураг 8-т үзүүлэв.



Зураг 8. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр дээр ажиллах үеийн сургалт, тоног төхөөрөмж хүрэлцээтэй эсэхийг дүгнэсэн байдал

### Шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр унтраах үйл ажиллагаа


Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр унтраах үед удирдлага зохион байгуулалт хангалттай түвшинд явагддаг эсэхийг үнэлж үзэхэд 0.6% маш сайн, 28.5% сайн, 58.9% дунд, 10.1% муу, 1.9% маш муу дүнтэй гэж

үнэлсэн. Гал түймэр унтраах ажиллагаанд оролцдог алба хаагчид шингэрүүлсэн шатдаг хийн болзошгүй гал түймрийн үед эрсдэл үүсэх магадлалтай буюу тактикийн бэлтгэл сургуулилт дутмаг гэж дүгнэсэн. Зураг 9-т үзүүлэв.





ᠬᠤᠮᠤᠰᠢᠭᠰᠤᠳᠤᠯᠠᠭᠤ




**Зураг 9. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр унтраах үед удирдлага зохион байгуулалт хангалттай түвшинд явагддаг эсэхийг дүгнэсэн байдал**

Судалгаанд оролцогч алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийг вагон болон автоцистернд тээвэрлэх явцад гал түймэр гарсан тохиолдолд гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэгийн түвшинг үнэлж үзэхэд 13.2 хувь нь их, 72.3 хувь нь дунд, 12.6 хувь нь бага, 1.9 хувь нь маш бага түвшинд үнэлэгдсэн байна. Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 72.3 хувь нь тухайн чиглэлийн мэдлэгийг дунд түвшинд эзэмшсэн байгаа нь ажиглагдаж байна.

Шингэрүүлсэн шатдаг хийг төмөр замын вагон болон автоцистернээр

тээвэрлэх явцад гал түймэр гарах тохиолдолд үүсэх эрсдэл нь өндөр байдаг бөгөөд гал түймэр унтраах ажиллагааг зөв зохион байгуулах нь ослын хор уршгийг бууруулахад чухал ач холбогдолтой юм. Иймээс судалгааны үр дүнгээс үзэхэд алба хаагчдын энэхүү чиглэлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, тухайлбал шингэрүүлсэн шатдаг хийн тээвэрлэлтийн үеийн гал түймрийн үед авах арга хэмжээ, тактикийн зохион байгуулалтын талаар сургалт, дадлагыг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна. Зураг 10-т үзүүлэв.




**Зураг 10. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийг вагон болон автоцистернд тээвэрлэх явцад гал түймэр гарсан тохиолдолд гал түймэр унтраах үйл ажиллагааг зохион байгуулах мэдлэгтэй эсэхийг дүгнэсэн байдал**

Судалгаанд оролцогч алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн баллоны гал түймрийн онцлогийн талаарх мэдлэгийн түвшинг үнэлж үзэхэд 20.1 хувь нь их, 72.3 хувь нь дунд, 7.5 хувь нь бага түвшинд

үнэлэгдсэн байна. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын дийлэнх буюу 72.3 хувь нь тухайн чиглэлийн мэдлэгийг дунд түвшинд эзэмшсэн байгаа нь ажиглагдаж байна.

Шингэрүүлсэн шатдаг хийн баллоны гал түймэр нь хий алдагдах, улмаар дэлбэрэлт үүсэх өндөр эрсдэлтэй байдаг тул гал түймэр унтраах, ажиллагааг зохион байгуулахад онцгой анхаарал шаарддаг. Иймээс судалгааны үр дүнгээс үзэхэд алба хаагчдын энэхүү


чиглэлийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, шингэрүүлсэн шатдаг хийн баллоны гал түймрийн онцлог, эрсдэлийн үнэлгээ болон гал түймэр унтраах тактикийн талаарх сургалт, дадлагыг цаашид тогтмол зохион байгуулах шаардлагатай байна. Зураг 11-т үзүүлэв.



Зураг 11. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн баллоны гал түймрийн онцлогийн талаар мэдлэгтэй эсэхийг дүгнэсэн байдал

Судалгаанд оролцож байгаа алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр унтраах ажиллагаанд шаардлагатай штабын тактикийн тооцоог боловсруулж чадах эсэхийг үнэлж үзэхэд 0.6% маш сайн, 18.4% сайн, 67.7% дунд, 11.4% муу, 1.9% маш

муу дүнтэй судалгаанд хамрагдсан байна. Гал түймрийн тактикийн тооцоог боловсруулах талаар онол, практик сургалтыг илүү нэвтрүүлэх шаардлагатай гэж дүгнэж байна. Зураг 12-т үзүүлэв.



Зураг 12. Судалгаанд хамрагдсан алба хаагчдаас шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр унтраах ажиллагаанд шаардлагатай штабын тактикийн тооцоог боловсруулж чадах эсэхийг дүгнэсэн байдал

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын шингэрүүлсэн шатдаг хийн галын аюулгүй байдалтай холбоотой мэдлэг, ур чадварын түвшин харилцан адилгүй байгааг илрүүлсэн. Тэсрэлтийн дээд болон доод хязгаарын

мэдлэгийг үнэлэхэд 76.7% нь дунд ба түүнээс бага гэж үнэлэгдсэн бол, шингэрүүлсэн шатдаг хийн тархалт, дэлбэрэлтийн аюулын онцлогийн мэдлэгийг үнэлэхэд 65.2% нь тэсрэлтийн аюултай бодис, материалын






ᠰᠢᠩᠭᠡᠷᠦᠭᠦᠯᠤᠰᠢᠨ ᠬᠢᠶᠢᠨ ᠭᠠᠯᠢᠨ ᠠᠵᠣᠯᠭᠦᠢ

шаталт ба тархалтын онцлогийг нарийвчилан мэдэх шаардлагатай гэсэн дүн гарсан. Мөн нефть болон нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн аюулгүй байдлын шаардлагыг мэддэг эсэхийг үнэлэхэд 57% нь тус бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн технологийн процессыг унтраах түвшний удирдах бүрэлдэхүүн дунд ба түүнээс доогуур мэдлэгтэй байх магадлалтай байна, шингэрүүлсэн шатдаг хийг вагон болон автоцистернээр тээвэрлэх явцад гал түймэр гарсан тохиолдолд гал унтраах

ажиллагааг зохион байгуулах мэдлэгийг 72.3% дунд, 12.6% бага, 1.9% маш бага гэж үнэлсэн. Шингэрүүлсэн шатдаг хийн баллоны гал түймрийн онцлогийн мэдлэгийг үнэлэхэд 77.8% бага гэсэн дүн гарсан тул цаашид асуулгын судалгааны үр дүнг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулах шаардлага тулгарч байгаа тул судалгааны дараагийн алхам нь боловсруулагдсан алгоритмын дагуу шингэрүүлсэн хийн галын аюулгүй байдалд хийсэн шинжилгээг Smart PLS 4.0 программаар дүгнэсэн байна.



Зураг 13. Шингэрүүлсэн хийн галын аюулгүй байдалд хийсэн судалгааны үр дүн

Судалгааны үр дүнгээс үзэхэд алба хаагчдын шингэрүүлсэн шатдаг хийн (ШШХ)-гэй холбоотой мэдлэг, ур чадвар нь гал түймэр унтраах удирдлага, зохион байгуулалтын үр дүнд шууд нөлөө үзүүлдэг болох нь тодорхой болсон. Загварын дүнгээр алба хаагчдын мэдлэгийг 10 хувьсагч (M1–M10) дээр үндэслэн үнэлсэн

бөгөөд эдгээрийн үзүүлэлт нь 0.329–0.779-ийн хооронд хэлбэлзэж, мэдлэг нь гал түймэр унтраах удирдлагын зохион байгуулалтанд шууд нөлөөлөх коэффициент 0.322 байсан нь дунд зэргийн нөлөөг илтгэж байна.

Мөн алба хаагчдын ур чадварыг 6 хувьсагч (Y1–Y6) дээр үндэслэн үнэлсэн бөгөөд хувьсагчийн жин нь

0.478–0.820-ийн хооронд хэлбэлзэж, ур чадвар нь гал түймэр унтраах удирдлагын зохион байгуулалтанд шууд нөлөөлөх коэффициент 0.490 гарсан нь мэдлэгтэй харьцуулахад харьцангуй өндөр, нөлөөлөлтэй болохыг харуулж байна.

ШШХ-тэй холбоотой гал түймэр унтраах удирдлагын зохион байгуулалтыг 5 хэмжигдэх хувьсагч (Y<sub>YA1</sub>–Y<sub>YA5</sub>) дээр үнэлсэн бөгөөд эдгээрийн жин 0.569–0.785 хооронд хэлбэлзэж, бүтцийн загварын тайлбарлах чадвар  $R^2 = 0.550$  гарсан нь гал түймэр унтраах удирдлагын зохион байгуулалтын хувийн мэдлэг, ур чадварын үзүүлэлтээс шууд хамааралтай болохыг харж болно.

Эдгээр дүнгээс үзэхэд алба хаагчдын мэдлэг, ур чадвар нь ШШХ-тэй холбоотой гал түймэр унтраах ажиллагааны зохион байгуулалт, үр дүнтэй шууд холбоотой болохыг нотолж байна. Тиймээс гал түймэр унтраах, ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд алба хаагчдын мэдлэг, ур чадварыг тогтмол дээшлүүлэх, сургалт, дадлагыг системтэйгээр зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

### Дүгнэлт

Энэхүү судалгаанд гал түймэр унтраах, аврах ангийн дунд түвшний удирдах алба тушаалтан нар оролцсон бөгөөд шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэртэй тэмцэх үеийн мэдлэг, ур чадвар, сургалт, тоног төхөөрөмжийн нөхцөл байдлыг тодорхойлох зорилготой байв.

Судалгааны үр дүнгээс харахад оролцогчдын ихэнх нь тухайн чиглэлийн мэдлэг, ур чадвараа “дунд” түвшинд гэж үнэлсэн байна. Тухайлбал тэсрэх аюултай орчинд багийн ажиллагаа зохион байгуулах, шингэрүүлсэн шатдаг хийн гал

түймрийн онцлогийг мэдэх, унтраах ажиллагаанд шаардлагатай тактикийн тооцоолол боловсруулах зэрэг чадваруудын дийлэнх хувь нь дунд ба бага түвшинд үнэлэгдсэн нь энэ чиглэлийн мэдлэг, ур чадварыг цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

Мөн шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэр дээр ажиллах сургалт болон тоног төхөөрөмжийн хүрэлцээ хангалтгүй гэж үзсэн оролцогчдын тоо нэлээд байгаа нь одоогийн Гал түймэр унтраах, аврах ангийн хувьд шаардлагатай өндөр өсөлтийн хөөс хангалттай түвшинд байхгүй буюу алба хаагчид санаа зоволт байгаа нь анхаарал татаж байна. Ялангуяа практик дадлага сургалт, бодит нөхцөлд ойртуулсан сургуулилалт, орчин үеийн тоног төхөөрөмжөөр хангах шаардлага байгааг оролцогчдын санал давтамжтай илэрхийлсэн байна.

Иймд цаашид шингэрүүлсэн шатдаг хийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр онол-практик хосолсон сургалтыг тогтмол зохион байгуулах, алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэх, шаардлагатай техник хэрэгсэл болон хамгаалах хувцас, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах нь зүйтэй гэж дүгнэж байна.

### Санал

Судалгааны үр дүнгээс үндэслэн шингэрүүлсэн хийн гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна.

Гал түймэр унтраах, аврах ангийн алба хаагчдын шингэрүүлсэн хийн галын аюулгүй байдлын талаарх онолын мэдлэгийг системтэйгээр нэмэгдүүлэх шаардлагатай. Ялангуяа тэсрэлтийн дээд, доод хязгаар, галын тархалтын онцлог, эрсдэлийн





ᠮᠤᠩᠭᠡᠯᠡᠭᠡᠨᠢ  
ᠲᠠᠯᠠᠶᠢᠷᠬᠤ  
ᠰᠤᠷᠭᠠᠯᠲᠤᠭ  
ᠰᠢᠨᠭᠡᠷᠦᠭᠦᠯᠰᠡᠨ  
ᠬᠢᠶᠢᠨᠭᠠᠯᠲᠤᠭ

үнэлгээний талаарх сургалтыг шаталсан байдлаар зохион байгуулах

Алба хаагчдын практик ур чадварыг сайжруулах зорилгоор бодит нөхцөлд ойртуулсан дадлага, сургуулилтыг тогтмол зохион байгуулах хэрэгтэй. Тухайлбал, шингэрүүлсэн хийн гал түймрийн үед аюулгүй бүс тогтоох, баллон хөргөх, дэлбэрэлтийн эрсдэлийг бууруулах тактикийн дадлагыг түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай

Гал түймэр унтраах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор удирдах бүрэлдэхүүнд зориулсан тусгайлсан сургалт, тактикийн тооцооллын чадамжийг хөгжүүлэх хөтөлбөрийг боловсронгуй болгох шаардлагатай

Шингэрүүлсэн хийн гал түймэртэй тэмцэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн хангалтыг сайжруулах, өндөр өсөлтийн хөөс, тусгай

зориулалтын багаж хэрэгслийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Гал түймэр унтраах сургалт, дадлагын баазыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, олон улсын түвшинд хүргэх, симуляци болон туршилтын орчинд суурилсан сургалтын арга хэлбэрийг нэвтрүүлэх шаардлагатай байна.

#### Ашигласан материал

1. Хийн аж ахуй техник ашиглалтын дүрэм.УБ.2001
2. Хийн аж ахуй ахуйн аюулгүй ажиллагааны дүрэм УБ.ДБЯ, 2002 он
3. Хийн хангамж. БНБД 42-01-04.УБ.ДБЯ, 2004 он
4. Шингэрүүлсэн хийг тээврийн хэрэгсэл, үйлдвэрлэл, ахуйд хэрэглэх техник-эдийн засгийн үндэслэл Ж.Цэвээнжав, Ц.Багмид, А.Баасанжаргал, Ц.Алтанцэцэг нар
5. Шингэрүүлсэн хийн түлш Ц.Багмид.УБ.2005 он

# МОНГОЛ УЛСЫН ОЙ, ХЭЭРИЙН БҮС НУТГИЙН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ

## ANALYSIS OF FIRE RISK IN FOREST AND LAND AREAS OF MONGOLIA

### Ж.Эрдэнэцогт

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

### J. Erdenetsogt

Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, captain

\*хариуцлагатай зохиогч: erdenetsogtj88@gmail.com

**Хураангуй:** Энэхүү судалгаанд Төвийн бүсийн ой, хээрийн түймрийн 2020–2024 оны статистик мэдээлэлд тулгуурлан түймрийн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшинг тодорхойлох, улмаар ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр боловсруулахад ашиглах зорилго тавив.

Судалгаанд тухайн хугацаанд бүртгэгдсэн түймрийн тоо, шатсан талбай, учирсан хохирлын хэмжээ, түймэр гарсан шалтгаан, газар зүйн байршлын онцлог, байгаль орчны нөхцөл, хүн амын нягтрал зэрэг олон талт үзүүлэлтийг хамруулан дүн шинжилгээ хийсэн. Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудын ой, хээрийн түймрийн нөхцөл байдлыг харьцуулан авч үзэж, түймрийн давтамж, тархалтын онцлог, хор уршгийн үзүүлэлтүүдэд үндэслэн эрсдэлийн түвшинг олон улсад хэрэглэгддэг эрсдэлийн үнэлгээний арга зүй, тооцооллын томъёоллын дагуу тодорхойлсон.

Судалгааны үр дүнд тухайн бүс нутгийн ой, хээрийн түймрийн эрсдэлийн орон зайн тархалт, давтамжийн зүй тогтол болон газар зүйн, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн хамаарлыг илрүүлэв. Үүний үндсэн дээр түймрийн эрсдэлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ, бодлогын зөвлөмжийг тодорхойлох боломж бүрдсэн. Судалгааны дүн нь цаашид бүс нутгийн түвшинд ой, хээрийн түймрийн эрсдэлийн менежмент, урьдчилан сэргийлэх стратеги боловсруулах, гал түймрийн хяналт, хариу арга хэмжээний үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр төлөвлөхөд практик ач холбогдолтой юм.

**Abstract:** This study aims to conduct a fire risk assessment based on statistical data on forest and steppe fires in the central region for the period 2020–2024, to determine fire risk levels, and to provide a scientific basis for developing evidence-based policies and measures for reducing and preventing forest and steppe fire risks.

The analysis incorporates multiple indicators, including the number of recorded fires, burned area, extent of damage, causes of fire ignition, geographical characteristics, environmental conditions, and population density during the study period. A comparative assessment of forest and steppe fire conditions in Darkhan-Uul, Selenge, and Tuv provinces was conducted, and fire risk levels were determined based on fire frequency, spatial distribution patterns, and impact indicators, using internationally recognized fire risk assessment methodologies and calculation formulas.

The results reveal spatial distribution patterns and temporal trends of forest and steppe fire risks in the study area, as well as the relationships between geographical and





socio-economic factors influencing fire occurrence. Based on these findings, priority preventive measures and policy recommendations for reducing fire risks were identified. The study findings are of practical significance for improving regional forest and steppe fire risk management, developing prevention strategies, and scientifically planning fire control and emergency response activities at the regional level.

**Түлхүүр үгс:** Төвийн бүс, ой, хээрийн түймэр, статистик, эрсдэл

**Key words:** Central region, forest and steppe fires, statistics, risk

### Удиртгал

Монгол Улсын уудам нутаг дэвсгэр, байгаль, цаг уурын онцлог, экосистемийн эмзэг байдалтай уялдан ой, хээрийн түймэр нь байгаль орчин, нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулдаг байгалийн аюулт үзэгдлийн нэг хэвээр байна. Ялангуяа ой, хээрийн бүс давамгайлсан төвийн бүсийн аймгууд нь ойн нягтрал өндөр, хүн амын төвлөрөл, аж ахуйн үйл ажиллагаа харьцангуй идэвхтэй байдгаас шалтгаалан түймрийн эрсдэл өндөр бүсэд хамаарах хандлагатай байна.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр хуурайшилт, ган гачиг нэмэгдэх, хур тунадасны хуваарилалт өөрчлөгдөх, салхины эрч хүч ихсэх зэрэг байгалийн хүчин зүйлс ой, хээрийн түймрийн давтамж, тархалтын цар хүрээг нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Үүний зэрэгцээ хүн амын нягтрал, газар ашиглалтын өөрчлөлт, хяналтгүй ил гал ашиглалт, үйлдвэрлэл, тээвэр, уул уурхайн үйл ажиллагаа зэрэг хүний хүчин зүйлс түймрийн эрсдэлийг улам нэмэгдүүлж байгаа нь судалгаагаар тогтоогдсоор байна.

Төвийн бүсийн хэмжээнд 2020–2024 оны хооронд бүртгэгдсэн ой, хээрийн түймрийн статистик мэдээллээс харахад түймрийн тоо, шатсан талбай, учирсан хохирол жил бүр харилцан адилгүй хэлбэлзэлтэй байсан ч ерөнхийдөө өсөх хандлага ажиглагдсан. Харин 2025 онд төвийн

бүсийн зарим аймгуудад ой, хээрийн түймрийн нөхцөл байдал онцгой хурцдаж, түймрийн тоо, тархалтын цар хүрээ өмнөх жилүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц нэмэгдсэн нь тухайн бүс нутгийн түймрийн эрсдэлийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дахин үнэлэх, эрсдэлийн хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлох зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Иймд энэхүү судалгаанд Төвийн бүсийн ой, хээрийн түймрийн 2020–2024 оны статистик мэдээлэлд тулгуурлан түймрийн эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн түвшинг тодорхойлох, улмаар 2025 онд ажиглагдсан түймрийн эрсдэл огцом нэмэгдсэн нөхцөл байдалтай уялдуулан эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээг боловсронгуй болгоход ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг бүрдүүлэх зорилго тавьсан болно.

Энэхүү судалгааны үр дүн нь төвийн бүсийн хэмжээнд ой, хээрийн түймрийн эрсдэлийн орон зайн ялгаа, давтамжийн зүй тогтол, түймрийн эрсдэлд нөлөөлөх байгаль, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн хамаарлыг тодорхойлох боломж олгохын зэрэгцээ бүс нутгийн түвшинд эрсдэлийн менежмент, урьдчилан сэргийлэх стратеги, гал түймрийн хяналт, хариу арга хэмжээний төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Сүүлийн 5 жилийн (2020–2024 он) хугацаанд Төвийн бүсийн аймгуудын хэмжээнд нийт 107 удаагийн ой, хээрийн түймэр бүртгэгдэж, түймрийн улмаас ойн бүсэд 4,196.2 га, хээрийн бүсэд 3,579.58 га, нийт 7,775.78 га талбай шатаж, байгаль орчин, экосистемд 843.5 сая төгрөгийн хохирол учирч, түймрийг унтраах ажиллагаанд нийт 65.1 сая төгрөгийн зардал гарсан байна.

Түймрийг унтраах, хяналт тогтоох ажиллагаанд төрийн болон орон нутгийн байгууллагууд хамтран ажилласан бөгөөд нийт 3,115 хүн, 444

автомашин, 15 мотоцикл, 16 морь оролцсон байна. Үүнд:

- Онцгой байдлын байгууллагаас 1,104 алба хаагч, 115 автомашин, 1 нисдэг тэрэг;
- Хил хамгаалах байгууллагаас 104 алба хаагч, 9 автомашин, 1 морь;
- Цагдаагийн байгууллагаас 35 алба хаагч, 3 автомашин;
- Орон нутгийн иргэдээс 1,872 хүн, 317 автомашин, 46 мотоцикл, 15 морь тус тус унтраах үйл ажиллагаанд оролцсон байна.]

Он	Түймрийн тоо (улсын хэмжээнд)
2020 он	140
2021 он	65
2022 он	179
2023 он	101
2024 он	137

Хүснэгт 1. Ой хээрийн түймрийн судалгаа (Сүүлийн 5 жилээр)<sup>1</sup>

Сүүлийн таван жилийн (2020–2024) статистик мэдээнээс үзэхэд Монгол Улсад бүртгэгдсэн ой, хээрийн түймрийн тоо жил бүр тогтворгүй хэлбэлзэж байгаа нь байгаль, цаг уурын нөхцөл байдал, хүний үйл ажиллагааны нөлөө, түүнчлэн урьдчилан сэргийлэх бодлого, менежментийн арга хэмжээний үр нөлөөтэй шууд хамааралтайг илтгэж байна.

Тухайлбал, 2020–2021 онд ой, хээрийн түймрийн тоо 140-өөс 65 болж, 53.6 хувиар огцом буурсан нь тухайн хугацаанд цаг уурын нөхцөл харьцангуй тааламжтай байсан, мөн төрийн байгууллагуудын зүгээс хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа илүү идэвхтэй, үр дүнтэй явагдсан байж болзошгүйг харуулж байна. Харин 2021–2022 онд түймрийн тоо эрс нэмэгдэж, 179-д хүрсэн нь өмнөх жилтэй харьцуулахад 114

түймрээр буюу 175 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд энэ нь ихэнх нутгаар хуурайшилт нэмэгдэж, хур тунадасны хэмжээ буурсан, салхины эрчим хүч ихэссэн зэрэг байгаль, цаг уурын эрсдэлтэй нөхцөл байдалтай холбоотой байж болох юм.

Үүнээс хойш 2022–2023 онд ой, хээрийн түймрийн тоо 179-өөс 101 болж, 43.6 хувиар буурсан нь зарим аймаг, бүс нутагт урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлсэнтэй тодорхой хэмжээнд холбоотой гэж үзэх үндэслэлтэй. Гэвч 2023–2024 онд түймрийн тоо дахин өсөж, 101-ээс 137 болж, 35.6 хувиар нэмэгдсэн нь зарим бүс нутгаар эрсдэлтэй уур амьсгалын нөхцөл байдал үргэлжилсэн, мөн хяналт, хариу арга хэмжээний үр нөлөө хангалтгүй байсныг илтгэн харуулж байна (Хүснэгт 2).





№	Түймрийн тоо	Өөрчлөлт (өмнөх оноос)	Өөрчлөлт (%)
2020 он	140	-	-
2021 он	65	-75	-53.6%
2022 он	179	+114	+175.4%
2023 он	101	-78	-43.6%
2024 он	137	+36	+35.6%

**Хүснэгт 2. Ой хээрийн түймрийн харьцуулсан судалгаа (2020-2024 он)**

**Ой, хээрийн түймэр гарах шалтгаан нөхцөл:** Ой хээрийн түймэр гэдэг нь байгалийн буюу хүний хүчин зүйлсийн нөлөөгөөр ой мод, өвс ургамал бүхий газар нутгийн экосистемд гал тархах үзэгдэл юм. Энэ нь тухайн бүс нутгийн экологийн бүтэц, амьдрах орчин, хөрс, амьтан ургамлын аймагт шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлдэг.

Судлаачдын үзэж байгаагаар, ой хээрийн түймрийн тархалт дараах үндсэн хүчин зүйлээс шалтгаалдаг (Keeley, 2009)

#### 1. Байгалийн шалтгаан

- Хуурайшилт, гандалт – Хэт халуун, хуурай улирал, хур тунадас багассан жилүүдэд ой, хээрийн ургамал чийгээ алдаж, шатамхай байдал нь нэмэгддэг.

- Салхи – Хүчтэй салхи нь галыг хурдтай тархааж, хяналтаас гаргах гол хүчин зүйл болдог.

- Аянга – Байгалийн гаралтай цахилгаан цахилт (аянга) нь гал үүсгэх шууд шалтгаан болдог. Монгол орны хангай, тайгын бүсэд энэ шалтгаан зонхилох хандлагатай.

- Хуурай өвс, модны хаягдал – Хуурайшсан өвс, мөчир, навч, модны үхмэл хэсгүүд их хэмжээгээр хуримтлагдсан үед түймрийн тархалт хялбар болдог.

#### 2. Хүний үйл ажиллагаанаас үүсэх шалтгаан

- Буруу гал түймрийн хэрэглээ – Хог шатаах, талбай цэвэрлэх зорилгоор гал түлэх, ил гал гаргах нь хяналтгүй

нөхцөлд түймэр үүсэх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

- Тамхи, шүдэнз – Зам дагуух тээврийн хэрэгслээс хаясан асаалттай тамхи, шүдэнз ой хээрийн бүсэд шаталт үүсгэх магадлал өндөртэй.

- Малчид, анчдын анхааралгүй үйлдэл – Хээрээр зорчсон иргэд, малчид гал унтраахгүй үлдээх, хяналтгүй орхих зэрэг үйлдэл ихэнх түймрийн шалтгаан болдог.

- Зам барилга, мод бэлтгэл, уул уурхай – Ойн бүсэд явуулж буй эдгээр үйл ажиллагаанд хяналт сул байвал оч үсэрч, гал авалцах эрсдэл нэмэгддэг.


### **ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМРИЙН ЭРСДЭЛИЙГ ТОДОРХОЙЛОХ ШИНЖИЛГЭЭ**

Эрсдэлийг шинжилгээг судалгааны хүрээнд ерөнхий болон нарийвчилсан гэсэн хоёр үндсэн түвшинд ангилан авч үздэг бөгөөд энэ нь бодлогын шийдвэр гаргалтад чухал ач холбогдолтой (World Bank, 2020; UNDRR, 2019).

Гамшгийн эрсдэлийн үнэлгээг дараах хэсэгт хуваан авч үздэг. Зураг 1 -т үзүүлэв.



Үндэсний эрх зүйн ухааны  
 гэрээний тусламжийн  
 төв



Өөрөөр хэлбэл тус судалгаанд Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний арга болох “Нийгэм-эдийн засгийн интеграл арга”-ыг сонгон авсан болно.

Энэхүү нийгэм-эдийн засгийн интеграл аргыг 4 үндсэн алхмаар үнэлдэг. Үүнд:

**ЭХНИЙ ШАТ:** Тухайн аюулын үндсэн эрсдэлийг тодорхойлно. Энэ шатанд ой-хээрийн түймрийн гаралт буюу тоо, түймэрт өртсөн талбайн хэмжээ, энэ түймэрт өртсөн хохирлын хэмжээ зэргийг тухайн бүс нутгийн хүн амд

харьцуулсан харьцуулалтыг үндсэн эрсдэл гэж үзнэ.

$R_{гал}$  түймэр тоо- тухайн бүс нутагт тохиолдсон гал түймрийн тоо;

$R_{өртсөн}$  талбай- тухайн бүс нутгийн ой, хээрийн түймэрт өртсөн талбай, га;

$R_{хохирол}$ -тухайн бүс нутагт тохиолдсон ой, хээрийн түймрийн улмаас өртөх эд материалын шууд хохирол, төгрөг.

Сүүлийн 5 жилийн хугацаанд Монгол Улсын төвийн бүсийн Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад гарсан ой, хээрийн түймрийн гаралтыг хүснэгт 3-т үзүүлэв.

Төвийн бүс хээрийн түймрийн тоо												
Статистик үзүүлэлт	Төвийн бүс	2020		2021		2022		2023		2024		Нийт дундаж
		/ой/	/хээр/	/ой/	/хээр/	/ой/	/хээр/	/ой/	/хээр/	/ой/	/хээр/	
Дархан-Уул аймаг		0	0	0	0	2	0	0	0	1	0	1
Сэлэнгэ аймаг		13	7	5	4	9	13	4	9	11	3	16
Төв аймаг		4	2	1	1	3	6	2	2	2	4	6
Нийт ой, хээрийн түймрийн тоо		26		11		33		17		20		21

Хүснэгт 3. Төвийн бүсийн ой, хээрийн түймрийн статистик мэдээлэл (2020-2024 он)

Тус үндсэн эрсдэлийг тодорхойлоход тухайн бүс нутгийн хүн амын мэдээлэл шаардлагатай болдог.

Иймд 2020-2024 оны Төвийн бүсийн хүн амын тоон мэдээллийг хүснэгт 4 – т үзүүлэв.



ᠬᠤᠠᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤᠨᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠰᠤ

Хүн амын тоо	2020	2021	2022	2023	2024
Дархан-Уул аймаг	106,909	107,751	107,932	109,236	110,544
Сэлэнгэ аймаг	109,285	108,878	107,341	106,691	106,042
Төв аймаг	93,162	93,468	92,038	91,451	91,555
Дундаж	103,119	103,366	102,437	102,459	102,714
Нийт	309,356	310,097	307,311	307,378	308,141

Хүснэгт 4. Төвийн бүсийн аймгуудын 2020-2024 оны хүн амын мэдээлэл




График 1. Төвийн бүсийн ой, хээрийн түймрийн график судалгаа

Дээрх хүснэгт 3 болон графикаас үзэхэд төвийн бүсийн хэмжээнд тохиолдох ой, хээрийн түймрийн 72.8% Сэлэнгэ аймгийн газар нутаг дээр гарсан байна. Эдгээр төвийн бүсийн 3 аймгийн нэгж хугацаанд гарсан ой, хээрийн түймрийг хүн амд харьцуулсан байдлыг томьёо (1) үзүүлэв.

$$R_{\text{гал түймрийн тоо ба эрсдэл}} = \frac{N_{\text{ой,хээрийн түймрийн тоо}}}{Q_{\text{хүн амын}}} \left[ \frac{\text{ой,хээрийн түймрийн тоо жилд}}{\text{Хүн амын тоо жилд}} \right]$$

(1)

Тооцооны хэсэг:

$$R_{\text{гал түймрийн тоо Дархан-Уул (2020)}} = \frac{N_{\text{ой,хээрийн түймрийн тоо}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{0}{106909} = 0$$

$$R_{\text{гал түймрийн тоо Сэлэнгэ (2020)}} = \frac{N_{\text{ой,хээрийн түймрийн тоо}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{20}{109285} = 0.00018 = 0.18 \cdot 10^{-3}$$

$$R_{\text{гал түймрийн тоо Төв (2020)}} = \frac{N_{\text{ой,хээрийн түймрийн тоо}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{6}{93162} = 0.000064 = 0.064 \cdot 10^{-3}$$

Энэхүү тооцооны загварын үр дүнг хүснэгт 5-д үзүүлэв.

Ой, хээрийн түймрийн тоо, хүн амын тоо $R_{\text{гал түймэр тоо (2020-2024)}}$
--------------------------------------------------------------------------------

Статистик үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	Нийт дундаж
Дархан-Уул аймаг	0	0	$0.018 \cdot 10^{-3}$	0	$0.009 \cdot 10^{-3}$	0
Сэлэнгэ аймаг	$0.18 \cdot 10^{-3}$	$0.082 \cdot 10^{-3}$	$0.204 \cdot 10^{-3}$	$0.121 \cdot 10^{-3}$	$0.132 \cdot 10^{-3}$	$0.144 \cdot 10^{-3}$
Төв аймаг	$0.064 \cdot 10^{-3}$	$0.021 \cdot 10^{-3}$	$0.097 \cdot 10^{-3}$	$0.043 \cdot 10^{-3}$	$0.065 \cdot 10^{-3}$	$0.042 \cdot 10^{-3}$

**Хүснэгт 5. Ой, хээрийн түймрийн эрсдэл нэг хүнд ноогдох түймрийн эрсдэл. (Нэгж хугацаагаар тооцов)**

Аймгуудын хоорондын ялгаа

• Сэлэнгэ аймаг нь судалгааны хугацаанд ой, хээрийн түймрийн эрсдэлийн үзүүлэлт хамгийн өндөр, тогтвортой түвшинд байсан бөгөөд 5 жилийн дундаж нь  $0.144 \cdot 10^{-3}$  байна. Энэ нь ой, хээрийн бүс давамгайлсан газарзүйн онцлог, хуурайшилт, хүний үйл ажиллагааны нөлөө өндөртэй холбоотой гэж үзэж болно.

• Төв аймгийн хувьд R утга  $0.021 \cdot 10^{-3}$  –  $0.097 \cdot 10^{-3}$  хооронд хэлбэлзэж, 5 жилийн дундаж  $0.042 \cdot 10^{-3}$  байгаа нь Сэлэнгэ аймгаас даруй бага

боловч тогтмол эрсдэл оршиж байгааг харуулж байна.

• Дархан-Уул аймагт ихэнх жилүүдэд ой, хээрийн түймрийн эрсдэлийн үзүүлэлт тэг буюу маш бага түвшинд байгаа нь тухайн аймгийн газарзүйн байршил, ой хээрийн талбай харьцангуй бага, суурьшил давамгайлсантай холбоотой гэж тайлбарлаж болно.

Статистик мэдээлэлд тулгуурлан 2020–2024 оны хугацаанд Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудад ой, хээрийн түймрийн улмаас шатсан га талбайн мэдээллийг хүснэгт 6-д үзүүлэв.

Ой, хээрийн түймрийн шатсан талбай, га						
Статистик үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024	Нийт дундаж
Дархан-Уул аймаг	0	0	56	0	2	11,6га
Сэлэнгэ аймаг	2626.5	456.13	934.65	833	290	1,028.056га
Төв аймаг	28.3	33.3	886.1	28	295	254.14га

**Хүснэгт 6. Төвийн бүсэд гарсан ой, хээрийн түймрийн улмаас өртөж шатсан талбайн мэдээлэл, га**

2020–2024 оны хугацаанд ой, хээрийн түймрийн улмаас шатсан талбайн хэмжээ аймгуудын хувьд ихээхэн ялгаатай байгаа нь ажиглагдаж байна. Сэлэнгэ аймагт шатсан талбай хамгийн их бөгөөд жилүүдийн хооронд хэлбэлзэлтэй байгаа ч нийт 5 жилийн дундаж нь 1,028.1 га болж, ой, хээрийн түймрийн нөлөөлөл хамгийн өндөр

байгааг илтгэж байна. Ялангуяа 2020 онд 2,626.5 га талбай шатсан нь бусад жилүүд болон аймгуудтай харьцуулахад эрс өндөр үзүүлэлт юм.

Төв аймгийн хувьд 2022 онд 886.1 га талбай шатсанаар огцом өсөлт ажиглагдсан бөгөөд бусад жилүүдэд шатсан талбай харьцангуй бага түвшинд байсан ч 5 жилийн дундаж





ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯᠤᠰᠤ ᠰᠤᠮᠤᠯᠤᠯᠤᠰᠤ

254.1 га байгаа нь тогтмол эрсдэл оршиж байгааг харуулж байна.

Харин Дархан-Уул аймагт судалгааны хугацаанд шатсан талбай маш бага, эсвэл огт бүртгэгдээгүй бөгөөд 2022 онд 56 га, 2024 онд 2 га шатсан тохиолдол бүртгэгдсэн ч 5 жилийн дундаж нь ердөө 11.6 га байгаа нь бусад аймгуудтай харьцуулахад түймрийн нөлөөлөл хамгийн бага

байгаа хэдийч энэхүү түймэрт өртсөн талбайн хэмжээгээр аль аймаг нь эрсдэл өндөр байгааг тогтоох шаардлагатай тул тооцож үзэв.

Төвийн бүсийн нутаг дэвсгэрт тохиолдох ой, хээрийн түймэрт ноогдох шатсан талбайн хэмжээгээр үндсэн эрсдэлийг томъёо (2)-оор тодорхойлно.

$$R_{\text{түймэрт өртсөн талбай}} = \frac{Q_{\text{шатсан талбай}}}{Q_{\text{хүн амын}}} \left[ \frac{\text{шатсан талбай}}{10^2 \text{ ой, хээрийн түймэр}} \right] \quad (2)$$

Тооцооны хэсэг:

$$R_{\text{түймэрт өртсөн талбай Дархан-Уул (2020)}} = \frac{Q_{\text{түймэрт өртсөн талбай}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{0}{106909} = 0$$

$$R_{\text{түймэрт өртсөн талбай Сэлэнгэ (2020)}} = \frac{Q_{\text{түймэрт өртсөн талбай}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{2626.5}{109285} = 0.024$$

$$R_{\text{түймэрт өртсөн талбай Төв (2020)}} = \frac{Q_{\text{түймэрт өртсөн талбай}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{28.3}{93162} = 0.0003$$

$$= 0.30 \cdot 10^{-3}$$

Энэхүү тооцооны загварын үр дүнг хүснэгт 7-д үзүүлэв.

Ой, хээрийн түймрийн улмаас нэгж хүн амд ноогдох шатсан талбайн хэмжээ, $R_{\text{түймэрт өртсөн талбай}}$ (2020-2024)						
$R_{\text{түймэрт өртсөн талбай}}$	2020	2021	2022	2023	2024	Нийт дундаж
Дархан-Уул аймаг	0	0	0.0005	0	0.00002	0.000104
Сэлэнгэ аймаг	0.024	0.0041	0.0087	0.0078	0.0027	0.005825
Төв аймаг	0.003	0.0003	0.0096	0.0003	0.0032	0.00335

**Хүснэгт 7. Ой, хээрийн түймэрт ноогдох шатсан талбай харьцуулсан эрсдэл. (Нэгж хугацаагаар тооцов)**

2020–2024 оны хугацаанд ой, хээрийн түймрийн улмаас нэгж хүн амд ноогдох шатсан талбайн хэмжээ аймгуудын хувьд илэрхий ялгаатай, жилүүдийн хооронд ихээхэн хэлбэлзэлтэй байгааг харуулж байна.

Аймаг тус бүрийн шинжилгээ

• Сэлэнгэ аймаг: Судалгааны бүх хугацаанд  $R_{\text{түймэрт өртсөн талбай}}$  хамгийн өндөр түвшинд байна. Ялангуяа 2020 онд 0.024 хүрсэн нь тухайн жилд түймрийн улмаас өргөн хэмжээний талбай шатаж, хүн амын ачаалал өндөр байсныг илтгэнэ. 5

жилийн дундаж утга 0.005825 байгаа нь Сэлэнгэ аймагт ой, хээрийн түймрийн нийгэм-экологийн нөлөөлөл хамгийн их байгааг харуулж байна.

• Төв аймаг: Үзүүлэлт нь жилүүдийн хооронд огцом хэлбэлзэж, 2022 онд 0.0096 болж өссөн нь тухайн жилд шатсан талбай огцом нэмэгдсэнийг илэрхийлнэ. Бусад жилүүдэд харьцангуй бага түвшинд хадгалагдсан ч 5 жилийн дундаж 0.00335 байгаа нь түймрийн нөлөөлөл тогтмол оршиж байгааг харуулж байна.

• Дархан-Уул аймаг: Судалгааны хугацаанд R (түймэрт өртсөн талбай) бараг тэгтэй дүйцэхүйц түвшинд байна. Зөвхөн 2022 (0.0005) болон 2024 (0.00002) онуудад бага хэмжээний утга бүртгэгдсэн бөгөөд 5 жилийн дундаж 0.000104 байгаа нь ой, хээрийн түймрийн нөлөөлөл бусад аймгуудтай харьцуулахад хамгийн бага байгааг илтгэнэ.

2020–2024 онд ой, хээрийн түймрийн улмаас нэгж хүн амд ноогдох

шатсан талбайн хэмжээ Сэлэнгэ аймагт хамгийн өндөр, Төв аймагт дунд түвшинд, Дархан-Уул аймагт хамгийн бага байна. Энэ нь ой, хээрийн бүсийн тархалт, хүн амын нягтаршил, цаг уурын нөхцөл болон түймрийн давтамжтай шууд уялдаж байгаа тул цаашид эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх бодлого, нөөц хуваарилалтыг Сэлэнгэ болон Төв аймагт түлхүү чиглүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Хохирлын тоо /мянган төгрөгөөр ( $\cdot 10^3$ )/ R <sub>хохирол</sub>						
Статистик мэдээлэл	2020	2021	2022	2023	2024	Нийт дундаж
Дархан-Уул аймаг	-	-	3,584,902	-	-	716,980
Сэлэнгэ аймаг	776.400.000	556.400.000	591.600.000	19.000.000	89.400.000	406,560,000
Төв аймаг	9.822.500	60.611.470	3.557.430	15.343.821	11.793.555	23,894,519

**Хүснэгт 8. Ой, хээрийн түймрийн улмаас хүн амд ноогдох эдийн засгийн хохирлын мэдээлэл. (Нэгж хугацаагаар тооцов)**

2020–2024 оны хооронд ой, хээрийн түймрийн улмаас учирсан хохирлын хэмжээ аймгуудын хувьд ихээхэн ялгаатай, жилүүдийн хооронд хэлбэлзэл өндөртэй байгаа нь ажиглагдаж байна.

Аймаг тус бүрийн шинжилгээ

• Сэлэнгэ аймаг: Судалгааны хугацаанд хохирлын хэмжээ хамгийн өндөр түвшинд байна. Ялангуяа 2020–2022 онуудад хохирол 556–776 тэрбум төгрөгийн хооронд хэлбэлзсэн нь тухайн аймагт гарсан ой, хээрийн түймэр эдийн засгийн ноцтой үр дагавартай байсныг илтгэнэ. 2023–2024 онд хохирол харьцангуй буурсан боловч 5 жилийн дундаж нь 406.56 тэрбум төгрөг байгаа нь нийт судлагдсан аймгуудаас хамгийн өндөр үзүүлэлт юм.

• Төв аймаг: Хохирлын хэмжээ жил бүр тогтмол бус, харьцангуй бага түвшинд хэлбэлзэж байгаа ч бүх

хугацаанд бүртгэгдсэн байна. Хамгийн өндөр хохирол 2021 онд (60.6 тэрбум төгрөг), хамгийн бага нь 2022 онд (3.6 тэрбум төгрөг) бүртгэгдсэн бөгөөд 5 жилийн дундаж нь 23.9 тэрбум төгрөг байна. Энэ нь Төв аймагт түймрийн эдийн засгийн нөлөөлөл дунд түвшинд байгааг харуулна.

• Дархан-Уул аймаг: Судалгааны хугацаанд зөвхөн 2022 онд 3.58 тэрбум төгрөгийн хохирол бүртгэгдсэн бөгөөд бусад жилүүдэд хохирол гараагүй буюу бүртгэгдээгүй байна. Үүний улмаас 5 жилийн дундаж хохирол 716.98 сая төгрөг болж, бусад аймгуудтай харьцуулахад эдийн засгийн нөлөөлөл хамгийн бага түвшинд байгааг харуулж байна. Иймд хүн амд ноогдох эдийн засгийн хохирлын эрсдэлийг дараах байдлаар тодорхойлно.

2020–2024 оны хугацаанд ой, хээрийн түймрийн улмаас учирсан эдийн засгийн хохирол Сэлэнгэ аймагт





хамгийн өндөр, Төв аймагт дунд түвшинд, Дархан-Уул аймагт хамгийн бага байна. Энэ нь түймрийн давтамж, шатсан талбайн хэмжээ, байгалийн нөхцөл болон эдийн засгийн идэвхжилтэй шууд уялдаж байгаа тул цаашид хохирлыг бууруулах чиглэлээр эрсдэлийн удирдлага, урьдчилан

сэргийлэх арга хэмжээг Сэлэнгэ болон Төв аймагт түлхүү хэрэгжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Төвийн бүсийн нутаг дэвсгэрт тохиолдох ой, хээрийн түймэрт ноогдох эдийн засгийн хохирлыг тооцоолох үндсэн эрсдэлийг томъёо (3)-оор тодорхойлно.

$$R_{\text{хохирол}} = \frac{Q_{\text{шатсан талбай}}}{Q_{\text{хүн ам}}} \left[ \frac{\text{шатсан талбай}}{\text{хүн ам}} \right] \quad (3)$$

Тооцооны хэсэг:

$$R_{\text{хохирол Дархан-Уул (2020)}} = \frac{C_{\text{хохирол}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{0}{106909} = 0$$

$$R_{\text{хохирол Сэлэнгэ (2020)}} = \frac{C_{\text{хохирол}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{776400000}{109285} = 7104$$

$$R_{\text{хохирол Төв (2020)}} = \frac{C_{\text{хохирол}}}{Q_{\text{хүн амын}}} = \frac{9822500}{93162} = 105.4$$

Энэхүү тооцооны загварын үр дүнг хүснэгт 9-т үзүүлэв.

Хохирлын тоо /мянган төгрөгөөр ( $\cdot 10^3$ )/ $R_{\text{хохирол}}$						
$R_{\text{хохирол}}$	2020	2021	2022	2023	2024	Нийт дундаж
Дархан-Уул аймаг	0	0	33.2	0	0	6.64
Сэлэнгэ аймаг	7104	5110	5511	178	843	3749.2
Төв аймаг	105.4	648.4	38.6	167.6	128.8	217.76

**Хүснэгт 9. Ой, хээрийн түймрийн улмаас хүн амд ноогдох эдийн засгийн хохирлын эрсдэл. (Нэгж хугацаагаар тооцов)**

2020–2024 оны хугацаанд ой, хээрийн түймрийн улмаас үүссэн эдийн засгийн хохирлын эрсдэл ( $R_{\text{хохирол}}$ ) аймгуудын хооронд эрс ялгаатай байна. Сэлэнгэ аймагт эдийн засгийн хохирол хамгийн өндөр төвшинд бүртгэгдэж, ялангуяа 2020–2022 онуудад  $R_{\text{хохирол}}$  5,110–7,104 хүрсэн нь тухайн бүс нутагт гарсан түймэр нь эдийн засагт ноцтой үр дагавар учруулж байсныг харуулж байна. Хэдийгээр 2023–2024 онд уг үзүүлэлт огцом буурсан ч 5 жилийн дундаж 3,749.2 байгаа нь Сэлэнгэ аймагт эдийн засгийн эмзэг байдал өндөр хэвээр байгааг илтгэнэ.

Төв аймгийн хувьд эдийн засгийн хохирлын хэмжээ жилүүдийн хооронд ихээхэн хэлбэлзэж, 2021 онд дээд

цэгтээ (648.4) хүрсэн бол бусад жилүүдэд харьцангуй бага түвшинд байна. Гэсэн хэдий ч 5 жилийн дундаж 217.76 байгаа нь ой, хээрийн түймэр эдийн засгийн тодорхой хэмжээний эрсдэл дагуулж байгааг харуулж байна.

Харин Дархан-Уул аймагт судалгааны хугацаанд эдийн засгийн хохирол бараг бүртгэгдээгүй бөгөөд зөвхөн 2022 онд 33.2 утга гарсан байна. Үүний улмаас 5 жилийн дундаж 6.64 болж, бусад аймгуудтай харьцуулахад эдийн засгийн хохирлын эрсдэл хамгийн бага түвшинд байна.

Нэгтгэн дүгнэхэд, ой, хээрийн түймрийн улмаас үүсэх эдийн засгийн хохирол Сэлэнгэ аймагт хамгийн их, Төв аймагт дунд түвшинд, Дархан-Уул





Сэлэнгэ аймаг

• Бүх стандарт үзүүлэлт 1 (хамгийн өндөр) түвшинд байна.

• Энэ нь түймрийн тоо их, хамарсан талбай өргөн, эдийн засгийн хохирол өндөр байгааг илэрхийлж, Төвийн бүсэд ой, хээрийн түймрийн хамгийн өндөр эрсдэлтэй аймаг болохыг нотолж байна.

Төв аймаг

• Түймрийн тоо (0.3), өртсөн талбай (0.4) нь дунд түвшний эрсдэлтэй,

• Харин хохирлын стандарт үзүүлэлт (0.1) харьцангуй бага байна. Энэ нь түймэр тодорхой давтамжтай гардаг ч эдийн засгийн хохирол харьцангуй бага, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээ тодорхой хэмжээнд үр дүнтэй байгааг илтгэнэ.

Дархан-Уул аймаг

$$K_{\text{гал түймрийн тоо}}^* = 0.5, K_{\text{өртсөн талбай}}^* = 0.33 \text{ харин } K_{\text{хохирол}}^* = 0.17 \quad (3)$$

**ДӨРӨВДЭХЬ ШАТ:** Энэ үе шатад дээрх тооцоолсон тооцооны үр дүнг нийгэм-эдийн засгийн интеграл аргаар тооцох буюу дээр тооцоолсон үзүүлэлтийг нэгтгэх тооцооллыг томъёо (4)-өөр үзүүлэв.

$$R_j^{\text{НЭ}} = R_{\Gamma}^* \cdot K_{\text{гал түймрийн тоо}} + R_{\text{өртөлт}}^* \cdot K_{\text{өртсөн талбай}} + R_{\text{хохирол}}^* \cdot K_{\text{хохирол}} \quad (4)$$

$$0 \leq R_j^{\text{СЭ}} \leq 1,$$

Тооцооллын хэсэг:

$$R_{\text{Дархан}}^{\text{НЭ}} = R_{\Gamma}^* \cdot K_{\text{гал түймрийн тоо}} + R_{\text{өртөлт}}^* \cdot K_{\text{өртсөн талбай}} + R_{\text{хохирол}}^* \cdot K_{\text{хохирол}} = 0 \cdot 0.5 + 0 \cdot 0.33 + 0.06 \cdot 0.17 = 0.01$$

$$R_{\text{Сэлэнгэ}}^{\text{НЭ}} = R_{\Gamma}^* \cdot K_{\text{гал түймрийн тоо}} + R_{\text{өртөлт}}^* \cdot K_{\text{өртсөн талбай}} + R_{\text{хохирол}}^* \cdot K_{\text{хохирол}} = 1 \cdot 0.5 + 1 \cdot 0.33 + 1 \cdot 0.17 = 1.0$$

$$R_{\text{Төв}}^{\text{НЭ}} = R_{\Gamma}^* \cdot K_{\text{гал түймрийн тоо}} + R_{\text{өртөлт}}^* \cdot K_{\text{өртсөн талбай}} + R_{\text{хохирол}}^* \cdot K_{\text{хохирол}} = 0.3 \cdot 0.5 + 0.4 \cdot 0.33 + 0.1 \cdot 0.17 = 0.3$$

Төвийн бүсийн аймгуудын ой, хээрийн түймрийн нэгдсэн эрсдэлийг хүснэгт 12-т үзүүлэв.

Ой, хээрийн түймрийн аюулын түвшний нэршил	Тоон хэмжигдэхүүн	Аймгуудын эрсдэлийн түшинг харуулсан байдал
--------------------------------------------	-------------------	---------------------------------------------

Хэт их аюултай түвшин [0.75-1.0]	1.0	Сэлэнгэ аймаг
Өндөр аюултай түвшин [0.5-0.75]	-	-
Дунд хэмжээний аюултай түвшин [0.25-0.5]	0.3	Төв аймаг
Бага хэмжээний аюултай түвшин [0-0.25]	0.01	Дархан-Уул аймаг

Хүснэгт 12. Төвийн бүсийн аймгуудын ой, хээрийн түймрийн эрсдэлийн аюулын түвшин

Энэхүү судалгаанд Төвийн бүсийн аймгуудын ой, хээрийн түймрийн эрсдэлийг нийгэм-эдийн засгийн интеграл аргаар үнэлэх зорилгоор гал түймрийн тоо, өртсөн талбай, хохирлын хэмжээ гэсэн стандартчилсан үзүүлэлтүүдийг нэгтгэн тооцсон. Тооцооллыг томьёо (4)-г заасан жинлэсэн интеграл загвараар гүйцэтгэж, нэгдсэн эрсдэлийн индекс ( $R_j^{H3}$ )-ийг 0–1 завсарт нормчлон тодорхойлсон нь аймгуудын хооронд харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэв.

Судалгааны үр дүнгээс харахад аймгуудын нэгдсэн эрсдэлийн түвшин хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай байна. Сэлэнгэ аймагт нэгдсэн эрсдэлийн индекс  $R_j^{H3} = 1.0$  буюу “хэт их аюултай түвшин”-д хамаарч байгаа нь гал түймрийн тоо, өртсөн талбай, эдийн засгийн хохирол зэрэг бүх үзүүлэлт өндөр байгаатай шууд холбоотой юм. Энэ нь тус аймагт ой, хээрийн түймэр байгаль орчинд төдийгүй нийгэм, эдийн засгийн тогтвортой байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлж байгааг харуулж байна. Иймд гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх, эрт илрүүлэлтийн системийг сайжруулах, нөөц хүч, хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох шаардлагатайг илтгэнэ.

Төв аймагт нэгдсэн эрсдэлийн индекс  $R_j^{H3} = 0.3$  гарч, “дунд

хэмжээний аюултай түвшин”-д хамаарав. Гал түймрийн давтамж болон өртсөн талбай дунд түвшинд байгаа хэдий ч хохирлын үзүүлэлт харьцангуй бага байгаа нь нэгдсэн эрсдэлийг тодорхой хэмжээнд бууруулж байна. Энэ нь урьдчилан сэргийлэх менежмент, газар ашиглалтын зохистой бодлого, анхан шатны бэлэн байдлыг сайжруулах замаар эрсдэлийг бууруулах боломжтойг харуулж байна.

Дархан-Уул аймагт нэгдсэн эрсдэлийн индекс  $R_j^{H3} = 0.01$  буюу “бага хэмжээний аюултай түвшин”-д хамаарч байгаа нь гал түймрийн тоо болон өртсөн талбай бараг байхгүй, эдийн засгийн хохирол маш бага байгаатай холбоотой юм. Гэсэн хэдий ч эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс хяналт, мониторингийг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай хэвээр байна.

Ерөнхийд нь дүгнэвэл, нийгэм-эдийн засгийн интеграл үнэлгээний арга нь ой, хээрийн түймрийн эрсдэлийг бүс нутаг, аймгийн түвшинд бодитой тодорхойлох, аюулын түвшинг ангилах, улмаар гамшгийн эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргалтад шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл өгөх давуу талтай болохыг энэхүү судалгаа харууллаа. Зураг 2-т Төвийн бүсийн аймгуудын ой, хээрийн түймрийн эрсдэлийн зураглалыг үзүүлэв.





Зураг 2. Төвийн бүсийн ой, хээрийн түймрийн эрсдэлийн зураглал

### Дүгнэлт

Төвийн бүсийн аймгуудын ой, хээрийн түймрийн эрсдэлийг нийгэм-эдийн засгийн интеграл үнэлгээний аргаар тооцоолсон үр дүнгээс харахад аймгуудын эрсдэлийн түвшин харилцан адилгүй байна. Интеграл эрсдэлийн үзүүлэлтийг гал түймрийн тоо, өртсөн талбай, учирсан хохирлын жинлэсэн коэффициентүүдийг ашиглан нэгтгэн тооцоолсон бөгөөд тооцооны үр дүн 0-ээс 1 хүртэлх интервалд хэлбэлзэж байгаа нь ( $0 \leq R^{НЭ} \leq 1$ ) тухайн бүс нутгийн гал түймрийн аюулын харьцангуй түвшнийг илэрхийлж байна.

Тооцооны үр дүнгээр Сэлэнгэ аймагт нэгдсэн эрсдэлийн утга 1.0 гэсэн үзүүлэлт үзүүлсэн нь уг аймаг ой, хээрийн түймрийн хэт их аюултай түвшинд ( $[0.75-1.0]$ ) хамаарахыг харуулж байна. Энэ нь гал түймрийн давтамж, өртсөн талбай, эдийн засгийн хохирол өндөр байгаатай шууд хамааралтай бөгөөд урьдчилан сэргийлэх болон эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатайг харж болно.

Харин Төв аймагт нэгдсэн эрсдэлийн үзүүлэлт 0.3 байгаа нь дунд түвшний аюултай ( $[0.25-0.5]$ ) ангилалд хамаарах бөгөөд гал түймрийн эрсдэл тодорхой хэмжээнд оршин байгааг илэрхийлж байна. Иймд хяналт-менежментийн арга хэмжээг тогтмол хэрэгжүүлж, эрсдэлийг өсөхөөс сэргийлэх бодлогыг хэрэгжүүлэх чухал ач холбогдолтой юм.

Дархан-Уул аймгийн хувьд нэгдсэн эрсдэлийн утга 0.01-д тооцогдсон нь бага аюултай түвшинд ( $[0-0.25]$ ) хамаарч байгааг харуулж байна. Энэ нь тухайн хугацаанд гал түймрийн нөлөөлөл харьцангуй бага байсан ба цаашид уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөг харгалзан урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд нийгэм-эдийн засгийн интеграл эрсдэлийн үнэлгээний арга нь бүс нутгийн ой, хээрийн түймрийн эрсдэлийг харьцуулан үнэлэх, аюулын түвшинг бодитой тодорхойлох, улмаар эрсдэлийн удирдлагын бодлого, төлөвлөлтөд шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэл өгөх чухал ач холбогдолтой болохыг энэхүү судалгааны үр дүн харуулж байна.

## Санал

Судалгааны үр дүнд тулгуурлан ой, хээрийн түймрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг бүс нутгийн онцлогт нийцүүлэн шат дараатай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түймрийн давтамж, тархалт өндөр бүс нутгуудад урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан менежментийн тогтолцоог бүрдүүлэх нь чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилтын нөлөөллийг харгалзан эрсдэлийн үнэлгээг тогтмол шинэчилж, шинжлэх ухаанд суурилсан тоон мэдээлэл, судалгаанд үндэслэн шийдвэр гаргах механизмыг боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнтэй уялдуулан гал түймрийн эрт илрүүлэлт, хяналтын дэвшилтэт технологи (хиймэл дагуул, алсын зайн тандалт, Газарзүйн мэдээллийн систем)-ийг нэвтрүүлэх нь үр дүнтэй арга хэмжээ болно.

Мөн ой, хээрийн түймрийн гол шалтгаан болох хүний буруутай үйл ажиллагааг бууруулах зорилгоор олон нийгэд чиглэсэн сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулж, хууль эрх зүйн хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгах нь зүйтэй. Түүнчлэн түймэр унтраах хүчин чадлыг нэмэгдүүлэх, техник хэрэгсэл, хүний нөөцийн бэлэн байдлыг сайжруулах замаар хариу арга

хэмжээний үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай байна.

Эцэст нь, ой, хээрийн түймрийн эрсдэлийн удирдлагыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, нэгдсэн зохицуулалттай, урт хугацааны тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

## Ашигласан материал

1. Улсын онцгой комиссын албан даалгавар 2020-2024 оны албан даалгавар,
2. Онцгой байдлын ерөнхий газрын гал түймэртэй тэмцэх газраас 2020-2025 оны ой, хээрийн түймрийн шифрийн мэдээ,
3. Онцгой байдлын ерөнхий газар. (2024). *Гамшигийн эрсдэлийн үнэлгээний тайлан*. Улаанбаатар.
4. Э.Ууганбаяр., “Судалгааны үр дүнд үндэслэн гал түймрийн эрсдэлийг бууруулах нь” 2024 он
5. Гамшиг судлалын үндэсний хүрээлэн., Судалгааны ажлын эмхтгэл. 2021 он
6. ГСХ., “Хээрийн түймрийн эрт илрүүлэхэд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх зарим асуудал” сурах бичиг,
7. Б.Энхтүвшин “Гамшиг, гал түймрийн аюулын үзүүлэлтийг тогтоох арга зүйг”, 2023 он.





## ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

### LEGAL STATUS OF THE STATE DISASTER CONTROL INSPECTOR

#### Д.Жамбалдорж

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

#### D. Jambaldorj

Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, captain

\*хариуцлагатай зохиогч: [davaanyam.jambaldorj@gmail.com](mailto:davaanyam.jambaldorj@gmail.com)

**Хураангуй:** Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь улс орны аюулгүй байдал, иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах чухал үүрэгтэй бөгөөд уг салбарын төрийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэгч гол субъект нь гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч юм. Гэсэн хэдий ч практикт байцаагчийн эрх, үүрэг, хариуцлага, хэрэгжүүлэх арга хэмжээний эрх зүйн зохицуулалт тодорхой бус, зарим талаар давхардсан болон хэрэгжилтийн хүндрэлтэй асуудлууд ажиглагддаг. Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг шинжлэх, практикт тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, цаашид боловсронгуй болгох боломж, чиглэлийг тодорхойлоход оршино. Судалгаанд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, тоон судалгаа зэргийг харьцуулсан судалгааны аргуудыг ашиглав. Судалгааны үр дүнд олон улсын туршлага (Япон, БНСАУ, АНУ)-аас харахад байцаагчийн эрх хэмжээ тодорхой, хариуцлагын тогтолцоо нарийвчилсан, хяналт шалгалтын механизм уялдаа холбоотой байх нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг байна. Иймд хууль эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, уялдаа холбоотой болгох, практикт хэрэгжих боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулав. Энэхүү судалгааны ажил нь гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн үйл ажиллагааг эрх зүйн хувьд боловсронгуй болгоход тодорхой хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

**Abstract:** Disaster prevention activities play an important role in protecting the security of the country and the lives and property of citizens, and the main subject of state supervision and regulation in this sector is the State Inspectorate for Disaster Prevention. However, in practice, the legal regulation of the rights, duties, responsibilities, and implementation measures of the inspector is unclear, and there are some overlapping and difficult implementation issues. The purpose of this study is to analyze the current status of the legal regulation of the State Inspectorate for Disaster Prevention in Mongolia, identify practical problems, and identify opportunities and directions for further improvement. The study used research methods that compared relevant Mongolian legislation and quantitative research. The results of the study show that, based on international experience (Japan, the Mongolian Academy of Sciences, the United States), the scope of the inspector's rights, the detailed responsibility system, and the coherence of the inspection mechanism increase the effectiveness of disaster prevention activities. Therefore, suggestions and recommendations were

developed to make legal regulations more clear and coherent, and to increase the possibility of practical implementation. This research work is significant in contributing to the legal improvement of the activities of the State Inspectorate for Disaster Protection.

**Түлхүүр үгс:** Гамшгаас хамгаалах, улсын хяналтын байцаагч, эрх зүйн байдал, хяналт шалгалт, аюулгүй байдал

**Keywords:** Disaster prevention, state inspection inspector, legal status, inspection, safety

### Удиртгал

Орчин үеийн нийгэмд байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, эрсдэл нэмэгдэж байгаа нь улс орнуудын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдалд томоохон сорилт учруулж байна. Ийм нөхцөлд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй арга хэмжээ авах үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах нь төрийн бодлогын чухал чиглэл болдог. Энэхүү бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн хяналт, шалгалтын тогтолцоо, түүний дотор гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн үйл ажиллагаа онцгой үүрэг гүйцэтгэдэг.

Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм журам, стандартын хэрэгжилтийг хангах, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх зэрэг чухал чиг үүргийг хэрэгжүүлдэг. Гэсэн хэдий ч практик хэрэгжилтийн явцад байцаагчийн эрх хэмжээ, хяналт шалгалт явуулах журам, байгууллага хоорондын уялдаа холбоо, хариуцлагын тогтолцоотой холбоотой зарим эрх зүйн зохицуулалт тодорхой бус, давхардсан, хэрэгжилт хангалтгүй байх зэрэг асуудлууд

ажиглагдаж байна (Монгол Улсын Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, 2025). Иймээс гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалтыг судлан шинжилж, өнөөгийн хэрэгжилтийн байдал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, түүнийг боловсронгуй болгох боломж, арга замыг тодорхойлох нь онолын болон практик ач холбогдолтой юм.

### Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны ойлголт

Гамшиг нь байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэн гарч болох бөгөөд хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засагт их хэмжээний хохирол учруулах аюултай үзэгдэл юм. Иймд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгийн үед хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үйл ажиллагаа нь аливаа улсын төрийн бодлогын чухал чиглэлд тооцогддог (Б.Ганболд, 2025). Монгол Улсад гамшгаас хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг Гамшгаас хамгаалах тухай хуульд тодорхойлсон байдаг. Тус хуульд гамшгаас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, сэргээн босгох үйл ажиллагааг төр, орон нутаг, байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоотой хэрэгжүүлэхээр





зохицуулсан (Гамшигаас хамгаалах тухай хууль, 2024). Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны гол зорилго нь гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед хүний амь нас, эд хөрөнгө, байгаль орчинд учрах хохирлыг багасгах, нийгмийн хэвийн үйл ажиллагааг богино хугацаанд сэргээхэд оршино. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын хяналт шалгалтын үйл ажиллагаа онцгой ач холбогдолтой юм.

### Улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалт

Улсын хяналтын байцаагч нь төрөөс хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулах эрх бүхий төрийн албан тушаалтан юм. Улсын хяналтын байцаагчийн эрх зүйн үндэс нь Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан бөгөөд тэдгээрийн эрх, үүрэг, хариуцлага, үйл ажиллагааны зарчмыг тодорхой зохицуулсан байдаг.

Монгол Улсад улсын хяналтын байцаагчийн эрх зүйн үндсэн зохицуулалтыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд тусгасан байдаг. Тус хуульд төрийн хяналт шалгалтын зорилго нь хууль тогтоомж, стандарт, техникийн шаардлагын хэрэгжилтийг хангах, иргэдийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах явдал гэж тодорхойлсон (Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, 2026). Улсын хяналтын байцаагч нь хяналт шалгалт хийхдээ төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тэдний шийдвэр нь хууль зүйн хүчинтэй байдаг. Иймээс улсын байцаагч нь хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Улсын хяналтын байцаагчийн эрх

Улсын хяналтын байцаагч нь хяналт шалгалтын явцад дараах үндсэн эрхийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх шаардлагатай баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах
- Хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, зөрчил арилгуулах талаар албан шаардлага тавих, акт, дүгнэлт гаргах, холбогдох этгээдэд хариуцлага тооцуулах санал гаргах
- Зөрчил илэрсэн тохиолдолд тухайн зөрчилд холбогдох хариуцлагыг Зөрчлийн тухай хуулийн дагуу ногдуулах үндэслэл бүрддэг.

### Улсын хяналтын байцаагчийн үүрэг

Улсын хяналтын байцаагч нь эрхээ хэрэгжүүлэхийн зэрэгцээ тодорхой үүргийг хүлээдэг. Тухайлбал:

Хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах, хяналт шалгалтыг шударга, ил тод явуулах  
Иргэн, байгууллагын хууль ёсны эрх ашгийг хүндэтгэх хяналт шалгалтын явцад олж мэдсэн нууц мэдээллийг задруулахгүй байх илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөмж, шаардлага өгөх зэрэг юм. Эдгээр үүргийг биелүүлэх нь төрийн хяналтын байгууллагын үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

### Улсын хяналтын байцаагчийн үйл ажиллагааны онцлог

Улсын хяналтын байцаагчийн үйл ажиллагаа нь нийгмийн аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд чухал үүрэгтэй. Ялангуяа гамшгаас хамгаалах салбарт улсын хяналтын байцаагч нь байгууллага, аж ахуйн

нэгжийн гамшгийн бэлэн байдлыг шалгах, аюулгүй ажиллагааг хангах, эрсдэлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалт нь тодорхой, уялдаа холбоотой, практикт хэрэгжих боломжтой байх шаардлагатай бөгөөд энэ нь төрийн хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлэх үндэс болдог. Тухайлбал, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч нь дараах эрх, чиг үүргийг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Байгууллага, аж ахуйн нэгжид гамшгаас хамгаалах төлөвлөгөө байгаа эсэхийг шалгах
- Галын аюулгүй байдал, гамшгийн бэлэн байдлыг хянах
- Зөрчил илэрсэн тохиолдолд шаардлага хүргүүлэх
- Зөрчил арилгуулах хугацаатай үүрэг даалгавар өгөх
- Хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хариуцлага тооцуулах

Жишээлбэл, үйлдвэр, худалдааны төв, сургууль, эмнэлэг зэрэг олон хүн төвлөрдөг газруудад гамшгаас хамгаалах төлөвлөгөө, галын аюулгүй байдлын шаардлага хангагдсан эсэхийг тогтмол шалгадаг. Хэрэв галын дохиолол ажиллахгүй, аврах гарц хаалттай зэрэг зөрчил илэрсэн улсын хяналтын байцаагч тухайн байгууллагад шаардлага хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авдаг. Мөн зөрчил ноцтой тохиолдолд холбогдох этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль ногдуулах, үйл ажиллагааг түр зогсоох зэрэг арга хэмжээ авах боломжтой байдаг (Зөрчлийн тухай хууль, 2015).

### Бусад улс орнуудын туршлага

Гамшгаас хамгаалах, хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалт нь олон улсад өөр өөр хэлбэрээр хөгжиж,

амжилттай хэрэгжиж байна. Судалгааны үр дүн, олон улсын туршлагаас харахад эрх зүйн зохицуулалт нь тодорхой, байцаагчийн эрх хэмжээ, хариуцлагын тогтолцоо нь тодорхой байх нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг байна.

**Япон улсын туршлага:** Япон нь байгалийн гамшиг, ялангуяа газар хөдлөлт, цунами, үерийн эрсдэл ихтэй орон юм. Тус улсын “Disaster Countermeasures Basic Act” болон холбогдох дүрэм журамд гамшгаас хамгаалах улсын байцаагчийн эрх үүрэг тодорхой заагдсан байдаг. Байцаагч нь гамшгийн эрсдэлийг үнэлж, байгууллага, орон нутгийн бэлэн байдлыг хянах эрхтэй. Илэрсэн зөрчил, аюулыг арилгуулах талаар шуурхай зөвлөмж өгөх эрхтэй. Байцаагчийн шийдвэрийг биелүүлэх нь хууль ёсны хүчинтэй. Японы туршлагаас харахад байцаагчийн эрх хэмжээ, хариуцлагын тогтолцоо тодорхой, практикт хэрэгжихүйц байх нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлдэг.

**Өмнөд Солонгос улсын туршлага:** Өмнөд Солонгос-ын гамшгаас хамгаалах тогтолцооны үндэс нь “Disaster and Safety Management Act” юм. Уул, усны үер, гал түймрийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналт шалгалтыг мэргэжлийн албан хаагчид явуулдаг. Байцаагч нь байгууллага, аж ахуйн нэгжийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хянах. Хяналт шалгалтын акт гаргаж, хэрэгжилтийг албан ёсоор шаардах эрхтэй. Байцаагчийн шийдвэрийг биелүүлэхгүй тохиолдолд торгуулийн арга хэмжээ авах боломжтой.

Өмнөд Солонгосын туршлагаас харахад, эрх зүйн зохицуулалт





тодорхой, байгууллага болон байцаагчийн хариуцлагын тогтолцоо нь сайн ажиллаж байж гамшгаас хамгаалах үйл ажиллагаа үр дүнтэй болохыг харуулж байна.

**АНУ-ын туршлага:** АНУ-ын гамшгаас хамгаалах тогтолцооны үндэс нь Federal Emergency Management Agency (FEMA) ба National Incident Management System (NIMS) юм. Гамшгаас хамгаалах хяналтын байцаагчийн үүрэг нь федерал, мужийн түвшинд тодорхойлогддог. Байцаагч нь

гамшгийн эрсдэлийг үнэлж, байгууллагын бэлэн байдлыг хянах, шаардлага тавих эрхтэй. Олон байгууллагын уялдаа холбоог хангасан зохицуулалттай. Хууль зөрчсөн тохиолдолд хууль ёсны арга хэмжээ авах механизмтай.

АНУ-ын туршлагаас харахад олон байгууллагын оролцоотой гамшгаас хамгаалах тогтолцоонд байцаагчийн эрх үүрэг, хариуцлагын тогтолцоо тодорхой байх нь гамшгийн эрсдэлийг бууруулахад чухал нөлөө үзүүлдэг.

Улс	Эрх зүйн үндэс	Байцаагчийн эрх хэмжээ	Хариуцлагын тогтолцоо	Онцлог /Туршлага/
Монгол	Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль	Хяналт шалгалт явуулах, зөрчил арилгуулах, шаардлага хүргүүлэх эрхтэй	Зарим тохиолдолд тодорхой бус, давхардах асуудалтай	Эрх зүйн зохицуулалт тодорхой бус, практикт хэрэгжилт сул
Япон	Disaster Countermeasures Basic Act	Байцаагч нь байгууллага, орон нутгийн бэлэн байдлыг хянах, зөвлөмж өгөх эрхтэй	Тодорхой, хуульд заасан арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх	Байцаагчийн эрх хэмжээ тодорхой, хариуцлагын механизм сайн
БНСАУ	Disaster and Safety Management Act	Байгууллагын төлөвлөгөө, бэлэн байдлыг шалгах эрхтэй	Хуульд заасан торгуулийн арга хэмжээ авах боломжтой	Эрх хэмжээ тодорхой, хяналт шалгалтын журам нарийвчилсан
АНУ	National Incident Management System (NIMS), FEMA	Байгууллагын бэлэн байдлыг үнэлж, шаардлага тавих	Тодорхой, хууль ёсны арга хэмжээ авах механизмтай	Олон түвшний хяналт шалгалттай, практикт хэрэгжихүйц

**Хүснэгт №1. Харьцуулалт (Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар)**

Монгол Улсын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалт бусад улстай харьцуулахад тодорхой бус, практикт хэрэгжилт хангалтгүй байгааг судалгааны болон олон улсын туршлага харуулж байна.

Байцаагчийн эрх хэмжээ тодорхой, хуульд заасан байх нь хяналт шалгалтын үр нөлөөг нэмэгдүүлдэг. Бусад улс орнуудын туршлагад эрх хэмжээ болон хариуцлагын механизм сайн хөгжсөн

нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй болгодог. Монгол Улсад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, байцаагчийн эрх, хариуцлагын тогтолцоог сайжруулах шаардлагатай байна.

**Үр дүн, хэлэлцүүлэг**

Энэхүү судалгааны зорилго нь гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг тодорхойлох, практикт тулгарч буй асуудлуудыг


илрүүлэх, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлоход оршино. Судалгааг асуулгын аргаар явуулсан бөгөөд төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл болон гамшгаас хамгаалах чиглэлээр ажилладаг албан хаагчдаас

мэдээлэл цуглуулсан. Судалгаанд нийт 30 албан хаагч оролцсон болно.

“Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн хэмжээ хангалттай гэж та үзэж байна уу?” гэсэн асуулгад оролцогчдын хариулт дараах байдалтай гарсан.



Үндэсний Цэвэрлэгч  
 Судалгааны  
 Хөгжлийн  
 Төв




■ хангалттай ■ тодорхой бус ■ хангалтгүй ■

**Зураг №1. Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн хэмжээ**

Судалгаанд оролцогчдын 32% хангалттай, 48% нь тодорхой бус, 20% хангалтгүй хэмээн хариулжээ. Энэхүү үр дүнгээс харахад оролцогчдын ихэнх нь улсын хяналтын байцаагчийн эрхийг тодорхой бус гэж үзсэн байна. Энэ нь эрх зүйн зохицуулалтыг илүү

тодорхой болгох шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд оролцогчдоос “Гамшгаас хамгаалах хяналт шалгалтын үйл ажиллагаа хэр үр дүнтэй гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултыг тавьсан.



■ үр дүнтэй ■ дунд зэрэг ■ хангалтгүй ■

**Зураг №2. Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөө**

Судалгаанд оролцогчдын 30% нь “үр дүнтэй” гэж хариулсан, 46% нь “дунд зэрэг” гэж хариулсан, 24% нь “хангалтгүй” гэж хариулжээ

Энэ нь хяналт шалгалтын үйл ажиллагаа тодорхой хэмжээнд


хэрэгжиж байгаа боловч үр нөлөөг сайжруулах шаардлагатай байгааг харуулж байна. Мөн судалгаанд оролцогчид хяналт шалгалт явуулах явцад зарим асуудалтай тулгардаг гэж тэмдэглэсэн. Жишээлбэл, зарим



ᠬᠤᠠᠨᠭᠠᠯᠠᠬᠤ ᠬᠢᠭᠤᠰᠢᠭᠠᠳᠤ ᠬᠢᠭᠤᠰᠢᠭᠠᠳᠤ

байгууллага гамшгаас хамгаалах төлөвлөгөөг бүрэн бэлдээгүй, барилга байгууламжийн аюулгүй байдлын стандарт хангагдаагүй тохиолдол гардаг нь хяналт шалгалтын үр нөлөөг бууруулдаг байна.

“Гамшгаас хамгаалах хяналт шалгалтын үйл ажиллагаа хэр үр дүнтэй гэж та үзэж байна вэ?” гэсэн асуулгад:




■ үр дүнтэй ■ дунд зэрэг ■ хангалтгүй ■

Зураг №3.Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөө

Судалгаанд оролцогчдын 28% үр дүнтэй, 50% дунд зэрэг, 22% хангалтгүй хэмээн хариулжээ. Үүнээс харахад ихэнх оролцогчид хяналт шалгалтын үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хэрэгждэг боловч илүү

сайжруулах шаардлагатай гэж үзсэн байна.

Судалгаанд оролцогчдоос байгууллагууд гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хэр хангаж байгааг асуухад дараах үр дүн гарсан.




■ үр дүнтэй ■ дунд зэрэг ■ хангалтгүй ■

Зураг №4.Байгууллагууд гамшгаас хамгаалах бэлэн байдлаа хэр хангаж байна вэ?

Судалгаанд оролцогчдын 25% сайн, 45% дунд, 30% хангалтгүй хэмээн үзжээ.

Энэ нь байгууллагуудын гамшгаас хамгаалах бэлэн байдал харилцан адилгүй байгааг харуулж байна.

“Гамшгаас хамгаалах хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалт ойлгомжтой гэж та үзэж байна уу?” гэсэн асуулгад:



■ ойлгомжтой ■ зарим талаараа ■ ойлгомжгүй ■

### Зураг №5. Эрх зүйн зохицуулалтын ойлгомжтой байдал

Судалгаанд оролцогчдын 30% ойлгомжтой, 55% зарим талаар ойлгомжгүй, 15% ойлгомжгүй гэсэн үр дүн гарчээ. Энэхүү үр дүн нь эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, ойлгомжтой болгох шаардлагатайг харуулж байна.

#### Дүгнэлт

Энэхүү судалгаанаас харахад Монгол Улсын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалт нь практикт хэрэгжиж байгаа ч тодорхойгүй, зарим талаараа хангалтгүй байгаа нь ажиглагдлаа. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь 48–55% байцаагчийн эрх хэмжээ болон хяналт шалгалтын эрх зүйн зохицуулалтыг тодорхой бус гэж үзсэн нь эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Мөн хяналт шалгалтын үйл ажиллагааны үр дүнгийн талаарх үнэлгээ нь харилцан адилгүй бөгөөд судалгаанд оролцогчдын ихэнх нь 46–50% “дунд зэрэг” гэж үнэлсэн нь хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах шаардлагатайг илтгэж байна. Байгууллагуудын гамшгаас хамгаалах бэлэн байдлын хувьд ч судалгааны үр дүн харилцан адилгүй 25% сайн, 30% хангалтгүй байгаа нь практикт хэрэгжилтэд дутагдал байгааг илэрхийлж байна. Олон улсын туршлагаас харахад (Япон, Өмнөд Солонгос, АНУ), байцаагчийн эрх

хэмжээ тодорхой, хариуцлагын тогтолцоо нарийвчилсан, хяналт шалгалт үр дүнтэй ажиллаж байгаа нь гамшгаас хамгаалах үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлдэг байна. Иймээс Монгол Улсад эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, байцаагчийн эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог тодорхой болгосноор хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх боломжтой юм. Эцэст нь дүгнэвэл, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь:

- Эрх хэмжээ, үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, хуульд суурилсан байдлыг хангах;
- Хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх;
- Байгууллагуудын гамшгаас хамгаалах бэлэн байдлыг сайжруулах;
- Төрийн хяналт шалгалт, нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Эдгээр алхмуудыг хэрэгжүүлснээр Монгол Улсын гамшгаас хамгаалах тогтолцоо илүү үр дүнтэй, зохион байгуулалттай, орчин үеийн эрсдэлийн менежментэд нийцсэн систем болох боломжтой.

#### Ашигласан материал

[1] Монгол Улсын Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр, 2025



[2] Ганболд. Г., (2025) Гамшиг судлалын өнөөгийн байдлын судалгаа

[3] Гамшгаас хамгаалах улсын хяналтын дүрэм, 2026

[4] Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал (2023). Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм. Улаанбаатар хот

[5] Монгол Улсын Их Хурал. (2017). Онцгой байдлын тухай хууль. Улаанбаатар: Засгийн газрын хэвлэл

[6] Darkwah, N. G. (2014). Exploring the effect of personality traits on employees.

[7] ОБЕГ. [www.nema.gov.mn](http://www.nema.gov.mn).

[8] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)

## ЗООНОЗЫН ХАЛДВАРТ ӨВЧИН ТАРХСАН ҮЕИЙН АЛБАДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ

### INTERAGENCY COORDINATION CHALLENGES IN RESPONSE TO ZONOTIC INFECTIOUS DISEASE OUTBREAKS

**Д.Санжхүү**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, ахмад

**D. Sanjkhuu**

Captain, Master's Student, School of Emergency Management, University of Internal Affairs

Хариуцлагатай зохиогч: sanjhvvd@gmail.com

**Хураангуй:** Зоонозын өвчин нь хүн, амьтан, хүрээлэн буй орчны хооронд дамжин халдварладаг онцлогтой бөгөөд энэ нь нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд аюул учруулж улмаар эдийн засгийн тогтвортой хөгжилд эрсдэл учруулдаг. Иймээс зоонозын халдварт өвчний тархалт, байгалийн голомтыг судлах, халдвар дамжих замыг тодорхойлох, эрсдэлийг үнэлэн шуурхай хариу арга хэмжээ авч ажиллах нь чухал юм. Зоонозын халдварын тохиолдлын үед (эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, онцгой байдал, байгаль орчин, хил гааль, нутгийн захиргаа) оролцогч байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа, мэдээлэл солилцоо, зохион байгуулалтын уялдаа нь шуурхай хариу арга хэмжээний үр дүнг сайжруулахад ихээхэн ач холбогдолтой.

Энэхүү судалгаагаар зоонозын өвчний дэгдэлтийн үед оролцогч байгууллагуудын хамтын ажиллагааны өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудлыг судалж, дүгнэлт гаргалаа. Судалгааны үр дүнд байгууллагуудын мэдээлэл солилцоо, эрсдэлийн үнэлгээ, хамтарсан сургалт, бэлтгэл ажиллагаа хангалтгүй байгааг тогтоов. Цаашид зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх менежментийг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн систем бий болгох, орон нутгийн түвшинд олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, орчин үеийн технологи ашиглах шаардлагатай байна.

**Abstract:** Zoonotic infectious diseases are characterized by transmission between humans, animals, and the environment, posing significant risks to public health, food safety, and ultimately economic stability. Therefore, studying the spread of zoonotic diseases, identifying natural foci, determining transmission pathways, and conducting risk assessments with prompt response measures are of critical importance. In the event of zoonotic outbreaks, the coordinated collaboration, information exchange, and organizational alignment among relevant agencies (health, veterinary, emergency management, environmental protection, border and customs authorities) play a vital role in enhancing the effectiveness of rapid response actions. This study examined the current state of interagency cooperation during zoonotic disease outbreaks and identified existing challenges. The findings revealed insufficient information sharing, inadequate risk assessment, limited joint training, and poor preparedness among institutions. Moving forward, it is essential to improve zoonotic disease prevention and management,



Урьдчилсан судалгаа  
2026





establish an integrated information system, expand multi-sectoral collaboration at the local level, and adopt modern technologies to strengthen outbreak preparedness and response.

**Түлхүүр үгс:** Зооноз, харилцан ажиллагаа, нэг эрүүл мэнд, эрсдэлийн удирдлага, хамтын ажиллагаа.

**Keywords:** Zoonosis, Coordination, One Health, Risk Management, Collaboration

### Удиртгал

Монгол Улсын эдийн засагт мал аж ахуй нь тэргүүлэх салбарын нэг бөгөөд хөдөө аж ахуй ДНБ-ийн 10.8%-ийг бүрдүүлдгээс мал аж ахуй нийт үйлдвэрлэлийн 84.2%-ийг эзэлж, мах, сүү зэрэг бүтээгдэхүүн дангаараа ДНБ-ийн 7%-ийг бүрдүүлж байгаа нь хүн амын амьжиргаа болон эдийн засгийн тогтвортой байдалд стратегийн ач холбогдолтойг харуулж байна. (хороо., 2024) Гэвч мал амьтнаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчин нь нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдалд аюул учруулж, улмаар эдийн засгийн хохирол үүсэх эрсдэлтэй болж байна. Сүүлийн жилүүдэд хил дамнасан малын хөдөлгөөн болон бусад хүчин зүйлсийн улмаас зоонозын халдварт өвчний дэгдэлтийн тоо, давтамж нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал, Улсын хэмжээнд зоонозын 9 төрлийн өвчин 21 аймаг, Улаанбаатар хотод бүртгэгдэж, нийт 978 дуудлагад хариу арга хэмжээг зохион байгуулсан (төв, 2025) нь эдгээр өвчний байнгын эрсдэлийг харуулж байна. Ийм нөхцөлд оролцогч эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, онцгой байдал, байгаль орчин, хил гааль байгууллагуудын зохион байгуулалтын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, хамтын ажиллагаа онцгой ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь: зоонозын халдварт өвчин тархсан үед төрийн болон орон нутгийн

байгууллагуудын харилцан ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, хамтын ажиллагааг сайжруулах үр дүнтэй арга замуудыг санал болгоход оршино. Мөн “Нэг эрүүл мэнд” (One Health) хандлагыг үндэсний нөхцөлд хэрэгжүүлэх боломж, орчин үеийн технологи болон мэдээллийн системийг ашиглах арга зүйг судлан, цаашдын бодлого боловсруулахад хувь нэмэр оруулах зорилготой.

### Зоонозын халдварт өвчний талаар авч үзэх нь

Зоонозын өвчин гэдэг нь амьтнаас хүнд, эсвэл хүнээс амьтанд халдвар дамждаг өвчнийг хэлнэ. “Зооноз” (англиар zoonosis) гэдэг үг нь грек хэлний zoo “амьтан”, nosos “өвчин” гэсэн үгнээс гаралтай. ДЭМБ-аас халдварт өвчнийг шавж болоод бусад төрлийн дамжуулагчид амьсгалдаг агаар, уудаг ус, гишгэж буй газар шороогоор дамжин эсвэл шууд ба шууд бус хавьтлаар хүн ба амьтнаас хүний бие махбодод орж үүсгэдэг өвчнийг халдварт өвчин гэж тодорхойлсон байдаг. Орчин цагийн мал эмнэлгийн шинжлэх ухаанд мал, амьтны дунд халдварладаг 300 гаруй өвчин байдгаас 160 орчим нь мал, амьтнаас хүнд халдварладаг зоонозын халдварт өвчин юм. (төв, ..., 2022) Зоонозын халдварт өвчнийг үүсгэгч биетнүүд нь вирус, бактери, паразит, мөөгөнцөр зэрэг олон

төрөлд багтдаг бөгөөд тэдгээр нь хүн, мал, амьтны эрүүл мэндэд ноцтой аюул учруулдаг.

### Зоонозын өвчний үүсгэгчид

Үүсгэгч	Жишээ өвчин
<b>Бактери</b>	Бруцеллэз, Сибирийн хижиг, Сальмонеллэз, Туляреми
<b>Вирус</b>	Галзуу, Шувууны томуу, Эбола, SARS-CoV-2
<b>Паразит</b>	Токсоплазмоз, Трихинеллэз, Эхинококкоз
<b>Мөөгөнцөр</b>	Дерматофитоз (арьсны мөөгөнцөр)

Хүснэгт №1. Зоонозын халдварт өвчнийг үүсгэгч биетнүүд  
(Эх сурвалж: PMC – Zoonoses Review)

#### Халдвар дамжих зам

Зоонозын халдварт өвчин дараах замаар дамждаг.

**Шууд харьцах** – амьтны шүлс, цус, ялгадастай хүрэх.

**Шимэгч хортон шавжаар** – шумуул, хачиг, бөөс.

**Хоол хүнсээр** – түүхий мах, сүү, өндөг.

**Агаар дуслын замаар** – амьтны найтаалт, ханиалт

**Хөрс, орчны бохирдлоор** – бохирдсон хөрс, эд зүйлсээр дамждаг.

Зоонозын халдварт өвчин нь дэлхийн өөр өөр бүс нутгуудын уур амьсгалын онцлог, тэдгээрийн байгаль дээр тархсан зэрлэг амьтдын төрөл зүйлийн олон янз байдлаас хамаарч өвчнийг тээгч, дамжуулагч нь ялгаатай байдаг. Жишээлбэл, тарваган тахал өвчнийг гол агуулагч нь манай оронд тарвага, зурам, оготно болон эдгээр мэргэгчдийн арьс, үсэнд шимэгчилдэг бүүрэг, бөөс байдаг бол халуун оронд дамжуулагч нь харх байх жишээтэй. Мөн хумхаа, зика вирус, шар чичрэг зэрэг өвчнүүдийг гол дамжуулагч Aedes, Anopheles, Culex, Culiseta төрлийн шумуул нь Африк тивд тархалттай байдаг бол манай оронд тухайн шумуулын тархалтгүй байх ба манай улсын хилээр зөвхөн уг тивд зорчиж халдвар авсан хүний биеэр зөөвөрлөгдөн орж ирэх боломжтой. Монгол Улсын эдийн засаг мал аж

ахуйд тулгуурласан онцлогтой тул бруцеллэз, боом, галзуу, шүлхий, хачгаар дамжих халдвар өвчнүүд тохиолдох өндөр эрсдэлтэй байдаг. Иймээс зоонозын өвчний хяналт, урьдчилан сэргийлэлт нь зөвхөн нэг байгууллагын хүрээнд бус, харин олон салбарын хамтын ажиллагаа, уялдаа холбоог шаардсан нийгмийн чухал асуудал юм.

#### Зоонозын халдварт өвчний онцлог ба эрсдэл

Зоонозын халдварт өвчин нь амьтан ба хүний хооронд халдвар дамжих замаар үүсдэг бөгөөд тухайн халдварын эх үүсвэр нь ихэвчлэн гэрийн болон зэрлэг амьтад байдаг. Ийм төрлийн халдваруудын дэгдэлт нь зөвхөн эрүүл мэндийн асуудал биш, харин мал аж ахуй, хүнсний аюулгүй байдал, байгаль орчин, эдийн засгийн аюулгүй байдалтай шууд холбоотой цогц нийгмийн асуудал юм.

#### Эрсдэл:

*Эрүүл мэндийн эрсдэл:* Хүн амын өвчлөл, нас баралт үүсгэх боломжтой (жишээ нь галзуу, боом, Эбола).

*Эдийн засгийн эрсдэл:* Малын өвчлөл, хорогдол, хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх замаар эрсдэл учирна.

*Нийгмийн эрсдэл:* Хүн амын хөдөлмөрийн чадвар буурах, эрүүл мэндийн тогтолцоонд дарамт учруулах.





**Хүнсний эрсдэл:** Малын гаралтай бүтээгдэхүүнээр дамжин хүнсний сүлжээнд халдвар нэвтрэх, хүнсний аюулгүй байдал алдагдах, улмаар хүн амын эрүүл мэндэд шууд эрсдэл учруулах.

#### Албадын харилцан ажиллагаа

Албадын харилцан ажиллагаа нь төрийн байгууллагууд (эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, онцгой байдал, байгаль орчин, хил гааль, нутгийн захиргаа) хоорондын зохион байгуулалтын уялдаа, мэдээлэл солилцоо, нөөц хуваарилалт, хамтын шийдвэр гаргалт зэргийг хамардаг. Халдварт өвчин тархах үед албадын хамтын ажиллагаа нь дараах шатлалтайгаар илэрдэг.

**Мэдээлэл солилцох шат** – өвчний сэжиг илэрсэн тухай мэдээг богино хугацаанд холбогдох байгууллагууд харилцан дамжуулах.

**Хамтарсан үнэлгээний шат** – өвчний тархалт судлал, лабораторийн шинжилгээ, мал эмнэлгийн хяналт, орчны үнэлгээг нэгтгэн дүгнэх.

**Хариу арга хэмжээний шат** – халдварын голомтыг устгах, хорио цээр тогтоох, иргэдэд мэдээлэл хүргэх, вакцинжуулалт болон ариутгалын ажлыг зохион байгуулах.

**Дүгнэлт, сургамж авах шат** – хамтын ажиллагааны үр дүнг үнэлж, цаашдын төлөвлөгөөнд тусгах. Энэ үйл явц нь “Нэг Эрүүл Мэндийн (One Health)” зарчимтай нягт уялддаг. Энэ зарчим нь хүн, мал, байгаль орчны эрүүл мэндийн уялдаа холбоог хүлээн зөвшөөрч, салбар хоорондын хамтын ажиллагааг үндэс болгодог.

Зоонозын халдварт өвчин тархах үед дараах төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай байдаг.

Алба, байгууллага	Үндсэн үүрэг
Эрүүл мэндийн байгууллага	Хүн амын дунд өвчлөлийг илрүүлэх, оношлох, эмчлэх, мэдээлэл цуглуулах, лабораторийн баталгаажуулалт хийх.
Мал эмнэлгийн байгууллага	Мал амьтдын өвчлөл, үхэлд тандалт судалгаа хийх, вакцинжуулалт зохион байгуулах, халдварын голомтыг устгах.
Онцгой байдлын байгууллага	Халдварт өвчинтэй холбоотой онцгой нөхцөл байдлын үед нүүлгэн шилжүүлэлт, хорио цээрийн бүс тогтоох, дэглэм сахиулах.
Цагдаагийн байгууллага	Хорио цээрийн дэглэм мөрдүүлэх, иргэдийн аюулгүй байдлыг хангах, хуулийн хэрэгжилтийг хянах.
Орон нутгийн захиргаа	Орон нутгийн түвшинд хариу арга хэмжээг зохион байгуулах, иргэдэд мэдээлэл түгээх, албадын уялдаа холбоог хангах.
Байгаль орчны байгууллага	Зэрлэг амьтдын дунд өвчний тандалт хийх, байгалийн голомтыг судлах, байгальд үзүүлэх нөлөөллийг үнэлэх.

#### Хүснэгт №2. Албадын харилцан үүрэг хуваарилалт

Эдгээр байгууллагуудын харилцан ажиллагаа нь Нэг Эрүүл Мэндийн (One Health) зарчмыг баримтлах ёстой. Учир нь энэ зарчим нь “хүн, мал, байгаль орчны эрүүл мэнд хоорондоо салшгүй уялдаатай” гэсэн ойлголт дээр тулгуурладаг бөгөөд зоонозын өвчний эсрэг хариу арга хэмжээг нэгдсэн

удирдлага, мэдээллийн уялдаа, нэгдсэн төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэхийг шаарддаг.

#### Судалгааны хэсэг Зоонозын халдварт өвчин тархсан үеийн албадын харилцан

### ажиллагааны өнөөгийн нөхцөл байдалын судалгаа

Завхан аймгийн онцгой байдлын газар, болон холбогдох байгууллагуудын түвшинд зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үед оролцогч байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоог үнэлэх

зорилгоор социологийн судалгаа авсан. Судалгаанд нийт 60 респондент хамрагдсан бөгөөд эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, онцгой байдлын байгууллага, цагдаагийн байгууллага, орон нутгийн удирдлагын албан хаагчдыг төлөөлж байна.

Хүснэгт №3. Зоонозын халдварт өвчин дэгдсэн үеийн албадын харилцан ажиллагааны тухай судалгаа

Үзүүлэлт	“Маш сайн”	“Дунд”	“Сул”	Дүгнэлт
1. Албадын уялдаа холбоо	25%	50%	25%	Уялдаа холбоо дунд түвшинд
2. Мэдээлэл солилцох хурд	20%	45%	35%	Цаг алдалттай, мэдээллийн систем сул
3. Хамтарсан сургалт, дадлагын оролцоо	15%	40%	45%	Сургалтын хамрагдалт хангалтгүй
4. Нөөц, техник хэрэгслийн хангалт	10%	35%	55%	Нөөцийн дутагдал ихтэй
5. Хорио цээр, хариу арга хэмжээний зохион байгуулалт	30%	50%	20%	Хамтын ажиллагаа боломжийн түвшинд
6. Олон нийтийн мэдээлэл, ухуулгын ажлын чанар	25%	45%	30%	Иргэдийн оролцоо дунд түвшинд
7. Албадын хооронд үүргийн зааг тодорхой байдал	35%	40%	25%	Үүргийн хуваарилалт тодорхой болж байгаа ч сайжруулах шаардлагатай

Зоонозын халдварт өвчин тархсан үед оролцогч албадын хамтын ажиллагаа дунд түвшинд байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

Зураг №1. Албадын харилцан ажиллагааны үнэлгээ (нийт 60 хүн, хувь)

Маш сайн 23%  
Дунд 44%  
Сул 33%

Оролцогчдын 44% нь “дунд түвшний” уялдаа холбоотой гэж үзсэн бөгөөд 33% нь сул гэж дүгнэжээ. Энэ нь орон нутгийн түвшинд мэдээлэл дамжуулах, хамтарсан арга хэмжээ зохион байгуулах үйл явц хангалтгүй байгааг харуулж байна.

Асуудал	Хувь (%)
Нөөц, санхүүжилт дутмаг	60%
Мэдээлэл солилцоо сул	55%
Сургалт, дадлага хангалтгүй	50%





Үүрэг, хариуцлагын давхардал	40%
Иргэдийн мэдээлэл дутмаг	35%

#### Хүснэгт №4. Хамтын ажиллагаанд тулгамдаж буй гол асуудлууд

Судалгаанд оролцогчдын олонх нь (60%) “нөөц, санхүүжилтийн дутагдал” болон “мэдээлэл солилцооны сул тал”-ыг хамгийн гол хүндрэл гэж тодорхойлсон байна.

Үзүүлэлт	Үнэлгээ	Тайлбар
Хамтын ажиллагааны ерөнхий түвшин	65% (дунд)	Үр дүнтэй боловч орон нутгийн хэрэгжилт сул
Мэдээлэл, уялдаа холбоо	58% (дунд)	Цахим мэдээллийн системийг сайжруулах шаардлагатай
Хамтарсан сургалт, дадлага	45% (сул)	Тогтмол зохион байгуулах шаардлагатай
Нөөцийн хангалт	40% (сул)	Техник, хамгаалах хэрэгсэл хомс
Олон нийтийн мэдээлэл	55% (дунд)	Иргэдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгтэй

#### Хүснэгт №5. Судалгааны нэгтгэл

Зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үед оролцогч албадын харилцан ажиллагаа системийн хувьд бүрэлдсэн боловч хэрэгжилтийн түвшин жигд бус байгаа нь нийт гүйцэтгэлд нөлөөлж байна. Мэдээлэл солилцох хурд, нэгдсэн шийдвэр гаргах үйл явц, орон нутгийн чадавх сул байгаа нь хариу арга хэмжээний үр нөлөөг бууруулж, цаг хугацааны алдагдал үүсгэдэг. Нэгтгэсэн дүнгээр албадын хамтын ажиллагаа 60–65 хувь буюу дунд түвшинд үнэлэгдсэн нь цаашид мэдээллийн системийг сайжруулах, сургалт, дадлагыг тогтмолжуулах, нөөцийн хангалтыг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

#### Албадын харилцан ажиллагааны хувилбар

Зоонозын халдварт өвчний дэгдэлт гарсан үед мэдээлэл хоцрох, хариу арга хэмжээ давхцах, нөөцийн зохион байгуулалт сул байх зэрэг хүндрэлүүдийг дээрх социологийн судалгаагаар тогтоолоо. Иймээс дараах чиглэлд анхаарах нь зүйн хэрэг болж байна. Үүнд:

Харилцаа холбооны тогтолцоо сайжруулах – мэдээлэл солилцох цахим систем, шуурхай мэдээ дамжуулах сүлжээг нэгтгэх.

Хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах – албадын мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх.

Нөөц, санхүүжилтийн уялдаа хангах – яаралтай хариу арга хэмжээнд шаардлагатай тоног төхөөрөмж, вакцин, лабораторийн хүчин чадлыг нэгтгэх.


Олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх – иргэдийн мэдээлэл, мэдлэгийг дээшлүүлэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх соёлыг төлөвшүүлэх зэрэг юм.

Зоонозын халдварт өвчин тархсан үед албадын харилцан ажиллагааг сайжруулах нь нийгмийн эрүүл мэндийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд чухал ач холбогдолтой. Хүний, амьтны, орчны эрүүл мэндийн нэгдмэл байдлыг хүлээн зөвшөөрсөн нь онолын үндэс бөгөөд “Нэг эрүүл мэнд” (One Health) энэ хандлагын дагуу байгууллагуудын хамтын ажиллагааг

системтэйгээр хөгжүүлэх нь зоонозын өвчний хяналтын тогтолцоог шинэ шатанд гаргах боломжийг бүрдүүлнэ.



Үндэсний Төрийн Газар  
 Зарлиг  
 2017



Тарваган тахал өвчний тархалтын үеийн харилцан ажиллагаа

Зураг №2.Тарваган тахал өвчинтэй тэмцэх үеийн харилцан ажиллагааны зураг (Хувилбар)

Д/д	Тэмдэглэгээ	Тайлал
1.		Голомтын бүс
2.		Сэжигтэй бүс
3.		Хязгаарлалтын бүс
4.	УБ	Аймаг, нийслэлийн удирдлагын байр
5.	С/ШБ	Сум, дүүргийн шуурхай бүлэг
6.		Хянах байр /Онцгой байдлын албаны/
7.		Автомашин хөдөлгөөн зохицуулах байр
8.		Уулзах байр
9.	РК	Хяналтын цэг



10.		Шалган нэвтрүүлэх байр
11.		Эргүүл машинтай
12.		Эргүүл явганаар
13.		Цар тахал
14.		Нас барсан хүн
15.		Нэрвэгдэгсдийг хүлээн авах байр
16.		Тусгаарлан ажиглах байр
17.		Эрүүл мэндийн байгууллага
18.		Агаараас тандалт, ажиглалт хийх район
19.		Тусгай цэвэрлэгээний машин /ариутгалын/

Хүснэгт №6. Таних тэмдэг

### Дүгнэлт

Монгол Улсад зоонозын халдварт өвчин нь нийгмийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлж буй үндэсний хэмжээний эрсдэлт хүчин зүйл хэвээр байна.

Судалгааны үр дүнгээс харахад зоонозын халдварт өвчин тархах үед холбогдох байгууллагуудын хамтын ажиллагаа онолын хувьд бүрэлдсэн боловч практик хэрэгжилт дунд түвшинд (60–65%) байгаа нь тодорхой болов. Албадын уялдаа холбоо, мэдээлэл солилцоо, нэгдсэн шийдвэр гаргалт, хамтарсан сургалт, нөөцийн хангалт зэрэг үндсэн чиглэлүүдийн хэрэгжилт тэгш бус бөгөөд орон нутгийн түвшинд илүү сул байна.

Судалгаанд оролцогчдын олонх нь нөөцийн хомсдол (60%), мэдээлэл солилцооны сул тал (55%), хамтарсан сургалт, дадлагын дутагдал (50%) зэргийг хамгийн тулгамдсан асуудал хэмээн тодорхойлжээ. Хэдийгээр

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн 2013 оны 404-р тушаал нь албадын харилцан ажиллагааны эрх зүйн болон зохион байгуулалтын суурийг бүрдүүлсэн ч, орчин үеийн “Нэг Эрүүл Мэнд” (One Health) хандлагын дагуу илүү уялдаатай, цахим мэдээлэлд тулгуурласан, хурдан хариу арга хэмжээ авах чадвартай системийг бүрдүүлэх шаардлага бий.

Судалгааны дүнгээс дараах гол дүгнэлтийг гаргаж болно. Зоонозын халдварт өвчний хяналт, хариу арга хэмжээ нь олон байгууллагын уялдаа холбоонд тулгуурлах ёстой бөгөөд одоогийн түвшинд энэ уялдаа дунд зэргийн үр дүнтэй байна.

Мэдээлэл солилцооны тогтолцоо сул, мэдээлэл хоцрох, давхардал үүсэх зэргээс болж хариу арга хэмжээний чанар буурч байна. Сургалт, дадлагын тогтолцоо тогтмол бус, орон нутгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадвар ялгаатай байна. Нөөцийн хомсдол (тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгсэл,

лабораторийн хүчин чадал) нь хариу арга хэмжээг саатуулж байна. Иргэдийн мэдээлэл, оролцоо дунд түвшинд байгаа нь халдварын дэгдэлтийн хяналтад сөргөөр нөлөөлж байна.

Эдгээрээс үзэхэд зоонозын халдварт өвчний дэгдэлтийн үед төрийн байгууллагуудын харилцан ажиллагааг технологийн шинэчлэл, мэдээллийн нэгдсэн систем, “Нэг Эрүүл Мэнд”-ийн зарчимд тулгуурлан хөгжүүлэх нь зүйтэй. Ийм арга хэмжээ нь зөвхөн өвчний хариу арга хэмжээг сайжруулах бус, цаашдын урьдчилан сэргийлэлтийн бодлого, тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чухал нөлөө үзүүлэх юм. Тарваган тахал өвчний тархалтын үед аймгийн албадын харилцан ажиллагааны хувилбарыг боловсруулав.

### Санал

1. Албадын уялдаа холбоог дижитал мэдээллийн системээр холбох.
2. Хамтарсан дадлага, сургалтыг жил бүр орон нутгийн түвшинд тогтмолжуулах.
3. Хүний нөөц, тоног төхөөрөмж, хамгаалах хэрэгслийн бэлэн байдлыг нэмэгдүүлэх.
4. Иргэдийн мэдээлэл, оролцоог нэмэгдүүлэх ухуулга, сурталчилгааг тогтмол явуулах.

### Ашигласан материал

1. Keeley. ( 2009).
2. *Онцгой байдлын газар*. (2025).
3. төв, З. ө. (2022, 04 30). ... Retrieved from <https://nczd.gov.mn/?p=9882>
4. төв, З. ө. (2025). Зоонозын өвчний эрүүл мэндийн үзүүлэлт: 2024 оны тайлан. 3.
5. хороо., Ү. с. (2024). Дотоодын нийт бүтээгдэхүүний 2024 оны эхний хагас жилийн урьдчилсан гүйцэтгэлийн танилцуулга. *ҮСХ*, 8.
6. *Эрүүл мэндийн яам*. (2025 ).





**Keywords:** Commanding officers, trust, mutual trust, organizational culture, team performance, collaboration, management, organizational climate, task performance

### Удиртгал

Орчин үеийн байгууллагын удирдлагын онолд итгэлцэл нь байгууллагын үр ашиг, гүйцэтгэл, тогтвортой хөгжлийн суурь хүчин зүйл хэмээн тодорхойлогддог. Ялангуяа өндөр эрсдэл, шуурхай шийдвэр гаргалт шаардсан байгууллагын хувьд харилцан итгэлцэл нь алба хаагчдын хамтын ажиллагаа, сахилга хариуцлага, шийдвэрийн чанарт шууд нөлөөлдөг стратегийн ач холбогдолтой ойлголт юм. Судлаач Edgar Schein байгууллагын соёлын онолдоо итгэлцэл нь байгууллагын гишүүдийн зан үйл, харилцааны далд үнэт зүйлсийн цөм болохыг онцолсон байдаг. Түүний “Organizational Culture and Leadership” бүтээлд дурдсанаар байгууллагын дотоод уур амьсгал, удирдлагын хэв маяг, багийн нэгдмэл байдал нь итгэлцлийн түвшнээс шууд хамаардаг байна (Schein, 2018). Мөн байгууллагын итгэлцлийн тухай орчин үеийн судалгаанд итгэл нь гүйцэтгэлийн хурд болон хамтын ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлдэг чухал хүчин зүйл болохыг тодорхойлсон. Тухайлбал, Stephen M. R. Covey “The Speed of Trust” бүтээлдээ итгэлцэл өндөр байх үед байгууллагын зардал буурч, шийдвэр гаргалт түргэсэж, багийн ажиллагаа илүү үр дүнтэй болдгийг нотолсон байдаг (Covey, 2016). Энэхүү үзэл баримтлал нь ялангуяа шуурхай удирдлага, зохион байгуулалт шаардсан онцгой нөхцөл байдлын байгууллагын хувьд онцгой ач холбогдолтой. Итгэлцлийн онолын суурийг бүрдүүлсэн судлаачдын нэг болох Roger C. Mayer нар итгэлцлийг “чадвар (ability), шударга байдал

(integrity), энэрэнгүй байдал (benevolence)” гэсэн гурван үндсэн хэмжүүрээр тодорхойлсон нь байгууллагын удирдлагын судалгаанд өргөн хэрэглэгддэг загвар болжээ. Энэхүү онолын хандлага нь удирдах бүрэлдэхүүний хоорондын итгэлцлийг хэмжих, үнэлэхэд онол арга зүйн чухал суурь болдог. Монгол Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, аврах, сэргээн босгох үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн цэргийн байгууллага болох онцгой байдлын байгууллагын хувьд ахлагч бүрэлдэхүүний нэгдмэл байдал, харилцан ойлголцол, итгэлцэл нь онцгой нөхцөл байдлын үед шуурхай, уялдаа холбоотой ажиллах үндсэн нөхцөл болдог. Онцгой байдлын алба хаагчид эрсдэлтэй орчинд богино хугацаанд шийдвэр гаргах шаардлагатай тул удирдах бүрэлдэхүүний хоорондын үл ойлголцол, итгэлцлийн сул байдал нь үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Гэсэн хэдий ч манай улсын хэмжээнд онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний хоорондын итгэлцлийн түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан эмпирик судалгаа харьцангуй хомс байна. Иймд энэхүү судалгаагаар ахлагч бүрэлдэхүүний харилцан итгэлцлийн өнөөгийн байдлыг тодорхойлох, байгууллагын дотоод уур амьсгал, багийн ажиллагаа, үүрэг гүйцэтгэлтэй хэрхэн уялдаж байгааг шинжлэх зорилгыг дэвшүүлж байна. Энэхүү судалгаа нь байгууллагын удирдлага, хүний нөөцийн бодлого, манлайллын хөгжилд практик ач холбогдол бүхий санал, зөвлөмж





боловсруулах онол арга зүйн суурийг бүрдүүлэхэд чиглэж байна.

### Үндсэн хэсэг

Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний ажилчдын дундах итгэлцлийн шалтгаан ба үр дагаврыг тайлбарлахаас өмнө “итгэл”-ийн талаар тодорхойлох нь чухал юм. Итгэл бол хүн чанарын нэг шалгуур, ёс суртахуун, ёс зүйн нэн чухал хэмжүүр хэдий ч салбар салбарын хүрээнд болон хэмжих хэжүүр бүрээр өөр өөрөөр тодорхойлсон байдаг. Rousseau, Sitkin, Burt, болон Camerer нар итгэлийг “өөр хүний санаа зорилго эсвэл үйлдэлд эерэг сэтгэгдлийг бий болгохын тулд эмзэг байдлыг хүлээн зөвшөөрөх сэтгэлзүйн төлөв байдал” гэж тодорхойлсон байдаг (Mayer 1995). Итгэлцлийн талаарх судалгаанд хэд хэдэн тодорхой чиглэл байдаг. Түүнчлэн “итгэл даах чадвар” гэдэг нь гурван хүчин зүйлээс шалтгаалдаг. Үүнд: чадвар(ability), шударга байдал(integrity), болон сайн санаа, энэрэнгүй байдал(benevolence) орно.

Чадвар(ability) ба шударга байдал(integrity) нь өмнөх амжилт болон үг, үйлдэл, үнэт зүйлсийн хоорондын нийцэлд үндэслэсэн, итгэх логик буюу рациональ шалтгааныг илэрхийлдэг. Үүний эсрэгээр, сайн санаа (benevolence) нь бусдад анхаарал халамж, энэрэл үзүүлж байсан өмнөх туршлагад тулгуурласан, илүү сэтгэл хөдлөлийн үндэстэй итгэх шалтгааныг илэрхийлдэг. Нөгөө нэг чиглэлийн судалгаа нь Rousseau нарын (1998) тодорхойлолтод дурдсан хүлээлтийн талыг илүү онцолдог. Энэ үзэл баримтлалд итгэлцлийг итгэлтэй, эерэг хүлээлт гэж үздэг (Cook & Wall, 1980). Мэдлэгт суурилсан итгэлцэл нь өмнөх гүйцэтгэл болон амлалтаа биелүүлж байсан туршлагад үндэслэдэг (Lewicki

& Bunker, 1995). Сайн санаанд суурилсан итгэлцэл нь сэтгэл санааны оролцоо болон халамж, анхааралд үндэслэдэг (McAllister, 1995). Харин өөрийгөө нэгэн адилтгах итгэлцэл буюу өөрийнгөө таних хандлага (Identification) нь хамтын үнэт зүйлс болон нийцэл, ижилсэлд суурилдаг (Lewicki & Bunker, 1995). Манай судалгаанд итгэлцлийг Mayer болон хамтрагчдын (1995) үзэл баримтлалд тулгуурлан чадвар (ability), шударга байдал (integrity), болон энэрэнгүй байдал (benevolence) гэсэн ойлголтуудаас үүдэлтэй нэгдмэл бүтэц (unitary construct) гэж тодорхойлсон. Энэхүү нэгдмэл хэлбэрийг сонгосон нь Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний ажилд илэрдэг ялгааг илүү оновчтой илэрхийлж чадна гэж үзсэнтэй холбоотой. Жишээлбэл, нэг гал сөнөөгч галын хамгаалалтын системийн талаар суралцах тал дээр хамт олондоо итгэж болох ч, гал түймэр гарсан үед иргэнийг аврах тал дээр итгэхгүй байж болох юм. Энэ жишээ нь гал сөнөөгч ердийн даалгаварт хамаарах итгэл болон өндөр найдвартай ажиллагаа шаардсан даалгаварт хамаарах итгэлийн хооронд ялгаа гарч ч болно. Мөн судлаач Roger C. Mayer болон James H. Davis нар итгэлцлийн онолыг үндэслэсэн юм. Энэхүү онол нь байгууллагын гишүүд хоорондын харилцаа, хамтын ажиллагаанд итгэл хэрхэн үүсч, хөгждөгийг тайлбарладаг. Roger C. Mayer болон James H. Davis нарын судалгаагаар итгэлцлийг гурван гол хүчин зүйлээр тодорхойлдог. Үүнд:

-Чадвар (Ability) – тухайн хүн үүрэг даалгаврыг гүйцэтгэх чадвартай байх.

-Шударга байдал (Integrity) – ёс зүй, амлалтаа баримтлах чанар.

-Энэрэнгүй байдал (Benevolence) – бусдад эерэг нөлөө үзүүлэх эрмэлзэл.

Эдгээр нь удирдлага, ахлагч бүрэлдэхүүний хоорондын итгэлцлийн түвшинг үнэлэх гол арга зүйг бүрдүүлдэг.

### Судалгааны хэсэг Онцгой байдлын ахлагч бүрэлдэхүүний өнөөгийн байдал

Сүүлийн жилүүдэд улсын хэмжээнд бүртгэгдэж буй гамшиг, аюулт үзэгдэл, ослын тохиолдол тогтмол өндөр түвшинд хадгалагдаж, жил бүр дунджаар 4,000–5,000 орчим дуудлагад хариу арга хэмжээ авч байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй, өндөр ачаалалтай, богино хугацаанд оновчтой шийдвэр гаргах шаардлагатай орчинд явагдаж байгааг илтгэнэ. Ийм нөхцөлд ахлагч бүрэлдэхүүний үүрэг, хариуцлага улам бүр нэмэгдэж, зөвхөн захирамж дамжуулах бус, бодит нөхцөлд шуурхай үнэлгээ хийж, эрсдэлийг тооцоолон, алба хаагчдын аюулгүй байдал, ажиллагааны үр дүнг нэгэн зэрэг хангах шаардлага тавигдаж байна. Өнөөгийн байдлаар ахлагч бүрэлдэхүүн нь олон зуун алба хаагч, техник хэрэгсэл, орон нутгийн удирдлагын байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага тулгардаг бөгөөд энэ нь ахлагч нарын зохион байгуулах, манлайлах, харилцах ур чадварт өндөр шаардлага тавьж байна. Нөгөө талаас байгууллагын бүтэц, чиг үүрэг өргөжин тэлж буйтай холбоотойгоор удирдлагын шат дамжлага нэмэгдэж, мэдээллийн урсгал илүү төвөгтэй болж байна. Энэ нь ахлагч бүрэлдэхүүний хоорондын уялдаа холбоо, ойлголцол, харилцааны чанарт шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна. Ялангуяа олон нэгж оролцсон томоохон гамшгийн үед ахлагч бүрэлдэхүүний зохион байгуулалтын нэгдмэл байдал нь ажиллагааны амжилтыг тодорхойлох

үндсэн нөхцөл болж байна. Иймээс Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний өнөөгийн байдал нь мэргэжлийн бэлтгэлжилт, дадлага туршлагын хувьд бэхжиж, үйл ажиллагааны цар хүрээ өргөжсөн боловч өсөн нэмэгдэж буй ачаалал, эрсдэлийн орчинд удирдлагын нэгдмэл байдал, зохион байгуулалтын үр нөлөө, харилцан ойлголцлын чанарыг тасралтгүй сайжруулах шаардлагатай үе шатанд байна.

### Судалгааны үр дүн

Уг тоон судалгаанд Онцгой байдлын байгууллагын Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн гал унтраах 10-р ангийн ахлагч бүрэлдэхүүн хамрагдсан бөгөөд нийт 94 албан хаагчид хамрагдсан.

Насны ангилал		
Ангилал	Тоо	Хувь(%)
20-30 нас	64	68.10%
31-40 нас	25	26.60%
41-50 нас	5	5.30%
Боловсролын байдал		
Бакалавр	12	12.80%
Бүрэн дунд	82	87.20%
Албан тушаал		
Гал сөнөөгч	61	64.90%
Жолооч	12	12.80%
Бусад	21	22.30%
Ажилсан жил		
1-2 жил	44	46.80%
3-4 жил	17	18.10%
5-6 жил	9	9.60%
7с дээш	24	25.50%
Санхүү байдал		
1-2 сая	89	94.70%
3-4 сая	4	4.30%
5-6 сая	1	1.10%
Гэрэлсэн эсэх		
Гэрэлсэн	36	38.30%
Гэрлээгүй	58	61.70%

### Хүснэгт 1. Судалгаанд ороолцогчдын ерөнхий мэдээлэл

Нийт хамрагдсан албан хаагчдын дийлэнх буюу 64 (68.10%) нь 20-30 насных байсан ба түүний дараагаар 31-40 насныхан 25 (26.60%) албан хаагч хамрагдсан байна. Маш бага буюу 5(5.3%) нь 41-50 насны албан хаагч хамрагдсан. Тус судалгаанд хамрагдсан албан хаагчдын боловсролын түвшин бакалавр 12(12.8%), дийлэнх болох 82(87.2%) нь бүрэн дунд боловсролтой албан хаагчид хамрагдсан. Үүнээс





61(64.9%) нь гал сөнөөгч, 12(12.8%) жолооч байсан бөгөөд 21(22.3%) нь бусад албан тушаалтай албан хаагчид хамрагдсан.

Судалгаанд хамрагдсан ахлагч бүрэлдэхүүний ихэнх буюу 44(46.8%) нь 1-2 жил ажилсан бол 17(18.1%) нь 3-4 жил ажилласан ба 9(9.6%) нь 5-6 жил, 24(25.5%) нь 7-оос дээш ажилласан албан хаагчид байлаа.

Тус судалгаанд хамрагдсан ахлагч бүрэлдэхүүний санхүүгийн байдлыг харахад дийлэнх буюу 89(94.7%) нь 1-2 сая төгрөгийн орлоготой байсан бол 4(4.3%) нь 3-4 сая орлоготой албан хаагчид байсан. Гэрлэсэн байдлыг харвал 58(61.7%) нь гэрлээгүй бол үлдсэн 36(38.3%) нь гэрлэсэн албан хаагчид байсан.

#### Ахлагч бүрэлдэхүүний албан хаагчдын итгэлийг үнэлэх судалгаа

Энэхүү судалгааны зорилго болох Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний хамтран ажиллаж байгаа алба хаагчдаа хэр хэмжээгээр итгэж байгаа болон өөрсдөө хэрхэн итгэлтэй байж ажил үүргийг биелүүлж байгаа зэргийг харуулахыг зорьсон бөгөөд судалгааны цогц асуумжыг нэгтгэн дунджаар харууллаа.

Судалгаанд 4н хүчин зүйлийн нийт 8 асуулт тус бүрийг 1-5 түвшинд тохирох хариултыг сонгож харгалзах оноо өгч тэмдэглэсэн ба судалгааны үр дүнгийн боловсруулалтыг нийт оноогоор дүгнэж 1 хамгийн бага, 2 бага, 3 дундаж, 4 их, 5 хамгийн их гэсэн үзүүлэлтээр тус тус үнэлэх аргаар боловсруулсан.

Асуулга	N	Бага	Их	Дундаж(Mean)	Cronbach's Alpha	
<b>Хамт ажиллагсдын Чадвар (Ability)</b>						
<b>0.841</b>						
1	Би хамтран ажиллаж байгаа алба хаагчдынхаа чадварт маш их итгэлтэй байдаг.	94	1	5	4.0106	0.877
2	Би хамтран ажиллаж байгаа алба хаагчдаа сайн мэргэшсэн гэж боддог.	94	1	5	3.9894	0.863
<b>Хамт ажиллагсдын Үнэнч шударга байдал(Integrity)</b>						
<b>0.773</b>						
3	Би хамтран ажиллаж байгаа алба хаагчдаа хэлсэндээ хүрэхгүй байх эсэхэд хэзээ ч эргэлздэггүй.	94	1	5	3.7979	0.853
4	Би хамтран ажиллаж байгаа алба хаагчдын үйдлэл, зан байдлыг тогтвортой гэж боддог.	94	1	5	3.2766	0.881
<b>Өрөвч нинжин сэтгэл(Benevolence)</b>						
<b>0.78</b>						
5	Миний хамтран ажиллаж байгаа алба хаагчид надад чухал зүйлийг байнга анхаарч ажилладаг.	94	1	5	3.7021	0.854
6	Миний хамтран ажиллаж байгаа алба хаагчид надад санаатайгаар ямар нэгэн хор хохирол учруулах зүйл хэзээ ч хийхгүй.	94	1	5	3.7553	0.866
<b>Өөрийгөө таних хандлага (Identification)</b>						
<b>0.788</b>						
7	Би өөрийгөө өөрийн байгууллагын нэгэн чухал ажилтан гэж боддог.	94	1	5	3.7979	0.867
8	Би байгууллагын бусад бусад алба хаагчидтайгаа сайн зохицож ажилладаг гэж боддог.	94	2	5	4	0.86

#### Хүснэгт 2. Найдвартай байдлын шинжилгээ

Хамтран ажиллаж байгаа алба хаагчдын чадвар хүчин зүйлийн “Би хамтран ажиллаж байгаа алба хаагчдынхаа ур чадварт маш их итгэлтэй байдаг” асуултын дундаж 4.0106, Cronbach's Alpha (судалгааны найдвартай байдлыг хэмжигч) 0.877 судалгааны найдвартай байдал болон дундаж үр дүнгээс харахад Хамтран ажиллаж байгаа алба хаагчдынхаа ур чадварт итгэлтэй байдаг гэдэг үр дүн харуулж байна.

Хамтран ажиллаж байгаа алба хаагчдын үнэнч шударга байдал хүчин зүйлийн “Миний хамтран ажиллаж байгаа алба хаагчид хэлсэндээ хүрэх эсэх талаар би хэзээ ч эргэлздэггүй” асуултын дундаж 3.7979, Cronbach's Alpha 0.853 судалгааны байдал найдвартай байдал болон дундаж үр дүнгийн хариуг харахад хамтран ажиллаж байгаа алба хаагчид нэгэндээ үнэнч шударга байдал итгэлтэй байдаг гэдэг хариу гарсан байна.

Өрөвч нинжин сэтгэл хүчин зүйлийн асуулгаас “Миний хамтран ажиллаж байгаа алба хаагчид надад санаатайгаар ямар нэгэн хор хохирол





(Benevolence), өөрийгөө таних хандлага (Identification) гэсэн дөрвөн хэмжүүрээр үнэлсэн. Найдвартай байдлын шинжилгээгээр бүх хүчин зүйлсийн Cronbach's Alpha коэффициент 0.853–0.877 хооронд гарсан нь судалгааны асуумж өндөр найдвартай болохыг харууллаа. Дундаж үнэлгээнээс харахад ахлагч бүрэлдэхүүн хамтран ажиллагчдынхаа ур чадварт (4.01), шударга байдал (3.79), өрөвч нинжин сэтгэлд (3.75), өөрийгөө таних болон зохицох чадварт (4.00) өндөр түвшний үнэлгээ өгсөн байна. Энэ нь байгууллагын хүрээнд харилцан итгэлцэл ерөнхийдөө “их” түвшинд байгааг илтгэнэ.

Корреляцийн шинжилгээний үр дүнгээр итгэлцлийн бүх хүчин зүйлсийн хооронд эерэг, статистикийн ач холбогдол бүхий хамаарал ( $p < .001$ ) илэрсэн. Ялангуяа үнэнч шударга байдал нь өрөвч нинжин сэтгэл ( $r = .660$ ), өөрийгөө таних хандлага ( $r = .655$ ) зэрэг үзүүлэлтүүдтэй харьцангуй өндөр хамааралтай байгаа нь ахлагч бүрэлдэхүүний харилцан итгэлцлийн суурь нь ёс зүй, амлалтаа биелүүлэх байдал, зарчимч чанарт тулгуурлаж байгааг харуулж байна. Судалгааны үр дүнгээс үзэхэд ахлагч бүрэлдэхүүний хоорондын итгэлцэл нь дан ганц мэргэжлийн чадварт бус, харин ёс зүй, энэрэнгүй хандлага, хамтын үнэт зүйл, байгууллагын соёлтой цогцоороо уялдан бүрэлддэг байна. Өндөр эрсдэлтэй, шуурхай шийдвэр гаргалт шаардсан нөхцөлд ажилладаг онцгой байдлын байгууллагын хувьд энэхүү харилцан итгэлцэл нь багийн ажиллагааны нэгдмэл байдал, шийдвэр гаргалтын хурд, алба хаагчдын аюулгүй ажиллагаанд стратегийн ач холбогдолтой хүчин зүйл болох нь батлагдлаа. Иймд Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний

итгэлцлийг тогтвортой хадгалах, цаашид бэхжүүлэх зорилгоор ёс зүйд суурилсан манлайллыг хөгжүүлэх, харилцааны соёлыг сайжруулах, багийн уялдаа холбоог дэмжих сургалт, хөгжлийн бодлогыг системтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### Санал

Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан Онцгой байдлын байгууллагын ахлагч бүрэлдэхүүний хоорондын итгэлцлийг хадгалах, бэхжүүлэх чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

#### 1. Ёс зүйд суурилсан манлайллыг хөгжүүлэх:

Ахлагч бүрэлдэхүүний үнэнч шударга байдал нь итгэлцлийн бусад хүчин зүйлстэй өндөр хамааралтай байгаа тул удирдах ажилтнуудын ёс зүй, хариуцлага, үлгэрлэн манлайлах ур чадварыг хөгжүүлэх сургалт, хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлэх шаардлагатай.

#### 2. Багийн харилцаа, уялдаа холбоог сайжруулах:

Хамт олны дунд нээлттэй, харилцан хүндэтгэлтэй харилцааг дэмжих, багийн ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр багийн сургалт, хамтын үйл ажиллагааг нэмэгдүүлэх нь зүйтэй.

#### 3. Сэтгэлзүйн дэмжлэг, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх:

Өрөвч нинжин сэтгэл итгэлцэлд чухал нөлөөтэй тул алба хаагчдын сэтгэлзүйн эрүүл мэндийг дэмжих, стресс бууруулах, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгтэй.

#### 4. Мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх:

Судалгаагаар хамтран ажиллагчдын чадварт өндөр үнэлгээ өгсөн хэдий ч энэ түвшинг хадгалах, ахиулах зорилгоор сургалт, дадлага, ур чадвар

дээшлүүлэх тогтолцоог тасралтгүй хэрэгжүүлэх шаардлагатай.

### 5. Байгууллагын соёл, үнэт зүйлсийг төлөвшүүлэх:

Итгэлцэл нь зөвхөн хувь хүний зан төлөвөөс гадна байгууллагын соёлтой шууд холбоотой тул хамтын үнэт зүйлсийг тодорхойлох, төлөвшүүлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэх бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

#### Ашигласан материал

[1] Edgar Schein (2018). Organizational Culture and Leadership

[2] Robert. L., Mathis. J. H. (2002) Human resource management. 2nd edition.

[3] С.Дэлгэрмаа. (2013).Төрийн захиргааны албаны тогтвор сууршлын судалгаа . ( 2022).

тушаал, Ш. с. (2019). Онцгой байдлын байгууллагын хүний нөөцийн бодлого

[4] Lewicki, R. J., & Bunker, B. B. 1995. Trust in relationships: A model of development and decline. In B. B.Bunker & J. Z. Rubin (Eds.), Conflict, cooperation, and justice: 133–173. San Francisco: Jossey-Bass.

[5] Mayer, R. C., Davis, J. H., & Schoorman, F. D. 1995. An integrative model of organizational trust. Academy of Management Review, 20: 709 –734.

[6] Mayer, R. C., & Gavin, M. B. 2005. Trust in management and performance: Who minds the shop while the employees watch the boss? Academy of Management Journal, 48: 874 – 888.

[7] Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал(2023). Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм. Улаанбаатар хот



ГАЛ ТҮЙМРИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧИЙН УР ЧАДВАРТ  
ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

## ANALYSIS OF FIRE SAFETY STATE INSPECTORS' PROFESSIONAL SKILLS



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨᠤᠯᠤᠰ ᠬᠡᠭᠡᠨᠠᠨᠠᠯᠠᠳᠤ ᠤᠯᠤᠰ ᠬᠡᠭᠡᠨᠠᠨᠠᠯᠠᠳᠤ ᠤᠯᠤᠰ ᠬᠡᠭᠡᠨᠠᠨᠠᠯᠠᠳᠤ

**Д.Тэгшбаяр**

Дотоод хэргийн их сургуулий Онцгой байдлын сургуулийн магистрант, ахлах дэслэгч

**D. Tegshbayar**

Master's student in the School of Emergency Management, University of Internal Affairs, first lieutenant

\*хариуцлагатай зохиогч: tegshbayrtegshee@gmail.com

**Хураангуй:** Энэхүү судалгааны өгүүлэл нь Smart PLS 4.0 программ ашиглан Монгол Улсын гал түймрийн улсын хяналтын байцаагчдын ур чадварт үзүүлж буй хүчин зүйлсийн хамаарлыг тодорхойлсон.

Судалгааны гол зорилго нь гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварт мэргэжлийн мэдлэг, ажлын ачаалал, удирдлага, зохион байгуулалтын хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг детерминацын хамаарлын ( $R^2$ ) аргаар судалгааг боловсруулсан. Судалгаанд 102 алба хаагч оролцож, нийт 45 асуулгын хүрээнд мэдээлэл цуглуулсан шинжилсэн.

Судалгааны загварын PLS-SEM шинжилгээний үр дүнгээр ГТУХБ-ын ур чадварт хамгийн хүчтэй нөлөөлж буй хүчин зүйл нь мэдлэг ( $R^2=0.655$ ) байна. Харин сэтгэл ханамж ( $\beta=0.180$ ) болон удирдлага зохион байгуулалт ( $R^2=0.127$ ) нь сул эерэг нөлөөтэй гарсан. Хүний нөөц ба ажлын ачаалал ( $R^2=0.022$ ) нь ур чадварт бараг нөлөө үзүүлэхгүй байна. Загварын тайлбарлах чадвар  $R^2 = 0.658$  буюу судалгааны хувьсагчид ур чадварын 65.8%-ийн магадлалтайгаар батлагдлаа.

Түүнчлэн судалгаагаар гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварт хамгийн их нөлөө үзүүлдэг хүчин зүйл нь мэргэжлийн мэдлэг бөгөөд түүний хамаарал 0.655 гэж гарчээ. Энэ нь байцаагчдын ур чадварыг нэмэгдүүлэхэд мэргэжлийн мэдлэгийг хөгжүүлэх, сургалт, дадлага, практик туршлагыг тасралтгүй сайжруулах нь хамгийн чухал болохыг илтгэж байна. Мөн ажлын ачаалал, удирдлага, зохион байгуулалт зэрэг бусад хүчин зүйлсийн ур чадварт үзүүлэх нөлөөллийн хамаарлыг нарийвчлан судалж гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэжлийн ур чадварыг системтэй үнэлж, хөгжүүлэх арга хэмжээг төлөвлөхөд чухал үндэслэл болж өгч байна.

**Abstract:** This study was conducted using Smart PLS 4.0 software to analyze the factors influencing the professional competencies of fire control inspectors in Mongolia. The main objective of the research was to evaluate how inspectors' professional knowledge, workload, management, and organizational factors affect their competencies, using a determinative relationship analysis.

A total of 102 inspectors participated in the study, and data were collected through 45 survey items and analyzed using statistical methods. The analysis indicated that the coefficient of determination for inspectors' competencies was 0.658, suggesting that their overall competency level can be considered moderate to adequate.

The study further revealed that professional knowledge had the strongest influence on inspectors' competencies, with a path coefficient of 0.655. This finding



highlights the importance of continuously enhancing professional knowledge, training, practical experience, and hands-on exercises to improve competency levels.

Moreover, the research provided insights into the effects of other factors, such as workload, management, and organizational arrangements, on competency, offering a solid basis for systematically evaluating and planning measures to develop the professional competencies of fire control inspectors.

**Түлхүүр үг:** Гал түймэр, улсын хяналт, байцаагч, ур чадвар, мэдлэг, шинжилгээ

**Keywords:** Fire, State Supervision, Inspector, Competence, Knowledge, Analysis

### Удиртгал

Гал түймрийн улсын хяналтын байцаагч нь галын аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох зэрэг чухал үүргийг гүйцэтгэдэг төрийн тусгай албан хаагч бөгөөд сүүлийн жилүүдэд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ажлын чиг үүрэг өргөжин, мэргэжлийн шаардлага нэмэгдэж байгаа нь тэдний ажлын гүйцэтгэл, үр дүнд нөлөөлөх хандлага ажиглагдаж байна. Үүнд:

- Хяналт шалгалтын ажлын ачаалал нэмэгдэх;
- Зөрчил шалган шийдвэрлэн ажиллах;
- Хяналт шалгалтад хамрагдах объектын тоо хэт өндөр;
- Галын шинжээчээр ажиллах;
- Ой, хээрийн гал түймэрт үүрэг гүйцэтгэх;
- Галын аюулгүй байдлын сургалтын хүртээмж зэрэг хүчин зүйлс багтана.

Эдгээр нөхцөл байдал нь гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын үр дүнд шууд нөлөөлж байгаа тул гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэжлийн ур чадвар болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлан шинжлэх шаардлага зайлшгүй болжээ. Энэхүү гал түймрийн

улсын хяналтын байцаагчийн ур чадварыг шинжлэхдээ Онцгой байдлын ерөнхий газрын 102 гал түймрийн улсын хяналтын байцаагчийг хамруулан “гоо-чанар”-ын аргад суурилсан SmartPLS 4.0 программ ашиглан нөлөөлж буй хүчин зүйлийн хамаарлыг шинжиллээ.

### Үндсэн хэсэг

Энэхүү судалгаанд гал түймрийн улсын хяналтын байцаагчдаас санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Судалгаанд оролцогчдын нийгэм-хүн ам зүйн үндсэн мэдээлэлд нас, хүйс, боловсролын түвшин, ажилласан жил, албан тушаал, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын ачаалал, удирдлага зохион байгуулалт зэрэг үзүүлэлтүүдийг хамруулан судалсан.

Судалгаанд оролцогчдын дийлэнх хувийг эрэгтэй алба хаагчид эзэлж байгаа бөгөөд энэ нь галын аюулгүй байдлын салбарын онцлогтой холбоотой байна. Насны хувьд 25-45 насны алба хаагчид зонхилж байгаа нь судалгаанд идэвхтэй ажиллаж буй дунд насны мэргэжилтнүүд түлхүү хамрагдсан болохыг харуулж байна. Боловсролын түвшний хувьд ихэнх оролцогчид бакалавр болон түүнээс дээш боловсролтой байгаа нь тухайн байгууллагын мэргэжлийн чадавх харьцангуй өндөр байгааг мөн ажилласан жилийн хувьд 5-15 жилийн туршлагатай алба хаагчид оролцсон





ᠮᠣᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤ ᠰᠠᠬᠢᠭᠤᠯᠠᠬᠤ

болохыг харуулж байна. Судалгаанд оролцогчдын албан тушаалын бүтэц нь удирдах болон гүйцэтгэх албан тушаалын төлөөллийг харьцангуй тэнцвэртэй хамруулсан болно. Иймд судалгаанд хамрагдсан алба хаагчдын ерөнхий мэдээлэл болон мэдлэг, сэтгэл ханамж, удирдлага зохион байгуулалт, ажлын ачаалал нь хэрхэн ур чадварт нөлөөлж буйг дараах байдлаар тодорхойлов.

### Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогчдын боловсролын түвшинээс харахад 79.4 хувь нь бакалаврын зэрэгтэй, 21.4 хувь нь магистрын зэрэгтэй байна. Нийт оролцогчдын дийлэнх нь дээд боловсрол эзэмшсэн байна. Мөн магистрын зэрэгтэй алба хаагчдын тодорхой хувь байгаа нь мэргэжлийн мэдлэгийн түвшин харьцангуй сайн байгааг илтгэнэ.





График №1. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин

Гал түймрийн улсын хяналтын чиглэлээр ажилласан хугацааг авч үзвэл судалгаанд оролцогчдын 55.8 хувь нь 1-3 жил ажилласан, 26.7 хувь нь 3-5 жил ажилласан, харин 14 хувь нь 5-10 жил ажилласан байцаагчид байна. Энэ нь судалгаанд оролцогчдын дийлэнх нь харьцангуй бага хугацаанд ажилласан,

ажлын туршлага багатай алба хаагчид давамгайлж байгааг харуулж байна. Нөгөө талаас 1-3 жилийн ажлын туршлагатай байцаагчид эзэлж байгаа нь тухайн салбарт тодорхой хэмжээний туршлага хуримтлуулсан боловсон хүчин шаардлагатай байгааг илтгэнэ.



Зураг 2. Судалгаанд оролцогчдын ажилсан туршилга

### Мэргэжлийн үнэлгээний хувьд:

Судалгааны үр дүнгээс харахад галын аюулгүй байдлын хууль

### мэдлэгийн

тогтоомж, норм дүрмийн мэдлэгийг оролцогчдын дийлэнх буюу 82.4 хувь нь “сайн” болон “маш сайн” гэж үнэлсэн нь байцаагчдын эрх зүйн










ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠢᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад галын аюулгүй байдлын талаар мэргэжлийн зөвлөмж өгөх чадварыг үнэлэхэд судалгаанд оролцогчдын 58 хувь нь сайн гэж

үнэлсэн байна. Энэ нь гал түймрээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд байцаагчдын зөвлөмж, зөвлөгөө өгөх чадвар харьцангуй сайн түвшинд байгааг харуулж байна.




Зураг 10. Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зөвлөмж өгөх чадвар

**Ажлын ачаалал**

Судалгаанд оролцогчдын 40.6 хувь нь ажлын ачааллыг их, 37.6 хувь нь маш их 20.8 хувь нь дунд гэж үнэлсэн нь Монгол Улсын гал түймрийн улсын хяналтын байцаагчдын ажиллах нөхцөл харьцангуй их ачаалалтай байгааг харуулж байна. Энэ нь байцаагчдын өдөр тутмын хяналт шалгалт, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, галын аюулгүй байдлын зөвлөмж өгөх, барилга байгууламжийн зураг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийх, улсын комисст ажиллах

зэрэг олон чиглэлд үүрэг гүйцэтгэдэгтэй холбоотой юм.


Олон улсын жишээгээр АНУ болон БНСУ-ын галын улсын хяналтын байцаагчдын ажлын ачаалал харьцангуй зохион байгуулалттай, нэг байцаагчид ногдож буй объектын тоо, шалгалтын давтамжийг тодорхой стандарт, программ хангамжаар удирддаг. Энэ нь Монголын байцаагчдын хувьд ачаалал харьцангуй өндөр, зарим тохиолдолд ажлын стресс, мэргэжлийн гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлтэй байгааг харуулж байна.



Зураг №11. Ажлын ачааллыг харуулсан байдал

Судалгаанд оролцогчдоос Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхүүд хамрагддаг уу? гэдэг асуултад хариулахад оролцогчдын 9.6 хувь нь маш их гэж, 29.8 хувь нь их гэж, 39.4

хувь нь дунд гэж, 8.7 хувь нь бага гэж, 12.5 хувь нь маш бага гэж хариулсан нь тогтоогдсон. Энэхүү үр дүнгээс үзэхэд судалгаанд оролцогчдын ихэнх нь гэр хорооллын айл өрхүүдийн хамралт дунд түвшинд буюу дунд гэж үнэлсэн болох нь ажиглагдаж байна.




Зураг 12. Гэр хороололын айл өрхүүд хяналт шалгалтанд хамрагддаг эсийг харулсан байдал

Аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч нар алслагдсан сум, багуудад хяналт шалгалтыг тэгш хүртээмжтэй үзүүлж чаддаг эсэхийг үнэлэхэд судалгаанд оролцогчдын 5 хувь нь маш сайн, 11 хувь нь сайн, 42.2 хувь нь дунд, 19.6 хувь нь муу, 22.5 хувь нь маш муу гэж хариулсан байна. Энэ нь байцаагчдын хувьд алслагдсан газруудад хяналт шалгалтыг тэгш хүртээмжтэй үзүүлэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Жишээ нь Төв аймгийн хэмжээнд аймгийн Онцгой байдлын газраас 249 км-ийн алслагдсан сумдад хяналт шалгалт үзүүлэх шаардлага тулгардаг. Энэ нь байцаагчдын ачаалал ихсэх, зарим сум, багт хяналт хийгдэх давтамж буурах, галын эрсдэлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх боломж хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Иргэдийн хувьд аюулгүй амьдрах эрхтэй бөгөөд галын эрсдэлээс хамгаалагдах нь үндсэн шаардлага юм.<sup>2</sup>



Зураг 13. Алслагдсан сум, багуудад хяналт шалгалт хүртээмжтэй үзүүлж чаддаг эсхийг харуулсан байдал


Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажилд бусад арга хэмжээ (иж бүрэн сургууль, жагсаалын бэлтгэл гэх мэт) хэр нөлөөлдөг вэ гэдэг асуултанд

судалгаанд оролцогчдын 13.9 хувь нь маш их, 36.6 хувь нь их, 36.6 хувь нь дунд, 10.9 хувь нь бага, 2 хувь нь маш бага гэж хариулсан байна.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 1 дэх заалт




ᠮᠤᠩᠭᠡᠯᠤᠯᠤᠰᠤ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ




Зураг 14. Хяналт шалгалтын ажилд бусад арга хэмжээ хэр нөлөөлдгийг харуулсан байдал

Судалгаанд оролцогчдоос “Удирдлагын зүгээс ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн ажлаас өөр ажил үүрэг гүйцэтгэхийг шаарддаг эсэх” талаар асуухад оролцогчдын ихэнх буюу 43.3 хувь нь “дунд” гэж үнэлсэн бол 26.9 хувь нь “маш их” болон “их” гэж, 29.8 хувь нь “бага” болон “маш бага” гэж хариулсан нь удирдлагын шаардлага зарим тохиолдолд нэмэлт ажил үүрэг даалгах байдлыг харуулж байна.



Зураг 15. Удирдлагын зүгээс ажил байдлын тодорхойлолтод заагсан ажилаас өөр ажил хийж гүйцэтгэдэг шаарддаг эсэх

Судалгаанд оролцогчдын ихэнх буюу 66.4 хувь нь “маш их” болон “их” гэж үнэлсэн нь орон нутгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох үйл явцад өндөр түвшинд оролцдог болохыг харуулж байна. Харин “дунд” болон “маш бага” гэж үнэлсэн хувь нь 32.7 хувь байгаагаар оролцоо зарим тохиолдолд дунд эсвэл бага түвшинд байгааг илтгэжээ.




Зураг 16. Гал түймрийн шалтгаан нөхцөлийг үйл явцад хэр оролцоотой байдлыг харуулсан байдал

### Сэтгэл ханамж

Өөрийн мэргэжлийн ур чадвартаа сэтгэл хангалуун байхыг үнэлэхэд судалгаанд оролцогчдын 22.5 хувь нь “маш их”, 52 хувь нь “их”, 25.5 хувь нь “дунд” түвшинд сэтгэл хангалуун гэж хариулсан байна. Энэ нь гал түймрийн улсын хяналтын байцаагчдын ихэнх нь өөрийн мэргэжлийн ур чадвартаа

харьцангуй өндөр үнэлэлт өгдөг, өөрөөр хэлбэл өөрсдийн чадвар, мэдлэг, ажлын гүйцэтгэлд итгэлтэй байдгийг харуулж байна.

Гэсэн хэдий ч дунд гэж үнэлсэн 25.5 хувь нь зарим байцаагчдын хувьд ур чадвараа бүрэн хөгжүүлж чадаагүй, эсвэл өөрийгөө хангалттай мэргэшсэн гэж үнэлдэггүй байгааг харуулж байна.




Зураг 17. Судалгаанд оролцогчдын өөрийн ур чадварыг үнэлсэн байдал

Судалгаанд оролцогчдоос нэмэлт сургалт шаардлагатай эсэхийг асуухад 35.3 хувь нь маш их, 39.2 хувь нь их, 20.6 хувь нь дунд, 2.9 хувь нь бага, 2 хувь нь маш бага гэж хариулсан байна. Энэ нь байцаагчдын дийлэнх нь нэмэлт сургалт шаардлагатай гэж үзэж байгаа нь тэд өөрийн мэргэжлийн ур чадвартаа

тодорхой хэмжээгээр санаа зовж байгааг илтгэж байна.

Тухайлбал, байцаагчдын хувьд хяналт шалгалт, галын шалтгаан нөхцөл тогтоох, зөвлөмж өгөх зэрэг олон чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг.



Зураг 18. Гал түймрийн улсын хяналтын байцаагч нарт нэмэлт сургалт, дадлага шаардлагатайг харуулсан байдал


Судалгаанд оролцогчдын ихэнх буюу 84.4 хувь нь “маш их” болон “их” гэж үнэлсэн нь байцаагчдын тоог нэмэгдүүлэх шаардлага өндөр байгааг тодорхой харуулж байна. Харин “дунд”

болон “маш бага” гэж үнэлсэн хувь нь цөөн буюу 15.6 хувь байгаа нь нэмэлт байцаагчийн хэрэгцээ зарим тохиолдолд харьцангуй бага байж болохыг илтгэжээ.






ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠬᠢᠨᠠᠯᠲᠤ ᠪᠠᠶᠴᠠᠭᠴᠢᠨ ᠤᠷ ᠴᠠᠳᠠᠷᠢᠨ ᠲᠣᠭᠲᠣᠯᠴᠣᠷᠢᠭᠢ



**Зураг 19. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулсан байдал**

Судалгаанд оролцогчдоос гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварын үнэлгээний тогтолцоо шаардлагатай эсэхийг асуухад 19 хувь нь “маш их”, 55 хувь нь их, 24 хувь нь дунд, 1 хувь нь бага, 1 хувь нь маш бага гэж хариулсан байна. Энэ нь байцаагчдын ихэнх нь ур чадварын үнэлгээний тогтолцоо шаардлагатай гэж үзэж байгааг харуулж байна.

Үнэлгээний тогтолцоо нь байцаагчдын мэргэжлийн ур чадварыг стандартчилах, обьектив үнэлэх, ямар чиглэлээр нэмэлт сургалт, дадлага шаардлагатайг тодорхойлох боломжийг олгодог. Судалгааны үр дүнгээс харахад байцаагчдын хувьд ур чадвараа тасралтгүй хөгжүүлэх, чадвараа үнэлүүлж, өөрийгөө сайжруулах шаардлага байгааг энэхүү хүсэл илтгэж байна.



**Зураг 20. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварын тогтолцоо хэрэгтэй байгааг харуулсан байдал**


Асуулгын судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын гал түймрийн улсын хяналтын байцаагчдын эрх зүйн мэдлэг харьцангуй сайн, онолын мэдлэг боломжийн түвшинд байна. Гэсэн ч практик дадлага, эрсдэлд суурилсан хяналт, галын магадлал (барилга, байгууламжийн зцраг төсөлд галын аюулгүй байдлын магадлал хийсэн дүгнэлт) хийх чадвар, алслагдсан газарт хүртээмж, нэмэлт сургалт, ур чадварын

үнэлгээний тогтолцоо зэрэгт сайжруулалт шаардлагатай байгааг дээрх асуулгын судалгаанаас харж болно.

Гэвч дээрх судалгаанаас үзэхэд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварт нөлөөлж буй хүчин зүйлсийн хамаарлыг тоо ба чанарын арга болох Smart PLS 4.0 программыг ашиглан судалсан болно.



ᠮᠣᠩᠭᠤᠯᠤᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ  
 ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ ᠤᠯᠤᠰ  
 ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠮᠤᠩᠭᠤᠯᠤᠯ



**Зураг 21. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн үр чадварт хийсэн шинжилгээний үр дүн**

Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн үр чадвар үр дүн 0.658 байна.

Энэ нь загварт оруулсан дөрвөн хүчин зүйл үр чадварын 65.8 хувийг тайлбарлаж байгааг илэрхийлнэ. PLS-

SEM судалгаанд 0.50-аас дээш хамаарал нь тайлбарлах чадвартай гэж үздэг тул энэхүү загвар нь статистикийн хувьд сайн тайлбарлах чадвартай, оновчтой загвар байна.

д/д	Хувьсагч	Асуулт	Хамаарлын коэффициент	Нөлөөлөх хүч
1	Ажлын ачаалал	AA1	-0.395	Сул < 0.5
2		AA2	0.829	Хүчтэй ≥ 0.5
3		AA3	0.351	Сул < 0.5
4		AA4	-0.127	Сул < 0.5
5		AA5	0.609	Хүчтэй ≥ 0.5
6		AA6	0.403	Сул < 0.5
7		AA7	0.487	Сул < 0.5
8		AA8	0.625	Хүчтэй ≥ 0.5
9		AA9	0.368	Сул < 0.5
10	Сэтгэл ханамж	CX1	0.742	Хүчтэй ≥ 0.5
11		CX2	-0.070	Сул < 0.5
12		CX3	0.758	Хүчтэй ≥ 0.5
13		CX4	0.385	Сул < 0.5
14		CX5	0.406	Сул < 0.5
15	Мэдлэг	M1	0.701	Хүчтэй ≥ 0.5
16		M2	0.675	Хүчтэй ≥ 0.5
17		M3	0.740	Хүчтэй ≥ 0.5



18		M4	0.586	Хүчтэй $\geq 0.5$
19		M5	0.656	Хүчтэй $\geq 0.5$
20		M6	0.759	Хүчтэй $\geq 0.5$
21		M7	0.774	Хүчтэй $\geq 0.5$
22		M8	0.342	Сул $< 0.5$
23		M9	0.710	Хүчтэй $\geq 0.5$
24	Удирдлага зохион байгуулалт	У31	0.472	Сул $< 0.5$
25		У32	0.362	Сул $< 0.5$
26		У33	0.359	Сул $< 0.5$
27		У35	0.633	Хүчтэй $\geq 0.5$
28		У36	0.732	Хүчтэй $\geq 0.5$

Хүснэгт 1. SmartPLS программаар гаргасан хамаарлын коэффициент

### Тайлбар:

**Сул нөлөө ( $<0.5$ ):** Path coefficient буюу хамаарал 0.5-аас бага гарсан асуултуудыг сул нөлөөтэй гэж үздэг. Энэ нь тухайн асуулт тухайн latent variable буюу гол хувьсагчид харьцангуй бага нөлөө үзүүлж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, асуулт нь тухайн хүчин зүйлд чухал хувь нэмэр оруулж чадахгүй, бусад асуулт эсвэл хүчин зүйлээс хамаарал илүү өндөр байх магадлалтай гэсэн үг юм. Судалгааны үр дүнгээр сул нөлөөтэй асуултууд нь тухайн чиглэлийн мэдлэг, ур чадвар, ажлын ачаалал, удирдлага, сэтгэл ханамж зэрэг хүчин зүйлд нэмэлт тайлбар, тодорхойлолт шаардлагатай байгааг харуулдаг. Мөн эдгээр асуултуудыг сайжруулах замаар тухайн latent variable-д үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх боломжтой. Тухайлбал, сургалт, практик туршлага, кейс

судалгаа, тодорхой жишээ, тайлбар зэрэг аргуудыг ашиглан асуултын агуулгыг баяжуулах нь зөвлөмж болно.

**Хүчтэй нөлөө ( $\geq 0.5$ ):** Path coefficient 0.5 буюу түүнээс их гарсан асуултуудыг хүчтэй нөлөөтэй гэж үздэг. Энэ нь тухайн асуулт тухайн latent variable-д гол нөлөө үзүүлж байгааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, асуулт нь тухайн хүчин зүйлд ихээхэн хувь нэмэр оруулж, байцаагчдын ур чадвар, мэдлэг, ажлын ачаалал, сэтгэл ханамж зэрэг latent variable-ийг тодорхойлох гол үзүүлэлт болж байна гэсэн үг юм. Судалгааны үр дүнгээр хүчтэй нөлөөтэй асуултууд нь тухайн гол хувьсагчийг үнэлэхэд хамгийн чухал мэдээллийг өгч, ур чадварын үнэлгээ, сургалт, удирдлага, практик арга хэмжээ боловсруулахад үндсэн суурь болж өгдөг.

д/д	Асуулт	Асуултын дэлгэрэнгүй
1	AA1	Таны ажиллаж байгаа аймаг, дүүрэг дэх галын аюулгүй байдлын хяналт шалгалтын ачаалал, хүртээмж хангалттай байж чадаж байгаа эсэх (Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн тоог нэмэх шаардлагатай эсэх)
2	AA3	Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхүүд хамрагддаг уу?
3	AA4	Аймгийн Онцгой байдлын газар, хэлтсийн гал түймрийн улсын хяналтын байцаагч нар алсагдсан сум, багуудад хяналт шалгалтыг тэгш хүртээмжтэй үзүүлж чаддаг эсэх
4	AA6	Гал түймрийн улсын хяналтын байцаагч ард иргэд, аж ахуй нэгж байгууллагад тэгш хүртээмжтэй хяналт шалгалт зохион байгуулаагүй, хүрэлцээгүйн улмаас объектын гал түймрийн тоо, хохирлын хэмжээ нэмэгдэх үү?
5	AA7	Удирдлагын зүгээс ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн ажлаас өөр ажил үүрэг гүйцэтгэхийг шаарддаг эсэх
6	AA9	Орон нутгийн Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох үйл явцад хэр оролцдог вэ?

7	M9	Барилгын зураг төслийн хяналт
8	У31	Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхүүд хамрагддаг уу?
9	У32	Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн хяналт шалгалтын ажилд бусад арга хэмжээ (иж бүрэн сургууль, жагсаалын бэлтгэл) хэр нөлөөлдөг вэ?
10	У33	Удирдлагын зүгээс ажлын байрны тодорхойлолтод заагдсан үндсэн ажлаас өөр ажил үүрэг гүйцэтгэхийг шаарддаг эсэх.
11	СХ2	Нэмэлт сургалт шаардлагатай гэж үздэг.
12	СХ4	Байцаагчийн тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
13	СХ5	Ур чадварын үнэлгээний тогтолцоо хэрэгтэй.

### Хүснэгт 2. Асуумжийн тойм

Судалгааны үр дүнгээс үзэхэд асуумжийн үнэлгээ болон Smart PLS 4.0 программаар гаргасан path coefficient-ийн үр дүн хоорондоо ерөнхийдөө нийцэж байна. Асуумжаар байцаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадвар, ажлын ачаалал, удирдлага зохион байгуулалтын хүчин зүйлд өгсөн үнэлгээ өндөр буюу дунд түвшинд байсан нь Smart PLS-ийн тоон дүнгээр баталгаажиг байна. Мэргэжлийн мэдлэг нь ур чадварт хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгааг path coefficient харуулсан ба ажлын ачаалал, удирдлага, сэтгэл ханамжийн зарим асуулт сул нөлөөтэй гарсан нь асуумжийн дунд болон сул үнэлгээтэй нийцэж байна. Ур чадварын latent variable-д бүх асуулт хүчтэй нөлөөтэй гарсан нь байцаагчдын ур чадварын үнэлгээ дунд болон хангалттай түвшинд байгааг нотолж байна.

Өөрөөр хэлбэл, байцаагчийн ур чадвар нь санамсаргүй бус, тодорхой хүчин зүйлсийн нөлөөллөөр бүрэлдэж буйг уг үр дүн баталж байна.

Судалгааны үр дүнгээс гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадварт хамгийн хүчтэй нөлөөлөгч хүчин зүйл нь мэргэжлийн мэдлэг (0.655) болох нь тогтоогдлоо. Суурь онол, хууль эрх зүйн мэдлэг бат бөх байх тусам хяналт шалгалт хийх, галын шалтгаан нөхцөлийг тогтоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ боловсруулах зэрэг практик ур чадвар илүү өндөр

түвшинд хэрэгжиж байна. Сэтгэл ханамж болон удирдлага, зохион байгуулалт нь ур чадварт эерэг боловч харьцангуй дунд түвшний нөлөөтэй бол ажлын ачаалал бодитой нөлөө үзүүлэхгүй байна.

Сэтгэл ханамж (0.180) болон удирдлага, зохион байгуулалт (0.127) нь ур чадварт эерэг боловч харьцангуй дунд түвшний нөлөө үзүүлж байна. Харин ажлын ачааллын нөлөө маш сул (0.022) байгаа нь ур чадварт бодитой нөлөө үзүүлэхгүй байгааг харуулж байна.

Иймд гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадвар нь туршлагаас илүүтэй мэдлэгт суурилсан мэргэжлийн чадвар болох нь тогтоогдож байна. Тиймээс ур чадварыг хөгжүүлэх бодлого нь мэргэжлийн суурь мэдлэгийг гүнзгийрүүлэх, онол-практик хосолсон сургалтыг тогтмолжуулах чиглэлд төвлөрөх нь зүйтэй.

### Дүгнэлт

Гал түймрийн улсын хяналтын байцаагчдын ихэнх нь дээд боловсролтой, мэргэжлийн мэдлэг, ажлын туршлагатай бөгөөд магистрын зэрэгтэй алба хаагчдын өндөр хувь нь салбарын ур чадварыг дээшлүүлэх боломжтойг харуулж байна. Шинээр ажиллаж эхэлсэн байцаагчдын өндөр хувь нь туршлага хуримтлуулж байгааг илтгэнэ.

Байцаагчдын эрх зүйн мэдлэг, галын шалтгаан, шаталт, тэсрэлтийн





онолын мэдлэг харьцангуй сайн боловч зарим нь дунд түвшинд байгаа нь мэдлэгээ тогтмол шинэчлэх сургалт, дадлага шаардлагатайг харуулж байна. Барилгын зураг төслийн шат, цахилгаан байгууламжийн эрсдлийн мэдлэг зарим алба хаагчдад дунд түвшинд байна.

Судалгаагаар байцаагчийн ур чадварт хамгийн хүчтэй нөлөө үзүүлэгч хүчин зүйл нь мэргэжлийн мэдлэг байгааг тогтоосон. Сэтгэл ханамж нь ур чадварт эерэг нөлөөтэй бол удирдлага, зохион байгуулалтын нөлөө шууд бус байна. Ажлын ачаалал ур чадварт тодорхой нөлөө үзүүлдэггүй ч нийтдээ өндөр гэж үнэлэгдсэн.

Байцаагчдын 74 хувь нь нэмэлт сургалт, ур чадварыг үнэлэх нэгдсэн тогтолцоо шаардлагатай гэж үзсэн нь мэргэжлийн түвшинг үнэлэх, хөгжүүлэх шаардлагыг харуулж байна.

Дүгнэж хэлэхэд, гал түймрийн улсын хяналтын байцаагчийн ур чадвар нь туршлага бус, мэдлэгт суурилсан мэргэжлийн чадвар бөгөөд онолын мэдлэгтэй баталгаажсан практик ажиллагаа нь ур чадварыг бүрэн хөгжүүлдэг. Энэ нь салбарын үйл ажиллагаа өндөр мэргэжлийн, шинжлэх ухааны үндэслэлтэй, хууль эрх зүйн зохицуулалттай болохыг нотолж байна.

### Санал

Энэхүү судалгааны үр дүн, шинжилгээнд үндэслэн гал түймрийн улсын хяналтын байцаагчийн мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх, хяналт шалгалтын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр дараах зөвлөмжийг дэвшүүлж байна.

Судалгааны үр дүнгээр мэргэжлийн мэдлэг нь ур чадварт хамгийн хүчтэй нөлөө үзүүлж байгаа тул галын аюулгүй байдлын хууль эрх зүй, шаталт тэсрэлтийн онол, цахилгаан байгууламжийн галын эрсдэлийн

үнэлгээ, барилгын зураг төслийн хяналт зэрэг чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Гал түймрийн шалтгаан нөхцөлийг тогтоох, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, зөрчил шалган шийдвэрлэх зэрэг ур чадварыг сайжруулах зорилгоор кейс судалгаа, практик дадлага, туршилтад суурилсан сургалтын арга хэлбэрийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажлын ачааллыг их гэж үнэлсэн тул нэг байцаагчид ногдох объектын тоо, хяналт шалгалтын давтамжийг оновчтой тогтоох, шаардлагатай тохиолдолд орон тоог нэмэгдүүлэх асуудлыг судлах шаардлагатай.

Галын эрсдэлийн түвшинг тодорхойлж, өндөр эрсдэлтэй объектод чиглэсэн хяналт шалгалтыг түлхүү хэрэгжүүлэх, эрсдэлийн үнэлгээнд суурилсан төлөвлөлтийн тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй.

Мөн судалгааны үр дүнгээр байцаагчдын сэтгэл ханамж ур чадварт эерэг нөлөө үзүүлж байгаа тул ажлын орчин, сургалт хөгжлийн боломж, урамшууллын тогтолцоог сайжруулах нь байцаагчдын ажлын гүйцэтгэл, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

### Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Монгол Улсын Галын аюулгүй байдлын тухай хууль 2015 он
3. Гал түймрийн улсын хяналтын дүрэм 2019 он
4. Д.Баян-Эрдэнэ, “Галын аюулгүй байдлыг хангах эрх зүйн бичиг баримтын эмхтгэл” УБ, 2019 он
5. <https://nema.gov.mn/post/164150>

## ЗҮҮН БҮСИЙН УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭЛТИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### AN ANALYSIS OF THE CURRENT STATUS OF STATE RESERVE DEVELOPMENT IN THE EASTERN REGIO

#### А.Даваасүрэн

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

#### A. Davaasuren

Lieutenant, Master's Student, School of Emergency Management, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: azaadavaasuren@gmail.com

**Хураангуй:** Улсын нөөцийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа нь гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зэрэг үе шатуудад хэрэгждэг.

Энэхүү судалгааны ажлаар бид Монгол Улсын нутаг дэвсгэрийн Зүүн бүс нутагт 2020-2024 онд тохиолдсон байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослын статистик мэдээнд үндэслэн тус бүсийн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд шинжилгээ хийхийг зорилоо.

Гамшиг судлалын хүрээлэнгээс гаргасан судалгаанаас үзэхэд Монгол Улсын хэмжээнд тохиолдсон нийт хүн ба мал, амьтны гоц халдварт өвчний гаралтын 17.4 хувь, ой хээрийн түймрийн 37 хувь нь зүүн бүсэд гарсан статистик үзүүлэлт байна. (ГСҮХ, 2025)

Бидний судалгаагаар зүүн бүсийн хэмжээнд гамшиг ослын тохиолдлоор ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл 12.2 хувь буюу хамгийн өндөр хувийг эзлэж байна. 2020–2024 оны хугацаанд тохиолдсон гамшгийн тохиолдлын улмаас үүссэн эдийн засгийн хохирлыг нөхөх, зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Засгийн газраас гаргасан тогтоол, эрх зүйн баримт бичиг, статистик мэдээлэлд тулгуурлан Зүүн бүсийн гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд хосолмол (чанарын ба тоон) арга зүйгээр дүн шинжилгээ хийсэн. (ОБГ, 2025) Шаардлагатай нөөцийн хэмжээг норм, стандарт, хүн ам болон малын тоо, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн тодорхойлсон. Судалгаагаар малын тэжээлийн хангалт 84%, дулаан хувцасны хангалт 45%, эмийн багцийн хангалт 95% байгааг тогтоосон.

Судалгааны дүнгээр нөөцийн бараа, материалын нэр төрөл, хэмжээ, байршлыг тогтоох, бүрдүүлэх, хадгалах, сэлгэх, шинэчлэх, зарцуулах эрх, үүрэг болгосон хуулийн зохицуулалтуудыг нөөцийн ангилал тус бүрээр харьцуулан шинжлэхэд нөөцийн зориулалтаас хамаараад бараа материалын нэр төрөл, тоо хэмжээ, байршлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай гэж үзлээ. Ялангуяа гамшгийн үеийн хэрэгцээ шаардлага нь тухайн бүс нутгийн хүн амын тоо, суурьшлын тархалт, малын тоо толгой, уур амьсгалын онцлог, зонхилох гамшгийн төрөл, эрсдэлийн түвшинтэй шууд хамааралтай тул эдгээр хүчин зүйлд тулгуурлан нөөцийн бүтэц, хэмжээг тодорхойлох шаардлагатай байна.

**Abstract:** The preparedness of state reserves in Mongolia encompasses activities aimed at disaster prevention, mitigation, urgent recovery, and the provision of humanitarian assistance. This study analyzes the disaster preparedness and stockpiling





activities in the Eastern region of Mongolia based on consolidated data on natural disasters, hazardous events, and accidents that occurred between 2020 and 2024.

Statistics show that 17.4% of outbreaks of infectious diseases affecting humans and livestock, and 37% of wildfires nationwide, occurred in the Eastern region. The most frequent hazards in this area are water- and weather-related events (12.2%), which have significant economic impacts and negative effects on local markets.

Using a mixed-methods approach (qualitative and quantitative), and drawing upon government resolutions, legal documents, and statistical data, the study assessed the current status of disaster-related reserves. The required stock levels were determined based on standards, population size, livestock numbers, and risk assessments. Findings indicate that the availability of livestock feed is 84%, winter clothing 45%, and medical kits 95%.

Legal regulations define the rights and responsibilities for identifying, assembling, storing, rotating, renewing, and utilizing reserve items. The study highlights the need to specify the types, quantities, and locations of reserve materials according to regional population distribution, livestock numbers, climatic conditions, prevalent disaster types, and risk levels, ensuring that reserve structures and volumes are tailored to local needs.

**Түлхүүр үгс:** аюулт үзэгдэл, нөөц бүрдүүлэлт, хангамж, хүртээмжтэй байдал

**Keywords:** Hazard events, Stockpiling, Supply, Accessibility

### Удиртгал

Сүүлийн хорин жилд байгалийн гамшигийн давтамж, цар хүрээ эрс нэмэгдэж, дэлхийн эдийн засаг, нийгэмд асар их хохирол учруулж байна. НҮБ-ын Гамшигийн эрсдэлийг бууруулах газраас мэдээлснээр 2000-2019 оны хооронд дэлхий дахинд 7,348 байгалийн гамшиг тохиож, 1.23 сая хүний амь нас хохирч, нийт гурван их наяд ам.долларын эдийн засгийн хохирол учирсан бол 2020-2024 онд 4,212 гамшиг бүртгэгдэж, 1.19 сая хүн амиа алдаж, 1.63 их наяд ам.долларын хохирол үүссэн байна. Судлаачдын үзэж буйгаар гамшигийн тоо ийнхүү өсөх болсон нь уур амьсгалын эрс тэс өөрчлөлтийн давтамж нэмэгдсэнтэй холбоотой бөгөөд үерийн тохиолдол хоёр дахин нэмэгдэж, хүчтэй салхи шуурга, ган гачиг, ойн түймэр, хэт халалт элбэгшсэнээс гадна цаг уурын хэт өөрчлөлтөд бэлтгэлгүй байдал нь нас баралтын гол шалтгаан болж байна.

Харин манай улсад сүүлийн 20 жилд гамшиг, аюулт үзэгдлийн тохиолдол 30.2 хувиар өсч, гамшиг ослын улмаас амь насаа алдсан хүний тоо 9.9 хувиар, бэртэж гэмтсэн хүний тоо 10.3 хувиар, улс орны эдийн засагт учирсан хохирол 54.8 хувиар өссөн байна. (Зүүн бүсийн гамшиг ослын статистик мэдээ, 2024, хууд. 8)

Дэлхий нийтэд тохиолддог 40 гаруй аюулт үзэгдлээс 10 орчим нь Монгол Улсад зонхилдог.

Ой, хээр түймэр, гол, усны осол, цаг агаарын нөхцөл байдлын талаар УОК-оос мэдээлсэнээр 2025 онд “Улсын хэмжээнд нийт 121 удаагийн ой, хээрийн гал түймэр бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40,4% өссөн дүнтэй байна. Эдгээр гал түймрийг унтраах, түүнээс ар түмний эд хөрөнгө, амь насыг авран хамгаалах ажиллагаанд Онцгой байдлын байгууллагын 359 алба хаагч, 22 автомашин, нэг нисдэг тэрэг, орон

нутгийн 76 иргэн, 16 автомашинтайгаар үүрэг гүйцэтгэж оролцсон тоон мэдээ байна (Зүүн бүсийн гамшиг ослын статистик мэдээ, 2024). Н. Насанбаяр болон бусад (2019) судлаачдын тэмдэглэснээр сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлтийн улмаас манай оронд гангийн давтамж өсөж, халуун өдрүүдийн тоо нэмэгдэн, хур тунадас орох өдрүүдийн тоо цөөрч, хөрс, ургамлаас, уурших усны хэмжээ ихсэж байна. ((UNDRR), 2019)

Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэмтдийн судалгаанаас үзэхэд нийт хүн малын гоц халдварт өвчний гаралтын 17.4 хувь, ой хээрийн түймрийн 37 хувь нь зүүн бүсэд гарсан статистик мэдээлэл гарсан. (П.Даш, 2021) Эдгээр статистик тоон мэдээллээс харахад Монгол орны Зүүн бүс нутагт эдгээр гамшиг, осол, байгалийн аюулт үзэгдлийн тоо хэмжээ, давтамж нь нэмэгдэж буй байдал ажиглагдсан тул бид бүс нутгийн сүүлийн 3 жилийн хугацааны ослын тоо хэмжээнд болон тухайн орон нутаг дахь гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхээр тухайн сэдвийг сонгосон болно.

**Судалгааны ажлын зорилго:** Зүүн

**Зүүн бүсийн гамшиг ослын өнөөгийн байдал болон эдийн засгийн хохиролд хийсэн шинжилгээний дүн:**

Бид тус судалгаандаа Монгол

бүсийн гамшиг ослын өнөөгийн байдлыг судлан, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зарцуулах бараа, материалын нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулахад судалгааны ажлын зорилго оршино. Энэхүү зорилгоо биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан.

**Зорилт:**

- Зүүн бүсийн гамшиг ослын өнөөгийн байдлыг судлах
- Зүүн бүсийн гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх
- Цаашид нөөц бүрдүүлэлтийн үйл ажилагааг боловсронгуй болгох талаар санал, дүгнэлт гаргах.

**Судалгааны арга зүй:** Судалгааны арга зүйн хувьд судалгааны ерөнхий зарчим, шаардлага, онцлогийг харгалзан, тохируулан орчин үед түгээмэл ашиглагддаг харьцуулалт хийх болон тоон ба чанарын аргуудыг хэрэглэн шинжилж, нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг математик аргачлалаар тооцсон.


Улсын нутаг дэвсгэрийн Зүүн бүсийн аймгуудын 2020-2024 онд тохиолдсон аюулт үзэгдэл, ослын нэгдсэн мэдээнд задлан шинжилгээ хийж үзэхэд:





ᠮᠤᠩᠭᠡᠯᠢ ᠭᠠᠮᠤᠰᠢᠭ ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

Зүүн бүсийн аюулт үзэгдэл, ослын статистик мэдээ (2020-2024)



Зураг №1: Зүүн бүсийн аюулт үзэгдэл, ослын статистик мэдээ (2020-2024)

Зүүн бүсийн 2020-2024 онд бүртгэгдсэн аюулт үзэгдэл, ослын тоон үзүүлэлтийг улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гамшигын тоотой харьцуулан үзэхэд геологийн гаралтай аюулт үзэгдэл 0.3%, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдэл 12.23%, биологийн гаралтай аюулт үзэгдэл 3.7%, гал түймэр 1.09%, хүний үйл ажиллагаатай холбоотой осол 3.1% хувийг тус тус эзэлж байна. Энэ нь зүүн бүсэд ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлийн эзлэх хувь харьцангуй өндөр


байгааг харуулж байна.

Нөлөөлөл нь хүчтэй цасан шуурга, шороон шуурга, их хэмжээний цас, ган, зуд, хээрийн түймэр гэх мэт гамшиг, ослоос үүдэн мал хорогдож, эдийн засгийн хувьд ч нөлөөлөхүйц бууралттай байдал үүссэн билээ. Гамшиг ослыг хохирол багатай даван туулахын тулд нэн шаардлагатай бараа, материалыг улсын нөөцөөс нийлүүлж, шаардлагатай бүс нутагт тушаал шийдвэрийн дагуу олгодог.

Зүүн бүсийн эдийн засгийн хохирол							
Аймаг, нийслэл	2020	2021	2022	2023	2024	Дундаж	Нийт
Сүхбаатар	1293.2	2935.1	3057.6	796.7	691.3	1754.78	8773.9
Дорнод	1996	1973	2722.2	786.4	2064.6	1908.44	9542.2
Хэнтий	710.1	900.35	1218.5	1521.2	1252.1	1120.45	5602.25
<b>Зүүн бүс</b>	<b>3999.3</b>	<b>5808.45</b>	<b>6998.3</b>	<b>3104.3</b>	<b>4008</b>	<b>4783.67</b>	<b>23918.35</b>


Хүснэгт №1. Зүүн бүсийн эдийн засгийн хохирол /Эх сурвалж: (Зүүн бүсийн гамшиг ослын статистик мэдээ, 2024)/

Статистик мэдээнээс үзэхэд Зүүн бүсийн хэмжээнд 2020–2024 оны хугацаанд дунджаар 3,663,220,000 төгрөгийн эдийн засгийн хохирол учирсан нь бүс нутгийн эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлийн идэвхжилд ноцтой сөрөг нөлөө үзүүлж




Зураг 2. Аюулт үзэгдэл, осолд нас барах эрсдэл

байна. Энэхүү хохирол нь аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ буурах, малчдад эдийн засгийн үнийн өсөлт нэмэгдэх, улмаар орон нутгийн орлого, хөрөнгө оруулалтын урсгал саарах нөхцөл байдлыг бий болгожээ.



Зураг 3. Аюулт үзэгдэл, осолд гэмтэж, бэртэх эрсдэл



Зураг 4. Аюулт үзэгдэл, осолд өртөх эд материалын шууд хохирол

### Эрсдэлийн үнэлгээний шинжилгээний үр дүн

Эрсдэлийн ерөнхий үзүүлэлтэд хийсэн статистик шинжилгээний үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан гол үзүүлэлтүүдийн хоорондын хамаарлыг илэрхийлэх детерминацийн коэффициент  $R^2=0.3-0.9$ -ийн хооронд хэлбэлзэж байна. Энэхүү үзүүлэлт нь аюулт үзэгдэл, ослын давтамж, тэдгээрийн улмаас үүсэх хүний болон эдийн засгийн хохирол хооронд дунд ба өндөр түвшний хамаарал байгааг илтгэж байгаа бөгөөд эрсдэлийн хүчин зүйлс харилцан уялдаатайгаар нөлөөлж

байгааг статистикийн хувьд баталж байна. Өөрөөр хэлбэл, гамшгийн давтамж нэмэгдэхийн хэрээр хүний амь нас, эрүүл мэнд, эд материалд учрах эрсдэл дагаад өсөх хандлага ажиглагдаж байна.

Аймгуудын түвшинд хийсэн харьцуулсан шинжилгээнээс үзэхэд аюулт үзэгдэл, ослын улмаас нас барах эрсдэл Дорнод аймагт 1.82 хувь байгаа нь бусад бүс нутагтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм. Үүнтэй зэрэгцэн гэмтэж, бэртэх эрсдэл 22.71 хувь байгаа нь улсын дунджаас (13.18%) мэдэгдэхүйц давсан үзүүлэлт бөгөөд энэ нь тухайн аймагт гамшгийн





үед эрүүл мэндийн үйлчилгээний ачаалал өндөр, эмнэлгийн тусламж, нөөцийн хүртээмж хангалтгүй байх эрсдэлийг илтгэж байна. Дээрх үр дүнгээс үзэхэд Дорнод аймагт гамшгийн үед хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чиглэлд онцгой анхаарал шаардлагатай бөгөөд ялангуяа эм, эмнэлгийн хэрэгсэл, эмийн багц, тусгаарлах болон ариун цэврийн зориулалттай бараа, материалыг төвлөрүүлэн байршуулах, мөн эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээ зайлшгүй шаардлагатай байна. Энэ нь гамшгийн дараах хохирлыг бууруулах, хүний эндэгдэл, хүндрэл үүсэх эрсдэлийг хязгаарлахад чухал ач холбогдолтой.

### **I. Улсын нөөцийн байршил, бүтэцтэй холбосон бодлогын зөвлөмж**

Нэгдүгээрт, аюулт үзэгдэл, ослын улмаас нас баралт болон гэмтэл, бэртлийн эрсдэл өндөртэй Дорнод аймагт Улсын болон орон нутгийн нөөц бүрдүүлэлтийн үед эрүүл мэнд эм эмийн хангамжийн чиглэлийн бараа, материалын эзлэх хувийг нэмэгдүүлэх нь зүйтэй гэсэн судалгааны дүн гарсан. Үүнд эмийн багц, анхан шатны тусламжийн хэрэгсэл, ариун цэврийн болон тусгаарлах зориулалттай бүтээгдэхүүн, дулаан хувцас, хүнсний богино хугацааны нөөцийг төвлөрүүлэн байршуулах шаардлагатай. Энэ нь гамшгийн дараах эхний 72 цагийн хугацаанд хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хоёрдугаарт, Хэнтий аймагт Улсын нөөц бүрдүүлэлтэнд мал аж ахуй, дэд бүтэц, орон байртай холбоотой бараа материалыг давамгайл байршуулах бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд өвс, тэжээл, түр орон байр

(гэр), инженерийн болон тээврийн хэрэгсэл, сэргээн босголтод ашиглах тоног төхөөрөмжийн нөөцийг нэмэгдүүлэх нь эдийн засгийн хохирлыг бууруулахад үр дүнтэй.

Гуравдугаарт, Улсын нөөцийн салбар, агуулахын байршлыг тогтоохдоо логистикийн хүртээмж түүнчлэн гамшгийн үед тээвэрлэлтийн саатал үүсэх эрсдэлийг цогцоор нь харгалзан үзэх шаардлагатай. Өндөр эрсдэлтэй аймаг, бүсүүдэд ойрхон төвлөрүүлэх бараа, материал нь цаг хугацааг хэмнэх, шуурхай байдлыг нэмэгдүүлэхээс гадна зах зээлд үүсэх хомсдол, үнийн огцом савлагааг бууруулах эерэг нөлөөтэй. Иймд Улсын нөөцийн бодлого нь зөвхөн нөөц бүрдүүлэлтэд бус, эрсдэлийн үнэлгээнд суурилсан, уян хатан, динамик шинэчлэлд чиглэж, гамшгийн эрсдэлийн статистик үзүүлэлтүүдийг тогтмол шинэчлэх, нөөцийн бүтэц, байршлыг жил бүр хянан сайжруулах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

### **Зүүн бүсийн гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдал хийсэн шинжилгээний дүн**

Иймд 2020–2024 оны хугацаанд тохиолдсон гамшгийн тохиолдлын улмаас үүссэн эдийн засгийн хохирлыг нөхөх, зах зээлд үзүүлж буй сөрөг нөлөөг бууруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас баталсан холбогдох тогтоолуудыг үндэслэн Улсын нөөц болон орон нутгийн нөөцөөс хэрэгжүүлсэн бодлогын болон шуурхай арга хэмжээг энэхүү судалгаанд харьцуулсан шинжилгээ хийсэн. Зүүн бүсийн гамшгийн үеийн нөөц бүрдүүлэлтийн өнөөгийн байдал, түүний хангамж, хүртээмжтэй байдалд дүн шинжилгээ хийхэд дараахи үр дүнг харуулж байна.

№	Тогтоолын дугаар	Олгосон аймаг	Олгосон бараа, материал /тоо, хэмжээ/	Хангалт /хувь/	Хүртгэмжтэй байдал (тайлбар)
1	МУЗГ 113-р тогтоол	1. Хэнтий 2. Сүхбаатар 3. Дорнод	<ul style="list-style-type: none"> <li>Өвс, тэжээл- 628.93 тонн</li> <li>Автомашин- 3 ширхэг</li> <li>Тусламжийн багц- 5200 хайрцаг</li> </ul>	1. Өвс 60% 2. Малын тэжээл 84% 3. Дулаан хувцас 45% 4. Эмийн багц 95% 5. Тусгай зориулалтын автомашин 56% 6. Хоол, хүнс 76%	1. Тухайн орон нутгийн улсын нөөцийн газарт нөөцөлсөн өвсийг бодит хэрэгцээнд тулгуурлан ашигласан. 2. Нийт 3 аймгийн 15 суманд шаардлагатай хэмжээгээр малын тэжээлийг хүргэсэн. 3. Эмзэг бүлгийн иргэдийг хамруулахад чиглэсэн боловч нийт хэрэгцээг бүрэн хангахад хүрээгүй. 4. Нийт 17 төрлийн эмийн багцыг нийлүүлж, эрүүл мэндийн үйлчилгээний тасралтгүй байдлыг хангасан. 5. Гамшгийн үеийн тээвэр, логистикийн чадавхыг тодорхой хэмжээнд дэмжсэн. 6. Зах зээлд үүссэн хомсдол, үнийн өсөлтийг тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлсэн.
2	МУЗГ 208-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Автомашин- 3 ширхэг</li> <li>Гэр- 196 ширхэг</li> <li>Хүнсний багц- 250 хайрцаг</li> </ul>		
4	МУЗГ 293-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Автомашин- 1 ширхэг</li> </ul>		
5	МУЗГ 436-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Автомашин- 1 ширхэг</li> <li>Гэр- 16 ширхэг</li> <li>Тусламжийн багц- 860 хайрцаг</li> </ul>		
6	МУЗГ 449-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Өвс, тэжээл- 157,75 тонн</li> </ul>		
7	МУЗГ 479-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Автомашин- 1 ширхэг</li> <li>Өвс, тэжээл- 315 тонн</li> </ul>		
8	МУЗГ 63-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Өвс, тэжээл- 770,4 тонн</li> <li>Тусламжийн багц- 1200 хайрцаг</li> </ul>		
9	МУЗГ 68-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Хүнсний бараа- 60 тонн</li> </ul>		
11	МУЗГ 242-р тогтоол		<ul style="list-style-type: none"> <li>Өвс, тэжээл- 100 тонн</li> <li>Автомашин- 2 ширхэг</li> <li>Хүнсний бараа- 50 тонн</li> <li>Тусламжийн багц- 1500 хайрцаг</li> </ul>		




Үндэсний аюулгүй байдлын  
 үйлчилгээний газар



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠵᠢᠰᠦᠭᠡᠨ ᠭᠠᠵᠢᠷ ᠲᠣᠭᠲᠤᠯᠠᠭ ᠣᠯᠭᠣᠰᠤᠨ ᠪᠠᠷᠠᠭ ᠮᠠᠲᠢᠷᠢᠭᠠᠯ

12	МУЗГ 150-р тогтоол	<ul style="list-style-type: none"> <li>• Өвс, тэжээл- 219.97 тонн</li> <li>• Автомашин- 4 ширхэг</li> <li>• Гэр- 12 ширхэг</li> <li>• Хүнсний бараа- 60 тонн</li> <li>• Тусламжийн багц- 5200 хайрцаг</li> <li>○ 3,739,198,870 төгрөг</li> </ul>
13	МУЗГ 230-р тогтоол	<ul style="list-style-type: none"> <li>• Өвс, тэжээл- 815.39 тонн</li> <li>• Автомашин- 2 ширхэг</li> <li>• Гэр- 6 ширхэг</li> </ul>
14	МУЗГ 138-р тогтоол	<ul style="list-style-type: none"> <li>• Автомашин- 2 ширхэг</li> <li>• Гэр- 42 ширхэг</li> </ul>



Зураг 5. Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор олгосон бараа материал (2020-2024)

2020–2024 оны хугацаанд тохиолдсон гамшгийн үед Улсын нөөц болон орон нутгийн нөөцөөс авсан арга хэмжээний хүрээнд хангалтын байдал дараах түвшинд хэрэгжсэн байна.

Тухайлбал, өвсний хангалт 60 хувьд хүрч, тухайн орон нутгийн улсын нөөцийн газарт нөөцөлсөн өвсийг бодит хэрэгцээнд тулгуурлан ашигласан байна. Малын тэжээлийн

хангалт 84 хувьтай байсан бөгөөд нийт 3 аймгийн 15 суманд шаардлагатай хэмжээгээр тэжээлийг хүргэж, мал аж ахуйн салбарын эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авсан нь судалгаагаар тогтоогдлоо. Дулаан хувцасны хангалт 45 хувьтай хэрэгжсэн нь хүн амын хэрэгцээг бүрэн хангах түвшинд хүрээгүй ч эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад тодорхой хувь нэмэр оруулсан байна. Харин эмийн багцын хангалт 95 хувьд хүрч, нийт 17 төрлийн эмийн багцыг нийлүүлсэн нь эрүүл мэндийн үйлчилгээний тасралтгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой байв.

Тусгай зориулалтын автомашины хангалт 56 хувьтай хэрэгжсэн бөгөөд энэ нь гамшгийн үед тээвэр, логистикийн чадавхыг тодорхой хэмжээнд дэмжсэн ч цаашид нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна. Мөн хүнсний хангалт 76 хувьтай байсан нь зах зээлд үүссэн хомсдол, үнийн өсөлтийг тодорхой хэмжээнд тогтворжуулахад эерэг нөлөө үзүүлсэн байна.

### Дүгнэлт

Гамшгийн үеийн нөөц гэдэг нь гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллааны үед гамшигт нэрвэгдсэн хүн амыг хангахад зориулагдсан бараа, материалын нөөц гэж үзэж болох юм. Иймд бүс нутгийн онцлогт тохируулан гамшгийн нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, ангилал зориулалтыг нь тодорхойлон хангамж, хүртээмжтэй байдлыг хангах нь нэн чухал юм.

Улсын нөөцийн тухай хуулинд “гамшгаас нөөц гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг хэлнэ”, “Гамшгаас хамгаалах тухай хууль”-ийн 51.2-т “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг

бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна.” гэж заасны дагуу бүс нутгийн хэмжээнд гамшгийг даван туулах боломжтой хэрэгцээт бараа, материалаар нөөц бүрдүүлэх шаардлагатай бөгөөд, энэхүү гамшгийн нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагааг аутсорсингийн аргаар зохион байгуулах боломжтой гэж үзлээ.

Харин бүс нутгийн хэмжээний томоохон гамшиг ослын үед эсвэл урт хугацаагаар байнгын байрлалаас хол үйл ажиллагаанд оролцох тохиолдолд нэмэлтээр багаж, тоног төхөөрөмж, бараа материал шаардлагатай болдог. Энэ тохиолдолд бүс нутгийн хэмжээний нөөц бүрдүүлэлтийн асуудлыг шийдвэрлэсэн байх шаардлагатай гэсэн дүгнэлт хийсэн.

Улсын нөөцийг ингэж ангилснаар нөөцийн үүрэг, зориулалт тодорхой болж, тэдгээрийн тоо хэмжээ, байршлыг тогтоох, бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, захиран зарцуулах нөхөн бүрдүүлэх эрх зүйн актыг боловсруулж мөрдөх боломжтой болно хэмээн дүгнэлээ.

Зүүн бүсэд объектын болон хээрийн түймэр, цасан шуурга, малын гоц халдварт өвчнөөс тус тус хамгаалахад чиглэсэн гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэх шаардлагатай байна. Мөн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд нөөцийн олон түвшний байршлын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай. Улсын төв нөөцөөс гадна бүсчилсэн болон орон нутгийн дэд агуулахыг стратегийн байршилд байгуулснаар гамшгийн үед хүргэлтийн хугацааг богиносгож, алслагдсан сум, суурин





газруудад нөөцийг цаг алдалгүй хүргэх боломж бүрдэнэ. Энэ нь зах зээлд үүсэх хомсдол, үнийн огцом өсөлтийг бууруулахад чухал нөлөө үзүүлнэ. Хүргэлтийн зохион байгуулалтыг уян хатан, олон хувилбарт логистикийн системд суурилуулах шаардлагатай байна.

### Санал

1. Эрсдэлд суурилсан нөөцийн төлөвлөлтийн загвар нэвтрүүлэх

Зүүн бүсийн аймаг тус бүрийн гамшгийн эрсдэлийн онцлог (ус, цаг уур, биологийн гаралтай аюулт үзэгдэл)-т тулгуурлан нөөцийн нэр төрөл, хэмжээ, байршлыг тодорхойлох математик загвар боловсруулж, туршилтаар хэрэгжүүлэх шаардлагатай.

2. Бүсчилсэн агуулах, логистикийн оновчтой байршлын судалгаа

Гамшгийн үед хүргэлтийн хугацааг багасгах зорилгоор олон түвшний

### Ном зүй

1. (UNDRR), Н.-ы. Д. (2019). “*The Human Cost of Disasters 2000-2019*” тайлан. Улаанбаатар хот: НҮБ.

2. ГСҮХ. (2025). *Гамшиг ослын статистик мэдээ 2017-2025*. Улаанбаатар.

3. Зүүн бүсийн гамшиг оёлын статистик мэдээ (12 15, 2024).

(улсын–бүсийн–орон нутгийн) агуулахын байршлыг логистикийн онол, GIS технологид суурилан оновчлох судалгаа хийж, загварчлал боловсруулах.

3. Нөөцийн менежментийн дижитал систем нэвтрүүлэх судалгаа

Улсын болон орон нутгийн нөөцийн бүрдүүлэлт, хадгалалт, сэлгэлт, зарцуулалтыг хянах нэгдсэн мэдээллийн (дижитал) системийн хэрэгцээ, боломжийг судалж, прототип загвар боловсруулах.

4. Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд суурилсан нөөц бүрдүүлэлтийн механизм

Гамшгийн үеийн нөөцийг зөвхөн төрөөс бус, хувийн хэвшлийн оролцоотой (аутсорсинг, гэрээт нийлүүлэлт, нөөцийн хамтын сан) хэлбэрээр бүрдүүлэх боломж, эдийн засгийн үр ашгийг судлах шаардлагатай.

4. ОБГ, Д. а. (2025). Зүүн бүсийн гамшиг ослын мэдээ 2020-2024., (pp. 8-10). Дорнод.

5. П.Даш. (2021). *Улсын нөөц түүний удирдлага*. Улаанбаатар: Өнө Монгол принтинг.

6. ярилцлагаас, О.-ы. д. (2024, 10 10). *Eagle.mn*. Retrieved 11 03, 2024, from Eagle.mn: 3

## ИРГЭДИЙН ГАМШГААС ХАМГААЛАХ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙН АСУУДАЛ

### METHODOLOGICAL ISSUES ON DISASTER PROTECTION TRAINING FOR CITIZENS



Дотоод Асуудлын  
Сургуулийн  
Университет

#### **О.Шинэтунгалаг**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

#### **O. Shinetungalag**

Lieutenant, Master's student School of Emergency Management, University of Internal Affairs

#### **Н. Отгонцэцэг**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

#### **N. Otgontsetseg**

Lieutenant, Master's student School of Emergency Management, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: shineeshinee.0513@gmail.com

**Хураангуй:** Дэлхийн дахинд байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшиг, ослын тоо, цар хүрээ нэмэгдэж, уур амьсгалын өөрчлөлт, хотжилт, байгаль орчны доройтол, технологийн эрсдэл зэргээс шалтгаалан олон улсын хэмжээнд хүний амь нас, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд ноцтой нөлөөлж буй төлөв байдал ажиглагдаж байна. Гамшгаас хамгаалах иргэний сургалт нь иргэдийг байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй аюул, ослын үед зөв шийдвэр гаргах, өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, чадвар, хандлагаар бэлтгэх чухал хэрэгцээтэй сургалт юм.

Дэлхийн дахинд гамшиг, ослын давтамж, хор хохирол нэмэгдэж буй нөхцөл байдалд нийцүүлэн иргэдэд гамшигийн эрсдэлийг танин мэдүүлэх, хариу арга хэмжээ авах чадвар, аврах ба хамгаалах дадал, ур чадварыг төлөвшүүлж, нийгмийн нийтлэг аюулгүй байдлыг хангах чадвартай, хариуцлагатай иргэн бэлтгэх хэрэгцээ шаардлагаар энэхүү өгүүлэл бичих үндэслэл тодорхойлогдож байна.

Энэхүү илтгэлд гамшгаас хамгаалах иргэний сургалтын арга, хэлбэр, эрх зүйн зохицуулалт, иргэдийн гамшгаас хамгаалах сургалтад хамрагдаж байгаа өнөөгийн төлөв байдлын талаар практик байгууллагын статистик тоо мэдээ, түүнчлэн уг сургалтын үр нөлөөг тодорхойлох зорилгоор иргэдээс авсан судалгааны үр дүн болон цаашид сургалтын үр нөлөөг дээшлүүлэх зарим арга замын талаар товч тусгасан болно.

**Abstract.** Globally, the frequency and magnitude of both natural and human caused disasters and accidents are increasing, and a state of affairs is being observed internationally that poses serious consequences for human life, the economy, and sustainable social development, driven by factors such as climate change, urbanization, environmental degradation, and technological risks.

Civil defense training for disaster protection is a vitally necessary training that prepares citizens with the knowledge, skills, and attitudes needed to make correct decisions and protect themselves and others during natural and human caused hazards and accidents.





The necessity for writing this article is determined by the need to adapt to the globally increasing frequency and damages caused by disasters and accidents, and to prepare responsible citizens capable of ensuring overall public safety by instilling in them disaster risk awareness, response capabilities, and rescue and protection habits and skills.

This article provides an overview of the methods and forms of civil defense training for disaster protection, its legal framework, and the current level of citizen participation in such training, supported by statistical data from relevant organizations. It also presents the results of a survey conducted among citizens to assess the effectiveness of the training and outlines several recommendations for improving its impact in the future.

**Түлхүүр үгс:** Гамшгаас хамгаалах иргэний сургалт, иргэн, сургалтын арга зүй, гамшгаас хамгаалах сургалт, бэлэн байдал, үр нөлөө

**Keywords.** Civil defense training for disaster protection, citizen, training methodology, disaster protection training, preparedness, effectiveness

### Удиртгал

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын давтамж, цар хүрээ нэмэгдэж буй өнөө үед иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ур чадварыг бэхжүүлэх асуудал нэн тэргүүний ач холбогдолтой хэвээр байна. Монгол Улсад газар хөдлөлт, уул-уурхайн осол, гал түймэр, түр зуурын цаг агаарын аюулт үзэгдэл зэрэг эрсдэлт хүчин зүйлс тогтмол тохиолддог бөгөөд эдгээрийн хор уршгийг бууруулах гол хүчин зүйл нь иргэн бүрийн бэлтгэл байдлыг сайжруулах явдал юм. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гамшгаас хамгаалах тухай хуульд гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоог анхаарсан хэдий ч сургалтын арга зүйн цогц төлөвлөлт, хэрэгжилтийн чанар хангалтгүй байдал харагдсаар байна.

Иргэдэд чиглэсэн сургалт нь зөвхөн мэдээлэл түгээх бус, аврах, нүүлгэн шилжүүлэх, анхны тусламж үзүүлэх зэрэг практик чадвар эзэмшүүлэхийг шаарддаг бөгөөд энэ нь шинжлэх ухааны үндэслэлтэй, насны онцлог, орчны нөхцөлд нийцсэн арга зүй боловсруулахыг шаардана. Гэвч

сургалтын агуулга, хэрэгжүүлэх арга барил, сургалтын хэлбэрүүдийн уялдаа, сургагч багшийн чадавх, үнэлгээ, дүгнэлт хийх тогтолцоо зэрэгт сул тал олон байна. Түүнчлэн олон нийтийн оролцоо, идэвх санаачилга харилцан адилгүй, мэдээлэл авах боломж хүртээмжтэй бус байгаа нь сургалтын үр нөлөөг бууруулах хүчин зүйл болсоор байна.

Иймд иргэдийн гамшгаас хамгаалах сургалтын арга зүйн асуудлыг судлан, өнөөгийн нөхцөл байдлыг шинжилж, сургалтын үр нөлөөг дээшлүүлэх оновчтой арга барил, шийдлийг тодорхойлох нь гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын чухал хэсэг юм. Энэхүү илтгэлд гамшгаас хамгаалах сургалтын арга зүйн онол, үндэслэл, тулгамдсан асуудлыг тодорхойлох зорилгоор судалгааны арга болох анкет асуулгын аргыг, хууль, төрөөс баримталж байгаа бодлого, практик байгууллагын статистик тоо мэдээнд баримт бичгийн шинжилгээ хийх арга, гадаадын зарим оронд нэвтрүүлж буй дэвшилтэд арга зүйн туршлагад харьцуулалтын аргуудыг тус тус ашигласан бөгөөд

цаашид Монгол Улсад хэрэгжүүлэх боломжит арга замыг хамруулан авч үзэх болно.

### Үндсэн хэсэг

Сүүлийн жилүүдэд дэлхий нийтэд уур амьсгалын өөрчлөлт, техник технологи, хүний үйл ажиллагаатай холбоотойгоор гамшгийн тохиолдох давтамж ойртож, хамрах хүрээ, эрч хүч нь улам бүр нэмэгдэж, гамшиг нь улс орны тогтвортой хөгжлийн ололтод сөргөөр нөлөөлөх хүчин зүйлд тооцогдож байна. Иймээс хүн төрөлхтөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, гамшгийг аль болох хохирол багатайгаар даван туулах чадварыг эзэмших хэрэгцээ, шаардлага улам бүр чухлаар тавигдаж байна. Энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулахад ихээхэн нөлөөтэй гэдгийг дэлхий нийт хүлээн зөвшөөрч үйл ажиллагаагаа чиглүүлэх болсон. Тухайлбал, гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичигт гамшгаас хамгаалах сургалтын хэрэгцээг "Бүх түвшний байгууллагын албан хаагчид, иргэний нийгэм, олон нийт, сайн дурынхан, хувийн хэвшлийнхний гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг боловсрол, сургалтын механизмыг ашиглан сайжруулах"(Sendai Framework for Disaster Risk Reduction 2015-2030 - The All India Disaster Mitigation Institute, n.d.) гэж тодорхойлсон.

Монгол Улсын хэмжээнд 2024 онд нийт 4905 удаагийн аюулт үзэгдэл, ослын тохиолдол бүртгэгдэж, Онцгой байдлын байгууллагын алба хаагчид 7890 хүний амь нас, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн 360 орчим тэрбум төгрөгийн эд хөрөнгийг авран хамгаалжээ Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга

хэмжээний хүрээнд улсын хэмжээний нийт өрхийн 42.4 хувьд урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх арга хэмжээг хүргэж ажилласнаар объектын гал түймрийн улмаас учирсан хохирлын хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.1 тэрбум төгрөг буюу 14.3 хувиар, тэр дундаа шатсан гэр, орон сууцны тоо 51 хувиар, нас барсан хүний тоо 18.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (Онцгой байдлын байгууллагын 2024 оны онцлох үйл явдлууд, n.d.) Дээрхи статистик тоо мэдээ нь гамшгаас хамгаалах иргэний сургалтын хэрэгцээ шаардлага өндөр болохыг харуулж байна.

Иргэдийн гамшгаас хамгаалах сургалт нь энгийн мэдээлэл түгээх үйл ажиллагаанаас хальж, оновчтой арга зүйн шийдэлд тулгуурлах шаардлага улам нэмэгдэж байна. Үүнийг нарийвчлан авч үзвэл:

### Сургалтын арга зүйн хэрэгцээ:

1. Эрсдэлийн бүтцийн өөрчлөлттэй уялдах хэрэгцээ – Гамшгийн төрөл олон болж, эрчим, давтамж нэмэгдэж байгаа тул сургалтын арга зүй нь зөвхөн нэг төрлийн аюулд бус, олон талт эрсдэлийг таньж, үнэлж, хариу арга хэмжээ авах чадвар эзэмшүүлэхэд чиглэх шаардлагатай.

2. Иргэдийн мэдлэг, чадварын түвшин харилцан адилгүй – Насны онцлог, боловсролын түвшин, амьдарч буй орчин, мэргэжил, амьдралын хэвслээс хамааран суралцагчийн хэрэгцээ өөр тул тэдэнд тохирсон сургалтын арга хэлбэр, тактик шаардлагатай.

3. Практик дадлага дутмаг байдал – Олон жил онолын мэдээлэл давамгайлж ирсэн тул дадлага, симуляци, бодит нөхцөлд тулгуурласан сургалтын аргачлал нэн шаардлагатай болсон.





4. Олон нийтийн оролцоог сайжруулах шаардлага – Иргэдийн идэвх оролцоо сул байгаа нь арга зүйн нэгдсэн стандарт, хүртээмжтэй, сонирхол татахуйц сургалтын арга барил хөгжөөгүйтэй холбоотой.

**Арга зүйн шаардлага:** Иргэдэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалтын арга зүй нь дараах шаардлагуудыг хангасан байх ёстой. Тухайлбал:

1. *Шинжлэх ухааны үндэслэлтэй байх* – Газар хөдлөлт, гал түймэр, үер, хүйтэн хуурайшилт, биологийн аюул зэрэг эрсдэлт хүчин зүйл бүрийн онцлогт тулгуурлан найдвартай мэдлэг, туршигдсан аргачлал ашиглах.

2. *Оролцоонд суурилсан байх* – Чиглүүлэг, багийн ажил, бодит кейс, дадлага сургуулилт зэрэг аргууд иргэдийн хариу арга хэмжээ авах чадварыг илүү үр дүнтэй хөгжүүлдэг.

3. *Хүртээмжтэй, ойлгомжтой байх* – Өндөр мэргэжлийн үг хэллэгээс зайлсхийж, энгийн хэрэглэгчдэд ойлгомжтой, хүн бүрийн амьдралын орчин, амьдралын хэвшилд нийцсэн агуулгатай байх.

4. *Нас, бүлгийн онцлогт нийцсэн байх* – Хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, алслагдсан орон нутгийн малчин зэрэг бүлэг бүрт өөр хандлага, арга барил шаардлагатай.

5. *Үр нөлөөг үнэлэх тогтолцоотой байх* – Сургалтын өмнө ба дараах үнэлгээ, дадлагын гүйцэтгэлийн шалгуур, олон нийтийн оролцооны түвшин зэргийг уялдуулан үнэлэх аргачлал шаардлагатай.

**Арга зүйн ач холбогдол:** Иргэдийн гамшгаас хамгаалах сургалтын арга зүйн зөв төлөвлөлт, хэрэгжилтийн ач холбогдлыг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Амь нас, эрүүл мэндийг хамгаалах хамгийн шууд арга юм. Иргэд зөв арга барилтай болсон

тохиолдолд гамшгийн үед авах хариу арга хэмжээний хугацаа богиносж, эрсдэл даамжрахаас сэргийлэх боломжийг бүрдүүлнэ.

- Эдийн засгийн хохирлыг бууруулна. Урьдчилан бэлтгэлтэй иргэд нь хөрөнгө өмчөө хамгаалах, гэр бүл, байгууллагын аюулгүй байдлыг хангах чадвартай болж, улс орны нийт эдийн засгийн ачааллыг багасгахад хувь нэмэр оруулна.

- Олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хамтын аюулгүй байдлын соёл төлөвшүүлнэ. Иргэдийн хандлагад эерэг соёл төлөвшсөнөөр гамшгийн эрсдэлийн талаарх мэдлэг бий болцгоож, нийгмийн хариуцлага, харилцан туслалцах хандлага нэмэгддэг.

- Оршин суугчдын шийдвэр гаргах чадварыг дээшлүүлнэ. Аюулыг таних, мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргах, нэгдсэн командлалтай уялдуулах зэрэг чадамжууд нь зөвхөн сайн боловсруулсан сургалтын арга зүйгээр бий болдог.

- Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын хэрэгжилтийг сайжруулна. Хэрэв иргэдийн мэдлэг чадвар хангалттай байвал төрийн байгууллагын ачаалал багасч, хариу арга хэмжээний бүх шат илүү уялдаа холбоотой ажиллах боломж нэмэгдэх юм.

Монгол Улсад 2020–2024 онд нийт 7,280 удаагийн гамшиг, аюулт үзэгдэл бүртгэгдэж, өмнөх таван жилээс 2.3 дахин өссөн бөгөөд 48.2% нь гал түймэр, 27.5% нь байгалийн, 12.6% нь технологийн гаралтай байжээ

Нийслэлийн хэмжээнд сүүлийн 3 жил /2023-2025 он/-д нийтдээ 5664 удаагийн гал түймрийн дуудлага бүртгэгдсэн нь хүн амын нягтаршил өндөр, хуучирсан цахилгаан шугам сүлжээ, стандартад нийцэхгүй хэрэглээ болон иргэдийн болгоомжгүй үйлдлээс

үүдэлтэй эрсдэл нэмэгдэж байгаа явдалтай холбоотой. Мөн гэр хорооллын хатуу болон шингэн түлшний хэрэглээ, халаалтын төхөөрөмжийн буруу ашиглалт, олон

айл өрхийн ойр байрлал зэрэг орчны хүчин зүйлс галын тархалтыг түргэсгэж, түймрийн тоо, хохирлыг нэмэгдүүлсээр байна.




График №1. Нийслэлийн гал түймрийн тоо мэдээ

Зөвхөн 2025 оны эхний 10 сарын байдлаар нийслэлийн хэмжээнд 2184 удаагийн гал түймрийн дуудлага ирж байгаа нь өдөрт дунджаар 6 удаагийн гал түймэр гарч байгаа гэсэн тооцоолол гарч байна. Онцгой байдлын албаны статистик тоо мэдээнээс үзвэл Монгол Улсад 2024 онд нийт насанд хүрэгчдийн 38.5% нь гамшгийн сургалтад хамрагдсан нь 2019 онд 27.2% байсан үзүүлэлттэй харьцуулахад 11.3 хувиар өссөн байгаа ч байгалийн гамшиг, хүний хүчин зүйлээс улбаатай гамшгийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байгаа нь гамшгаас хамгаалах иргэний сургалт хангалттай бус байгааг харуулж байна. Гэвч сургалтын агуулга, арга зүй нь онолын хэлбэр давамгайлж, дадлага сургуулилтын эзлэх хувь 31.4%-д хүрч, сургалтын үр нөлөө сул байгаа нь тодорхойлогдов.нөөгийн дэлхийд уур амьсгалын өөрчлөлт, технологийн эрсдэл, нийгмийн эмзэг байдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан гамшгийн давтамж, цар хүрээ, хор уршиг нэмэгдэж байна.

### Гамшгаас хамгаалах иргэний сургалтын өнөөгийн төлөв байдал

Онцгой байдлын албанаас зохион байгуулсан гамшгаас хамгаалах иргэний сургалтад 2019 онд насанд хүрсэн нийт иргэдийн 27.2% нь хамрагдаж байсан бол 2024 онд 38.5% нь хамрагдаж, гамшгаас хамгаалах сургалтад иргэний оролцоо нэмэгдэх хандлагатай болсон байна. Өөрөөр хэлбэр иргэдийн сургалтад хамрагдалтын хувь (2019–2024) сүүлийн таван жилд 27.2%-иас 38.5% болж 11.3 хувиар өссөн нь сайшаалтай байна. Харин сургалтын хэлбэрийн хувьд 58.7% нь “лекц”, 31.4% нь “дадлага”, 9.9% нь “цахим сургалт” хэлбэрээр зохион байгуулагдсан байна. Иргэдийн үзэж буй сургалтын хэрэгцээ — 77.4% нь сургалтыг зайлшгүй шаардлагатай гэж үзсэн. Гамшгийн сургалтын чанарын үнэлгээ (2024)-г авч үзвэл “Сургалтын хэрэгцээ”-г 78.2% сайн гэж үнэлсэн бол “Дадлагын чанар”-ыг 28.4% нь сайн, 45.9% нь дунд (ОБЕГ, 2025) гэж үнэлсэн анхаарал татаж байна.

Гэвч иргэдийн бэлэн байдлын түвшин хангалтгүй, сургалт орон нутагт хүрэхгүй, сургалтын хэлбэр нэг хэвийн, үр дүнг хэмжих үнэлгээ дутмаг





ᠮᠤᠩᠭᠢᠮᠤᠯᠠᠭᠤᠯᠤᠰᠤ

байна. Тиймээс энэхүү судалгаа нь сургалтын арга зүйг орчин үеийн шинжлэх ухаанд тулгуурлан боловсронгуй болгох шаардлага тулгарч байна.

**Иргэдээс авсан судалгаа:** Гамшгаас хамгаалах иргэний сургалтын төлөв байдлыг танин мэдэх зорилгоор 100 иргэнээс авсан бидний судалгаа нь иргэдийн гамшгийн талаарх мэдлэг, ур чадвар, бэлэн байдлын түвшинг үнэлж, сургалтын чанар болон хүртээмжийг сайжруулахад шаардлагатай бодит өгөгдөл цуглуулахад хэрэгтэй юм. Энэхүү судалгааны ач холбогдол нь гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийн оролцоо, мэдлэгийн нөлөөллийг тодорхойлж, сургалтын арга зүй, бодлогын шийдвэрийг илүү үр нөлөөтэй болгоход чиглэгдэнэ.

**Судалгаанд оролцогчдын товч анкет:** Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл 37 буюу 37.4% нь “18-30”, 54 буюу 54.5% нь “30-50”, 8 буюу 8.1% нь 50 ба түүнээс дээш настай иргэд хамрагдсан бөгөөд хүйсийн байдлыг авч үзвэл 43 буюу 43.4% нь “эмэгтэй”, 56 буюу 56.6% нь “эрэгтэй” иргэд оролцжээ.

Судалгаанд оролцогчид “Гамшгийн үед авах арга хэмжээний талаар та хэр мэдлэгтэй гэж боддог вэ?” гэсэн асуултад 39 буюу 40% нь “маш сайн”, 48 буюу 49% нь “дунд зэрэг”, 9 буюу 9% нь “бага”, 2 буюу 2% нь “мэдэхгүй” гэсэн бол “Та гамшгаас хамгаалах сургалтад өмнө нь хамрагдаж байсан уу?” гэсэн асуултад 84 буюу 86% нь “тийм”, 14 буюу 14% нь “үгүй” гэсэн хариултыг тус тус өгчээ.




График №2. Арга хэмжээний мэдлэг  
График №3. Сургалтад хамрагдсан эсэх



Судалгаанд оролцогчдын дийлэнх буюу 86% нь гамшгаас хамгаалах сургалтад өмнө нь хамрагдсан ч, гамшгийн үед авах арга хэмжээний мэдлэгийн түвшин нь “маш сайн” гэж үнэлсэн нь 40% төдий, харин 49% нь “дунд зэрэг”, 9% нь “бага”, 2% нь “мэдэхгүй” гэж үзсэн нь сургалтын хүртээмж, үр нөлөө нь зарим хэсэгт хангалтгүй байгааг харуулж, иргэдийн мэдлэг, дадлагын хооронд тодорхой зөрүү байгааг илтгэж байна. Дүн шинжилгээ: Иргэд “Гамшгийн үед авах арга хэмжээний талаар та хэр мэдлэгтэй гэж боддог вэ?” гэсэн асуултад 57 буюу 63% нь “Маш үр дүнтэй”, 29 буюу 32% нь “дундаж, 4 буюу 5% нь “үр дүн багатай” гэж хариулсан бол “Сургалтын мэдээллийг ямар сувгаар авах нь тохиромжтой гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад 17 буюу 17% нь

“радио, телевиз”, 39 буюу 40% нь “нийгмийн сүлжээ буюу Facebook, X, TikTok, 6 буюу 6% нь “нутгийн захиргааны байгууллага”, 37 буюу 37% нь сургалт, семинар, сургалтын төвийн үйл ажиллагаагаар дамжуулан мэдээллээ авах нь тохиромжтой гэсэн хариултыг тус тус өгчээ.




График №4. Хариу арга хэмжээ



График №5. Сургалтад хамрагдсан эсэх

Дүн шинжилгээ: Судалгаанд оролцогчдын ихэнх нь буюу 63% нь гамшгийн үед авах арга хэмжээний талаарх сургалтыг “маш үр дүнтэй” гэж үнэлсэн бол 32% нь “дундаж”, 5% нь “үр дүн багатай” гэж үзсэн нь сургалтын ач холбогдол өндөр болохыг харуулж, мэдээллийг авах хамгийн тохиромжтой сувгаар 40% нь нийгмийн сүлжээ (Facebook, X, TikTok), 37% нь сургалт, семинар, сургалтын төв, 17% нь радио, телевиз, 6% нь нутгийн захиргааны байгууллагыг сонгосон нь

иргэдийн мэдээлэл авах хүсэл, суралцах хэв маяг нь олон сувгаар давхцан байгааг илтгэж байна.

Иргэд “Иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэхэд ямар агуулгыг түлхүү оруулах нь зүйтэй вэ?” гэсэн асуултад 71 буюу 72% нь “Гамшгийн үед авах анхан шатны арга хэмжээ”, 15 буюу 15% нь “Байгалийн гамшгийн талаарх мэдлэг”, 13 буюу 13% нь “Гамшгийн давтамж, төрөл” гэж хариулсан бол “Сургалт хэр хугацаанд явагдах нь хамгийн тохиромжтой гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад 38 буюу 38% нь “1 өдөр”, 18 буюу 18% нь “2-3 өдөр”, 43 буюу 44% нь “Тасралтгүй үе шаттай сургалт” гэсэн хариултуудыг тус тус өгсөн байна.



График №6. Сургалтын агуулга



График №7. Тохиромжтой хугацаа





ᠮᠣᠩᠭᠡᠯᠡᠳᠡᠰᠡᠨ ᠰᠤᠳᠤᠯᠠᠭᠤᠨ ᠭᠠᠮᠤᠰᠢᠭ

Дүн шинжилгээ: Судалгаанд оролцогчдын 72% нь иргэдийн мэдлэгийг нэмэгдүүлэхэд гамшгийн үед авах анхан шатны арга хэмжээг түлхүү заах шаардлагатай гэж үзсэн бол сургалтын хэлбэрийн хувьд 44% нь тасралтгүй үе шаттай сургалтыг, 38% нь нэг өдрийн сургалтыг тохиромжтой гэж сонгосон нь иргэд онолын суурь мэдээллээс илүү бодит нөхцөлд хэрэглэх чадвар, дадлыг сайжруулах агуулгад төвлөрсөн, үе шаттай, үргэлжилсэн сургалтын хэрэгцээ өндөр байгааг харуулж байна.

“Гамшгаас хамгаалах сургалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд юу хамгийн чухал вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 70 буюу 70.7% нь “Сургалтыг илүү сонирхолтой, дадлагатай болгох”, 29 буюу 29.3% нь “сургалтын мэдээллийг хүртээмжтэй хүргэх” гэсэн хариулыг өгчээ. Харин “Иргэдийн сургалтыг ямар хэлбэрээр явуулах нь илүү үр дүнтэй гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад 42 буюу 43.3% нь “практик дадлага олгох”, 6 буюу 6.2% нь “онол, танхимийн сургалт”, 5 буюу 5.2% нь “онлайн сургалт”, 44 буюу 45.4% нь “онол, дадлага хосолсон сургалт”-ын хэлбэрүүдийг үр дүнтэй гэсэн байна.



График №8. Шаардлагатай арга



График №9. Үр дүнтэй хэлбэр

Дүн шинжилгээ: Судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 70.7% нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд сургалтыг илүү сонирхолтой, дадлага давамгайл хэлбэртэй болгох шаардлагатай гэж үзсэнтэй уялдан сургалтын хэлбэрийн хувьд 45.4% нь онол-дадлага хосолсон, 43.3% нь шууд практик дадлагын сургалтыг илүү үр дүнтэй гэж сонгосон нь иргэд бодит нөхцөлд хэрэгжүүлэх чадварыг хөгжүүлэх, оролцоог идэвхжүүлэх дадлага төвтэй сургалт хамгийн их үр нөлөөтэй болохыг нотолж байна.

Судалгааны дүнгээс харахад иргэдийн ихэнх нь гамшгийн үед авах арга хэмжээний талаар дундаас дээш түвшний мэдлэгтэй гэж үнэлдэг боловч сургалтад хамрагдсан байдал ба бодит мэдлэгийн түвшний хооронд тодорхой зөрүү байгаа нь сургалтын үр нөлөөг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

Иргэд сурталчилгаа, мэдээллийг голчлон нийгмийн сүлжээ болон дадлага, семинарын хэлбэрээр авахыг илүүд үздэг бөгөөд сургалтын агуулгад хамгийн түрүүнд анхан шатны арга хэмжээний мэдлэг, бодит дадлага олгох хэсгийг түлхүү оруулах хэрэгтэй гэж үзжээ. Мөн гамшгаас хамгаалах сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх хамгийн чухал нөхцөл нь сургалтыг

дадлага голлосон, сонирхол татахуйц, үе шаттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд онол-дадлага хосолсон сургалт иргэдийн хэрэгцээ, хүлээлтэд хамгийн үр дүнтэй нийцэж байгааг хариултауд харуулж байна.

### Гадаадын зарим орны гамшгаас хамгаалах иргэний сургалтын туршлага

Гадаадын улс орнуудад гамшгаас хамгаалах иргэний сургалтыг дүрчилсэн дадлага, том хэмжээний симуляци, сургуулийн хөтөлбөрт суурилсан боловсрол, орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан (CBDRM) сургалт, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон дижитал платформ ашигласан өргөн хүрээний сургалтаар зохион байгуулж, бодит нөхцөлд шуурхай үйлдэх чадварыг хөгжүүлэхэд анхаардаг юм байна.

Мөн хөгжингүй орнуудад VR/AR симуляци, онлайн модуль, практик дадлага хосолсон сургалтыг өргөн хэрэглэж, иргэдийн нас, хэрэгцээнд тохирсон олон түвшний хөтөлбөрөөр тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлэхэд анхаардаг юм байна. Тухайлбал:

- Симуляци болон томоохон дадлага сургууль (evacuation/response drills) —

Япон, Чили зэрэг улсууд бүх нийтийн, олон байгууллагын оролцоотой томоохон сургууль, гамшгийн симуляци тогтмол явуулж, дүрэм, харилцан үйл ажиллагаа, мэдээллийн урсгалыг шалган сайжруулдаг; энэ нь бодит нөхцөлд үйл ажиллагааг хялбаршуулж, түргэн шийдвэр гаргах чадварыг сайжруулдаг. (*Open Knowledge Repository*, n.d.)

- Орон нутгийн идэвхитэй оролцоон дээр тулгуурласан “Community-based DRR / CBDRM”

Орон нутгийн иргэд, ахмад волонтер, НҮБ/ОУ-ын болон АНУ-ийн туршлагаар чадавхжуулах сургалт, эрсдэл үнэлгээ, жижиг багуудын дадлага зэргийг нэгтгэж, иргэд өөрсдөө эрсдэлийг тодорхойлон шийдэл гаргахад сургадаг. Эдгээр нь орон нутгийн нөхцөлд нийцсэн, тогтвортой үр нөлөөтэй гэж судалгаагаар тогтоогдсон. (Que et al., 2022)

- Сургууль, хүүхэд төвтэй аян ба сургалтын хөтөлбөр

Азийн орнуудад (Япон, Филиппин, Бангладеш г.м.) сургуулийн сургалтын хөтөлбөрт гамшгийн бэлэн байдлын сургалтыг оруулж, насанд тохирсон дадлага, тоглоом, тэмцээн, дадлагын багцуудыг хэрэглэн хүүхдүүдийг бэлтгэдэг нь гэр бүлийн түвшинд мэдлэг тархахад тусладаг юм байна. (Vision, 2024)

- Мэдээлэл, харилцаа (risk communication)

Олон нийтийн кампанит ажил (радио/телевиз, нийгмийн сүлжээ, гар утасны сэрэмжлүүлэг), богино видео/инфографик, “KnowRisk” хэвлэл, нутгийн удирдлагатай хамтарсан мэдээлэл дамжуулах аргууд олон оронд амжилттай хэрэгжиж ирсэн. Энэ нь ялангуяа залуус болон хязгаарлагдмал орон зайтай бүлгийн хүртээмжийг нэмэгдүүлдэг. (Ufmsecretariat, 2025)

- Дижитал сургалт, симулятор, тоглоом (serious games) ба виртуал сургалт

Сүүлийн жилүүдэд симулятор, VR/AR, вэб-семинар, богино онлайн модулуудыг ашиглан ахлах дадлагыг бага зардлаар олон хүнд хүргэх хандлага нэмэгдэж байна; эдгээр нь сургалтын давтамжийг өсгөж, дадлагын үр нөлөөг нэмэгдүүлдэг (Natalie Pafitis, 2025) гэж туршлагуудыг нэвтрүүлэн ашиглаж байна.





## Дүгнэлт

Гамшгаас хамгаалах иргэний сургалтын өнөөгийн төлөв байдлаас харахад дэлхий дахинд гамшгийн давтамж өсөж, иргэдийн мэдлэг, ур чадварын хэрэгцээ эрс нэмэгдэж байгаа ч улс орнуудын сургалтын чанар, хүртээмж харилцан адилгүй байна.

Монгол Улсад гамшгийн сургалтын тогтолцоо хууль эрх зүйн хувьд бүрдсэн боловч хэрэгжилт сул, сургалтын арга хэлбэр хуучин хэвээр байгаа нь бидний хийсэн судалгаанаас харагдаж байна. Сургалтын шинэчлэл, орчин үеийн технологийн нэвтрэлт нь иргэдийн бэлэн нэмэгдүүлэх боломжтой бөгөөд энэ нь гамшгийн эрсдэлийг бууруулах, хүний амь нас, эд хөрөнгийн хамгаалалтыг сайжруулах үндсэн нөхцөл болох юм.

Хөгжингүй орнууд танхимын сургалтыг бодит ажиллагааны дадлага, VR/AR симуляц, олон нийтийн оролцоонд суурилсан хөтөлбөртэй хослуулж, сургалтын үр нөлөө, авралтын дадлагуулалтыг өндөр түвшинд хүргэж байна. Бидний хийсэн судалгаанаас үзэхэд иргэдийн оролцоо сургалтын хэлбэрийн сонирхол, хүртээмж, практик дадлагын чанараас хамаарч байгаа бөгөөд уламжлалт лекцэн хэлбэр үр нөлөө багатай, харин тоглоомчилсон, бодит орчны туршилт бүхий сургалт илүү үр дүнтэй байна.

Гадаадын зарим орны туршлагуудыг судалж үзээд шинэ арга зүй болох хиймэл оюунтай хувийн сургалтын платформ, хотын түвшний өгөгдөлд суурилсан эрсдэлийн симуляц, олон нийтийн оролцоот төлөвлөлтийн интерактив систем зэрэг нь иргэдийн оролцоог шинэ шатанд гаргах боломжтой юм байна гэж үзлээ.

Дээрхи бүгдийг нэгтгэн авч үзвэл Монгол Улсад гамшгаас хамгаалах сургалтыг шинэ технологи, олон нийтийн идэвхтэй оролцоог

хослуулсан, дата-суурьтай, бодит орчны дадлагатай хэлбэрээр шинэчлэх нь гамшгийн эрсдэлийг бууруулах үндсэн шийдэл болох нь тодорхой харагдаж байна.

## Санал

Дээрх дүгнэлтүүдийг үндэслэн Монгол Улсад гамшгаас хамгаалах иргэний сургалтын чиглэлээр урьд өмнө нэвтрүүлж байгаагүй дараах саналуудыг дэвшүүлж байна. Доорх таван арга зүй нь олон улсын сургалтын уламжлалт хандлагаас илүү иргэдийн оролцоо, дижитал технологи, бодит туршлагад суурилсан, хэрэгжүүлэхэд боломжтой, шинэлэг загварууд бөгөөд Монголын нөхцөлд дасан зохицуулан хэрэгжүүлбэл сургалтын үр нөлөөг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх давуу талтай юм. Үүнд:

### 1. Хосолсон (Hybrid) “Гэр бүлийн төвтэй симуляци сургалт”

Арга зүйн тайлбар. Гэр бүлийг нэг баг болгон төсөөлж, гэрийн орчинд гарах эрсдэлүүдийг (гал, газар хөдлөлт, утаа, үер, химийн асгаралт) VR/AR технологиор дүрслэн, гэртээ сууж байхдаа бодит нөхцөлд хэрхэн зугтах, холбоо тогтоох, анхны алхам хийхийг сургадаг шинэ загвар юм.

Нэвтрүүлэх арга зам:

- Монгол айл өрхийн онцлогт тохирсон энгийн VR апп хөгжүүлэх;
- “Гэр бүл бүрийн дадлага хийх өдөр” гэх аяныг зарлан нийтийн оролцоог бий болгох;
- Сургалтын төвүүд VR цэг ажиллуулж, хүүхэд-эцэг эх хамтын сургалт хийх; (Daly et al., 2024)

### 2. Хэсэгчилсэн богино туршлага (Micro-experience learning)

Арга зүйн тайлбар. Иргэдэд 1–3 минутын бодит нөхцөлд суурилсан мини-сценарийг өдөр тутмын амьдралд нь “тоглож давтдаг” хэлбэрээр хүргэдэг арга юм. Жишээ нь: “Газар хөдлөлт 5

секундийн дараа эхэлнэ, та юу хийх вэ?” гэсэн гар утасны интерактив дасгал байж болно.

Нэвтрүүлэх арга зам:

- Нийтийн мессенжер платформд (Facebook Messenger, Telegram) өдөр бүр 1 жижиг дасгал илгээдэг бот ажиллуулах;

- Аймаг/дүүрэг бүрт өөрийн орчны онцлогт тохирсон микро-дасгалын багц гаргах; (*How Does Micro Experiences Work?* | *Arc XP*, n.d.)

### 3. “Гудамжны хамгаалагч” (Street-based DRR education) загвар

Арга зүйн тайлбар. Ердийн сургалтын орчноос гарч, иргэдийн хамгийн их үйлчлүүлдэг гудамж, байр орчмоор дамжуулан богино дадлага, бичил симуляци, QR код бүхий мэдээллийн цэгүүд байршуулан сургалт явуулах хэлбэр юм. Энэ нь сургалтыг иргэд рүү нь хүргэдэг, хотын орчинд суурилсан шинэ арга юм байна.

Нэвтрүүлэх арга зам:

- Хотын захиргаа, НОБГ хамтран “гамшгийн гудамж”— сургалтын маршрут гаргах;

- QR тайлбар бүхий 10–15 богино дадлагын цэг ажиллуулах;

- Залуучууд, оюутан волонтерууд сургалтын хөтөчөөр ажиллах. (*Are You Ready Campaign* | *UNDRR*, n.d.)

### 4. Хөршийн хамтын шийдвэр гаргалт (Neighborhood decision-simulation)

Арга зүйн тайлбар. Нэг байрны 20–30 айл эсвэл нэг гудамжны бүлэг хүмүүсийг симуляци өрөөнд оруулж, бодит цагийн команд, мэдээллийн тасалдал, худал мэдээлэл, нөөцийн хомсдол зэрэг нөхцөлд багийн шийдвэр гаргах чадварыг сорьдог шинэ сургалтын хэлбэр юм.

Нэвтрүүлэх арга зам:

- Нийслэл болон аймгуудад жижиг “Simulation Lab” байгуулах;

- Нэг байр, нэг баг, нэг хорооны баг сургалтад хамрагдах систем нэвтрүүлэх;

- Иргэдийн шийдвэр гаргалтын үр дүнг онооны системээр харуулж хөгжүүлэх. (*How We're Using Simulation to Make Neighbourhood Working Real* - PPL, n.d.)

### 5. Дадлагажсан иргэдийн түвшин тогтоох (Citizen competency ladder)

Арга зүйн тайлбар. Иргэдийг чадамжийн түвшинээр ангилан “Шаталсан сургалтын систем” нэвтрүүлж (Level 1–5), хүн бүр гэр бүлийн хамгаалагч → хөршийн зохицуулагч → олон нийтийн аврагч гэсэн шатлалаар ахиж хөгждөг инновацтай сургалтын бүтэц.

Нэвтрүүлэх арга зам:

- Түвшин бүрийн сургалтын багц, шалгалт, дадлагын шаардлага боловсруулах;

- Дүүрэг бүрт “Community Resilience Leader” хөтөлбөр хэрэгжүүлж, сайн дурын хамгаалагчдыг бэлтгэх;

- Сургалтын дүнг цахим үнэмлэх (digital badge) хэлбэрээр гэрчилж, олон нийтийн үйлчилгээнд урамшуулал олгох. (*A Ladder of Citizen Participation — People Powered*, n.d.)

### Ашигласан материал

1. Монгол Улсын Их Хурал. (2020). *Гамигаас хамгаалах тухай хууль* (шинэчилсэн найруулга).

2. Засгийн газар. (2015). *Гамигийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр*.

3. Онцгой байдлын ерөнхий газар. (2025). *Гамигийн сургалтын тайлан 2020–2024*.

4. *A Ladder of Citizen Participation — People Powered*. (n.d.). Retrieved November 16, 2025, from





## УЛСЫН НӨӨЦИЙН БАРАА ХАДГАЛАЛТЫН ЛОГИСТИКИЙН ХӨГЖЛИЙН ХОЦРОГДОЛ, ТУЛГАМДСАН АСУУДАЛ

### DEVELOPMENTAL CONSTRAINTS AND KEY CHALLENGES IN THE LOGISTICS OF STATE RESERVE GOODS STORAGE

**Б.Бат-Эрдэнэ**

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн гамшиг судлалын магистрант, дэслэгч

**B. Bat-Erdene**

Lieutenant; Master's Student in Disaster Studies, Emergency Management School, University of Internal Affairs, Mongolia

\*хариуцлагатай зохиогч: bataabaterdene06@gmail.com

**Хураангуй:** Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэлд Улсын нөөц, агуулахын аж ахуй, бараа хадгалалтын логистикийн тухай авч үзлээ. Улсын нөөц гэж нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах, үндэсний аюулгүй байдал, хүн амыг хангахад зориулагдах болон гамшиг, эдийн засгийн хүндрэл бэрхшээл, дайны байдал зэрэг онцгой байдлын үед энэ хуульд заасан зориулалт, нөхцөлийн дагуу ашиглахаар нөөцлөн хадгалж буй бараа, материалыг, гамшгийн нөөц гэж гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд зарцуулахаар хадгалсан бараа, материалыг хэлнэ. (В.В., 2015, хуудсд. 45-46) гэж заасны дагуу уг нөөц, түүний бүрэлдэхүүн хэсэг болсон агуулахын аж ахуйн талаар товч дурдсан болно. Энэ өгүүлэл нь Улсын нөөцийн үйл ажиллагаанд логистикийг хэрхэн нэвтрүүлэх боломжийг судалсан бөгөөд өөрийн дүгнэлт, зөвлөмжийг агуулсан болно. Агуулахын логистик нь агуулахын аж ахуйг зохион байгуулдаг дүрэм, бараатай ажиллах журам, тэдгээрт нийцсэн нөөцийн (хүн, техник, мэдээллийн) удирдлагын үйл явц зэргийг нэгтгэсэн ойлголт учраас логистикийг энэ хүрээнд авч үзэв. Бараа хадгалалтын логистик нь Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагааг шаардлагатай чанартай, бараа бүтээгдэхүүнийг, шаардлагатай цаг хугацаанд нь шаардлагатай тоо хэмжээгээр, шаардлагатай газарт нь хүргэж өгөх ажлыг зүй зохистой, хурдан шуурхай зохион байгуулахаас гадна үйл ажиллагааг оновчтой төлөвлөж зохицуулах арга замыг болосронгүй болгож өгч буй чухал ач холбогдолтой ойлголт юм. Иймд улсын нөөцийн бараа хадгалалтын логистикийн өнөөгийн байдалд шинжилгээ хийж, улсын нөөцөд логистикийг нэвтрүүлэх боломжийг судаллаа.

**Abstract:** The concepts of state reserves, warehouse management, and storage logistics were examined. State reserves refer to goods and materials that are stored and maintained in accordance with the law to ensure social and economic stability, safeguard national security, and support the population. These reserves are intended for use under special circumstances such as natural disasters, economic crises, or wartime situations. Meanwhile, disaster reserves refer to goods and materials specifically stored for use in disaster prevention and emergency response operations. Warehouse logistics is a comprehensive concept that integrates the rules governing warehouse operations, procedures for handling goods, and the management processes of related resources - such as human, technical, and informational resources. It serves as the organizational and managerial foundation for efficient warehouse operations. Storage logistics plays a vital role in organizing and coordinating state reserves and humanitarian aid operations





by ensuring that goods of the required quality, quantity, and type are delivered to the right place at the right time. In addition to facilitating rapid and well-organized supply activities, storage logistics contributes to the optimization of operations and the improvement of planning and coordination mechanisms, thereby enhancing overall system efficiency and responsiveness.

**Түлхүүр үгс:** Улсын нөөц, санхүүгийн урсгал, мэдээллийн урсгал, материалын урсгал

**Keywords:** State reserve, Financial flow, Information flow, Material flow

### Удиртгал

Сүүлийн жилүүдэд дэлхий дахинд байгалийн гамшиг, цар тахал, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь улс орнуудын стратегийн нөөцийн удирдлага, логистикийн тогтолцооны ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Монгол Улсын хувьд газар нутгийн өргөн уудам байдал, хүн амын тархмал суурьшил, тээвэр ложистикийн дэд бүтцийн хязгаарлагдмал байдал нь улсын нөөцийн бараа материалыг хадгалах, хамгаалах, шуурхай хүргэх асуудлыг оновчтой зохион байгуулах шаардлагыг бий болгож байна. Гэвч улсын нөөцийн агуулахын аж ахуй, бараа хадгалалтын логистикийн зохион байгуулалт, мэдээллийн систем, эрсдэлийн удирдлагын төлөвлөлтийн чиглэлд судалгаа харьцангуй хязгаарлагдмал байна.

Иймээс энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын улсын нөөцийн агуулахын аж ахуй, бараа хадгалалтын логистикийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, сайжруулах арга замыг тодорхойлоход оршино. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, системийн анализ, ажиглалтын арга, статистик мэдээллийн боловсруулалтыг ашигласан.

Судалгааны үр дүнгээс харахад улсын нөөцийн мэдээллийн нэгдсэн

систем хангалтгүй хөгжсөн, бодит цагийн хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй, логистикийн сүлжээ бүсчилсэн зохион байгуулалт дутмаг, хүний нөөцийн чадавх жигд бус, эрсдэлийн удирдлагын төлөвлөлт хангалтгүй зэрэг асуудлууд байгаа нь улсын нөөцийн үр ашиг, хүртээмж, шуурхай ажиллагаанд нөлөөлж байна.

Иймд улсын нөөцийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх, агуулах болон логистикийн сүлжээг оновчтой зохион байгуулах, хүний нөөцийн мэргэшлийг дээшлүүлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан төлөвлөлтийн тогтолцоог хөгжүүлэх шаардлагатай байна.

Монгол Улсын хувьд логистикийг нэвтрүүлэхэд хэд хэдэн сорилтууд байгаагийн нэг нь гадаад худалдаа, тээвэр, дэд бүтцийн хязгаарлалт юм. Монгол улс нь өргөн уудам нутагтай, хүн ам цөөтэй бөгөөд тээвэрлэлт, нөөцийн хадгалалт, түгээхтэй холбоотой асуудлууд тулгардаг. Гэсэн хэдий ч, логистикийн дэвшилтэт технологи, цахим мэдээллийн систем, тээвэрлэлт, түгээлт зэрэг салбарын хөгжил нь эдгээр сорилтуудыг даван туулах боломжийг олгоно. Улсын нөөцөд логистикийг ашиглах нь дэлхийн олон улс оронд чухал ач холбогдолтой байдаг бөгөөд энэ нь төрийн нөөцийг удирдах, хомсдол, байгалийн гамшиг эсвэл бусад өвөрмөц нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлэх

зорилготой байдаг. Тухайлбал, олон улс орнууд улсын нөөцөө хуваарилах, хадгалах, хүргэх логистикийн оновчтой системүүдийг хэрэгжүүлдэг.

Логистик нэвтрээгүйгээс үүдэн түргэн шуурхай ажиллах боломжгүй цаашлаад хэд хоног, хэдэн цагийн өмнөөс бэлтгэх шаардлага гардагаас авахуулаад тээвэрлэн хүргэх шатанд хүртэл удаашрах бөгөөд тооцоололгүйгээс болж санхүүгийн алдагдал гаргах зэрэг маш олон дутагдалтай талтай юм.

Иймд нөөцийн бараа материалыг бүрдүүлэхээс эхлүүлээд хэрэглэгчид хүргэх хүртэлх бүх үе шатанд логистикийг нэвтрүүлэх шаардлагатай юм. Логистик эдгээр үе шатуудад бүрэн нэвтэрснээрээ улсын нөөцийн нөхөн бүрдүүлэх, агуулахад байршуулах, хадгалах, захиран зарцуулах болон тээвэрлэлтийн оновчтой маршрутыг тогтоох үед түүнтэй холбоотой санхүү, мэдээллийн болон материалын урсгалыг удирдах оновчтой арга тодорхойлж хэрэгжүүлэх давуу талтай, чухал ач холбогдолтой юм.

Монгол Улсын эдийн засгийн тогтвортой байдал, үндэсний аюулгүй байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь улсын нөөцийн тогтолцоо юм. Улсын нөөц нь гэнэтийн байгалийн гамшиг, онцгой байдал, хүнсний болон эрчим хүчний хомсдол зэрэг нөхцөл байдалд нийгэм, эдийн засгийг тогтвортой байлгах чухал баталгаа болдог. Гэвч нөөцийг удирдах, хадгалах, түгээх үйл ажиллагаанд орчин үеийн логистикийн систем дутмаг байгаа нь үр ашиггүй байдал, нөөцийн алдагдал, мэдээллийн зөрүү, хугацааны хожимдол зэрэг асуудлыг дагуулж байна.

Улсын нөөцийн бараа материалыг агуулахад байршуулах, боловсруулахтай холбоотой зардлыг хамгийн бага хэмжээнд байлгахын тулд

агуулахын аж ахуй, худалдан авалт, бараа материалыг хүлээн авалт, байршуулалт, бүртгэлийн системийг зохион байгуулах аргыг боловсронгуй болгох асуудлыг судлана.

Логистикийн удирдлагын зарчим, арга технологийг улсын нөөцийн тогтолцоонд нэвтрүүлэх шаардлага зайлшгүй бий болсон. Энэ нь зөвхөн нөөцийн үр ашиг, зардлын хэмнэлтийг нэмэгдүүлэх төдийгүй онцгой байдлын үед түргэн шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулахад чиглэнэ. Тиймээс уг асуудал нь өнөөдөр тулгамдсан бөгөөд төрийн бодлого, эрдэм шинжилгээний хүрээнд анхаарал татсан сэдэв болж байна.

### Сэдвийг судалсан байдал

Агуулахын бүтэц, нөөцийн удирдлагын хууль эрх зүйн орчин, тээвэрлэлт, логистикийн үйл ажиллагааны ерөнхий байдал, улсын нөөцийн бүтэц, зохион байгуулалт зэрэг судлагдсан бөгөөд үйл ажиллагаанд логистикийг нэвтрүүлэх чиглэлээр судалгаа, шинжилгээ хийгдээгүй байна.

Улсын нөөцөд бараа хадгалалтын логистик нэвтрээгүй бөгөөд албаны бие бүрэлдэхүүн энэ талаар ямарваа нэгэн ойлголтгүй байна.

Логистик, агуулахын менежмент, бараа хадгалалтын асуудал нь дэлхийн олон улс оронд нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын чухал бүрэлдэхүүн хэсэг болгон судлагдаж ирсэн. Логистикийн онолын үндсийг гадаадын олон судлаачид хөгжүүлсэн бөгөөд тэдгээрийн судалгаанд бараа материалын урсгал, мэдээллийн урсгал, санхүүгийн урсгалыг нэгдсэн байдлаар удирдах нь байгууллагын үйл ажиллагааны үр ашигт чухал нөлөө үзүүлдэг гэж үздэг. Тухайлбал, Christopher (2016) логистикийг түүхий эд, бараа бүтээгдэхүүн, мэдээллийн





урсгалыг эх үүсвэрээс эцсийн хэрэглэгч хүртэл үр ашигтайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах цогц үйл ажиллагаа гэж тодорхойлсон бөгөөд нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг нь байгууллагын өрсөлдөх чадварт шууд нөлөөлдөг болохыг онцолсон.

Түүнчлэн Волгин (2015) бараа хадгалалтын логистик нь агуулахын үйл ажиллагааг зөв зохион байгуулах, бараа материалын хөдөлгөөнийг хянах, хадгалалтын хугацаа, чанарыг хамгаалах зэрэг асуудлыг хамардаг болохыг судалгаандаа тодорхойлсон байна.

Монгол Улсад логистик болон тээвэр, агуулахын удирдлагын асуудлаар зарим судалгаанууд хийгдсэн байдаг. Тухайлбал, Батсайхан (2019) логистикийн менежмент нь байгууллагын эдийн засгийн үр ашиг, зардлын хэмнэлт, нийлүүлэлтийн тогтвортой байдалд чухал нөлөө үзүүлдэг болохыг судалсан бол Өнөртүвшин (2020) Монгол Улсын тээвэр, логистикийн салбарын өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлагыг судалж, дэд бүтцийн хөгжил, мэдээллийн системийн уялдаа холбоо сул байгааг тодорхойлсон байна. (Б.Өнөртүвшин, 2020)

Мөн улсын нөөцийн удирдлагын талаар Монгол Улсын төрийн бодлогын баримт бичиг, тайлан, хууль эрх зүйн баримт бичгүүдэд тодорхой хэмжээнд тусгагдсан байдаг. Тухайлбал, Монгол Улсын нөөцийн тухай хуульд улсын нөөц нь нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, гамшиг, онцгой байдлын үед ашиглах стратегийн нөөц болохыг тодорхойлсон байдаг. Гэсэн хэдий ч улсын нөөцийн бараа хадгалалтын логистикийн менежмент, агуулахын зохион байгуулалт, мэдээллийн системийн уялдаа холбоог шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судалсан

судалгаа харьцангуй хязгаарлагдмал байна.

Иймээс улсын нөөцийн бараа хадгалалтын логистикийн тогтолцоог онолын болон практик талаас нь судалж, түүний үр ашиг, зохион байгуулалтыг сайжруулах арга замыг тодорхойлох шаардлага бий болж байна. Энэхүү судалгаа нь Монгол Улсын нөөцийн агуулахын аж ахуй, бараа хадгалалтын логистикийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, логистикийн орчин үеийн арга, технологийг нэвтрүүлэх боломжийг тодорхойлох зорилготойгоор хийгдэж байна.

### Судалгааны зорилго:

Монгол Улсын улсын нөөцөд логистикийн системийг нэвтрүүлэх шаардлагыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлж, түүний хэрэгжилтийн онол, арга зүйн шийдлийг боловсруулах.

### Судалгааны арга зүй:

- **Баримт бичгийн шинжилгээ:** Улсын нөөцийн тухай хууль, холбогдох бодлогын баримт бичгийг судалсан.

- **Харьцуулсан шинжилгээ:** Гадаадын нөөцийн удирдлагын логистикийн туршлагыг Монголын нөхцөлтэй харьцуулсан.

- **Судалгааны асуулга, ярилцлага:** Онцгой байдлын байгууллага, агуулахын удирдлагын ажилтнуудаас мэдээлэл цуглуулсан.

- **SWOT шинжилгээ:** Улсын нөөцийн логистикийн орчны давуу болон сул талыг тодорхойлсон.

### Судалгааны агуулга:

**Бараа хадгалалтын логистикийн онолын үндэс**

Бараа хадгалалтын логистик нь хангамжийн сүлжээний дотоод процесс бөгөөд бараа бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалах, ангилах, бүртгэх, түгээх

үйл ажиллагааг оновчтой удирдах зорилготой. Энэхүү процесс нь дараах үндсэн зарчимд тулгуурладаг.

- Цаг хугацааны зарчим – бүтээгдэхүүн хэрэгцээт цагтаа хүрэх ёстой;

- Зардлын оновчлол – хадгалалт, тээвэрлэлтийн зардлыг бууруулах;

- Аюулгүй байдал ба чанарын баталгаа – барааны бүрэн бүтэн байдлыг хангах;

- Мэдээллийн урсгалын уялдаа – дижитал мэдээллийн системийг ашиглан барааны хөдөлгөөнийг хянах.

### **Бараа хадгалалтын логистикийн хөгжлийн чиг хандлага**

Ирээдүйд дараах чиглэл давамгайлах төлөвтэй байна:

1. **Автомат агуулахын систем (AS/RS)** – робот, дрон ашиглан бараа хадгалах, гаргах;

2. **Ногоон логистик** – эрчим хүчний хэмнэлттэй, байгальд ээлтэй агуулах;

3. **Мэдээллийн нэгтгэл** – ERP болон WMS системийн уялдаа;

4. **АйТи ба хиймэл оюун ухаан** – эрэлт таамаглал, нөөцийн оновчлол.

Эдгээрийг хэрэгжүүлэхэд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, хүний нөөцийн чадавх чухал үүрэг гүйцэтгэнэ.

Энэхүү судалгааны ажлын онолын үндэс нь логистикийн онол, бараа хадгалалтын онол болон агуулахын менежментийн онолууд дээр тулгуурлаж байна. Логистик нь түүхий эд, бараа бүтээгдэхүүн, мэдээллийн урсгалыг эх үүсвэрээс эцсийн хэрэглэгч хүртэл үр ашигтай, зохион байгуулалттайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах үйл ажиллагааг хамардаг. Логистикийн удирдлагын үндсэн зорилго нь зардлыг бууруулахын зэрэгцээ хэрэглэгчийн хэрэгцээг хангах, нийлүүлэлтийн

сүлжээний үр ашгийг нэмэгдүүлэхэд оршино.

Агуулахын менежмент болон бараа хадгалалтын онол нь бараа материалын хадгалалт, ангилал, байршил, хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах, барааны чанар, аюулгүй байдлыг хадгалах зарчимд тулгуурладаг. Агуулахын зөв зохион байгуулалт нь бараа материалын эргэлтийг хурдасгах, хадгалалтын зардлыг бууруулах, логистикийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй.

Мөн нийлүүлэлтийн сүлжээний удирдлагын онолын хүрээнд агуулах нь бараа бүтээгдэхүүний урсгалын зангилаа цэг болж, үйлдвэрлэл, тээвэрлэлт, түгээлтийн үйл ажиллагааг уялдуулах стратегийн ач холбогдолтой гэж үздэг. Иймээс агуулахын менежмент нь зөвхөн хадгалалтын функцээр хязгаарлагдахгүй, харин логистикийн системийн чухал бүрэлдэхүүн хэсэг болдог.

Дээрх онолын үндэслэлд тулгуурлан улсын нөөцийн бараа хадгалалтын төвийг үр ашигтай, зохион байгуулалттайгаар төлөвлөн байгуулах шаардлагатай юм. Гадаад улс орнуудын туршлагаас харахад агуулахын үйл ажиллагаанд орчин үеийн технологи, автоматжуулалт, мэдээллийн системийг нэвтрүүлэх нь бараа материалын хяналт, бүртгэл, аюулгүй байдлыг сайжруулахад чухал нөлөө үзүүлдэг байна.

Эдгээр онолын үндэслэлд тулгуурлан улсын нөөцийн бараа хадгалалтын төвийг үр ашигтай, зохион байгуулалттайгаар төлөвлөн байгуулах шаардлагатай юм. Мөн гадаад улс орнуудын туршлагаас харахад агуулахын логистик, нөөцийн удирдлагыг орчин үеийн технологи, системтэй уялдуулан хэрэгжүүлснээр хадгалалтын үр ашиг, аюулгүй байдал,





зохион байгуулалт сайжирдаг болох нь ажиглагддаг. Тухайлбал:

### **Зарим гадаад орнуудын туршлага, үйл ажиллагаа:**

#### **1. АНУ:**

○ АНУ-ын "FEMA" (Федерал Эмерженсийн Менежмент Агентлаг) болон бусад холбооны агентлагууд улсын нөөцийг шаардлагатай үед хурдан бөгөөд үр дүнтэй түгээхэд зориулсан логистикийн системүүдийг хөгжүүлсэн. Эдгээр нь бараа материал хадгалахад илүү үр өгөөжтэй, ашигтай бөгөөд тухайн жилийн төсөв, төлөвлөгөөндөө сууж өгсөн байдаг.

○ АНУ-ын улсын нөөц нь голчлон төрийн нөөцийн агуулах, зэвсэг, хүнс, эмнэлгийн хангамж, түлш зэрэг төрөл бүрийн барааг агуулдаг.

○ Логистикийн хувьд Хүнд даацын машинууд, агаарын болон тэнгисийн тээвэрлэлтийг ашигладаг бөгөөд онцгой нөхцөлд түргэн хариу үзүүлэх чадвартай.

#### **2. Хятад:**

○ Хятад улс нь улсын нөөцөө төрийн түвшинд системтэйгээр удирддаг бөгөөд зөвхөн хүнс, эрүүл мэндийн тусламжийн зүйлс бус, шатахуун, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, стратегийн ашигт малтмал зэрэг нөөцийг хадгалдаг.

○ Хятад улсын логистикийн дэд бүтэц өндөр хөгжсөн бөгөөд төмөр зам, авто зам, агаарын тээвэр, болон тэнгисийн тээвэр ашиглан нөөцийг улс даяар тараах арга хэрэгсэлүүдийг хэрэглэдэг.

#### **3. Орос:**

○ Орос улсын "Российский резерв" (Оросын улсын нөөц) нь улсын эрчим хүчний эх үүсвэр, хүнсний нөөц, эмнэлгийн тоног төхөөрөмж зэрэг зүйлсийг хадгалдаг.

○ Логистикийн хувьд Орос нь том талбайтай, олон бүс нутагтай тул тээвэрлэх ажиллагааг төмөр зам,

агаарын тээвэр, болон авто зам ашиглан зохион байгуулдаг.

○ "Хүн ам, нутаг дэвсгэрийг байгалийн болон хүнээс үүдэлтэй онцгой байдлаас хамгаалах тухай" Холбооны хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Оросын Улсын Засгийн газар:

○ Байгалийн болон хүнээс үүдэлтэй онцгой байдлыг арилгах зорилгоор холбооны гүйцэтгэх байгууллагын материаллаг нөөцийн нөөцийг байгуулах, ашиглах, нөхөн сэргээх хавсралт дүрмийг батална.

○ Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой зардлыг санхүүжүүлэх нь дээрх зорилгоор Холбооны төсвөөс гүйцэтгэх эрх мэдлийн холбооны байгууллагуудад олгосон төсвийн хэмжээнд зарцуулна.

○ Материаллаг нөөцийн нөөцийг холбооны гүйцэтгэх байгууллага бүрдүүлнэ.

○ Материаллаг нөөцийн нөөцийг онцгой байдлын урьдчилан таамагласан төрөл, цар хүрээ, тэдгээрийг арилгах ажлын тооцоолсон хэмжээ, онцгой байдлыг арилгахад боломжийнхоо хэрээр ашиглахад үндэслэн бүрдүүлнэ.

○ Материаллаг нөөцийн нөөцийг Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн дагуу тэдгээрийг хадгалах зориулалттай байгууламжид байрлуулна.

○ Хүний амь нас, эрүүл мэндэд заналхийлж буй шууд аюулыг арилгах онцгой нөхцөл байдлыг шийдвэрлэхэд яаралтай аврах болон бусад яаралтай ажиллагааны явцад материаллаг нөөцийн нөөцийг ашиглана. Төрийн материалын нөөцөөс бусад материалын нөөцийг өндөр сэрэмжлүүлгийн дэглэм нэвтрүүлэхэд ашиглаж болно.

○ Оросын Холбооны Улсын Иргэний хамгаалалт, Онцгой байдал, байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах яам нь

материаллаг нөөцийн нөөцийг бий болгох, хадгалах, ашиглах, нөхөн сэргээх ажлыг арга зүйн арга зүйн удирдлагыг явуулна.

#### 4. Европын холбоо:

○ Европын холбооны улс орнууд нь улсын нөөцийн логистикийг хамтран зохион байгуулж, нэгтгэн, улс орнуудад хомсдол үүсэх үед тусламж үзүүлэх тогтолцоог бий болгосон.

○ Европын комисс нь гамшигийн нөхцөлд Европын орнуудын хооронд нөөц, хүнсний бүтээгдэхүүн, эмнэлгийн тусламжийг түргэн хүргэхээр хуулиар зохицуулсан логистикийн сүлжээг хөгжүүлсэн.

#### 5. Япон:

○ Япон улс нь байгалийн гамшигт өртөх өндөр эрсдэлтэй учир улсын нөөцийн логистикийг сайн зохион байгуулдаг.

○ Япон улсын онцгой байдлын агентлагууд нь эрүүл мэндийн хангамж, хүнсний нөөцийг ойр дотнын бүс нутагт хүргэхээр томоохон логистикийн сүлжээг хөгжүүлсэн.

Эдгээр улсууд нь улсын нөөцийн логистикийн үр дүнтэй системийг хөгжүүлсэн бөгөөд шаардлагатай үед улс орон даяар түргэн шуурхай хариу үйлдэл үзүүлэхэд шаардлагатай бүхий л логистикийн арга хэрэгслүүдийг ашигладаг.

### 1. Улсын нөөцийн бараа хадгалалтын логистикийн өнөөгийн байдал

Монгол Улсад сүүлийн жилүүдэд худалдаа, үйлдвэрлэлийн өсөлттэй уялдан бараа хадгалалтын хүчин чадал нэмэгдэж байгаа боловч дараах хүндрэлүүд ажиглагддаг.

- Агуулахын технологи, автоматжуулалт сул хөгжсөн

- Зам, тээврийн дэд бүтцийн холболт муу

- Эрэлт, нийлүүлэлтийн мэдээллийн систем хангалтгүй

- Эрчим хүч, дулаан, хөргөлтийн зардал өндөр

Улсын нөөцийн тогтолцоо нь улс орны аюулгүй байдал, эдийн засгийн тогтвортой байдал, гамшиг ослын үед хүн амын хэрэгцээг хангах стратегийн ач холбогдол бүхий систем юм. Иймээс улсын нөөцийн бараа, материалын хадгалалт, хамгаалалт, түгээлтийн үйл ажиллагаа нь өндөр түвшний зохион байгуулалт, үр ашигтай логистикийн менежмент дээр суурилсан байх шаардлагатай байдаг. Гэвч өнөөгийн нөхцөл байдлыг судлан үзэхэд улсын нөөцийн бараа материалын хадгалалтын тогтолцоонд логистикийн менежментийн зарчим нэвтрээгүй, үр ашиг багатай зохион байгуулалт давамгайлж байгаа нь ажиглагдаж байна.

Улсын нөөцийн бараа материалын агуулахын байршил, бүтэц зохион байгуулалт нь орчин үеийн логистикийн шаардлагад бүрэн нийцэхгүй байна. Олон агуулахууд нь тухайн бүс нутгийн тээврийн зангилаа, авто болон төмөр замын сүлжээтэй уялдаа багатай байрласан байдаг. Үүний улмаас бараа материалыг богино хугацаанд шилжүүлэх, гамшиг ослын үед шуурхай хүргэх боломж хязгаарлагддаг. Логистикийн онолын хувьд агуулахын байршлыг тодорхойлохдоо тээврийн зардал, хүргэлтийн хугацаа, хэрэглэгчид хүрэх зай зэрэг хүчин зүйлсийг тооцдог боловч улсын нөөцийн одоогийн байршлын хувьд ийм оновчлол хангалттай хийгдээгүй байна.

Агуулахын дотоод зохион байгуулалт, бараа материалын хадгалалтын технологи нь мөн логистикийн орчин үеийн шаардлагаас хоцрогдсон байдал ажиглагддаг. Зарим агуулахад бараа материалыг





стандартын дагуу ангилж байрлуулах, эргэлтийн зарчим (FIFO, LIFO гэх мэт)-ийг мөрдөх, агуулахын орон зайг оновчтой ашиглах зэрэг логистикийн үндсэн зарчмууд (лса, 2022) хангалттай хэрэгждэггүй байна.

Үүний улмаас зарим бараа материалын хадгалалтын хугацаа дуусах, чанар муудах, нөөцийн бодит мэдээлэл алдагдах зэрэг эрсдэл бий болж байна.

Мэдээллийн удирдлагын системийн хувьд мөн тодорхой сул талууд ажиглагддаг. Улсын нөөцийн бараа материалын бүртгэл, хяналт нь зарим тохиолдолд уламжлалт буюу гараар хөтлөх системд тулгуурласан хэвээр байна. Энэ нь нөөцийн бодит үлдэгдэл, байршил, эргэлтийн мэдээллийг шуурхай тодорхойлох боломжийг хязгаарладаг. Орчин үеийн логистикийн системд агуулахын удирдлагын систем (Warehouse Management System), мэдээллийн нэгдсэн сан, автомат бүртгэлийн технологи өргөн ашиглагддаг боловч улсын нөөцийн салбарт ийм системүүдийн хэрэглээ хангалттай түвшинд нэвтрээгүй байна.

Мөн хүний нөөцийн чадавхтай холбоотой асуудал тодорхой хэмжээнд ажиглагддаг. Логистикийн мэргэжлийн мэдлэг, ур чадвартай боловсон хүчин харьцангуй цөөн, агуулахын үйл ажиллагааг уламжлалт арга барилаар удирдах хандлага давамгайлж байна. Энэ нь логистикийн орчин үеийн менежментийн арга, технологийг нэвтрүүлэхэд саад болж байгаа нэг хүчин зүйл болж байна.

Иймээс улсын нөөцийн системийн үр ашиг, шуурхай ажиллагааг дээшлүүлэхийн тулд логистикийн менежментийн орчин үеийн арга, технологийг үе шаттайгаар нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай гэж үзэж байна.

Тодруулбал агуулахын байршлыг логистикийн судалгаанд үндэслэн оновчтой болгох, агуулахын дотоод зохион байгуулалтыг стандартчлах, мэдээллийн нэгдсэн системийг бий болгох, бараа материалын эргэлтийн менежментийг сайжруулах, мөн логистикийн мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэх нь улсын нөөцийн системийн үр ашгийг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх боломжтой юм.

Иймд улсын нөөцийн бараа материалын хадгалалт, түгээлтийн үйл ажиллагаанд логистикийн менежментийг нэвтрүүлэх нь зөвхөн байгууллагын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх төдийгүй улс орны гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах стратегийн ач холбогдолтой асуудал болох нь энэхүү шинжилгээнээс харагдаж байна.

### **Бараа хадгалалтын логистикийн өнөөгийн байдал хийсэн шинжилгээний үр дүн:**

Судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсын улсын нөөцийн удирдлага, агуулахын аж ахуй, бараа хадгалалтын логистикийн үйл ажиллагаанд тодорхой давуу талууд байгаагаас гадна хэд хэдэн тулгамдсан асуудал байгааг тогтоов.

1. Улсын нөөцийн бүртгэл, хяналтын мэдээллийн системийн хөгжил хангалтгүй байна. Одоогийн нөхцөлд нөөцийн бүртгэл, агуулахын мэдээлэл нь бүрэн автоматжуулагдаагүй, бодит цагийн хяналт, мэдээллийн нэгдсэн сан бүрэн хөгжөөгүй байгаа нь нөөцийн хөдөлгөөн, үлдэгдэл, хадгалалтын нөхцөлийг шуурхай хянах боломжийг хязгаарлаж байна. Үүний улмаас удирдлагын шийдвэр гаргалт удаашрах, мэдээллийн уялдаа холбоо сулрах зэрэг сөрөг нөлөө ажиглагдаж байна.

2. Улсын нөөцийн логистикийн сүлжээ нь бүсчилсэн зохион байгуулалт хангалтгүй байна. Агуулахуудын байршил, тээвэрлэлтийн дэд бүтэц, эрсдэл өндөртэй бүс нутгуудын уялдаа хангалтгүй байгаа нь гамшиг, онцгой байдлын үед нөөцийн бараа материалыг шуурхай хүргэхэд хүндрэл учруулж болзошгүй байна.

3. Улсын нөөцийн байгууллагуудын хүний нөөцийн чадавх харилцан адилгүй байгааг судалгаагаар тогтоолоо. Зарим тохиолдолд логистик, агуулахын удирдлага, мэдээллийн системийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин дутмаг байгаа нь орчин үеийн удирдлагын арга, технологийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж байна.

4. Эрсдэлийн удирдлагын төлөвлөлт бүрэн системжээгүй байна. Гамшиг, эдийн засгийн хямрал, нийлүүлэлтийн тасалдал зэрэг эрсдэлийн үед хэрэгжүүлэх урьдчилсан төлөвлөгөө, хувилбарчилсан бэлтгэл хангалтгүй байгаа нь улсын нөөцийн системийн шуурхай хариу арга хэмжээ авах чадварт нөлөөлж байна.

Иймээс улсын нөөцийн удирдлагын тогтолцоог сайжруулахын тулд мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх, логистикийн бүсчилсэн сүлжээг оновчтой зохион байгуулах, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, эрсдэлийн удирдлагад суурилсан төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх шаардлагатай байна.

Логистикийг Улсын нөөцийн бараа материалын үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь хэд хэдэн үр дүнтэй холбоотой байх боломжтой:

1. **Зардлын хэмнэлт:** Логистикийн сайн зохион байгуулалт нь зардлыг бууруулах, нөөцийг аюулгүй хадгалах болон хурдан түгээх боломжийг олгоно.

2. **Цаг хугацааны хэмнэлт:** Логистикийн дэвшилтэт аргачлал, мэдлэг нь нөөцийг илүү хурдан байршуулах, ачаа шилжүүлэх үйл явцыг хялбаршуулах боломжтой.

3. **Эдийн засгийн тогтвортой байдал:** Үндэсний стратегийн нөөцийг зөв зохион байгуулах нь эдийн засгийн хувьд тогтвортой байдал, эрсдлийг бууруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.

4. **Гамшгийн үеийн бэлэн байдал:** Логистикийн системийг сайжруулснаар, байгалийн гамшиг болон бусад аюулт үзэгдлийн үед нөөцийн зохион байгуулалт, нийлүүлэлт нь илүү хурдан, үр дүнтэй болж, аюулгүй байдлыг хангана.

### Дүгнэлт

Энэхүү судалгаагаар Монгол Улсын улсын нөөцийн бараа хадгалалтын үйл ажиллагаанд логистикийн менежмент нэвтрүүлэх шаардлага, боломж, үр нөлөөг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тодорхойлов. Судалгааны зорилгын хүрээнд улсын нөөцийн агуулахын аж ахуй, бараа хадгалалтын үйл ажиллагааны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийхэд логистикийн систем нэвтрээгүй, мэдээллийн нэгдсэн систем дутмаг, агуулахын байршил болон зохион байгуулалт оновчгүй, хүний нөөцийн чадавх жигд бус, эрсдэлийн удирдлагын төлөвлөлт сул зэрэг нийтлэг хүндрэлүүд байгааг тогтоолоо.

Судалгааны үр дүнгээс үзэхэд логистикийн менежментийн зарчим, арга технологийг улсын нөөцийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх нь нөөцийн удирдлагын үр ашиг, шуурхай байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болох нь батлагдсан. Ялангуяа агуулахын удирдлагын систем, мэдээллийн нэгдсэн сан, бүсчилсэн логистикийн сүлжээ, бараа материалын эргэлтийн оновчтой удирдлага зэрэг





шийдлүүдийг хэрэгжүүлэх нь нөөцийн бодит хяналт, шийдвэр гаргалтыг сайжруулах ач холбогдолтой байна.

Мөн олон улсын туршлагатай харьцуулсан шинжилгээнээс харахад хөгжингүй орнууд улсын нөөцийн логистикийг өндөр түвшинд хөгжүүлж, автоматжуулалт, дижитал систем, уялдаа холбоотой тээвэрлэлтийн сүлжээг ашиглан гамшгийн үед шуурхай хариу арга хэмжээ авах чадавхийг бүрдүүлсэн байна. Энэ нь Монгол Улсад логистикийн тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлэх бодит шаардлага байгааг нотолж байна.

Иймд улсын нөөцийн бараа хадгалалтын үйл ажиллагаанд логистикийн нэгдсэн системийг нэвтрүүлэх нь зөвхөн үйл ажиллагааны зардал, хугацааг бууруулах төдийгүй улсын аюулгүй байдал, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах стратегийн ач холбогдолтой гэж дүгнэв. Энэхүү судалгаа нь улсын нөөцийн логистикийн менежментийг боловсронгуй болгох онол, арга зүйн суурь болох бөгөөд цаашид бодлогын түвшинд хэрэгжүүлэх шийдвэр гаргалтад ашиглах боломжтой юм.

### Санал

Энэхүү судалгааны үр дүн, дүгнэлтэд тулгуурлан Улсын нөөцийн бараа хадгалалтын үйл ажиллагаанд логистик нэвтрүүлэх чиглэлээр дараах саналуудыг дэвшүүлж байна. Үүнд:

**Мэдээллийн нэгдсэн систем нэвтрүүлэх** - Улсын нөөцийн бараа материалын бүртгэл, хяналт, хөдөлгөөнийг бодит цагийн горимд удирдах боломжтой агуулахын удирдлагын систем, нэгдсэн мэдээллийн санг үе шаттайгаар нэвтрүүлэх шаардлагатай. Ингэснээр шийдвэр гаргалтын хурд, мэдээллийн үнэн зөв байдал сайжирна. Агуулахын дотоод зохион байгуулалт,

хадгалалтын технологийг олон улсын стандартын дагуу шинэчилж, автоматжуулалтын шийдлүүдийг нэвтрүүлэх шаардлагатай.

**Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх** - Логистик, агуулахын менежмент, мэдээллийн системийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог бий болгох нь чухал. Энэ хүрээнд дотоод, гадаад сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай.

**Эрсдэлийн удирдлагад суурилсан төлөвлөлт хэрэгжүүлэх** - Гамшиг, нийлүүлэлтийн тасалдал, эдийн засгийн хямрал зэрэг эрсдэлийн нөхцөлд хэрэгжүүлэх хувилбарчилсан төлөвлөгөө боловсруулж, тогтмол дадлага, сургуулилалтаар баталгаажуулах хэрэгтэй. Логистикийн дэд бүтэц, технологийн шинэчлэлд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааны механизм бий болгох нь хөрөнгө оруулалт, үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой байна.

### Ашигласан материал

1. С. Батсайхан, (2019). *Логистикийн менежмент ба түүний эдийн засагт үзүүлэх нөлөө*. Улаанбаатар: Монголын Эдийн Засгийн Академи.
2. Б. Өнөртүвшин, (2020). *Монгол Улс дахь тээвэр, логистикийн хөгжил*. Улаанбаатар: Тээвэр, логистикийн үндэсний академи.
3. Волгин, В. В. (2015). *Логистика хранения товаров*. Москва.
4. Тебекин, А. В. (2021). *Логистика*. Москва.
5. Christopher, M. (2016). *Logistics and Supply Chain Management* (5th ed.). London: Pearson.
6. Rushton, A., Croucher, P., & Baker, P. (2017). *The Handbook of*

*Logistics and Distribution Management*.  
London: Kogan Page.

7. JICA. (2022). *Logistics Infrastructure Development Report for Mongolia*.

8. Монгол Улсын Их Хурал. (2011). *Улсын нөөцийн тухай хууль*.

9. Онцгой байдлын ерөнхий газар. (2023). *Үйл ажиллагааны тайлан*.

10. П. Даш, (2025). *Гамшиг судлалын шинжлэх ухаан*. Улаанбаатар.



ВИРТУАЛ ХӨРӨНГӨ (КРИПТОВАЛЮТ)-ИЙН ЭРХ ЗҮЙН  
ЗОХИЦУУЛАЛТ

## LEGAL REGULATION OF VIRTUAL ASSETS (CRYPTOCURRENCY)

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠨ ᠶ᠋ᠢᠨᠠᠭᠢᠨᠠᠵᠤᠯᠠᠭᠤ ᠶ᠋ᠢᠨ  
ᠰᠤᠬᠤᠭᠠᠷᠠᠭᠠᠴᠢᠭᠠᠭ**Б.Лхагварাগчаа**

Дотоод хэргийн их сургуулийн Гадаад хэлний институтийн захирал, доктор (Ph.D), дэд профессор, цагдаагийн хошууч

**B. Lkhagvaragchaа**

University of Internal Affairs Director of the Institute of Foreign Languages, Doctor (Ph.D.), Associate Professor, Police Major

\*хариуцлагатай зохиогч: ragchaа1215@gmail.com

**Хураангуй:** Орчин үеийн техник, технологийн дэвшлийн хөгжлийг даган цахим орчны хэрэглээ нэмэгдэн, олон төрлийн цахим төлбөр тооцооны хэрэгсэл бий болж байгаагийн нэг илрэл нь виртуал хөрөнгийн нэг хэлбэр криптовалюта юм. Дэлхийд криптовалютын нэр хүндтэй койн болох биткойн анх гарч, түүнийг дагасан олон төрлийн криптовалюта дэлгэрч, олон улсад хэрэглэгдэж эхэлснээс хойш гэмт хэргийн шинжтэй үйлдлүүд гарч, зохион байгуулалттайгаар үйлдэгдэх нь ихсэх чиг хандлагатай байна.

Виртуал хөрөнгө (криптовалюта)-ийн зах зээл, эрх зүйн зохицуулалт нь дэлхийн олон улсад шинэ тутам үүсэж байгаа зохицуулагдах ёстой салбарын нэг юм. Иймд виртуал хөрөнгийн олон улсын зах зээл, түүнтэй холбоотой болзошгүй эрсдэлүүдийг судлан, Монгол Улсад цаашид баримтлах стратеги бодлого, хууль эрх зүйн орчинг боловсруулах шаардлага үүсч виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан ч бүрэн хэмжээний эрх зохицуулалт болж чадаагүй байна. Энэхүү өгүүлэлд виртуал хөрөнгө (криптовалюта)-ийн тухай ойлголт, Монгол Улс болон олон улс дахь эрх зүйн зохицуулалтын талаар дурдсан болно.

**Abstract:** Cryptocurrency, a sort of virtual capital, is an example of how the electronic environment is becoming more popular as a result of the growth of current techniques and technology, as well as the advent of different electronic payment systems. Since the first appearance of Bitcoin, the world's most famous cryptocurrency coin, and the expansion and international use of numerous cryptocurrencies that followed, there has been an increase in organized crime.

The market and legal regulation of virtual assets (cryptocurrency) is one of the emerging fields of international regulation. As a result, there is an urgent need to analyze the worldwide market for virtual assets and the potential risks associated with it, as well as to develop a long-term strategic policy and regulatory framework for Mongolia. Rights are not protected. The National Assembly approved it on December 17, 2021, although it was not fully regulated.

This article discusses the concept of virtual assets (cryptocurrencies) and their legal regulations in Mongolia and many other countries.

**Түлхүүр үг (keywords):** Мөнгө, хууль, Монгол банк, фатф, нууцлал, санхүү, зөвшөөрөл, хориглох

**Key words:** Money, law, Bank of Mongolia, fatf, privacy, finance, authorization, and prohibition



## Удиртгал

Цахим орчинд технологийн дэвшлүүд хурдацтай хөгжин шинэ төрлийн үйлчилгээ нэвтэрч, эдийн засаг, санхүү, мөнгөний бодлогод инноваци болж үр ашигтай байдал, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж буй хэдий ч нөгөө талаараа нийгэмд аюултай, гэмт болон террорист бүлэглэлд хууль бус үйлдлээ санхүүжүүлэх арга замуудыг бий болгож төрийн хяналтаас гадуур гэмт үйл ажиллагаандаа криптовалютыг ашиглаж байгаа нь энэ талаар сонирхон судалсан судалгааны ажлын тайлан мэдээнээс харж болно.

Криптовалют нь шинэ технологийн үндсэн дээр үүссэн бөгөөд цаашид ч техник, технологийн хөгжлийг дагаад шинээр санхүүгийн үйлчилгээний тоо ихсэж, түүнийг дагасан эрх зүйн зохицуулалтууд нэмэгдэх хандлагатай байна. Криптовалютын нэг төрөл болох блокчэйн технологид суурилсан биткойноор Монгол Улсад албаны ёсны бараа, үйлчилгээний төлбөрт ашигладаггүй, харин иргэд хоорондоо арилжааны хэрэгсэл болгон ашиглаж байна. Өнөөгийн байдлаар банк, санхүүгийн салбарын зохицуулагч байгууллага бүх төрлийн криптовалютыг төлбөрийн хэрэгсэл гэж үздэггүй, үүнд зөвшөөрөл олгодоггүй, үйл ажиллагааг хянан зохицуулдаггүй боловч Монгол Улсад криптовалютын арилжаа хийдэг хэд хэдэн цахим бирж үйл ажиллагаа явуулж байна.

Дэлхийд биткойн анх гарч, түүнийг дагасан олон төрлийн криптовалют дэлгэрч, олон улсад хэрэглэгдэж эхэлснээс хойш гэмт хэргийн шинжтэй үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн тоо, тэдгээрийн үйлдэж буй гэмт үйлдэл, олон улсын стандартад нийцсэн хяналт, зохицуулалтгүйгээр өмч хөрөнгийг

нуун дарагдуулах, хөрөнгийн эс үүсвэрийг нууцлах, татвараас зайлсхийх, мөнгө угаах болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, терроризмыг санхүүжүүлэх гэмт үйлдлүүд нэмэгдсээр байна. Криптовалютын зах зээл, эрх зүйн зохицуулалт нь дэлхийн олон улсад шинэ тутам үүсэж байгаа зохицуулагдах ёстой салбарын нэг юм.

## Виртуал хөрөнгө ба криптовалютын тухай ойлголт

Криптовалют нэг төрөл болох биткойныг анх 2008 онд Япон Улсын иргэн Сатоши Накамото нэртэй автор (программист)-ын бичсэн загвар, томъёоны дагуу явагдаж “Аи Ти” компани, хувь хүмүүс олборлон зах зээлд нийлүүлж эхэлсэн байна.

Виртуал хөрөнгийг хаалттай виртуал хөрөнгийн нэгж, нэг чиглэлт виртуал хөрөнгийн нэгж, хоёр чиглэлт виртуал хөрөнгийн нэгж гэсэн гурван төрөлд ангилж үзнэ.

Хаалттай виртуал хөрөнгө гэж эдийн засагт бодитоор оршин байх боломжгүй зөвхөн виртуал хаалттай систем дотор зарцуулагдах боломжтой хөрөнгийг ойлгоно. Энэ хөрөнгийг зөвхөн онлайн видео тоглоомд ашиглах боломжтой (Strauss, 2010) юм.

Нэг чиглэлт виртуал хөрөнгийн нэгж гэж виртуал орчинд фиат мөнгөөр худалдаж авах боломжтой ба харин худалдаж авсан виртуал хөрөнгийн нэгжээ буцаан мөнгө болгох боломжгүй. Энэ ангилал дахь виртуал хөрөнгийн нэгжээр бодит бараа бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авч болдог.

Хоёр чиглэлт виртуал хөрөнгийн нэгж гэж хэрэглэгч фиат мөнгөөр виртуал хөрөнгийн нэгж гэж хэрэглэгч фиат мөнгөөр виртуал хөрөнгийн нэгж худалдан авч болох ба хүсвэл авсан виртуал хөрөнгийн нэгжээ буцааж





худалдан фиат мөнгө болгох боломжтой виртуал хөрөнгийн нэгжүүд юм. Энэ ангилалд виртуал хөрөнгийн нэгжээр бодит бараа бүтээгдэхүүн үйлчилгээг худалдан авах төлбөр тооцооны хэрэгсэл болгон ашиглах бүрэн боломжтой юм.

Криптовалют нь блокчэйн технологид тулгуурлан бүтээсэн цахим орчинд тоон хэлбэрээр байрших өндөр нууцлал бүхий цахим тооцооны хэрэгслийн нэг хэлбэр юм. Гэхдээ доллар, евро, иен зэрэг валютаас ялгаатай нь криптовалютыг аль нэг улсын төв банк эсвэл санхүүгийн байгууллагаас гаргадаггүй бас хэвлэдэггүй бөгөөд ямар нэгэн дундын зохицуулагчгүй оршиж байдаг биет бус валют юм. Криптовалютын цахим гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдал нууцлалыг хангахад криптограф ашигладаг. Энэ бол тодорхой мэдээллийг тайлахад хэцүү код болгон хөрвүүлэх математикийн процесс юм. Дэлхийн хоёрдугаар дайны үед нууц мэдээллийг шифрлэх хэрэгцээ шаардлагын дагуу криптографыг ашиглаж байсан бол харин цахим эринд математик онолын элементүүд болон компьютерын тусламжтайгаар криптограф цахим мэдээлэл, харилцаа холбоо болон мөнгөний нууцлал, аюулгүй байдлыг хангах аргачлал болсон байна. Тоо, үсгийн нууцлалтай мэдээлэл шифрлэсэн байдгаас гадна, бүх мэдээлэл нь дэлхий даяар сервер компьютеруудад хадгалагддаг тул цахим халдлагаар хулгайлах, шинээр хуурамчийг бий болгох боломжгүй. Тус валютыг анх зах зээл дээр санал болгон гаргахдаа тодорхой тоон хэмжээ тогтоодог ба тэдгээрийг компьютер болон тусгай зориулалтын төхөөрөмж ашиглан зориулалтын программ хангамжийн тусламжтайгаар олборлох (mining) байдлаар эзэмшдэг. Мөн тус үйл явц нь тухайн криптовалютын

арилжааг хянаж баталгаажуулдаг нь түүний онцлог давуу тал юм.


Криптовалютын нууцлалын технологи болох блокчейн технологи нь 1991 онд бүтээгдсэн бөгөөд 2008 оноос эхлэн олон нийт мэдэх болсон юм. Блокчейн технологи гэдэг нь блок хэсгүүд нэг нэгэнтэйгээ гинжин хэлхээ байдлаар холбогдон дамжуулалт үүсгэдэг мэдээллийн сан юм. Мэдээлэл нь блокчейн системд байх блок руу бүртгэгддэг ба мэдээлэл тус бүр бүртгэгдсэн хугацааг давхар бүртгэдэг байна. Системд бүртгэгдсэн бүх үйлдэл кодлогдсон хэлбэрээр блок хэсэгт байрших бөгөөд блокууд тодорхой өгөгдсөн багтаамжтай, блокийн багтаамж дүүрсэн тохиолдолд дахин шинэ блок нээгдэж шинэ блок нь өмнөх блокийн мэдээлэлтэй холбогдсоноороо гинжин хэлхээ үүснэ. Тухайн блокод нэвтрэхэд hash (хэш) гэж нэрлэдэг урт үргэлжилсэн тоо, үсэг холилдсон нууцлал бүхий код буюу хурууны хээ гэж нэрлэж болох кодоор нэвтэрнэ. Нэг блокийн мэдээлэлд хийсэн аливаа өөрчлөлт тухайн блокийн хэшийг өөрчилдөг ба улмаар хэлхээнд холбогдсон бусад блокийн хэшийг өөрчлөхөд хүргэдэг байна. Энэ нь блокчейн технологийн гол нууцлалын онцлог юм. Блокт байгаа кодлогдсон бүх гүйлгээний мэдээллийг системд холбогдсон бүх хэрэглэгч нар харах боломжтой ба нэг блок үүсэх хугацаа 10 орчим минут болдог байна.

Блокчейн технологи нь аливаа гүйлгээ, шилжүүлэг хийхэд завсрын зуучлагч буюу банк, санхүүгийн байгууллага шаардлагагүй бөгөөд гүйлгээнд оролцогчид хоорондоо шууд харьцах буюу peer-to-peer (тус тооцоолол нь компьютерын хэрэглээний ойлголт ба шууд компьютероос компьютер луу буюу хувийн компьютер нь төв серверийг тойрч бусад компьютеруудтай шууд

хамтран ажиллах боломжийг хангаж чаддаг) ([www.geeksforgeeks.org](http://www.geeksforgeeks.org)) гүйлгээ хийдгээрээ онцлог юм. Мөн төлбөр тооцоо хийж буй хүний хувийн мэдээлэл нууцлагддаг, хэн нэгэн зохицуулагчийн зүгээс хяналт багатай зэргээрээ онцлогтой. Мөнгийг анх төв банк хэвлээд, харин гүйлгээг

санхүүгийн байгууллагуудаар дамжуулж хийдэг, сэжигтэй гүйлгээг хянадаг уламжлалт ойлголтыг криптовалют эвдсэн санхүүгийн гүйлгээ байсан нь олны анхаарлыг татаж эхэлсэн байна.

Блокчейн технологийн үйлдлийг схемээр харуулбал.



Зураг 1: Блокчейн технологийн үйлдэл

Эх сурвалж: Satoshi Nakamoto "Bitcoin : A Peer-to-peer Electronic Cash System" 2008, p.8.

## Криптовалюттай холбоотой Монгол Улс дахь хууль, эрх зүйн зохицуулалт

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн зорилго нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийг бүртгэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих, холбогдох эрх үүргийг нь тодорхойлохтой холбоотой холбогдсон харилцааг зохицуулах байна. Харин Монгол Улсад бүртгэлтэй компани Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улс руу энэ хуульд заасан виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг

зохицуулах бөгөөд виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч болон түүний харилцагчийн хооронд хийгдсэн гэрээ, хэлцлээс үүсэх маргаантай холбогдсон харилцааг зохицуулахгүй байна.

Хүн, хуулийн этгээд гэрээ, хэлцэлд оролцогчийн нэрийн өмнөөс, тэдгээрийн захиалгаар, эсхүл тэдгээрт зориулан үзүүлэх виртуал хөрөнгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамааруулахаар хуульд тусгаж өгсөн байна. Үүнд:

- Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих;
- Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд нь арилжих;





- Виртуал хөрөнгийг шилжүүлэх;
- Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах;
- Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх зэрэг байна.

Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд Санхүүгийн зохицуулах хороо зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд хяналт тавихаар зохицуулсан байна.

Монгол Улсын мөнгөний эргэлтийн бодлогыг зохицуулахдаа Төв банк Монгол банкны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкны үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөл, Монголбанкны үйлчилгээний хураамж, шимтгэлийн ерөнхий нөхцөл, Үндэсний цахим гүйлгээний төвийн төлбөрийн картын сүлжээний дүрэм, Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам, Дансны нэгдсэн дугаарлалтын заавар, Цахим мөнгөний журам, Их дүнтэй төлбөрийн системийн журам, Санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг үнэлэх аргачлал, Төлбөрийн картын журам, Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам, Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам, Төлбөрийн системийн хяналтын бодлого, Клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам, Үндэсний төлбөрийн системийн зөвлөлийн дүрэм, Төлбөрийн системийн тайлан гаргах заавар, АСН (автомат клиринг хаус) системийн хөлс, хураамж, шимтгэл, АСН системийн дүрэм болон Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан 2020.06.17-

ны өдрийн Үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлд түр өөрчлөлт оруулах тухай, 2020.03.30-ны өдрийн Үйлчилгээний хөлс, шимтгэлийн ерөнхий нөхцөлд түр өөрчлөлт оруулах тухай, 2020.03.13-ны өдрийн Дансны нэгдсэн дугаарлалт нэвтрүүлэх тухай, 2020.03.03-ны өдрийн Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл шинэчлэн баталсан тушаалд нэмэлт оруулах тухай, 2019.06.13-ны өдрийн Төлбөрийн системийн тайлан гаргах заавар батлах тухай, 2019.04.05-ны өдрийн Хөдөлгөөнт банкны үйлчилгээний журам батлах тухай, 2018.11.20-ны өдрийн Бага дүнтэй гүйлгээний мөнгөн дүнгийн дээд хязгаар батлах тухай, 2018.10.30-ны өдрийн клирингийн системийн оператор болон төлбөр тооцооны төлөөлөгчийн үйл ажиллагааны журам батлах тухай, 2018.05.10-ны өдрийн Үндэсний цахим гүйлгээний төвийн төлбөрийн картын сүлжээний дүрэм батлах тухай, 2018.03.30-ны өдрийн Их дүнтэй төлбөрийн системийн журам батлах тухай, 2017.12.25-ны өдрийн Монголбанкны үйлчилгээний шимтгэлийн ерөнхий нөхцөл шинэчлэн батлах тухай, 2016.01.20-ны өдрийн Төлбөрийн системд мөрдөх мэдээллийн технологийн тасралтгүй, найдвартай ажиллагааны журам, 2015.04.28-ны өдрийн Төлбөрийн систем, түүний оролцогчийн үйл ажиллагаанд газар дээр нь шалгалт хийх журам батлах тухай, 2014.06.27-ны өдрийн "Төлбөрийн системийн хяналтын бодлого"-ын баримт бичгийг батлах тухай тушаалуудаар зохицуулдаг байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь төлбөрийн системийг төлбөр гүйцэтгэгч, хүлээн авагчийн хооронд мөнгөн хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой үйл

ажиллагаа, түүнийг гүйцэтгэх, үр дүнгийн тооцооллыг хийх эрх бүхий байгууллага, холбогдох дүрэм, журам, гэрээ болон төлбөрийн хэрэгслийн цогц нэгдэл гэж тодорхойлсон байдаг. Монголбанкнаас төлбөрийн хэрэгсэл буюу карт гаргах, хүлээн авах, төлбөр тооцооны төлөөлөгчийн үүрэг гүйцэтгэх, цахим мөнгөний үйл ажиллагаа эрхлэх, клирингийн систем ажиллуулах, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа гэсэн 5 төрлийн зөвшөөрлийг олгодог байна.

Үндэсний төлбөрийн системийн тухай хууль нь Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг удирдах, зохион байгуулах, зохицуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахаас гадна Үндэсний төлбөрийн системд банкнаас бусад этгээд оролцох боломжийг нээж өгсөн. Уг хуульд Мөнгөн хөрөнгийн тухай ойлголтуудыг тодорхойлсон байна. Цахим мөнгөний журам. Монголбанкны ерөнхийлөгчийн 2018 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн А-45 дугаартай тушаалаар 9 бүлэг 67 зүйлтэй “Цахим мөнгөний журам”-ыг баталж, 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж байна. Уг журамд Нийтлэг үндэслэл, цахим мөнгөний үйлчилгээ, үйлчилгээ эрхлэгчид тавих шаардлага, оролцогч, цахим мөнгөний үйлчилгээний хязгаарлалт, цахим мөнгө гаргах зөвшөөрөл олгох, хүчингүй болгох, цахим мөнгөний үйл ажиллагаанд тавих хяналт, баталгааны данс, хариуцлага, цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд харилцан хөрвүүлэх, төлбөр, шилжүүлэгт хэрэглэх болон энэ үйл ажиллагааны оролцогчид тавигдах шалгуур үзүүлэлтийг зохицуулсан байна.

Цахим мөнгөний үйлчилгээнд мөнгөн хөрөнгийг цахим мөнгөнд, цахим мөнгийг мөнгөн хөрөнгөнд

хөрвүүлэх, цахим мөнгөөр төлбөр гүйцэтгэх, гүйлгээ хийх үйл ажиллагаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр зөвхөн үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр гүйцэтгэхээр заажээ. Цахим мөнгөний эрх зүйн зохицуулалт нь баталгааны данс юм. Цахим мөнгийг хэдий хэмжээгээр гаргах гэж байна, түүнтэй тэнцүү хэмжээний мөнгөн хөрөнгийг банкны дансанд баталгаа болгож байршуулах ёстой. Баталгааны дансанд дахь мөнгөн хөрөнгийг өөр ямар нэгэн зориулалтаар ашиглаж болохгүй, зөвхөн хэрэглэгчийн цахим мөнгийг төгрөгт хөрвүүлэхэд л ашиглана. Ийм баталгаа гаргаснаар эцсийн хэрэглэгчийг цахим мөнгөний үйлчилгээ эрхлэгч дампуурах эрсдэлээс баталгаатай хамгаалах зохицуулалттай юм. Монгол Улсын нутаг дэвсгэрт хийж буй гүйлгээг хуулийнхаа хүрээнд Монголбанк зохицуулах бөгөөд харин Монгол Улсаас гадагшаа гарах, дотогш орох олон улсын гүйлгээнд Монгол Улсын төлбөрийн системийн хууль дүрэм үйлчилдэггүй байна. Банкууд тус тусдаа олон улсын сүлжээний гарцтай байх бөгөөд үүнийгээ ашиглаж олон улсын гүйлгээ хийдэг учраас Монголбанкнаас олон улсын гүйлгээнд ямар нэгэн зохицуулалт хийх боломж нь одоогоор байхгүй байна.

Монгол Улс дахь банкны гадаад гүйлгээний тухайн дансыг олон улсын хууль дүрмээр зохицуулж байдаг нь Монголбанк гүйлгээнд нөлөөлөх хууль эрх зүйн зохицуулалт байдаггүй байна. Харин гаднаас оруулж ирж буй мөнгө угаах гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй сэжигтэй, ихээхэн хэмжээний мөнгөний гүйлгээг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд зохицуулсан байдаг. Тухайлбал, 20 сая төгрөгөөс дээш гүйлгээ хийсэн тохиолдолд холбогдох газарт нь бүртгүүлэх ёстой гэсэн заалт байна.





ᠮᠤᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰ  
ᠰᠠᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ  
ᠡᠷᠬᠡᠵᠢᠨ  
ᠰᠤᠳᠤᠯᠠᠯ

## Криптовалюттай холбоотой олон улс дахь хууль, эрх зүйн зохицуулалт

Криптовалютын олон улсын эрх зүйн зохицуулалт улс орон бүрд өөр өөр байна. Тодруулбал зарим улсад криптовалютаар хийх гүйлгээг хүлээн зөвшөөрч байгаа бол зарим улсад нь хориглож байна. Хүлээн зөвшөөрч байгаа улсууд нь криптовалютыг бараа, хөрөнгө оруулалтын нэгж гэж үзэн өөрийн улсын татварыг ногдуулдаг байна. Герман улсад криптовалютыг мөнгөн нэгж, Япон улсад биткойн бол хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцогддог байна.

Өнөөдөр дэлхийн дээр криптовалютыг зохицуулсан нэгдсэн эрх зүйн зохицуулалт байхгүй байгаа нь тус зах зээлд хөрөнгө оруулагчдыг хамгаалах боломжгүй байна. Гэсэн хэдий ч зарим нэг улсад шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зохицуулсан журмыг гаргаж байна. Тодруулбал Швейцар улсад 2016 оноос 1 сая Швейцар франкийн хөрөнгө оруулалтыг тодорхой компани эзэмшиж болохоор зохицуулсан байна. Ингэхдээ ямар нэгэн үүрэг хүлээдэггүй байна. Мөн Япон улс бол хамгийн эхэнд криптовалютыг албан ёсны мөнгөн тэмдэгттэй дүйцүүлэн хэрэглэж байгаа ба энэ нь хууль эрх зүйн тулгуур зохицуулалтыг бий болгосон хэдий ч бүхэлд нь зохицуулж одоо болтол чадаагүй байна.

2018 онд ФАТФ криптовалют болон криптовалютаар үйлчилгээ үзүүлэгч гэсэн нэр томъёог тодорхойлон үүн дээрээ үндэслэн 2019 оны 6 дугаар сард зохицуулалтын зөвлөмждөө криптовалют болон криптовалют үйлчилгээ үзүүлэгчидтэй холбоотой зохицуулалтын зөвлөмжийг гаргасан байдаг. Криптовалюттай холбоотой тус хэсгийг 15 дугаар зөвлөмж буюу “Шинэ технологи” гэсэн

хэсгийг дэлгэрүүлсэн байдлаар нэмжээ. Энэхүү зөвлөмжийн гол зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааг криптовалютаар холбоотой бүхий л үйл ажиллагаанд хэрэгжүүлэх, тэдгээрийн зохицуулалт, тусгай зөвшөөрөл, бүртгэл, хяналт зэргийг бий болгох юм.

Хөгжиж байгаа эдийн засагтай улс орнуудын хувьд криптовалютыг хэрэглэх тал дээр бүрэн дэмжсэн эсвэл үгүйсгэсэн байр суурьтай байгаа бол барууны ихэнх улсууд болон Азийн орнуудаас Япон, Сингапур эдийн засгийн инновацийг дэмжих замаар бусад улсаас илүү уян хатан хандаж байна.

Австри, Австрали, Франц, Герман, Малайз зэрэг улс орнууд криптовалютыг зөвшөөрөх, мөн татварын болон мөнгө угаахтай холбоотой зохицуулалтуудыг хийж эхлээд байгаа бол Бангладеш, Бельги, Бразил, Хятад, Индонез зэрэг орнууд криптовалютыг хууль ёсны гэж үзэхгүй болохоо мэдэгдэн, хориглох хүртэл арга хэмжээ аваад байна.

2017 оны 12 дугаар сарын 13-нд Солонгосын засгийн газар криптовалютын арилжааг хянах үүднээс шинэ журмын төслөө танилцуулсан. Үүнд: криптовалютын данс нээлгэх үйлчилгээ үзүүлдэг банкнууд шинээр данс нээхдээ данс эзэмшигч нарын мэдээллийг шалгаж баталгаажуулах, насанд хүрээгүй болон гадаад иргэнд данс нээж өгөхгүй байх, санхүүгийн байгууллагууд криптовалютад хөрөнгө оруулах, эзэмшихийг хориглох, эрх бүхий зохицуулах байгууллага нь криптовалютын биржүүдийн арилжаанд оролцогчдыг жинхэнэ нэрээр баталгаажуулах, дансны нууц үгийн хамгаалалтыг сайжруулах, хэлцэл болгоны үнэ ба хэлцлийн

хэмжээний мэдээллийг ил тод болгохыг шаардах, арилжааны ашгийн татвар ногдуулах тухай хэлэлцэх, криптовалютаар холбоотой луйвар, залилангийн талаар илүү хатуу арга хэмжээ авах тухай зүйл заалтууд багтсан байна.

Дэлхийд хууль бус бараа худалдаа, гүйлгээ хийгддэгээрээ алдартай Darknet дээрх криптовалютын гүйлгээтэй холбоотой гэмт хэргийг АНУ-ын Холбооны мөрдөх товчоо (FBI)-оос хоёр жил гаруй хугацаанд мөрдсөний эцэст нь хууль бус үйл ажиллагааг илрүүлж гэмт этгээдийг 2013 оны 10-р сард баривчилж, криптовалютаар холбоотой гүйлгээ хийгдсэн жагсаалтыг шалгахад хар тамхи, хүний худалдаалах, мөнгө угаах, захиалгат аллага гэх мэт гэмт хэргүүдийн төлбөр, тооцоо хийгдэж байсан болохыг тогтоосон байна (Casey, 2016). Энэ нь криптовалютаар холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгаж илрүүлсэн анхны тохиолдолд байсан бөгөөд дахин гэмт хэрэг үйлдэхдээ криптовалют ашигласан этгээдийг олж илрүүлсэн тохиолдолд одоогоор байхгүй байна. Үндэстэн дамнасан болон хууль бус худалдаа гэх мэт гэмт хэрэг үйлдэхэд криптовалютыг ашиглаж байгаа нь цахим гэмт хэргээс өөр ойлголт юм. Монгол Улсын хувьд биткойн худалдах түүнийг ашиглах боломжтой интернэт сайт <https://cloudmining.mn/> -ээс гадна хэд хэдэн сайт байдаг.

### Дүгнэлт

1. Монгол Улсад криптовалютаар холбоотой одоогоор хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль нь “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль” байна. Бусад хууль тогтоомжийг судлан үзэхэд Иргэний хуульд хөрөнгийн тухай зохицуулалт байдаг ч криптовалютыг нарийвчилсан зохицуулалт байхгүй. Төлбөр тооцоог

үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд Монгол Улсын газар нутагт төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэх харилцааг зохицуулсан, Татварын ерөнхий хуульд цахим хөрөнгөөс татвар авах зохицуулалт тусгаагүй, Авлигын эсрэг хуульд болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд хөрөнгө орлогын мэдүүлэгт криптовалютыг бүртгүүлэх шаардлага тавигдаагүй зэрэг зохицуулалт байхгүй байна.

Эрх зүйн зохицуулалтгүй байгаа нь өмнө нь дурдсанчлан тус технологийн шийдлийг буруугаар ашиглаж үүсэж болох эдийн засгийн хор хөнөөл, учирч болох аюул өндөр байна. Цаашилбал, хариуцлагын тогтолцоогүй, криптовалют эзэмшигч өмч хөрөнгөөрөө хохирох тохиолдолд хэрхэн зохицуулах, төр ямар байдлаар оролцох, маргааныг хэрхэн шийдвэрлэх, олон улсын эрх зүй хэрхэн үйлчлэх зэрэг асуудал тодорхойгүй хэвээр байсаар байна. Криптовалютаар холбоотой гэмт хэрэг одоогоор манай улсад бүртгэгдээгүй байгаа хэдий ч криптовалют худалдан авч ашиглаж байгаа иргэдийн хувьд хууль, эрх зүйн зохицуулалт болон төрийн хяналт тавих боломжгүй байгаагаас эрсэлд орох магадлал маш өндөр байна. Монгол Улсад цахим мөнгөтэй холбогдсон харилцааг Монголбанкны тухай, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монгол банкны ерөнхийлөгчийн баталсан цахим мөнгөний журам зэрэг эрх зүйн баримт бичгээр зохицуулж байна. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Эрүүгийн, иргэн, зөрчлийн хэрэгтэй холбогдуулан ямар нэгэн хэрэг маргааныг шийдвэрлэх бүрэн боломжтой байна. Криптовалютыг зохицуулсан ямар нэгэн нэгдсэн эрх





зүйн баримт бичиг одоогоор олон улсын хэмжээнд байхгүй байна. Үүнтэй тэмцэж байгаа ганцхан туршлага бол зарим нэг улс орон дотооддоо гүйлгээ хийх, ашиглахыг хориглох арга хэмжээ авч байна. Криптовалютаас үүдэн гарах эрсдэлийг хэрхэх нь тодорхойгүй хэвээр байсаар байна.

2. Одоо хүчин төгөлдөр байгаа хууль, тогтоомжоор иргэн, хуулийн этгээд заавал банк, санхүүгийн байгууллагад биечлэн очиж санхүүгийн үйлчилгээ авдаг, төлбөр тооцооны сонголт бага, хөрөнгө оруулах салбар цөөхөн зэрэг асуудлууд байгаа тул технологийн шийдлийг нутагшуулж эрх зүйн орчныг бүрдүүлснээр Монгол Улс цаашид хөрөнгө оруулагч нарт таатай орчин бүрдүүлэх, дотоодын иргэн, ахуйн нэгжүүдэд төлбөр тооцооны шинэ төрөл санал болгох, үүнийг дагаад зардал бууруулах, эдийн засгийг эргэлтэд оруулах зорилгод нийцүүлэн хамгийн зохистой шийдлийг илрүүлэх, шинэ технологийн хүрээнд бусад улсууд криптовалютын зохицуулалтыг бий болгож түүнд тавих хяналт, шаардлагыг тодорхойлж өгснөөр тухайн улсын иргэн, аж ахуйн нэгжүүдэд хууль ёсны бизнесийн боломжуудыг нээж өгч байгаагаас гадна мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын шаардлагад нийцсэн өөрийн улс орны онцлогт тулгуурлан эрх зүйн орчныг бүрдүүлж уламжлалт санхүү, эдийн засгийн бүтцийн зэрэгцээ виртуал санхүүгийн орчныг бий болгож байна.

3. Эрүүгийн хуульд виртуал хөрөнгө буюу криптовалот ашиглан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд криптовалоттай холбоотой мөрдөн шалгах ажиллагааг тодорхой тусгаж

өгөх хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах нь илүү эерэг нөлөөтэй гэж үзэж байна.

4. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэсэн нь яг ямар зүйл, заалт, хэсгээр хариуцлага хүлээлгэх эсэх нь тодорхой бус байгааг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

### Ашигласан материал

1. Виртуал хөрөнгийн тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилсан тандан судалгаа. УБ., 2020

2. Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны даргын хамтарсан тушаал,

3. Монгол банкны “Төлбөрийн хэрэгсэл - цахим мөнгө”-ний зөвшөөрлийн бүртгэл

4. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль

5. Хөдөлгөөнт банкны үйлчилгээ, цахим мөнгөний талаар баримтлах бодлого

6. <https://mn.wikipedia.org/wiki/%D0%9C%D3%A9%D0%BD%D0%B3%D3%A9>

7. <https://www.bankofengland.co.uk/knowledgebank/what-are-cryptocurrencies>

8. <https://www.mongolbank.mn/news.aspx?id=1918&tid=2>

9. <https://newswall.mn/?p=29422>

10. <http://www.ardcredit.com/mn/about>

11. <https://www.rbc.ru/crypto/currency/btcusd>

12. [https://mn.wikipedia.org/wiki/Peer\\_to\\_peer\\_computing](https://mn.wikipedia.org/wiki/Peer_to_peer_computing)

13. <https://www.avatrade.mn/forex/cryptocurrencies>

# БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮЕИЙН ОРОС ЗҮГИЙН ХАРУУЛЫН АЛБАНЫ ТУХАЙ

## CONCERNING THE RUSSIAN GUARD SERVICE DURING THE PERIOD OF AUTONOMY

**Л.Одзаяа**

Дотоод хэргийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн Нийгмийн ухааны  
тэнхимийн ахлах багш, хошууч

**L. Odzaya**

Senior lecturer at the Department of Social Science, School of Law, UIA, major

хариуцлагатай зохиогч: lodzayaka@gmail.com

**Хураангуй:** Дурдан буй үеийн харуулын алба нь Манжийн үеийн өрх харуулын албатай ерөнхийдөө төстэй байсан хэдий ч зарим нэг өөрчлөлт орсон байна. Үүний гол шалтгаан нь Монгол-Оросын 1912 оны гэрээтэй холбоотой байв. Иймээс Богд хаант Монгол Улс нь хилийг хуучин хэвээр буюу өрх харуулаар дагнан хамгаалуулж байсан хэдий ч харуулын тоог цөөтгөх бодлого баримтлав. Гэхдээ хилийн харуул дахь сүм хийдийг дэмжих бодлого баримталж байжээ.

**Abstract:** The guard services during this period generally remained similar to the “household guards” the Mangi era; however, certain changes were implemented. The main reason for these changes was related to treaties and agreements established with Emperor Russia. Consequently, while the nation’s borders continued to be protected solely by traditional household guards as before, a policy was accepted to reduce the number of guard posts while simultaneously supporting temples and monasteries located within those guard zones.

**Түлхүүр үгс:** Өрх харуул, харуулын нутаг, харуулын нутгийн түрээс, гадаадын харьяат, Буурын гэрээ, Сангийн явдлын яам, дагаар орогсод

**Keywords:** Home guard, border land, border land’s rent, foreigners, Treaty of Buur, Russia, Manchu, Ministry of Finance Mongolia

### Удиртгал

Дурдан буй үеийн харуулын албаны талаарх мэдээ сэлт хомс учраас тус сэдвийг судлахыг зорьсон болно. Иймийн тул Үндэсний төв архивд хадгалагдаж буй харуулд холбогдох баримтуудад үндэслэн Богд хаант Монгол Улсын хойд зүгийн өрх харуулын албаны онцлог болон хувьсал өөрчлөлтийг шинжлэн судалсан болно.

### Хиагтын гэрээ байгуулагдахын өмнөх өрх харуулын алба

Манж Дайчин улс 1911 онд мөхөж, Монголчууд өөрсдийн улсын тусгаар

тогтнолоо дахин сэргээн мандуулаад гадаад харилцаагаа өргөжүүлэн тэлэх бодлого баримтлав. Улмаар Хаант Оростой 1912 онд гэрээ байгуулж, найрамдалт харилцаа тогтоосноор, улсын хилийг хуучин хэвээр гэр харуулаар дагнан хамгаалуулах болсон хэдий ч харуулын тоог цөөтгөх бодлого баримтлах болжээ. Тухайлбал, Халхын дөрвөн аймгаас тэгшээр гаргаж суулгасан бүгд 47 суурь харуул тутам 20-30 өрх цэрэг суулгаж байсныг 2 болгон цөөтгөж, нийт 94 өрх цэргээр уг хил, овоо, нутгийг харгалзуулахаар үлдээж, тэднийг захирахад аймаг





бүрээс нэгжгээд түшмэд гаргаж хуучин ёсоор захирч, үлдсэнийг түшмэдийн хамт уул аймаг, хошуунд татуулж, бусад албанд туслалцуулахаар шийдвэрлэсэн байна (МУҮТА, А-3, Х-1, ХН.316. 6.2).

Ийнхүү 1912 оноос эхлэн Халхын дөрвөн аймгийн хойд зүгийн харуул тутам 2 өрх цэрэг суулгаснаар харуул дахь хүн бүл цөөдөж, сүм хийдийн хурал номын ажил тасалдаж буй талаарх санал хүсэлт, гомдол олонтоо гарах болсон тул уг хүсэлтийг үндэслэн Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас харуул тутамд 5-10 өрх цэрэг суулгахаар шийдвэрлэсэн байна. Жишээ нь, Сэцэн хан аймагт нэр бүхий 14 харуул ноогдож байсан бөгөөд үүнээс сүм дугангүй 5 байсан тул тэдгээрт тус бүр 2 өрх цэргийг улираан үлдээж, бусад сүм дугантай 9 харуулд 5-10 өрх цэрэг суулган ном, хурлыг тасалдуулахгүй залгамжилж, сүм шүтээнийг харгалзуулахаар шийдвэрлэсэн байна (МУҮТА, А-3, Х-1, ХН.397. 6.1).

Түдэлгүй Дотоод явдлын яамны шийдвэрээр Хиагтын зүүн, баруун гарын харуулыг захирагч оронг хасаж, харуулуудыг нутаг ойр хошуунд, харин харуулын сүм хийдийг өндөр хэргэмтэй хутагт хувилгаадад захируулахаар шийдвэрлэсэн байна.

Энэхүү шийдвэртэй холбоотойгоор харуулуудаас харьяат хошууны засгууд хурал номыг тэтгэн дэлгэрүүлэх байтугай дарлан зовоож буй талаарх гомдол гарах болсон учраас 1913 оны 12-р сарын 24-ний өдрийн шийдвэрээр харуулуудыг хошуунд захируулахыг болиулж, Хиагтын баруун, зүүн гарын дарга оронг бий болгон түүнд захируулсан байна. Мөн харуулын нутгийг дагаар орж, гавьяа байгуулсан гачигдал бүхий зүтгэлтэнд олгох ба харуулын сүм хийдийг Хиагтын баруун, зүүн гарын дарга нарт дахин

хариуцуулахаар шийдвэрлэжээ (МУҮТА, А-3, Х-1, ХН.447. 6-23).

Ийнхүү гэр харуулын тоог цомхотгон цөөлж, тэднийг уул нутаг хошууд руу буцааж алба ноогдуулах болсонтой холбоотойгоор харуул занги, хошууны засгийн дунд маргаан гарч байв. Тухайлбал, Хавтгай харуулд сууж байсан Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны харьяат харуул занги Шаравцэнд 1912 оны 3-р сарын 7-оос 1913 оны 8-р сарын 27 хүртэл уул албыг осолдолгүй хаажээ. Гэтэл түүний харьяат хошууны засгийн зүгээс алба авахаар жил гаруй нэхэмжилсэнд, тэрээр хил хязгаарын чухал алба хааж буй учраа хэлж, хошууны данс харааг үзэж, харуулд суусан албыг суутган хорогдуулахыг гуйсанд, хошууны эрх баригчид “ноосон алба бус” тул уул албыг хэрэгсэхгүй болгосон байна. Иймд тэрээр харьяа аймгийн чуулган даргын газраар уламжлуулан Дотоод явдлын яам руу алба хаасан данс харааг зохих газраас олгуулж, хохирлыг арилгуулж өгөхийг хүссэн албан бичиг явуулсан байна. Дотоод явдлын яамнаас дээрх бичгийг хянан үзээд, цагдаа цэргийн албыг харьяат аймгийн хошуунд дансгүй хаасан нь үнэн бол зүй нь Сайн ноён хан аймгийг хамаарсан чуулганы даргад явуулаад байцаан үзэж, энэ зүйлийн цагдаа цэргийн албыг дансгүй хаасан занги Шаравцэндийн хохирлыг арилган дуусгуулах даалгасан байна (МУҮТА, А-3, Х-1, ХН.91. х.72-74).

Ийнхүү харуулуудын өрх цэргийг цөөтгөсөнтэй холбоотойгоор зарим хошууд харуулд суулгасан бүх өрх цэргээ уул хошууд руу татаж Богд хааны зарлигийг зөрчсөн үйлдэл гаргаж байжээ. Энэ тухай архивын баримтад, ...эдүгээ Агацаас Хаслаг харуулын өмнө этгээд хүртэл байгуулсан тус хошууны нутгийн овооны өмнө суулгасан цагдаа нарыг

захирсан тайж Гонгоржавын мэдүүлсэн бичигт, өчүүхэн хүн тушаасныг дагаж харьяат нутгийн захын овоодыг харгалзан цагдаа нарыг захиран сууж байхад Агац болон Хяраан харуулын захирагчид ирж, урьд харуулыг татан буулгахад таны хошуунаас дээрх харуулуудад алба хааж суусан тус хошууны нэр бүхий 7 өрхүүдийг мөнхүү бүлүүдийн хамтаар хураан аваачсан боловч одоо Богд эзэн хааны зарлигийг дагаж, тэд нарыг уул харуулд хэвээр суулгах болсон учир тэдгээр нэр бүхий хүмүүсийг өрх хөрөнгийн хамт бүрмөсөн нүүлгэн ирүүлсүгэй хэмээсэн байна. Үүний хариуд, цагдаа нарыг захирсан тайж Гонгоржав харуулд суугсдыг харьяат хошууны нутагт бүрнээ хураан авчирч баримтлан захирснаас нааш энэ завсар заримыг нь сэргийлэн суулгах ба дайчлагдсан цэрэгт мордуулж, бусдыг нь өртөөний зэрэг газар алба хаалгахаар өрхөөр илгээн нутаглуулсан. Мөн харуулуудын нутгийг харьяат хошуунд эгүүлэн захируулах болсноор үлэмж тайж, ардуудыг харуулд суулгаж байсан, үгүйг ялгалгүй харуулд ойр нутаглах тайж, ард нэлээдийг харуул руу нүүлгэн нутаглуулсан нь энэ завсар зарим нь нүүн очиж завдаагүй байж болзошгүй гэж хариулсан байна.

Энэхүү асуудлыг Дотоод явдлын яамнаас хянаж үзээд "...Манай яамнаас томилон гаргасан түшмэл Жамбалжигмэдээс өргөсөн хэргийн дотор Агац, Хираан зэрэг харуулын эдүгээгийн занги, цэргүүд ба хурал номыг залгамжлан сууж бүхий түшмэл, ардаас гагцхүү сайд Жонон вангийн хошуу үлэмжхэн тооны өрх цэргүүдийг эзэрхгээр хураан аваачсан бөгөөд бидний үлдсэн цөөн шар, хар ард уг хурал номыг гүйцэтгэхэд хүчин мөхөсдөж буй билээ. Учир иймийн тул олон харуулын өрх цэргүүдээс 5-аас дээшийг хэвээр суулгаж, язгуурын

байгуулсан хурал шашныг хөсөрдүүлэхгүй болгон залгамжлуултугай хэмээснийг зохих газруудад тушааж нэгэн адил дагаж шийтгүүлсэн буй атал тэдний нэгэн хошуу тийнхүү нутаг заалдан буй бөгөөд тоо бүхий өрх цэргүүдийг зоргоор татан хураасныг үзвэл дээдийн зарлигийг зөрчсөнгүй хэмээх буюу. Зүй нь зохигчдыг дараалан шийтгэж цээрлэл үзүүлвээс зохивч мөн хошуудаас эл харуулын газар байгуулсан сүмийн газар хааяа хурдаг лам нар байваас цаг тухайд хурж хуралдуулсаар байвал болмуй хэмээсний тулд энэ удаа нягтлан хэлэлцэхийг түдгэлзэн нэгэнт татан хураасныг эгүүлэхийг үл хэлэлцэн, бусдыг хэвээр суулгаж хурал номыг залгамжуулбаас зохино (МУҮТА, А-3, Х-1, ХН.91. б.183-192) гэж шийдвэрлэсэн байна.

Дурдан буй үед харуулд сууж буй өрх цэргүүдээс амь эрсдэх тохиолдол гарч байсан бөгөөд ийм үед харьяа харуулаас Хиагтын баруун, зүүн гарын захирагчдаар уламжлуулан харьяа аймгийн чуулган даргын газар болон Дотоод явдлын яаманд мэдэгдэж, орны хүн томилуулах хүсэлтээ өргөн мэдүүлж, шийдвэрлүүлдэг журамтай байв (МУҮТА, А-3, Х-1, ХН.91. б.287-288).

Мөн Хиагтын баруун этгээдийн харуулуудыг захирах дарга, гүн Найданжав харуул хязгаарын аливаа хэргүүдийг хавсран шийтгэлцэх зангийн орон тоо нэмэн байгуулах хүсэлтээ Дотоод явдлын яаманд гаргаж байсан хэдий ч түүний хүсэлтийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байдаг (МУҮТА, А-3, Х-1, ХН.91. х.127-130).

Дурдан буй үед өрх харуул нь урьдын адил өртөөний албаны үүрэг зарим тохиолдолд хавсран гүйцэтгэж байв. Тухайлбал, буу, жад зэрэг





зэвсгийг Хиагтаас Хүрээнд хүргэхэд Хавтгай зэрэг 3 харуулын занги нар ачилга, зүйлийг аль олдох газраас эрин олж энэхүү чухал зэвсгийг нэн хурдан өнгөрүүл хэмээн чангалан тушааж байжээ (МУУТА, А-3, Х-1, ХН.91.6.46-51).

Хиагтын гэрээ байгуулагдахын өмнөх өрх харуулын алба нь үндсэндээ Манжийн үеийн харуулын зохион байгуулалт ерөнхийдөө хэвээр хадгалагдах болсон хэдий ч зарим талаар өөрчлөлт орсон байна. Тодруулбал, Халхын 4 аймгийн хойд зүгийн нийт 47 хэвээр байсан хэдий ч харуулд суугчдын тоо буурч, нэмэгдсэн байна. Тухайлбал, 1912оны үед харуул тус бүрд 20-30 өрх цэрэг байсныг 2 өрх цэрэг суулгаж, тэдний аль нэгийг занги болгохоор шийдвэрлэсэн хэдий ч 1913 оны үеэс харуулд суугчдаас гомдол ирэх болсон учраас энэхүү тоог 5-10 өрх цэрэг болгон нэмэгдүүлэв. Мөн Хиагтын зүүн, баруун гарын харуулыг захирагч оронг хасаж, харуулуудыг нутаг ойр хошуунд, харин харуулын сүм хийдийг өндөр хэргэмтэй хутагт хувилгаадад захируулахаар шийдвэрлэснийг болиулж, дахин Хиагтын баруун, зүүн гарын харуулын даргын оронг сэргээжээ.

### **Байгалийн баялаг ба харуулын алба**

Дурдан буй үед Монгол, Орос хоёр улс найрамдалт харилцаатай байсан тул Оросын худалдааны газраас 1913 оны 7-р сарын 1-ний өдөр ирүүлсэн хүсэлтийн дагуу Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаас Хиагтын баруун, зүүн этгээдийн нэр бүхий 35 харуулын дотроос алт гаргах газрыг үзүүлж, алт олдвоос малтаж болох эсэх талаарх хүсэлтийг ёсоор болгож, тэрхүү газрыг үзэхэд 3 сарын хугацаатай үнэмлэх бичиг олгосон байна (МУУТА, А-3, Х-1, ХН.12. х.175-177). Түдэлгүй тэд дахин урьд олгосон

үнэмлэх бичгийн хугацааг 4 сараар нэмэн сунгаж өгнө үү гэсэн хүсэлт гаргасанд үнэмлэх бичиг дахин олгожээ. Мөн Оросын худалдааны газраас хойд зүгийн Ордого зэрэг 7 харуулын нутагт алт малтахаар хэлэлцэн гэрээ бичиг байгуулсан байна.

Улмаар Ордого харуул дахь алтны уурхайн хорооны газарт Монгол Улсын Засгийн газраас тусгай түшмэл, бичээч нарыг томилон суулгаж, уул уурхайн Орос хүмүүстэй хамт нийлж харьяат уурхайн хэргийг эрхлэн шийтгэхээр шийдвэрлэсэн тул Сангийн яамнаас нутгийн ойр, дав дувьг харгалзан Түшээт хан аймгийн сайд Эрдэнэ дайчин чин вангийн хошууны түшмэл занги Жамбал, бичээч Дэндэв нарыг тус уурхайд суулгахаар тогтож, гэрээ бичгийн нэг хувийг тус уурхайн алтны газар алт малтаж, үйлдвэр хийх хүнд тэмдэгт бичгийн хамт олгосон байна. Улмаар тэдэнд алтны уурхайн газар очоод урьд малтаж олсон ба одоо малтаж олох алтыг бүгдээр нүд үзэж байцаан 2 этгээд тус бүр тодорхой данс үйлдэн манай улсын санд хураалгаваас зохих гаалийн алтыг сар бүрийн шинийн 10-ны дотор Сангийн яаманд хүргэн ирүүлж байхыг тэдэнд даалгажээ (МУУТА, А-11, Х-1, ХН.627.6.17).

Улмаар тэд Сангийн явдлын яам болон Түшээт хан аймгийн чуулган даргын газар руу албан бичиг явуулжээ. Албан бичигт, энэ жил намраас эхлэн Орос хүн олноор хуралдан алт гаргаж бүхий хэсэг хэсэг газар малтаж байхад бидний цагдаагийн албаны хаагчид тэдний Орос тэргүүлэгч хүнээс учрыг асуухад, бид нар Хиагтын худалдааны захиргаанаас олон харуулын нутагт алтны ордыг нээх албан хэрэг буй ба одоо тус газраас алтны элс нэгэнт гарсан тул энэ учрыг зохих газарт мэдэгдэн явуулснаас хойш 2 сар илүү

болсон атал огт чимээгүй хэмээв. Жамц, Жамбал бид энэ 6 сард 3 удаа бага сага алт хураан авахыг үзэж, энэхүү харуулын нутаг болбоос манай харуулын дэвсгэр тохиолдсон хэрэг тул хэрхэхийг тушаан заамуу гэж өчсөн байна (МУҮТА, А-11, Х-1, ХН.627. б.16).

Ийнхүү Ордого зэрэг харуулын нутгаас алт малтаж олсонтой холбоотойгоор 7 харуул төдийгүй 28 харуулын нутагт алт эрж хайх зорилгоор зөвшөөрлийн бичиг 1 жилийн хугацаатай авсан байна. Тодруулбал, Хиагтын баруун, зүүн этгээдийн 28 харуулын газар алт эрж олохоор эрх олгосныг 1 жилийн хугацаатай тэмдэгт бичиг олгосныг гуйсанд ёсоор болгож Оросын харьяатуудад харьяат харуулын газрыг үзүүлж алт гарах газар байвал малын бэлчээр ба эрхэм сүлдэт тахилга зэрэгт харшлалгүй болбоос Дотоод явдлын яаманд тодорхойлон ирүүлж гэрээ бичиг байгуулан алт малтуулахад бэлтгүүлэхээр тогтсон байна (МУҮТА, А-11, Х-1, ХН-627. б.23).

Үүнээс гадна Гадаад явдлын яамнаас харуулын нутагт тариа тариулах газар бий эсэхийг харуулын захирлуудаар тодорхойлуулж авч байжээ. Тухайлбал, “Орос хүмүүс Уялга, Ашинга, Тоосог харуулуудын газар нутгаас газар хэмжээлэн авч тариа тариулахад эдгээд харуудын нутаг дотроос эрхэм сүлд тахилга бүхий онгон дархан ба малын бэлчээр зэрэг харшлалтай газар бүхий, үгүйг тодорхойлон гаргаж мэдүүлэн ирүүлэхийг тушаасанд Буур, Хяраан, Чигтай, Хүдэр, Уялга харуулын цагдаа нараас Минж орчмын харуулуудын нутаг их төлөв уул хад, мод бургас эзэлсэн өндөр бэрх хангай бөгөөд тал уужим газарт өвс хадах газар бий боловч гүн Хайсанд олгосон болно

(МУҮТА, А-11, Х-1, ХН.665. б.3) гэж мэдүүлж байжээ.

Дурдан буй үед харуулын нутагт алт олборлох болон түрээслүүлж байсантай холбоотой өрх харуулын гүйцэтгэж байсан үүрэгт тодотгол хийгдэж нэмэгдсэн байна. Тодруулбал, өрх харуул нь хилийн овоо тэмдгийг харгалзахаас гадна гадаад, дотоодын харьяат иргэдийн харуулын нутагт байгалийн баялгийг зөвшөөрөлгүй ашиглалтад хяналт тавих, мөн тэднээс түрээсийн төлбөрийг хураан авч Дотоод хэргийг бүгд захиран шийтгэгч яаманд мэдүүлэн хүргүүлэх үүрэг хүлээх болжээ. Энэ тухай нэгэн баримтад дурдахдаа, Гилбэр харуулын түшмэл занги, цагдаа нараас сайд Эрдэнэ жонон вангийн хошууны нутгийн захын цагдаа нарыг захирах тайж Гонгоржавт илгээв. Явуулах учир. Эдүгээ сая Буур зэрэг 28 харуулыг захирах гүн таны газраас тушаан хүрч ирсэн бичгийн дотор мод түлээ, өвс хадлан зүйлийг авах, гөрөөс авлах зэрэг Орос, Буриад, Хятад, Монгол хүн бий бөгөөс харьяат харуулын занги цагдаагийн газраас цаг цагт түрээс мөнгөний зүйлийг хүлээн авч манай яамнаа мэдүүлэн хүргүүлэн хураалгаад гүйцэтгэн шийтгэвээс зохимуй. Хэрэв цагдан байцаахыг алдаж осолдох ба пүн лигийн төдий ч даран далдалж баянд ашиг болгон шингээхэд хүргүүлбээс мөн нэгэн адил хүнд ял хэлэлцмүй. Манай яамнаас тэмдэг бичиггүй басхүү харьяат харуулуудын занги хүнд цагдаа нарт сонсгож уламжлан манай яамнаас мэдүүлсэнгүйгээр мод түлээ, өвс хадлан авхуулах ба гөрөөс авлаж үл болмуй хэмээн тушаан хүрч ирснийг хэвээр шийтгүүлж эрхэм тайж түшмэл таны газар явуулав. Хүрмэгц бичгийг доторхыг хянан үзэж тус захиргааны дотроос манай харуулын нутагт дээр тодорхойлсон зүйлүүд эээр явах ба жич





өрхөөр нүүн ирэх бусад олон газруудын хүн байх аваас учрыг мэдэж тогтоон тушаасан зүйлд нийлүүлэн гүйцэтгэж болох ажаамуу хэмээн түүний тул илгээв” (МУУТА, А-3, Х.1, ХН.91. 6.183-192) гэжээ.

Харуулын нутагт байгалийн баялаг ашиглах болсон нь улсын санг арвижуулах бодлого байсан бөгөөд энэхүү бодлогын хэрэгжүүлэхийн тулд харуулуулын нутагт газар болон байгалийн баялаг ашиглуулах зөвшөөрлийн бичих олгох болсон байна. Үүний тулд харуулын нутагт тусгай түшмэл суулгаж, харуулын нутаг дэвсгэрт малын бэлчээр ба эрхэм сүлдэт тахилга бүхий газар буй эсэхийг тодорхойлуулан аваад дурдсан газарт байгалийн баялаг ашиглахыг хориглодог байв. Мөн дагаар орогсодод харуулын нутгаас газар олгосонтой холбоотойгоор тэд уул газрыг гадаадын иргэдэд түрээслүүлж ашиг олж байсан нь олон маргааны үндэс болж байв.

### **Хиагтын гэрээ байгуулагдсаны дараах өрх харуулын алба**

1915 оны Хиагтын гурван улсын гэрээ байгуулагдсанаар Улиастай, Ховд, Хиагтад суух сайдуудад хязгаарын хэрэг шийтгүүлэх болсонтой холбоотойгоор харуул занги нэжгээд, Халхын 4 аймгаас товчлон захирах түшмэл 4 орон тоог хэвээр үлдээсэн хэдий ч илүү чирэгдлийг хэмнэсэн зорилгоор Хиагтын хоёр этгээд харуулыг захирах дарга 2 оронг дахин хассан байна. Үүнийг баримтаас дэлгэрүүлэн харвал, Хиагтын хоёр этгээд харуулыг захирах дарга 2 оронг хасаж мөнхүү Хиагтад сууж хэрэг шийтгэх сайдад хавсарган захируулах явдлыг хичээнгүйлэн нугалбар бичиж айлтгаад айлтгахыг гуйсан учир байцааваас, 1913 оны 12-р сарын 21-нд буулгасан зарлигийг дагаж Хиагтын хоёр этгээд харуулыг 2 зам хувааж,

захирах дарга 2 орон байгуулж, тус тус тамга үйлдэн олгуулсны дараа ... одоод манай улс гурван этгээдээр тогтоосон гэрээг дагаж Засгийн газраас мөнхүү Улиастай, Ховд, Хиагтад суух сайдуудыг томилон гаргаж, тамга олгож хязгаарын хэрэг шийтгүүлэх зэрэг явдлыг дараа дараагаар айлтгаж, ... шавь боолчууд дөрвөн яамны тэргүүн сайдуудтай зөвлөлдөн хянаваас, Хиагтын хоёр этгээд харуул угаас өөрийн хязгаарыг захирах занги нэжгээд, 4 аймгаас товчлон захирах түшмэл 4 орон бүхий төдий илүү чирэгдлийг хэмнэн хавсаргасан даргын тушаалыг татаж, тус бүрийн захирах сахих албаны хэргийг шавь боолчууд бичиж айлтгаад зарлиг гуйсан ёсоор болгогтун (МУУТА, А-11, Х-1, ХН.814. 6.1) гэжээ.

Мөн Хиагтын зүүн этгээдийн Буураас Агац хүртэл 13 харуулыг Түшээт хан аймгаас томилсон товчлон захирах түшмэл захирч байсан бөгөөд үүний дотор Хүеэгээс Агац хүртэлх 7 харуулд Сэцэн хан аймгийн түшмэд, цэргүүд сууж байв. Улмаар Буур орчмын харуулын нутагт өвөл цас их унаж, хүн мал нэвтрэн явах болон элдэв албаны зүйлийг нэвтрүүлэхэд бэрхшээлтэй байсан тул Түшээт хан аймгийн товчлон захирах түшмэлийн хүсэлтээр дээрх нэр бүхий 7 харуулыг Сэцэн хан аймгийн товчлон захирах түшмэлийн мэдэлд шилжүүлсэн байна. (МУУТА, А-11, Х-1, ХН.1009. 6.4).

Дурдан буй үед харуул занги, харуулын нутаг дахь сүм хийдийн удирдлагын хооронд эрх мэдэл, албан тушаалын маргаан гарч байв. Тодруулбал, харуул занги Базар анх 1913 онд Эрэнцаламын харуулд нэгэн өрхийн албыг хааж эхэлсэн бөгөөд 1915 онд Дотоод явдлын яамнаас харуул тутам үлдээн суулгасан өрх цагдаа цэргийн нэгэнд зангийн тушаал хүлээлгэх тухай тушаасанд тэрээр

харуул зангийн тушаалд алба хаах болов. Гэтэл харуул дахь Дашпунцаглан сүмийн орлосон зайсан лам Намсрай, Минжүүр нар ирж манай сүмийн хэргэмтэн нар Базар чиний олон зүйлээр харгислан дарласан элдэв гэм учрыг сийрүүлэн гаргаж, Дотоод явдлын яамнаа өргөн заалдсанд, чиний бие ба танай хошууны хүмүүс энэхүү харуулын цагдаагийн алба хаахыг бүрмөсөн зогсоож халалцахаар тушаасан тул харуулын нутгийн зураг, цэсийг авахаар ирсэн байна. Тэгтэл тэрээр нэгэн энгийн хүний үгээр хүлээн хаасан чухал албыг орхин зайлж үл чадна гэж хариулжээ. Улмаар харуул занги Базар энэхүү асуудлаа шийдвэрлүүлэхээр Дотоод явдлын яаманд өргөх бичиг явуулсан байна. Үүний хариуд, эдүгээ түүнийг ер албанаас халсан явдлыг аль ч газраас тушааж ирсэн зүйлгүй ба хил хязгаарын алба чухал тул зохих газраас хэрхэн тушаан ирэх эсэх тухайг үзтэл харьяат занги уул албыг хэвээр залгамжлуулбаас зохино (МУҮТА, А-11, Х-1, ХН.1050. 6.7) гэжээ.

Хиагтын гэрээний байгуулагдсаны дараа тус гэрээний биелэлтийг хангах болон илүү зардал чирэгдлийг хэмнэх зорилгоор Хиагтад сууж хэрэг шийтгэх сайдын газар байгуулагдав. Ингэснээр Хиагтын баруун, зүүн гарын харуулуудыг захирах оронг хасаж, тэдгээрийг Хиагтад сууж хэрэг шийтгэх сайдад харьяалуулах болсон байна. Мөн зарим харуулын нутаг нь алба нэвтрүүлэхэд бэрхшээлтэй байсан учраас нэр бүхий 7 харуулуудыг зэргэлдээ харуулыг товчлон захирах түшмэлийн мэдэлд шилжүүлэх тохиолдол гарч байв. Үүнээс гадна харуулд суух занги, сүмд хийдийн удирдлагын дунд албан тушаалын маргаан гарч байв. Тодруулбал, сүм хийдийн удирдлага нь харуул занги өөрийн хариуцах газрыг гадны иргэдэд

түрээсэлж ашиг хонжоо болж байна гэж үзээд, түүнийг албан тушаалаа өгөхийг шаардаж байжээ.

Мөн харуулын нутгийг гадаадын харьяатуудад олон жилээр түрээслүүлснээр газар нутгийн маргаан гарч байв. Тухалбал, 1919 оны 6-р сарын 26-ны өдрийн Гадаад яамнаас гадаадын хүнд алдахад хүрсэн харуулын нутаг газрын хэргийг сайнаар нийлэн шийтгэж дуусгасан ба бас ч сайнаар захиран суугаа түшмэд нарт зэрэг дэвшүүлж, хөхиүлсэн учрыг мэдэгдэн тушаасан эх гэх баримтад Жирмийн чуулганы Засагт чин вангийн хошууны гүн ламд харьяат шавь нарын хамт нутаглахаар шагнаан олгосон харуулын зүүн этгээд Хүдэр харуулын нутгийг 1915 онд Орос Мухиликовд 15 жилийн хугацаатайгаар түрээслэн өгсний дараа Орос Мухиликов гэрээ бичгийг зөрчин харьяат харуулын бүх газар нутгийг ганцаар эзэрхэн хэд хэдэн өрх Орос хүмүүсийг элсүүлэн авчирч, газар оронд байшин байгуулан харьяат харуулын газар ба нутгийн түшмэд, ардын хадлан бэлчээр, эрхэм сүлдэт тахилга бүхий газруудыг зоргоор хагалж тариа тарих ба өвс модыг хадаж авах зэргээр шар, хар олныг гачигдуулан зовоосонд Дотоод ба Гадаад яамнаас түшмэл томилон Оросын элчин, консул сайдтай зүйлчлэн хэлэлцэж, хэргийн доторх этгээдийг зарлан ирүүлж, хамт нийлэн байцаасанд, Орос Мухиликов харин шууд Орос газар зарлал бичиг тарааж, хэдэн зуун өрх Орос хүмүүсийг нэмэн элсүүлэн ирүүлж, харьяат газрыг хэд хэдэн хэсгээр таслан хэмжиж хот балгас байгуулан тариа будаа тариулан үүрд эзлэн суулгахаар шийдвэрлэн үйлдвэрийг үүсгэсэн бүхийг олж сонсоод, шавь боолчуудын газраас ойрыг үзэн Шүүн таслах яамны дэс түшмэл Цэдэнбалжирын хамт харьяат нутгийг шууд эгүүлэн авч, батлан





ᠬᠤᠠᠨᠮᠤᠭ᠎ᠠᠯᠵᠢ ᠴᠢᠳᠠᠬᠤᠭᠢ ᠪᠣᠳᠤᠵᠢ ᠲᠤᠰ ᠶ᠋ᠠᠮᠨᠢ

хамгаалж чадахыг бодож, тус яамны дэс түшмэл Амарыг томилон гаргаж зэвсэг бүхий цэрэг 20-ийг дагалдуулан яаравчлан илгээсэнд, Орос Мухиликовыг түүний элсээн ирүүлсэн хэдэн зуун өрхийн хүний хамтаар харьяат нутгаас шууд үлдэн буцааж, орон байшин, усан тээрэм, бэлтгэсэн мод зэргийг хураан аваад урьдын орон байшин, газрыг нарийвчлан хэмжиж, түрээсийг хураан авч бас Уялга, Чигтай харуулын нутагт дураар орон байшин байгуулан сууж, тариа тарьсан Орос хүнийг мөн нэгэн адил байцаан шийтгэж, мэдүүлэн ирсэн нь хэргийн зүйлд тавтай нийлэлцсэн ба тухайд шавь боолчуудын газраас дэс түшмэл Цэдэнбалжирыг хэвээр томилон Хүдэр, Чигтай, Уялга 3 харуулын газар нутгийг сахин суулгасан. Гэтэл бас Орос Мухиликов зальхай муу Орос хүн нар лугаа сүлбээлдэн харьяат харуулын нутгийг эрхлэх эрх хэвээр буй хэмээн элдэв үг тархаасан учир Хүдэр харуулын нутагт бүхий Орос хүн нар сэмхнээр үлэмж тооны буу зэвсэг цуглуулан хууль дүрмийг дагахгүй хэмээн мөчөөрхөн зөрчиж, зах хязгаарын газар түгшүүртэй байдал өдүүлсэн учрыг Оросын элчинтэй хэлэлцэхэд түшмэл томилон гаргуулж, тэдгээр Орос нарыг гэрээ бичиг, дүрэм хэмжээг дагуулан шийтгэж Орос Мухиликовд түүний хураагдсан орон байшин, усан тээрэм зэргийг буцаан өгч, гэрээ бичгийг эргүүлэн авахаар тогтсон (МУҮТА, А-11. Х-1. ХН.1118. б.31).

Дурдан буй үед харуулын нутагт байгалийн баялаг ашиглах явдал урьдын адил хэвээр үргэлжилж байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор зарим тохиолдолд харуулын нутгийг гадаадын иргэдэд алдах нөхцөл байдал үүсэж байжээ. Ийм тохиолдолд талууд гэрээнд тусгасанчлан гэрээний үүргийг

биелүүлээгүй тохиолдолд тус гэрээг цуцлах тохиолдол гарч байв.

### Дүгнэлт

Хиагтын гэрээ байгуулагдахын өмнөх өрх харуулын алба нь үндсэндээ Манжийн үеийн харуулын зохион байгуулалт ерөнхийдөө хэвээр хадгалагдах болсон хэдий ч зарим талаар өөрчлөлт орсон байна. Тодруулбал, Халхын 4 аймгийн хойд зүгийн нийт 47 хэвээр байсан хэдий ч харуулд суугчдын тоо буурч, нэмэгдсэн байна. Тухайлбал, 1912оны үед харуул тус бүрд 20-30 өрх цэрэг байсныг 2 өрх цэрэг суулгаж, тэдний аль нэгийг занги болгохоор шийдвэрлэсэн хэдий ч 1913 оны үеэс харуулд суугчдаас гомдол ирэх болсон учраас энэхүү тоог 5-10 өрх цэрэг болгон нэмэгдүүлэв. Мөн Хиагтын зүүн, баруун гарын харуулыг захирагч оронг хасаж, харуулуудыг нутаг ойр хошуунд, харин харуулын сүм хийдийг өндөр хэргэмтэй хутагт хувилгаадад захируулахаар шийдвэрлэснийг болиулж, дахин Хиагтын баруун, зүүн гарын харуулын даргын оронг сэргээжээ. Мөн харуулын нутагт байгалийн баялаг ашиглах болсон нь улсын санг арвижуулах бодлого байсан бөгөөд энэхүү бодлогын хэрэгжүүлэхийн тулд харуулуудын нутагт газар болон байгалийн баялаг ашиглуулах зөвшөөрлийн бичих олгох болсон байна. Үүний тулд харуулын нутагт тусгай түшмэл суулгаж, харуулын нутаг дэвсгэрт малын бэлчээр ба эрхэм сүлдэт тахилга бүхий газар буй эсэхийг тодорхойлуулан аваад дурдсан газарт байгалийн баялаг ашиглахыг хориглодог байв. Мөн дагаар орогсдол харуулын нутгаас газар олгосонтой холбоотойгоор тэд уул газрыг гадаадын иргэдэд түрээслүүлж ашиг олж байсан нь олон маргааны үндэс болж байв.

Харин Хиагтын гэрээний байгуулагдсаны дараа тус гэрээний биелэлтийг хангах болон илүү зардал чирэгдлийг хэмнэх зорилгоор Хиагтад сууж хэрэг шийтгэх сайдын газар байгуулагдав. Ингэснээр Хиагтын баруун, зүүн гарын харуулуудыг захирах оронг хасаж, тэдгээрийг Хиагтад сууж хэрэг шийтгэх сайдад харьяалуулах болсон байна. Мөн зарим харуулын нутагт алба нэвтрүүлэхэд бэрхшээлтэй байсан учраас нэр бүхий 7 харуулуудыг зэргэлдээ харуулыг товчлон захирах түшмэлийн мэдэлд шилжүүлсэн байна. Үүнээс гадна харуулд суух занги, сүмд хийдийн удирдлагын дунд албан тушаалын маргаан гарч байв. Мөн харуулын нутагт байгалийн баялаг ашиглах явдал урьдын адил хэвээр үргэлжилж байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор зарим тохиолдолд харуулын нутгийг гадаадын иргэдэд алдах нөхцөл байдал үүсэж байжээ. Ийм тохиолдолд талууд гэрээнд тусгасанчлан гэрээний үүргийг биелүүлээгүй тохиолдолд тус гэрээг цуцлах тохиолдол гарч байв.

### Санал

Монголчууд Манж Чин улсын ноёрхолд орох үеэс анх харуулын алба залгуулж эхэлсэн бөгөөд энэхүү алба нь Богд хаант Монгол Улсын үед үргэлжилсэн нь. Гэвч дурдан буй үед

харуулын албаны талаарх архивын баримт мэдээ Үндэсний төв архивт хадгалагдаж буй хэдий ч судалгааны эргэлтэд орсон нь ховор байна. Иймээс харуулын албаны талаарх баримтыг судалгааны эргэлтэд оруулж, танилцуулах хэрэгцээ шаардлага байна.

### Ашигласан материал

1. МУУТА. А-11, Х-1, ХН.1009
2. МУУТА. А-11, Х-1, ХН.1050
3. МУУТА. А-11, Х-1, ХН.627
4. МУУТА. А-11, Х-1, ХН.665
5. МУУТА. А-11, Х-1, ХН.814
6. МУУТА. А-11. Х-1, ХН.1118
7. МУУТА. А-3, Х.1, ХН.91
8. МУУТА. А-3, Х-1, ХН.12
9. МУУТА. А-3, Х-1, ХН.316
10. МУУТА. А-3, Х-1, ХН.397
11. МУУТА. А-3, Х-1, ХН.447
12. МУУТА. А-11, Х-1, ХН.1009
13. МУУТА. А-11, Х-1, ХН.1050
14. МУУТА. А-11, Х-1, ХН.627
15. МУУТА. А-11, Х-1, ХН.665
16. МУУТА. А-11, Х-1, ХН.814
17. МУУТА. А-11. Х-1, ХН.1118
18. МУУТА. А-3, Х.1, ХН.91
19. МУУТА. А-3, Х-1, ХН.12
20. МУУТА. А-3, Х-1, ХН.316
21. МУУТА. А-3, Х-1, ХН.397
22. МУУТА. А-3, Х-1, ХН.447



## МОНГОЛ УЛС ДАХЬ СОЁЛЫН ӨВИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭЖ ИРСЭН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ

### THE HISTORICAL TRADITION OF COMBATING CRIMES AGAINST CULTURAL HERITAGE IN MONGOLIA



Улсын дотоод асуудлыг зохицуулах  
юстицийн их сургууль

#### Ц.Түвшинжаргал

Дотоод хэргийн их сургуулийн докторант

#### Ts. Tuvshinjargal

Doctoral student of the University of Internal Affairs, Mongolia

\*хариуцлагатай зохиогч: tuvshu2017@gmail.com

**Хураангуй:** Монгол төрийн хууль цаазын түүхэн эх сурвалжид соёлын биет өв (түүх соёлын дурсгалт зүйл)-ийг хамгаалах үзэл санаа эрт үеэс шашин, нийгмийн ёс суртахуун, зан заншилд суурилсан төрийн бодлогоор илэрхийлэгдэж ирсэн бөгөөд XIII зуун, “Их засаг хууль”-нд энэ тухай зохицуулалт анхлан тусгасан байна.

Түүх, соёлын биет өв (хөдлөх болон үл хөдлөх дурсгалууд) нь авто болон төмөр замын дэд бүтэц, уул уурхайн үйл ажиллагаа, эрчимжсэн газар тариалан, түүнчлэн дайн, зэвсэгт мөргөлдөөн, нийгмийн бослого үймээн, суурьшлын бүсийн тэлэлт, вандализм, зарим сүсэг бишрэлийн үйлдэл зэрэг хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй нийгмийн хүчин зүйлсээс гадна, эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой (жишээ нь, амар хялбар аргаар хууль бус ашиг олох зорилготой тонолт, худалдаа) гэмт хэргийн улмаас бодит аюул, эрсдэлд байнга өртөж байдаг.

Манай улсад сүүлийн жилүүдэд амар, хялбар аргаар мөнгө олох гэсэн шунахайн сэдлээр, хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх, тэр дундаа эртний булш, бунхан, сүм хийдийн туурь зэргийг тонох замаар эвдэх, гэмтээх, устгах, завших, худалдан борлуулах, улсын хилээр хууль бусаар гаргах гэмт хэргийн гаралт ихсэх хандалгатай байгаагийн зэрэгцээ, нийгмийн хөгжлийг дагасан дэд бүтэц, барилга байгууламж, уул уурхай, газар тариалан зэрэг аж үйлдвэрлэлийн явцад түүх, соёлын үл хөдлөх дурсгал устаж үгүй болж байна.

Монгол үндэстний оршин тогтнохын үндэс болсон түүх, соёлын дурсгалт зүйлсээ хадгалж, хамгаалах, хойч үедээ өвлүүлэх зайлшгүй шаардлага тулгарч буй энэ цаг үед, өвөг дээдсийн соёлын биет өвийг хамгаалж ирсэн түүхэн уламжлалд үндэслэн, орчин цагийн нийгэм, эдийн засаг болон олон улсын жишигт нийцсэн эрх зүйн орчинг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн түүхэн уламжлал, эрх зүйн орчныг судалсан болно

**Abstract:** In the historical sources of Mongolian state law, the idea of protecting tangible cultural heritage (historical and cultural monuments) has been expressed in state policy based on religion, social morality, and customs since ancient times, and regulations on this were first included in the 13th century, in the "Great Law".

Historical and cultural heritage (movable and immovable monuments) is constantly exposed to real threats and risks due to social factors caused by human activities, such as road and railway infrastructure, mining activities, intensive agriculture, as well as war, armed conflict, social unrest, urban sprawl, vandalism, and

some religious practices, as well as crimes related to economic conditions (for example, robbery and trafficking aimed at obtaining illegal profits through easy means).

In recent years, in our country, there has been an increase in the number of crimes such as illegal archaeological and paleontological exploration and excavation, including looting, damaging, destroying, embezzling, selling, and illegally exporting ancient tombs, shrines, and temple ruins, motivated by greed for easy money. At the same time, historical and cultural monuments are being destroyed in the process of social development, such as infrastructure, construction, mining, and agriculture.

In this era of urgent need to preserve, protect, and pass on to future generations the historical and cultural monuments that are the foundation of the Mongolian nation's existence, based on the historical tradition of protecting the tangible cultural heritage of our ancestors, this study examines the historical tradition and legal environment of combating crimes against cultural heritage in order to contribute to the creation of a legal environment that is in line with modern society, economy, and international standards.

**Түлхүүр үгс:** Соёлын өв, түүх, соёлын дурсгалт зүйл, хууль бус эргэлт, уламжлал

**Keywords:** Cultural heritage, history, cultural monuments, illicit circulation, traditions

### Удиртгал

Соёлын өв нь ард түмний түүхэн ой санамж, үнэт уламжлал, оюуны дархлаа бөгөөд аливаа улс үндэстний оршин тогтнохын баталгаа юм.

Өрнө дорны улсуудын түүх, соёлын өвийн судалгааг багтаасан ном бүтээл, судалгаа шинжилгээний ажлуудаас үзэхэд, Монголын түүхийн ухааны нэрт эрдэмтэн судлаач Д.Майдар “Олон зуун жилийнхээ хөгжлийн явцад Монголын ард түмний бүтээсэн түүх соёлын дурсгалууд нь тэдний түүхэн замнал, уламжлал, гавьяа бүтээл, хүсэл мөрөөдөл, зан суртахууны зарчим, гоо зүйн үзэл, уран сайхны туршлагыг тольдон харуулж байна. Иймээс өнгөрсөн үеийн дурсгалууд бол түүхийг танин мэдэх арга хэрэглүүр төдийгүй, мөн урагш давшин хөгжихийн эх булаг болно. Тэр дурсгалууд нь иргэний хүмүүжлийн хүчирхэг зэвсэг болж, олон үеийнхний холбоог гагнан бэхжүүлдэг юм” гэсэн бол судлаач П.К.Козлов 1926 онд Монголын тухай бичихдээ “Газрын гадаргуу дээр болоод доор өчнөөн их

хөшөө дурсгал, олон янзын соёл иргэншлийг хадгалсан өөр ийм орон бараг байхгүй (Д.Майдар, 1982) гэсэн байдаг.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуульд “Соёлын өв гэдэг нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий биет болон биет бус хэлбэрээр оршин буй өвийг хэлнэ (эмхэтгэл, 2024)” гэж тодорхойлсон байдаг.

Түүхийн ном хэвлэлд Монгол улсын нутаг дэвсгэрээс нээн илрүүлсэн археологийн дурсгалууд нь Монголд эртнээс нутаглан суусан овог, аймаг, угсаатан, улс түмний ялангуяа өвөг дээдсийн эртний түүх соёлыг судлахад эрдэм шинжилгээний онцгой чухал баримтууд болдог (хүрээлэн, 2004). Эд өгийн сурвалж нь бичиг үсэг үүсэхээс өмнөх нэн эртний түүхийг судлах, боловсруулахад “цорын ганц” сурвалж болохоос гадна бичиг үсэг үүссэнээс хойш ч эртний ба дундад эртний үеийн бичигдэн тэмдэглэгдээгүй түүхэн хэрэг





явдал, соёл боловсролыг сэргээн шинжлэхэд мөн л эрхэмлэгдэж байна (ШУА, 2004) хэмээн тэмдэглэсэн байдаг нь эдгээр зүйлсийн шинжлэх ухаан, танин мэдэхүйн ач холбогдол өндөр болохыг илтгэн харуулна.

Олон улсын шинжтэй гэмт хэргүүдийн дотор урлагийн бүтээл, хуучны ховор эд юмс хулгайлж, дамлан худалдах явдал үйлдэгдсэн тоогоороо мансууруулах бодис наймаалахын дараа ороод байна. Интерполын мэдээгээр дэлхий дээр өдөр бүр 450-500 уран зураг, баримал, хуучны ховор эд зүйлс, шашны шүтээн, археологийн үнэт олдвор болон янз бүрийн эрин үеийн ба ард түмний соёлын дурсгалт зүйлсийг хулгайлж байна (Д.Мөнхтуяа, 2000) гэсэн байна. Энэ төрлийн гэмт хэрэг нэг орны хүрээнээс гарч улс дамжин үйлдэгдэх болсон нь дан ганц улс тэмцэх бус олон улсын хэмжээнд хамтран ажиллаж байж тодорхой үр дүнд хүрэх нь дамжиггүй юм. Иймд энэ төрлийн гэмт хэргүүдийн онцлогт нийцсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох, шалтгаан нөхцөлийг судалж тэмцэх, урьдчилан сэргийлэх арга замыг боловсронгуй болгох шаардлагатай байна (Б.Лхагварагчаа, 2024).

Улс орнууд ирээдүйд орших эс орших асуудал нь техник, технологийн хөгжлөөр бус дэлхийн хүн амын өсөлт, үндэсний капитал, угсаа гарвал, түүхийн тодорхой цаг хугацаа дамжин хадгалагдаж ирсэн түүх, соёлоос жил ирэх тусам хамааралтай болсоор байна. Монгол үндэстний гал голомтод хадгалагдан ирсэн түүхэн цаг хугацааг илэрхийлэх, эртний эд өлгийн зүйлсийг хууль бусаар олж аван, угсаа гарвалаа хамаатуулах улс төрийн зорилготой гадаад орны далд сонирхол, хувь хүмүүсийн амар хялбар аргаар ашиг орлого олох, эдийн засгийн хууль бус үйл ажиллагаа нь үндэстэн дамнасан

зохион байгуулалттай гэмт хэргийн шалтгаан нөхцөл болж байна. Дээрх үйл ажиллагааг гадаад орнуудын зүгээс хамтарсан хайгуул судалгаа, шинжилгээ хийх, түүхийг гуйвуулсан үзэл суртлын үйл ажиллагааг төрөл бүрийн аргаар явуулах хандлагатай байдаг (Б.Лхагварагчаа, 2024).

Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Монгол Улсын нэгдэн орсон Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай, Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах, Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхиүлэн дэмжих тухай, Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай, Соёлын биет бус өвийг хамгаалах зэрэг конвенц нь энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд холбогдох хууль, эрх зүйн актууд болж байна.

Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг нь ихэвчлэн нууц, далд аргаар тодорхой хүмүүсийн хүрээлэл дунд үйлдэгддэг. Гэмт хэрэг нь үйлдсэн үед эзэн холбогдогч тодорхойгүй, гэмт хэргийн ул мөр устаж үгүй болсон байдаг. Хулгайлах, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх, Мөнгө угаах, Албан тушаалын гэмт хэргийн шинжийг давхар агуулдаг. Монгол Улсад бүртгэгдсэн нийт гэмт хэрэгт соёлын өвийн эсрэг гэмт хэргийн эзлэх хувь бага боловч энэ төрлийн гэмт хэргийн эрүүгийн нөхцөл байдал жил ирэх тутам хүндэрч, гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж байна. Энэ төрлийн гэмт хэрэг нь нууц далд аргаар, зохион

байгуулалттай, улс дамжин, гадаадын иргэд холбогддог зэрэг онцлогтой (Б.Лхагварачаа, 2024).

Соёлын өвийн өвийг хамгаалах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэж ирсэн эрх зүйн хөгжлийг түүх, соёлын болон хууль зүйн хөгжлийн түүхийн эх сурвалж, бүтээлд тулгуурлан гурван үечлэлд хуваан авч үзлээ. Үүнд: Нэгдүгээр үечлэл буюу “Эртний үе”, хоёрдугаар үечлэлд Богд хаант Монгол Улсаас Ардчилсан Монгол Улс хүртэлх, гуравдугаар үечлэлд Ардчилсан Монгол Улсаас өнөөг хүртэлх цаг үеийн баримт, эрх зүйн хэм хэмжээг хамааруулсан.

### Нэгдүгээр үечлэл /ЭРТНИЙ ҮЕ/

Энэ үеийг түүхэн эх сурвалжаас хамааруулан Монголын эзэнт гүрнээс өмнөх ба хойших гэж хоёр хэсэгт хуваан авч үзлээ.

Монголын эзэнт гүрнээс өмнөх үе – Монголчууд мал ахуйгаа дагасан нүүдэлчин соёлтой ард түмэн төдийгүй ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйл, **соёл**, ахуйн өвөрмөц хэв маягийг өөртөө тээж байдаг.

Монголчууд булш бунханыг дээдсийн нутаг, онгод шүтээн нь тухайн овог аймгийн сүнс, дээдэс нь хойдсоо хамгаалдаг гэх үзэл санаанаас эхлэлтэй юм. Тиймдээ ч дайн тулааны өмнө овог аймгууд нэгнийхээ онгод шүтээн, булш бунханыг сүйтгэх, тонох өөрөөр хэлбэл тэтгэх сүнсгүй болгох зорилготой байжээ. Мөн шунахай сэдлээр, олз хайгсад байсныг дурьдах нь зүйлтэй. Үүний нэг илрэл нь монгол орны хэмжээнд хүннүүгийн үеийн 10400 орчим булш, бунхан байгаагаас ихэнх нь тоногдсон явдал юм.

“Хан улсын бичиг”-ийн “Хүннү шастир” болох 94-р бүлэгт” ухуаньчууд тэнгэрт хальсан шаньюйн булш онгоныг ухаж тонож сүйтгэсэнд

хүннүчүүд хэлгэнэн 2 түмэн цэрэг илгээн ухуаныг довтлов” гэсэн тэмдэглэн үлдээсэн буй. Язгууртны булшийг тонож сүйтгэсэн дээрх явдал нь түүнээс сэргийлэх, хамгаалалтыг сайжруулах шаардлагатайг ойлгуулсан бөгөөд үүний илрэл нь нүхийг илүү гүнзгий ухдаг болж, тонуулчид хялбар нэвтрэхээс сэргийлж олон үе чулуун чигжээс хийхэд хүргэсэн гэж болно.

Хүннүгийн язгууртны булш эхэн үедээ жирийн жижиг булшнуудтай төстэй цагариг хэлбэрийн гадаад чулуун байгууламжтай, гүнзгий нүхэнд том хэмжээтэй дүнзэн хашлага буюу бунхантай байсан бол ХуХане шаньюй, эсвэл түүний удмын шаньюй нарын төр барьсан үе, НТӨ I зууны төгсгөл, НТ I зууны үед булшны нүхийг ухах арга барил өөрчлөгдөж үүдэвчтэй дөрвөлжин хэлбэрийн шатласан асар гүнзгий нүх ухаж оршуулга хийдэг болсон (Архелогийн хүрээлэн, 2024).

Монголын эзэнт гүрнээс хойших – Монголын төрийн анхны хууль цааз болох “Их засаг хууль” (XIII зуун)-д шашин, булш оршуулгын ёсыг доромжлохыг хориглосон нь соёлын өвийг хамгаалах эрх зүйн үндэс болсон гэж судлаачид үздэг (хууль).

Тус хуулинд Монгол цэргүүд аялан явах замдаа тухайн улс орны ард түмний түүхэн дурсгалт зүйлүүд ба өмч эд хөрөнгийг тонон дээрэмдэж болохгүй. Мөн тэдний орон байрыг галдан шатааж болохгүй. Мал бусад ан амьтаныг устгаж хэрхэвч үл болмой. Манай цэргүүд зөвхөн дайсан этгээдийг устгамай гэж заасан нь тухайн үеийн түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах анхны хэм хэмжээг тогтоосон явдал юм (хууль).

Мөн Түмэдийн алтан ханы цаазад “Оршуулгын газраас эд юмсыг авбаас амьд хүний эдийг хулгайлсантай адил цаазтай” гэж заасан байжээ (Б.Баярсайхан, 2006).





XVII–XIX зуунд Манжийн төрийн зарлигаар хийдийн дотоод сахилга, дүрмээр дамжуулан соёлын үнэт зүйлсийг хамгаалж байсан. Шүтээн, судар, бурхан эвдэгчдийг хатуу шийтгэдэг байсан тухай сурвалжид тэмдэглэгдсэн (Paul, 1989). Мөн Судрын чуулганд “Би өвөг дээдсийнхээ газар нутаг, орон өргөөг алга болгоход хүргүүлэхгүй. Би тэдний ёс заншил зам мөрийг устгуулахгүй (Аддин, 2002). Халхын үйсэн дээрх бичээс, Яамны халх журам дүрэм /В эх/, Гурван их цаазад “Сүм бурханы харьяат чимэг эд малыг хэн хүн хулгай хийвээс гэгээний сан сүргийг хулгай хийсэн лүгээ адил үзэхээр хууль, цаазын бичигт тусгаж байсан нь тухайн үедээ сүсэг бишрэл, зан заншлийн шинжтэй байсан хэдий ч түүхэн эх сурвалжийг хамгаалж ирсэн нэгэн хэлбэр болж байгаа юм.

Монголын цааз бичиг. Аравдугаар дэвтэрт “Хүүр уудлах нь”: Түшмэл ба харц хүн ван, бэйл, бэйс, гүн, жич бас эдний хатдын хүүрийг уудалбал тэргүүлсэн хүнийг даруй дээр цавчиж ал. Эм, хөвгүүд ба гэр, малыг хийсгэгтүн. Тэд хүнийг зуугаад ташуурдаад, гурван есөөр торгоод, засгаар болгсон хулгайчийн эм, хөвгүүд, гэр, мал сэлтийг хүүрийн эзэнд өг. Тайж тавнангуудын хүүрийг уудалбал тэргүүлсэн нэг хүнийг дөвчилж ал. Гяданд хорьж хүлээ. Дэд хүнийг зуугаад ташуурдаад, хошоод есөөр торгож хүүрийн эзэнд өг. Түшмэдийн хүүрийг уудалбал тэргүүлсэн нэг хүнийг зуу ташуурдаад ялын мал гурван есөөр торго. Бусдыг зуугаад ташуурдаад нижгээд есөөр торгож, цөм хүүрийн эзэнд өг. Энгийн хүний хүүрийг уудалбал тэргүүлсэн хүнийг нэг зуу ташуурдаж ялын малын нэгэн есөөр торго. Бусдыг наяд ташуурдаад нижгээд есөөр торгож цөм хүүрийн эзэнд өг (бичиг).

Үүнээс гадна Зарлигаар тогтоосон гадаад монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичгийн Гучин есдүгээр дэвтэрийн 39.1 Харц хүн вангуудын хүүрийг эрэх нь, Тавинзургаадугаар дэвтэрийн 56.7. Хутагт нарын тамга навчит өргөмжлөл сурах зарлигийн тогтоосон хууль зэрэг булш ухахыг хориглосон зүйл заалтуудыг тусгаж өгсөн байна.

Оросын эрдэмтэн Н.М. Ядринцев 1889 онд Орхон голын хөндийгөөс эртний үл уншигдах бичээст хөшөө олж, Монголын эзэнт Их Гүрний нийслэл Хар Хорим хотын ор үлдцийг малтаж эрдэм шинжилгээний тодорхойлолт бичсэн цагаас Монгол орны археологийн судалгааны ажил эхэлсэн гэж үзлэг (Г.Энхбат, 2004). Түүхийн эх сурвалжийг судалж үзэхэд эрт үеэс нас барагсдын эдэлж, хэрэглэж байсан эд өлгийн зүйлийг хамтад нь оршуулдаг байсан бөгөөд овог, аймгууд хоорондын дайн, олз хайгчид язгууртны булш бунханыг тонох явдал НТӨ III мянган буюу Хүрэл зэвсгийн үеэс эхлэлтэй гэж үзэхээр байна.

Монгол оронд хийгдсэн археологийн судалгаанаас үзэхэд хүннүгийн үеэс язгууртны булш, бунхан илүү гүнд, байгууламж хэлбэртэй болж, нууцлагдсан бөгөөд XIII зууны Монголын эзэнт гүрний үеийн язгууртны булш нэг ч олдоогүй байгаагаас Монголын төрт улс үеийн үед хаадын булш бунханыг тонуулах, сүйтгүүлэхгүй байхад анхаарч хадгалалт, хамгаалалтыг сайжруулсаар ирсэн харагдаж байна. Энэ үед булш, бунханыг дээдсийн нутаг, онгод шүтээн нь тухайн овог аймгийн сүнснийг хөндүүлэхгүй байх сүшиг бишрэлийн агуулгаар нь хамгаалж байсан гэж үзэж болохоор байна.

## Хоёрдугаар үечлэл

### /БОГД ХААНТ ОНГОЛ УЛСААС АРДЧИЛСАН МОНГОЛ УЛС ХҮРТЭЛХ ҮЕ/

Манжийн дарлалас тусгаар тогтнолоо 1911 онд зарлаж VIII Богд Жавзандамба Богд хаанаар өргөмжлөгдсөн үеэс эхэлж, 1924 онд Богд хаан таалал төгснөөр Бүгд Найрамдах Монгол Ард Улсыг байгуулсан бөгөөд 1990 оны ардчилсан хувьсгалаар нийгмийн байгуулал өөрчлөгдөж, 1992 онд шинэ Үндсэн хууль батлагдан Сонгол Улс ардчилсан эрх зүйт улс болсон.

Түүхийн энэ үеэс хууль, эрх зүйн өөрчлөгдөж Монгол Улс түүхэндээ үндсэн хуультай болж, бусад салбар хуулиуд Үндсэн хуульдаа нийцүүлэн батлагдан, эрх зүйн орчин дээшлэх үе шат руугаа орсон гэж үзэж болно.

Богд хаант Монгол Улсын “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичиг”-ийн Арав, Тавингурав, Тавин дөрөв, Тавинтавдугаар дэвтэрүүдэд соёлын өвийн талаар “хүүр эрэх, явалдах, аргадан авч худалдах ба худалдан авах тухай 8 зүйлийг багтаасан байдаг.

Эртний уламлалт оршуулгын заншил нь хаад хоёд, хутагт хувилгаад, бөө, чойжинг оршуулах тусгай зан үйл, эгэл ардыг хөдөөлүүлэх ёслолоос бүрддэг байсан ба “хууль зүйлийн бичигт” хүүр эрэх гэмт хэргийг хоёр зүйл болгон эхний зүйлд ван, бэйл, бэйс, гүн, засаг тайж зэрэг ноёд, язгууртнууд, тэгээрийн хатдын хүүрийг эрэх хэрэг, удаад нь бусад хүний хүүрийг эрэх хэрэг гэж ангилдаг байжээ.

Ноёд язгууртны хүүр эрсэн хэргийг дотор нь үйлдлийн байдлаас хамааран хэд хэдэн бүрэлдэхүүнд хуваасан. Үүнд:

- Хүүрийг эрсэн боловч үзээгүй

- Эрээд авсыг олж үзсэн бол
- Авсыг нээж яс /цогцос/-ыг үзсэн бол

- Ясыг эвдэлж гээсэн бол  
Дээрх хэргийг үйлдсэн этгээдүүдийг гэмт хэрэгт оролцсон байдлаар нь

- Тэргүүлсэн
- Дэд болж явсан этгээд
- Явыг авдаж гээсэн этгээд гэж ангилж, тус бүр ялыг ялгамжтай оногдуулж байсан (Б.Баярсайхан, 2011).

Мөн Арвантав. Жарантавдугаар дэвтэрт “Янз бүрийн гэмт хэрэг” хэмээх гэмт хэргийг тусгасан байх бөгөөд үүнд Булшны чулуу, тэмдэг чулуу, дурсгалт хөшөө зэргийг эвдэж сүтгэх, хүний бичсэн зүйлс, зурсан зургийг гэмтээж сүйтгэсэн бол 80 ташуур занчих. “Цаазалсныг зөрчих нь” хэмээх 64 дүгээр дэвтэрт ёс заншлын болон хэвшүүлэн тогтоосон хэм хэмжээг зөрчсөн тохиодолд хүлээлгэх эргүүгийн харицлагын талаар дурьджээ (бичиг Х. з., 1911).

Ардын хувьсгалаас хойш 1990 он хүртэлх үеийн хууль, эрх зүйн актууд хамаарах үе юм. Эрүүгийн хуулийн Арваннэгдүгээр бүлэгт “Ард олны ашиг, хөрөнгийг хамгаалах тухай хууль дүрмийг зөрчих нь” 114 дүгээр зүйл. “Эртний цагаас үлдсэн хуучны ба орлож үйлдсэн дурсгал болох онц зүйлүүдийг сахин хамгаалах дүрэм зөрчигсдийг 1 жил хүртэл гянданд хорино” гэж заасан. Гучдугаар бүлэгт “Хулгайлах, булаах ба дээрэмдэх зэргээр бусдын эд хөрөнгийг сүтгэх нь” 208 дугаар зүйл. Аливаа хүн үхдэлийн гэр ба булш зэргийг уудлах, юм зүйлсийг хулгайлбаас 6 сараас 3 жил хүртэл гяндах хорино. Тайлбарлах нь: Олны тахисан овоо, сүлд буюу эртний булш зэргийг эвдэж юм зүйлсийг хулгайлан авбаас энэ ёсоор шийтгэнэ (бичиг III. ц., 1929).





БНМАУ-ын Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлэгт “Нийгмийн аюулгүй байдал, нийгмийн хэв журам, ард иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг”-үүд хамаарах бөгөөд 188-р зүйл. Булш шарилыг сүйтгэх “Булш шарилыг сүйтгэсэн буюу түүнд байсан зүйлүүдийг хулгайлан авсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих, эсхүл нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэнэ”. 189-р зүйл. Соёлын дурсгалт ба хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгах, эвдэх, гэмтээх.

Соёлын дурсгал ба улсын хамгаалалт бүхий байгалийн зүйлүүдийг санаатайгаар устгасан, эвдсэн, гэмтээсэн байвал нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл туган зуун төрөг хүртэл тогоно. 257-р зүйл. Булш сүйтгэх “Булш сүйтгэсэн буюу түүнд байсан зүйлүүдийг авсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ”. “258-р зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг санаатай устгах, эвдэх, гэмтээх. Түүх, соёлын дурсгал зүйлийг санаатай устгасан, эвдсэн, гэмтээсэн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар хорих буюу мөн хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл нэг мянга хүртэл төрөгөөр торгох ял шийтгэнэ (хууль Э., 1942).

“Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль”-ийг 1970 онд шинэчлэн найруулж, археологийн хайгуул, малтлага зөвхөн төрийн зөвшөөрлөөр явуулах, олдворыг хувь хүн эзэмшихийг хориглосон. Энэ үед археологийн судалгааг шинжлэх ухааны төвшинд явуулж, олдворыг музей, архивт төвлөрүүлсэн байна.

## Гуравдугаар үечлэл /1990 ОНООС ХОЙШ ӨНӨӨГ ХҮРТЭЛХ ҮЕ/

Монгол Улсын Үндсэн хууль /1992 он/-д Төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж, Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна хэмжээн Монгол Улсын бүрэн эрхэт байдлыг зарлан тунхагласан.

Энэ ч утгаараа 2002 оны Эрүүгийн хуульд Хорин гуравдугаар бүлэг, байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт 210 дугаар зүйл. Байгалийн объектыг санаатай эвдэх, гэмтээх, устгах гэмт хэрэгт 210.1.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалтад орсон байгалийн объектыг санаатай эвдсэн, гэмтээсэн, устгасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 175 дугаар зүйл. Эд зүйлийг хууль бусаар хил нэвтрүүлэх, 175.2-д ...түүх соёлын дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны болон ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн ба палентологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн ..., Гучдугаар бүлэг “Хүн төрөлхтөний аюулгүй байдал, энхтайвны эсрэг гэмт хэрэг” 299 дүгээр зүйл. Хориглосон арга хэрэгслээр дайн хийх 299.1-д ... эзлэгдсэн нутагт түүх соёлын үнэт зүйлийг тонон дээрэмдсэн (хууль Э., 2002) ... гэж тус тус дээрх нэр томъёоллоор тусгасан.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байнаа Эрүүгийн хуулийн 25 дугаар бүлэг Соёлын өвийн эсрэг гэмт хэрэгт 25.1 Түүх соёлын дурсгалт

зүйлийг эвдэх, гэмтээх, устгах, 25.2 Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах, 25.3 Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх, 25.4 Хууль бусаар археологи, палеонтологийн хайгуул, малтлага хийх, 25.5 Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах, 25.6 Түүх соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх, 25.7 Эрдэнэсийн сангийн үндсэн санг хууль бусаар зарцуулах хэргүүд багтах бөгөөд мөн эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.2 түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлах, 18.5 дугаар зүйлийн 3 түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх (хууль Э. , 2015) зэрэг үйлдүүдийг гэмт хэрэгт тооцоохоор зохицуулалт хийж, түүхийн соёлын үнэт дурсгалт зүйлээ хуулиар хамгаалж байна.

Соёлын биет өвийн хууль бус худалдаа зохион байгуулах, зуучлах гэмт хэрэг нь буурахгүй, нуугдмал байсаар байгаа нь тухайн улс үндэстний оюун ухаан, хүч хөдөлмөр шингэсэн түүхэн тодорхой орон зай, шалгуурыг давсан цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой шашны болон шашны бус шинж чанартай бүтээл, эд өлгийн зүйл төдийгүй хүн төрөлхтний түүх, соёл иргэншлийн баримтат гэрч болдог ба улс орны өвөрмөц соёлын онцлог, түүхэн тодорхой цаг үеийг илэрхийлж чадах, тухайн ард түмний оршин тогтнох үндэс, шинжлэх ухаан, танин мэдэхүй, урлагийн ач холбогдлын

хувьд үндэсний язгуур ашиг сонирхолд нөлөөлдөг учир Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, өв соёл устаж үгүй болох хор уршигтай юм (Б.Лхагварачаа, 2024).

### Дүгнэлт

Монгол угсаатны түүх, соёлын дурсгалыг хамгаалах уламжлал XIII зууны “Их засаг” хуулиас эхтэй бөгөөд үе үеийн хууль эрх зүй, төрийн бодлогоор улам боловсронгуй болж иржээ. XX зуунд төрийн төвшинд хууль эрх зүйн тогтолцоо бий болж, ардчиллын дараа олон улсын хамтын ажиллагаатай уялдан өргөжсөн байна. Өнөөдөр Монгол Улс соёлын өвийг хамгаалахдаа хууль эрх зүй, олон улсын гэрээ конвенц, иргэдийн оролцоог зэрэгцүүлэн ашиглаж байгаа хэдий ч хууль бус худалдаа, устгалын эрсдэл бүрэн арилсангүй. Иймээс уламжлалт хэм хэмжээ, хууль эрх зүйн механизм, олон улсын хамтын ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх нь цаашдын чухал зорилт юм.

Монгол улсад ардчилсан хувьсал явагдаж, 1992 онд улс төрийн тогтолцоог шинэчлэн, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан Үндсэн хууль баталж, зах зээлийн эдийн засагт шилжиж, хувийн хэвшлийг чөлөөтэй болгож, хувийн өмчтэй болох, хүний эрх чөлөөний үндэс болох шашин шүтэх, гадаадад зорчих эрхийг чөлөөтэй болгосны сацуу соёлын өвийг хууль бусаар улсын хилээр гаргах явдал гарах болсон. Гэсэн ч энэ үед олон хууль бус худалдаа илэрч, цагдаагийн байгууллага заримыг нь буцаан авчирч байжээ. (ЦЕГ, 1995–1999)

Үүний зэрэгцээ 1994 оны “Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг батлагдаж, улсын бүртгэл, хамгаалалтын тогтолцоог бий болгосон. Энэ хуулиар Соёлын өвийг бүртгэлд авч, зөвхөн үзэсгэлэнгийн





зориулалтаар гадагш гаргахыг зөвшөөрсөн байна.

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг 2001, 2014 онуудад шинэчлэн баталж, биет болон биет бус өвийг нарийн ангилж, хариуцлагыг өндөржүүлсэн бөгөөд 2015 оны Эрүүгийн хуульд соёлын өвийг хууль бусаар ухах, устгах, хил дамнуулан худалдахыг онц хүнд гэмт хэрэгт тооцсон нь хуулиар хүлээлгэх хариуцлагыг хүндрүүлсэн нь соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаанд ахиц гарсан гэж үзэж болно.

Соёлын өвийн хууль бус худалдааны эсрэг гааль, цагдаагийн байгууллага, олон улсын хамтын ажиллагаа идэвхжиж байгаагийн нэг тод жишээ 2019 онд хуучны ном, бурхан, эртний зэвсгийг хил нэвтрүүлэхийг завдсан хэргийг илэрүүлсэн юм. Энэхүү байгууллагуудын хамтын ажиллагааг улам тогтворжуулж, албан хаагчдын энэ талын мэдлэгийг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага байна.

#### Ашигласан материал

1. Б.Баярсайхан. Монголын төр, эрх зүйн түүх /дээж бичиг/. I дэвтэр. УБ., 2006
2. Б.Баярсайхан нар. Монгол Улсын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011
3. Б.Баярсайхан нар. Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУ-ын Эрүүгийн хууль тогтоомжийн түүхэн уламжлал. УБ., 2011
4. Г.Энхбат.Түүх, соёлын үл хөдлөх дурсгалд сөрөг нөлөөт хүчин зүйлсийн учруулах эрсдэлийн үнэлгээний судалгаа. УБ., 2020
5. Г.Энхбат. Монгол Улсын түүх. Тэргүүн боть (Нэн эртнээс XII зууны дунд үе). Хоёр дахь хэвлэл. УБ., 2004
6. Д.Адъяабазар. Монгол Улсын 1921 оноос хойшхи эрүүгийн хууль тогтоомжийн хөгжил. УБ.,1998
7. Их засаг хууль (XIII зуун)
8. МУ-ын ШУА-ийн Археологийн хүрээлэн.Дурсгалын он цагийн асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ., 2024
9. Монголын нууц товчоо
- 10.Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл
- 11.Рашид Аддин. Судрын чуулган. Орчуулсан Сүрэнхорлоо. I, II, III дэвтэр. УБ.,2002
- 12.Bawden, C.R. The Modern History of Mongolia. Kegan Paul, 1989

## БАГШ, АЛБАН ХААГЧДЫН БИЕ БЯЛДРЫН БЭЛТГЭЛЖИЛТИЙН ӨНӨӨГИЙН ТҮВШИН, ТҮҮНИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

### CURRENT LEVEL OF PHYSICAL FITNESS OF TEACHERS AND STAFF AND WAYS TO IMPROVE IT

#### Д.Түмэнцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Биенийн тамир, албаны бэлтгэлийн институтийн багш, ахлах дэслэгч

#### D. Tumuntsetseg

Senior Lieutenant, Lecturer, Institute of Physical Training and Professional Development, University of Internal Affairs

\*хариуцлагатай зохиогч: dtumee666@gmail.com

**Хураангуй:** Бие бялдрын бэлтгэлжилт нь хүний эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар, ажлын бүтээмжид чухал нөлөө үзүүлдэг. Ялангуяа хууль сахиулах болон цэргийн байгууллагын алба хаагчдын хувьд бие бялдрын өндөр түвшний бэлтгэлжилт нь мэргэжлийн үүргээ амжилттай гүйцэтгэх үндсэн нөхцөл болдог. Иймээс алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг судлах, сул талуудыг тодорхойлох, цаашид сайжруулах арга замыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны ажлын зорилго нь Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн өнөөгийн түвшинг тодорхойлох, сул хөгжсөн бие бялдрын чанаруудыг илрүүлэх, тэдгээрийг сайжруулах боломжит арга замыг тодорхойлоход оршино. Судалгаанд Дотоод хэргийн их сургуулийн 325 багш, албан хаагч хамрагдсан бөгөөд цэргийн биений тамирын бэлтгэлийн стандартын дагуу гар дээр суниалт, 10×10 метрийн гүйлт, 1000 метрийн гүйлт, 1 дүгээр цогцолбор дасгал, сууж урагш бөхийх дасгал зэрэг шалгалтыг авч дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнгээс харахад уян хатан чанарын үзүүлэлт 93.7% буюу хамгийн өндөр гарсан бол хурд 49.4%, тэсвэр 34.6% буюу харьцангуй доогуур үзүүлэлттэй байна. Мөн судалгаанд хамрагдсан алба хаагчдын дунд илүүдэл жинтэй хүмүүс тодорхой хэмжээгээр байгаа нь бие бялдрын бэлтгэлжилтэд сөргөөр нөлөөлж байгааг тогтоосон.

Иймд багш, албан хаагчдын бие бялдрын бэлтгэлийг тогтмол зохион байгуулж, ялангуяа хурд болон тэсвэрийг хөгжүүлэх дасгал сургуулилыг нэмэгдүүлэх, эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

**Abstract:** Physical fitness plays an important role in human health, work capacity, and productivity. For personnel working in military and law enforcement organizations, a high level of physical fitness is essential for performing professional duties effectively. The purpose of this study was to determine the current level of physical fitness of teachers and staff at the University of Internal Affairs and to identify possible ways to improve it.

A total of 325 teachers and staff participated in the study. Physical fitness tests were conducted according to military physical training standards, including push-ups, a



Дотоод Хэргийн Их Сургуулийн  
Биенийн Тамир, Албаны  
Бэлтгэлийн Институт



10×10 meter shuttle run, a 1000 meter run, a complex exercise test, and a sit-and-reach flexibility test.

The results showed that flexibility had the highest performance rate at 93.7%, while speed (49.4%) and endurance (34.6%) were relatively low. In addition, a number of personnel were found to have excess body weight, which negatively affects their physical fitness.

Therefore, it is necessary to organize regular physical training and increase exercises aimed at improving speed and endurance among teachers and staff.

**Түлхүүр үгс:** Бие бялдрын бэлтгэлжилт, цэргийн биеийн тамир, хурд, тэсвэр, дасгал хөдөлгөөн

**Keywords:** Physical fitness, military physical training, speed, endurance, exercise

### Удиртгал

Хүний бие бялдрын хөгжил нь эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар, амьдралын чанарт шууд нөлөөлдөг. Бие бялдрын бэлтгэлжилт сайн байх нь хүний өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй гүйцэтгэх, бие махбодын тэсвэр тэвчээрийг нэмэгдүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зэрэг олон давуу талтай.

Бие бялдрын бэлтгэлжилт нь ихэвчлэн хүч, хурд, тэсвэр, авхаалж самбаа, уян хатан чанар гэсэн үндсэн таван үзүүлэлтээр тодорхойлогддог. Эдгээр нь хүний хөдөлгөөний чадвар, биеийн ерөнхий хөгжлийг илэрхийлдэг.

Цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын хувьд бие бялдрын бэлтгэлжилт нь мэргэжлийн бэлтгэлийн салшгүй хэсэг юм. Тэд онцгой нөхцөл байдалд ажиллах, биеийн хүчний ачаалалтай үйл ажиллагаа явуулах шаардлагатай байдаг тул бие бялдрын өндөр түвшний бэлтгэлжилттэй байх ёстой.

Сүүлийн жилүүдэд хөдөлгөөний дутагдал, суурин амьдралын хэв маяг нэмэгдэх, технологийн хэрэглээ ихсэх зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан хүмүүсийн бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин буурах хандлага ажиглагдаж байна.

Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагчид нь сургалт, эрдэм шинжилгээ, захиргааны болон албаны үйл ажиллагааг зэрэг гүйцэтгэдэг. Тиймээс тэдний бие бялдрын бэлтгэлжилтийн өнөөгийн байдлыг судалж, сул талуудыг тодорхойлох нь байгууллагын хэмжээнд биеийн тамирын сургалтын бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой юм.

### Судалгааны арга, арга зүй

Энэхүү судалгаанд Дотоод хэргийн их сургуулийн нийт 325 багш, албан хаагч хамрагдсан. Үүнээс 181 нь эрэгтэй, 144 нь эмэгтэй алба хаагч байсан.

Судалгаанд оролцогчдын бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тодорхойлох зорилгоор цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандартын дагуу дараах шалгалтуудыг авсан.

**Гар дээр суниалт:** Энэ шалгалт нь гар, мөр, цээжний булчингийн хүчийг тодорхойлох зорилготой.

**10×10 метрийн гүйлт:** Энэ шалгалт нь богино хугацаанд хурдтай хөдөлгөөн хийх болон чиглэл өөрчлөх чадварыг тодорхойлдог.

**1000 метрийн гүйлт:** Энэ нь зүрх судасны болон амьсгалын





Хамгийн доогуур үзүүлэлт тэсвэрийн чанарт ажиглагдсан бөгөөд энэ нь 34.6% буюу хамгийн бага үзүүлэлт болсон байна. 1000 метрийн гүйлтийн шалгалтаар оролцогчдын зүрх судасны болон амьсгалын тогтолцооны үйл ажиллагаа, урт хугацаанд ачаалал даах чадварыг үнэлсэн. Судалгааны дүнгээс харахад оролцогчдын нэлээд хувь нь стандартын шаардлагыг хангаагүй байна.

Энэ нь оролцогчдын дунд тогтмол гүйлт, аэробик дасгал хийх дадал харьцангуй сул байгаатай холбоотой байж болох юм. Мөн ажлын ачаалал их, суурин ажлын нөхцөл, хөдөлгөөний дутагдал зэрэг хүчин зүйлүүд тэсвэрийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж байж болох юм.

Судалгааны явцад оролцогчдын биеийн жингийн үзүүлэлтийг мөн авч үзсэн. Үр дүнгээс харахад алба хаагчдын дунд илүүдэл жинтэй хүмүүс тодорхой хувь эзэлж байсан нь бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинд сөргөөр нөлөөлж байгааг харуулж байна. Илүүдэл жинтэй оролцогчдын хувьд тэсвэр болон хурдны шалгалтын үзүүлэлт харьцангуй доогуур байсан нь ажиглагдсан.

Биеийн жингийн зохистой харьцаа алдагдсан тохиолдолд хөдөлгөөний идэвх буурах, зүрх судасны ачаалал нэмэгдэх, бие бялдрын гүйцэтгэл буурах зэрэг сөрөг үр дагавар үүсэх магадлалтай байдаг. Иймээс бие бялдрын бэлтгэлжилтийг сайжруулахын зэрэгцээ эрүүл хооллолт, амьдралын зөв хэв маягийг төлөвшүүлэх нь чухал юм.

Судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл Дотоод хэргийн их сургуулийн багш, албан хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн ерөнхий түвшин 67.5% буюу дундаж түвшинд байна гэж дүгнэж болно. Бие бялдрын хөгжлийн

таван чанараас уян хатан чанар хамгийн өндөр, харин хурд болон тэсвэрийн үзүүлэлтүүд хамгийн бага байна.

Энэ нь багш, албан хаагчдын дунд биеийн тамирын дасгал хөдөлгөөн тогтмол хийдэггүй, хөдөлгөөний идэвх харьцангуй сул байгааг илтгэж байна. Гиймээс байгууллагын хэмжээнд бие бялдрын бэлтгэлийг илүү системтэй, төлөвлөгөөтэй зохион байгуулах шаардлагатай байна.

Ялангуяа тэсвэр болон хурдны чанарыг хөгжүүлэхэд чиглэсэн гүйлтийн дасгал, аэробик дасгал, биеийн ерөнхий тэсвэрийг нэмэгдүүлэх сургалт дасгалуудыг тогтмол зохион байгуулах нь чухал ач холбогдолтой юм.

### Дүгнэлт

Дотоод хэргийн их сургуулийн албан хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг сайжруулахын тулд биеийн тамирын сургалт, дасгал хөдөлгөөнийг тогтмол зохион байгуулах, ялангуяа хурд болон тэсвэрийг хөгжүүлэхэд чиглэсэн дасгал сургуулилтыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Мөн эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, илүүдэл жинг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх нь бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэхэд ач холбогдолтой. Цаашид бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тогтмол үнэлж, судалгааны үр дүнд үндэслэн сургалт, бэлтгэлийн арга зүйг боловсронгуй болгох нь багш, албан хаагчдын бие бялдрын хөгжлийг сайжруулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой гэж үзэж байна.

### Санал

1. Бие бялдрын бэлтгэлийг тогтмол зохион байгуулах

2. Хурд, тэсвэрийг хөгжүүлэх дасгал сургуулилтыг нэмэгдүүлэх
3. Илүүдэл жинтэй алба хаагчдад зориулсан тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх
4. Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшинг тогтмол шалгах
5. Спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулах
6. Эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх сургалт явуулах

### Ашигласан материал

1. Монгол Улсын Зэвсэгт хүчний жанжин штаб. Цэргийн биеийн тамирын заавар. Улаанбаатар, 2018.
2. Монгол Улсын Зэвсэгт хүчний жанжин штаб. Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт. Улаанбаатар, 2018.
3. Дотоод хэргийн их сургууль. Албан хаагчдын бие бялдрын хөгжлийг хангах журам. Улаанбаатар, 2023.
4. Батсайхан Б. Биеийн тамирын онол, арга зүй. Улаанбаатар, 2019.



## “АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААН” СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГАД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

### ANALYSIS OF THE CONTENT OF THE “SAFE LIVING SKILLS” TRAINING PROGRAM

#### Н.Отгонцэцэг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

#### N. Otgontsetseg

Professor of the Disaster protection department of the Disaster emergency Master's student at the Emergency management school, University of Internal Affairs, Mongolia

#### О.Шинэтунгалаг

Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн магистрант, дэслэгч

#### O. Shinetungalag

Professor of the Disaster protection department of the Disaster emergency Master's student at the Emergency management school, University of Internal Affairs, Mongolia

\*хариуцлагатай зохиогч: otgoonoo.9401@gmail.com

**Хураангуй:** Энэхүү судалгааны өгүүлэл нь ерөнхий боловсролын сургуулийн “Аюулгүй амьдрах ухаан” хичээлийн хөтөлбөрийн агуулгыг шинжилж, сургалтын зорилго, бүтэц, агуулга, үнэлгээний уялдааг судалсан болно.

Судалгааны үндсэн зорилго нь уг хөтөлбөрийн агуулгын давуу болон сул талыг тодорхойлон илрүүлж, цаашдын боловсронгуй болгох чиглэл, арга замыг санал болгоход оршино. Судалгаанд баримт бичгийн шинжилгээ, харьцуулсан шинжилгээ, агуулгын задлан шинжилгээний аргуудыг ашиглав.

Судалгааны үр дүнгээс үзэхэд аюулгүй амьдрах ухааны боловсролын агуулга нь байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюул, осол, гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгоход чиглэсэн боловч биологийн болон нийгмийн гаралтай гамшгийн агуулга хангалтгүй тусгагдсан, түүнчлэн сургалтын түвшин хоорондын залгамж холбоо, уялдаа сул байна. Иймээс боловсролын түвшин бүрийн хөгжлийн онцлогт нийцсэн, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн цогц агуулгыг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэв.

**Abstract:** This research article analyzes the content of the “Safe Living Skills” curriculum implemented in Mongolian general secondary schools and examines the alignment among learning objectives, structure, content, and assessment.

The main purpose of the study is to identify the strengths and weaknesses of the curriculum and to propose directions and approaches for its further improvement. Document analysis, comparative analysis, and content analysis methods were employed in the study.

The findings indicate that while the content of safe living skills education is primarily focused on providing knowledge for the prevention of hazards, accidents, and disasters related to natural and human-induced risks, the coverage of biological and social disasters remains insufficient. In addition, the continuity and coherence between different educational levels are weak. Therefore, it is concluded that the curriculum needs to be further developed through a comprehensive framework aimed at disaster risk reduction and aligned with the developmental characteristics of learners at each educational level.





(Хүснэгт 1-ээс харна уу). Тус байгууллагын үзэл баримтлалаар амьдрах ухаан гэдэг нь хувь хүнийг өдөр тутмын амьдралын сорилт, эрсдэлийг даван туулах, сэтгэл зүй,

нийгмийн дарамтад зохистой хариу үйлдэл үзүүлэх, эрүүл, аюулгүй зан төлөвийг төлөвшүүлэхэд чиглэсэн чадваруудын цогц юм.

№	Чадварын нэр	Тайлбар
1	Өөрийгөө ойлгох чадвар ( <i>Self-awareness</i> )	Өөрийн давуу ба сул тал, үнэт зүйл, зорилго, сэтгэл хөдлөлөө ухамсарлах чадвар.
2	Бусдыг ойлгох чадвар ( <i>Empathy</i> )	Бусдын мэдрэмж, нөхцөл байдлыг ойлгож, хүндэтгэх, туслах чадвар.
3	Харилцааны чадвар ( <i>Effective communication</i> )	Үзэл бодлоо илэрхийлэх, бусдыг сонсох, эерэг харилцаа тогтоох чадвар.
4	Хүн хоорондын харилцааны чадвар ( <i>Interpersonal relationship skills</i> )	Хамт олонтой харилцах, зөрчил шийдвэрлэх, багийн ажиллагаанд оролцох чадвар.
5	Шийдвэр гаргах чадвар ( <i>Decision-making</i> )	Хариуцлагатай, мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах чадвар.
6	Асуудал шийдвэрлэх чадвар ( <i>Problem-solving</i> )	Хүндрэлтэй нөхцөл байдалд үр дүнтэй шийдвэр гаргах чадвар.
7	Бүтээлч сэтгэлгээ ( <i>Creative thinking</i> )	Шинэлэг санаа гаргах, сорилтыг шинэ өнцгөөс харах чадвар.
8	Шүүмжлэлтэй сэтгэлгээ ( <i>Critical thinking</i> )	Баримт, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрсдэлийг үнэлэх чадвар.
9	Сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар ( <i>Coping with emotions</i> )	Сэтгэл хөдлөлийг хянах, эерэг илэрхийлэх чадвар.
10	Стрессийг даван туулах чадвар ( <i>Coping with stress</i> )	Дарамт, стрессийг даван туулах, сэтгэлзүйн тогтвортой байдлаа хадгалах чадвар.

Хүснэгт №1. Аюулгүй амьдрах ухаанд шаардагдах амьдралын 10 чадвар (ДЭМБ-ын хандлага)

Дээрх хүснэгтээс харахад эдгээр чадварыг эзэмшсэн хүн эрсдэлтэй нөхцөл байдлыг зөв үнэлэх, аюул ослоос урьдчилан сэргийлэх, өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах боломжтой болдог. Иймээс амьдрах ухааны боловсрол нь зөвхөн мэдлэг олгох бус, зан үйл, дадал хэвшил, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн зан төлөвт суурилсан боловсрол байх ёстой гэж үздэг.

ЮНЕСКО-гийн үзэл баримтлалын хүрээнд амьдрах ухааны боловсрол нь зөвхөн хувь хүнд шаардлагатай практик чадвар, зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэх бус, иргэний боловсрол, хүний эрхийн боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, энх тайвны боловсрол, гамшгийн эрсдэлийг бууруулах боловсрол зэрэг салбар хоорондын уялдаат

чиглэлүүдтэй уялдан хэрэгжих ёстой гэж үздэг. Энэ нь амьдрах ухааны боловсролыг ардчилсан үнэт зүйлсийг дэмжих, хүний эрхийг дээдлэх хандлагыг төлөвшүүлэх, байгаль орчинд ээлтэй, тогтвортой амьдралын хэв маягийг хэвшүүлэх, нийгмийн эв нэгдэл, энх тайвны соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн суурь боловсролын стратегийн чиглэл болгож байна.

Дээрх үзлээр орчин үеийн иргэн нь зөвхөн мэдлэг эзэмшсэн байх төдий бус, мэдээлэлд шүүмжлэлтэй хандах, эрсдэлийг үнэлэх, олон соёлт нийгмийн орчинд хамтран ажиллах, нийгмийн хариуцлага, оролцоог ухамсарлах цогц чадамжийг эзэмшсэн байх шаардлагатай. Иймд аюулгүй амьдрах ухааны боловсрол нь нийгмийн тогтвортой байдлыг хангах, гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэдийн

идэвхтэй оролцоог дэмжихэд чиглэсэн боловсролын стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг хэмээн тодорхойлогдож байна.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан (UNICEF) нь амьдрах ухаан, аюулгүй байдлын боловсролыг хүүхдийн эрхийг хамгаалах, аюулгүй орчинд өсөж хөгжих таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн суурь институцийн механизм хэмээн тодорхойлдог бөгөөд үзэл баримтлалын дагуу нь хүүхэд зөвхөн хамгаалуулах объект бус, харин өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангахад идэвхтэй оролцох чадамжтай, оролцоот субъект байх ёстой гэж үздэг. Иймд амьдрах ухааны боловсрол нь хүүхдэд аюул, эрсдэлийг танин мэдэх, эрсдэлийг үнэлэх, эрсдэлтэй нөхцөл байдалд зөв шийдвэр гаргах, шаардлагатай үед дэмжлэг, тусламж эрэлхийлэх, бусдад туслалцаа үзүүлэх, нийгмийн орчинд аюулгүй амьдрах зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн цогц сургалтын агуулгатай байх ёстой гэж тодорхойлдог.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн сан, (ЮНЕСКО), Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын үзэл баримтлалыг нэгтгэн авч үзвэл амьдрах ухаан, аюулгүй байдлын боловсрол нь дараах үндсэн шинжүүдтэй байна. Үүнд:

1. Эрсдэлд суурилсан боловсрол – амьдралын бодит нөхцөлд тулгуурласан сургалт

2. Чадварт суурилсан хандлага – мэдлэгээс гадна зан төлөв, дадал хэвшил төлөвшүүлэх

3. Иргэний боловсрол – нийгмийн хариуцлага, оролцоог дэмжих

4. Тогтвортой хөгжлийн суурь – нийгэм, эдийн засаг, байгаль орчны тэнцвэрийг хангах

Иймээс “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгохдоо эдгээр байгууллагын үзэл баримтлалд тулгуурласан, гамшгийн эрсдэлийг бууруулах боловсролын (Disaster Risk Reduction Education) цогц загварыг нэвтрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

#### **Хоёр. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн өнөөгийн хэрэгцээ, зорилго ба агуулга**

Хүн бүр үр хүүхдээ эрүүл, эрсдэлгүй тайван орчинд аз жаргалтай өсгөхийг хүсдэг. Гэвч өнөөдрийн нийгэмд бидний хүүхдийн хүрээлэн буй орчин бүрэн аюулгүй, тайван бус байна. Иймээс гамшиг, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, гэнэтийн нөхцөлд бэлэн байх, түүнээс өөрийгөө хамгаалах болон бусадтай мэдлэг чадвараа хуваалцах, ухамсарыг хүүхэд наснаас нь иргэн бүрт төлөвшүүлэх асуудал зүй ёсоор тавигдаж байна.

Өмнө нь хүүхдийг гамшгаас хамгаалах боловсрол эзэмшүүлэх шаардлагагүй, тэдний аюулгүй байдлыг насанд хүрэгчид хариуцах ёстой гэж үздэг байв. Гэвч анхаарал, халамж хэт давамгайлах нь хүүхдийн аюулыг таних, зайлсхийх, зөв шийдвэр гаргах чадварыг сулруулж, улмаар эрсдэлд өртөх нөхцөл бүрдүүлдэг. Тиймээс аюулгүй байдлын боловсролыг хүүхдийн хөгжлийн онцлогтой уялдуулан бага наснаас нь эхлэн олгох нь зүйтэй юм. Энэ нь хүүхдэд өөрийгөө хамгаалах дадал, хариуцлагатай зан төлөв, ухамсарт хандлагыг эртнээс төлөвшүүлэх чухал үндэс болдог.


“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг





ᠬᠤᠠᠨᠠᠭᠤᠯᠦᠭᠦᠢ ᠠᠮᠢᠳᠤᠷᠠᠬᠤ ᠤᠬᠠᠨ

хэрэгжүүлэхдээ, сургуулийн өмнөх түвшинд тус тус хэрэгжүүлж байна. боловсрол (СӨБ)-ын түвшинд, бага, (Зураг 1-ээс харах) суурь, бүрэн дунд боловсрол (ЕБС)-ын



<sup>3</sup>Зураг №1. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн түвшин

Зураг 2-г үзүүлсэн, ЕБС-ийн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг “Орчны аюулгүй байдал”, “Гамшиг, осол, аюулт үзэгдэл гэж 2 ангилж байна.



<sup>4</sup>Зураг №2. Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөрийн агуулга (ЕБС)  
Эх сурвалж: “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (сургуулийн өмнөх боловсрол).

<sup>3</sup> Аюулгүй амьдрах ухаан, гарын авлага. 2019 он., хуудас 15

<sup>4</sup> Аюулгүй амьдрах ухаан, гарын авлага. 2019 он., хуудас 20

“Аюулгүй амьдрах ухаан” түвшин ахихын хэрээр хүүхдүүд сургалтын хөтөлбөр нь бага насны зөвхөн өөрийнхөө бус, бусдын аюулгүй хүүхдүүдэд аюулыг урьдчилан байдлыг хангах чадварт суралцаж, төсөөлөх, түүнээс зайлсхийх чадварыг нийгмийн аюулгүй байдалд хувь нэмэр төлөвшүүлдэг бол боловсролын оруулах хандлагатай болдог.

Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэгч	“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрөөр эзэмших дадал, ур чадвар	
	Болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх чадвар	Бусдын болон нийгмийн аюулгүй байдлыг хамгаалахад хувь нэмэр оруулах чадвар
Сургуулийн өмнөх боловсрол	Өдөр тутмын амьдралдаа аюулгүй амьдралын дадалтай болно. Багш, асран хамгаалагчийн зааврыг баримтална.	Аюултай учирвал ойр байгаа том хүмүүст дуулгана
Бага анги	Аюулгүй үйл хөдлөл хийхийн чухлыг ойлгож аюулгүй байдлын дүрмийг баримтална. Өөрийнхөө эргэн тойрны аюулыг мэдэрнэ. Орчны аюулгүй байдал, гамшиг, осол, аюулт үзэгдлийн шалтгаан, ослоос урьдчилан сэргийлэх талаар ойлголттой болж, оновчтой үйл хөдлөл хийж чаддаг болно.	Аюултай учирвал, мөн гэмт хэрэг, осол, гамшгийн нөхцөл байдал тохиолдсон үед ойр байгаа том хүмүүст дуулгаж, зааврыг дагана. Бусдыг хамгаалахад санаа тавина. Анхан шатны энгийн тусламж хүргэж чаддаг болно.
Дунд анги	Өдөр тутмын амьдралдаа аюулгүй үйлдэл хийнэ. Гамшгаас хамгаалахад өдөр тутмын бэлэн байдлаа хангаж, нүүн шилжих оновчтой арга хэмжээг авна.	Бусдын аюулгүй байдалд анхаарал тавина. Анхан шатны тусламж үзүүлэх чадвартай болно. Сургууль, орон нутгийн сайн дурын үйл ажиллагааны чухлыг ойлгож, оролцоно.
Ахлах анги	Янз бүрийн нөхцөлд өөрийн аюулгүй байдлын хангана.	Найз нөхөд, гэр бүл, игэдийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулахын чухлыг ойлгоно. Амилуулах суурь тусламж үзүүлэх чадвараа дээшлүүлж тохирох арга хэмжээг авч чаддаг болно. Орон нутгийн аюулгүй байдлын арга хэмжээ ба гамшгийн үеийн сайн дурын үйл ажиллагаанд идэвхи санаачлагатай оролцоно.

#### Хүснэгт №2. Аюулгүй амьдрах ухаанаар эзэмших чадвар

Эх сурвалж: “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (сургуулийн өмнөх боловсрол).

**Гурав. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулгад хийсэн шинжилгээ**

**“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулгаас харахад аюулгүй байдлын ойлголтод:**

• Хувийн аюулгүй байдал: Бие махбодь, сэтгэл зүйгээр бэлтгэгдсэн,

аюулыг урьдчилан төсөөлж, өөрийгөө хамгаалах чадвартай байх үзэл баримтлал.

• Нийгмийн аюулгүй байдал: Хамт олны эв нэгдэл, олон нийтийн энх тайван, улсын аюулгүй байдлыг хангах ойлголт ба үзэл санаа.



Аюулгүй амьдрах ухаан



ᠬᠤᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰᠤᠨ ᠰᠠᠬᠢᠭᠤᠯᠠᠬᠤ


• Терроризм, хүчирхийлэл, мансууруулах бодис: Хорт утаа, сэтгэл санаанд нөлөөлөх бодис зэрэг аюулт хүчин зүйлсээс хамгаалах, хяналт тавих асуудал.

• Бэлгийн мөлжлөг, хүний наймаа, гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, даван туулах



арга зам зэргийг хамааруулж ойлгож болохоор байна.

Гамшиг, аюулт үзэгдэл, ослын ойлголт: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлт зэрэг олон хүний амь нас, эрүүл мэнд, мал амьтан хохирох нөхцөл үүсгэдгийг тусган боловсруулсан

Үүнийг графикаар харуулбал:



■ аюулт үзэгдэл, осол гамшигийн ойлголт  
 ■ аюулгүй байдлын ойлголт



Дээрх графикаас харахад аюулт үзэгдэл, гамшигийн агуулгыг боловсролын түвшнээр авч үзвэл:

• Сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд хувийн аюулгүй байдалд түлхүү анхаарсан;

• Суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд байгалийн болон экологийн гаралтай гамшигийн ойлголт илүү өргөжсөн байна.

Бүлэг	Сэдэв	Суралцахуйн зорилтын тоо	Нийт
Ахуйн осол	Ахуйн ослоос сэргийлэх	53	59 (28.6%)
	Эм, химийн бодистой харьцах	5	
	Анхны тусламж үзүүлэх	1	
Орчны аюулгүй байдал	Байгалийн орчин	36	84 (40.7%)
	Нийгмийн орчин	48	
Аюулт үзэгдэл, осол	Байгалийн эрсдэлүүд	24	63 (30.5%)
	Экологийн эрсдэлүүд	26	
	Биологийн эрсдэлүүд	6	
	Нийгмийн эрсдэлүүд	7	

Хүснэгт №3. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулгыг цаг сэдвээр задлан харуулбал:

Дээрх хүснэгтээс харахад тус хөтөлбөрт багтсан бүлэг сэдвийн суралцахуйн зорилтод ахуйн осол бүлэг 28.6 хувийг, орчны аюулгүй байдал бүлэг 40.7 хувийг, аюулт үзэгдэл, осол бүлэг 30.5 хувийг тус тус эзэлж байна. Гэвч биологийн гаралтай гамшиг, нийгмийн болон холимог гаралтай гамшгийн агуулга хангалттай тусгагдаагүй, Монгол орны онцлогт тохирсон зуд, ган, шороон болон цасан шуурга, үер, түймэр зэрэг аюулт үзэгдлийн сэргийлэлт, бэлтгэлийн асуудал хязгаарлагдмал байгааг судалгааны үр дүн харуулж байна.

**Агуулгын шинжилгээний үр дүн:** Гамшиг, осол, аюулт үзэгдлийн ойлголт суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөрт хангалттай тусгагдсан бол сургуулийн өмнөх болон бага боловсролын түвшинд тодорхой хэмжээнд орсон байна. Тодруулбал:

- Гамшгийн гарал үүсэлээр экологийн гаралтай гамшгийн агуулга давамгайлж, нийт 48 хувийг эзэлж, газарзүй болон химийн сургалтын хөтөлбөрт түлхүү туссан.

- Байгалийн гаралтай аюулт үзэгдлийн агуулга голчлон газарзүйн хичээлд багтсан.

- Техник технологийн гаралтай ослын агуулга химийн хичээлд, химийн бодисын нөлөөллийг судлах, аюулгүй ажиллахтай уялдан туссан.

- Нийгмийн болон холимог гаралтай гамшгийн агуулга харьцангуй бага туссан.

- Биологийн гаралтай буюу хүн, мал, амьтны гоц халдварт өвчний агуулга сургалтын хөтөлбөрт орсонгүй.

- Гамшгийн хамрах хүрээний хувьд объектын хэсэгчилсэн, орон нутгийн, үндэсний, тив дэлхийд тархсан зэрэг ангиллууд тодорхой

хэмжээгээр тусгагдсан.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад цаашид боловсролын түвшний зорилготой уялдуулан гамшгаас хамгаалах боловсролын зорилго, зорилтыг тодорхойлж сургалтын хөтөлбөрт тусгах нь зүйтэй гэж үзэж байна.

### Дүгнэлт

Судалгааны үр дүнгээс дараах үндсэн дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр нь байгалийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой аюул, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгоход чиглэсэн боловч гамшгийн боловсролын цогц хандлага хангалттай тусгагдаагүй байна.

2. Сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний агуулгын залгамж холбоо сул, түвшин ахих тусам агуулгын уялдаа тодорхой бус байна.

3. Байгалийн гаралтай гамшгийн агуулга харьцангуй сайн тусгагдсан боловч Монгол орны онцлогт тохирсон цаг уурын эрсдэлүүдийн талаар системтэй мэдлэг олгох шаардлага байна.

4. Биологийн болон нийгмийн гаралтай гамшгийн агуулгыг сургалтын хөтөлбөрт нэмж тусгах зайлшгүй хэрэгцээ байна.

Иймээс цаашид аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг гамшгийн эрсдэлийг бууруулах боловсролын (Disaster Risk Reduction Education) олон улсын үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх, боловсролын түвшин бүрийн онцлогт тохирсон, бодит чадвар төлөвшүүлэхэд чиглэсэн цогц агуулгаар баяжуулах шаардлагатай гэж үзэж байна.

### Ашигласан материал

1. “Аюулгүй амьдрах ухаан”





- сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (сургуулийн өмнөх боловсрол) (2019)
2. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (бага, суурь, бүрэн дунд боловсрол) (2019)
3. Боловсролын сайдын тушаал А/181 (2018). Аюулгүй амьдрах ухаан сургалтын хөтөлбөр. УБ.
4. НЭМА. (2020). Хүүхдэд зориулсан аюулгүй амьдрах сургалтын гарын авлага. УБ.
5. Онцгой байдлын ерөнхий газар. (2025). гамшиг, аюулт үзэгдэл ослын үед нэн яаралтай авах 10 алхам: хүүхдэд зориулсан тараах материал. улаанбаатар: нэма хэвлэл.
6. НЭМА. албан ёсны вэбсайт
7. Гамшгийн эрсдэлийг бууруулах сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийн хэрэгжилтийн монгол улсын дунд хугацааны тайлан, 2022.

Техник редактор:

Л.Одхүү

Дугаар эрхлэн гаргасан:

Ц.Чингүнжав

Эх бэлтгэсэн:

М.Цэцгээ

Сэтгүүлийн редакцын зөвлөл

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
Хилчиний гудамж, Ш/х-210332

Утас: 976 7015-5061  
И-мэйл: [journal@uia.gov.mn](mailto:journal@uia.gov.mn)  
Вэб: [www.uia.gov.mn](http://www.uia.gov.mn)

13301 Ulaanbaatar city, Bayanzurkh district-8,  
Khilchin street, P/O-210332

Tel: 976 7015-5061  
E-mail: [journal@uia.gov.mn](mailto:journal@uia.gov.mn)  
Web: [www.uia.gov.mn](http://www.uia.gov.mn)



e-ISSN 2958-051X



ISSN 2312-0797

